

НҮБ-ын Гэмт хэрэг, мансууруулах бодистой тэмцэх газар (UNODC-НҮГХМБТГ)

Бүс нутаг дамнасан Гэмт хэрэг, Шударга ёсны Судалгааны Институт (UNICRI-БГШСИ)
(аюулгүй байдлыг бэхжүүлэх, шударга ёсыг эрхэмлэх, энх тайвныг цогцлоох)

Авлигын эсрэг НҮБ-ын Конвенцийг хэрэгжүүлэх мэргэжил арга зүйн удирдамж

НҮБ Гэмт хэрэг, мансууруулах бодистой тэмцэх газар, Вена

Авлигын эсрэг НҮБ-ын Конвенцийн техникийн Удирдамж

НҮБ, Нью-Йорк, 2009 он.

Энэ хэвлэлийг албан ёсоор хянан тохиолдуулаагүй болно

Талархал

Энэхүү удирдамжийг Димитри Влассисийн удирдсан НҮБХГГ-ын Гэрээ хэлэлцээрийн асуудал хариуцсан алба болон Анжела Патригнанийн удирдсан БГШСИ-ийн Шударга ёс, нийгмийн хамгаалал, ёс зүйн хэсгийн хамтарсан төслийн хүрээнд боловсруулсан болно. 2006 оны V сард Турин хотноо, мөн оны IX сард Вена хотноо тус тус чуулсан мэргэжилтнүүдийн бүлгийн хоёр удаагийн уулзалт болон Вена дэхь НҮГХМБТГ-ын мэргэжилтнүүдийн хичээл зүтгэл удирдамжийг боловсруулахад ихээхэн хувь нэмэр оруулсан юм.

Төсөл боловсруулахад БГШСИ-н дараахь ажилтнууд голлох үүрэг гүйцэтгэсэн. Үүнд:

- Сандра Калвани, Төслийн захирал
- Анжела Патригнани, Шударга ёс, нийгмийн хамгаалал, ёс зүйн хэсгийн дарга
- Жиоаччино Полимени, Захирал асан
- Андреа Рачеле Фиоре, Хөтөлбөрийн ажилтан
- Мехди Бача, Хөтөлбөрийн ажилтан
- Алексис Франке, Хөтөлбөрийн туслах ажилтан

Удирдамжийг боловсруулахад дэмжлэг үзүүлж үнэтэй хувь нэмрээ оруулсан НҮГХМБТГ-ын дараах ажилтнуудад талархал илэрхийлж байна.

- Димитри Влассис, Авлига, эдийн засгийн гэмт хэрэг хариуцсан хэлтсийн дарга
- Стюарт Жиллиан, Хөрөнгө буцаан олгох төслийн дэд захирал
- Оливер Столпе, Шударга ёс, шударга байдлын хэсгийн дарга
- Демостенес Крисикус, Авлига, эдийн засгийн гэмт хэрэг хариуцсан хэлтсийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, эрүүгийн шүүн таслах ажиллагаа хариуцсан ажилтан
- Доротсий Готтуорд, Авлига, эдийн засгийн гэмт хэрэг хариуцсан хэлтсийн туслах мэргэжилтэн
- Элса Гопала Кришнан, Авлига, эдийн засгийн гэмт хэрэг хариуцсан хэлтсийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэргэжилтэн
- Александра Соуза-Мартинс, Шударга ёс, Шударга байдал хариуцсан хэсгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэргэжилтэн, Үйл ажиллагааны Алба
- Елайн Берна
- Патрик МкГоуан

НҮБХГГ болон БГШСИ-н зүгээс энэхүү удирдамжийг шинэчлэн сайжруулахад харамгүй туслалцаа үзүүлсэн дараах мэргэжилтнүүдэд талархаж байна:

- Алан Бакаресе,
- Алан Дойс,
- Гуйллермо Жорже,
- Майкл Кубисиел.

Удирдамжийг боловсруулах үйл ажиллагаанд санхүүгийн дэмжлэг үзүүлж өгөөмрөөр дэмжиж тусалсан АНУ-ын Төрийн департамент болон Фондационе (CRT) нарт онцгойлон талархал илэрхийлье.

Гарчиг

Оршил (5-14 зүйлүүд)

Урьдчилан сэргийлэх арга хэмжээ (II бүлэг, 5-14 зүйлүүд)

Тавдугаар зүйл: Авлигаас урьдчилан сэргийлэх бодлого, үйл ажиллагаа

- I. Ерөнхий тойм
- II. Бодит бэрхшээл ба шийдэл
 - II.1. Авлигаас урьдчилан сэргийлэх бодлого, үйл ажиллагаа
 - II.2. Авлигын эсрэг бодлогын үр дүн, уялдаа холбоо
 - II.3. Нийгмийн оролцоо
 - II.4. Удирдамжийг ашиглах тухай
 - II.5. Олон улсын хамтын ажиллагаа
- III. Стратеги боловсруулах
- IV. Стратегийн бүтэц

Зургаадугаар зүйл: Авлигаас урьдчилан сэргийлэх байгууллага

- I. Ерөнхий тойм
- II. Бодит бэрхшээл ба шийдэл
 - II.1. Авлигаас урьдчилан сэргийлэх байгууллага
 - II.2. Байгууллагын бүрэн эрх, эрх мэдэл
 - II.3. Байгууллагын чиг үүрэг
 - II.4. Хараат бус байдал ба хариуцлага хүлээх байдал
 - II.5. Материаллаг нөөц
 - II.6. Мэргэшсэн боловсон хүчин ба сургалт

Долоодугаар зүйл: Төрийн алба

- I. Ерөнхий тойм
- II. Бодит бэрхшээл ба шийдэл
 - II.1. Төрийн албанд албан тушаалтанг сонгон шалгаруулах, ажилд авах, ажиллуулах, албан тушаал дэвшүүлэх, чөлөөлөх үр ашигтай, ил тод, бодит тогтолцоо
 - II.2. Авлигад өртөмтгйд тооцогдох төрийн албан тушаалд иргэнийг сонгон шалгаруулж авах, сургах журам
 - II.3. Хангалттай урамшуулал, тэгш шударга цалингийн түвшин
 - II.4. Төрийн албан хаагчид зориулсан ёс зүйн сургалт
 - II.5. Төрийн албан тушаалд нэр дэвших, сонгогдох шалгуурыг тогтоох
 - II.6. Сонгуулийн компанит ажил болон улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдал
 - II.7. Ил тод байдал ба сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тогтолцоо

Наймдугаар зүйл. Төрийн албан тушаалтны ёс зүйн дүрэм

I. Ерөнхий тойм

II. Бодит бэрхшээл ба шийдэл

II.1. Төрийн албан тушаалтны шударга, үнэнч, хариуцлагатай байдлыг хөхиүлэн дэмжих

II.2. Ёс зүйн дүрэм, стандарт

II.3. Хэрэгжих нөхцөл

III. Төрийн албан тушаалтан авлигын талаар мэдээлэх нь

IV. Мэдүүлэх тогтолцоо

V. Сахилгын арга хэмжээ

Есдүгээр зүйл. Төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа, төсвийн удирдлага

I. Ерөнхий тойм

II. Бодит бэрхшээл ба шийдэл

II.1. Төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан тогтолцоо

II.1.1. Зарчим

II.1.2. Ил тод байдлыг сайжруулах арга хэмжээ

II.1.3. Тендерийн шалгаруулалтын дүрэм ба нягтлан шалгах үйл явц

II.1.4. Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа хариуцсан боловсон хүчин

II.2. Төсвийн удирдлага

II.2.1. Төрийн санхүүгийн удирдлага

II.2.2. Улсын төсвийг батлах ажиллагаа

II.2.3. Орлого зарлагыг цаг тухайд нь тайлагнах

II.2.4. Нягтлан бодох бүртгэл, аудитын стандарт, хяналт

II.2.5. Эрсдлийн удирдлага, дотоодын хяналтын тогтолцоо

II.2.6. Баримт бичгийн үнэн зөв байдлыг хангах арга хэмжээ

Аравдугаар зүйл: Олон нийтэд тайлагнах

I. Ерөнхий тойм

II. Бодит бэрхшээл ба шийдэл

II.1. Төрийн захиргаанд ил тод байдлыг сайжруулах арга хэмжээ

II.2. Төрийн захиргаанд хамаарах мэдээллийг олж авах

II.3. Захиргааны журмыг хялбарчлах замаар шийдвэр гаргах эрх бүхий байгууллагад нэвтрэх боломж

II.4. Авлигын эрсдлийн талаар олон нийтэд тогтмол илтгэх

11 дүгээр зүйл: Шүүх засаглал болон мөрдөн байцаах байгууллагад хамаарах арга хэмжээ

I. Ерөнхий тойм

II. Бодит бэрхшээл ба шийдэл

- хэмжээ
- II.1. Шүүхийн байгууллагад ажиллагсадын шударга байдлыг бэхжүүлэх арга хэмжээ
 - II.2. Шүүхийн байгууллага авлигад автах эрсдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ
 - II.3. Дүрэм ба стандарт
 - II.4. Прокурорын шударга байдлыг бэхжүүлэх арга хэмжээ
 - II.5. Прокурорын байгууллага авлигад өртөх нөхцөл бүрдэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ
 - II.6. Прокурорын ёс зүйн дүрэм ба стандарт

12 дугаар зүйл: Хувийн хэвшил

I. Ерөнхий тойм

II. Бодит бэрхшээл ба шийдэл

- II.1. Хувийн хэвшилд авлига үүсэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ
- II.2. Нягтлан бодох бүртгэл болон аудитын стандартыг сайжруулах арга хэмжээ
- II.3. Хувийн хэвшилд иргэний, захиргааны болон эрүүгийн хариуцлага хүлээлгэх
- II.4. Хууль сахиулах байгууллага болон хувийн хэвшил хоорондын хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжих арга хэмжээ
- II.5. Хувийн байгууллагын зөв шударга байдлыг хамгаалах жишиг ба журам
- II.6. Хамтарсан байгууллага байгуулах, удирдах ажиллагааны ил тод байдал
- II.7. Хувийн байгууллагын үйл ажиллагааг зохицуулах журмыг буруугаар ашиглахаас урьдчилан сэргийлэх
- II.8. Төрийн албан хаагч байсан этгээд хувийн хэвшилд ажил эрхлэхэд тавигдах хязгаарлалт
- II.9. Дотоод аудит, магадлан итгэмжлэлийн ажиллагаа
- II.10. Бүртгэл, тооцоо, санхүүгийн мэдээлэл задруулах, нягтлан бодох бүртгэлийн болон аудитын стандарт
- II.11. Хахууль болсон зардал болон холбогдох бусад зардлыг татвар ногдох зардлаас хасч тооцохыг үл зөвшөөрөх

13 дугаар зүйл: Нийгмийн оролцоо

I. Ерөнхий тойм

II. Бодит бэрхшээл ба шийд

- II.1. Авлигатай тэмцэхэд нийгмийн оролцоог хөхиүлэн дэмжих
- II.2. Авлигын талаар олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх
- II.3. Шийдвэр гаргах ажиллагаанд олон нийтийн оролцоог дэмжих
- II.4. Олон нийтийн мэдлэг, боловсрол
- II.5. Авлигатай холбоотой мэдээлэл эрж хайх, олж авах, хэвлэн нийтлэх, тараах эрх чөлөө ба хязгаарлалт
- II.6. Авлигын эсрэг тэмцэх байгууллагын талаар олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх
- II.7. Олон нийт мэдээлэл олж авах боломжийг бүрдүүлэх
- II.8. Авлигын хэргийн талаар (нэрээ нууцлан) мэдээлэх

14 дүгээр зүйл: Мөнгө угаахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ

I. Ерөнхий тойм

II. Бэрхшээл ба шийдэл

II.1. Мөнгө угаахтай тэмцэхэд илүү тохиромжтой институцийн хүрээг сонгох

II.2. Урьдчилан сэргийлэх асуудлыг хариуцах этгээд

II.3. Зохицуулалт хийгдэх байгууллага болон үйл ажиллагаанд тавигдах наад захын шаардлага

II.4. Тайлагнах явдлыг хөхиүүлэн дэмжих

II.5. Санхүүгийн мэдээллийн харилцан солилцоо

II.6. Бэлэн мөнгө ба эргэлтийн баримт бичгийн хил дамжсан хөдөлгөөн

II.7. Мөнгөн шилжүүлэг

II.8. Хэрэгжүүлэлт

Гэмт хэрэгт тооцох, хууль сахиулах (III бүлэг, 15-42 дугаар зүйлүүд)

30 дугаар зүйл: Яллах, шүүхийн шийдвэр гаргах, шийтгэл ноогдуулах

I. Ерөнхий тойм

II. Бэрхшээл ба шийдэл

II.1. Гэмт хэргийн ноцтой байдлыг харгалзан шийтгэл ноогдуулах

II.2. Дархан эрх буюу шүүхийн харъяаллын давуу эрх

II.3. Өөрийн үзэмжээр шийдвэрлэх хууль зүйн эрх мэдэл

II.4. Шүүх хуралдаан буюу давж заалдахаас өмнө түр суллах тухай шийдвэр

II.5. Хугацаанаас нь өмнө суллах буюу тэнсэн суллах

II.6. Албан тушаалаас чөлөөлөх, түдгэлзүүлэх буюу өөр албан тушаалд томилох

II.7. Эрх хасах

II.8. Нийгэмшүүлэх

31 дүгээр зүйл: Битүүмжлэх, түр хураах, хураах

I. Ерөнхий тойм

II. Хураах хэлбэрүүд

III. Хураах загварууд

IV. Юуг гэмт үйлдлээс олсон орлогод тооцож хураах тухай

V. Дараа хураах зорилго бүхий урьдчилсан арга хэмжээ

VI. Нотолгоо шаардахыг хүчингүй болгох/шилжүүлэх

VII. Шударга (Bona fide) гуравдагч талыг хамгаалах тухай

32 дугаар зүйл: Гэрч, шинжээч, хохирогчийг хамгаалах

I. Ерөнхий тойм

II. Бодит бэрхшээл ба шийдэл

- II.1. Гэрч, шинжээч мөн тэдний хамаатан садан болон бусад ойрын хүн
 - II.2. Үр дүнтэй хамгаалалт
 - III. Бусад улсуудтай гэрээ байгуулах, тохиролцоо хийх
 - IV. Хохирогч
- 33 дугаар зүйл: Мэдээлэгч этгээдийг хамгаалах
- I. Ерөнхий тойм
 - II. Бодит бэрхшээл ба шийдэл
 - II.1. Бодлогын хүрээ, тогтолцоо
 - II.2. Төрийн албан тушаалтныг татан оролцуулах
 - II.3. Олон нийтийг татан оролцуулах
 - II.4. Хэнд мэдээлэх тухай
 - II.5. Мэдээлэх шалгуур
 - II.6. Мэдээлэгч этгээдийг хамгаалах
- 34 дүгээр зүйл: Авлигадах үйлдлийн үр дагавар
- I. Ерөнхий тойм
 - II. Бодит бэрхшээл ба шийдэл
 - II.1. Арга хэмжээний төрлүүд
 - II.2. Урьдчилан сэргийлэхэд төвлөрөх
 - II.3. Дотоодын хууль тогтоомжид нийцүүлэн арга хэмжээ авах
- 36 дугаар зүйл: Эрх бүхий тусгай байгууллага
- I. Оршил
 - II. Бэрхшээл ба шийдэл
 - II.1. Тусгай байгууллагын төрлүүд
 - II.2. Тусгай байгууллагын ач холбогдол ба үүрэг роль
 - II.3. Хараат бус байдал ба материаллаг нөөц
- 37 дугаар зүйл: Хууль сахиулах байгууллагатай хамтран ажиллах
- I. Ерөнхий тойм
 - II. Бодит бэрхшээл ба шийдэл
 - II.1. Холбогдох мэдээлэл
 - II.2. Ялыг хөнгөрүүлэх
 - II.3. Ялаас чөлөөлөх
 - II.4. Оролцогч улс хооронд гэрээ байгуулах, тохиролцоо хийх
- 38 дугаар зүйл: Үндэсний эрх бүхий байгууллага хоорондын хамтын ажиллагаа
- I. Ерөнхий тойм
 - II. Бодит бэрхшээл ба шийдэл
- 39 дүгээр зүйл: Үндэсний эрх бүхий байгууллага, хувийн хэвшил хоорондын хамтын ажиллагаа
- I. Ерөнхий тойм

II. Бодит бэрхшээл ба шийдэл

40 дүгээр зүйл: Банкны нууцлал

I. Ерөнхий тойм

II. Бэрхшээл ба шийдэл

II.1. Хэн ямар орчин нөхцөлд ямар зорилгоор банкны нууцлалд нэвтрэх эрх эдлэх тухай

II.2. Банкны нууцлалыг цуцлахад ямар журам шаардлагатай вэ?

II.3. Мэдээллийг шууд эсвэл хүсэлтийн дагуу задлах

II.4. Мэдээллийн төвлөрсөн санг ашиглах

II.5. Хүсэлтийн агуулга

II.6. “Харилцагчаа тань, жинхэнэ эзнээ тань” гэсэн урьдчилан сэргийлэх зарчмыг хэрэгжүүлэх тухай

II.7. Банкны нууцлал ба мэргэжилтэн

41 дүгээр зүйл: Гэмт хэргийн талаарх бүртгэл

I. Ерөнхий тойм

II. Бодит бэрхшээл ба шийдэл

42 дугаар зүйл: Шүүхийн харъяалал

I. Ерөнхий тойм

II. Бодит бэрхшээл ба шийдэл

II.1. Гэмт хэргийг тухайн оролцогч улсын нутаг дэвсгэрт үйлдсэн байх тохиолдол

II.2. Гэмт хэргийг тухайн улсын харьяатын эсрэг үйлдсэн байх тохиолдол

II.3. Гэмт хэргийг тус улсын харьяат буюу тус улсын нутаг дэвсгэрт байнга оршин суудаг харьяалалгүй этгээд үйлдсэн байх тохиолдол

II.4. Мөнгө угаахаар завдсан гэмт хэрэгт шүүхийн харъяалал тогтоох

II.5. Гэмт хэргийг Оролцогч улсын эсрэг үйлдсэн тохиолдол

II.6. Шүүхийн харьяаллыг “aut dedere aut iudicare” (нэг бол шилжүүлэн өг эсвэл шүүн тасал) зарчмын үндсэн дээр тогтоох

Олон улсын хамтын ажиллагаа (IV бүлэг, 43-50 зүйлүүд)

43 дугаар зүйл: Олон улсын хамтын ажиллагаа

I. Ерөнхий тойм

II. Бодит бэрхшээл ба шийдэл

II.1. Хоёр талаас гэмт хэрэгт тооцохтой холбоотой асуудал

II.2. Төвийн буюу эрх бүхий бусад байгууллагын оролцоо

II.3. Хамтын ажиллагааны хүрээ

II.4. Эрүүгийн гэмт хэргийн асуудлаар олон улс хамтран ажиллах явцад үүсэх бодит бэрхшээлийг шийдэх, материаллаг нөөцөөр хангах арга зам, хэрэгсэл

II.5. Чадавхийг бэхжүүлэх

III. Шалгах асуултууд

44 дүгээр зүйл: Шилжүүлэн өгөх

I. Ерөнхий тойм

II. Бэрхшээл ба шийдэл

II.1. Өнөөгийн санаа зовоосон асуудлыг шийдвэрлэх тухай

II.2. Орчин, хам нөхцлийг өөрчлөх

II.3. Шилжүүлэн өгөх эрх зүйн хүрээг тогтоох

II.4. Журмыг сайжруулах

III. Шалгах асуултууд

45 дугаар зүйл: Шийтгэгдсэн этгээдийг шилжүүлэх

I. Ерөнхий тойм

II. Бэрхшээл ба шийдэл

II.1. Эрх зүйн хүрээ

II.2. Гэмт этгээдийг шилжүүлэх нөхцөл

II.3. Шилжүүлэх үйл явц ба шийтгэл

II.4. Мэдээлэл

III. Шалгах асуултууд

46 дугаар зүйл: Эрх зүйн харилцан туслалцаа

I. Ерөнхий тойм

II. Бэрхшээл ба шийдэл

II.1. Тулгарч буй асуудлыг шийдвэрлэх

II.2. Бэрхшээлийг шийдэх: 46 дугаар зүйлд тусгасан эрхзүйн өргөн цар хүрээ

II.3. Холбогдох бусад конвенцтой уялдах

II.4. Шинэ дэвшил

II.5. Зохицуулан дэмжих шинэ механизм

III. Шалгах асуултууд

47 дугаар зүйл: Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг шилжүүлэх

I. Ерөнхий тойм

II. Бэрхшээл ба шийдэл

II.1. Шилжүүлэх шийдвэр гаргахад тавигдах бодлогын шалгуур

II.2. Шилжүүлэх шийдвэр гаргахад тавигдах бодит шалгуур

III. Шалгах асуултууд

48 дугаар зүйл: Хууль сахиулах талаар хамтран ажиллах

I. Ерөнхий тойм

II. Бэрхшээл ба шийдэл

II.1. Шийдвэрлэх асуудлууд

II.2. Хамтран ажиллах талбарууд

II.3. Хамтран ажиллах арга зам

III. Шалгах асуултууд

49 дүгээр зүйл: Хамтарсан мөрдөн шалгах ажиллагаа

- I. Ерөнхий тойм
- II. Бэрхшээл ба шийдэл
 - II.1. Үйл ажиллагаатай холбоотой асуудлууд
 - II.2. Мөрдөн шалгах ажиллагааны хүрээ, бүтэц
 - II.3. Хамтарсан ажиллагааг төлөвлөх
- III. Шалгах асуултууд

50 дугаар зүйл. Мөрдөн шалгах тусгай арга хэрэгсэл

- I. Ерөнхий тойм
- II. Бэрхшээл ба шийдэл
 - II.1. Хүний эрхийн хамгаалалт
 - II.2. Материаллаг нөөц/Технологийн чадавхи
 - II.3. Нотлох баримтын хүлээн зөвшөөрөгдөх байдал
 - II.4. Арга хэрэгслүүд
 - II.4.1. Техникийн ажиглалт-судалгаа – харилцуур утас чагнах, чагнах төхөөрөмж суулгах
 - II.4.2. Биет судалгаа ба газар дээрх ажиглалт
 - II.4.3. Нууц ажиллагаа, гүнд нь нэвтэрч судлах арга
 - II.4.4. Мэдээлэгч
 - II.4.5. Үнэнч байдлыг турших
 - II.4.6. Санхүүгийн гүйлгээнд хяналт тавих
 - II.5. Холбогдох конвенцууд
- III. Шалгах асуултууд

Хөрөнгө буцааж олгох арга хэмжээ (V бүлэг, 51-ээс 59 дүгээр зүйл)

51 дүгээр зүйл. Ерөнхий тойм

52 дугаар зүйл. Гэмт хэргээс олсон орлогыг шилжүүлэхээс урьдчилан сэргийлэх, шилжүүлгийг илрүүлэх

- I. Ерөнхий тойм
- II. Бодит бэрхшээл ба шийдэл
 - II.1. Харилцагчийн хэн болохыг нягтлан шалгах
 - II.2. Өндөр дүнтэй данс эзэмшигчдийн хэн болохыг тогтоох
 - II.3. Улс төрд оролцогч этгээдийн (PEP) эзэмших дансанд хатуу хяналт тавих
 - II.4. Дотоодын санхүүгийн байгууллагад хатуу хяналт тавих заавар
 - II.5. Бүртгэл хөтлөх
 - II.6. Санхүүгийн байгууллагад үл харьяалагдах банк байгуулах, корреспондент харилцаа тогтоох явдлаас урьдчилан сэргийлэх
 - II.7. Төрийн зохих албан тушаалтны санхүүгийн мэдээллийг нээлттэй болгох тогтолцоо
 - II.8. Төрийн албан тушаалтан ба гадаад улс дахь данс

53 дугаар зүйл: Эд хөрөнгийг шууд буцаан олгох арга хэмжээ

I. Ерөнхий тойм

II. Бодит бэрхшээл ба шийдэл

II.1. Эрхзүйн байр суурийг баталгаажуулах

II.2. Авлигын гэмт хэргийн хохирлыг нөхөн төлүүлэх, арилгуулах

II.3. Гадаадын эд хөрөнгө хураах ажиллагаанд эд хөрөнгө өмчлөх эрхийг тогтоох

54 дүгээр зүйл: Эд хөрөнгийг хураах асуудлаар олон улсын хэмжээнд хамтран ажиллах замаар эд хөрөнгийг буцаан олгох механизм

I. Ерөнхий тойм

II. Бодит бэрхшээл ба шийдэл

II.1. Эд хөрөнгө хураах гадаад улсын шийдвэрийг биелүүлэх боломж

II.2. Мөнгө угаах буюу холбогдох өөр бусад гэмт хэрэгт хамаарах гадаад улсын авлигын гэмт хэргээс олсон орлогыг хураан авах

II.3. Эрүүгийн хэрэгт буруутгалгүйгээр эд хөрөнгө хураах тухай

II.4. Хөрөнгийг дараа хураах зорилготой түр арга хэмжээ

56 дугаар зүйл: Тусгай хамтын ажиллагаа

I. Ерөнхий тойм

II. Бодит бэрхшээл ба шийдэл

58 дугаар зүйл: Санхүүгийн мэдээллийн нэгж (СМН)

I. Ерөнхий тойм

II. Бодит бэрхшээл ба шийдэл

II.1. СМН-ийн үүргүүд

II.2. СМН-ийн загварууд: захиргааны байгууллага

II.3. СМН-ийн загварууд: хууль сахиулах байгууллага

II.4. СМН-ийн загварууд: шүүхийн буюу прокурорын байгууллага

II.5. СМН-ийн загварууд: Эрлийз загвар

59 дүгээр зүйл: Хоёр ба олон талт хэлэлцээр ба тохиролцоо

I. Ерөнхий тойм

II. Бодит бэрхшээл ба шийдэл

Удиртгал

Авлигын эсрэг НҮБ-ын Конвенц (UNCAC) нь авлигатай тэмцэх олон улсын хуульчлагдан батлагдсан анхны баримт бичиг болж байгаагаараа ихээхэн онцлог юм. Энэхүү конвенцийг НҮБ-ын Ерөнхий Ассемблейн 2003 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 58/4 тоот тогтоолоор соёрхон баталж 2005 оны 12 дугаар сарын 14-ний өдөр хүчин төгөлдөр болгосон. Олон улсын хамтын нийгэмлэгийн харилцан зөвшилцөл, зориулалт, хүсэл эрмэлзлийн тод илэрхийлэл болсон энэхүү конвенцид эдүгээ 122 орон нэгдэн орсон болно. Авлигын эсрэг конвенцийн гол зорилго нь авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг илүү үр нөлөөтэй, үр дүнтэй байдлаар зохион байгуулах; авлигаас урьдчилан сэргийлэх, тэмцэх талаархи олон улсын хамтын ажиллагаа, техникийн туслалцааг (тухайлбал хөрөнгө буцаан олгох талаар) хөгжүүлэх, чиглүүлэх, хөхиүлэн дэмжих; төрийн —үйл хэрэг болон төрийн өмчийн шударга, хариуцлагатай, зохистой удирдлагыг хангахад оршино. Конвенцид авлигатай тэмцэх олон талт арга хэмжээг тусгаснаас гадна авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгай бүлэг болгон авч үзсэн. Түүнчлэн авлигатай тэмцэх олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэхийг чухалчилснаас гадна хөрөнгө буцаан олгох, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх болон хэрэгжүүлэх механизмын талаар шинэ соргог, алсыг харсан зүйл заалтуудыг багтаасан болно.

НҮБ-ын Гэмт хэрэг, мансууруулах бодистой тэмцэх газар (UNODC-НҮГХМБТГ) болон НҮБ-ын бүс нутаг дамнасан Гэмт хэрэг, шударга ёсны судалгааны институтын хамтран боловсруулсан энэхүү удирдамж нь Оролцогч улсуудын зүгээс авлигын эсрэг Конвенцийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой. Удирдамжийн ерөнхий төслийг боловсруулах ажлын хүрээнд дэлхийн өнцөг булан бүрээс мэргэжилтнүүд 2006 оны 5 дугаар сард Итали улсын Турин хотноо, мөн оны 6 дугаар сард Австри улсын Вена хотноо уулзалт зохион байгуулсан. Удирдамжийг эцэслэн боловсруулах явцад НҮБ-н нарийн бичгийн дарга нарын газрын зүгээс өргөн хүрээний хэлэлцүүлгээс гарсан дүгнэлт, залруулга, зөвлөмжид ихээхэн ач холбогдол өгч уг баримт бичигт тусгасан болно.

2006 онд батлагдсан Конвенцийг хэрэгжүүлэх эрх зүйн удирдамжийн дараа боловсруулсан энэхүү Мэргэжил, арга зүйн удирдамж нь авлигатай тэмцэх байгууллага албан хаагчдад Конвенцийн зүйл заалтыг хэрэгжүүлэх зөв дадал, бодит жишээ туршлагаар баяжуулахад голчлон төвлөрсөн мэргэжил арга зүйн шинжтэй зөвлөмж, арга хэрэгсэл болж чадсан. Конвенцийн эрх зүйн болон мэргэжил, арга зүйн энэхүү хоёр удирдамж харилцан бие биенээ нөхсөн шинжтэй. Эрх зүйн удирдамж нь Конвенцийг соёрхон баталж, хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий хууль тогтоогч болон бодлого боловсруулагч байгууллагад хандсан бол мэргэжил, арга зүйн удирдамж нь Авлигын эсрэг конвенцийн дагуу улс орны хуулийн тогтолцоонд эрх зүйн өөрчлөлт хийхэд төвлөрөхөөс илүүтэй Конвенцийн зүйл заалтыг бүрэн байдлаар, үр нөлөөтэйгээр хэрэгжүүлэх үүднээс бодлогын асуудал, институцын онцлог болон үйл ажиллагааны эрхзүйн орчинг онцгойлон тодотгохыг зорьсон болно.

Иймд мэргэжил арга зүйн удирдамжийг эрх зүйн удирдамжтай нь нягт уялдуулан авч үзэх шаардлагатай. Мэргэжил, арга зүйн удирдамжийн нэлээн хэдэн хэсэгт (ялангуяа Конвенцийн 3 дугаар бүлгийн гэмт хэрэгтэй холбоотой заалтууд болон 5 дугаар бүлгийн зарим заалтад холбогдуулан) эрх зүйн удирдамжийн заалтууд дурдагдсан. Эдгээр удирдамжийг Конвенцийн

хэрэгжилтийг хангах хүрээнд авлигатай тэмцэх газар, шүүх болон хууль сахиулах байгууллага зэрэг оролцогч талуудын мэдлэг чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн багц арга хэрэгсэл болгон ашиглах нь зүйтэй.

Эдгээр удирдамжийг зэрэгцүүлэн авч үзэж, ашиглах явдал оролцогч улс орнууд төдийгүй НҮБ-ын хувьд чухал ач холбогдолтой. Нэг талаас оролцогч улсын холбогдох байгууллага Конвенцийн зүйл заалтын талаар бүрэн ойлголттой болж Удирдамжаар дамжуулан олон талт зөвлөмжөөр хангагдана. Нөгөө талаас, НҮБ-ын зүгээс энэхүү удирдамжийг Конвенцийг бүрэн хэрэгжүүлэхэд зайлшгүй шийдвэрлэх шаардлагатай илүү өргөн хүрээг хамарсан бодлого, институцийн асуудлыг багтаасан бүрэн хэмжээний мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх х үндэс суурь болгон ашиглах боломж бүрдэнэ.

Энэхүү удирдамжийн зорилго нь оролцогч улс орнууд Конвенцийг хэрэгжүүлэх явцдаа харгалзан үзэх бодлогын хувилбар сонголт хийгээд зөвлөмжийг санал болгоход оршино. Мэргэжил, арга зүйн удирдамж нь конвенцийг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудалд төвлөрөх бөгөөд оролцогч улс бүрийн хууль эрхзүйн тогтолцоо, уламжлалт ёс, зан заншил, институцийн хүчин чадал харилцан адилгүй янз бүр тул үндэсний бодлого боловсруулагчдад зориулсан иж бүрэн зөвлөмж хэмээн үзэх боломжгүй юм.

Мэргэжил, арга зүйн удирдамж нь бүтцийн хувьд Конвенцийн агуулгын дагуу Конвенцийн тодорхой бүлэгт тулгуурлан бичигдсэн бөгөөд Конвенцийн үндсэн дөрвөн багана нь (авлигаас урьдчилан сэргийлэх, шүүн таслах ба хууль сахиулах, олон улсын хамтын ажиллагаа, хөрөнгө буцаан олгох) авлигын эсрэг олон талт иж бүрэн стратегийн салшгүй бүрдэл хэсэг гэсэн ойлголтонд тулгуурласан болно.

Конвенцийн зүйл заалтын цар хүрээ мэдээж үүнээс илүү нарийн арга хэрэгсэл шаардана. Конвенцийг хамгаалах чиг үүрэг бүхий, Оролцогч улсуудын бага хурлын нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч НҮБ-ын Гэмт хэрэг, мансууруулах бодистой тэмцэх газар (UNODC-НҮГХМБТГ) болон НҮБ-ын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан гол байгууллага болох НҮББГШСИ нарын зүгээс өргөн хүрээний түншүүдтэйгээ хамтран цаашид тэдгээр бүрэн цогц арга хэрэгслийг боловсруулахад хүчин зүтгэх болно.

**Урьчилан сэргийлэх арга хэмжээ
[II бүлэг 5-14 заалтууд]**

Тавдугаар зүйл: Авлигаас урьдчилан сэргийлэх бодлого, үйл ажиллагаа

- 1) *Оролцогч улс бүр эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн нийгмийн оролцоог дэмжсэн, хууль дээдлэх ёс, төрийн үйл хэрэг болон төрийн өмчийг зохистойгоор удирдах, шударга байх, ил тод байх, хариуцлага хүлээх зарчмыг илэрхийлсэн үр дүнтэй, уялдаа холбоо бүхий авлигын эсрэг бодлогыг боловсруулж, хэрэгжүүлнэ.*
- 2) *Оролцогч улс бүр авлигаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үр дүнтэй үйл ажиллагааг явуулах буюу хөхиүлэн дэмжих талаар хүчин чармайлт гаргана.*
- 3) *Оролцогч улс бүр авлигаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэхэд чадавхиа тодорхойлох зорилгоор холбогдох эрх зүйн баримт бичиг болон захиргааны арга хэмжээгээ тогтоосон хугацаанд үнэлэх талаар хүчин чармайлт гаргана.*
- 4) *Оролцогч улсууд шаардлагатай тохиолдолд эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн энэ зүйлд заасан арга хэмжээг хөхиүлэн дэмжиж, хөгжүүлэх чиглэлээр өөр хоорондоо, түүнчлэн холбогдох олон улсын болон бүс нутгийн байгууллагатай хамтран ажиллана. Ийм хамтын ажиллагаанд авлигаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн олон улсын хөтөлбөр, төсөл багтана.*

I. Ерөнхий тойм

Тавдугаар зүйлд оролцогч улс бүр Конвенцийн шаардлагын дагуу авлигын эсрэг цогц стратеги боловсруулж хэрэгжүүлэх замаар авлигаас урдчилан сэргийлэх суурь орчин нөхцлийг бүрдүүлсэн байх талаар заасан байна. Энэхүү зорилгодоо хүрэхийн тулд хууль дээдлэх ёс, төрийн үйл хэрэг, төрийн өмчийн зохистойгоор удирдах, шударга байх, ил тод байх, хариуцлага хүлээх зарчмыг хөхүүлэн дэмжих хэрэгтэй.

Түүнчлэн авилгын эсрэг стратегийн зохицуулалт, дотоод уялдаа холбоог сайжруулж бэхжүүлэх үүднээс холбогдох институци, хууль тогтоомжийн холбогдох заалтуудыг хянаж үзэж байх шаардлага оролцогч улс бүрт тавигдсан. Үүний тулд стратегийг төлөвлөж хэрэгжүүлэх үйл явцад иргэний нийгмийн байгууллага болон хувийн хэвшлийн төлөөллийг багтаасан өргөн хүрээний оролцоог хангаж тэдний туслалцаа дэмжлэгийг авах нь зүйтэй. Оролцогч улс бүр тэргүүн туршлагаа харилцан солилцох, хамтын ажиллагаагаа өргөжүүлэх болон харилцан бие биенээ дэмжих үүднээс бүс нутгийн болон олон улсын зохицуулалтуудыг боловсронгуй болгох талаар бусад улс орнуудтай хамтран ажиллавал зохино.

II. Бодит бэрхшээл ба шийдэл

Тавдугаар зүйлд авлигаас сэргийлэх үйл ажиллагааны ерөнхий төлөв байдал, нөхцлүүдийг тусгахыг зорьсон. Энэ зүйл нь төрийн үйл хэргийн зохистой удирдлага (9 дүгээр зүйл), хувийн хэвшлийн ил тод байдал (10 дугаар зүйл), хувийн хэвшилд гарч болзошгүй авлигаас сэргийлэх арга хэмжээ (12 дугаар зүйл), нийгмийн оролцоо (13 дугаар зүйл) гэх мэт өргөн хүрээний асуудлыг шийдэхийг зорьсон бүлгийн хамгийн эхний зүйл юм. Оролцогч улсууд нь зохих мэдээлэл, статистик тоо баримтанд үндэслэн гаргасан эрсдлийн үнэлгээнд тулгуурлан стратегиа боловсруулах ёстой. Үүнд төрийн байгууллагын төсвийг буруугаар ашигласныг илчилсэн, нягтлан бодох бүртгэлийн ажиллагаанд хяналт хийж байгаа дутагдлыг илрүүлсэн хөндлөнгийн хяналт шалгалтын тайланг багтааж болно. Төрийн үйл ажиллагаатай холбоотой бусад статистик тоо баримт үүнд хамаарч болно. Авлигын шалтгаан, чиг хандлага болон авлигад өртөх магадлалыг тогтоох зорилгоор тусгай судалгаа явуулах шаардлага гардаг. Ийм мэдээлэл баримт нь авлигын чиг хандлага, шалтгаан, хэв шинж, цар хүрээ үр дагаврыг тогтоох авлигын эрсдлийн буюу авлигад өртөх магадлалын үнэлгээний үндсийг бүрдүүлнэ. Ингэснээр авлигад өртсөн салбар болон үйл ажиллагааны талаар илүү их мэдлэгтэй болохоос гадна авлигаас илүү найдвартай урьдчилан сэргийлэх, авилгыг илрүүлэхэд шаардлагатай бодлого, үйл ажиллагаанд тулгуурласан авлигаас урьдчилан сэргийлэх стратеги боловсруулах үндсийг тавьж өгөх болно.

II.1. Авлигаас урьдчилан сэргийлэх бодлого, үйл ажиллагаа

Ихэнх улс орон хууль тогтоох, мөрдөн байцаах, шүүх гэх мэт салбарт хяналтын арга хэмжээг онцгойлон авч үздэг. Гэтэл энэ нь авлигаас урьчилан сэргийлэх үр дүнтэй бодлогын зөвхөн нэг л хэсэг юм. Хяналтын арга хэмжээ нь өндөр өртөгтэй бөгөөд хууль тогтоомж зөрчсөн, төрийн хөрөнгө санг шамшигдуулсан зөрчил, сул тал дээр илүүтэй төвлөрдөг. Авлигаас урьдчилан сэргийлэх нь төрийн тогтолцооны шударга байдлыг сахин хамгаалах, хууль тогтоомж, хөрөнгө санхүүгийн зохистой хэрэглээг хангаад зогсохгүй төрд итгэх итгэлийг нэмэгдүүлэх, төрийн албан хаагчийн төлөв байдлыг удирдан чиглүүлэхэд илүү өргөн хүрээний ашиг тустай тул онцгойлон авч үзэх хэрэгтэй юм.

II.2. Үр дүн уялдаа холбоо бүхий бодлого

НҮБ-ын Авлигын эсрэг Конвенцийн авлигаас сэргийлэх арга зам нь ерөнхий зарчмаас бодит тодорхой стратеги, үйл ажиллагааны хөтөлбөр, журам мөн стратегийг хэрэгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээний хэрэгжилтийг тогтмол хянах үйл явц руу шилжих уялдаа холбоо бүхий орчин, тогтолцоог бий болгох шаардлага дээр үндэслэсэн. Үүний тулд тухайн улс орны ерөнхий нөхцөл байдлын талаархи тоон болон чанарын мэдээллийг системтэйгээр цуглуулах, харьцуулах, гарсан үр дүнд шинжилгээ хийх, бодлого, бодлогын хэрэгжилтэнд өөрчлөлт хийх үүднээс ерөнхий зорилгоос тодорхой зорилгууд, үйл ажиллагааны төлөвлөгөө хүртэл нарийвчлагдсан стратеги боловсруулах бүхий л уялдааг хангах цогц, уялдаа холбоо бүхий аргачлал шаардлагатай. Стратеги боловсруулах, батлах, хэрэгжүүлэх, хянах, үнэлэх үйл явцыг (төрийн болон хувийн хэвшил, иргэний нийгэм гэх мэт) бүхий л оролцогчдын хүрээнд сайтар төлөвлөж, удирдаж, зохицуулах шаардлагатай бөгөөд авлигад өртөж болзошгүй бүхий л салбарыг хамрах нь зүйтэй.

II.3. Нийгмийн оролцоог дэмжих

Үр дүнтэй стратеги нь авлигын үр уршиг, аюул заналын талаар олон нийтийн мэдлэгийг нэмэгдүүлэх арга замыг тусгасан байх учиртай. Стратегийн боловсруулалт, хэрэгжилтийн шатанд нийгмийн идэвхитэй дэмжлэгийг олж авахын тулд стратегийн эхний шатнаас эхлэн нийгмийн оролцоог хангах хэрэгтэй. Үүний тулд (13 дугаар зүйлд заасан) стратегийн загвар гаргах, агуулга тодорхойлох, боловсруулах, батлах, хэрэгжүүлэх, хянах, мөн гарсан ахиц дэвшлийг хэмжих бүхий л үйл явцад нийгмийн төлөөллийг оролцуулах тодорхой арга замуудыг бодлогод тусгасан байвал зохино.

II.4. Удирдамжийг ашиглах

Тавдугаар зүйлд стратегийн иж бүрэн аргачлал-хандлагыг хөхүүлэн дэмжсэнээр Конвенцийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх тухай заалтууд тусгагдсан. Авлигын олон талт мөн чанараас хамаарч авлигаас сэргийлэх, авилгыг хянахын тулд олон талт иж бүрэн арга хэмжээ шаардлагатай талаар бодлого боловсруулагчид болон мэргэжилтнүүд санал нэгддэг болохыг эндээс харж болно. Ийм стратегийн янз бүрийн бүрэлдэхүүн хэсгүүдийг Конвенцийн хоёрдугаар бүлгийн удаах зүйлүүдэд тодорхой тусгасан. Гэхдээ бодлого боловсруулагчдын зүгээс Конвенцийн нэгдмэл цогц чанарыг бүрэн ухамсарлахын зэрэгцээ Конвенцийг иж бүрнээр нь тусгасан бүрдэл хэсгүүд бүхий стратегийг боловсруулах учиртай.

II.5. Олон улсын хамтын ажиллагаа

Оролцогч улсууд нь авлигын эсрэг стратеги болон бусад хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан авлигаас урьдчилан сэргийлэх бодит оролдлого хүчин чармайлтаа, мөн тэдгээрийн үр дүн, учир шалтгааныг тодорхойлох арга замуудаа ч байнга сайжруулах шаардлагатайг хэзээд санаж байвал зохино. Үр дүн нь туршилтаар батлагдсан арга хэмжээг цаашид хөгжүүлж, сонирхсон улс орнуудад түгээн дэлгэрүүлж, илүү өргөн хүрээнд үр дүнтэйгээр нэвтрүүлэх нь чухал. Оролцогч улсууд нь зохистой, үр өгөөжтэй тэргүүн туршлагауудыг бүх шатанд олж тогтоож, өөрийн болгож, дүн шинжилгээ хийж, дэлгэрүүлж шинэчлэн сайжруулах арга замыг боловсруулж хэрэгжүүлдэг байх нь зүйтэй.

III. Стратеги боловсруулах

Төрийн шийдвэр гаргагчид нь дараах гол асуудлуудыг авч үзвэл зохино:

- Стратегийг хэн голлон боловсруулах ёстой вэ?
- Стратеги боловсруулах үйл явц дахь төрийн болон төрийн бус байгууллагуудын төлөөллүүдийг өргөн хүрээтэй оролцуулахын тулд ямар нэг холбоо, эвсэл байгуулах хэрэгтэй юу? Үүнийг зөвлөлгөөн хэлбэрээр явуулахад хангалттай юу?
- Стратегийн хэрэгжилтийг хэн хариуцаж хянах вэ?

- Үйл явцыг хэрхэн үнэлж тодорхойлох вэ?
- Стратегийг шаардлагатай үед хэрхэн хянаж өөрчлөлт оруулах вэ?

Авлигаас сэргийлэх стратегийг боловсруулах гол хариуцлага төрд ноогдоно. Ийм стратеги боловсруулахад маш их дэмжлэг шаардагдах нь тодорхой. Түүнчлэн энэхүү үүргийг хүлээсэн байгуулга, нэгж эсвэл хувь хүнд тодорхой, тусгай эрх олгох замаар төр болон олон нийт дунд энэхүү дэмжлэгийг тодорхой байдлаар илэрхийлж гаргаж ирнэ. Энэ эрх үүргийг тухайн даалгаврыг биелүүлэхэд шаардлагатай эрх мэдэл мөн материаллаг нөөц дагалдана. Стратеги боловсруулах үйл явц харилцан зөвшилцсөн мөн олныг хамарсан байдлаар явагдана. Иргэний нийгэм, хувийн хэвшлийн оролцоо стратегийн агуулгыг баяжуулж, хүлээн зөвшөөрөгдөх магадлалыг нэмэгдүүлэх сайн талтай. Боловсруулах үйл явц нь стратегийн эхний үе шат тул авлига тохиолдсон газар болон учир шалтгааны талаархи мэдээллийг цуглуулж, харьцуулж, дүн шинжилгээ хийнэ.

Стратегиэр тодорхой, хүрч болохуйц зорилго тавьж, хэрэгжих цаг хугацаа болон тусгай зорилтуудад хүрэх үе шат, дараалалыг тодорхой тусгаж өгөх хэрэгтэй. Эдгээр нь олон нийтэд нээлттэй, ил тод байж, олны дэмжлэгийг авах шаардлагатай. Түүнчлэн дараа дараагийн үйл ажиллагааг төлөвлөх мөн өнгөрсөн болон одоо явагдаж буй үйл ажиллагаанд үнэлэлт өгөхийн тулд урьдаас тогтоосон хуваарийн дагуу нягтлан үзэж шаардлагатай өөрчлөлтүүдийг тусгаж байх нь чухал.

Стратеги нь төрийн байгууллагын шаардлага, хандлага, өвөрмөц байдлаас гадна хувийн хэвшил болон иргэний нийгмийн санал, шаардлагыг харгалзаж ерөнхий хандлагыг тусгасан байх учиртай. Ингэснээр энэхүү стратеги нь бодитой, асуудлыг үнэлж эмхэлсэн, хэмжигдэхүйц бодлогын хүрээний үүрэг гүйцэтгэж оролцогч байгууллагууд нөхцөл байдалд мониторинг хийх, хянан шалгах, өөрчлөлт хийхдээ ашиглах боломж бүрдүүлнэ.

Стратегийн хэрэгжилт болон хариуцлагыг Зургаадугаар зүйлд заасан байгууллага буюу байгууллагуудад хариуцана. Тэдний бүрэн эрхэд хамаарах асуудлыг удаах бүлгүүдэд авч үзэх хэдий ч, стратегийн хэрэгжилтэд гүйцэтгэх үүрэг хариуцлагыг тогтоохдоо байгууллага буюу байгууллагуудын эрх мэдлийн цар хүрээг тооцож үзэх нь чухал. Стратеги нь ерөнхий удирдамж чиглэл олгох үндсэн зорилготой. Удирдамжийн хүрээнд стратеги, төрийн бүх байгууллагыг хамарч байгааг баталгаажуулахын тулд аж ахуйн нэгж байгууллага тусгай үйл ажиллагааны төлөвлөгөө боловруулж хэрэгжүүлэх учиртай. Үйл ажиллагааны төлөвлөгөө нь энэ стратеги зүгээр нэг хандлага төлөвлөгөөг зарласан хэрэг биш гэдгийг баталж өгнө. Итгэл төрүүлэхүйц байхын тулд үйл ажиллагааны төлөвлөгөө нь уялдаа холбоотой байхаас гадна тодорхой, хэмжиж болохуйц зорилтуудтай байх хэрэгтэй. Түүнчлэн эдгээрийг хэрэгжүүлж, тогтмол үнэлж, тохируулан өөрчилж байх болно гэдгийг баталсан байх нь чухал. Ялангуяа, авилгатай тэмцэх үндсэн аргуудын нэг нь үр дүнтэй байдлаар тогтмол хянан шалгаж, нягтлан үзэж байх явдал юм. Үүнийг институцийн түвшинд зохион байгуулж, уялдан зохицуулах хэрэгтэй гэдгээс авлигаас урьдчилан сэргийлэх стратегийг хариуцсан бие даасан байгууллага байх нь зайлшгүй чухал хэмээн дүгнэх боломжтой.

IV. Стратегийн бүтэц

Дээрх хоёрдугаар дэд бүлгийн хүрээнд үнэлгээг хийсний дараа стратегийг хэд хэдэн үе шаттайгаар хийнэ. Хамгийн эхний үе шатанд асуудлуудаа ач холбогдлоор нь эрэмбэлэн дарааллуулж, стратеги хэдий хугацаагаар үргэлжлэхийг тооцоолж, үүнийг хэрэгжүүлэхийн тулд шаардлагатай нөөцийг тодорхойлж боловсруулалт хийдэг. Үнэлгээнд төрийн захиргааны бүх байгууллага, шаардлагатай гэж үзвэл ямар нэг мэдээлэл орхигдсон байхаас сэргийлж хувийн хэвшил ч мөн хамрагдах ёстой. Энэ шатны стратеги нь цаашдын үйл явцыг үнэлэхэд харьцуулж үзэх суурь нөхцөл болж байгаа юм. Үүний дараагийн загвар гаргах үе шатанд стратеги болон түүний бүрдэл хэсэг бүрд таарсан тодорхой, хэрэгжихүйц зорилтууд болон тэдгээрийн биелэлтийг хэмжих гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг тодорхойлно.

Стратегийг түгээх үе шатанд оролцогчид болон олон нийтэд авлигын мөн чанар, цар хүрээ, үр нөлөөний талаар мэдлэг олгоно. Ийнхүү мэдлэг олгож, танин мэдүүлснээр авлигаас сэргийлэх стратегийг ойлгож үнэлэх явдлыг нэмэгдүүлж, авлигаас сэргийлэх арга хэмжээний хүрээнд хувийн хэвшил, иргэний нийгэм, төрийн бус байгууллагын дэмжлэг хүлээж, хүн амын дунд төрийн үйлчилгээнд шударга байдал, үйл ажиллагааны өндөр стандартыг шаардах явдлыг урамшуулж дэмжиж өгөх юм. Эцэст нь, хяналтын үе шатанд гарсан ахиц дэвшилд стратегитэй харьцуулсан үнэлэлт өгч, стратегийн чухал бүрэлдэхүүн хэсгүүдийн хэрэгжилт болон тэдгээрийн авлига дахь үр нөлөөний талаар мэдээллээр тогтмол хангаж, стратегийн шинжтэй амжилт, алдаа дутагдлыг харгалзан үзэж, стратегийн бүрэлдэхүүн хэсгүүдийг хэрхэн өөрчилж сайжруулах, юуг илүүтэйгээр чухалчилж үзэх хэрэгтэй байгаа талаар шийдвэр гаргана.

Зургаадугаар зүйл: Авлигаас урьдчилан сэргийлэх байгууллага буюу байгууллагууд

1. Оролцогч улс бүр эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн, зохистой гэж үзвэл авлигаас дор дурдсан арга хэлбэрээр урьдчилан сэргийлэх байгууллага буюу байгууллагууд ажиллуулах явдлыг хангана:

(a) энэхүү конвенцийн 5 дугаар зүйлд дурдсан бодлогыг хэрэгжүүлэх, шаардлагатай тохиолдолд бодлогын хэрэгжилтэд хяналт тавьж, уялдуулан зохицуулах;

(b) авлигаас урьдчилан сэргийлэх талаархи мэдлэгийг нэмэгдүүлж, түгээх;

2. Оролцогч улс бүр эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан байгууллага буюу байгууллагуудыг чиг үүргээ үр дүнтэйгээр, аливаа зүй бус нөлөөллөөс ангид биелүүлэхэд шаардлагатай хараат бус байдлыг олгоно. Шаардлагатай материаллаг нөөц болон мэргэшсэн боловсон хүчин, түүнчлэн боловсон хүчнийг нь чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардагдах сургалтаар хангавал зохино.

3. Оролцогч улс бүр авлигаас урьдчилан сэргийлэх тусгай арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлэхэд нь бусад оролцогч улсад туслах эрх бүхий байгууллага буюу байгууллагуудын нэр, хаягийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад мэдээнэ.

I. Ерөнхий тойм

5,6 дугаар зүйлд зааснаар авлигаас сэргийлэх стратегийг бүрэн эрх олгогдсон институцийн түвшинд анхаарч үзэх хэрэгтэйг зааж өгсөн байна. Гэхдээ Конвенцид энэхүү институцийн түвшингийн хариуцлага нэг агентлагт ногдох эсвэл нэгээс илүү агентлагт ноогдох эсэхийг зааж өгөөгүй. Энэ зүйлийн хэрэгжилтээс үзэхэд авлигын эсрэг мэргэжлийн хяналтын алба шаардлагатай эсэхийг урьдчилан олж тогтоох тухай 36 дугаар зүйлийг ч мөн анхаарч үзэх хэрэгтэй болно. Зургаадугаар зүйлд заасны дагуу байгууллага буюу байгууллагууд авлигаас урьдчилан сэргийлэхэд ялангуяа тавдугаар зүйлд заасан урьдчилан сэргийлэх бодлогын хэрэгжилтэд гол анхаарлаа хандуулах нь зүйтэй.

Бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн загвар байхгүй боловч оролцогч улсууд нь авлигаас сэргийлэх байгууллага буюу байгууллагуудын үр нөлөөг дээшлүүлэхэд ач холбогдолтой хэмээн тодорхойлсон нэлээн хэдэн онцлог бүтэц зохион байгуулалтыг судалж үзэж болно.

II. Бодит бэрхшээл ба шийдэл

II.1. Авлигаас урьдчилан сэргийлэх байгууллага

Тавдугаар зүйлийн дагуу боловсруулсан стратеги болон бодлогын хэрэгжилтийг хангахын тулд байгууллага буюу байгууллагууд дараах асуудлуудыг шийдвэрлэх хэрэгтэй болно. Үүнд, аль ч салбарт хэрхэн шударга, тогтвортой хандлагыг бий болгох; байгууллага буюу байгууллагууд бусад салбарын хүрээнд мөн адил эрх мэдэлтэй байж үйл ажиллагаагаа явуулах эрхзүйн тогтолцоог бий болгох; бодлогын уялдаа холбоо бүхий хэрэгжилтийг хангах мөн байцаалт, судалгаа, хянан шалгалт гэх мэт шаардлагатай үйл ажиллагааг авч хэрэгжүүлэх арга замыг тодорхойлох, албан томилгоонд ил тод, шударга байж, танил тал харахгүй байх явдлыг хангахаас гадна ажилтны ажлын байр, бүрэн эрхийг баталгаажуулж өгөх; байгууллагыг бүрэн эрхээ үр дүнтэйгээр хэрэгжүүлэх үйл ажиллагааны бие даасан байдлаар хангах; төсөв болон тайлан мэдээний зохих орчинг бүрдүүлэх орно.

Оролцогч улсууд нь институцийн ерөнхий тогтолцоог бүрэлдүүлэхдээ урьд байсан байгууллагадаа түшиглэх, илүү үүрэг ноогдуулах замаар авч үлдэх болон шинэ байгууллага байгуулах хувилбаруудаас сонгох боломжтой. Эдгээрийн аль аль нь өөрийн онцлог хүндрэл бэрхшээлтэй байх бөгөөд оролцогч улсууд нь шинээр байгуулагдсан байгууллагын ач холбогдлыг хуучин байсан байгууллагын үйл ажиллагаатай харьцуулан үнэлж цэгнэх нь зүйтэй. Цаашлаад шинэ байгууллагын эрх мэдэл, үйл ажиллагааны гүйцэтгэлд хуучин байгууллагын нөлөөг тунгаан үзэх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл шинээр байгууллага байгуулах талаар шийдвэр гаргахын тулд хуучин байгууллагын үүрэг, үйл ажиллагааг нягтлан шалгаж үзэх нь чухал.

Шинэ байгууллагын ач холбогдол:

- Шинээр байгууллага байгуулах нь шинэ эхлэл, шинэ үүрэг амлалт зориулалтыг илэрхийлдэг.

- хуучин байгууллага итгэл төрүүлэхээ нэгэнтээ больж хэвшил болсон амжилтгүй үйлдлүүдийг өөрчлөхөд хүндрэл учирч болзошгүй.
- хуучин байгууллагын боловсон хүчин байгууллагын шинэ чиг үүргийг биелүүлэхэд шаардлагатай ур чадварыг эзэмшээгүй байх талтай
- Шинэ байгууллагад тухайн нөхцөл байдалд таарсан эрх мэдэл олгогдох боломжтой.

Нөгөөтэйгүүр урьд байсан хуучин байгууллага дараах давуу талыг агуулдаг.

- хуучин байгууллага нь орон байр, мэргэшсэн боловсон хүчин, хуулиар олгогдсон эрх мэдэл, дотоод журамтай байх ба шинэ байгууллага байгуулахад эдгээрийг шинээр бий болгох шаардлагатай тул зардал өндөр гарах эрсдэлтэй.
- хуучин байгууллага нь угаас өндөр түвшний итгэл хүлээсэн байж болох ба үр нөлөөг нь сайжруулахын тулд тэдний ажил үүргийн хуваарь буюу эрх мэдэлд өөрчлөлт оруулах асуудал яригдаж болох юм.
- Шинээр байгууллага байгуулснаар хуучин байгууллагыг хэвээр авч үлдэх эсвэл бүрэн татан буулгах талаар шийдвэр гаргах хэрэгтэй болно. Хэвээр авч үлдсэнээр хурцадмал байдал үүсгэж, зөрчил мөргөлдөөн гарах магадлалтай бол, татан буулгаснаар хуучин байгууллагад хувийн ашиг сонирхолтой байсан этгээдүүдийн эсэргүүцэлтэй зайлшгүй тулгарна.

II.2. Бүрэн эрх, эрх мэдэл

Байгууллага буюу байгууллагууд нь тавдугаар зүйлийн дагуу боловсруулсан стратегийн хүрээнд үр дүнтэй, уялдаа холбоотой бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, нягтлан үзэх, хянан шалгах үүргийг хүлээнэ. Авлигын эсрэг стратегид төрийн байгууллага, хувийн хэвшил, сайн дурын болон төрийн бус байгууллага, иргэний нийгмийг хамарсан чиг үүрэг хариуцлагын тогтолцоог тусгасан байх боломжтой.

Стратегийн дагуу, байгууллага буюу байгууллагууд авлигаас сэргийлэхэд чиглэсэн үр дүнтэй дадлыг хэвшүүлж, дэмжих учиртай. Авлигаас сэргийлэх түүнтэй тэмцэх зорилгоор холбогдох эрх-зүйн баримт бичиг, захиргааны арга хэмжээнд тогтмол үнэлэлт өгч байх нь чухал.

Авилгатай тэмцэх байгууллагуудад олгох олон төрлийн эрх мэдэл байж болохыг туршлага харуулж байна. Конвенц, ийм байгууллагын (захиргааны эсвэл эрх-зүйн гэх мэт) тодорхой тогтолцоонд хариу үйлдэл үзүүлэх шаардлага болон улс бүрт зонхилсон нөхцөл байдлыг харгалзан үзэж энэ сонголтыг хийх эрхийг оролцогч улс эдэлдэг. Тэгэхээр авилгатай тэмцэх зарим байгууллага зөвхөн авлигаас сэргийлэх асуудлыг хариуцдаг байхад өөр бусад нь сэргийлэхээс авахуулаад мөрдөн байцаах, яллах гэх мэт өргөн хүрээний эрх мэдэлтэй байж болно гэсэн үг.

Эрх мэдлийн цар хүрээ ямар байхаас үл хамааран байгууллага буюу байгууллагууд үйл ажиллагаагаа явуулахын тулд хуулиар олгогдсон албан ёсны эрх мэдэлтэй байх ёстой. Ийм эрх мэдлийн хүрээнд дараах элементүүд багтаж болно:

- Тухайн байгууллага эсвэл байгууллагуудыг конвенцид заасан бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх хууль ёсны эрх мэдлийг олгох;
- Байгууллагад удирдамж гарын авлага хэвлэж гаргах, удирдлагын дүрэм журам боловсруулах боломж олгох
- Хууль тогтоомж боловсруулахад зөвлөмж өгөх, мөн авлигаас сэргийлэхтэй холбоотой хууль тогтоомж батлан гаргахаас өмнө тус байгууллагатай зөвлөлдөх шаардлагыг тусгах;
- Байцаалт явуулах эрх мэдэл олгосон үед, байгууллагад өөрийн санаачлагаар¹ байцаалт эхлүүлэхийг зөвшөөрөх, түүнчлэн байцаалтын үр дүнг байгууллага өөрөө дамжуулахаас өмнө аль нэг хэсгийг нь дамжуулахыг шаардахгүй байх;
- Шүүхийн баримт бичиг, мэдээлэл, мэдүүлэг болон бусад нотлох баримтыг шаардах эрх олгох;
- Шаардлагатай үед холбогдох хууль сахиулах байгуулагыг оролцуулан авлигаас сэргийлэх үйл ажиллагаа явуулдаг дотоодын болон олон улсын байгууллагуудтай мэдээлэл солилцох боломжоор хангах;
- Үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай зохих бие даасан байдлаар хангах;
- Байгууллагын ажилтан албан хаагч албан үүргээ шударгаар гүйцэтгэх явцад учирч болзошгүй аливаа гүтгэлэг, нэхэмжлэлээс хамгаалах
- Зохих түвшинд хариуцлага хүлээх, тайлагнах боломжоор хангах;
- Байгууллагыг зохих удирдлагаар хангах;
- Зохих материаллаг нөөцөөр хангах;

II.3. Байгууллагын чиг үүрэг

Байгууллага буюу байгууллагууд нь холбогдох эрхзүйн тогтолцооныхоо хүрээнд эрх үүргийн онцлог болон цар хүрээнээсээ хамааран дараах үүргүүдийг гүйцэтгэнэ. Үүнд, хувийн хэвшлийн байгууллагаас тусгай үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэхийг шаардаж, хэрэгжилтийн үед удирдлага, чиглэл хяналтаар хангах; байгууллагын талаар үнэлэлт ЮгЮх эсвэл шалгалт хийх; олон нийтийн гомдол, саналыг хүлээн авч, хянаж үзэх, авлигын эсрэг мөрдөн байцаалт хийх эрх бүхий байгууллагаас хөндлөнгийн хяналтын, шалган тогтоох болон парламентын тайлан хүлээн авах; эрх-зүй болон захиргааны процедурын судалгаа хийх, олон нийтийн дунд судалгаа хийх мөн мэдээллийн бусад эх үүсвэрийг боловсруулах; авлигаас сэргийлэх төлөвлөгөөний талаар ахиц дэвшлийг нягталж үзэхээр сонголт, хурлыг тогтмол зохион байгуулж, нотолгоо мэдүүлэг цуглуулах орно. Эцэст нь, байгууллага буюу байгууллагууд зургаадугаар зүйлд заасан арга хэмжээг дэмжиж, хөгжүүлэхэд бусад агентлагууд түүнчлэн

холбогдох олон улсын болон бус нутгийн байгууллагуудтай хамтран ажиллахаар гэрээ, хэлэлцээр хийж авлигаас сэргийлэхэд чиглэсэн олон улсын хөтөлбөр, төсөлд хамрагдах нь зүйтэй.

Байгууллага буюу байгууллагууд урьчилан сэргийлэх ажил хийгээд ерөнхий боловсролын болон их дээд сургуулийн хичээлийн хөтөлбөрт авлигаас урьдчилан сэргийлэх сэдвийг оруулах үүднээс авлигаас сэргийлэх арга хэмжээний талаарх мэдээллийг зохих агентлаг, олон нийт, төрийн бус байгууллага болон боловсролын байгууллагуудад түгээн дэлгэрүүлэхийн тулд хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллах хэрэгтэй. Байгууллага буюу байгууллагууд тайлангаа нийтлэх эрхтэй байна. Түүнчлэн удирдамж, гарын авлагыг аль болох өргөн дэлгэр тарааж түгээх нь зүйтэй.

Гол анхаарал урьдчилан сэргийлэх бодлого, дадал дээр төвлөрөхийн зэрэгцээ, байгууллага буюу байгууллагууд хувь хүний мэдээллийг (ялангуяа хууль сахиулах байгууллагын байцаалт, магадгүй цаашид үүсэх яллах үйл явцад сөргөөр нөлөөлөхөөс сэргийлж) хэрхэн шийдвэрлэх зэрэг асуудлаар бусад агентлагтай ажлаа уялдуулахын тулд зохих арга хэмжээг авч, урт хугацааны стратегийн хэтийн төлөвийг тодорхойлохдоо аль нэг талыг барьсан туйлширсан хандлагыг бус тэнцвэртэй байдлыг хадгална.

II.4. Хараат бус байдал ба хариуцлага

Байгууллага нь хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагааны бие даасан статусаа хадгалж өөрийн ажлын хөтөлбөр төлөвлөгөөг боловсруулж хуулиар олгогдсон чиг үүргээ хэрэгжүүлэхээр шийдвэр гаргана. Бие даасан байдлын тухайд, дараах асуудлуудыг авч үзэх шаардлагатай:

Захирал болон бусад өндөр албан тушаалын ажилтны томилгоо, бүрэн эрхийн хугацаа болон албан тушаалаас чөлөөлөх тухай дүрэм журам; байгууллага болон хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүн; зохих санхүүгийн нөөц болон боловсон хүчний цалин хөлс; зохих төсөв; хүнээ олж ажилд авах, томилох, сонгох, үнэлэх, урамшуулах журам, хууль тогтоох байгууллага болон төрийн бусад байгууллагад тогтмол тайлагнаж байх үүрэг; бусад агентлагтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох албан ёсны дэг жаяг; иргэний нийгэм болон хэвлэл мэдээллийн оролцоог тогтоох зөвшилцөл. Байгууллага болон байгууллагын ажилтан албан хаагчид агентлагийн эрх мэдэл болон өөрийн чиг үүргийн хүрээнд, эрхэлсэн үйл хэргийнхээ улмаас шүүхэд татагдах, гүтгэлэгт өртөхөөс шударгаар хамгаалагдсан байвал зохино (гэхдээ энэ нь дор дурдсанчлан зохих ёсны шүүхийн хяналтанд хориг учруулах ёсгүй).

Байгууллагын бие даасан байдлыг хангах, хариуцлага ноогдуулах арга хэрэгслийг (байгууллагыг хялбархан байгуулж мөн татан буулгаж чадах) ямар нэг зарлиг тогтоолоос илүүтэйгээр хуулиар зохицуулах нь зүйтэй. Туршлагаас харахад байгууллагын бие даасан байдлыг хуулиар тогтоох буюу үндсэн хуулийн түвшинд баталгаажсан байх нь үр дүнтэй бодлого хэрэгжүүлэх эрх мэдэлтэй, тогтвортой сэтгэгдэл төрүүлэх магадлалыг нэмэгдүүлдэг. Байгууллага буюу байгууллагууд нь өөрсдийн өгсөн зөвлөмжийн бодит хэрэгжилтийг нягтлан үзэх эрхтэй байхаас гадна авлигаас сэргийлэх талаар мэдлэг чадвар бүхий боловсон хүчин

бэлтгэх, ажиллуулах боломжоор хангагдсан байх нь зүйтэй. Мөн төрийн албан хаагчид ба олон нийтэд танигдаж, мэдээллийн эх сурвалж нь байж, тэдэнтэй ойр ажиллаж ажлаа олон нийтэд тогтмол тайлагнадаг байх хэрэгтэй.

Бие даасан байдлыг хариуцлага хүлээх чадвартай сөргүүлж тавихгүй байвал зохино. Авилгатай тэмцэх байгууллага нь үр нөлөөтэй хяналт шалгалт болон тэнцвэртэй байдлыг агуулсан, хэн ч, юу ч хуулийн дагуу байхыг шаарддаг, урьдаас тогтоосон засаглалын тогтолцооны хүрээнд үйл ажиллагаагаа явуулах учиртай. Улсын Их Хурал болон түүний хороод гэх мэт эрх бүхий институцид тайлагнаж, хянан шалгуулах хөндлөнгийн хянаншалгалтанд хамрагдах мөн зарим тохиолдолд шүүхийн хянан шалгалт болон шүүх хуралд тайлагнах замаар байгууллага буюу байгууллагуудын ил тод байдал, хариуцлага хүлээх чадварыг батлах механизмаар бие даасан байдлыг тэнцвэржүүлнэ.

Иймэрхүү үйл явцад авилгатай тэмцэх ажлын онцлог, нарийн байдлаас шалтгаалан нууц хадгалах шаардлагыг хангах хэрэгтэй. Эдгээр байгууллага нь хүний эрх чөлөө, эд хөрөнгө, нэр хүндийг эрсдэлд оруулах магадлалтай байр суурьтай болох нь элбэг, иймээс дүгнэлт боловсруулах хүртэл мэдээллийг чандлан хадгалах үүрэг хүлээнэ.

Байгууллага буюу байгууллагууд нь өөрийн үйл ажиллагааг хэрхэн явуулахаа бие даан шийдвэрлэх бөгөөд энэ нь тухайн байгууллагын бие даасан байдлыг илтгэхийн зэрэгцээ олон нийтэд өөрсдийгөө таниулах арга хэрэгсэл болно. Тухайлбал, байгууллага буюу байгууллагууд өөрийн ажлыг олон нийтэд хүртээлтэй байхыг нээлттэй шүүх хурлаар дамжуулан илэрхийлж болно. Энэ хурал нь авлигын нотолгоог ил гаргах болон авлигын талаар ард нийтэд мэдлэг мэдээлэл өгөх чухал хэрэгсэл болох юм.

Үүнээс гадна, байцаалтын шударга байдлыг хадгалах, гэрч болон мэдээллийн эх сурвалжийг хамгаалах, дараа нь гэмт болон сахилгын хэргээр буруутгах үйл явцад хэрэглэгдэж болох мэдээлэл авах, өөр бусад шүүн таслах ажиллагаанд хөндлөнгөөс оролцохоос зайлсхийх, хувь хүний нэр хүндийг шаардлагагүйгээр унагахаас сэргийлэхийн тулд тусгаарласан сонсгол явуулж болно. Гэхдээ байгууллага буюу байгууллагууд төрийн шударга байх зарчмыг баримтлахад өөрийн үүргийг тодотгох үүднээс дүгнэлт болон тайлангаа хэвлэн нийтлэх ерөнхий бодлоготой байна.

II.5. Материаллаг нөөц

Авлигатай тэмцэх байгууллага буюу байгууллагууд нь зохих түвшинд хангалттай хэмжээгээр санхүүжигдсэн байх нь чухал. Үүнийг хийх нэг арга нь байгууллага жилийн ажлын төлөвлөгөө болон төсвийн нарийвчилсан танилцуулгаа хууль тогтоох байгууллагын төсвийн хороонд батлуулахаар өргөн барих юм. Байгууллагын санхүүжилтийн гэрээг аль болох олон жилээр хийвэл зохино. Ингэснээр хууль тогтоох байгуулгын өөрийн төсөв батлах эрх мэдлээ байгууллагын бие даасан байдлыг хязгаарлах эсвэл тодорхой авлигын хэргүүдтэй холбоотойгоор зохисгүй нөлөөлөл үзүүлэхэд ашиглах магадлалыг багасгаж өгөх юм. Өөр нэг арга нь байгууллага бүх татаасаа нэг удаад авснаар өөрийн төсвийн тодорхой асуудлаар хууль тогтоох байгууллагын нөлөөллөөс ангид үлдэж болох арга юм. Санхүүгээ хэрхэн зарцуулах нь

байгууллагын эрхийн асуудал ч байгууллага жил бүр нягтлан бодох бүртгэлийн тайлан тооцоогоо өргөн барьж төрийн дүйцэх байгууллагын жишгээр хөндлөнгийн хянан шалгалтанд хамрагдана.

Хэдийгээр зохих нөөцийг олж авах олон арга зам байдаг ч гол нь авилгатай тэмцэх байгууллага буюу байгууллагуудын бие даасан байдлыг хадгалж үлдэх явдал юм.

II.6. Мэргэшсэн боловсон хүчин ба сургалт

Байгууллага буюу байгууллагууд нь жилийн ажлын төлөвлөгөө болон төсвийн хэмжээнд тааруулан боловсон хүчний хэрэгцээгээ тогтооно. Тэдгээрийг байгуулсан эрх бүхий субъект авилгатай тэмцэх байгууллагад өөрийн боловсон хүчний бодлогоо төлөвлөж, боловсон хүчний тоо, мэргэжлийн болзол нөхцлийг тогтоож, шаардлагатай мэргэшил болон сургалтын болзол нөхцөл, хэрэгцээг тодорхойлох эрхийг олгох хэрэгтэй. Ил тод байдлыг хангах үүднээс, байгууллага нь ажилтан сонгож авах, томилох журмаа хэвлэн нийтэлсэн байвал зохино. Энэ нь Конвенцийн долоодугаар зүйлд заасан төрийн албанд томилолт хийх шаардлагатай нийцсэн байхаас гадна хөндлөнгийн хяналтанд хамрагдах учиртай.

Долоодугаар зүйл: Төрийн алба

1. Оролцогч улс бүр шаардлагатай гэж үзвэл эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн төрийн албан хаагч, түүнчлэн зохих тохиолдолд сонгогддоггүй төрийн бусад албан тушаалтныг сонгон шалгаруулах, ажилд авах, ажиллуулах, албан тушаал дэвшүүлэх, чөлөөлөх талаар дор дурдсан тогтолцоог бий болгох, хэрэгжүүлэх, бэхжүүлэхийг чармайна:

(a) үр ашигтай, ил тод байх зарчим болон мэдлэг чадвар, эрх тэгш байдал, авъяас зэрэг бодит шалгуурт үндэслэсэн;

(b) авлигад ялангуяа өртөмтгий гэж тооцогдох төрийн албан тушаалд хувь этгээдийг сонгон шалгаруулж авах, сургах, шаардлагатай гэж үзвэл, тэдгээр хүмүүсийг өөр албан тушаалд шилжүүлж байх талаар хангалттай журмыг багтаасан;

(c) оролцогч улсын эдийн засгийн хөгжлийн түвшинг харгалзан хангалттай урамшуулал, тэгш шударга цалингийн түвшинг дэмжсэн;

(d) тэднийг төрийн чиг үүргийг зөв, нэр төртэй бөгөөд зохих ёсоор хэрэгжүүлэх шаардлагыг хангахуйц боловсрол, сургалтын хөтөлбөрийг хөхиүлэн дэмжсэн, түүнчлэн чиг үүргээ биелүүлэхэд нь гарч болзошгүй авлигын эрсдлийн талаархи мэдлэгийг нь дээшлүүлэхэд чиглэсэн зохих тусгай сургалтанд хамруулсан байна. Ийм хөтөлбөр нь холбогдох салбарт мөрддөг ёс зүйн дүрэм, жишгийг багтаасан байна.

2. Оролцогч улс бүр энэхүү конвенцийн зорилго, дотоодын хууль тогтоомжийнхоо тулгуур зарчимд нийцүүлэн төрийн албан тушаалд нэр дэвших, сонгох шалгуурыг тогтооход чиглэгдсэн хууль тогтоох болон захиргааны зохих арга хэмжээг авах асуудлыг авч үзнэ.

3. Оролцогч улс бүр энэхүү конвенцийн зорилго, дотоодын хууль тогтоомжийнхоо тулгуур зарчимд нийцүүлэн сонгуулиар томилогддог төрийн албан тушаалтанд нэр дэвшүүлэх үйл ажиллагааны санхүүжилт, шаардлагатай гэж үзвэл улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдлыг дээшлүүлэхэд чиглэгдсэн хууль тогтоох болон захиргааны зохих арга хэмжээг авах асуудлыг мөн авч үзнэ.

4. Оролцогч улс бүр дотоодын хууль тогтоомжийнхоо тулгуур зарчимд нийцүүлэн ил тод байдлыг дэмжих бөгөөд сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тогтолцоог бий болгох, хэрэгжүүлэх, бэхжүүлэхийг чармайна.

I. Ерөнхий тойм

Конвенцын хоёрдугаар зүйлд, төрийн үйлчилгээний бүхий л боловсон хүчин болон төрийн албанд сонгогдон ажиллаж буй албан тушаалтанд хамаарах “албан хаагч” хэмээх нэр томъёог өргөн хүрээнд, ойлгомжтой байдлаар тодорхойлсон. Төрийн албанд томилох явдал нь сонгон шалгаруултан дээр харин албан тушаал хаших явц нь ил тод бодлого, дүрэм журам болон мэдлэг чадвар дээр үндэслэнэ. Сонгуулиар төрийн алба хашиж байгаа этгээдэд төрийн албан хаагчид зориулсан стандарт хэм хэмжээтэй төстэй шаардлага тавигдана. Иймд ёс зүйн болон авлигаас сэргийлэх шаардлага нь төрийн албаны салшгүй хэсэг бөгөөд хоёрдугаар зүйлд тодорхойлсон төрийн сонгогддог болон томилогддог бүх албан хаагчид хамаарна гэсэн үг. Наймдугаар зүйлд сонирхлын зөрчилтэй холбоотой асуудлыг авч үзсэн бол 10 болон 13 дугаар зүйлд мэдээллийн эрх чөлөө, улсын бүртгэлд нэвтрэх эрх болон ил тод байдлаар шийдвэр гаргалтын тухай өгүүлнэ.

II. Бодит бэрхшээл ба шийдэл

II.1. Төрийн албанд албан тушаалтанг сонгон шалгаруулах, ажилд авах, ажиллуулах, албан тушаал дэвшүүлэх, чөлөөлөх үр ашигтай, ил тод, бодит тогтолцоо

Үр ашигтай, ил тод, үр нөлөөтэй бөгөөд авилгагүй Төрийн тулгуур багана нь өндөр төвшний мэдлэг чадвартай, үнэнч шударга хувь хүмүүсээс боловсон хүчнээ бүрдүүлсэн төрийн үйлчилгээ юм. Оролцогч улс бүр ийм хувь хүмүүсийг татаж, ажиллуулах тогтолцоог бий болгохыг чармайх хэрэгтэй. Үүний тулд ажилтан сонгон шалгаруулах, ажилд авах, ажиллуулах, албан тушаал дэвшүүлэх журмыг мөрдүүлэх эсвэл энэ талын удирдамжаар хангах төрийн үйлчилгээний хороо гэх мэт байгууллагыг бий болгож болно. Ийм байгууллага нь зөвлөгөө өгөх (хэлтэс нэгжүүд нь харьяа боловсон хүчнээ өөрөө удирддаг), эсвэл гүйцэтгэх (байгууллага боловсон хүчний асуудлыг шууд хариуцдаг) үүрэгтэй байхаас үл хамааран эдгээр журам аль болох нийтлэг, ил тод мөн эрх тэгш байх нь чухал.

Энэ журамд шинэ албан тушаалын хэрэгцээ ажил үүргийн хуваарийг тогтоосон шаардлага, болзол нөхцлийн хамтаар тусгаж өгсөн байвал зохино. Ажлын орон тоог ил тодоор зарлаж урьдаас тохирсон сонгон шалгаруулах журмын дагуу ажилд сонгон шалгаруулна. Сонгон

шалгаруулах журамд сонгох болон томилох шалгуурыг заасан ил тод журам, нэр дэвшигчээс шаардах болзол нөхцөл хийгээд зан байдлын тодорхойлолт зэргийг оруулж өгсөн байна. Томилгоо нь урьдаас тогтсон болзол, нөхцөлтэй байхаас гадна хөдөлмөрийн хөлсний хэмжээ тухайн албан тушаалын үүрэг болон хариуцлагатай уялдсан байх шаардлагатай. Төрийн албан хаагч нь ёс зүй, ажил мэргэжлийн хувьд зохих түвшинд сургагдаж боловсорсон байна. Албан тушаалд дэвшүүлэх, шагнах болон ажлын бүтээмжтэй холбоотой үнэлж урамшуулах журам нь төрийн албанд нийтлэг тогтмол байна.

Түүнчлэн албан хаагчийн бүтээлч байдал, сургалтын хэрэгцээ, ажил мэргэжлийн ахиц болон албан тушаал дэвших байдлыг тогтоох зорилгоор жил бүр ажлын бүтээмжинд нь үнэлгээ өгч байна.

Оролцогч улс бүр төрийн албанд албан тушаалтанг сонгон шалгаруулах, ажилд авах, ажиллуулах, албан тушаал дэвшүүлэх, чөлөөлөх, огцуулах болон боловсон хүчинтэй хамаатай бусад асуудлын талаар тодорхой бүртгэл хөтлөх шаардлагыг яам, хэлтэстээ тавих нь зүйтэй. Цалингийн данс нь төрийн зарлагыг бүрдүүлэгч гол хэсэг бөгөөд үүнд тавих хяналт сулрах магадлал өндөр тул цалингийн цэс нь батлагдсан албан тушаалын орон тооны жагсаалт болон албан хаагч тус бүрийн бүртгэлийг багтаасан албан хаагчийн эсвэл байгууллагын боловсон хүчний мэдээллийн төвлөрсөн системд түшиглэсэн байх хэрэгтэй.

II.2. Авлигад өртөмтгийд тооцогдох төрийн албан тушаалд иргэнийг сонгон шалгаруулж авах, сургах журам

II.1.-д төрийн үйлчилгээний байгууллагын дагаж мөрдөх ерөнхий хандлагыг тодорхойлж өгсөн. Үүний зэрэгцээ оролцогч улсууд тодорхой албан тушаал, үйл ажиллагаа авлигад харьцангуй өртөмтгий байдгийг тооцох нь зүйтэй. Эдгээр нь албан тушаалаа урвуулан ашиглах явдлаас урьдчилан сэргийлэх өндөр төвшний арга хэмжээний баталгаа шаардана. Иймээс авлигад өртөх магадлалыг тооцоолж урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа болон процедурыг тогтоож өгөх нь чухал. II.1.-д дурдсан байгууллага нь хөндлөнгийн хянан шалгалтыг зургаадугаар зүйлд заасан байгууллага буюу байгууллагуудтай хамтран дараах зорилгоор явуулна. Үүнд:

- Авлигад өртөмтгий албан тушаал болон үйл ажиллагааг тодорхойлох,
- Авлигад өртөмтгий салбарыг шинжлэн судлах,
- Авлигад өртөмтгий салбарын үнэлгээ болон онцгой эрсдлийн талаарх тайланг тэдгээрийг шийдвэрлэхэд чиглэсэн зөвлөмжийн хамтаар бэлтгэх.

Мөн зөвлөмж болон урьдчилан сэргийлэх арга хэмжээнд дараах зүйлсийг багтааж болно: Үүнд амжилттай нэр дэвшигчийг томилолт хийгдэхээс өмнө шалгаж, нягтлах (томилогдох магадлалтай нэр дэвшигч ёс зүйн өндөр хэм хэмжээ баримталдаг эсэхийг нягтлах); амжилттай нэр дэвшигчээс албан тушаалын тусгай болзол, нөхцөл шаардах, гүйцэтгэлийг суурь үзүүлэлттэй жишиж үзэх, мөн нэг албан тушаал удаан хашсанаас үүдэлтэй авлигын магадлал, үр нөлөөг хязгаарлах үүднээс ажилтнуудыг өөр газар сэлгэн ажиллуулах гэх мэт үйл ажиллагааны хяналтыг тогтоох гэх мэт.

Удирдлагын зүгээс авлигад онцгой өртөмтгий хэмээн тооцогдох албан тушаал эрхэлж буй төрийн албан хаагчид тогтмол үнэлгээ хийх, нууцлал бүхий тайлан шаардах, мөн хөрөнгө орлогын мэдүүлэг, дайллага, бэлгийн бүртгэлийг багтаасан хяналтын арга хэмжээ авах, мэдэгдлийн үнэн зөвийг тогтмол хянах үр нөлөөтэй арга замыг нэвтрүүлэх зэргээр тусгай дэмжлэг үзүүлж хяналт тавьж байх шаардлагатай. Түүнчлэн боломжтой нөхцөлд, эрсдлийн төвшингөөс хамааран тодорхой асуудлаар шийдвэр гаргах тал дээр бүрэн эрх мэдэлтэй дан ганц хувь хүнээс бүрдсэн тогтолцооноос илүүтэйгээр олон төвшинд хянаж баталгаажуулах тогтолцоог хэвшүүлэх нь зүйтэй. Энэ нь нэг талаар боловсон хүчинг зохисгүй нөлөөллөөс хамгаалахад, нөгөө талаас шийдвэр гаргах үйл явцад бие даасан байдлыг нэвтрүүлэхэд чиглэх юм.

Үүнээс гадна зарим томоохон албан тушаалтны амьдралын хэв маягийг хянах арга замыг эрэлхийлэх хэрэгтэй. Энэ нь мэдээж маш нарийн, эмзэг асуудал бөгөөд хувь хүний хувийн амьдрал, нууцлалыг хамгаалах талаар хүчин төгөлдөр хууль тогтоомжийн хүрээнд зохих хүндэтгэлийг үзүүлж болгоомжтой хандах шаардлагатай. Ийм төрлийн хяналтанд орон байр, унаа, эсвэл мэдэгдэж буй цалингийн төвшинтэй үл уялдах амралтын стандарт хэм хэмжээ зэргийг шалгах арга хэмжээ багтана. Албан хаагчийн хөдөлмөрийн гэрээнд тусгагдсан тохиолдолд тухайн албан тушаалтны банкны хувийн дансыг шалган хянах боломжтой.

II.3. Хангалттай урамшуулал, тэгш шударга цалингийн төвшин

Анхаарч үзэх шаардлагатайтай бас нэгэн чухал асуудал бол хөгжиж буй болон эдийн засгийн шилжилтийн шатанд буй орнуудад ялангуяа төрийн албан хаагчийг хангалттай хэмжээнд цалинжуулах явдал байдаг. Цалингийн сул төвшин болон хэвшмэл байдал нь төрийн албан үүргийг цалгардуулахаас авахуулаад өөр ажил хавсарч эрхлэх, хээл хахууль авах зэрэг ёс зүйн зохимжгүй үйлдлийг өөгшүүлэх талтай. “Хангалттай” цалин хөлс гэдгийг эрхэлж буй албан тушаал, хүлээж буй хариуцлагатай харьцуулахад мөн бусад салбар дахь төстэй албан тушаалтантай жишихүйц амьжиргааны өртгийг хангах хэмжээ гэж ойлгоно. Оролцогч улс бүр цалингийн төвшинг ажил мэргэжлийн ахиц, мэргэшил дээшлүүлэх, албан тушаал ахих боломжтой уялдаатай байлгавал зохино. Төрийн албаны цалинг тогтоох арга болон шалгуур нь олон нийтэд ил тод байна.

II.4. Төрийн албан хаагчид зориулсан ёс зүйн сургалт

Төрийн албанд ажиллах явцад гарах авлигын эрсдэл болон авлигаас сэргийлэх түүнчлэн энэ талаар мэдэгдэх арга замын талаар төрийн албан хаагчийн мэдлэгийг авлигын талаар сургалт явуулах болон тогтмол мэдээлэл цуглуулах замаар дээшлүүлнэ. Төрийн албыг бүхэлд нь хамарсан цогц, тогтмол сургалтын хөтөлбөр бий болгох арга замыг хайх хэрэгтэй бөгөөд тусгай зорилтот хөтөлбөр болон сургалтууд нь энэ цогц хөтөлбөрт тулгуурлаж болно. Ингэснээр төрийн албан хаагч бүр анх ажилд орохдоо төдийгүй ажиллах явцдаа ялангуяа авлигад өртөх эрсдэл бүхий албан тушаалд ажиллаж буй тохиолдолд мэргэжлийн ёс зүйн сургалтанд хамрагдаж байх нь ач холбогдолтой байдаг. Сургалтанд бодит амьдралд суурилсан тусгай асуудлын шийд болон тулгараад буй асуудлыг ил гаргаж ирэх, мэдэгдэх тохиромжтой арга

замын талаар хэлэлцүүлгийг багтаах хэрэгтэй. Ажилтнуудад тэдний эрх, үүрэг болон үүргийн гүйцэтгэлтэй холбоотой авилга эсвэл албан тушаалаа урвуулан ашиглах эрсдлийн талаар хангалттай мэдлэг өгснөөр албан хаагчаас шаардах ёс зүйн ач холбогдлыг тодотгож, шударга байх явдлыг дэмжиж өгөх юм. Жил бүрийн авлигын хяналт шалгалтанд ажилтан албан хаагчдыг оролцуулсанаар тэдний мэдлэгийг нэмэгдүүлэх, түүнчлэн тэдэнд тулгараад буй асуудал болон урьдчилан сэргийлэх арга хэмжээг тодорхойлоход тустай. Төрийн байгууллагын удирдлага дараах эх сурвалжаас авсан баримт мэдээн дээр үндэслэн тайлан бэлтгэнэ:

- Хариуцлага бүхий албан тушаалтан,
- Олон янзын эх сурвалжууд:
 - i. Удирдлагын эрсдлийн үнэлгээ,
 - ii. Эрсдлийн техникийн удирдлага,
 - iii. Гадаад, дотоод хөндлөнгийн хяналт,
 - iv. Авлигаас сэргийлэх арга хэмжээний үр дүнгийн талаарх ойлголтын талаар олон нийтийн дунд хийсэн судалгаа,
 - v. Дараах сэдвээр ажилтны судалгаа:
 1. Сургалтын ач холбогдол,
 2. Тусгай байдлаас хэвшмэл үзэгдэлд шилжих эрсдэл,
 3. Урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр дүнгийн талаарх ойлголт
 4. Ажилтны зүгээс сэжигтэй зүйлсийн талаар мэдээлэх бэлэн байдал хүсэл эрмэлзлийн талаарх илтгэл.

Төрийн байгууллага урьдчилан сэргийлэх шинэлэг арга хэмжээг санал болгох талаар ажилтныг өдөөх хөшүүрэг бодож олох хэрэгтэй. Жишээ нь, урьдчилан сэргийлэх үр нөлөө бүхий арга хэмжээг санаачилсан ажилтанг гүйцэтгэлийн үнэлгээгээр байгууллагын ажлын үр дүнг сайжруулсан хэмээн сайшааж болно.

II.5. Төрийн албанд нэр дэвших, сонгогдох шалгуурыг тогтоох

II.1 ба II.4-т төрийн албанд томилогдсон албан тушаалтанд хамаарах асуудлыг хэлэлцсэн бол оролцогч улс бүр сонгуулиар томилогддог албан тушаалын хүрээнд дээрх асуудлуудыг харгалзан шийдэж өгөх хэрэгтэй. Оролцогч улсуудын ихэнх нь сонгуульд нэр дэвших шаардлага болон сонгуулийн үйл явцын шударга байдлыг зохицуулсан хууль тогтоомж, дүрэм журмыг үндсэн хуулийн болон хууль зүйн хүрээнд зохицуулсан байна. Оролцогч улсууд нь төрийн алба хааж байгаа болон хаахаар нэр дэвшиж буй хувь хүнээс ёс зүйн өндөр стандарт хэм хэмжээг сахьдаг байхыг шаардаж болно. Үүнд зарим албан тушаалд намын гишүүн буюу тодорхой эрх бүхий албан тушаал хашиж буй этгээдийг оролцуулахгүй байх замаар улс төрийн оролцоог хязгаарласан хууль тогтоомж, дүрэм журам багтаж болно. Мөн төрийн сонгогддог албанд шинээр эсвэл хавсрах байдлаар нэр дэвшихэд үл тохирох сонгогддог болон томилогддог албан тушаалын жагсаалтыг гаргаж болно. Гэмт хэрэг, ялангуяа авилгатай холбоотой хэргийн улмаас ял шийтгэл эдэлж байсан этгээдийг төрийн алба хаах, нэр дэвшихийг хориглох заалт байж болно. Түүнчлэн нэр дэвшигчээс хөрөнгө болон орлогын бүрэн мэдүүлгийг шаардаж, нэр дэвшигч, нэр дэвшигчийн нам эсвэл дэмжигч сонгуулийн булхайд холбогдсон бол сонгуулийг хүчингүйд тооцох заалт оруулж болно.

II.6. Сонгуулийн компаниг ажил болон улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдал

Улс төрийн сонгуулийн компаниг ажил болон улс төрийн намуудын санхүүжилтийг зохицуулсан зохих дүрэм журамтай байх нь авлигаас урьдчилан сэргийлж, авлигад хяналт тавихад чухал үүрэг гүйцэтгэж ирсэн. Олон оролцогч улсад сонгогчдыг бүртгэж, сонгуулийг зохион явуулах, намуудыг бүртгэх, намын санхүүд мониторинг тавих, нэр дэвшигчийн сонгогдох эрх болон санхүүгийн мэдүүлгийг нягтлах, компаниг ажлын санхүүтэй холбоотой хуулийг мөрдүүлэх түүнчлэн холбогдох аливаа хууль бус үйл ажиллагааг мөрдөн шалгах үүрэгтэй төрийн байгууллага буюу байгууллагуудыг байгуулсан байдаг.

Ил тод санхүүжилтийг хөхүүлэн дэмжихэд чиглэсэн олон төрлийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх боломжтой. Үүнд, компаниг ажлын зарлагын хэмжээ хязгаар, зорилго болон хугацааг хэмжих хэмжигдэхүүн, хандивын хязгаарлал, хандивлагчийн тодорхойлолт (нэр тодорхойгүй, гадаадын буюу гуравдагч талын хандив эсвэл зээл зөвшөөрөгдсөн, хязгаарлагдсан эсвэл хориглосон эсэх гэх мэтийг оролцуулан), ямар төрлийн тусламж зөвшөөрөгдсөн, нам байгууллагын тооцоо болон зарлагыг өргөн барих хэлбэр ба хугацаа, орлого, зарлагыг батлах арга хэрэгсэл, хандив эсвэл зээлийг татвараас чөлөөлөх эсэх, төрд сонгуулийн зорилгоор Улсын нөөцийг ашиглахыг хориглох зэрэг арга хэрэгсэл орно. Сонгууль болон намууд нь төрөөс санхүүждэг оролцогч улсын тухайд татаасын хэмжээг тооцохтой холбоотой асуудал тулгарахаас гадна (санхүүжилт олж авах гол зорилгоор нам байгуулах явдлаас сэргийлэн) шинэ нам байгуулахыг хэрхэн дэмжихийг мөн төрийн хэвлэл мэдээллийн хэрэгслийг хэрхэн ашиглаж болохыг шийдэж өгөх хэрэгтэй болно. Эцэст нь нэр дэвших болон сонгуульд өрсөлдөх талаархи хэргийг шийдвэрлэх хүчин чадалтай хуулийн заалт болон байгууллагын дотоод журмыг боловсруулсан байвал зохино. Оролцогч улсууд нь улс төрийн намын санхүүжилт болон сонгуулийн компаниг ажилтай холбоотой авлигаас сэргийлэх нийтлэг журмын талаарх Европын Зөвлөлийн 4-р зөвлөмж (2003) зэрэг бүсийн байгууллагуудын холбогдох санаачилга арга хэмжээнд анхаарал хандуулах нь зүйтэй.

II.7. Ил тод байдал ба сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тогтолцоо

Оролцогч улс бүр Улсын баримт бичигтэй холбоотой хадгалах, бүрдүүлэх болон нууцлалын талаар захиргааны зохих дүрэм журмаас гадна мэдээллийн болон мэдээлэл олж авах эрх чөлөө түүнчлэн төрийн шийдвэрийг ил тод байлгах тухай заасан хууль тогтоомжийг нэвтрүүлэхийг чармайх хэрэгтэй. Энэ шаардлагыг 10 ба 13 дугаар зүйлд илүү тодорхой авч үзнэ.

Оролцогч улс болгон төрийн албан хаагч бүрт хашиж буй албаас нь хамааран Конвенцийн төрийн сонгогддог эсвэл томилогддог албан хаагч ашиг сонирхлын зөрчилтэй албан тушаал хаших, хөрөнгийн мэдүүлэг өгөхөөс татгалзах болон хууль ёсны бус чиг үүрэг биелүүлэх, зохисгүй үйл ажиллагаанд хууль бусаар оролцохыг хориглосон гол шаардлагад үндэслэн ашиг сонирхлын зөрчил болон эдгээрт холбогдох асуудлыг хамарсан ерөнхий зүйл заалтыг тодорхойлон тусгах шаардлагатай. Энэ шаардлагыг наймдугаар зүйлд илүү тодорхой авч үзнэ.

8 дугаар зүйл. Төрийн албан тушаалтны ёс зүйн дүрэм

1. Авлигатай тэмцэхийн тулд оролцогч улс бүр эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн төрийн албан тушаалтны холбогдогдох бусад, ялангуяа шударга, үнэнч, хариуцлагатай байдлыг дэмжинэ.

2. Оролцогч улс бүр, ялангуяа, төрийн чиг үүргийг зөв, нэр төртэй хийгээд зохих ёсоор хэрэгжүүлэх ёс зүйн дүрэм буюу жишигийг өөрийн байгууллагын болон эрх зүйн тогтолцооныхоо хүрээнд хэрэглэхийг чармайна.

3. Энэ зүйлийн заалтыг хэрэгжүүлэх зорилгоор оролцогч улс бүр шаардлагатай тохиолдолд, эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн Ерөнхий Ассамблейн 1996 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 51/59 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Төрийн албан тушаалтны ёс зүйн олон улсын дүрэм зэрэг бүс нутгийн, бүс нутаг хоорондын болон олон талт байгууллагын холбогдох санаачлагыг анхааралдаа авна.

4. Оролцогч улс бүр дотоодын хууль тогтоомжийнхоо тулгуур зарчимд нийцүүлэн, төрийн албан тушаалтан нь чиг үүргээ биелүүлэх явцад өөрт нь мэдэгдсэн авлигын талаар эрх бүхий зохих байгууллагад мэдээлэх явдлыг хялбарлах арга хэмжээ, тогтолцоог бий болгох асуудлыг авч үзнэ.

5. Оролцогч улс бүр шаардлагатай гэж үзвэл, дотоодын хууль тогтоомжийнхоо тулгуур зарчимд нийцүүлэн төрийн албан тушаалтан чиг үүргээ хэрэгжүүлэх явцад сонирхлын зөрчил үүсгэж болохуйц нөхцлүүд, түүний дотор албан үүргээс гадуурх үйл ажиллагаа, ажил хөдөлмөр, хөрөнгө оруулалт, өмч хөрөнгө, том хэмжээний бэлэг буюу ашиг орлогын талаар эрх бүхий холбогдох байгууллагад мэдүүлж байх арга хэмжээ, тогтолцоог бий болгох талаар хүчин чармайлт гаргана.

6. Оролцогч улс бүр энэ зүйлийн дагуу тогтоосон ёс зүйн дүрэм буюу жишигийг зөрчсөн төрийн албан тушаалтанд сахилгын буюу бусад арга хэмжээг дотоодын хууль тогтоомжийнхоо тулгуур зарчимд нийцүүлэн авах асуудлыг авч үзнэ.

I. Ерөнхий тойм

Оролцогч улс бүр төрийн албан хаагчдын дунд шударга, үнэнч, хариуцлагатай байдал зэрэг хувь хүний стандарт хэм хэмжээ болон төрийн чиг үүргийг зөв, үнэнч, шударга, зохих ёсоор гүйцэтгэх мэргэжлийн хариуцлагатай байдлыг идэвхтэйгээр хөхүүлэн дэмжвэл зохино. Үүний тулд, оролцогч улс бүр төрийн албан хаагчдыг стандарт хэм хэмжээнд нийцүүлэн биеэ авч явах хийгээд үйлдэл болон шийдвэрийнхээ хариуцлагыг хэрхэн хүлээх талаарх удирдамжаар хангах ёстой. Тус зүйлд оролцогч улс бүр ялангуяа төрийн албан хаагчдын зүгээс олон нийтийг мэдээллээр хангах тухай хууль тогтоомж, сонирхлын зөрчилтэй холбоотой журам, ёс зүйн дүрэм болон сахилгын журмаар хангана гэж заасан байна.

Оролцогч улсуудын ихэнх нь ёс зүйн дүрэм эсвэл төрийн дүйцэх мэдэгдлийг ашигладаг. Энэ нь хэд хэдэн зорилготой. Үүнд төрийн тодорхой албан хаагч эсвэл албан хаагчдын тодорхой

бүлэгт тавих шаардлагыг нарийн зааж өгсөн байх ба үүгээр авилгыг таслан зогсоох зан үйлийн үндсэн стандартыг хэвшүүлж өгнө. Түүнчлэн энэ нь ажиллагсдын сургалтын суурийг тавьж, төрийн албан хаагч бүрт үүргээ гүйцэтгэх стандартыг таниулахад тустай. Энэхүү стандарт хэм хэмжээнд үнэнч, шударга байх, тал тохой татахгүй, үл ялгаварлах үзэл, бие даасан байдал, зарчимч байдал, байгууллагад үнэнч байх, хичээл зүтгэлтэй байх, албан хаагчийн биеэ авч явах ёс зүй, ил тод байдал, хариуцлагатай байх, байгууллагын нөөцийг хариуцлагатай ашиглах болон олон нийттэй зохих ёсоор харилцах зэрэг нь хамаарна.

Нөгөөтэйгүүр, ёс зүйн дүрэм эсвэл төрийн дүйцэх мэдэгдэл нь сургалтын хамтаар ёс зүйн доголдлын үр дагавраас сэрэмжлүүлж, ажилтан тухайн стандарт хэм хэмжээнд нийцээгүй буюу зөрчил гаргасан үед ажлаас чөлөөлөх гэх мэт сахилгын арга хэмжээний үндэс суурийг бий болгож өгнө. (Ихэнх тохиолдолд ёс зүйн дүрэм нь ёс зүйн хувьд шаардах эсвэл хориглох зүйлсийг тодорхойлсон байхаас гадна дүрэм зөрчсөн тохиолдолд шийдвэрлэх журам болон шийтгэлийг багтаасан байдаг).

Иймд хүчин төгөлдөр стандарт хэм хэмжээ, журам, дадал зуршил нь нэгдэн ёс зүйн цогц дүрмийг бүрдүүлснээр төрийн албан хаагч зөвхөн албаны чиг үүрэг болон хариуцлагатай холбоотой стандарт хэм хэмжээгээ мэдээд зогсохгүй төрийн албан хаагч биеэ хэрхэн авч явахаа илүү анхаарах шаардлагатай болдог. Гэхдээ төрийн албан хаагч ёс зүйн стандарт хэм хэмжээ болон хэрхэн биеэ авч явах шаардлагатайг урьдаас мэдэх эрхтэй бөгөөд ингэснээр өөр хэн нэгэнд сахилгын ямар нэг дүрмийг санаанаасаа зохион тэднийг сүрдүүлэх эсвэл албан тушаалаас халах боломж олгохгүй байх юм.

Оролцогч улсын ёс зүйн дүрэм эсвэл төрийн дүйцэх мэдэгдлийг хэрхэн түгээн дэлгэрүүлэх нь тэдний байгуулгын болоод эрх зүйн тогтолцооноос хамаарна. Зарим улс оронд төрийн албан хаагч бүрт тохирох стандартыг тогтооход тусгай хууль, тогтоомж ашигладаг. Өөр нэг арга нь эрх мэдэл шилжүүлэх арга юм. Үүнд хууль тогтоох байгууллага нь ерөнхий дүрмийг боловсруулж прокурор, хууль тогтоох байгууллагын гишүүн, нягтлан бодогч, ханган нийлүүлэлт хариуцсан мэргэжилтэн гэх мэт албан хаагчийн тодорхой бүлгийн ёс зүйн жишгийг тогтоохын тулд тусгай нарийвчилсан дүрэм боловсруулах эрх мэдлийг өөр байгууллагад шилжүүлэн өгнө. Эцэст нь гэрээний эрх зүй болон холбогдох хөдөлмөр эрхлэх болзол нөхцөлд тодорхой албан хаагчийн ёс зүйн дүрэмд хамаарах болзол шаардлагыг оруулж хөдөлмөрийн гэрээний нэг хэсэг болгож зааж өгч болно. Өөрөөр хэлбэл агентлаг, хэлтсийн зүгээс ажилтан, гэрээлэгч бүрийн ажил үүргийн нөхцөл болгон хүлээн зөвшөөрөх ерөнхий ёс зүйн жишгийг тогтоох боломжтой.

Ёс зүйн дүрэм боловсруулахад оролцогч улс бүр бүс нутгийн, бүс нутаг хоорондын болон олон талт байгууллагын холбогдох санаачилгыг анхаарч үзэх хэрэгтэй. Үүнд Ерөнхий Ассемблейн 1996 оны 12 сарын 12-ны 51/59 дугаар тогтоолын хавсралтанд орсон Төрийн албан тушаалтнын ёс зүйн олон улсын дүрэм, төрийн албан хаагчийн ёс зүйн загвар дүрмийг хавсаргасан Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай Европын Зөвлөлийн R (2000)10 тоот Зөвлөмж, мөн Төрийн албанд удирдлагын ёс зүйн зарчмыг багтаасан төрийн албанд ёс зүйн удирдлагыг сайжруулах талаар Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Зөвлөмж (1998-C(98)70/FINAL) орж болно.

II. Бодит бэрхшээл ба шийдэл

II.1. Төрийн албан тушаалтны шударга, үнэнч, хариуцлагатай байдлыг хөхиүлэн дэмжих тухай

Оролцогч улс бүр төрийн албан тушаалтны шударга, үнэнч, хариуцлагатай байдлыг сурталчлахдаа эерэг, сөрөг аль аль талаас нь авч үзнэ. Эерэг талаас нь авч үзэхдээ оролцогч улс бүр төрийн албан тушаалтны ёс зүйтэй биеэ авч явах байдлыг дэмжиж урамшуулж, удирдамж гарын авлагаар хангана. Үүнд ажилд орох үед болон ажиллаж байх хугацаанд төрийн албан тушаалтанд биеэ авч явах байдлын зохих шаардлагын талаар сургалт явуулж болно. Төрийн албан хаагч бүр ажиллах хугацаандаа зохих сургалтанд хамрагдах ёстой. Оролцогч улс бүр төрийн албан тушаалтныг санхүүгийн буюу гэр бүлийн сонирхол, бэлэг болон дайллага цайллагыг мэдүүлэх журам болоод арга замаар хангана. Оролцогч улс бүр төрийн албан тушаалтныг өөр бусад төрийн албан хаагчийн зан үйлийн талаар мэдээлж хэлэлцүүлээд зогсохгүй мөн хамтран ажиллагсад буюу бусдын зүгээс тэдэнд үзүүлж буй дарамт болон зохисгүй нөлөөллийн талаар мэдээлэх боломжоор хангах ёстой. Энэхүү мэдээллийн нууцыг чанд хадгалж тэдний ажил үүрэгт сөрөг нөлөө үзүүлэхгүй байх баталгаагаар хангана. Оролцогч улс бүр авлигад өртөмтгий албан тушаал буюу үйл ажиллагааны эрсдлийг үнэлж, тухайн албан тушаалтантай тэднийг болон үйл ажиллагааг нь авлигаас хэрхэн хамгаалах талаар хэлэлцэнэ. Ер нь тэдний ажил үүрэгтэй холбоотой эрсдэл, заналхийлэл болон авлигад өртөх магадлалын талаар төрийн албан тушаалтны судалгааг тогтмол явуулна.

II.2. Ёс зүйн дүрэм, стандарт

Стандарт хэм хэмжээ нь албан тушаалтны үүрэг хариуцлагын ач холбогдлыг тодотгодог. Түүнчлэн стандарт хэм хэмжээгээр албан тушаалтны ажил мэргэжилдээ чин сэтгэлээсээ хандах, олон нийтэд үйлчлэх, албан тушаалаар олгогдох эрх мэдэл ба хангамжинд хариуцлагатай хандах явдлыг урамшуулан дэмжинэ. Олон нийттэй харьцдаг албан тушаалтны зан үйлийн зарчим үнэт зүйлсийг стандарт жишгээр тогтоох учиртай. Үүнд ажил үүргээ хуулийн хүрээнд эрхлэх, үнэнч шударга байх, тал тохой татахгүй байх, мэргэжлийн ёс зүйтэй байх зэрэг орно. Олон улс орны өөрчлөлт шинэчлэлтийн үйл ажиллагаа нь удирдлагын ур чадварыг сайжруулах болон төрийн албыг чиг үүргээ биелүүлэх тал дээр илүү хангагдсан байлгахад төвлөрч байна. Төрийн албан тушаалтнаас шаардах шаардлага урьд өмнөхөөс илүү өргөн хүрээний зарчимтай уялдах хэрэгтэй болж байна. Эдгээр зарчим нь үр нөлөө, зорилго, хариуцлагатай байх тал дээр төвлөрч байгаа юм.

Стандарт хэм хэмжээг боловсруулахад үндэслэлтэй шийдвэр болон дүгнэлт гаргахад суурь үндэс болгодог өндөр түвшний зарчим, үнэт зүйлсийг илүү ашигладаг. Тодорхой шийдвэр гаргах ялангуяа төрийн албан хаагч өөрийн хянуур байдлыг ашиглаж шийдвэр гаргах шаардлагатай болсон үед хэрэглэж болох ерөнхий зарчмууд байдаг. Жишээлбэл:

- Нийгмийн ашиг сонирхолд үйлчлэх,
- Ур чадвараа ашиглан, бүтээмжтэйгээр, хууль, бодит байдал, ил тод байдал болон нууцын халдашгүй байдлыг хүндэтгэн, тал тохой таталгүйгээр, үнэнч шударгаар, онц сайн байхыг мэрийж ажиллах,
- Чиг үүргээ ямагт нийгмийн итгэлийг хүлээх Юйц байдлаар гүйцэтгэх,

- Иргэд болон төрийн албан тушаалтантай хүндэтгэлтэй, шударга, эелдэг байдлаар харьцах.

Төрийн албан тушаалтны зан үйлийн жишгийг ёс зүйн дүрмээр тогтоох бөгөөд энэ нь үйл ажиллагааны тодорхой журам болон шаардлагаар илэрч гарч ирнэ. Үүгээр хүлээн зөвшөөрөх болон үл зөвшөөрөгдөх зан үйлийн хил хязгаарыг тогтоож, олон байдлаар бүлэглэж болно. Жишээ нь, гол харилцаануудын хил хязгаар, хариуцлага хүлээсэн бүлгүүдийг харгалзан бүлэглэж болно.

Ийнхүү ёс зүйн дүрэм нь төрийн үйлчилгээтэй холбоотой асуудлууд (жишээ нь төрийн үйлчилгээ үзүүлэх, мэдээллээр хангахдаа шударга ёс, ил тод байдлыг хангах процедур) болон улс төрийн үйл ажиллагааны (улс төрийн үйл ажиллагаанд хориг тавих болон улс төрийн үйл ажиллагаа нь төрийн албан үүрэгт нөлөөлөхгүй буюу үүнтэй зөрчилдөхгүй байх явдлыг хангах гэх мэт) асуудлыг шийдэхэд чиглэнэ. Үүнд санхүүгийн сонирхлын зөрчил (жишээ нь, төрийн албан тушаалтан өөрийн эсвэл ойр дотны нэгнийхээ санхүүгийн сонирхолд нөлөөлөх албан тушаалын эрх мэдэлд хамаарах асуудлыг эрхэлж байхад үүсэх) болон санхүүгийн бус сонирхлын зөрчилд хамаарах (жишээ нь, төрийн албан тушаалтан түүнтэй хувийн, угсаа гарлын, шашин шүтлэгийн болоод улс төрийн хамааралтай хувь хүн болон байгууллагад нөлөөлөх асуудлыг эрхэлж байх үед үүсэх) болзол нөхцлийг тусгаж өгсөн байна. Ёс зүйн дүрэм нь бэлэг авах буюу бэлгээс татгалзах, дайлуулах болон бусад шан харамжийн талаар тодорхой, хоёрдмол утгагүй заалтуудыг багтаах бөгөөд ялангуяа тухайн байгууллагатай ажил үүргийн харилцаатай хувь хүн болон байгууллагаас бэлэг авах, давхар ажил эрхлэх (гэхдээ энэ нь албан тушаалтай нь зөрчилдөхгүй байж болно) улсын нөөцийг ашиглах (улсын нөөцийг зөвхөн улсын үйл хэрэгт эсвэл олон нийтэд хаалттай мэдээллийг хамгаалахад ашиглах) зэрэгт тавих хязгаарлалтыг тодорхой заасан байна. Эцэст нь ёс зүйн дүрэм нь албан тушаалаас чөлөөлөгдсний дараах үеийн болон дараагийн ажил эрхлэлтийн хязгаарлалыг шийдэж өгөх хэрэгтэй. Жишээ нь төрийн албан тушаалтан асанд өмнөх албан байгууллагынхаа өмнө шинэ ажил олгогчийг төлөөлөхийг эсвэл шинэ ажил олгогчид нууц мэдээлэл дамжуулахыг хориглоно.

II.3. Хэрэгжих нөхцөл

Үндсэн санаанаас гадна конвенцийн 8 дугаар зүйлийн шаардлагыг үр нөлөөтэйгээр мөрдүүлэх үүднээс төрийн албан тушаалтны янз бүрийн бүлэгт зориулан ёс зүйн дүрмүүдийг гаргаж болно. Түүнчлэн (төрийн сангаас зарцуулалт хийж буй) гэрээлэгч гэх мэт төрийн байгууллагатай ажил хэрэг явуулагсад, хувийн хэвшил хийгээд төрийн бус байгууллагад зориулсан хэрэгжихүйц дүрмийг бий болгож болох юм.

Хэрэгжилтийн хувьд хамгийн эхний асуудал бол эдгээр дүрэм хууль зүйн статустай байх эсэх асуудал юм. Албан тушаалтны чиг үүргийн үнэнч шударга, ил тод гүйцэтгэлтэй холбоотой асуудлыг дүрмээр зохицуулж болно. Энэ дүрэм нь олон албан тушаалтанд хамаарах болохоор дүрэм олон талаараа эрх зүйн хүрээнд хэрэгжиж байх явдлыг сайтар бодолцож үзэх шаардлагатай.

Хоёр дахь асуудал бол оролцогч улс дүрмийн, албан тушаалтны чиг үүргийн гүйцэтгэлтэй юун түрүүн хамаарах хэсэг болон сонирхлын зөрчлийг шийдэх хэсэг түүнчлэн албан тушаалтны үйл ажиллагаа болон шийдвэрт зохистой буюу зохисгүй нөлөөллийг ялган салгахад чиглэсэн эсэхтэй холбоотой. Энд оролцогч улс хөрөнгө орлогын мэдүүлэг, давхар ажил эрхлэлт, дайллага болон бусад шан харамжийн мэдүүлэг гэсэн ашиг сонирхлын үүсч болох хэсгийг илүү албан бөгөөд хууль зүйн хүрээнд авч үзэх нь зүйтэй.

Гурав дахь асуудал нь дүрэм боловсруулаад хэрэгжүүлдэггүй хавтсанд хийгээд орхидог хандлагыг шийдвэрлэх асуудал юм. Ёс зүйн дүрмүүд нь ихэнхдээ боловсруулсны дараа ажилд орох гарын авлагад хавсрагдаад өнгөрдөг эсвэл боловсруулах явцад боловсон хүчний санааг тусгаагүй тул албан хаагч ёс зүйн дүрмийн хэрэгтэй эсэхэд эргэлзэх цаашлаад хүчээр тулгасан зүйл мэтээр үзэх явдал гардаг.

Үр нөлөөтэй ёс зүйн дүрмийг боловсруулахын тулд оролцогч улс дор дурдсан зүйлийг анхаарах хэрэгтэй:

- Төрийн дээгүүр албан тушаалтан ёс зүйн дүрмийг мөрдөж, үлгэр жишээ үзүүлэх;
- Ажилтнууд ёс зүйн дүрмийг боловсруулах, хэрэгжүүлэх бүх шатанд оролцох;
- Дүрмийг сахиулах механизмыг бий болох;
- Дүрмийг мөрдөх явдал нь ажил мэргэжлийн ахиц дэвшилд хамаатай байхаар тооцох;
- Дүрмийг мөрдөж буй эсэхийг тодорхой арга хэрэгслээр тогтмол хянаж шалгадаг байх
- Ёс зүйн дүрмийн (болон авлигын талаар ерөнхий мэдлэг олгох) сургалтыг тогтмол бөгөөд цогц хэлбэрээр явуулах;
- Байгууллага өөрийн ёс зүйн соёлыг үргэлж хөхиүлэн дэмжиж ажиллана (ёс зүйн дүрэм мэдээж хэрэг чухал хэрэгсэл, гэхдээ зөвхөн энэ зорилгоор ашиглагдахгүй)
- Дүрмийг сахиулах тал дээр шаардлагатай бол сахилгын арга хэмжээ хэрэглэж болно
- Хэрэглээ, ач холбогдол болон хүртээмжийн талаас нь дүрмийг хэзээд нягтлан хэлэлцэж байна
- Дүрмийн загвар болон бүтэц нь байгууллагын тодорхой хэрэгцээнд нийцсэн байна.
- Дүрэм нь ажлын газрын хэв хандлага, шийдвэр болон үйл ажиллагаанд нөлөөлөх тал дээр чухал үүрэгтэй байна.

Анхаарах зайлшгүй шаардлагатай дөрөв дэх зүйл бол дүрэмд зориулан ямар хэв загвар хэрэглэх тухай асуудал буюу үүний агуулга юм. Агуулга нь цар хүрээний хувьд дараах сэдвүүдийг хамарсан байна. Үүнд төрийн албаны жишиг болон байгууллагын үнэт зүйлс; сонирхлын зөрчил; бэлэг ба урамшуулал; хахууль; ялгаварлал болон дарамт хүчирхийлэл; олон нийтэд шударга бөгөөд эрх тэгш хандах; нууц мэдээллийг зохицуулах; материаллаг нөөцийг хувийн хэрэглээнд ашиглах явдал, тухайлбал барилга байгууламж, техник хэрэгсэл (э-шуудан, Интернет, компьютер, факс гэх мэт); давхар ажил эрхлэлт; улс төрд оролцох оролцоо; нийгмийн болон сайн дурын ажилд оролцох явдал; авлигач үйлдэл, нөөцийн буруу ашиглалт, үрэлгэн

байдлын талаар мэдээлэх; ажил эрхлэлтийн дараах ёс зүйн хэм хэмжээ; сахилгажуулалт, шийтгэлийг багтаана.

Тав дах асуудал, оролцогч улсын дүрмээ боловсруулах тэрхүү агуулга буюу суурь хүрээтэй холбоотой. Дүрмийг бичснээр бүх асуудал шийдэгдэхгүй. Тиймээс оролцогч улс бүр стасус болон нөлөөллийн хувьд дүрмийг илүү үр нөлөөтэй болгох арга замыг эрэлхийлвэл зохино.

Оролцогч улс бүр хууль, тогтоомжийн дагуу дүрэмд эрх зүйн баталгаа болон эрх мэдэл олгож болохоос гадна ажил санал болгохдоо дүрмийг зөвшөөрсөн байхыг шаардах замаар үүнийг хувь хүнд хамааруулж өгч болно (нийтээр эсвэл албан хаагч бүр тус тусдаа хөдөлмөрийн гэрээг хүлээн зөвшөөрч эсвэл тангараг өргөж байж болно). Оролцогч улс бүр дүрмийн хэрэгжилтийг тасаг, хэлтэс бүрийн дээд удирдлага нь хариуцаж байвал зохино. Энэ удирдлага нь ерөнхий дүрэмд суурилсан, өөрсдийн тодорхой шаардлага, нөхцөл байдалболон чиг үүрэг, үйл ажиллагаанд тохирсон дүрэм хийгээд илүү нарийвчилсан бодлогыг боловсруулах хэрэгтэй. Энэ нь үйл ажиллагаанд илүү хамаарал бүхий үнэлэмж болон жишгийг бий болгож тэдэнд удирдлагын тогтолцоонд нэвтрэх боломж олгоно.

Хэлтэс, тасаг бүр шаардах болон хориглох зүйлсийг илүү нарийвчилсан байдлаар заасан бодлого, дүрэм, сургалт болон журам бүхий ёс зүйн дүрмийг бий болгоно. Үүнд авлигад автах өндөр эрсдэл бүхий албан тушаалтныг тусгайлан авч үзвэл зохино. Дүрмийг олж авахад мөн ойлгоход хялбар байх нь үүний хэрэгжилтэнд дэмжлэг болж өгөх юм. Хөрөнгө орлогын мэдүүлэг өгөх гэх мэт үйл ажиллагааг урьдаас бэлдсэн хөрөнгө орлогын мэдүүлгийн маягтаар хялбарчилж өгнө. Дээд удирдлага албан хаагчийн ёс зүйн дүрмийн мөрдсөн байдлыг боловсон хүчний болон удирдлагын тогтолцооны гүйцэтгэлийн үнэлгээнд оруулж тооцохоос гадна ёс зүйн дүрмийг зөрчсөн тохиолдолд сахилгын арга хэмжээ авахаас гадна энэ нь зохих байдлаар шүүхэд шилжүүлэх үндэс суурь болж өгнө гэдгийг боловсон хүчинд ойлгуулна.

Оролцогч улс бүр ёс зүйн дүрмийг хэвлэл мэдээлэл болон олон нийтэд тодорхой болгох зорилгоор хэвлэн нийтэлнэ. Ингэснээр тэд төрийн албан хаагч ямар жишигт нийцсэн байвал зохихыг мөн төрийн албан хаагчид зөвшөөрөгдсөн хийгээд хориглосон үйлдлүүдийг мэдэж авах юм. Түүнчлэн дүрэм зөрчсөн явдлыг хэнд хэрхэн мэдээлэх талаар олон нийтийг зааварчилгаагаар хангаж, ямар нэг өс хонзон эсвэл дарамт учрахаас эмээлгүйгээр дүрэм зөрчсөн явдлыг мэдээлэх бололцоог хэвлэл мэдээллийн хэрэгсэлд олгосон байвал зохино.

Эцэст нь оролцогч улс бүр 6 дугаар зүйлд заасанчлан төрийн албан хаагчдын ёс зүйн дүрмийн талаарх мэдлэг, хэрэгжилт, тэдэнд тулгарч буй хүндрэл бэрхшээлийг тодорхойлох зорилгоор тогтмол судалгаа, шалгалт явуулдаг, ёс зүйн дүрэмтэй холбоотой үүргээ биелүүлж байгаа эсэх талаархи тайланг жил бүр хэвлэн нийтэлдэг ёс зүйн дүрмийн хэрэгжилтийн хянагч тусгай байгууллагатай байх нь зүйтэй.

III. Төрийн албан тушаалтан авилгын талаар мэдээлэх нь

Ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн, хуулийн цоорхойг тойрсон нууц хуйвалдаан, чимээгүй байдлыг эвдэх чухал арга нь ерөнхийдөө хууль зөрчигчдийг, нэн ялангуяа авилга үйлдэгчдийг мэдээлэх үр дүнтэй системийг бий болгоход оршдог. (ихэнхдээ “шүгэл үлээх” гэж нэрлэдэг, мөн олон нийтийн ашиг сонирхлыг илчлэх, олон нийтэд мэдээлэх, мөн мэргэжлийн стандартаар тайлагнах гэнэ).

Оролцогч улсууд нь төрийн албаны хүмүүсийг эдгээрийг мэдээлэхэд нь хялбар болгох үүднээс хангалттай дүрэм журмуудыг боловсруулах шаардлагатай. Үүнд ажилтан албан хаагчийг авлигыг мэдээлэхэд нь зоригжуулах, хэнд тайлагнахыг нь мэдүүлэх, мөн ийнхүү тайлан мэдүүлсэний төлөө дээд эрх мэдэл бүхий хүмүүсийн зүгээс ирж болзошгүй довтолгоо, сөрөг үйлдлээс хамгаалах зэрэг нь багтана.

Ёс зүйн журмын нэг зорилго нь албаны хүмүүст гүн сэтгэгдэл төрүүлж чухалчлан ойлгуулах, сургалтаар дамжуулан тэдэнд мэргэжлийн ажлынх нь мөн чанарыг, ажлын хариуцлагыг нь ойлгуулах, мөн бусад албан хаагчдын гаргаж буй зөрчлийг мэдээлэх нь тэдний хариуцлага гэдгийг ойлгуулах явдал юм.

Мэдээллийг нууцлалыг хадгалахын тулд шуудангийн хайрцаг, тусгай телефон утасны нээлттэй шугам ажиллуулах, эсвэл хөндлөнгийн хяналтын байгууллагаар дамжуулан мэдээлэл хүргэх тодорхой журам боловсруулагдах ёстой.

Бий болсон системийн дагуу тэдгээр авилга, луйврын сэжгийг мэдээлсэн хүмүүст ил далдын алив хохирол учрахаас бүрэн хамгаалахын тулд онцгой анхаарал тавигдах ёстой.

Төрийн алба нь аливаа зөрчил авилгын хэргийг мэдүүлсэний үр дүнд мэдүүлэг гаргасан хүмүүст ирээдүйд гарч болзошгүй ялгаварлал, албан тушаалд аюул хохирол учрах зэргээс хамгаалах хэрэгцээ түлхүү хамгаалалт хэрэгцээтэй. Оролцогч улсууд нь [http://www.coe.int/t/dgl/greco/documents/2007/Greco\(2007\)1_act.rep06_EN.pdf](http://www.coe.int/t/dgl/greco/documents/2007/Greco(2007)1_act.rep06_EN.pdf) сайт дээрээс GRECO-ийн 2006 оны үйл ажиллагааны тайланд эдгээр асуудлын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг, мөн ТББ Олон нийтийн төлөө санаа тавих талаар <http://www.pcaaw.co.uk/> вебсайтаас мөн ашиглах боломжтой.

Тиймд оролцогч улс орнууд нь авлига хууль зөрчсөн этгээдийн талаар хэнд мэдүүлэг өгөх ямар хэлбэрээр (жишээ нь; бичгээр, нэрээ нууцлах байдлаар), мэдээллийн ямар хэлбэрийг ашиглан (утсаар, и-мэйлээр, эсвэл захидлаар), эх сурвалжийг хамгаалах аюулгүй байдлын журмын дагуу, мэдүүлгийн дагуу хэрхэн сурвалжлах; хариу өс хонзон авах, хохирох үйлдлээс хамгаалах зэрэг хууль дүрэм журмыг боловсруулан гаргасан байвал зохино.

IV. Авлигыг мэдүүлэх тогтолцоо

Оролцогч улсууд нь сонирхлын зөрчил, зүйд үл нийцэх байдал болон холбогдох үйл ажиллагааны талаар ерөнхий заалтуудыг нэвтрүүлэх шаардлагатай.

Ерөнхий зарчмын хувьд, төрийн байгууллага нь төрийн үйлчилгээг ил тод, шударга явагдах, бэлэг санал болгох, хүлээн авах, дайллага цайллага зэргийг хөхүүлэн дэмжихгүй байх, албаны үйл ажиллагаа шийдвэрт амин хувийн болон бусад төрлийн ашиг сонирхол хэрхэвч үл нөлөөлөх уур амьсгалыг бүрдүүлсэн байх хэрэгтэй.

Үүнийг төрийн үйлчилгээний талаар олон нийтэд мэдээлэх (10-р зүйлийг үзнэ үү), луйвар болон авлигын эсрэг бодлого, ёс зүйн хэм хэмжээг хэвлэн нийтлэх зэрэг хэд хэдэн аргаар хийгдэж болно. Мөн онцгойлон тендер, гэрээ хэлэлцээрийн бичиг баримтыг нийтэд зарлах, олны нүдэнд өртөх газар зарлал тавих, интернетэд байрлуулах зэргээр олон нийтийн хүртээл болгож болно.

Сонирхлын зөрчлийг зохицуулах дүрэм журмуудаар улс орнуудын санааг зовоох болсон сонирхлын зөрчлийн томоохон төрлүүдийг тодорхойлсон байх нь зөв юм. Сонирхлын зөрчил гарах магадлал байгаа, эсвэл сонирхлын зөрчил хэдийнэ учирсан тохиолдолд хэрхэх тухай журам процедур мөн байвал зохино. Сонирхлын зөрчлөөс зугатах боломжгүй тохиолдолд (жигжигхэн газарт) тухайн байгууллагын ажлыг алдагдуулахгүйгээр олны анхаарлаас сэргийлэх нөхцлийг бүрдүүлэх нь зүйтэй. Төрийн албаныхан сонирхлын зөрчлийн талаар ойлголттой байхаас гадна түүнийг хэрхэн шийдвэрлэх талаарх арга барил, дүрэм журмаа мэддэг байвал зохино. Төрийн ажилтны зүгээс сонирхлын зөрчил үүсч болзошгүй тохиолдолд хэрхэх тухай мэдээлэл, зөвлөгөө авдаг байх ёстой. Ийм нөхцөлд зөвлөгөө авах, тодруулж хэлэлцэх албан бус зөвлөх үйл явцын механизмыг хэрэгжүүлэх нь тустай.

Байгууллага /байгууллагууд нь ашиг сонирхлын зөрчил гарч болзошгүй тохиолдол, нөхцөл байдал бүрийн талаар мэдээлэл авч судалж мэдсэн байх шаардлагатай. Сонирхлын зөрчлийн талаарх журмыг зөрчсөн тохиолдолд авах торгууль шийтгэлийн арга хэмжээг хууль дүрэм, шилжсэн эрх мэдэл, ажилтантай байгуулсан гэрээ зэрэгт тусгасан байвал зохино. Төрийн албан хаагчид тавигдах сонирхлын зөрчилтэй холбоотой шаардлагуудыг олон нийтэд нээлттэй зарлах ёстой.

Тодруулбал, эд хөрөнгөө нийтэд мэдээлэх, эд хөрөнгө, сонирхлоо бүртгүүлэх шаардлагад дараах зүйлсийг багтаавал зохино:

- Төрийн албан хаагч нь томоохон бүх төрлийн орлого, эд хөрөнгөө мэдүүлэх ёстой (ойр дотны хүрээлэл, салбар хамаатан саданд ч хамаарах талтай)
- Төрийн албан хаагчийн жил бүрийн санхүүгийн тайлан, байр суурийг харьцуулан харах боломжтой байх
- Төрийн албан хаагч өөрийн эд хөрөнгийг алив аргаар нуун дарагдуулах тухайлбал төрийн нэвтрэх боломжгүй хэн нэгнийг ашиглахаас сэргийлэх (тухайлбал гадаад руу эсвэл харьяа бус этгээдийн нэр дээр шилжүүлэх) процедур журамтай байх
- Төрийн албан хаагчтай холбоотой хувь хүн хуулийн этгээдэд нэвтрэхийн тулд бүх хуулийн этгээд болон иргэдийн орлого, хөрөнгийг хянах найдвартай тогтолцоог бүрдүүлсэн байх- жишээ нь татварын алба-

- Төрийн албан хаагч нь өөрийн орлогын эх сурвалжийг баримтжуулан нотлох чухал үүрэг хүлээсэн байх
- Төрийн албан хаагч нь өөрт байхгүй эд хөрөнгөний талаар мэдүүлэхгүй байх. Хожим тайлбарлах боломжгүй хөрөнгөө үүнтэй холбохоос сэргийлнэ.
- Хяналт тавьдаг агентлагууд нь хангалттай хүн хүчтэй, туршлагатай, техникийн чадамжтай, хяналтыг мэргэжлийн түвшинд гүйцэтгэх эрхзүйн чадамж эрх мэдэлтэй байх
- Эдгээр шаардлагыг зөрчигсдөд зохих түвшний шийтгэл оногдуулдаг байх

Оролцогч улсууд нь сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх шаардлагуудыг зохиохдоо дараах зүйлсэд онцгой анхаарал хандуулах нь зүйтэй. Үүнд:

- Тухайн төрийн албаны зүйд үл нийцэх ямар албан тушаал үйл ажиллагаа байна вэ?
- Хүмүүс ямар сонирхол, эд хөрөнгөө мэдүүлэх ёстой вэ? (өр, төлбөрийг мөн оруулна)
- Албан тушаал бүрт сонирхлын зөрчлийн шаардлага өөр өөрөөр тавигдах ёстой юу?
- Мэдээллийн ямар төвшин, нарийвчлалыг багтаах ёстой вэ? (Босго)
- Мэдүүлэг ямар хэлбэрээр хийгдэх ёстой вэ?
- Мэдүүлсэн мэдээллийг хэн баталгаажуулах вэ?
- Мэдээлэл рүү нэвтрэх эрх хэнд байх ёстой вэ?
- Шууд бус сонирхлын бүртгэлийг (гэр бүл) ямар түвшинд хүртэл явуулах ёстой вэ?
- Хэн мэдэгдэл хийх үүрэгтэй вэ? (Жишээлбэл авлигын эрсдлээс; мөн мэдүүлгийг баталгаажуулах институтын чадамжаас хамаарна)
- Хир их мэдэгдлийг ямар аргаар олон нийтэд өгөх вэ? (хувийн нууцлал болон байгууллагын чадавхийг харгалзан үзнэ)
- Мэдэгдлийг хийх үүргийн биелэлтийг хэрхэн, хэнээр мөрдүүлэх ёстой вэ?

Оролцогч улсууд нь бэлэг сэлт хүлээн авах, дайллага цайллагатай холбоотой журам, бодлогыг боловсруулах ёстой. Үүнд:

- Бэлэг, урилга, дайллага цайллага хүлээн авах зөвшөөрөл
- Бүртгүүлэх шаардлагатай мэдээлэл
- Бүртгэлд нэвтрэх;
- Аливаа бэлгийг өмчлөх
- Мэдээллийг баталгаажуулах;
- Зөрчил буюу ам дамжсан ярианы мөрөөр эрэн сурвалжлах арга хэрэгсэл;
- Хориг тавих зэрэг асуудлууд тусгагдсан байна.

Бэлэг өгсөн болон хүлээн авсан, дайлсан ба дайлуулсан зэргийг аль алиныг бүртгэх нь зүйтэй. Тэдгээрийг хэзээ, хэрхэн бүртгүүлэх талаар төрийн албан хаагчид зааварчилгаа өгөгдөх ёстой (албан ёсны системтэй байж зааварчилгааг мөрдлөг болгох нь төрийн албан хаагчийг аливаа хорт гүтгэлгээс хамгаална). Сайтар боловсруулсан удирдамж чиглүүлэгт мэдүүлбэл зохих үнэ бүхий эд зүйлсийн доод хязгаарыг тогтоож, бэлэг хүлээн авахаасаа өмнө ахлах ажилтнаасаа зөвшөөрөл авах бэлгийн зүйлсийн үнэ өртгийг ч тогтоосон байдаг. Мэдүүлгийг түргэн шуурхай хийх, удирдлага болон дотоод аудитын зүгээс бүртгэлийг хийж хянаж байх заалтуудыг мөн тусгана.

Оролцогч улсууд нь ёс зүйн дүрмийг шинэчлэх, хэрэгжилтийг хянах, сургалт болон хяналтыг зохицуулах арга замуудыг улам боловсронгуй болгох хэрэгтэй; Оролцогч улсууд нь эдгээр үүрэг хариуцлагыг 6-р зүйлд заасан байгууллага буюу байгууллагуудад даатгах нь зүйтэй.

V. Сахилгын арга хэмжээ

Оролцогч улс бүр ёс зүйн дүрмийг зөрчсөн явдлыг шийдэх тодорхой бөгөөд хоёрдмол санаагүй журамтай байвал зохино. Эдгээр нь тухайн улсын институцийн болон эрх зүйн тогтолцооноос хамаарах ч хөрөнгө, бэлэг болон дайлуулахтай холбоотой мэдэгдлийг хүлээн авч, үнэн зөвийг тогтоож, шалгах этгээд эсвэл байгууллагыг сонгохдоо ажлын ачаалал болон шаардлагатай мэдээллийг олж авахад хялбар байдал зэргийг тооцож үзэх шаардлагатай. Түүнчлэн шаардлагыг зөрчсөн нь тогтоогдсны дараа хэн эсвэл аль байгууллага шүүж яллахыг ч мөн тодорхой зааж өгнө.

Төрийн албан хаагчийн эрх үүрэгтэй холбоотой хууль дүрэм болон үйлчилгээ үзүүлэх орчин нөхцөл нь үр нөлөөтэйгээс гадна зохих ёсны сахилгын арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд нийцсэн байна. Тиймээс мэргэжлийн ёс зүйг зөрчих явдлаас урьдчилан сэргийлж гарсан үед нь илрүүлж шийдэх журам, шийтгэлийг төрийн байгууллага бүр боловсон хүчний болон удирдлагын тогтолцоогоороо зохицуулж өгөх хэрэгтэй гэсэн үг.

Ёс зүйн дүрэм нь үйлчилгээний болон төрийн албан хаагчийн шударга байдлыг хамгаалж бэхжүүлэх, сахилгын болон гомдол мэдүүлэх нэгдсэн тогтолцооны суурь болж өгнө. Энэхүү тогтолцоо нь тодорхой бөгөөд хоёрдмол санаагүй, хариу өгөх болоод хориг арга хэмжээ авах замаар авлига болон ёс зүйн дүрмийг зөрчих явдлаас сэргийлж, гарсан үед нь шийдэх чухал механизмтай байх хэрэгтэй. Гомдол мэдүүлэх тогтолцоонд авлига болон бусад ёс зүйн зөрчил гаргасан хэмээн ямар нэг үндэслэлээр эсвэл ташаа байдлаар буруутгагдсан төрийн албан хаагчаас гадна ойр орчинд нь болж буй авлигын үйлдлийг мэдээлсэн төрийн албан хаагчийг хамгаалах журмыг мөн зааж өгсөн байна.

9 дүгээр зүйл. Төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, төсвийн удирдлага

1. Оролцогч улс бүр эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн авилгаас үр дүнтэй урьдчилан сэргийлэх зорилгоор ил тод байх, өрсөлдөх болон бодит шалгуураар шийдвэр гаргах зарчимд үндэслэсэн төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тогтолцоог бий болгох шаардлагатай арга хэмжээ авна. Босго үнийг харгалзаж болох ийм тогтолцоо нь бусад олон нөхцөл, түүний дотор дараахь зүйлсийг хамаарна:

(а) тендерт оролцох этгээдэд тендерээ бэлтгэж ирүүлэхэд хангалттай хугацаа олгож, тендерийн урилга болон гэрээ байгуулах эрх олгох талаархи холбогдох буюу тохирох мэдээлэл зэрэг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах журам болон гэрээнд хамаарах мэдээллийг олон нийтэд тараах;

(b) сонгон шалгаруулах болон эрх олгох шалгуур, тендер шалгаруулалтын дүрэм зэрэг шалгаруулалтын нөхцлийг урьдчилан тогтоох, тэдгээрийг нийтлэх;

(c) дүрэм, журмыг зөв хэрэглэсэн эсэхийг хожим нь нягтлан шалгах боломжийг бий болгох үүднээс төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах шийдвэрийг гаргахдаа урьдчилан тогтоосон, бодитой шалгуурыг хэрэглэх;

(d) энэ хэсэгт заасны дагуу тогтоосон дүрэм буюу журмыг мөрдөөгүй тохиолдолд хуулиар хамгаалуулах, зөрчигдсөн эрхээ сэргээлгэх явдлыг баталгаажуулах зорилгоор давж заалдах үр дүнтэй тогтолцоог оролцуулан дотоодын хяналтын үр дүнтэй тогтолцоог бий болгох;

(e) Шаардлагатай тохиолдолд төрийн өмчийн хөрөнгөөр тодорхой бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг хариуцсан боловсон хүчинтэй холбоотой тодорхой тендэрт сонирхлоо илэрхийлэх, үйл явцыг ажиглах, сургалтад тавигдах шаардлага зэрэг асуудлуудыг зохицуулах арга хэмжээг авах.

2. Оролцогч улс бүр төсвийн удирдлагын ил тод, хариуцлагатай байдлыг хөхиүлэн дэмжих зохих арга хэмжээг эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн авна. Ийм арга хэмжээ нь бусад олон нөхцлүүд, түүний дотор дараахь асуудлуудыг хамрана:

(a) Улсын төсвийг батлах үйл явц;

(b) Орлого, зарлагыг цаг тухайд нь тайлагнах;

(c) Нягтлан бодох бүртгэлийн болон аудитийн стандарт, холбогдох бусад хяналт;

(d) эрсдлийн удирдлага, дотоодын хяналтын үр дүнтэй бөгөөд үр ашигтай тогтолцоо;

(e) шаардлагатай тохиолдолд, энэ хэсэгт заасан шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд засаж залруулах арга хэмжээ.

3. Оролцогч улс бүр дотоодын хууль тогтоомжийнхоо тулгуур зарчимд нийцүүлэн улсын орлого, зарлагад хамаарах нягтлан бодох бүртгэл, тэмдэглэл, санхүүгийн мэдээлэл, бусад баримт бичгийн үнэн зөв байдлыг хангах, тийм баримт бичгийг хуурамчаар үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд шаардлагатай иргэний болон захиргааны боломжит арга хэмжээ авна.

I. Ерөнхий тойм

Төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа нь авлига, хуйвалдаан, залилан болон булхайд өртөх магадлал өндөртэй үйл явцад тооцогддог. Оролцогч улс бүр дээр 1. а.-гаас е.-д дурдсан нөхцлөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах журмаа

боловсруулах хэрэгтэй. Энэ талаар Эдийн засаг, хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас (OECD) сүүлийн үед дараах материалыг хэвлэн нийтэлснийг оролцогч улсууд харгалзан үзэх нь чухал. Үүнд,

Төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад гарч болох хээл хахууль: Арга зам, оролцогчид болон сөрөг арга хэмжээ, ЭЗХАХБ (OECD) 2007 http://www.oecd.org/document/60/0,3343,en_2649_37447_38446908_1_1_1_37477,00.html хаягаас харах боломжтой. Түүнчлэн, Төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад Шударга байдал: А-гаас Я хүртэл зөв дадал (OECD, 2007) мөн Төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад Авлигатай тэмцэх ба Шударга байдлыг хөхиүлэн дэмжих нь (OECD, 2005), Олон улсын Ил тод байдлын байгууллага (Transparency International)-аас дэвшүүлсэн бодлого болон судалгааны ажил, <http://www.transparency.org>, болон Дэлхийн Банк, <http://www.go.worldbank.org/KVOEGWC8Q0> орно.

Төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах зохицуулалт нь дан ганц авлигын эсрэг зүйл биш гэдгийг санах хэрэгтэй. Төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тохиолдолд мөнгөний үнэлэмж, шударга байдал, хариуцлага хүлээх чадвар, ялгаваргүй хандах байдал болон нийгмийн/үйлдвэрийн хөгжил орсон байдаг. Харилцан адилгүй зорилгоо тэнцвэртэй гүйцэтгэхийн тулд төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах зохицуулалт хийх нь гол асуудал юм. Ямартай ч төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах журам нь дээрх 9 (1) зүйлд заасан шаардлагыг тусгах хэрэгтэй. Төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах талаар зөвлөмжөөр хангадаг олон байгууллага байдаг. Үүнд “Бараа, үйлчилгээ, барилга байгууламж худалдан авах тухай загвар хууль” болон үүнийг дагалдсан “Хэрэгжүүлэх тайлбарт удирдамж”-ийг хэвлэн гаргасан Олон улсын худалдааны хуулийн НҮБ-н Комисс (UNCITRAL) болон “Төрийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах болон холбогдох удирдамж”-ийг хэвлэн гаргасан Дэлхийн Банк багтана. Гишүүн улсуудын хуулийн төсөлдөө анхаарах Төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах зохицуулалт бүхий олон улсын хийгээд бүс нутгийн бүлэг, холбоонд Ази, Номхон далайн орнуудын Эдийн засгийн хамтын ажиллагааны нийгэмлэг (АРЕС)-ээс гадна (2004 онд Удирдамж 2004/17/ЕС (ахуйн үйлчилгээний салбарт эрх олгогдсон гэрээнүүд) болон Удирдамж 2004/18/ЕС (төрийн байгууллагаас эрх олгогдсон гэрээнүүд) гэсэн Төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах талаар хоёр удирдамжийг нэвтрүүлсэн) Европын Холбоо (EU), Америкийн худалдааны чөлөөт бүсийн гэрээний төсөл (ФТААА), Хойд Америкийн худалдааны чөлөөт бүсийн гэрээ (НАФТА), Америк мужуудын байгууллага (ОАС), Төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай Дэлхийн Худалдааны байгууллагын (WTO) гэрээ орно.

II. Бодит бэрхшээл ба шийдэл

II.1. Төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах

II.1.1. Зарчим

Тухайн улсын төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тогтолцооны гол бүрэлдүүлэгч хэсэг нь худалдан авах барааг тодорхойлох, зарлах, оролцох эрх

бүхий нийлүүлэгчдийг, оролцоог хязгаарлах тодорхой үндэслэл үгүй бол ил тендерийн болзол нөхцлийг, үнэлэх болон эрх олгох, түүнчлэн хяналтын болон үнийн саналаа ирүүлэх журмыг тодорхойлж тогтоох явдал юм.

Төрийн албан хаагчийн үүрэг, гэрээтэй холбоотой хүчин зүйлсийг хамарсан энэхүү хууль тогтоомжийг оролцогч улсууд үнэнч шударгаар мөрдөхийг хөхиүлэн дэмжиж, бэхжүүлж байна. Түүнчлэн тогтоосон журмаас хазайх бүрд зохицуулалт хийх үүнтэй төстэй болзол нөхцлийг зөвтгөн хамгаалахын тулд баримтжуулж, олон нийтэд ил тод байдлаар бүртгэл хөтөлсөн байна. Аливаа шийдвэрийг ил тод гаргаж, хариуцах эзнийг тодорхойлж аливаа хяналт шалгалт, хууль тогтоох байгууллага, олон нийтийн хараа хяналтанд байлгах нь зүйтэй.

III.1.2. Ил тод байдлыг сайжруулах арга хэмжээ

Ил тод байдал нь бараа, ажил, үйлчилгээ худалдан авах асуудалд шударга байдлыг тогтоох гол арга хэрэгсэл юм. Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл явц нь 3 үе шаттай байна: үйл ажиллагааны болон техникийн орчин нөхцлийг (техникийн тодорхойлолт) бүрдүүлэх бараа, ажил үйлчилгээ худалдан авах асуудлаар төлөвлөх болон шийдвэр гаргах үе шат, (өөр журмын үндэслэл болох онцгой нөхцөл байдлаас бусад тохиолдолд) ил тод байдлаар Төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулах, хуваарилах, гэрээ байгуулах үе шат болон эрх олгосны дараа гүйцэтгэлийг хийх, төлбөрийг барагдуулах замаар гэрээг дуусгавар болгох үе шат. Энэ зүйлд зохицуулалт хийх шаардлагатай хэсгүүдийн талаархи тайлбар мөн багтсан болно.

9 дүгээр зүйлийн 1 (а) догол мөрд тусгасан бараа, ажил, үйлчилгээ худалдан авах асуудалтай холбоотой мэдээллийг олон нийтэд тараах шаардлагатай UNCUTRAL-ын загвар хуулинд ил тод байдлыг хангах арга замыг эрэлхийлсэн тодорхой зүйл заалт багтдаг. Үүнд, холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг хэвлэх, хязгаарлагдмал арга зам сонгох үндэслэл бүхий тодорхой нөхцөл байдлаас бусад тохиолдолд ил тендер эсвэл үүнтэй дүйцэх үйлчилгээг заавал ашиглана. Энэ хуулийг дагалдсан Хэрэгжүүлэх удирдамжинд, тендерийг илээр явуулах нь олон нийтийн үзэл бодлоор авлигаас сэргийлэх тодорхой бараа, ажил, үйлчилгээ худалдан авах зорилгыг хөхиүлэн дэмжихэд хамгийн үр нөлөөтэй арга юм. Тендерийг илээр явуулах нь, ерөнхий зарчим ёсоор, нийлүүлэгч буюу гэрээлэгчдэд оролцох урилгыг ямар нэг хязгаарлалтгүйгээр хүргэх; тендерээс өмнө худалдан авах бараа, үйлчилгээ зэргийг цогц байдлаар тогтоож, тодорхойлох; тендерийг үнэлэх, харьцуулах, амжилттай тендерийг сонгон шалгаруулахад хэрэглэх шалгуурыг нийлүүлэгч болон гэрээлэгчид ил тод байлгах (үнэ дангаар эсвэл үнэ болон зарим техникийн буюу эдийн засгийн шалгуур хосолсон); тендерт нөлөөлөх үүднээс бараа, ажил, үйлчилгээ худалдан авагч хийгээд нийлүүлэгч буюу гэрээлэгчийн хооронд хэлэлцэж тохирох явдлыг хатуу хориглох; тендер хүлээн авах хугацаа дуусгавар болоход тендерийг нээлттэй задлах, мөн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээнд аливаа журмыг ил тод байлгахыг шаарддаг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ил тод арга зам болно. Үйлчилгээ худалдан авах тухайд ил тендер нь ач холбогдлоос хамаарч үйлчилгээ нийлүүлэгчийн ур чадвар, мэргэшсэн байдлыг үнэлэх үйл явц өөр өөр байж болдог.

Дээр дурдсан аргууд тохиромжгүй буюу боломжгүй байх онцгой нөхцөл байдлын хувьд UNCITRAL-ын загвар хууль болон ихэнх тогтолцооны зүгээс бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад үндэслэлтэйгээр хэрэглэж болох өөр бусад аргыг санал болгодог юм. Холбогдох гэрээг байгуулахаар уригдсан нийлүүлэгчийн тоонд эсвэл ил тод байх зарчимд зарим нэг хязгаарлал хийх шаардлагатай болдог эсвэл магадгүй цор ганц эх үүсвэрээс бараа, ажил, үйлчилгээ худалдан авах болдог зэргээс үүдэн тодорхой үндэслэлтэй байх зайлшгүй шаардлага үүснэ. Өөр арга хэрэглэх үндэслэл бүхий нөхцөл байдал гэдэгт бараа, ажил, үйлчилгээ худалдан авч буй байгууллагын хувьд тендерийн журмын дагуу тодорхой эсвэл бүрэн эцэслэн шийдэгдсэн байдлаар техникийн тодорхойлолтыг нарийвчлан гаргах боломжгүй байх, гамшиг ослын улмаас гэнэтийн шаардлага гарах, нарийн буюу мэргэжил шаардсан бараа, барилга байгууламж, үйлчилгээг хязгаарлагдмал тооны нийлүүлэгчээс авч болохоор байх, түүнчлэн бараа, ажил, үйлчилгээг маш доогуур үнээр худалдан авах болсонтой холбогдуулан энэ нь тендерийн тоонд хязгаарлалт хийх үндэслэл болж үүнийг тухайн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах байгууллага тухайлан авч үзэх зэрэг орно. Аль аргыг ямар нөхцөл байдалд хэрэглэхийг тусгасан зохих удирдамжаар хангах нь маш чухал. Гэхдээ UNCITRAL-ын загвар хуулинд дурдсан мөн олон улсад хэрэглэгдэж буй нийтэд сурталчлах онц шаардлагагүй материал болон бусад ихэнх бараа, ажил, үйлчилгээ худалдан авах талаархи бичиг материалд заасанчлан, оролцох болон сонгон шалгаруулах нөхцөл хийгээд шалгуур нь бодит, урьдаас тогтоосон мөн оролцогчдод ил тод байхаас гадна гэрээний эрхийг олгох нөхцөл байдал нь урьдаас хэвлэгдсэн байх ёстой (зарим тохиолдолд *de minimus* босго тавина). Ил бус үйл ажиллагаанд ялангуяа, ил тод байдалтай холбоотой эдгээр арга хэмжээг хүндэтгэн үзвэл зохино.

Ил тод байдлын өөр нэг онцлог тал нь мэдээлэл үнэгүй, үнэн зөв, олж авахад хялбар байх явдал юм. Ил тод байх гэсэн үндэслэлээр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбоотой бүхий л мэдээлэл үнэгүй байх ёстой ч үнэгүй байвал зохих мэдээллийн төрөл болон олж авахад хялбар байх гэдгийг бодит байдалд хэрхэн ойлгох талаар зөрүүтэй санал бодол байдаг. Хэдийгээр ихэнх улс тендерт оролцоход ямар нэг төлбөр авдаггүй ч (зарим нэг тохиолдолд тендерийн бичиг баримтыг тараах төлбөр гэж нэр төдий төлбөр авдаг) зарим олон улсын байгууллага оролцооны зарим нэг хэсэгт төлбөр шаардах нь бий. Иймээс оролцогч улс бүр тендерийн урилга болон зөвшөөрөл олгосон жагсаалтын төрлийн талаар мэдээлэл гэх мэт бараа, ажил, үйлчилгээ худалдан авах журам болон гэрээтэй холбоотой мэдээлэл, тендерт оролцох этгээдэд тендерээ бэлтгэж ирүүлэхэд хангалттай хугацаа олгох зорилгоор гэрээ байгуулах эрх олгох талаархи холбогдох мэдээллийг олон нийтэд түгээх явдлыг хангах хэрэгтэй. Оролцогч улсууд энэ мэдээллийг аль болох үнэгүй түгээхийг хичээнэ.

Оролцогч улс бүр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл явцад оролцоог үр нөлөөтэй байлгахад чухал ач холбогдолтой тэдгээр бүх мэдээллийг урьдаас боловсруулж, тараах хэрэгтэй. Ийм мэдээлэлд, холбогдох бүхий л хууль тогтоомж, дүрэм журам, сонгон шалгаруулах болон эрх олгох шалгуур гэх мэт тендерт оролцох нөхцөл болзол орно. Үүнээс гадна оролцогч улсууд дээр дурдсан бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тусгай арга замд дээд хязгаар болон шаардах тодорхой орчин нөхцлийг зааж өгөх нь чухал. Дүрэм, журмыг зөв хэрэглэсэн эсэхийг дараа нь нягтлан шалгах ба үүнийг хөнгөвчлөх зорилгоор, төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах шийдвэрийг гаргахад бодит бөгөөд урьдчилан тогтоосон шалгуурыг хэрэглэвэл зохино.

Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд хариуцлага хүлээх боловсон хүчинд хамаарах эрсдлийн удирдлага, аудитийн бүртгэл, тодорхой томилох үйл явц, ёс зүйн тодорхой дүрэм болон сургах шаардлага гэх мэт асуудлыг хэрхэн зохицуулахыг урьдаас тогтоосон байх бөгөөд энэ нь олон нийтэд ил тод байх хэрэгтэй. Хууль зүйн хороо хийгээд Улсын Аудитын газрыг гэрээтэй холбоотой баримт бичиг болон төрийн албан хаагчид хүрч ажиллах боломжоор хангасан байх асуудлыг авч үзэх нь чухал. Оролцогч улс бүр дүрэм, журмыг мөрдөөгүй үед хуулийн дагуу нөлөөтэй давж заалдах буюу гомдол гаргах тогтолцоог багтаасан дотоодын үр нөлөө бүхий хяналтын тогтолцоог бий болгоно. Үр дүнд нь, жишээлбэл, бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл явцад хууль дүрэм зөрчсөн эсвэл ёс зүйн зөрчил гаргасан нь нэгэнт батлагдсан тохиолдолд гэрээлэгч байх эрхийг нь түдгэлзүүлж болох юм. Үр нөлөө бүхий хориг арга хэмжээний журмын жишээг http://www.eipa.eu/files/repository/eipascope/Scop06_3_3.pdf хаягаас харна уу. Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах асуудал хариуцсан албан хаагч авилгач үйлдэл эс үйлдлийг эхлүүлсэн тохиолдолд түүнд тодорхой арга хэмжээ авч байх хэрэгтэй.

Оролцогч улс бүр Төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг зохион байгуулж гүйцэтгэх бие даасан байгууллага эсвэл хороо байгуулах асуудлыг судалж үзвэл зохино. Ийм байгууллага нь дараах асуудлуудад гүйцэтгэх буюу хянан шалгах чиг үүрэг тэй байна:

- Үнэ санал болгох болон хэрэгжүүлэх үйл явцад хүрч ажиллах мөн хянах;
- Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл явцын аливаа хэсэгт оролцох;
- Авлигач үйл ажиллагааг эрт үед нь илрүүлэхэд тус болох заль, булхайг илрүүлэх үзүүлэлтийг тодорхойлох;
- Бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбоотой залилан болон авлигын талаар мэдээллийг эмхэтгэж судлах; Үүнд (i) бүхий л гомдлыг хүлээн авах, (ii) утсаар нууц мэдээлэл өгөх үйлчилгээ/шугам нэвтрүүлэх, (iii) эрхийг нь түдгэлзүүлсэн этгээдүүдийн жагсаалтыг олон нийтэд тараах, (iv) хувийн хэвшилтэй гэрээлэх үйл явцад оролцсон төрийн бусад байгууллагатай холбогдох мэдээллийг зохих байдлаар, үр нөлөөтэйгээр солилцох орно.
- ганц эх сурвалжаас бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэх мэт тодорхой эрх олгох байдлыг хянах;
- Шударга байдлын гэрээг боловсруулж, хариуцан удирдах;
- Боловсрол болон сургалтаар дамжуулан урьдчилан сэргийлэх стратегиудыг уялдуулах, дотоод аудитын чиглэл болон удирдамж түүнчлэн авлигаас сэргийлэх асуудалд зөвөлгөө өгөх зүйл заалтаар хангах, хяналт шалгалтыг нямбай, хичээл зүтгэлтэй байдлаар гүйцэтгэх, эрхийг нь түдгэлзүүлсэн этгээдүүдийн жагсаалтыг бий болгож, хөтлөх;
- Мэдээлэл олж авах эрх чөлөө болон мэдээлэлд хүрэх боломжийг хөхиүлэн дэмжих;
- Мэргэжилтэн сургаж бэлтгэх, ёс зүйн дүрэм болон бараа, ажил, үйлчилгээ худалдан авах асуудал хариуцсан боловсон хүчин ба хяналт шалгалтын байцаагчаас хөрөнгө орлогын мэдүүлэг шаардах явдлыг хөхиүлэн дэмжих.

II.1.3. Тендерийн шалгаруулалтын дүрэм ба нягтлан шалгах үйл явц

Ийм байгууллага нь дор дурдсантай холбогдуулан журам хэрэглэх шаардлагатай:

- Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах журмыг хэрхэн сонгох -жишээ нь: нээлттэй, хязгаарлагдмал, ганц эх сурвалжтай, тохиролцсон, онцгой тохиолдлын журам гэх мэт. Мөн тэдгээрээс хэрхэн сонголт хийх;
- Гэрээг хэрхэн төлөвлөх –жишээ нь: үндсэн буюу эх гэрээ, нэг удаагийн гэрээ;
- Тендер явуулах болон эрх олгох журам: үнэ санал болгох бэлтгэл; төсөв төлөвлөлт; тендерийн хүсэлт тавих болон сонгон шалгаруулалт; гэрээг түгээх; гэрээний хувилбар болон гүйцэтгэл; зөвшөөрөл олгогдсон жагсаалт;
- Эрх олгох шалгуур; үнэ, үнэ/чанар г.м.;
- Тендер явуулах үндэс суурь: босго хязгаар, өөрийн өртөг, нэмэлт өртөг, нөхцөл г.м.
- Жишиг нотолгоо, баталгаажуулалт болон хөндлөнгийн хяналтыг хэрэглэх. Үүнд хуйвалдааны эсрэг болон хээл хахуулийн эсрэг зүйл заалт, эрх түдгэлзүүлэх бодлого, мэдээ баримт тааруулах болон ашиглах, нийлүүлэгчийн бүтээгдэхүүний жишиг, компанийн эдийн засгийн тогтвортой байдлын баталгаа болон гэрээнд нийцэхүйц хүчин чадалтай байх орно. Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тогтолцооны стандартчлал нь хяналт шалгалт явуулахад ашиглах бүрдүүлэгч хэсгүүд бүхэлдээ нэгдсэн байдалтай байхыг шаардана. –жишээ нь., бараа, ажил, үйлчилгээ худалдан авах э-тогтолцоо хэрэглэх замаар;
- Заль, булхайн үзүүлэлт буюу индикатор нь авлигад өртөх эрсдэлтэй талбар, үйл ажиллагааг шийдвэрлэх тодорхой журмыг хянана. (Үүнд, жишээ нь, гэрээний техникийн тодорхойлолтыг зориудаар хуваах, хуурамч бүтээгдэхүүнээр орлуулах гэх мэт)
- Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл явцад оролцож буй төрийн албан хаагч бүрээс хөрөнгө орлогын мэдүүлэг шаардах;
- Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл явцад оролцож буй төрийн албан хаагч бүрт ажлаас чөлөөлөгдсөний дараа болон ажил үүрэг эрхлэхээ больсон үед тавигдах шаардлага (жишээ нь: Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл явцад оролцож буй төрийн албан хаагч албанаас халагдахаас өмнө буюу алба хашиж байх үедээ сайн ажлын байр олж авах талаар нийлүүлэгчтэй тохиролцох явдлаас сэргийлэх);
- Гэрээний хувилбар;
- Гэрээг батлах;
- Гэрээний мэдээллийг түгээх нэг хэрэгсэл болгож Интернет ашиглах;
- Хээл хахууль болон ажил хөнгөвчлөх зорилгоор төлбөр төлөх зэрэг гэмт хэргийн чанартай үйлдэл түүнчлэн авлигын тухай мэдэгдэлтэй холбогдуулан хууль сахиулах газартай уялдаа холбоотой байх;
- Эрх түдгэлзүүлэх үйл явц.

Ийм байгууллага нь техникийн тодорхойлолт болон журмыг будлиантуулах, үнэ санал болгоход хуйвалдах, андуу ташаа зарга болон мэдэгдэл хийх, жишигт үл нийцсэн эсвэл хуурамч бараа материал хэрэглэх гэх мэтээр техникийн тодорхойлолтонд үл нийцэх, гэрээг өөр хооронд нь холих, худал нэхэмжлэл гаргах, гэрээний төлбөрийг давтан төлөх, гэрээний хувилбарыг

урвуулан ашиглах болон худалдаа арилжаанд гачигдал үүсгэх, хуурмаг гэрээлэгч бий болгох гэх мэт авлига болон залилан гарч болзошгүй гол цэгүүдэд эрсдлийн үнэлгээ хийх буюу хийгдсэн байхыг шаардах болно.

II.1.4. Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах асуудлыг хариуцсан боловсон хүчин

Долдугаар зүйлд дурдснаар, оролцогч улс бүр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл явцад оролцдог тодорхой албан тушаалд эрсдлийн үнэлгээ хийх хэрэгтэй. Эдгээр нь албан тушаалаа урвуулан ашиглахгүй байх тал дээр өндөр төвшний баталгаа шаардах ба байгууллагын авлигад өртөх магадлал болон шийдвэрлэвэл зохих үйл явцыг олж тогтооох нь чухал.

Үнэлгээг явуулсны дараа төрийн байгууллага тодорхой тооны урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх явдлыг тооцож үзэх шаардлагатай. Урьдчилан сэргийлэх арга хэмжээнд (томилогдох магадлалтай нэр дэвшигч ёс зүйн өндөр жишигт нийцсээр ирснийг баталгаажуулан) амжилттай нэр дэвшигчийг томилолт хийгдэхээс өмнө шалгаж, нягтлах; амжилттай нэр дэвшигчээс албан тушаалын тусгай болзол, нөхцөл шаардах, албан тушаалд удаан байснаас үүдэлтэй авлига үүсэх магадлал болон үр нөлөөг хязгаарлах арга хэмжээ болгож гүйцэтгэлийг жишиж үзэх эсвэл боловсон хүчинг шилжүүлэх гэх мэт үйл ажиллагааны хяналт орж болно.

Удирдлагаас авилгад өртөх магадлалтай албан тушаал эрхэлж буй төрийн албан хаагчид дэмжлэг үзүүлэхээс гадна тогтмол үнэлэлт өгөх, нууц байдлаар тайлагнах мөн хөрөнгө орлогын, дайлуулгын болон бэлгийн мэдүүлгийг гаргуулж, бүртгэх гэх мэт журмыг удирдан хянах хэрэгтэй. Түүнчлэн боломжтой нөхцөлд, эрсдлийн төвшингөөс хамааран шийдвэр гаргах тал дээр нэг талаар боловсон хүчинг зохисгүй нөлөөллөөс хамгаалах, нөгөө талаас шийдвэр гаргах үйл явцад бие даасан байдлыг нэвтрүүлэх зорилгоор бүрэн эрх мэдэлтэй дан ганц хувь хүнээс илүүтэйгээр зарим тодорхой асуудлын хувьд олон төвшинд хянаж батлах тогтолцоог хэвшүүлэх нь зүйтэй.

II.1.3.-д дурдсанчлан, бараа, ажил, үйлчилгээ худалдан авах асуудал хариуцсан байгууллага нь гадаад хяналтын байцаагч болон 6, 36 дугаар зүйлд тодорхойлсон агентлаг, газар гэх мэт өөр бусад байгууллагатай зөвлөлдөн, Удирдлагын Авлига болон Заль булхайн Эрсдлийн Бүртгэлийг боловсруулж заль булхайгаас урьдчилан сэргийлэх индикаторын тогтолцоо хэлбэрээр ашиглах хэрэгтэй. Энэ тогтолцоо нь төрийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааны тодорхой цэгүүдэд илүү нарийн шинжилгээ хийх мөн хууль зөрчсөн болон авилгач үйлдэл гаргасан компани болон боловсон хүчинг багтаасан эрхийг нь түдгэлзүүлээд буй этгээдүүдийн бүртгэлийг хөтлөх суурь үндэс болж өгнө. Түүнчлэн энэ нь менежер, хяналтын байцаагч болон шинжээчдийг ажлын мэдлэг болон дадал олгох мэргэжлийн сургалтаар мөн тэдний ажлыг хөнгөвчлөх үүднээс бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай журмаар хангах явдлыг хөхиүлэн дэмжих юм.

Техникийн тодорхойлолт хийхэд хэрэглэгдэх бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбоотой ерөнхий үгсийн сан болон жишиг болсон нэр томъёо нь бараа, ажил, үйлчилгээ

худалдан авах үйл явцад бодит байдлыг хангахад чухал үүрэгтэй. Жишээ болгож UNCITRAL-ын загвар хуулийн 16 дугаар зүйлийг харна уу.

Дор дурдсанаар үр нөлөө бүхий нягтлан шалгах үйл ажиллагаа явуулахад хангалттай бичиг баримт олж авах нь нэн чухал. UNCITRAL-ын загвар хуульд (11 дүгээр зүйл) бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл явц бүрт бүртгэл хөтөлж байхыг зааснаас гадна үүнд ямар мэдээлэл багтаасан байхыг ч тодорхой томъёолж өгсөн. Энэ нь хянан шалгалт хийхэд хэрэгтэй гол мэдээллийг бүрдүүлдэг юм. Үүнээс гадна энэ хуулинд мэдээлэл хэр ил тод байх тухай дүрмийг ч тусгасан байгаа. Үндсэндээ, бараа, ажил, үйлчилгээ худалдан авч буй нэгжийн олон нийтийн өмнө хариуцлага хүлээх чадварт тохирсон гол мэдээлэл гэдэг нь олон нийтийг бүрдүүлэгч гишүүн нэг бүрт ил тод байж, талууд өөрсдийн гүйцэтгэлээ үнэлэх мөн гомдол гаргах эрх зүйн үндэслэл бүхий тохиолдлыг илрүүлэн гаргах боломж олгох тийм мэдээлэл байх учиртай юм.

Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл явцын бүрэн бүртгэл нь давж заалдах гэх мэт аливаа зарга үүсгэхэд үр нөлөөтэйгээс гадна ялангуяа хурд, ил тод байдал, олонд хүрч байгаа байдал болон бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл явц буюу гэрээг түр хугацаагаар зогсоох тал дээр тохиромжтой байх шаардлагатай.

Бараа, ажил, үйлчилгээ худалдан авч буй нэгжийн төвшинд төсвийн зохих бэлтгэл нь бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөө гол хүчин зүйл болж өгдөг. Бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад урвуулан ашиглах сайтар баримтжуулсан эх сурвалж болж, жишээлбэл, үндэслэлгүй зарга, нээлттэй бус журам, (бараа, ажил, үйлчилгээ худалдан авах яаралтай бус шаардлага “яаралтай” болж хувирдаг) шаардлагагүй бараа, ажил, үйлчилгээ худалдан авах байдалд (төсөвлөсөн сан хөрөнгө нь зарцуулагдаагүй гэдгээс үрэгдэж алга болсон мэт харагдаж байгаа бол) хүргэдэг. Түүнчлэн сан хөрөнгө үгүй болсноос чухал бараа, ажил, үйлчилгээ худалдан авч чадахгүйд хүрэх талтай.

II.2. Төсвийн удирдлага

II.2.1. Төрийн санхүүгийн удирдлага

Оролцогч улс бүрт төсвийн бэлтгэл болон танилцуулга нь үүрэг хариуцлагын тодорхой байдал, мэдээллийн олон нийтэд хүргээмжтэй байдал, төсвийн бэлтгэл, гүйцэтгэл болон тайлагналтын нээлттэй байдал, аудитын болон хууль тогтоох байгууллагын үр нөлөө бүхий хяналтыг тусгасан байх явдлыг хангана. Төрийн санхүүгийн эрүүл тогтолцоо дараах бүрэлдэхүүн хэсгүүдийг агуулсан байна:

- Төрийн орлогын эх үүсвэрийн ил тод байдал;
- Татварын шаардлагын таамаглаж болохуйц байдал;
- Төсвийн бодитой байдал – төсөв бодит байж төлөвлөсний дагуу хэрэгжих байдал;
- Цогц байдал болон ил тод байдал – төсөв болон санхүүгийн эрсдлийн хяналт нь цогц түүнчлэн санхүү ба төсвийн мэдээлэл нь олон нийтэд хүртээмжтэй байх;

- Олон нийтэд ил тод бөгөөд зохих ёсны шалгуур болон хяналтанд захирагдах төсвөөс хэтэрсэн, төсвөөс гадуур буюу нэмэлт төсвийн тодорхой хэмжээний зарлага;
- Бодлогод суурилсан төсөв төлөвлөлт –төрийн бодлогыг зохих байдлаар харгалзан үзэж төсвийг төлөвлөх;
- Төсвийн гүйцэтгэл таамаглахуйц бөгөөд хяналттай байх – төсвийг цэгцтэй мөн урьдаас таамаглахуйц байдлаар хэрэгжүүлэхээс гадна төрийн сангийн ашиглалтанд хяналтын болон зохион байгуулалтын арга хэмжээ авахад төлөвлөж бэлтгэх;
- Нягтлан бодох бүртгэл, тэмдэглэл, тайлагнал– шийдвэр гаргах үйл явцын хяналт, удирдлага болон тайлагналтын зорилтыг биелүүлэх зорилгоор хангалттай тэмдэглэл, мэдээллийг бий болгох, хөтлөх мөн түгээх;
- Хөндлөнгийн ажиглалт, аудит – Улсын Аудитын газар болон Хууль тогтоох байгууллагын зүгээс төрийн санхүүг хянан шалгаж, Гүйцэтгэх засаглал нь нягтлан үзэж байх; нууц зарлага бүхий тодорхой хязгаарлагдмал хэсгүүд болон төрийн санхүүжилттэй бүх байгууллагад хүрч ажиллах; хууль тогтоох байгууллагын зүгээс аудитын тайланг жил бүр нягтлан хянах.

II.2.2. Улсын төсвийг батлах ажиллагаа

Оролцогч улс бүр зохих үйл явцын дагуу жил бүр улсын төсвийг баталдаг. Сонгуулийн үр дүнд байгуулагдсан хууль тогтоох байгууллага нь улсын жилийн төсвийг батлах эрх мэдлийг хэрэгжүүлдэг. Хэрэв хууль тогтоох байгууллага эсвэл хянан шалгах эрх бүхий байгууллага төсвийг нягтлан шалгаж, хэлэлцэхгүй байх аваас эрх мэдлээ үр нөлөөтэйгээр хэрэгжүүлэхгүй байхын зэрэгцээ төрийн хариуцлагыг хөсөрдүүлж байгаа хэрэг юм. Жилийн төсвийн хэлэлцүүлэгт төсвийг хянах цар хүрээ, хэлэлцүүлгийн дотоод журам, зарцуулах хугацаа зэрэг хэд хэдэн хүчин зүйлийг бодолцож үзэх хэрэгтэй. Сонгуулиар сонгогдсон хууль тогтоох байгууллага байхгүй тохиолдолд оролцогч улсууд нь төрөөс төсвийг дээд зэргээр хянах арга замыг эрэлхийлэх нь чухал.

Төсөв нь төрийн үндсэн бичиг баримт болох тул цогц байж, төрийн бүхий л орлого, зарлагыг хамарч байх хэрэгтэй. Ингэснээр өөр өөр бодлогын сонголт дунд шаардлагатай буулт хийх явдлыг үнэлж чадахаас гадна хууль тогтоох байгууллагын болон төрийн бусад хяналт шалгалт утга учиртай болох юм. Төсвийг батлах хүртэлх үйл явц нь олон тооны асуудлыг шийдэж байх учиртай.

Оролцогч улс бүр нь төсвийн үнэлгээний тайлан гаргахад зориулж төсөв боловсруулах стандартын дагуу хүлээгдэж буй орлогын талаархи хэлэлцүүлэгт түшиглэсэн эдийн засгийн таамаглал дэвшүүлнэ. Төсөвт түүнчлэн санхүүгийн актив болон пассив, санхүүгийн бус хөрөнгө (актив), боловсон хүчний цалин хөлс тэтгэмж мөн нөөцийн санг тусгана.

Оролцогч улс бүр батлан хамгаалах салбарт төлөвлөсөн төсөв болон төрийн бус байгууллагын зардлыг тусгасан төсвийн саналыг олон нийтэд ил тод, хүртээмжтэй байлгана. Улсын төсвийн төслийг хууль тогтоох байгууллага болон олон нийтийн зүгээс зохих ёсоор хянахад хүрэлцэхүйц хугацаа олгох бөгөөд санхүүгийн шинэ жил эхлэхээс наанадаж гурван

сарын өмнө байвал зохино. Хууль тогтоох байгууллага төсвийг санхүүгийн жил эхлэхээс өмнө хянаж дуусгана.

Төсөв болон холбогдох баримт бичигт орлого, зарлагын хөтөлбөрийг дэлгэрэнгүй тайлбарын хамт, мөн санхүүгийн бус гүйцэтгэлийн мэдээ баримтыг (гүйцэтгэлийн зорилго бүхий) тусгасан байна. Хөтөлбөр тус бүрийн өмнөх жилийн орлого, зарлагын харьцуулалтыг бодитоор харин тухайн жилийн хүлээгдэж буй дүнг сүүлийн байдлаар гаргана. Санхүүгийн бус гүйцэтгэлийн мэдээ баримтын тухайд үүнтэй төстэй харьцуулсан мэдээ бэлтгэнэ.

Төсөвт мөн дараагийн санхүүгийн жилээс хойшхи хоёроос доошгүй жилийн орлого, зарлагыг урьдчилсан байдлаар төлөвлөсөн дунд хугацааны хэтийн төлөвийг тусгаж өгнө. Мөн өнөөгийн төсвийн саналыг өмнөх жилийн тухайн үеийн урьдаас таамагласан байдалтай харьцуулж үзэх; төлөвлөгөөнөөс ихээхэн хэмжээгээр зөрүүтэй байх тохиолдол бүрт тайлбар өгөх нь чухал.

Хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн орлого, зарлагын тухайд тухайн орлого, зарлагын хэмжээг мэдээллийн зорилгоор бусад орлого, зарлагын хамтаар төсөвт тусгах шаардлагатай.

Зарлагыг нийт хэмжээгээр нь авч үзвэл зохино. Урьдчилан төлөвлөсөн орлого болон төлбөр хураамжийг тодорхой байдлаар тусад нь тооцно. Төлбөр хураамж цуглуулан төвлөрүүлэгч агентлагийн зүгээс зарлагыг бүхэлд нь эсвэл зарим хэсгийг хангах урамшуулал, хяналтын тогтолцоо байдаг эсэхээс үл хамааран үүнийг хийх шаардлагатай. Зарцуулалтыг захиргааны нэгжээр (яам, агентлаг г.м.) ангилах бөгөөд эдийн засаг болон чиг үүргийн категориор ангилсан нэмэлт мэдээллийг мөн тусгасан байвал зохино.

II.2.3. Орлого зарлагыг цаг тухайд нь тайлагнах

Оролцогч улс бүр татвар төлөгчийн бүртгэл болон тэдгээрийн татвар төлөх үүргийн зөв үнэлгээ хоорондын харилцаагаар тодорхойлогдох татварын үнэлгээний тааварлахуйц байдал хийгээд үр нөлөөтэй байдлыг хангана. Түүнчлэн орлогын гол эх үүсвэрийн ил тод байдлыг татвар хариуцсан эрх мэдэл бүхий байгууллагад мэдүүлсэн байх явдлыг хангах арга хэмжээг авах хэрэгтэй. Оролцогч улс бүр олон улсад үйлдвэрлэлийн зарим тодорхой салбарт авлига гарах магадлал илүү өндөр байдгийг санах нь чухал. Үүнд байгалийн нөөц баялаг олборлолт, үйлдвэрлэлт, түгээлт гэх мэт ашигт малтмал болон бусад нөөцтэй холбоотой салбараас гадна буу зэвсэг, нисдэг тэрэгний наймаа, мөрийтэй тоглоом, эмийн худалдаа орно.

Оролцогч улс бүр, зарцуулалт хийж буй яам, хэлтэс, газар нь орж ирэх хөрөнгө мөнгөний дүнд түшиглэн зарцуулалт хийх тэрхүү хөрөнгө, санхүүгийн боломжийн талаархи үнэн зөв мэдээллийг авч байх явдлыг хангах зорилгоор, ажлын төлөвлөгөөний хүрээнд, төсвийн үр нөлөө бүхий гүйцэтгэлийг хангавал зохино. Түүнчлэн улс бүр санхүүгийн удирдлагын тогтолцоог ил тод байлгахад зайлшгүй чухал хүчин зүйл болох жилийн эцсийн санхүүгийн нэгдсэн тайланг цаг тухайд нь хүргүүлж байх явдлыг хангах хэрэгтэй. Энэ нь бүрэн гүйцэд байхын тулд бүхий л яам, бие даасан хэлтэс болон харьяа нэгж тасгийн дэлгэрэнгүй мэдээлэл дээр тулгуурласан байх учиртай. Үүнээс гадна, жилийн эцсийн санхүүгийн тайланг цаг тухайд нь бэлтгэж чадаж байх нь

нягтлан бодох бүртгэлийн тогтолцоо хэр сайн ажиллаж байгааг болон хөтөлж буй бүртгэлийн чанар ямар байгааг харуулах гол шалгуур үзүүлэлт, болох юм. Зарим тогтолцоонд сангийн яам, санхүүгийн тайланг нэгтгэхээс өмнө бие даасан яам, хэлтэс, харьяа нэгж тасаг тэдгээрийг авч хэлэлцдэг. Илүү төвлөрсөн тогтолцооны хувьд, тайланд хамаарах бүхий л мэдээллийг сангийн яам хариуцаж хадгална.

II.2.4. Нягтлан бодох бүртгэл, аудит, нягтлан шалгалт

Санхүүгийн мэдээллийг үнэн зөв тайлагнахын тулд үйл ажиллагааг тогтмол хянаж, үйл явцын бүртгэл болон үйл ажиллагааг баталгаажуулж байх хэрэгтэйгээс гадна энэ нь дотоод хяналтын гол хэсэг төдийгүй удирдлага болон гадаад тайланг чанартай мэдээллээр хангах үндэс суурь болж өгдөг. Өөр өөр эх сурвалжаас цаг тухайд нь, тогтмол байдлаар мэдээлэл, баримт цуглуулж нэгтгэж байх нь мэдээллийн үнэн зөв байдалд маш чухал нөлөөтэй.

Оролцогч улс бүр хөндлөнгийн болон дотоод аудитын зохих бүтэцтэй байх хэрэгтэй.

Дотоод аудитын гол үүргийг өргөн хүрээнд ийнхүү тодорхойлж болох юм: хөрөнгийн хяналт, орлогын тайлагналт, зардлын хуваарилалтын үнэн зөв байдлыг нягтлан шалгах аудитын үндсэн үйл ажиллагаа; санхүүгийн, үйл ажиллагааны болон удирдлагын хяналтын тогтолцооны хангалттай хийгээд үр нөлөөтэй байдлыг шалгах зорилго бүхий тогтолцоонд суурилсан аудит; ажил хэргийн хуульд нийцэх байдал болон үргүй зарцуулалт, хэт зарцуулалт, мөнгөнд доогуур үнэлэмж өгөх явдал, залилан мөн авлигаас сэргийлэх байдлыг хянах шударга байдлын, эдийн засгийн, үр ашгийн болон үр нөлөөний аудит; бүхэлдээ эрсдлийн менежментэд суурилсан аудит.

Сангийн яамны зүгээс аж ахуйн нэгжийн эргэлтийн хөрөнгийн хэмжээ, болон дотоод аудитын чадавхи цар хүрээнээс хамааран аудитын чиг үүргээ хангалттай биелүүлэх мэргэжлийн итгэмжлэгдсэн этгээдүүдийг түшиглэн жилийн санхүүгийн тайлан тооцоогоо өгөх талаар зохих удирдамжаар хангана.

Товчхондоо, Дотоод аудитыг Оролцогч улсын үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд төрийн байгууллагын удирдлага бий болгоно. Энэ нь хэдийгээр бие даасан байдлаар үйл ажиллагаа явуулах ч зохион байгуулалтын хувьд удирдлагын чиг үүргийн нэг хэсэг болох юм.

Хөндлөнгийн буюу төрийн аудитын ерөнхий зорилго нь удирдлагын зохион байгуулах чиг үүргийн гүйцэтгэлд, ялангуяа төрийн мөнгөний ашиглалттай холбоотой хэсэгт үнэлгээ өгөх мөн хариуцлагатайгаар чиг үүргээ гүйцэтгэх явдлыг хангах юм. Энэхүү ажилд Дотоод аудитын ажилд болон боловсон хүчний хүчин чадалд үнэлэлт өгөх явдал мөн орно. Дотоод болон Улсын аудитын хооронд тайлагнах, сургах, албан тушаал баталгаажуулах асуудлаас гадна дундын итгэмжлэлийн төвшинтэй байх мөн боловсон хүчин солилцох талаар урьдаас томъёолж тогтоосон албан харилцаа байна.

Улсын аудитын газрууд чадвар болон ажилтай холбоотойгоор Дээд аудитын институциудын Олон улсын байгууллага (INTOSAI) зэрэг олон улсын байгууллагад хандаж удирдамж, зөвлөмж авч болно. Энэ тал дээр 1998 онд Уругвайд явагдсан INTOSAI-н XVI дугаар бага хурлын дүгнэлтэнд авлигаас сэргийлэх үйл хэрэгт дээд аудитын байгууллагын оролцоог

улам нэмэгдүүлэхийг дэмжсэн байдаг. Оролцогч улс бүр Улсын аудитын тусдаа нэгж байлгаж, үйл ажиллагааны бие даасан байдал, зохих шаардлагыг хангаж хуулийн дагуу томилогдсон удирдлага болон чиг үүргээ биелүүлэх хангалттай хүчин чадлаар хангахаас гадна төрийн аливаа сангийн зарлагад хүрч ажиллах мөн хууль тогтоох байгууллагад тайлагнах эрх олговол зохино. Түүнчлэн оролцогч улс бүр олон улсын аудитын ерөнхий жишигт нийцүүлэн илүү өргөн хүрээний сургалт явуулж, аудитуруудын ур чадварыг дээшлүүлэх зорилгоор мэргэжлийн байгууллагын төлөөлөлтэй хамтран ажиллах хэрэгтэй.

Хөндлөнгийн аудитын ажлаа хэрхэн гүйцэтгэж байгааг тодорхойлоход тухайн аудитын газрын хамрах хүрээ, аудитын зохих жишгийг хэрхэн дагаж мөрдөж байна, өөрийн тайландаа санхүүгийн удирдлагын зохион байгуулалтын асуудалд төвлөрөлт, түүнчлэн санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, ажил хэргийн тогтмол байдал, дотоод хяналтын болон бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тогтолцооны үүргийн гүйцэтгэл гэх мэт санхүүгийн аудитын бүхий л хүрээний гүйцэтгэлийг харгалздаг. Өндөр зэрэглэлийн аудитын үүрэгт (томоохон гэрээнд мөнгөний үнэлэмж гэх мэт) гүйцэтгэлийн аудитын зарим нэг онцлог тал багтсан байх учиртай. Аудитын чиг үүрэг нь дээр дурдсанчлан төсвөөс гадуур сан, харьяа агентлаг түүнчлэн хувийн хэвшлийн гэрээлэгч гэх мэт төрийн сангаас санхүүжилт авдаг аливаа байгууллагыг хамарна.

Аудитын үйл явц үр нөлөөтэй байхад тайлан болон дагалдах үйл ажиллагааг цаг тухайд нь гүйцэтгэж байх явдал маш чухал. Туршлагаас харахад хөндлөнгийн хяналт хийсэнээс хэдэн жилийн дараа аудитын тайлан нь ил болж байгаа тохиолдолд аудитаар шалгуулсан байгууллага энэхүү дүгнэлтийг хугацаа хэтэрсэн гэж үзэх эрхтэй болохоос гадна эсвэл тухайн холбогдох этгээд нүүж өөр газар шилжсэн байх явдал гардаг. Энэ тохиолдолд арга хэмжээ авах шахалт буурна гэсэн үг. Аудитын тайланг цаг тухайд нь өргөн барьж байх явдлыг хуулиар эсвэл өөр бусад үр нөлөө бүхий хэрэгслээр зохицуулах нь зүйтэй.

Үйл явц нь төрийн тогтолцооноос зарим нэг байдлаар хамаарч болох ч, ерөнхийдөө Гүйцэтгэгч (бие даан аудит хийсэн байгууллага нэгж буюу сангийн яам) хөндлөнгийн шалгагчдын тодорхойлсон алдаа доголдол болон тогтолцооны сул талыг засах замаар аудитын дүгнэлтийг бататгана. Аудитын дүгнэлтийг үр нөлөөтэй байдлаар бататгасан эсэхийг гэрчлэх баримт нь Гүйцэтгэгчийн зүгээс аудитын дүгнэлтийн хариуд эдгээр асуудал хэрхэн шийдэгдэхийг эсвэл хэдийн шийдэгдснийг тодорхойлон бичсэн албан хариу юм. Дараагийн жилийн хөндлөнгийн аудитын тайлан нь хөндлөнгийн хяналтын байгууллагын аудитын асуудлыг шийдвэрлэн, зөвлөмжийг хэрэгжүүлсэн цар хүрээг дүгнэх замаар хэрэгжилтийг гэрчилж байж болно. Эдгээрийг хууль тогтоох байгууллагын зохих хороонд өргөн барьж хэлэлцүүлнэ.

Хууль тогтоох байгууллага өөрийн баталсан төсвийн гүйцэтгэлийг хянан шалгах асуудалд чухал үүрэг хүлээнэ. Энэхүү үүргийг ихэвчлэн гадаад аудитын тайланг хянаж, тайлангийн дүгнэлтийн талаар хариуцсан талуудад асуулт тавих үүрэг бүхий хууль тогтоох байгууллагад харьяагдах хороо, комисс гүйцэтгэдэг. Энэ хороог үйл ажиллагаагаа явуулах хангалттай санхүүгийн болон техникийн нөөцөөр хангахаас гадна түүнд төрийн албан тушаалтан болон холбогдох баримт бичгийг шаардах эрх болон аудитын тайланг хянан шалгахад хангалттай цаг хугацаа олгох учиртай. Нээлттэй шүүх хурлыг олон нийтэд нээлттэй явуулна. Хороо гадаад аудитын зөвлөмжийг батлахаас гадна Гүйцэтгэгчид авч хэрэгжүүлэх арга хэмжээ болон хориг

арга хэмжээг санал болгож болно. Хороо засч сайжруулахтай холбоотой авч хэрэгжүүлж буй арга хэмжээг хянах эрхтэй байна.

Зөвхөн төрийн байгууллагаар зогсохгүй мөн төрөөс санхүүждэг аливаа байгууллага дээр төвлөрөх нь чухал. Тэдгээр нь (а) хуулийн дагуу хууль тогтоох байгууллагад аудитын тайлангаа өргөн барих үүрэгтэй эсвэл (б) тэдгээрийн хариуцагч эсвэл хянагч яам, хэлтэс нь тухайн агентлагийн өмнөөс асуултанд хариу өгч, арга хэмжээ авах үүрэгтэй байж болно. Иймээс оролцогч улс бүр Улсын аудитын газарт төрийн болон хувийн хэвшлийн аливаа байгууллагын төрийн сангийн зарцуулалтанд хүрч ажиллахыг мөн хууль тогтоох байгууллагад жил бүр хуваарийн дагуу тайлангаа өргөн барихыг зөвшөөрсөн хуулийн зүйл заалттай байвал зохино. Хууль тогтоох байгууллага нь тайланг хожуу өргөн барьсан болон Улсын аудитын газартай хамтран ажиллахад доголдол үүссэн аливаа асуудлыг шалгах эрхтэй байх учиртай. Ийм төрлийн тайлан нь дүрэмд зааснаас бусад тохиолдолд олон нийтэд нээлтэй байна. Улсын аудит нь төрийн байгууллагын санхүүгийн ёс зүйн болон хяналтын журмын жишиг, түүнчлэн аудитын байгууллагын зүгээс өөрийн санхүүгийн харилцааг зохих байдлаар удирдахын тулд хийсэн бэлтгэл ажлын онцлог байдалтай холбоотой асуудлыг хянаж зохих тохиолдолд тайлагнах үүрэгтэй.

Улсын аудитын байгууллагын төрийн сангийн зарцуулалтыг хууль тогтоох байгууллагаас хянаж тогтвортой байдал болон зүй зохистой байдлын асуудлыг онцгойлон анхаарна. Улсын аудит залилан, авлига болон бусад хэлбэрийн зүй зохисгүй явдалд хамаарах аливаа зөрчлийг шинжлэх болон мэдээллэхэд үүрэг хүлээхээс гадна хууль тогтоох байгууллагын мэргэжлийн хороонд тайлагнах эрхтэй.

II.2.5. Эрсдлийн удирдлага, дотоодын хяналтын тогтолцоо

Төрийн мөнгөтэй харьцаж буй этгээд үүний ашиглалтыг ч мөн хариуцах явдлыг хангахад улсын аудит чухал үүрэгтэй. Зүй зохистой байдал нь санхүүгийн тайлангийн хөндлөнгийн хяналт, үйл ажиллагаа тогтмол байхтай холбоотой асуудал болон “мөнгөний үнэлэмж” гэх мэтийг багтаасан аудитын ажлын хүрээнд тодорхойлогдсон нэг төрлийн үүрэг хариуцлага юм. Төрийн албаны хөндлөнгийн шалгагч, төрийн байгууллагын санхүүгийн ёс зүйн болон хяналтын журмын жишиг, түүнчлэн аудитын байгууллагын зүгээс өөрийн санхүүгийн харилцааг зохих байдлаар удирдахын тулд хийсэн бэлтгэл ажлын онцлог байдалтай холбоотой асуудлыг хянаж зохих тохиолдолд тайлагнах үүрэгтэй.

Хөндлөнгийн шалгагч санхүүгийн тайлангийн талаар мэдээлэхээс гадна мөнгөний үнэлэмж, засаглалын асуудал түүнчлэн хэрэгтэй гэж үзсэн үед залилан болон авлигын талаар шалгалт явуулна. Түүнчлэн зүй зохисгүй байдал болон муу засаглалын асуудлаар олон нийтийн ашиг сонирхолд хамаатай гэж үзсэн үед шууд байдлаар тайланг хэвлүүлэх эрх мэдэлтэй байх учиртай. Хууль бус байх магадлалтай үйлдэлд хамаатай мэдэгдэл нь бодит шаардлагаас үүдэн ихэнхи тохиолдолд тусгай тайланд түшиглэсэн байдаг.

Дотоод аудит нь хяналтын асуудалд чухал үүрэгтэй. Дээр дурдсанчлан дотоод хяналтын орчинг бүрдүүлэгч нэг хэсэг болохоос гадна энэ нь зүй зохистой байдлын асуудалд

байгууллагын өөрийн хяналт явуулах хэсэг болж үүрэг гүйцэтгэнэ. Дотоод аудитын энэхүү өөрийн байгууллагын эрсдэл, дотоод хяналт болон нарийн тодорхой мэдлэгт төвлөрч байгаа байдал нь зүй зохистой байдлын асуудлыг шийдвэрлэхэд чухал үүрэг хүлээхэд хүргэдэг. Аливаа байгууллагын дотоод аудиттай ойр уялдаа холбоотой байх нь хөндлөнгийн аудит болон тухайн бинзесийн талаар нарийн ойлголт олж авахын тулд зүй зохистой байдлын хяналт шалгалтыг явуулж буй, 6 болон 36 дугаар зүйлийн хүрээнд тодорхойлсон авлигаас сэргийлж, шалгах үйл явцад оролцох байгууллагад тустай болно. Оролцогч улс бүр Улсын аудит нь тэдгээр байгууллагатай мэдээлэл солилцон хамтран ажиллах эрхтэй байх явдлыг хангах хэрэгтэй.

Хөндлөнгийн аудитор зүй зохисгүй байдлыг тодруулах зорилгоор санхүүгийн тайлангийн шалгалтын нэг хэсэг болгож тусгай үйл ажиллагааг явуулах шаардлагагүй үед мөн аудитын ерөнхий ажилтай холбоотойгоор санхүүгийн тайлан нь залилан болон авлигын үйлдэлтэй холбоотой буруу мэдэгдлээс ангид гэдгийг өөрсөдөө баталгаажуулах үндэслэл бүхий алхамуудыг авч хэрэгжүүлж, төрийн ёс зүйн ерөнхий стандартыг үл мөрдөх явдал гарч болзошгүй хийгээд гарсан тохиолдлуудын талаар сонор сэрэмжтэй байвал зохино. Тухайлбал, хөндлөнгийн шалгагч ерөнхий хяналтын орчны талаар мэдлэг олж авах зорилгоор ажлын байрнаасаа тухайн нэгжийн үйл ажиллагаагаа явуулдаг засаглалын хүрээ болон ёс зүйн жишгийн талаар ерөнхий ойлголт олж авч болно. Энэ нь аливаа зүй зохисгүй байдлын талаархи мэдээллийн чухал эх сурвалж болох боломжтой. Хөндлөнгийн аудитор дараах үүргийг гүйцэтгэнэ:

- Байгууллагын үйл ажиллагаагаа явуулахтай холбоотой ерөнхий дүрэм журам болон бусад удирдамжтай танилцах;
- Бодлого болон журам нь цогц, орчин үеийн шаардлагад нийцсэн эсэхийг харгалзахын сацуу ёс зүйн дүрэм болон зааврыг хэрэгжүүлэхтэй холбоотой бодлого болон журмын талаар удирдлагуудтай хэлэлцэж мэдээлэл авах
- Холбогдох дүрэм болон зааврыг мөрдөхийг сурталчилж, хянах зорилгоор нэвтрүүлсэн бодлого буюу журмыг удирдлага, дотоод хөндлөнгийн шалгагч болон бусад холбогдох газартай хэлэлцэх.

Иймэрхүү зүй зохисгүй байдалд хөндлөнгийн шалгагчийн анхаарал хандуулах бусад журамд эдгээр орно:

- Удирдах төвшинд шийдвэр гаргахтай холбоотой баримтжуулалтыг хянах;
- Байгууллагын хяналтын орчинг, ялангуяа залилан, авлига болон бусад зүй зохисгүй байдал гарах эрсдэл өндөртэй салбартай холбоотой бодлого болон журам байхгүй байх явдлыг үнэлэх;
- Байгууллагын соёл, төрийн албан хаагчийн тайлагнах орчинг хянах;
- Дотоод хөндлөнгийн шалгалтын үр дүнг хянах;
- Арилжааны дэлгэрэнгүй мэдээлэл буюу тайлан тэнцлийн шалгалтыг тогтмол явуулах;

Дотоод хяналтын тогтолцооны гүйцэтгэлийн талаар удирдлагад тогтмол бөгөөд хангалттай мэдээлэл өгөгдөх шаардлагатай. Ийм үүрэг нь зохих институцийн орчин үүнд ялангуяа мэргэжлийн бие даасан байдалтай холбоотой институцийн орчин (а), эрх үүрэг,

мэдээлэл олж авах байдал болон тайлагнах эрхийн хангалттай цар хүрээ (b), эрсдлийн үнэлгээний техник гэх мэт аудитын мэргэжлийн арга зүйн хэрэглээний (c) хувьд олон улсын жишгийг тусгасан байх шаардлагатай.

Дотоод хяналтын үүрэг нь дор дурдсан тогтолцооны чухал асуудлыг тайлагнахад төвлөрсөн байна: Үүнд санхүүгийн болон үйл ажиллагааны мэдээллийн үнэн зөв бөгөөд шударга байдал; үйл ажиллагааны үр нөлөөтэй бөгөөд үр ашигтай байдал; хөрөнгийн хамгаалал; эрсдлийн хяналт; хууль тогтоомж, дүрэм журам болон гэрээний хэрэгжилт орно. Зарим оронд эдгээр үүрэг нь үйл ажиллагааны урьдчилсан аудитад хамаардаг ба урьдчилсан аудит нь дотоод аудитын тогтолцооны нэг хэсэгт тооцогдох тул үүнд үнэлгээ өгөх шаардлагатай юм. Өндөр эрсдэлтэй цэгүүдэд төвлөрч байгаа байдал, дотоод аудитын тайланг гадаад аудитын хэрэглэж байгаа байдал мөн дотоод аудитын дүгнэлтэнд үндэслэн удирдлагын авч буй арга хэмжээ нь дотоод аудитын (эсвэл тогтолцооны хяналтын) үйл ажиллагаа үр нөлөөтэй байгаагийн тод нотолгоо болно.

II.2.6. Баримт бичгийн үнэн зөв байдлыг хангах арга хэмжээ

Оролцогч улс бүр төрийн сангаас санхүүжиж буй аливаа байгууллагын бичиг баримт бүрийг урьдаас зөвшилцөн тохиролцсон хугацаагаар хадгалж, мөн нэгдсэн данс болон туслах бүртгэлийг тохиролцсон хуваарийн дагуу устгалд оруулж байх явдлыг хангавал зохино. Энэ төрлийн мэдээлэлд дээр дурдсан бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл явцын бүртгэл мөн орно. Бичиг баримтын эх хувийг хадгалж байхыг хуулиар шаардаж байх учиртай. Гэрээ, хэлэлцээр болон хөрөнгө эзэмших эрхийн бичиг зэрэг бичиг баримтын эх хувийг шүүхэд нотолгоо болгон өргөн барих гэх мэт зорилгоор шаардаж болно.

Өндөр эрсдэлтэй мөн өртөх магадлалтай талбаруудаас гадна (бэлэн мөнгөөр төлбөр хийх; хоосон зардал санаанаасаа зохион бүртгэх; зорилгын буруу тодорхойлолт бүхий үүрэг хариуцлага бүртгэх; хуурамч бичиг баримт ашиглах; болон хуульд заасан хугацаанаас өмнө бичиг баримтыг санаатайгаар устгах зэрэг) холбогдох бичиг баримтын гэмт хэргийг шийдэх хуулийн зүйл заалттай байвал зохино.

10 дугаар зүйл: Олон нийгэд тайлагнах

Авлигатай тэмцэх хэрэгцээг харгалзан үзэж зохих тохиолдолд оролцогч улс бүр зохион байгуулалт, үйл ажиллагаа болон шийдвэр гаргах явцыг оролцуулан нийтийн захиргааны үйл ажиллагаандаа ил тод байдлыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн боломжит арга хэмжээг дотоодын хууль тогтоомжийнхоо тулгуур зарчимд нийцүүлэн авна. Эдгээр арга хэмжээ нь ялангуяа дараахь зүйлийг багтаана:

(a) хувийн нууц, хувь хүний талаарх мэдээллийг хамгаалахад анхаарахын хамт, шаардлагатай тохиолдолд нийгмийн гишүүн нийтийн захиргааны зохион байгуулалт, үйл

ажиллагаа болон шийдвэр гаргах үйл явц, өөрт хамааралтай шийдвэр, эрх зүйн баримт бичгийн талаар мэдээлэл олж авах дүрэм, журмыг батлах;

(b) Эрх бүхий байгууллагад олон нийт нэвтрэх боломжийг дэмжих үүднээс шаардлагатай тохиолдолд, захиргааны журмыг хялбарчлах;

Мэдээллийг нийтлэх. Уг мэдээлэлд нийтийн захиргааны байгууллага дахь авилгын эрсдлийн талаархи тогтмол илтгэлийг багтааж болно.

I. Ерөнхий тойм

Энэхүү зүйл нь иргэд төрийн захиргааны үйл ажиллагааг ойлгож, төрийн албан тушаалтны шийдвэрийн талаар мэдээлэлтэй байж, энэхүү шийдвэр хүрч чаддаг байх явдлыг хангахад чиглэсэн юм. Түүнчлэн, төрийн байгууллага нь тэдний үйл ажиллагаатай холбоотой авлигын эрсдэл зэрэг өөрсдийн үйл ажлын талаар илтгэлийг тогтмол хэвлэн нийтэлж байх хэрэгтэй.

Ил тод байдлын ачаар ард иргэд төрийн захиргаа тэдний тусын тулд юу хийж байгааг ойлгон төрийн байгууллагад илүү их итгэл хүлээлгэх болно. Иргэд тодорхой шалгуурын хүрээнд мэдээлэл олж авах эрхтэй. Үүний зэрэгцээ мэдээлэл олж авах үйл явцыг хялбарчлах арга хэрэгсэл, иргэдийг мэдээллээр хангах цаг хугацаа, хэлбэрийг заасан тодорхой дүрэм болон татгалзах тохиолдолд гомдол гаргах журам байвал зохино.

Ил тод байдал болон мэдээлэл олж авахад хялбар байдлыг нэвтүүлэхэд журам зэрэг мэдээллийг олж авах олон нийтийн эрх болон шийдвэр гаргах журмаас гадна мэдээлэл нь хэр цогц, ойлгомжтой мөн олж авч болохуйц байгааг хянан шалгах явдал зайлшгүй шаардлагатай. Оролцогч улс одоо үйлчилж буй хууль тогтоомж болон шинэ хууль тогтоомжийн нөлөөг хянаж үзэж арга хэрэгслийг эрэлхийлж байж болно. Ийм арга хэрэгсэлд мэргэжлийн холбоо зэрэг хууль ёсны байгууллага болон иргэний нийгэмтэй зөвлөлдөх орно.

Оролцогч улс бүр захиргааны шийдвэр гаргах үйл явцад авлигатай тэмцэх асуудал тусгалаа олсон байх явдлыг хангах хэрэгтэй. Шийдэх шаардлагатай хүчин зүйлд: журмын нарийн төвөгтэй байдал; шийдвэр гаргахад бие даасан байдлын хэм хэмжээ; төрийн мэдээллийг олж авч болохуйц байдал хийгээд мэдээлэл олж авах нөхцөлтэй холбоотой ил тод байдал; ёс зүйн дүрэм байгаа эсэх, мөрдөгдөж байгаа эсэх, түүнчлэн үүний үйлчилгээг хүргэх асуудалтай холбогдож байгаа байдал орно. Оролцогч улс бүр дүрэм журам, дадал хэвшил болон соёлын үнэ цэнийг хөхиүлэн дэмжих замаар зохицуулагч албан тушаалтанд бие даасан байдал олгосноор төрийн үйл хэрэг явуулахад саад болж буй хэт нарийн тодорхой эсвэл нүсэр хяналтгүйгээр авлига газар авах тэр орчин нөхцлийг хэрхэн багасгахыг тооцож үзэх хэрэгтэй.

II. Бодит бэрхшээл ба шийдэл

II.1. Төрийн захиргаанд ил тод байдлыг сайжруулах арга хэмжээ

Энэ зүйлийн үндсэн зорилго нь шийдвэр гаргах явцыг илүү үр ашигтай, ил тод мөн хөриуцлага тооцохуйц байлгаж, төрийн зохион байгуулалтыг тэдгээрийн үйлчилж буй ард түмний эрэлт хэрэгцээ, хүсэл эрмэлзэлд илүү уялдаа холбоотой, нээлттэй болгох явдал юм. Шийдвэр гаргах үйл явц хийгээд шийдвэр гаргагчдад ард түмэн үр нөлөөтэй байдлаар хүрч чаддаг байх нь гүйцэтгэлийн орчны гол цөмийг бүрдүүлэх болно. Захиргааны чиг үүрэг болон үйлчилгээг, тэдгээрийг хэрхэн үнэлдгийг, ямар дүрэм журам болон бусад бичиг баримт шаардлагатайг, мөн зөвшөөрөл олгохоос авахуулаад бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хүртэл асуудлыг хамрах шийдвэр гаргах үйл явцыг тайлбарласан товхимол болон бусад мэдээллийн хэрэгсэлд дээр дурдсан шийдвэр гаргах үйл явц хийгээд шийдвэр гаргагчдад ард түмэн үр нөлөөтэй байдлаар хүрч чаддаг байх явдлыг зааж өгсөн байх учиртай. Яам болон хэлтсүүд ерөнхий мэдээлэл болон журмыг түгээхэд электроник мэдээллийн хэрэгслийг өргөн дэлгэр ашиглах нь зүйтэй. Хэрэв веб хуудастай бол үүгээр дамжуулан мэдээлэл болон холбогдох бичиг баримтыг олонд хүргэж болно. Интернетэд холбогдох боломж хязгаарлагдмал бол төрөөс мэдээлэл олж авах боломжийг илүү уламжлалт арга ашиглан хөнгөвчилж болох юм.

Мэдээлэл үр нөлөөтэй байдлаар олж авах явдалд анхаарвал зохих асуудлууд:

- шийдвэрийг хэн хариуцаж байгаа нь олон нийтэд ил тод байна.
- гаргасан шийдвэр нь олон нийтэд ил тод байна.
- ард иргэд мэдээлэл олж авах арга замын тусламжтайгаар энгийн үгээр тайлбарласан шийдвэрийн талаархи мэдээллийг олж авч чаддаг байна.
- ард иргэд ямар шийдвэр гарсныг мөн шалтгааныг нь мэддэг байна.
- шийдвэрийг эсэргүүцэх буюу давж заалдах үр нөлөөтэй, хялбар арга замаар хангасан байна.

Шийдвэр гаргах эрх мэдэл бүхий аливаа яам, төрийн албан газар нь тэдгээр шийдвэрийг гаргах, бүртгэх болон нийтлэх талаар тодорхой бодлоготой байна. Энэхүү бодлогыг ялангуяа өдөр тутмын үйл ажиллагааны болон удирдлагын шийдвэрт мөрдөж байна. Иргэний хувьд, энэхүү мэдээлэл нь яам, хэлтсийн үзүүлж буй төрийн үйлчилгээний нэг хэсэг эсвэл иргэдэд нээлттэй бичиг баримтад хамаарах нэг зүйл болно. Иргэн энэхүү мэдээллийн тусламжтайгаар аливаа үйл ажиллагаа эсвэл шийдвэртэй холбоотой асуудлаар хаана, хэнд хандахаа, хүсэлт гаргахад ямар бичиг баримт бүрдүүлэх хэрэгтэйг, аль шийдвэрийг хэн хариуцахыг, тэдгээртэй хэрхэн холбоо барихыг, үйл ажиллагааны талаар ямар мэдээлэл олж авч болохыг мөн маргаантай шийдвэрийн талаар хэнд гомдол гаргаж, дав заалдаж болохыг тодорхой мэдэж авах юм

Олон нийтийн олж авах эрхтэй бичиг баримт эсвэл тэрхүү албан тушаалтны гаргасан аливаа шийдвэрт хамаарах аливаа хууль тогтоомж, дүрэм журам зэрэг шийдвэр гаргах үйл явцтай холбоотой олон нийтийн олж авах холбогдох бусад материалыг нуун дарагдуулсан болон ийм мэдээлэл олж авахыг санаатайгаар саатуулсан аливаа эрх бүхий албан тушаалтан нь ёс зүйн дүрмийг (8 дугаар зүйлийг харна уу) эсвэл хүчин төгөлдөр бусад дүрэм журмыг, эсвэл захиргааны зааврыг зөрчсөнд тооцогдоно.

II.2. Төрийн захиргаанд хамаарах мэдээллийг олж авах

Олон нийт төрийн мэдээллийг шаардах эрхтэй байна. Оролцогч улс бүр тайлагнах үүргийн талаархи болон тайлан илтгэлүүдийг, албан бичиг баримтын болоод (үндэсний аюулгүй байдал, хүний хувийн нууц гэх мэт үндэслэлээр) мэдээллийг задруулахыг үл зөвшөөрөх журмын тодорхойлолтыг, бичиг баримтыг олонд нээлттэй болгох хуваарь мөн болон зарга үүсгэх журмыг олж авах талаархи бодлогыг бий болгож, хэвлэн нийтлэх шаардлагатай.

Асуудалд эсрэг өнцгөөс хандах явдал маш чухал. Гэхдээ бодлогын талаархи мэдээлэл олж авах тал дээр аливаа бичиг баримт олж авч болохуйц байна гэсэн зарчмаас хазайхаас гадна аль үндэслэлээр мэдээлэл олж авах явдлыг хязгаарласан эсвэл бүрэн хориглосон болохыг тусгайлан зааж өгнө. Ийм үндэслэлд үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах болон олон улсын харилцаа, төрийн аюулгүй байдал, гэмт хэргийн чанартай үйлдлээс сэргийлэх, мөрдөх болон яллах, хувийн амьдрал болон хуулиар тогтоосон бусад хувийн ашиг сонирхлыг хамгаалах явдал, шүүхийн үйл явцтай холбоотойгоор талуудын эрх тэгш байдал, Улсын эдийн засаг, мөнгө болон валютын ханшийн бодлого, төрийн бодлогыг дотооддоо бэлтгэх явцад төрийн эрх мэдэл бүхий байгууллага доторх болон байгууллага хоорондын хэлэлцүүлгийн нууц байдал орно.

Төрийн байгууллага түүнчлэн олон нийтэд мэдээлэл өгч болох албаны веб хуудас бий болгох асуудлыг бодож үзэн, төрд хамаарах мэдээллийг түгээх, э-төрийн, э-прокурмэнтийн (бараа, ажил, үйлчилгээ худалдан авах), э-захиргааны тогтолцоог хэрэглэх мөн захиргааны журмыг хялбарчлах хэрэгслийг ашиглах явдлыг хариуцах боловсон хүчнийг томилж болно.

Оролцогч улс бүр мэдээлэл олж авах журмыг хариуцах, гомдол саналыг шийдвэрлэх түүнчлэн Обдусмэн буюу Улсын аудит нь тайлагнахтай холбоотой доголдлын талаарх мэдэгдлийг хэлэлцэх эрхтэй байна. Мөн мэдээлэл олж авах болон шийдвэр гаргахтай холбоотой тааруу удирдлагын талаар гомдлыг шинжилж судлах явдлыг хангах тусгай бие даасан агентлаг газартай байх явдлыг бодож үзүүштэй. Түүнчлэн оролцогч улс бүр мэдээлэл олж авах, шийдвэр гаргах болон авлигын эрсдлийн хоорондын харилцааг хянах зорилгоор 6 дугаар зүйлийн хүрээнд байгуулагдсан байгууллага буюу байгууллагуудын үүргийг хэлэлцэж үзэж болох юм.

II.3. Захиргааны журмыг хялбарчлах замаар шийдвэр гаргах эрх бүхий байгууллагад нэвтрэх боломж

Олон тохиолдолд захиргааны журам нь хуучирсан, шинэ журамтай зөрчилдсөн, давхацсан эсвэл хэт үнэтэй болсон байж болно. Энэ нь иргэдээс хүнд суртлын дааж даважгүй их бичиг цаас бүрдүүлэхийг шаардах явдал, шийдвэр гаргах үйл явцад тодорхой бус байдал мөн иргэдээс мэдээллийг давхацсан байдлаар (зарим тохиолдолд нэг ижил албан газраас) шаардах зэрэг явдал үүснэ гэсэн үг. Чөлөөтэй, шударга зах зээлийг хөгжүүлж, гадаад хөрөнгө оруулалтыг татахад саад болохоос гадна иймэрхүү дадал нь төрийн албан тушаалтны албан тушаалаа урвуулан ашиглах цаашлаад залилан болон авлига газар авах орчин нөхцлийг бий болгодог.

Оролцогч улс бүр шаардаж буй журам нь үнэхээр хэрэгтэй эсэх, төлбөр нь асуудлыг шийдэх өртөгт тохирсон эсэх, мөн тэдгээр асуудлыг шийдэхэд олон тооны агенлаг газар эсвэл үйлчилгээ оролцох шаардлагатай эсэхийг тодруулах зорилгоор, тогтмол хянаж байх хэрэгтэй. Жишээлбэл, зөвшөөрөл болон тусгай зөвшөөрөл олгох асуудлыг Иймэрхүү асуудлыг

шийдвэрлэхэд байгууллагын хэрэглэж буй бүртгэлийн тогтолцоо, түүний чанар, үнэн зөв байдал, олон нийтэд хүртээмжтэй байдлаас гадна шийдвэр гаргахад давхцал болон хэт их саатлыг арилгах зорилгоор мэдээлэл, харилцааны технологи нь (ICT) олон тооны албан байгууллагын интерактив хэрэглээг дэмжиж байх явдал маш чухал.

Ямар ч тохиолдолд, Төрөөс мэдээлэл болон үйлчилгээ хүсч буй иргэнд тусах зохицуулалтын дарамтыг багасгахын тулд яам хэлтсүүд хоорондоо ойр уялдаа холбоотой байвал зохино. Оролцогч улсууд зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл, эсвэл тусгай хөнгөлөлттэй холбоотой хууль эсвэл хяналтын заалтыг багтаасан журмын нарийн төвөгтэй байдлыг багасгах замаар илүү үр нөлөөтэй хандлагыг нэвтрүүлж болно. Түүнчлэн авлигад автах магадлалыг багасгахаас гадна захиргааны үйл ажиллагааны ашигтай байдлыг нэмэгдүүлэх зорилгоор, үе шатыг багасгах гэх мэтээр бүтцийн өөрчлөлт хийх, нэг цэгийн үйлчилгээг ялангуяа хувь хүн, компани болон иргэний нийгмийн бусад бүрэлдүүлэгч хэсэгтэй харьцах шаардлага ихтэй “үйлчилгээ хүргэх” талбаруудад нэвтрүүлэх явдлыг бодолцох хэрэгтэй. Энэ нь мэргэжлийн ур чадварыг дээшлүүлж, өгөгдлийн сангийн хэрэглээг бий болгож, шат дамжлагыг цөөлөхийн тулд зөвшөөрөл болон тусгай зөвшөөрлийн төрлийг нэгтгэх эсвэл хоорондоо ялгаатай зөвшөөрөл болон тусгай зөвшөөрлийн асуудлыг шийдвэрлэх нэг ижил үндсэн үйл явц болон журмыг нэгтгэх нэг төрлийн арга хэрэгсэл болж өгөх юм.

II.4. Авлигын эрсдлийн талаар олон нийтэд тогтмол илтгэх

Төрийн байгууллага бүр авлигын аюул занал хийгээд авлигаас сэргийлэх тал дээр хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар тогтмол илтгэж байвал зохино. Энэ илтгэлийн талаар 5 дугаар зүйлд заасан байгаа. Илтгэл нь дараах асуултуудад хариулж байж болно: Яам эсвэл хэлтэс нь ямар чиг үүргийг гүйцэтгэдэг вэ? Ямар үйл ажиллагааг явуулдаг вэ? Аль үйл ажиллагаа, тогтолцоо болон журам нь залилан болон авлигад өртөмтгий вэ? Дотоод болон гадаад эрсдэл нь юу байж болох вэ? Одоогоор хэрэгжиж буй залилан болон авлигаас сэргийлэх зохих гол арга хэмжээ нь юу вэ? Бодит амьдрал дээр эдгээрт хэрхэн үнэлгээ хийж байна вэ?

Оролцогч улсын хууль тогтоох байгууллага нь эсвэл 6 дугаар зүйлийн хүрээнд байгуулсан байгууллага буюу байгууллагууд нь зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл болон тусгай хөнгөлөлтийн хүчин төгөлдөр үйлчилж буй шаардлага болон журмын хэрэгцээ болон ашигтай байдлыг түүнчлэн шинэ зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл болон тусгай хөнгөлөлтийн захиргааны нөлөөллийн үнэлгээг тогтмол хянаж байвал зохино. Эдгээрийг хянаснаар албан тушаалаа урвуулан ашиглах эсвэл авлигад автах магадлалд үнэлгээ өгөх юм. Ийм үнэлгээг 6 дугаар зүйлд танилцуулсан байгууллага буюу байгууллагууд жил бүр хэвлэн нийтэлж, харьцуулан жишиж, хянаж шалгаж байна.

11 дүгээр зүйл: Шүүх засаглалын болон мөрдөн шалгах байгууллагад хамаарах арга хэмжээ

1. Шүүхийн хараат бус байдал, авлигын эсрэг тэмцэлд гүйцэтгэх шүүхийн шийдвэрлэх үүргийг анхааралдаа авч, оролцогч улс бүр эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд

нийцүүлэн, шүүхийн хараат бус байдалд хохирол учруулахгүйгээр шүүхийн байгууллагад ажиллагсдын шударга байдлыг бэхжүүлэх, авлигад өртөх боломжоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.

Ийм арга хэмжээнд шүүхийн байгууллагын ажилтнуудын үйл ажиллагааны дүрэм багтана.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасантай нэгэн адил үр нөлөөтэй арга хэмжээг зарим Оролцогч улсын хувьд шүүх засаглалд хамаарахгүй боловч түүнтэй адил хараат бус статустай мөрдөн шалгах байгууллагад мөн нэвтрүүлж, хэрэглэнэ.

I. Ерөнхий тойм

Энэхүү зүйлд шүүхийн байгууллагад ажиллагсдын шударга байдлыг бэхжүүлэх, тэднийг авлигад автагдах боломжоос урьчилан сэргийлэх арга хэмжээ авна. Ийм арга хэмжээнд шүүхийн байгууллагын ажилтнуудынүйлажиллагааныдүрэмбагтана. Энэхүү шаардлага нь прокурорын байгууллагын хувьд мөн хүчинтэй. Ийм зорилгоор удирдамжийн ихэнх хэсгийг шүүхийн болон прокурорын байгууллагын аль алинд нь ашиглаж болох юм. Шүүхийн байгууллагатай холбоотой удирдамжийг шүүхийн байгууллагын бүхий л боловсон хүчинд хэрэглэж болохуйц байлгахын зорьсон юм. Оролцогч улс бүр дараах удирдамжуудаас санаа авч болно. Үүнд, Шүүхийн Ёс зүйн зарчим, Бангалор, 2002; Шүүхийн шударга байдлын бүлгийн 4 дүгээр чуулганы тайлан, UNODC, 2005; Нэгдсэн Үндэсний байгууллагаас гаргасан Прокурор болон мөрдөн байцаагчдад зориулсан Авилгатай тэмцэх бодит арга хэмжээний талаар гарын авлага, 2005; НҮБ Прокурорын үүргийн талаар Удирдамж, 1990; болон 1999 оны Олон улсын прокурорын нийгэмлэгийн Прокурорын мэргэжлийн үүрэг хариуцлагын жишиг болон Прокурорын гол эрх, үүргийн талаар мэдэгдэл орно. Хэрэгжүүлэлт шүүхийн хараат бус байдал дээр суурилсан байхаас гадна үүнийг холбогдох арга хэмжээг төлөвлөн бий болгох, түгээх мөн хэрэгжүүлэхэд ямагт анхааран үзэх шаардлагатай.

II. Бодит бэрхшээл ба шийдэл

Оролцогч улс бүр авлигын талаар одоогийн шүүхийн тогтолцоонд хяналт явуулж, анхаарал хандуулах шаардлагатай сул тал эсвэл доголдлыг хэлэлцэх хэрэгтэй.

Ийм төрлийн хяналт тавих институцийн орчин нь ямар байхаас үл шалтгаалан Оролцогч улс бүр “манаачдад” (шүүгч, өмгөөлөгч, шүүхийн боловсон хүчин гэх мэт) авлигад автах боломж олгох тогтолцооны сул талыг тодорхойлох зорилгоор шүүхийн байгууллагуудад үнэлгээ өгч байвал зохино. Ийм хяналтаар шүүхийн томилгоо, бүрэн эрхийн хугацаа болон албан тушаалтай холбоотой чухал асуудлаас гадна шүүхээс зарлан дуудах хуудас гаргах, зарлан дуудах, нотолгоог хамгаалалтанд авах, давж заалдах эрхээр хангах, шүүхийн шийдвэрийн баталгаажсан хуулбараар хангах, шүүх хурлыг шуурхайлах болон хойшлуулах гэх мэт асуудлуудыг ч шийдэж өгнө.

Энэ нь эргээд, авлигад автах орчин нөхцлийг хязгаарлахын тулд системтэй шинэтгэл хийх замаар авлигад автах боломжийг багасгах арга хэмжээг авна. Ийм шинэтгэлийн ажилд хэргийн оролцогчид буюу талууд, хотын удирдлага, өмгөөлөгч, цагдаа, хорих байгууллагын ажилтан

зэрэг шүүхийн үйл ажиллагаанд оролцогчдыг шүүхийн байгууллагаас зохион байгуулах зөвөлгөөн, хувь эзэмшигчдийн үндэсний уоркшоп (цугларалт), шүүгчдийн бага хуралд оруулж болно. Хянан шалгах болон нягтлан шалгах үйл ажиллагааг Дээд шүүх, Шүүх үйл ажиллагааны хороо эсвэл үүнтэй дүйцэх байгууллага, эсвэл Хууль зүйн яам гэх мэт байгууллага хариуцаж болно. Энэ байгууллага нь шударга байдалд аюул занал үүсгэх аливаа асуудалд ажиглалт хийн, тогтолцоо болон журмыг шалгаж, энэ талаар илтгэж байх мөн авлигын талаар гомдлыг илтгэж байх эсвэл шүүх үйл ажиллагаан дах авлигын аливаа асуудлын шалтгааныг тогтоох зорилгоор байцаагчийн эсвэл үүнтэй дүйцэх хараат бус албан тушаалын орон тоог бий болгох үндэслэл болон шаардлагыг бодож үзвэл зохино.

II.1. Шүүхийн байгууллагад ажиллагсадын шударга байдлыг бэхжүүлэх арга хэмжээ

Энэхүү зүйлийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор шүүхийн шударга байдлын хүрээнд дараах зүйлсийг хамааруулна. Үүнд:

- Гадаад хүчин зүйлсийн нөлөө, хээл хахууль, дарамт, сүрдүүлэг, аль нэг этгээдийн зүгээс ямар нэг шалтгаанаар шууд болон шууд бус байдлаар хөндлөнгийн оролцоогүйгээр үйл ажиллагаагаа явуулах чадвар;
- Үл ялгаварлах байдал (өөрөөр хэлбэл алагчлалгүй, тал засалгүй мөн ялгаварлалгүйгээр үйл ажиллагаагаа явуулах чадвар);
- Зохих ажиглагчийн нүдэнд биеэ өв тэгш байдлаар авч явах байдал;
- Шүүх байгууллагад ажиллагсдын хувийн болон мэргэжлийн ажил үүргээ зүй зохистойгоор гүйцэтгэж байгаа байдал;
- Нийгмийн олон талт, ялгаатай байдлыг мэдэрч, ойлгож, хүлээн зөвшөөрөх мөн ийм ялгаатай байдлыг хүндэтгэх явдал;
- Ур чадвар;
- Хичээл зүтгэл ба сахилга бат орно.

“Шүүхийн хараат бус байдал” нь шүүхийн байгууллага болон засгийн газрын бусад байгууллагын хоорондын харилцааг тодорхойлж, шүүхийн үйл ажиллагааны шударга байдлыг хангах институцийн болон үйл ажиллагааны орчинд мөн хамаарна. Энэхүү орчин нь шүүхийн тогтолцоонд хамаатай аливаа асуудлын хүрээнд шүүн таслах эрхийг шударга бөгөөд эрх тэгш байдлаар хэрэгжүүлэхэд шаардлагатай хамт олны буюу байгууллагын хараат бус байдлыг баталгаажуулахыг зорино. Шүүхийн хараат бус байдалд зайлшгүй чухал гурван нөхцөл байдаг.

Үүний эхнийх нь шүүхийн аливаа томилгоонд албан тушаалын баталгаажсан байдал шууд хамаарна. Өөрөөр хэлбэл аливаа албан тушаалтан өндөр насны тэтгэвэрт гарах хүртэл хугацааг хамарсан, тодорхой хугацаанд үргэлжлэх эсвэл тусгай шүүн таслах даалгавартай холбоотой байхаас үл хамааран Гүйцэтгэх засаглалын байгууллага болон бусад томилгоо явуулах эрх мэдэл бүхий албан тушаалтны өөрийн үзэмжээр эсвэл дур зоргоор хөндлөнгөөс оролцох явдлаас хамгаалагдсан байна гэсэн үг юм. Хоёрдугаарт, шүүхийн албан тушаалд томилогдсон этгээдийг цалин, өндөр насны тэтгэвэр зэрэг санхүүгийн баталгаагаар хангасан байх бөгөөд энэхүү санхүүгийн баталгаа нь хуулиар зохицуулагдаж, Гүйцэтгэх засаглалын зүгээс шүүхийн хараат байдалд нөлөөлөх байдлаар, дур зоргоор хөндлөнгөөс оролцох явдлаас ангид байна. Эцэст нь,

оролцогч улс бүр шүүхийн тогтолцоонд хуваарилсан сангийн удирдлага гэх мэт шүүхийн чиг үүргийн гүйцэтгэлд шууд хамаарах захиргааны асуудалтай холбоотойгоор байгууллагын бие даасан байдлыг хангана. Шүүгчийн хуваарилалт, шүүх хурал, шүүхийн жагсаалт зэрэг шүүн таслах үйл ажиллагаанд шууд хамаарах асуудалд хөндлөнгөөс оролцох боломжийг ямарваа нэг гадаад хүчин зүйлд нөлөөлөхгүй байвал зохино. Хэдийгээр шүүх байгууллага болон Гүйцэтгэх засаглалын хооронд ямар нэг байдлаар институцийн харилцаа үүсэх нь гарцаагүй ч ийм харилцаа нь хувь этгээдийн заргыг шүүн шийдвэрлэх мөн Үндсэн хууль болон бусад хуулийг эрхэмлэн дээдлэх шүүхийн үүрэгт хөндлөнгөөс ямар нэг нөлөө үзүүлэхгүй байх учиртай.

Шүүх хараат бус байхын тулд шүүгчид иргэний нэхэмжлэлээс хамгаалагдсан байхаас бусдаар хуулийн хэрэгжилтээс ангид, халдашгүй байх шаардлагагүй бөгөөд шүүхийн үйл ажиллагааг сааруулахгүй байвал зохино. Олон оронд шүүгчид бусад иргэний адилаар эрүүгийн хуулийн өмнө хариуцлага хүлээдэг. Шүүгч хуулийг мөрдөх явдлаас ангид биш бөгөөд ийм байх ч учиргүй юм. Шүүгч хийгээд шүүхийн байгууллагад ажиллагсдын гэмт хэрэгт холбогдсон тухайд цагдаа болон төрийн бусад байгууллагын зүгээс мөрдлөг явуулах зохих үндэслэл байгаа тохиолдолд ийм мөрдлөгийг хуульд заасан ёсоор зохих байдлаар явуулна.

Зарим улс шүүгчийг гэмт хэрэгт буруутган яллах явдлаас хамгаалсан байдаг. Ийм халдашгүй байдал хэрэгжиж байгаа үед, шүүгчийн авлигатай холбоотой хэргээр яллагдахаас мултрах магадлалыг хязгаарлах мөн шүүгчийн хариуцлага хүлээх байдлыг сулруулахгүй байх зорилгоор “чиг үүргийн” хандлагыг бий болговол зохино. Ингэснээр шүүгч зөвхөн шүүхийн чиг үүргээ гүйцэтгэх үйл ажиллагаатай холбогдон гарсан гэмт хэргээр яллагдах явдлаас хамгаалагдах юм. “Чиг үүргийн” хандлагыг эрүүгийн хариуцлагаас мултрах зорилгоор урвуулан ашиглах явдлаас сэргийлэхийн тулд зохих нөхцөлд халдашгүй байдлыг цуцлах нь маш чухал. Гэхдээ үүний зэрэгцээ энэхүү цуцлах үйл явц нь ил тод, шударга бөгөөд тогтмол хэрэгжиж байх баталгаагаар хангавал зохино.

II.2. Шүүхийн байгууллагад авлигадөртөх нөхцөл бүрдэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ

Шүүхийн байгууллагад ажиллагсадын дунд авлига гарахаас сэргийлэхэд хоёр зүйлийг онцгой анхаарах хэрэгтэй. Эдгээр нь шүүгчийг томилох, албан тушаал ахиулах явдал болон тэдний хариуцсан ажилтай холбоотой.

Юун түрүүнд, шүүгчийг томилох болон тушаал ахиулах талаар ил тод журмыг бий болговол зохино. Шүүхийн томилгоо нь бодит бөгөөд урьдаас тогтоосон шалгуур дээр үндэслэсэн байна. Гэхдээ энэ шалгуур нь ерөнхий байдлаараа төрийн бусад албан тушаалтныг сонгох шалгуураас доогуур биш мөн тухайн чиг үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай тусгай мэргэжлийн ур чадварыг тусгасан байх учиртай. Түүнчлэн томилолт явуулахаас өмнөх ажил үүргийн гүйцэтгэлийг зохих байдлаар нягтлан үзэх нь ашиг тусаа өгнө. Цөөнгүй улсад, шүүхийн байгууллагад ажилд орохын тулд шүүхийн академи зэрэг мэргэжлийн байгууллагын зохион явуулах элсэлтийн шалгалт мөн үүнийг дагасан эрх олгох сургалтанд хамрагдах шаардлагатай байдаг. Түүнээс гадна олон орны хувьд элсэлтийн шалгалт болон сургалтын асуудлыг багтаасан томилгооны тогтолцоог шүүхийн дээд зөвлөл, шүүхийн комисс гэх мэт шүүхийн өөрийн институцийн механизмаар зохицуулж өгдөг. Ахлах шүүгчдээр удирдуулсан институцийн

механизм нь тэдгээрийн алба хаах хугацаанд үүсэх ажилд авах, томилох, тушаал ахиулах, сургах асуудлаас гадна шүүгчдийн дүрэм болон удирдлагыг багтаан шийдвэрлэсэн байдаг. Энэхүү механизм нь шүүгчийг шилжүүлэх, албан тушаал үл ахиулах эсвэл ажлаас халах замаар улс төрийн зорилготой хөндлөнгөөс ангид байх шүүхийн шийдвэрийн хараат бус байдлыг хамгаалахыг зорьж байгаа юм. Шүүгчийг түтгэлзүүлэх тал дээр тодорхой дүрэм байх шаардлагатай. Цөөнгүй тооны улс оронд энэ асуудлыг шүүх тогтолцоог зохицуулах механизм нь хариуцдаг бөгөөд тогтоосон шалгуур болон харилцан тохиролцсон, ил тод журмын дагуу ёс зүйн зөрчил гаргасан эсвэл ажил үүргээ цаашид явуулах боломжгүй болсон нь нэгэнт батлагдсан тохиолдолд л энэхүү арга хэмжээг авдаг аж.

Хоёрдугаарт, оролцогч улс бүр шүүхийн үйл ажиллагааг нээлттэй, хүртээмжтэй байлгаж шүүхийн шударга байдлыг бэхжүүлвэл зохино. Хуульд заасан онцгой нөхцлөөс бусдаар шүүх хурал олон нийтэд нээлттэй байна. Шүүгч өөрийн гаргасан шийдвэрт үндэслэл өгч байх явдлыг шүүгчид хуулиар үүрэг болгосон байх учиртай. Давж заалдах үйл явцыг үр нөлөөтэй байлгах зэрэг арга замаар шүүхийн шударга байдлыг хангахын тулд шүүхийн шийдвэрийн үндэслэлийг бүртгэж байх.

Нөгөөтэйгүүр, шүүхийн үйл ажиллагааг тогтмол зохицуулж, чиглүүлж байх нь авлигаас сэргийлэхэд маш чухал үүрэг гүйцэтгэдэг. Шүүх хурлыг үр нөлөөтэйгээр удирдан явуулахад дараах зүйлсийг анхаарвал зохино. Үүнд:

- Шүүхийн журам болон шүүх хурлын талаар тайлбарласан мэдээллийг (шүүх хурал явуулах байранд) тогтмол байрлуулж олны хүртээл болгож байх;
- Шүүхийн шийдвэрийг багтаасан шүүх хурлын протоколуудыг хадгалж, эмхэлж байх;
- Шүүх хурлын хуваарийг багтаасан шүүхийн бүртгэл мэдээллийг компьютерт оруулах, мөн компьютерт оруулсан хэргүүдийг зохицуулах компьютерийн удирдлагын системийг нэвтрүүлэх;
- Хэргийг шүүх хуралд бэлтгэхэд зайлшгүй шаардлагатай үе шатуудад эцсийн хугацааг тогтоох явдлыг нэвтрүүлэх;
- Шүүх тогтолцооны зүгээс иргэдийн гомдолд даруй, үр нөлөөтэй байдлаар хариу өгөх орно.

Шүүгчид шүүх хуралдааныг явуулах хийгээд эцэслэн шийдэхэд гарч буй хүлээлгэх, саатуулах ажиллагааг багасгах мөн зохисгүй байдлаар хүлээлгэхийг таслан зогсоох үүрэг хүлээнэ. Түүнчлэн хуулийн мэргэжилтэн болон заргалдагч талуудад шүүх хурлын статусын талаар мэдлэг олж авах боломж олгох ил тод механизмыг нэвтрүүлэх нь чухал. (Шийдэгдэх шатанд байгаа хэргийн жагсаалтыг шүүгчид дунд тараах аргыг энд дурдаж болох юм.) Хууль ёсны арга хэмжээ одоогоор байхгүй тохиолдолд шүүгчид өөрсдөө жишгийг тогтоож болох бөгөөд үүнийхээ хууль ёсоор хэрэгжих явдлыг хангах зорилгоор олон нийтэд зарлан мэдэгдэж болно.

Шүүхийн бүртгэлийг устгах болон нуун дарагдуулах явдлаас сэргийлэх тал дээр шүүхийн байгууллага шаардлагатай арга хэмжээг авбал зохино. Ийм арга хэмжээнд шүүхийн бүртгэлийг компьютерт оруулж болно. Шүүхийн баримт материал алга болох болон үрэгдүүлсэн

тохиолдолд мөрдөх ажиллагаа явуулах. Зөрчил үүссэн байж болзолгүй тохиолдол бүрт баримт материал алдагдсан эсэх талаар шинжилгээ судалгаа хийж байвал зохино. Ер нь баримт материал алдагдах нь шүүхийн үйл ажиллагааны ноцтой зөрчилд тооцогддог. Баримт материал алдагдсан нь нэгэнт тогтоогдсон бол тухайн баримтыг дахин сэргээх мөн цаашид баримт материал дахин алдагдахаас сэргийлэх арга хэмжээг авах хэрэгтэй.

Заргалдагч талын зүгээс шүүгчийг хяналтандаа авсан байдал үүсгэхгүй байх мөн ийм ойлголт төрүүлэхгүй байх зорилгоор тодорхой шүүгчдэд хэрэг хуваарилах тал дээр ил тод бөгөөд олон нийтэд нээлттэй журмыг шүүхийн байгууллагаас авч хэрэгжүүлнэ. Өөрөөр хэлбэл нас, хүйс, арьс, өнгө, үндэс угсаа, шашин шүтлэг, цөөнхөд харъяалагдах байдал болон шүүгчийн бусад онцлогтой холбоотой хүчин зүйлийг харгалзан шүүгчдийн хуваарилалтыг тогтмол өөрчилж байхын тулд шүүхийн тогтолцооны хүрээнд зохих журмыг авч хэрэгжүүлнэ. Ийнхүү тогтмол өөрчилж байх нь ялгаварлах ойлголтыг төрүүлэхгүй байх юм.

Энэ тухайд тодорхой арга зам байхгүй тохиолдолд, хүчин төгөлдөр хэрэгжиж буй хуулийн хүрээнд, шүүхийн байгууллагын зүгээс эрүүгийн ялын зөвтгөх аргагүй байдлаар хэлбэлзэж буй явдлыг багасгах арга замыг нэвтрүүлбэл зохино. Хуулинд ялыг тодорхой заагаагүй тохиолдолд ял шийтгэлийн удирдамж болон үүнтэй төстэй журмыг нэвтрүүлэх замаар энэ асуудлыг шийдэх хэрэгтэй. Ял шийтгэлийн тууштай байдлыг сайжруулах өөр нэг арга нь ялын статистик, мэдээллийг гаргах, шүүхийн сургалт явуулах, ялын жишиг болон зарчмыг тусгасан шүүхийн гарын авлага нэвтрүүлэх явдал юм.

II.3. Дүрэм ба стандарт

Шүүхийн үйл ажиллагаанд шударга ёсыг дэмжих зорилгоор олон арга хэмжээг авах хэрэгтэй байдаг.

Ийм нэг чухал арга хэмжээ бол шүүгчийн албанд орохын тулд хуулийн өндөр түвшний боловсролтой байхыг мөн мэргэжлээрээ ажиллах хугацаандаа ч хуулийн талаархи боловсролдоо анхаарч өндөр түвшинд байлгахыг шаардах явдал юм. Оролцогч улс бүр шүүгчид зориулсан тогтмол сургалтын хөтөлбөрийг нэвтрүүлэх хэрэгтэй. Олон улсын хуулийн салбарт Шүүхийн болон хуулийн сургалт нь шүүгчдэд илүү ерөнхий хууль зүйн мэдлэгийг олгож байвал зохино. Олон улсын хуульд олон улсын хүний эрхийн хууль, хүмүүнлигийн хууль, байгаль орчны хууль, эрх зүйн гүн ухаан зэрэг багтаж болно. Шүүхийн боловсролд шүүхийн (бодит хийгээд өнгөц байдлаар) тал засах болон бодит байдлаар ялгаварлаж үзсэн эсвэл ийм ойлголт төрүүлсэн тохиолдолд өөрийн эрхийг түдгэлзүүлэх шүүхийн хариуцлагын талаар сургалтыг багтаах хэрэгтэй.

Өөр нэг арга хэмжээ нь сүүлийн үеийн стандартыг тусгасан шүүхийн ёс зүйн дүрмийг нэвтрүүлж, мөрдөх явдал юм. Энэ дүрмээр шүүгч бүрт өөрийн болон гэр бүлийн гишүүдийн хөрөнгө орлого болоод өр төлбөрийг мэдүүлж байхыг үүрэг болгосон байна. Энэ нь 8 дугаар зүйлд заасан илүү ерөнхий сонирхлын зөрчлийг илчлэхтэй холбоотой удирдамжид нийцсэн байвал зохино. Эдгээр мэдүүлгийг тогтмол шинэчилж байх хэрэгтэй. Зургаа дугаар зүйлд заасан шүүхийн хяналтын байгууллага буюу байгууллагуудын ажлын нэг хэсэг болгож хараат бус

тусгай мэргэжилтний зүгээс томилгооны дараа үзлэг шалгалт явуулж, цаашид ч тогтмол нягтлан хянаж байвал зохино.

Ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг нь тогтмол хянахаас гадна шүүгч болон шүүхийн байгууллагын боловсон хүчний талаархи гомдлыг хүлээн авч, шалгаж, шударга, шуурхай байдлаар шийдвэрлэж байх нь ёс зүйн дүрмийг үр нөлөөтэй байлгахад маш чухал. Хэрэгт холбогдон шалгагдаж буй шүүгчид хамаарах зүйл заалтыг тогтоохдоо хүссэн үр дүндээ хүрч чадаагүй заргалдагч тал болон бусад этгээдийн зүгээс шүүгчийн авлига авсан талаар ташаа мэдүүлэг өгөх магадлал хэзээд байдгийг тооцож үзвэл зохино.

Шүүгчийн ёс зүйн дүрмийг шүүхийн боловсон хүчний ёс зүйн дүрэмд хавсаргаж болно.

Өөр нэг арга хэмжээ нь Өмгөөлөгчдийн Холбоо эсвэл Хуулийн Нийгэмлэгийн хариуцлагатай холбоотой. Эдгээр байгууллага нь зохих үндэслэл бүхий авлигын хэргийн талаар холбогдох эрх бүхий байгууллагад мэдээлж байх үүрэг хүлээнэ. Тэд мөн шүүгч болон шүүхийн байгууллагын боловсон хүчинд холбогдох гомдлыг шийдвэрлэх зарчим, журмыг үйлчлүүлэгч болон олон нийтэд тайлбарлах үүрэгтэй. Ийм байгууллага нь мөн авлигын хэрэгт оролцсон гэж сэжиглэгдэж буй гишүүндээ арга хэмжээ авах үр нөлөөтэй арга замыг нэврүүлэх асуудлыг хариуцна. Энэ нь шүүгч болон шүүхийн байгууллагын боловсон хүчинд хамаарна. Шүүгч, шүүхийн ажилтан гэх мэт хуулийн мэргэжил бүхий аливаа этгээд авлигын хэрэгт холбогдсон тохиолдолд мөрдөн шалгах арга хэмжээг авч, бүрэн батлагдсан тохиолдолд албан тушаалаас түтгэлзүүлнэ.

Эцэст нь, хуулийн өмнө эрхтэгш байдлыг хангахад түүнчлэн хувийн өмгөөлөгч хөлслөх үнэ төлбөрт төрөөс үзүүлэх эрх зүйн тусламжинд тодорхой хязгаарлалт хийхтэй холбоотой эрх тэгш байдлыг хангахад шүүхийн хүртээмжтэй байдал чухал ач холбогдолтой гэдгийг тооцон үзэж, хүчин төгөлдөр хуулийн заалтын хүрээнд, мөн хуулийн мэргэжилтнүүдийн санал бодлыг харгалзан шүүхийн хүртээмжтэй байдалд шүүхийн үйл ажиллагааны жишгийг дэмжих төрөл бүрийн санаа, санаачлагыг анхаарч үзвэл зохино. Үүнд жишээлбэл аль нэг заргалдагч талыг үнэ төлбөргүй өмгөөлөгчөөр хангах явдал орж болох юм.

Шүүгчид, ийм хүртээмжтэй байдал нь үндсэн хуулийг дээдэлж, хуульд захирагдах ёсыг төлөвшүүлэхэд амин чухал гэдгийг бодолцон шүүхийн хүртээмжтэй байдлын ач холбогдлыг зохих байдлаар онцгойлон авч үзэх хэрэгтэй. Оролцогч улс бүр авлигын хэргийн нарийн эдрээтэй мөн чанарыг харгалзан үзэж шүүгчдийг авлигын тухай мэргэжлийн сургалтаар хангаж байвал зохино.

II.4. Прокуроруудын шударга байдлыг бэхжүүлэх арга хэмжээ

Оролцогч улс бүр прокурорын үүргээ хуулийн хүрээнд, шударга, тогтвортой шуурхай байдлаар гүйцэтгэж, хүний нэр хүндийг хүндлэн хамгаалж, хүний эрхийг дээдэлж байх явдлыг хангах зорилгоор тодорхой арга хэмжээг авбал зохино. Энэ нь эрүүгийн шүүхийн тогтолцоо саадгүй, жигд байдлаар үүргээ гүйцэтгэж байх явдалд хувь нэмэр болох юм.

Үүргээ гүйцэтгэхтэй холбоотойгоор прокурор дараах зүйлийг анхаарвал зохино. Үүнд: (a) чиг үүргээ гүйцэтгэхдээ улс төрийн, нийгмийн, шашин шүтлэгийн, арьс өнгөний, соёлын, хүйсийн болон бусад ялгаварлалаас ангид байна; (b) нийгмийн ашиг сонирхлыг хамгаалж, бодит байдлаар хандаж, сэжигтэн болон хохирогчийн байдлыг тооцож үзэхээс гадна холбогдох бүхий л орчинг анхаарч, сэжигтэнд хохиролтой эсвэл ашигтай байгаа эсэхээс үр хамааран ажил үүргээ гүйцэтгэнэ; (c) ажил үүргийн гүйцэтгэл хийгээд шударга ёсны шаардлагаас бусад тохиолдолд тэдэнд хамаарах асуудлыг нууцлана; (d) хохирогчийн ашиг сонирхол хөндөгдөх тохиолдолд түүний санал бодлыг харгалзан үзэхээс гадна хохирогч “Гэмт хэргийн хохирогч болон Эрх мэдлийг урвуулан ашиглах талаар Шүүхийн суурь зарчмын Тунхаг”-ийг мэдэж байх явдлыг хангана. Энэ тухайд www.iap.nl.com хаягаар олж авч болох Олон улсын Прокурорын Холбооны Зөв үйл ажиллагааны цувралын дугаар 5 –Хохирогч- тус болж болох юм.

II.5. Прокурорын байгууллагаавлигадөртөхнөхцөлбүрдэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ

Прокурор нь бие даасан байдлаар чиг үүргээ гүйцэтгэдэг улс оронд, ял төлөвлөх, ялаас татгалзах зэрэг прокурорын үйл ажиллагаатай холбоотойгоор шийдвэр гаргахад шударга, тогтвортой хандлагыг дэмжих арга замыг хууль болон хүчин төгөлдөр дүрэм, журмаар тогтоож өгнө.

II.6. Прокурорын ёс зүйн дүрэм ба стандарт

Долоо дугаар зүйлд авч хэлэлцсэн албан тушаалын жишгийн дагуу хараат бусаар мэргэжлийн үүрэг хариуцлагаа гүйцэтгэх төрийн албан тушаалтны хувиар, прокурор нь засгийн газрын дур мэдсэн үйлдэл хийгээд мэргэжлийн жишиг, ёс зүйд харшилсан, хууль бус тушаалыг дагахаас хамгаалагдсан байна. Прокурор төрийн бусад албан тушаалтантай нэг адил нөхцөл, болзлоор хангагдсан байна. Прокурорыг ажилд авах, тушаал дэвшүүлэх журам нь бодит хүчин зүйлст, ялангуяа мэргэжлийн ур чадвар, чадамж, шударга байдал, гүйцэтгэл, туршлага зэрэг шалгуурт суурилсан байвал зохино. Тэднийг урьдаас тогтоосон, үндэслэл бүхий албан тушаал, цалин, өндөр насны тэтгэвэрээр хангаж, тэтгэвэрт гарах болзлыг тодорхой зааж өгсөн байна. Түүнчлэн тэд өөрсдийн ашиг сонирхлыг төлөөлүүлэх, мэргэжлийн сургалтыг дэмжих, статусаа хамгаалах зорилгоор мэргэжлийн холбоо болон бусад байгууллагад нэгдэж болно.

Прокурорыг сүрдүүлэг, саад, дарамт шахалт, хөндлөнгийн зохисгүй нөлөөлөл болон зөвтгөх аргагүй байдлаар иргэний буюу эрүүгийн шийтгэл ноогдуулалтаас ангид мэргэжлийн чиг үүргээ гүйцэтгэх боломжоор хангасан байна. Хэрэв прокурорын чиг үүргээ гүйцэтгэсэнтэй холбоотойгоор тэдний өөрсдийн болон гэр бүлийн аюулгүй байдалд аюул занал учирвал эрх бүхий байгууллага буюу этгээдийн зүгээс тэдний амь насыг хамгаалалтанд авах учиртай. Төрийн бусад албан тушаалтны нэгэн адилаар, ажил үүргээ зохих мэргэжлийн жишигт үл нийцэх байдлаар гүйцэтгэсэн гэсэн шалтгаанаар сахилгын арга хэмжээ авах шаардлага үүсвэл тэднийг хуулийн дагуу шуурхай бөгөөд шударга хуралдаанаар авч хэлэлцэнэ.

Оролцогч улсууд прокурорын үйлчилгээнд өөрсдийн жишгийг боловсруулахдаа авлигатай тэмцэх бодит арга хэмжээний талаар прокурор болон мөрдөн байцаагчдад зориулан

НҮБ-аас 2005 онд гаргасан гарын авлагыг ашиглахаас гадна өөрсдийн орчинд жишиг суулгаж өгөхөд хэд хэдэн гол шаардлагыг хангасан байх арга замыг эрэлхийлж байж болох юм.

Хамгийн эхний шаардлага бол мэргэжлийн ёс зүйд ач холбогдлыг өгөх явдал юм. Прокурорууд өөрсдийн мэргэжлийн нэр хүндийг хэзээ ямагт эрхэмлэж, хууль, мэргэжлийн дүрэм, ёс зүйд нийцүүлэн биеэ авч явах юм. Түүнчлэн хэзээ ямагт шударга, анхаарал болгоомжтой байж, амжилтаа жигд хадгалж, хараат бус, ялгаварлалгүй хичээл зүтгэлтэйгээр үүргээ гүйцэтгэх хэрэгтэй. Прокурорууд хэргээ шударга шүүх хурлаар шийдүүлэх тухай сэжигтний эрхийг байнга хамгаалж, ялангуяа хуулийн дагуу мөн шударга шүүх хурлын шаардах байдлаар сэжигтнийг хамгаалсан нотолгоог гаргаж ирж байвал зохино. Прокурорууд хэзээд нийгмийн ашиг сонирхолыг хамгаалж ажиллахаас гадна хүний нэр хүнд болон хүний эрхийн тухай бүх нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн ойлголтыг хамгаалж эрхэмлэн дээдэлж байвал зохино.

Шүүхийн тодорхой эрх мэдлийн хүрээнд прокурорыг хараат бус тусгаар байдлаар хангасан тохиолдолд энэхүү хараат бус байдалд улс төрийн болон (хэвлэл мэдээлэл, бүлгийн сонирхол зэрэг) хөндлөнгийн зохисгүй оролцооноос ангид байх явдал багтсан байна. Прокурорын зүгээс өөрийн үзэмжээр шийдвэр гаргах тохиолдолд мэргэжлийн тодорхой үндэслэлтэй байвал зохино. Прокурорын өөрийн үзэмжээр шийдэх эрхээ зохих байдлаар хэрэгжүүлэх явдлыг хангахад мөрдөн байцаах эрх мэдэл бүхий байгууллагаас хэрэгт зохих зүйл ангиар зүйлчилсэн ялыг дуусгавар болгох буюу хэргийг яллахгүй байх шалтгаанаа прокурор өөрөө бүртгэж байх явдал чухал ач холбогдолтой. Үүнээс гадна, ямар нэг оролцогч талын зүгээс тодорхой хэргийг яллахгүй байх прокурорын шийдвэрийг хянаж шалгаж байх арга замыг эрэлхийлвэл зохино. Прокурорт ерөнхий болон тусгай зааварчилгааг өгөх эрх ямар нэг прокурорын бус байгууллагад олгогдсон тохиолдолд, энэ зааварчилгаа нь ил тод, хуулиар олгогдсон эрх мэдэлд тохирсон мөн прокурорыг хараат бус байлгах аас гадна ийм ойлголтыг төрүүлэх явдлыг баталгаажуулах зорилгоор урьдаас тогтоосон удирдамжид нийцсэн байх учиртай.

Прокурор чиг үүргээ ямар нэг айдасгүйгээр, тал засалгүйгээр, ялгаварлалгүйгээр, шударгаар гүйцэтгэх хэрэгтэй. Тэд хувийн болон бүлгийн сонирхлоос, нийгмийн болон хэвлэл мэдээллийн дарамтаас ангид байж зөвхөн нийгмийн ашиг сонирхлыг эрхэмлэж байвал зохино. Прокурор нь бодит байдлаар шаардлагатай үндэслэлтэй бүхий л мөрдөн шалгалт хийгдэж, сэжигтний буруутай эсвэл буруугүйг тогтоосон шийдвэр ил тод болсон байх явдлыг хангах арга замыг эрэлхийлнэ. Тэд зөвхөн үнэн мөнийг эрэлхийлж, хуулийн болон шударга ёсны дагуу үнэн мөнийг тогтооход шүүхэд тусалж ажиллах хэрэгтэй.

Прокурор 8 дугаар зүйлд заасан төрийн албан хаагчийн удирдамжийг тусгасан ёс зүйн дүрэмд захирагдана. Энэ нь прокурорт тулгараад буй тодорхой бэрхшээлийг тусгасан байх онцгой шаардлагад нийцсэн байна.

Шүүх үйл ажиллагааны нэг хэсэг болохын хувиар прокурор нь цагдаа, шүүх, өмгөөлөгч болон засгийн газрын бусад агентлаг газартай улс болон олон улсын хэмжээнд хамтран ажиллах замаар ялын шударга байдал болон үр нөлөөтэй байдалд хувь нэмрээ оруулна. Түүнчлэн тэд

хуулийн дагуу мөн хамтран ажиллах хүсэл эрмэлзлээр яллах үйл ажиллагаанд болон шүүхийн бусад байгууллагын мэргэжил нэгтгүүдээ туслалцаа үзүүлэх хэрэгтэй.

Авлигатай тэмцэх талаар мэргэжлийн сургалт явуулах зэргээр шүүгчдийг сургаж бэлтгэх тухай урьд нь авч хэлэлцсэн тэр асуудал прокуроруудын хувьд ч мөн адил болно.

12 дугаар зүйл: Хувийн хэвшил

1. Оролцогч улс бүр дотоодын хууль тогтоомжийнхоо тулгуур зарчимд нийцүүлэн хувийн хэвшилд авлигаас урьдчилан сэргийлэх, хувийн хэвшлийн нягтлан бодох бүртгэлийн болон аудитын стандартыг сайжруулах арга хэмжээ авах бөгөөд шаардлагатай гэж үзвэл тийм арга хэмжээг биелүүлээгүй тохиолдолд авах үр дүнтэй, тухайн үйлдэлд тохирох, үйлдлийг хязгаарлахад чиглэгдсэн иргэний, захиргааны болон эрүүгийн хариуцлагыг тогтооно.

2. Эдгээр зорилгод хүрэх үүднээс олон төрлийн, түүний дотор дараахь арга хэмжээг авч болно:

(a) Хууль сахиулах байгууллага болон холбогдох хувийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг хөхүүлэн дэмжих;

(b) Бизнесийн болон холбогдох бусад мэргэжлийн үйл ажиллагаагзөв, нэр төртэй хийгээд зохих ёсоор явуулахад ёс зүйн дүрэм, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зэрэг хувийн холбогдох байгууллагуудын зөв шударга байдлыг хамгаалах, түүнчлэн бизнес эрхлэгчдийн хооронд буюу бизнес эрхлэгчдийн гэрээний журмаар төртэй харилцах сайн харилцаанд бизнесийн найрсаг дадлыг хэвшүүлэн хэрэглэхийг дэмжихэд чиглэсэн жишиг, журмыг хөгжүүлэхийг хөхүүлэн дэмжих;

(c) Шаардлагатай тохиолдолд, хамтарсан байгууллагыг үүсгэн байгуулах, удирдах ажиллагаанд холбоотой хувь хүн, хуулийн этгээдийг тодорхой болгох арга хэмжээ авах зэргээр хувийн хэвшлийн байгууллагад ил тод байдлыг хөхүүлэн дэмжих;

(d) Аж ахуйн үйл ажиллагаа явуулахад төрийн эрх бүхий байгууллагаас олгох татвар, тусгай зөвшөөрлийн талаархи журмыг оролцуулан хувийн хэвшлийн үйл ажиллагаатай холбоотой журмыг урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэх;

(e) төрийн албан хаагч байсан этгээдийн мэргэжлийн үйл ажиллагаа, төрий албан хаагч огцрох буюу тэтгэвэрт гарсныхаа дараа хувийн хэвшилд хөдөлмөр эрхлэхэд нь, хэрэв ийм үйл ажиллагаа буюу ажил хөдөлмөр нь тэдний хийж байсан буюу удирдаж байсан чиг үүрэгтэй шууд хамааралтай байвал, шаардлагатай тохиолдолд боломжит хугацаагаар хязгаарлалт тавих замаар сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх;

(f) бүтэц, хэмжээнд нь тохирсон байдлаар байдлаар хувийн хэвшлийн байгууллагуудыг авлигаас урьдчилан сэргийлэх, авилгыг илрүүлэхэд туслах хангалттай хөндлөнгийн, дотоод

хяналттай байх болон хувийн байгууллагын данс, шаардлагатай санхүүгийн мэдээллийг хөндлөнгийн хяналт, магадлан итгэмжлэлийн зохих ажиллагаанд хамруулах явдлыг хангах.

3. Авлигаас урьдчилан сэргийлэх үүднээс оролцогч улс бүр энэхүү конвенциор тодорхойлсон гэмт үйлдлийн аль нэгийг үйлдэх зорилгоор явуулсан дараахь үйлдлийг хориглоход бүртгэл тооцоо, санхүүгийн мэдээллийг дэлгэх задруулах, нягтлан бодох бүртгэлийн болон аудитын стандартын талаархи дотоодын хууль тогтоомжийнх нь дагуу шаардлагатай байж болох арга хэмжээг авна:

(a) бүртгэлээс гадуур данс нээх;

(b) бүртгэлээс гадуур буюу хангалтгүй мэдээлэл бүхий гүйлгээ хийх;

(c) гараагүй зардлыг бүртгэх;

(d) объектыг нь буруу тодорхойлсон өр үүсгэх;

(e) хуурамч баримт бичиг ашиглах;

(f) нягтлан бодох бүртгэлийн баримт бичгийг хуульд заасан хугацаанаас өмнө санаатайгаар устгах.

4. Оролцогч улс бүр энэхүү конвенцийн 15, 16 дугаар зүйлд тодорхойлсон гэмт үйлдлийн бүрэлдэхүүн хэсэг болох хахууль болсон зардал болон зохих тохиолдолд авлигын үйлдлийг дэмжсэн бусад зардлыг татвар ногдох зардлаас хасч тооцохыг үл зөвшөөрнө.

I. Ерөнхий тойм

Энэхүү зүйл нь дараах гурван зорилготой. Үүнд, хувийн хэвшил дэх авлигын асуудлыг шийдвэрлэх, нягтлан бодох бүртгэл болон хөндлөнгийн хяналтын стандартыг мөрдүүлэх, мөн зохих тохиолдолд энэхүү жишгийг үл мөрдөх явдалд хориг арга хэмжээ авах орно. Хувийн хэвшилд дэх авлигыг шийдвэрлэх нь чухал ач холбогдолтой. Жишээ болгож хөрөнгө оруулагчид итгэл төрүүлэх болон хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах явдлыг энд дурдаж болох юм. Энэ нь зөвхөн хувийн хэвшилд гарч болох авлигын асуудлыг шийдэж өгч байгаагаараа Конвенцийн нэгэн шинэ санааг тусгаж байна гэдгийг анхаарч үзвэл зохино.

II. Бодит бэрхшээл ба шийдэл

II.1. Хувийн хэвшилд авлига үүсэхээс сэргийлэх арга хэмжээ

Тав дугаар зүйлд заасан авлигаас урьдчилан сэргийлэх стратегийг боловсруулах, 10 дугаар зүйлд заасан захиргааны журмыг хянаж үзэх, мөн 6 дугаар зүйлд заасны дагуу байгуулагдсан аливаа байгууллагын үйл ажиллагааг явуулахад хуулийн байгууллага эсвэл хуулийн байгууллагуудын холбоог оролцуулах нь үр дүнтэй, ач тустай юм. Хувийн

байгууллагын шударга байдлыг баталгаажуулах зорилгоор стандарт болон журмыг боловсруулах явдлыг хөхиүлэн дэмжихтэй холбоотойгоор ёс зүйн дүрэм, авлигын асуудлын удирдамж, хамтарсан засгийн дүрэм, сонирхлын зөрчлийн зохицуулалт болон дотоодын хөндлөнгийн хяналтанд голлон анхаарах нь чухал. Оролцогч улсууд, биржид ханшаа тогтоохыг хүссэн компанид тавих шаардлагандаа ийм жишиг болон журмыг багтаахыг хүсч байж болно. Эсвэл хөрөнгийн бирж болон бусад зохицуулагч агентлагаар дамжуулан энэ шаардлагыг тавьж болох юм. Компаний хувьд, эдгээрийг компанийн дүрэм, бизнесийн ёс зүйн хөтөлбөр болгон нэвтрүүлж, компанийн боловсон хүчний эрхэлж буй ажлын байрны чиг үүргээс үл хамааран компанийн үнэ цэнэ, зарчмыг ойлгон, үнэлж, мөн өдөр тутмын ажил үүрэг, харилцаа болон шийдвэртээ эдгээрийг харгалзан үзэхээс гадна эрх зүйн, байгууллагын, мэргэжлийн болон зохицуулалтын бодлогыг даган мөрдөж байх явдлыг хангавал зохино. Жишиг болон журмын талаар оролцогч улсын хууль тогтоомжийн хүрээнд, хөндлөнгийн хяналтын дагуу санал илэрхийлж, шүүмжилж болно.

II.2. Нягтлан бодох бүртгэл болон аудитын стандартыг сайжруулах арга хэмжээ

Оролцогч улс бүрийн дотоодын хяналтын хэмжүүрийг тогтоох аудитын жишиг хийгээд хувийн хэвшлийн суурь орчин нь хувийн хэвшил дэх дотоодын хяналтын үндсэн чиг үүрэгт хамаарах тодорхой удирдамж болон журмыг багтаасан байх явдлыг хангана. Энэ чиг үүргийг дараах байдлаар бүлэглэж болох юм: хөрөнгийн хяналт, орлого, зарлагын бүртгэлийн үр нөлөөтэй байдлыг үнэлэх үндсэн аудит; санхүүгийн, үйл ажиллагааны болон удирдлагын хяналтын тогтолцооны хангалттай, үр нөлөөтэй байдлыг үнэлэх тогтолцооны аудит; гүйлгээний хуульд нийцсэн байдал болон залилан, авлигаас хамгаалагдсан байдлыг үнэлэх аудит; бүхэлдээ эрсдлийн удирдлагад суурилсан аудит.

Байгууллагад санхүүгийн зохих бүртгэлийг хөтөлж, санхүүгийн мэдээллийг тогтмол бэлдэж байх явдлыг хуулиар үүрэг болговол зохино. Илүү том компанид тухайлбал биржид арилжаа хийдэг байгууллага, биржид арилжаа хийдэггүй ч хэмжээний хувьд дүйцэхүйц том байгууллага, мөн олон улсын хэмжээнд томоохон бизнес эрхэлдэг хувийн компанид дансаа хөндлөнгийн байгууллагаар хянуулж, үр дүнг нь жил бүр хэвлэн нийтэлж байх шаардлага тавих хэрэгтэй. Ийм дансыг компани болон компанийн дансыг бүртгэх ажлыг хариуцсан байгууллага бүртгэж авна. Хөрөнгийн биржид ханшаа тогтоосон компанийн хувьд илүү нарийвчилсан хөндлөнгийн хяналт явуулах шаардлага тавигдах бөгөөд энэхүү шаардлагыг хөрөнгийн бирж болон санхүүгийн зохицуулагч агентлагаас тогтооно.

Оролцогч улсууд сургалтын хүрээг өргөжүүлэх, ажиллагсдын ур чадварыг нэмэгдүүлэх болон мэргэжлийн хувьд тогтмол дэвшиж байх явдлыг хангах зорилгоор нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн байгууллагын төлөөлөлтэй хамтран ажиллах хэрэгтэй.

II.3. Хувийн хэвшилд иргэний, захиргааны болон эрүүгийн хариуцлага хүлээлгэх

Оролцогч улс бүр хууль тогтоох байгууллага хийгээд засаглалаа харгалзан үзээд зөвлөмж болон санаа авах зорилгоор олон улсын байгууллагуудын үйл ажиллагаатай танилцаж болно. Олон улсын Аудитын Жишиг (ISA) одоогоор хяналтын шатанд байгаа. Харин саяхан нягтлан

хянагдсан ISA 240 жишиг нь санхүүгийн мэдээллийг гэрчилгээжүүлэх явцад залилангийн асуудалтай тулгарсан аудиторын зан үйлийн асуудалд төвлөрдөг. Энэ нь авлигаас сэргийлж, түүнийг илрүүлэх тал дээр аудиторын хувь нэмрийг нэмэгдүүлэх болно. Зарчмын хувьд, тэдгээр жишгийг хэрэгжүүлэх явдлыг бизнесийн орчин өөрөө хариуцах ёстой байдаг ч төрөөс энэ үйл явцад олон талаар дэмжлэг үзүүлж болох юм.

Оролцогч улсууд хувийн хэвшил дэх авлигад холбогдсон этгээдэд зохих байдлаар эрүүгийн шийтгэл ноогдуулдаг. Шүүх болон бусад зохицуулагч агентлаг үүнээс өөрөөр шийтгэл ноогдуулах эрх мэдэлтэй байвал зохино. Ийм шийтгэлд торгууль ноогдуулах, хөрөнгө хураах болон бусад хэлбэрийн санхүүгийн шийтгэл, компанийн үйл ажиллагааг зогсоох, хяналтад авах, компанийг татан буулгах, удирдлагын мэргэжлийн эрхийг хасах түүнчлэн компанийн хуульч, нягтлан бодогч зэргийн мэргэжлийн магадлан итгэмжлэлийг түтгэлзүүлж болно.

II.4. Хууль сахиулах байгууллага болон хувийн хэвшил хоорондын хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжих арга хэмжээ

Хууль сахиулах байгууллага болон холбогдох хувийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжих талаар 39 дүгээр зүйлд хэлэлцсэн. Гэмт хэргийн талаар хууль сахиулах байгууллагад мэдээлэх явдлыг хуулиар үүрэг болгоогүй ч зарим улс оронд мөнгө угаах хэргийг заавал мэдээлэхийг шаардаж болно. Хуулийн этгээдийн зүгээс авлигатай холбоотой гэмт хэргийн талаар хууль сахиулах байгууллагад мэдээлэх явдлыг оролцогч улсууд хөхиүлэн дэмжвэл зохино. Түүнчлэн гэмт хэргийг хууль сахиулах байгууллагад мэдээлэх явдлыг хувь хүн, хуулийн этгээдэд хуулиар үүрэг болгосон байвал илүү зохимжтой. Үүний хариуд хууль сахиулах байгууллагын зүгээс иргэдийн мэдлэгийг дээшлүүлэх сургалт семинар зохион явуулж, нэг цэгийн үйлчилгээ бий болгож мөн гэмт хэргээс урьчилан сэргийлэх талаар зөвөлгөө өгч байх хэрэгтэй.

II.5. Хувийн байгууллагын зөв шударга байдлыг хамгаалах стандарт ба журам

Хувийн хэвшилд төрийн зохицуулалтын хэр хэмжээ ямар байх талаар санал зөрүүтэй байж болох ч хувийн хэвшил өөрөө компанийн шударга байдал, бизнес эрхлэх ёс зүй болон (хэрэглэгч, үйлчүүлэгч, иргэн, боловсон хүчин, хувь эзэмшигч зэрэг) оролцогч талын өмнө хүлээх компанийн нийгмийн хариуцлага маш чухал болохыг ухамсарласан байвал зохино. Бизнесийн ёс зүйн асуудлыг шийдэх болон байгууллагын үүрэг хариуцлагын хүрээнд үйл ажиллагаагаа явуулах нь үнэндээ нилээд ярвигтай асуудалд тооцогдоно. Бизнесийг ашиг олох зорилгоор эрхэлдэг. Гэтэл үүний зэрэгцээ –зохицуулагч агентлаг, нийлүүлэгч, худалдан авагч, олон нийт зэрэг- оролцогч талуудын зүгээс тэдэнд хүлээлгэх үүрэг хариуцлага улам бүр нэмэгдснээр ашиг олох зорилгоос халихад хүргэдэг. Эдгээр харилцан адилгүй үүрэг хариуцлагыг шийдэхэд байгууллагын хэрэглэж болох нэг арга бол ёс зүйн дүрэм, ёс зүйн болон компанийн удирдлагын хөтөлбөр боловсруулах мөн хувийн хэвшилд тавих шаардлага, хүсэлтэд нийцэх явдал юм. Сүүлийн жилүүдэд санаа авч болох эх сурвалжаар хангах зорилгоор цөөнгүй тооны багц зарчим болон загвар⁵ боловсруулагдсан байгаа. Саяхны нэгэн санаачлагын үр дүнд эдгээр зарчмыг Авлигын эсрэг НҮБ-ын конвенцид дурдсан зарчимтай нийцүүлэх зорилгоор хянан судалж байна.

II.6. Хамтарсан байгууллага байгуулах, удирдах ажиллагааны ил тод байдал

Оролцогч улс бүр компани байгуулсан явдлыг батлах, бүртгэх болон тэдний данс бүртгэлийг хүлээн авах асуудлыг төрийн тодорхой байгууллагад хариуцуулж байвал зохино. Компанийг бүртгэх журам болон улсад бүртгэгдсэн хууль ёсны байгууллагын талаархи мэдээлэл нь дэлгэрэнгүй, тодорхой бөгөөд батлагдсан байна. Төрийн байгууллагууд зохицуулах чиг үүргээ гүйцэтгэхэд нь шаардлагатай болсон тохиолдолд, хууль бус хэрэг явдалд холбогдсон хуулийн этгээд болон хувь хүний талаар мэдээллийг олж авах (албадах эрх, шүүхийн зарлан дуудах эрх зэргээ ашиглан) эрх мэдлээр хангагдсан байвал зохино.

II.7. Хувийн байгууллагын үйл ажиллагааг зохицуулах журмыг буруугаар ашиглахаас урьдчилан сэргийлэх

Оролцогч улс бүр төртэй гэрээлэгчид тавих бараа, ажил, үйлчилгээ худалдан авах асуудалтай холбоотой бүхий л шаардлага нь 9 дүгээр зүйлийн заалтуудад түшиглэсэн бодлого болон үйл ажиллагаанд нийцсэн байх явдлыг хангана. Тухайлбал, эдгээр шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд гэрээг хүчингүй болгох, үйл ажиллагааг зогсоох зэрэг арга хэмжээг авна гэдгийг хувийн байгууллага урьдаас мэдсэн байвал зохино.

Оролцогч улсууд тухайн заалт нь засгийн газарт болон стратегид шууд байдлаар хамаарахгүй байгаа тохиолдолд тодорхой зөвшөөрөл ба тусгай зөвшөөрлийн хэрэгцээ хэзээд үүсч байдгийг анхаарч үзвэл зохино. Ийм тохиолдолд хувийн хэвшлийнхэн энэ заалтыг урвуулан ашиглах магадлал үүсдэг бөгөөд энд үйл ажиллагааг илүү үр нөлөөтэй байдлаар зохицуулах шаардлагатай. Илүү тодорхой бөгөөд өргөн олонд хүрч үйлчлэх үйлчилгээг нэвтүүлэх зорилгоор нэг цэгийн үйлчилгээг бий болгох зэргээр зөвшөөрөл болон тусгай зөвшөөрөл авах арга замыг оновчтой болгох асуудалд холбогдох байдлаар анхаарал хандуулах нь зүйтэй. Хүсэлт гаргасан этгээд бүрт тэдэнд ямар түвшний үйлчилгээ үзүүлэхийг, ямар бичиг баримт бүрдүүлэх шаардлагатайг мөн зөвшөөрөл болон тусгай зөвшөөрлийн асуудал хариуцсан газар энэ жишгийг мөрдөж чадахгүйд хүрвэл үүнийг ямар арга хэрэгслээр орлуулахыг тодорхой болгож өгөхийн тулд жишгийг хүн бүрт хүртээмжтэй байлгана.

II.8. Өмнө нь төрийн албан тушаалтан байсан этгээдэд хувийн хэвшилд ажил эрхлэхэд тавигдах хязгаарлалт

Оролцогч улсууд, өмнө нь төрийн албан тушаал эрхэлж байсан этгээд огцорсон буюу тэтгэвэрт гарсны дараагаар төрийн албан тушаал эрхэлж байх үеийн ажил үүрэгтэй шууд хамаатай ажил эсвэл нууц болон арилжааны мэдээллийг нь мэдэх тийм ажил эсвэл өмнөх ажил олгогч болон хамт ажиллагсад нөлөөлөх ажил эрхлэхээр хувийн хэвшилд ажилд орох асуудлыг зохицуулах журамтай байвал зохино. Энэ журам нь томилогддог болон сонгогддог албан тушаалын аль алинд нь хамаарч байна. Оролцогч улсууд дараах үйлдлүүдийг гаргахаар завдсан төрийн албан тушаалтанд ямар арга хэмжээ авах боломжтойг тооцож үзэх шаардлагатай юм.

- Ажил олгох магадлалтай этгээдэд тал засч албан тушаалаа ашиглах;

- Алба эрхэлж байх үедээ ажил хайх;
- Төрийн алба тушаал эрхлэх замаар олж авсан нууц мэдээллээ урвуулан ашиглах;
- Төрийн албан тушаалтны хувиар хариуцсан асуудалдаа хувийн ашиг сонирхлыг урьтал болгох;
- Өмнө нь албан тушаал эрхэлж байсан газраа ямар нэг асуудлаар (тодорхой хугацааны дотор) хувийн хэвшлийг төлөөлөх;

Төрийн албан тушаал эрхэлж байсан этгээдийн цаашид хувийн хэвшилд эрхлэх ажил үйлчилгээний тодорхойлолт болон энэ асуудлыг зохицуулсан журам нь тодорхой, ойлгомжтой байвал зохино. Оролцогч улс бүр дараах арга хэмжээг авах боломжийг тооцож үзэх хэрэгтэй:

- Ажилд орох болзол нөхцөлд хувийн хэвшилд ажиллах зөвшөөрлийг урьдаас тусгаж өгсөн байх;
- Мэдээлэл ашиглах болон өмнөх ажил олгогчтойгоо харилцах талаар болзол нөхцөл тулгах;
- Төрийн чухал албан тушаал эрхэлж байсан этгээдийн хувийн хэвшилд ажилд орсон талаар тухайн этгээдийн ажилд орсон компанийн өрсөлдөгч пүүсүүдэд мэдээлэл өгөх;
- Ямар нэг болзол нөхцлийг зөрчсөн тохиолдолд хувийн хэвшлийн байгууллагыг төртэй үйл хэрэг эрхлэхээс түтгэлзүүлэх;

Эдгээр заалтыг боловсруулахдаа оролцогч улсын зүгээс дараах зүйлсийг анхаарч үзвэл зохилтой:

- Хязгаарлалт нь тодорхой хугацаатай байх;
- Хязгаарлалт хийх албан тушаал болон албан тушаалын зэрэг дэвийг тодорхой зааж өгөх;
- Өмнө нь төрийн албан тушаал эрхэлж байсан этгээдээр төлөөлүүлэх боломжгүй хувийн хэвшлийн салбар болон үйл ажиллагааг тодорхой зааж өгөх;

II.9. Дотоод хөндлөнгийн аудит, магадлан итгэмжлэлийн ажиллагаа

Оролцогч улс бүр хувийн хэвшлийн нягтлан бодох бүртгэлийн тайлангаа жил бүр хүргүүлж байх явдлыг хангаж, зохих байдлаар хянаж мөн нягтлан бодох бүртгэлийн тайлангаа дутуу эсвэл хугацаанаас нь хоцроож ирүүлсэн байгууллагад хариуцлага тооцож байвал зохино. Түүнчлэн хөрөнгийн бирж, санхүүгийн зохицуулагч агентлаг болон мэргэжлийн холбоогоор дамжуулан тухайн байгууллагын хэмжээ болон хүчин чадалд тохирсон байдлаар дотоодын хөндлөнгийн хяналтын хэмжээг мөн тэдний хөндлөнгийн хяналтын үйл ажиллагаагаа хангалттай байдлаар явуулахад шаардлагатай мэргэжлийн сургалт, магадлан итгэмжлэлийн түвшинг тогтоох чиглэл өгч болох юм.

II.10. Бүртгэл, тооцоо, санхүүгийн мэдээлэл зарцуулах, нягтлан бодох бүртгэлийн болон аудитын стандарт

Оролцогч улс бүр байгууллагын үйл ажиллагаанд холбогдох бүртгэл мэдээллийг хуваарийн дагуу тогтоосон хугацаанд хадгалах мөн нэгдсэн данс болон нэмэлт мэдээллийг устгах асуудлыг хуулиар зохицуулсан байх явдлыг хангана. Үүнд ямар баримт бичиг, мэдээлэл эх эсвэл хуулбараараа хадгалагдсан байх ёстойг зааж өгнө. (Гэрээ, хэлэлцээр, баталгаа болон хөрөнгийн гэрчилгээ зэргийг шүүхэд нотлох баримт болгох гэх мэт зорилгоор эх хувиар нь шаардаж байж болох юм). Энэхүү хууль тогтоомжид дараах зүйлст хамаарах эрх зүйн тодорхойлолт, шаардлага болон холбогдох арга хэмжээг тодорхой зааж өгсөн байх учиртай. Үүнд бүртгэлээс гадуур данс нээх; гараагүй зардлыг бүртгэх; объектыг нь буруу тодорхойлсон өглөг үүсгэх; хуурамч баримт бичиг ашиглах; нягтлан бодох бүртгэлийн баримт бичгийг хуульд заасан хугацаанаас өмнө санаатайгаар устгах орно.

II.11. Хахууль болсон зардал болон холбогдох бусад зардлыг татвар ногдох зардлаас хасч тооцохыг үл зөвшөөрөх

Оролцогч улс бүр хахууль болсон байх магадлалтай төлбөрийг татвараас чөлөөлүүлэх явдлыг хувийн хэвшилд хориглосон зүйл заалттай байвал зохино. Гадаадын төрийн албан тушаалтанд хахууль болсон зардлыг мөн татвар ноогдох зардлаас хасахыг хориглоно. Энэхүү хахууль болсон зардлыг татвар ноогдох зардлаас хасч тооцохыг хориглох заалт нь хувь этгээдэд ч мөн хүчин төгөлдөр хэрэгжих учиртай. Энэ заалт нь тодорхой томъёологдсон байхаас гадна хахуулийн зардлыг “амралт зугаалгын болон үзвэр үйлчилгээний зардал” хэлбэрээр хууль ёсны зардлын бүлэгт багтаах явдлыг гаргуулахгүй байх тал дээр татварын эрх мэдэл бүхий байгууллагын зүгээс онцгой анхаарал хандуулбал зохино. Авлигын гэмт хэргийг илрүүлэхэд татварын арга хэмжээний үүрэг роль нь, авлига гарсан байж болзошгүй хэрэг явдлыг хууль сахиулах байгууллагад мэдээллэхийг Улсын орлогын болон татварын эрх мэдэл бүхий байгууллагад үүрэг болгосон эсвэл үгүйдээ л зөвшөөрсөн тохиолдолд л үр дүнгээ өгнө.

13 дугаар зүйл: Нийгмийн оролцоо

1. Оролцогч улс бүр авлигаас урьдчилан сэргийлж, тэмцэхэд хувь хүн болон иргэний нийгмийн, төрийн бус, олон нийтийн байгууллагууд зэрэг төрийн албанаас гаднах бүлгийн идэвхитэй оролцоог хөхүүлэн дэмжих бөгөөд бодит авлига, түүний шалтгаан, цар хүрээ, учруулж буй аюул заналын талаархи олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн зохих арга хэмжээг дотоодын хууль тогтоомжийнхоо тулгуур зарчимд нийцүүлэн өөрийн бололцооны хүрээнд авна. Энэхүү оролцоог дараахь аргахэмжээгээр бэхжүүлнэ:

(a) шийдвэр гаргах ажиллагааны ил тод байдлыг сайжруулах, олон нийтийн оролцоог дэмжих;

(b) олон нийт мэдээлэл авах боломжтой байх явдлыг хангах;

(c) авлигыг үл тэвчих уур амьсгал бий болгоход хувь нэмэр оруулахад чиглэсэн олон нийтэд мэдээлэл хүргэх үйл ажиллагаа, дунд болон их, дээд сургуулийн хөтөлбөр зэрэг олон нийтийн боловсролын хөтөлбөр хэрэгжүүлэх;

(d) авлигатай холбоотой мэдээлэл хайх, авах, хэвлэн нийтлэх, түгээх эрх чөлөөг хүндэтгэх, хөхүүлэн дэмжих, хамгаалах. Тэрхүү эрх чөлөөнд тодорхой хязгаарлалт тавьж болох боловч хязгаарлалт ньз өвхөн хуульд заасан байх бөгөөд дараахь үндэслэлээр шаардлагатай байвал зохино:

(i) бусдын эрх, нэр хүндийг хүндэтгэх;

(ii) үндэсний аюулгүй байдал, нийтийн дэг журам, нийтийн эрүүлмэнд, ёс суртахууныг хамгаалах.

2. Оролцогч улс бүр энэхүү конвенцид заасан авлигын эсрэг холбогдох байгууллагын талаар олон нийт мэдэж байх явдлыг хангах талаар зохих арга хэмжээ авч, шаардлагатай тохиолдолд энэхүү конвенциор тодорхойлсон гэмт үйлдлийг нөхцөлдүүлж байна гэжү зэж болох аливаа тохиолдлын талаар мэдээлэхээр эдгээр байгууллагад хандах боломж (үүнд нэрээ мэдүүлэхгүйгээр хандах боломж багтана)-оор хангана.

I. Ерөнхий тойм

Авлигаас урьчилан сэргийлж, хяналтанд авах нь төрийн үйлчилгээг илүү үр ашигтай, үр нөлөөтэй, шийдвэр гаргах үйл явцыг илүү ил тод, эрх тэгш байдалтай мөн төсөв болон хуулийг нийгэмд ядуу, эмзэг бүлгийн гишүүдийн хүсэл, шаардлагад нийцсэн байдалтай болгох зорилгоор сайн засаглалыг болон төрийн үйлчилгээнд шинэтгэл хийх явдлыг хөхиүлэн дэмжих нэг арга юм. Авлигад, төрийн сан, нөөцийг урвуулан ашиглах замаар шууд бус байдлаар болон төрийн үйлчилгээ авахын тулд хахууль өгөхөөс өөр аргагүйд хүрэх замаар шууд байдлаар өртсөн тэдгээр этгээдийг ямар асуудлыг шийдвэрлэх, үр дүн нь ямар байх, болон шийдвэрлэх асуудлыг хэн хариуцахыг тогтооход чиглэсэн үйл явцад оролцуулбал зохино.

II. Бодит бэрхшээл ба шийдэл

II.1. Авлигатай тэмцэхэд нийгмийн оролцоог хөхиүлэн дэмжих

Оролцогч улс тэдэнтэй холбогдон ажиллах нийгэм болон мэргэжлийн холбоо нь ямар бүтэцтэй байгааг анхаарч үзвэл зохино. Нийгэм, төрийн бус байгууллага, үйлдвэрчний эвлэл, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, шашны үйл ажиллагаа явуулдаг байгууллага зэргийг анхаарахаас гадна үүнд төртэй ойр харилцаагүй этгээд, байгууллагуудыг ч хамруулах хэрэгтэй. Оролцогч улсууд нийгмээс гадуурхагдсан бүлэг зэрэг тодорхой төлөөлгүй этгээдүүдийн санал бодлыг гэр бүлийн болон бусад төстэй судалгаа явуулах гэх мэт арга замаар тусгаж өгвөл зохино.

II.2. Авлигын талаар олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх

Авлигатай тэмцэх асуудал хариуцсан олон агентлаг, газар авлигын эсрэг үр нөлөө бүхий компаниг ажил явуулж энэхүү конвенцид төрийн зүгээс авлигын талаархи мэдлэгийг дээшлүүлэхэд анхаарал хандуулж, үүнийг өөрийн үүрэг амлалт болгох явдлыг дэмжихэд онцгой

анхаарч байгаа юм. Төрийн байгууллага авлигаас урьдчилан сэргийлэх явдлыг үүрэг амлалтаа болгосон байвал зохино. Үүнд сүрдүүлэг болон өс санах явдлаас айлгүйгээр авлигын талаар санал бодлоо илэрхийлж, авлигын хэргийг мэдээлж байх арга замаар иргэдийг хангах явдал маш чухал. Авлигын мөн чанар, үр дагавар, авлигатай холбоотойгоор хориглох зан үйл болон авлигатай тэмцэхэд анхаарах зүйлийн талаар компани ажлаар тодорхой тайлбарлаж байх учиртай.

II.3. Шийдвэр гаргах ажиллагаанд олон нийтийн оролцоог дэмжих

Оролцогч улс бүр 5 дугаар зүйлд заасан урьдчилан сэргийлэх стратеги боловсруулах ажиллагаанд шууд төлөөлүүлэх замаар болон 6 дугаар зүйлд заасан байгууллага буюу байгууллагуудад оролцуулах замаар шийдвэр гаргах ажиллагаанд олон нийтийг оролцуулж болох юм. Тав дугаар зүйлд заасан үйл ажиллагаа нь захиргааны үйлчилгээний нөхцлийг олон нийтийн хүлээн авч байгаа байдалд мөн энэ зүйлд заасан мэдээлэл олж авах эрхэд үнэлэлт өгөх асуудлыг багтаасан.

II.4. Олон нийтийн мэдлэг, боловсрол

Энэ асуудлыг олон нийтэд сурталчилах ажил болон иргэдээс авлигын хэргийн талаар мэдээллийг зохих байдлаар авах асуудлыг 6 болон 36 дугаар зүйлд дурдсан байгууллагууд хариуцна. Олон нийтэд сурталчилах ажилд ухуулах хуудас ба зурагт хуудас гаргаж төрийн байгууллага бүрт дэлгэн үзүүлж олон нийтийн хүртээл болгох явдал орж болох юм. Төрийн байгууллага бүр өөрийн байгууллагаас явуулах үйлчилгээ болон чиг үүргийн талаархи мэдээллийг үүн дотор авлигын хэргийг хэрхэн мэдээлэх талаар мэдээллийг хэвлэн нийтэлж байвал зохино.

II.5. Авлигатай холбоотой мэдээлэл эржсэх, олж авах, хэвлэн нийтлэх, тараах эрх чөлөө ба хязгаарлалт

Оролцогч улс бүр авлигатай холбоотой хэргийг шалгах болон хэвлэн нийтлэхэд тодорхой хязгаарлал тавих зорилгоор хэвлэл мэдээллийн төрөл бүрийн хэрэгслийг улс төр болон намын ашиг сонирхолд үйлчлэх зорилгоор ашиглах явдлыг гаргахгүй байх тал дээр тэдний зүгээс зохицуулах зөвшөөрөл болон болзол нөхцлийн асуудлыг анхаарч үзвэл зохино. Үүний зэрэгцээ, авлигын хэрэгт буруутгагдсан этгээдийг, энэхүү хэргийг далд санаатайгаар эсвэл ташаа байдлаар өдүүлсэн талаар шүүхэд хандах боломжоор хангасан байхаас гадна оролцогч улсууд үндсэн хууль болон бусад хууль эрх зүйн орчин нь мэдээлэл цуглуулах, хэвлэн нийтлэх болон түгээх эрх чөлөөг дэмжсэн байх, түүнчлэн хүний нэр төр, Төрийн аюулгүй байдал болон гүтгэлэгийн талаархи хуулиуд нь нэг талыг баримтлах байдлаар хэт хатуу чанга, өндөр өртөгтэй эсвэл хязгаарлагдмал биш байх явдлыг хангана.

II.6. Авлигын эсрэг тэмцэх байгууллагын талаар олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх

Оролцогч улс бүр боловсролын байгууллага, иргэний бүлэг болон бусад иргэний нийгмийн байгууллагад боловсролын хөтөлбөр хэрэгжүүлж, сургалт явуулах асуудлыг авлигатай

тэмцэх газар (урьдчилан сэргийлэх болон мөрдөн байцаах), омбудсмен, сонгуулийн хороо зэрэг холбогдох төрийн байгууллагад албан ёсоор хариуцуулж, холбогдох хангалттай нөөцийг олгоно.

II.7. Олон нийтийн мэдээлэл олж авах боломж

Төр болон иргэний хоорондын харилцааны эрх тэгш байдалтай холбоотой үүсдэг гол асуудлуудын нэг нь иргэний өөрийн эрх болон төрийн үйл ажиллагааны талаар мэдлэггүй байх түүнчлэн ойлгохгүй байх явдал юм. Үүнтэй холбоотойгоор гарч болзошгүй харилцан үл итгэлцэх болон хардах явдлыг иргэний боловсролыг дээшлүүлэх замаар багасгаж болно. Энэ нь эргээд улс төрд оролцох болон төрд алба хаших боломжийг залууст танилцуулах нэмэлт ач холбогдолтой. Оролцогч улс мэдээллийн эрх чөлөөний хууль боловсруулах нь мэдээлэл олж авах боломж, арга зам болон журмыг тодорхой болгоход тус болох эсэхийг тооцож үзвэл зохино. Түүнчлэн мэдээлэл олж авах байдал болон мэдээллийн эрх чөлөөний талаархи бодлогоо ямар ч тохиолдолд хэвлэн нийтлэхээс гадна төрийн эрх мэдэл бүхий байгууллагын эзэмших албан баримт бичгийг хүсэлт гарган ялгаварлалгүйгээр олж авах эрхийг хүн бүрт олгох хэрэгтэй. Энэ талаар зөвлөмжийг 10 дугаар зүйлд цаашид авч үзнэ.

II.8. Авлигын хэргийн талаар (нэрээ нууцлан) мэдээлэх

Авлигын хэргийн талаар мэдээлэх тал дээр олон нийтийн хүсэл эрмэлзлийг хөхиүлэн дэмжихийн ач холбогдлыг оролцогч улс бүр анхаарч үзвэл зохино. Үүнтэй холбогдуулан, авлига гарсан байж болзошгүй талаар мэдээлэх асуудлаар төрийн албан тушаалтан, хуулийн байгууллагын боловсон хүчин төдийгүй энэ талаар мэдээлсэн аливаа этгээдийг статус харгалзалгүйгээр хамгаалдаг улс орнуудын туршлагыг бодолцож үзэх хэрэгтэй.

Авлигын хэргийг мэдээлэх талаар 33 дугаар зүйлд илүү дэлгэрэнгүй авч үзэж байгаа бөгөөд оролцогч улс бүр авлига гарсан байж болзошгүй талаар аль байгууллагад хандах болон хэрхэн энэ талаар мэдээлэх асуудлаар олон нийтэд зөвлөсөн авлигын талаар мэдээлэх удирдамжийг гаргавал зохино. Түүнчлэн оролцогч улс далд санаатайгаар эсвэл нэр төр гутаах байдлаар мэдээлэх явдлын эсрэг эрх зүйн хамгаалалт бий болгож, авлигын хэргийг мэдээлэх урьдаас тогтоосон арга хэрэгсэлд үл итгэж буй болон мэдээлэгчийг илрүүлэх эсвэл хариу арга хэмжээ авах явдлаас айж буй этгээдийг II.7.-д заасан байгууллагад авлигын хэргийн талаар мэдээлэх боломжоор хангана.

14 үгээр зүйл: Мөнгө угаахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ

1. Оролцогч улс бүр

(а) Мөнгө угаах бүх хэлбэрийг таслан зогсоох болон илрүүлэхийн тулд мөнгө болон бусад үнэт зүйлийн шилжүүлгийн албан буюу албан бус үйлчилгээ үзүүлдэг хувь хүн буюу хуулийн этгээдийг оролцуулан банк болон банк бус санхүүгийн байгууллага, шаардлагатай тохиолдолд мөнгө угаахад ялангуяа өртөмтгий бусад байгууллагад зохицуулалт, хяналтын дотоодын иж бүрэн дэглэмийг эрх хэмжээнийхээ хүрээнд тогтоох бөгөөд ийм дэглэм нь харилцагч болон зохих

тохиолдолд жинхэнэ өмчлөгчийн хэн болохыг тогтоох, тэмдэглэл хөтлөх, сэжигтэй гүйлгээг мэдээлэхэд тавих шаардлагыг онцлон тогтооно. ;

(b) Энэхүү конвенцийн 46 дугаар зүйлийг зөрчихгүйгээр захиргаа, зохицуулалт, хууль сахиулах болон мөнгө угаахтай тэмцэх эрх бүхий бусад байгууллага (дотоодын хуулийн дагуу зохих тохиолдолд шүүхийн эрх бүхий байгууллага) нь дотоодын хуулинд нь заасан нөхцлийн хүрээнд үндэсний болон олон улсын хэмжээнд хамтран ажиллах, мэдээлэл солилцох боломжтой байх явдлыг хангах бөгөөд үүний тулд мөнгө угааж байж болзошгүй гэсэн мэдээллийг цуглуулах, дүн шинжилгээ хийх, түгээх зорилго бүхий үндэсний төв болох санхүүгийн мэдээллийн нэгж байгуулах асуудлыг авч үзнэ.

2. Оролцогч улсууд хилээр нь дамжин өнгөрөх бэлэн мөнгө болон эргэлтийн зохих баримт бичгийн хөдөлгөөнийг илрүүлж, хянах талаар боломжит арга хэмжээ авах асуудлыг авч үзэх бөгөөд ингэхдээ мэдээллийг зохистойгоор ашиглах явдлыг хангах баталгааг мөрдөж, хөрөнгийн хууль ёсны хөдөлгөөнд саад болохгүй. Эдгээр арга хэмжээнд хувь хүн болон аж ахуйн байгууллага их хэмжээний бэлэн мөнгө болон эргэлтийн зохих баримт бичгийг хил дамнуулан шилжүүлсэн талаар мэдээлж байх шаардлага багтана.

3. Оролцогч улсууд санхүүгийн байгууллага, үүний дотор мөнгө гуйвуулагч байгууллагад дараахь шаардлага тавих талаар шаардлагатай, боломжит арга хэмжээ хэрэгжүүлэх асуудлыг авч үзнэ:

(a) Мөнгөний цахим шилжүүлгийн маягт болон холбогдох мэдээнд шилжүүлэгчийн талаар үнэн зөв бөгөөд зорилгод нийцсэн мэдээллийг тусгах;

(b) Ийм мэдээллийг төлбөрийн гүйцэтгэлийн бүх шатанд хадгалах;

(c) Шилжүүлэгчийн талаар бүрэн мэдээлэл байхгүй мөнгөн шилжүүлгийн талаар нарийн шалгалт явуулах.

4. Энэ зүйлийн нөхцлийн дагуу зохицуулалт, хяналтын дотоодын дэглэм тогтоохдоо энэхүү конвенцийн аливаа буад зүйлийг үл хөндөн бүс нутгийн, бүс нутаг хоорондын болон олон талт байгууллагаас мөнгө угаахын эсрэг холбогдох санаачлагыг удирдлага болгохыг оролцогч улсуудад уриалж байна.

5. Оролцогч улсууд мөнгө угаахтай тэмцэхийн тулд шүүх, хууль сахиулах болон санхүүгийн зохицуулалтын эрх бүхий байгууллага хоорондын хамтын ажиллагааг дэлхийн, бүс нутгийн, дэд бүсийн болон хоёр талын хэмжээнд хөгжүүлж, дэмжих талаар хүчин чармайлт гаргана.

I. Ерөнхий тойм

Мөнгө угаахаас сэргийлэх цогц стратегийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хэд хэдэнд асуудлыг өөр өөр өнцгөөс авч үзсэн бодлогын өргөн сонголт багтана.

14 дүгээр зүйлд авч хэлэлцсэн стратегийн урьдчилан сэргийлэхтэй холбоотой асуудалд төрийн байгууллагын удирдлаган дор түүнтэй хамтран ажилладаг хувийн хэвшил, үүнд ялангуяа санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа явуулдаг байгууллага илүү ихээр оролцоно. Урьдчилан сэргийлэх стратегийг хэрэгжүүлэхэд, хэдэн хэдэн онцлогтой. Үүний дотор санхүүгийн үйлчилгээний улсын эдийн засагт гүйцэтгэх үүрэг, эдийн засгийн чадавхи, санхүүгийн салбар болон үүний зохицуулагчийн хоорондын харилцаа, төрийн агентлаг хоорондын зохицуулалтын хүчин чадал, оролцогч улсын зүгээс энэхүү стратегийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн болон боловсон хүчний нөөцөөс хамааран бодлогын чухал сонголтууд урган гарч ирэх юм.

Мөнгө угаахаас урьдчилан сэргийлэх нь хувийн болон төрийн байгууллага, оролцогчийн хамтран гүйцэтгэх үүрэг юм. Хувийн хэвшил, ялангуяа санхүүгийн зуучлалын байгууллага “Хаалгач”(урьдчилан сэргийлэгч, хамгаалагч)-ийн гэж нэрлэгддэг үүргийг гүйцэтгэнэ. Хууль бусаар олсон ашгаа санхүүгийн тогтолцоонд нэвтрүүлэх буюу шилжүүлэхийг чармайх мөнгө угаагч байх магадлал бүхий этгээдтэй шууд харилцдаг гэдэг утгаараа санхүүгийн зуучлалын байгууллага нь ийм гүйлгээ явуулахаас сэргийлэх. Энэ талаар мэдээлэл өгөх болон ийм хэрэг гарсан тохиолдолд холбогдох бичиг баримтыг хөтлөхөд чухал байр суурь эзэлдэг. Нөгөөтэйгүүр хувийн хэвшил нь , зохицуулалтын болон хяналтын үүргийн аль алиныг гүйцэтгэнэ. Зохицуулалтын үүрэг гэдэгт мөнгө угаах бүх хэлбэрийг илрүүлэх болон таслан зогсооход шаардагдах дүрэм журмыг тогтоох явдал ордог бол хяналтын үүрэгт –хориг арга хэмжээ авах буюу хамтын ажиллагаа явуулах замаар- ийм дүрэм журмыг мөрдүүлэх явдал багтана.

II.Бэрхшээл ба шийдэл

II.1. Мөнгө угаахтай тэмцэхэд илүү тохиромжтой институцийн хүрээг сонгох

Оролцогч улсууд мөнгө угаахаас урьдчилан сэргийлэх тогтолцооны гурван гол бүрэлдэхүүн хэсгийг анхааран үзэж арга хэмжээ авч байвал зохино. Энэ гурван бүрэлдэхүүн хэсэгт урьдчилан сэргийлэх тогтолцооны цар хүрээ, холбогдох үүргийг гүйцэтгэх этгээд болон энэхүү үүргийг гүйцэтгэх үйл ажиллагааны хамгийн бага цар хүрээ орно.

Оролцогч улс бүр “мөнгө угаах бүх хэлбэрийг таслан зогсоох болон илрүүлэхийн тулд зохицуулалт, хяналтын дотоодын иж бүрэн дэглэмийг” тогтоох шаардлагатай. Энэ тогтолцоо нь зохицуулалтын болон хяналтын асуудлын аль алинийг хамарч байх хэрэгтэй бөгөөд оролцогч улс ийм тогтолцоог удирдан чиглүүлэхэд гарах шаардлага болон үүний нарийн төвөгтэй байдлыг харгалзан, өөрийн орчин нөхцөлд хамгийн сайн тохирох тогтолцоог сонгох эрхтэй.

Энэ шалтгаанаар оролцогч улсуудын дотоодын “зохицуулалт, хяналтын дэглэм”-ийн агуулга харилцан адилгүй байж болно. Энэхүү зүйлийг хэрэгжүүлэх зорилгоор мөн 58 дугаар зүйлийн зааврыг анхаарч үзэн оролцогч улс өөрийн сонгосон дэглэмийн ерөнхий институцийн хүрээг үнэлэх буюу тогтоохыг мөн урьдчилан сэргийлэх болон олон улсын хамтын ажиллагааны зохих хандлагыг бий болгохыг хүсч байж болох юм.

Мөнгө угаахтай тэмцэх үр нөлөө бүхий тогтолцоо нь дараах зүйлийг анхаарсан байна:

- Санхүүгийн болон санхүүгийн бус байгууллага нь мөнгө угааж болзошгүй этгээдийн зүгээс үйлчилгээг нь ашиглах явдлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авбал зохино. Ийм арга хэмжээнд, харилцагчийн ерөнхий шаблон үүсгэж, явуулж болох үйл ажиллагааг урьдаас таамаглах, үйл ажиллагааг хянах мөн сэжигтэй буюу шаблонтэй зөрчилдөж буй өвөрмөц ажиллагааг мэдээлэх боломжийг байгууллагад олгох байдлаар харилцагчид зохих шаардлагыг тавих явдал орж болно.
- Хууль сахиулах үйл ажиллагааны үндсийг тавьж өгөх зорилгоор санхүүгийн байгууллагын тайлан болон бусад эх сурвалжаас мэдээлэл цуглуулж, дотоодын болон олон улсын бусад байгууллагатай зохих байдлаар мэдээллээ хуваалцаж, үүнд дүн шинжилгээ хийж байх хэрэгтэй.
- Мөнгө угаасан байж болзошгүй хэргийг шалгаж, зохих байдлаар хөрөнгө битүүмжлэх болон хурааж авах түүнчлэн яллах ажиллагааг явуулах.

Ихэнх улс банк, даатгалын компани, үнэт цаасны пүүс, валют солих цэг зэрэг санхүүгийн байгууллагад ёс зүйн жишгийг мөрдүүлэх ажлыг хариуцсан зохицуулалтын болон хяналтын байгууллагатай байна. Ийм байгууллага нь хяналтын болон зохицуулалтын зохих эрх мэдэл эдэлж, санхүүгийн байгууллагын ажил хэргийн талаар мэдлэгтэй байж, байгууллага болон түүний удирдлагын хүчин чадал, зохимжит байдлыг хянаж, компанийн удирдлага, дотоодын хяналт, боловсон хүчний ёс зүй, зохих зан үйл зэрэг асуудлаар өндөр жишигт хүрэх явдалд төвлөрч байна. Үүнээс гадна, олон орон ийм байгууллагад авлигаас олсон ашгийг угаахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээг авах явдлыг хариуцуулдаг. Харин зарим улс орон энэ үүргийг тусдаа байгууллагад (ихэнхдээ дээр жагсаасан үүргийн хоёр дугаархыг биелүүлэх зорилгоор байгуулагдсан Санхүүгийн мэдээллийн нэгжид -СМН) ноогдуулж байна. Энэ хандлага нь авлигаас олсон ашгийг угаах асуудалд мэргэжилтнүүдийг төвлөрүүлэх ач холбогдолтой ч байгууллагуудын зааварчилгаанд зөрчил үүсэх болон хүчин чадал, зохимжит байдлын хяналт, компанийн удирдлагын хяналт түүнчлэн бүртгэлд давхцал бий болохоос сэргийлж ийм байгууллагын загварыг маш анхааралтай төлөвлөх шаардлагатай.

Үл хөдлөх хөрөнгийн зуучлагч, үнэт эдлэл болон автомашин худалдаалагч гэх мэт санхүүгийн бус байгууллагын хувьд харилцагчид тавих зохих шаардлага хийгээд бусад шаардлагыг мөрдүүлэх явдлыг хариуцсан байгууллага ихэнхдээ байдаггүй. Зарим улс оронд энэ үүрэг хариуцлагыг (хэдийгээр ийм чиг үүргийг гүйцэтгэх хангалттай эрх мэдэл олгогдоогүй ч) үйлдвэрчний эвлэлд оногдуулсан байдаг бол бусад нь санхүүгийн бус байгууллагатай холбоотой энэ үүрэг хариуцлагыг Санхүүгийн мэдээллийн нэгжид (СМН) даалгадаг.

Ер нь бүх орон дээр дурдсан –хуулийн дагуу санхүүгийн (болон зарим тохиолдолд санхүүгийн бус) байгууллагаас тайлан авах зэргээр мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийх-хоёр дахь чиг үүргийг гүйцэтгэх СМН байгуулсан эсвэл байгуулах шатандаа яваа. Зарим оронд, СМН нь мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх болон түгээхэд төвлөрсөн цэвэр захиргааны байгууллагын статустай байдаг. Бусад тохиолдолд СМН нь мөрдөлт шалгалт явуулах, түүгээр зогсохгүй яллах, хөрөнгө битүүмжлэх болон хураах эрх мэдэлтэй буюу дээр дурдсан гуравдугаар чиг үүргийг гүйцэтгэх байгууллага байна.

СМН, Хууль зүйн яам эсвэл хууль сахиулах эрх мэдэл бүхий байгууллагад багтах бүрэн биеэ даасан байгууллага байж болохын нэгэн адил Сангийн яам, төв банк зэрэг хяналтын байгууллагад харъяалагдаж ч байж болно. Биеэ даасан байх нь тодорхой ач холбогдолтой. Гэхдээ, мэдээллийг хууль сахиулах байгууллагын хүссэн хэлбэрээр боловсруулж байх зорилгоор тэдэнтэй уялдаа холбоотой ойр байх нь мөн ашиг тусаа өгнө. Нөгөөтэйгүүр, (сэжигтэй үйлдлийн тухай мэдээллээр хангах гол эх сурвалж болсон) зарим нэг санхүүгийн байгууллага өөрсдийн урьдаас мэдэх байгууллагад нууц мэдээлэл дамжуулах хүсэлтэй байх явдал ажиглагддаг болохоор СМН-ийг хяналтын байгууллагад харъяалуулж өгөх нь мөн зохих ач холбогдолтой байж болно.

Оролцогч улсууд эрх зүйн, бүтцийн болон захиргааныхаа орчинд хамгийн сайн тохирсон загварыг нэвтрүүлэх хэрэгтэй. Загвар бүр өөрийн гэсэн давуу талтай бөгөөд оролцогч улс боловсон хүчнийг сургалтаар хангах, хууль ёсны эрх мэдэл олгох болон агентлаг хооронд уялдаа холбоо тогтоох орчин нөхцөл нь үр ашгийг дээд хэмжээнд байлгаж, эрсдлийг боломжийн хэрээр багасгахад чиглэсэн байх явдлыг хангана.

Өөр нэг өнцгөөс харвал, оролцогч улс төрийн байгууллагад үл ногдох байдлаар хувийн хэвшлийн гүйцэтгэх чиг үүргийн хэв хэмжээнээс хамааран урьдчилан сэргийлэх тогтолцооны хувьд өөр байна. Дээр танилцуулсан загваруудад зохицуулалтын болон хяналтын үүргийг төрийн байгууллага хариуцдаг. Оролцогч зарим улс өөрийн гэсэн зохицуулалттай загварыг нэвтрүүлсэн байдаг бөгөөд энэ загварт зохицуулалтын үүрэг бүхий (бизнесийн холбоо, мэргэжлийн нийгэмлэг зэрэг) хувийн байгууллага нь “өдөр тутмын” зохицуулалтын үүргийг хүлээж, төрийн байгууллагын зүгээс тэдгээр хувийн байгууллагыг хянаж, тэдний гүйцэтгэж буй зохицуулалтанд урьдаас төлөвлөлгүй, гэнэтийн шалгалт явуулдаг юм. Бусад улс орон ийм байгууллагад зохицуулалт хийх илүү албан эрх мэдэл олгож байж болно. Эдгээр тогтолцоог нэвтрүүлсэн улсад дотоодын эдийн засгийн гэмт хэрэг гарах явдал харьцангуй бага байдаг ч хууль бус арилжааны үйл ажиллагаанд санхүүгийн тогтолцоог урвуулан ашиглах явдал нилээд ажиглагддаг. Эдгээрээс харахад, нэр хүндийг нь харгалзан үзээд өөрийн гэсэн зохицуулалттай, хэрэглэхэд хялбар тогтолцоог нэвтрүүлэх тусгай хөшүүрэг хувийн хэвшилд байгаа нь тодорхой бөгөөд оролцогч улс хяналтыг сулруулах боломжийг тооцож үзэж болох юм.

II.2. Урьдчилан сэргийлэх асуудлыг хариуцах этгээд

14 дүгээр зүйлийн 1 (а) хэсэгт дурдсан 2 дахь асуудал нь урьдчилан сэргийлэх асуудлыг хариуцах байгууллага болон түүний үйл ажиллагаатай холбоотой. Эхэндээ зөвхөн банк дээр төвлөрсөн байдалтай байсан бол байгууллагын болон түүний үйл ажиллагааны цар хүрээ нь одоо оролцогч улс орны хувьд үнэт цаасны ба даатгалын зах зээл дэх зуучлагчдыг ихэнхдээ өөртөө агуулдаг банк бус санхүүгийн байгууллагуудыг хамрах болж байгаа юм. Олон оронд санхүүгийн үйл ажиллагаа явуулах тал дээр хувь хүн, хуулийн этгээд болон аж ахуйн нэгжийг илүү өргөн хүрээнд хамрах, үүрэгт чиглэсэн хандлагыг нэвтрүүлээд байна. Ийм санхүүгийн үйл ажиллагаанд зээл, мөнгө болон бусад үнэт зүйлсийн шилжүүлэг, (зээлийн болон өрийн карт, чек, аяны чек, солигдох шилжүүлэг, банкны шилжүүлэг, цахим мөнгө зэрэг) төлбөрийн хэрэгслийг

бий болгох ба удирдах, баталгаа болон амлалт өгөх, (чек, мөнгөн дэсвгэрт гэх мэт) валютын зах зээлийн хэрэгслээр арилжаа хийх, гадаад валют солих, хүүгийн хэмжээ, индексийн хэрэгсэл буюу шилжүүлэх боломжтой үнэт цаас, хувийн болон хамтарсан хөрөнгө оруулалтын багц буюу бусдын өмнөөс сан хөрөнгийн хөрөнгө оруулалт, удирдлага буюу зохицуулалт хийх орж болно. Зарим орон энэхүү үүрэг хариуцлагын хүрээнд үнэт чулуу, урлагын бүтээл зэрэг өндөр үнэтэй бараа болон автомашин гэх мэт илүү түгээмэл барааг оролцуулсан үйл ажиллагааг ч хамааруулдаг. Оролцогч улсуудын зарим нь төрийн бус(буяны байгууллагаг.м)эсвэл хувийн хэвшлийн байгууллага(худалдаа, арилжааны байгууллага)-н үйл ажиллагаанд төстэй үүрэг хариуцлага ногдуулах эсэхээ бодолцож үзвэл зохино.

Энэ хэсэгт байгууллага болон түүний үйл ажиллагаанаас илүүтэйгээр ийм байгууллагын авлигаас олсон ашигийг нуун дарагдуулах болон шилжүүлэх асуудалд өртөмхий байдал дээр төвлөрч байна. Тиймээс энэхүү зүйл нь оролцогч улсад банк болон банк бус санхүүгийн байгууллага хийгээд албан болон албан бус мөнгө шилжүүлэгчдэд мөнгө угаахаас урьдчилан сэргийлэхтэй холбоотой үүрэг хариуцлагыг ногдуулах эрхийг олгож байгаагаас гадна оролцогч улсын зүгээс ялангуяа мөнгө угаахад өртөмтгий бусад байгууллагад мөн адил үүрэг ногдуулах явдлыг хангаж өгч байгаа болно. Нэгэнтээ дурдсанчлан, оролцогч улс гэмт хэргийн чанартай буюу хууль бус үйл ажиллагаанаас олсон орлогыг ийм сан хөрөнгийн эх сурвалжаас төдийгүй ийм үйл ажиллагааг явуулж болох арга хэрэгслээс хамааралтай тэрхүү албан эдийн засагт нэвтрүүлэх боломж олгож буй арга хэрэгслийг тооцож үзвэл зохино. Нөгөөтэйгүүр, үүнд, албан бус эдийн засгийн цар хүрээнээс авахуулаад тухайн улсын хууль ёсны санхүүгийн арга хэрэгслийн боломжит байдал хүртэл олон хүчин зүйлсээс шалтгаалж болно. Зарим улс санхүүгийн зуучлалын үйл ажиллагатай холбоотойгоор мөнгө угаахтай тэмцэхэд хуульчдыг оролцуулбал зохино гэж үзэж байгаа бол зарим нь дотоодын автомашины худалдаа, үл хөдлөх хөрөнгө зуучлал гэх мэт өндөр өртөг бүхий бэлэн мөнгөд суурилсан үйл ажиллагааны улмаас эрсдэл өндөртөйд тооцогддог салбаруудыг мөнгө угаахтай тэмцэх үйл ажиллагааны цар хүрээнд багтааж өгөх нь зүйтэй гэж үзэж байна. Тиймээс “Хаалгач”(урьдчилан сэргийлэгч, хамгаалагч)-ийн үүргийг хэн гүйцэтгэх талаар шийдвэр гаргахдаа оролцогч улс мөнгө угаах зорилгоор урвуулан ашиглахад өртөх магадлалтай байгууллага, байгууллагын үйл ажиллагаа болон авлигаас олсон орлогыг угаах хүсэлтэй этгээдийн ашиглаж болох арга хэрэгслийг тулд -58 дугаар зүйлд санал болгосон СМН болон 6 ба 36 дугаар зүйлд заасан байгууллагаар дамжуулан тодорхойлж, дотоодын хууль бус зах зээлийн үйл ажиллагааг анхаарч, эрсдлийн бүрэн үнэлгээ хийвэл зохино.

II.3. Зохицуулалт хийгдэх байгууллага болон байгууллагын үйл ажиллагаанд тавихгдахнаадзахыншаардлага

Урьдчилан сэргийлэх тогтолцооны гурав дах шаардлага нь зохицуулалт хийгдэх салбар болон салбарын үйл ажиллагаанд тавих шаардлагын доод хэмжээ юм. Конвенцид зааснаар бол, урьдчилан сэргийлэх тогтолцоо нь “харилцагч болон зохих тохиолдолд жинхэнэ өмчлөгчийн хэн болохыг тогтоох, тэмдэглэл хөтлөх, сэжигтэй гүйлгээг мэдээлэхэд тавих шаардлагыг онцлон тэмдэглэнэ”.

Мөнгө угаахаас урьдчилан сэргийлэхийн тулд, энэхүү ажлыг хариуцсан “Хаалгач”(урьдчилансэргийлэгч, хамгаалагч)-ийн эхний үүрэг бол санхүүгийн харилцаа үүсгэх этгээдийн хэн болохыг тогтоох явдал юм. “Харилцагчаа мэдэж байх” дүрэм болон банкны сэрэмжтэй байхыг заасан хуулийг сайтар тооцож үзэж тогтоосон зарчим нь мөнгө угаахаас урьдчилан сэргийлэхэд гол тулгуур багана болж өгнө. Харилцагчынхаа хэн болохыг тогтоох зарчмаас эхэлсэн энэхүү асуудал нь нилээд динамик шинжтэй бөгөөд 52 дугаар зүйлд гол ололтуудыг нь илүү дэлгэрэнгүй байдлаар авч үзэх болно. Харин 14 дүгээр зүйлд, харилцагчийн хэн болохыг тогтоохоос гадна тухайн шилжүүлэг, гүйлгээнд хамаарах хөрөнгөд сонирхол илэрхийлэх байдлаар үндсэн харилцагчаас гадна өөр хуулийн этгээд байж магадгүй гэж үзэх үндэслэл бүхий тохиолдлуудад “жинхэнэ өмчлөгчийн” хэн болохыг тогтоохын ач холбогдлыг онцгойлон авч үзэхийг шаардах ерөнхий суурь хүрээг бий болгосон байгаа. Оролцогч улс болж өгвөл холбогдох байгууллагын хамтаар, харилцагчийн хэн болохыг тогтоох болон баталгаажуулах талаар тэрхүү олонд нээлттэй байх үндсэн хүрээг зөвшилцөн тогтоох хэрэгтэй. Үүнээс гадна, оролцогч улс тухайн байгууллага харилцагчийн шаблон үүсгэж, түүний үйл ажиллагааг хянаж, өвөрмөц болон сэжигтэй гүйлгээ, үйл ажиллагааг мэдүүлж байх бололцоог түүнд олгох байдлаар харилцагчийн бизнесийг ойлгож байх явдлыг хангахтай холбоотой нэмэлт шаардлагыг тогтооно. Нэмэлт шаардлагын суурь хүрээг харилцагч бүрт зориулан бий болгосон эрсдлийн байдалд уялдуулан тодорхойлно. Оролцогч улс, энэхүү суурь хүрээг шинэ харилцагчийн нэгэн адилаар хуучин харилцагчид ч хэрэглэх эсэхийг холбогдох байгууллагатай тохиролцож, ийнхүү хуучин харилцагчийг энэ үндсэн хүрээнд хамруулах болсон тохиолдолд хуучин харилцагчид шаардлага тавих цаг хугацааны хязгаарыг ч мөн адил тогтоовол зохино.

Оролцогч улсууд “Хаалгач”(урьдчилан сэргийлэгч, хамгаалагч)-ийн үүргийг гүйцэтгэгч этгээдэд санхүүгийн үйл ажиллагааны тэмдэглэлийг эх байдлаар нь хөтлөхийг үүрэг болговол зохино. Энэхүү тэмдэглэл нь мөнгө угаасан тухай хэргийг шалгах болон яллах үйл ажиллагаанд хамгийн гол нотлох баримтыг бүрдүүлдэг учир энэхүү үүрэг нь урьдчилан сэргийлэх болон мөрдөн шалгах хандлагын хооронд гол холбогч зүйл болно.

Оролцогч улсууд санхүүгийн мэдээллийн хэлбэр, агуулгыг хадгалах болоод нотлох баримт болгох зорилгод нийцэх байдлаар тодорхойлохоос гадна санхүүгийн мэдээллийг хадгалах хугацааг зохих байдлаар тогтоох хэрэгтэй. Тэмдэглэл хөтлөхтэй холбоотойгоор “Хаалгач”(урьдчилан сэргийлэгч, хамгаалагч)-д ногдох бодит бөгөөд өртөг өндөртэй үүргийг тодорхойлохдоо шүүгдэгч тал буюу талууд албан тушаалыг орхих хүртэл ихэнхи авилгын хэргийг мөрдөх ажиллагаа эхэлдэггүйг тооцон үзвэл зохино. Ийм учраас 29 дүгээр зүйлд хязгаарлалт тавих тухайд нилээд урт дүрмийг дурдсан байгаа. Үүнтэй холбоотойгоор оролцогч улс 52 дугаар зүйлд дурдсан этгээдтэй холбоотой үйл ажиллагаанд мөн тэмдэглэл хөтлөхийг бодолцож үзвэл зохино.

Эцэст нь оролцогч улс сэжигтэй үйл ажиллагааны талаар мэдээлж байхыг “Хаалгач”(урьдчилан сэргийлэгч, хамгаалагч)-д үүрэг болгох хэрэгтэй. Сэжигтэй үйл ажиллагааг мэдээлэх тогтолцоог нэвтрүүлэх тал дээр оролцогч улс ямар нэг үйл ажиллагааны сэжигтэй эсэхийг шийдэхтэй холбоотойгоор “хаалгач”-д олгосон эрх мэдлийн хүрээ болон оролцогч улсын СМН-ийн мэдээлвэл зохих бүх мэдээллийг ойлгогдох байдлаар боловсруулах, дүн шинжилгээ хийх, хэрэглэх чадамж хоорондын тэнцвэрийг тооцож үзвэл зохино. Зарим улс үйл ажиллагааны

талаар мэдээлэхэд хамгийн бага үнийн дүнгийн босго бүхий мэдээлэх бодит тогтолцоог нэвтрүүлэхийг илүүд үздэг. Энэхүү загварыг зохих байдлаар нэвтрүүлэхийн тулд, СМН-ийг зохицуулалт хийгдсэн салбараас авсан бүх мэдээллийг боловсруулж, дүн шинжилгээ хийхэд шаардлагатай нөөцөөр хангана. Угтаа үйл ажиллагааны талаар мэдээлэхэд босго тавьсан улсуудыг оролцуулан оролцогч улс бүр сэжигтэй гэж тооцогдсон ямар нэг үйл ажиллагааны талаар шийдвэр гаргахад “Хаалгач”(урьдчилансэргийлэгч, хамгаалагч) хамгийн чухал үүрэгтэй гэдгийг тооцон үзэж, “Хаалгач”(урьдчилан сэргийлэгч, хамгаалагч)-ийн гаргасан шийдвэр нь тогтоосон шалгуурт нийцэж буй эсэхийг төрийн байгууллагын зүгээс хянадаг “субъектив” тогтолцоог нэвтрүүлсэн байна. Энэ загварт зохицуулалт хийгдсэн байгууллагад өөрийн нэр хүндээ хадгалж, эх сурвалж нь орчноо сэжиг бүхий мөнгөнөөс хол хөндий байлгах тусгай хөшүүрэг байна гэж хэлж болно. Босгод түшиглэсэн тогтолцоонд тогтмол бий болох мэдээллийг “хаалгач”-ийн зүгээс сэжигтэй гэж мэдээлсэн үйл ажиллагаанд шалгалт хийхэд хэрэглэх зорилгоор санхүүгийн өгөгдлийн сан үүсгэхэд эх сурвалж болгон ашиглаж болно.

II.4. Тайлагнах явдлыг хөхиүлэн дэмжих

Оролцогч улс “Хаалгач”(урьдчилансэргийлэгч, хамгаалагч)-тай хамтын ажиллагааны харилцааг бий болгохын тулд хэрхэн эерэг хөшүүргийг бий болгож, сөрөг хөшүүргээс ангижрах асуудлыг бодолцож үзэж, мэдээлэх үүргээ ойлгомжтой байдлаар гүйцэтгэхэд нь тэдэнд тусалвал зохино.

Эерэг хөшүүрэг дундаас “аюулгүйн боомт”-ын дүрэм онцгой ач холбогдолтой. Аюулгүй боомтын дүрэмд зааснаар шударгаар мэдээлж байгаа үед мэдээлэгч байгууллага болон түүний боловсон хүчнийг иргэний, захиргааны болон эрүүгийн хариуцлагас хамгаална. Үүнээс гадна тухайн мэдээлүүлсэн этгээдийн зүгээс сүрдүүлэх явдлаас хамгаалах нь чухал бөгөөд мэдээлж буй албан тушаалтны хэн болохыг нууцлах хэрэгтэй. Өөр бусад эерэг хөшүүрэг нь “Хаалгач”(урьдчилансэргийлэгч, хамгаалагч)-ийн үүргийг хөнгөвчлөх зорилгоор хангалттай цаг хугацаа олгох болон бөглөхөд хялбар маягт, Интернетээр дамжуулан нууц түлхүүр ашиглан мэдээлэх тогтолцоо зэрэг дарамт үл үүсгэх арга хэрэгслийг ашиглах гэх мэт бодит асуудалтай холбоотой байж болно. Оролцогч улс мэдээлэгч байгууллагад хэрхэн хариу өгөх болон субъектив тогтолцоонд энэхүү хариу нь хандлагаа төгөлдөржүүлэх тал дээр мэдээлэгч байгууллагад хэрхэн ашиг тусаа өгөх асуудлыг бодолцож үзвэл зохино. Оролцогч улс зохицуулалтын хориг арга хэмжээнээс мултрах зорилгоор хангалтгүй мэдээлэл өгөх буюу урьтаж сэрэмжүүлсэн мэдээлэл өгөх явдлыг өөгшүүлэх сөрөг хөшүүрэг үүсгэхээс хэрхэн зайлсхийхийг тооцож үзэх хэрэгтэй. Ер нь, аль ч тогтолцоонд мэдээллийн чанар, нарийвчилсан байдал болон хэрэгцээ хангах чадварын талаар мэдээлэгч байгууллагад холбогдох хариуг тогтмол өгч, мэдээлэл хүргэгдсэн байх явдлыг чухалчилж, төгөлдөржүүлэх тал дээр байгууллагатай хамтран ажилладаг. Хамгийн гол нь төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын хооронд хамтын үйл ажиллагааны орчин бүрдүүлэх юм. Энэ орчин нь одоогоор явуулж буй үйл ажиллагаа, байгууллагууд болон нэвтрүүлэхийг зорьж буй тогтолцооны зорилгоос хамаарч өөр өөр байж болох юм.

II.5. Санхүүгийн мэдээллийн харилцан солилцоо

14 дүгээр зүйлийн 1(b) хэсэгт мөнгө угаахтай тэмцэхэд оролцсон төрийн байгууллагын дотоодын болон олон улсын хэмжээнд хамтран ажиллах, мэдээлэл солилцох чадварыг авч хэлэлцсэн.

Дотоодын хэмжээнд мэдээлэлтэй харилцахад хоёр гол асуудал урган гардаг. Эхнийх нь эрүүгийн хэрэгт (энэ тохиолдолд авлига болон авлигаас олсон орлогыг угаах хэрэгт) буруутгагдсан байж болох этгээдийн эрхтэй холбоотой бол, дараагийнх нь хувь хүний хувийн харилцааны (энэ тохиолдолд хувийн санхүүгийн харилцааны) асуудлын нууцлалд хамаарна.

Ихэнх орон шүүх хуралд нотлох ажиллагааг танилцуулах асуудлыг зохицуулсан дүрэмтэй байдаг. Энэ нь мэдээлэл цуглуулах болон мэдээллийг нотлох баримт болгон ашиглах явдалд тодорхой хязгаарлалт тавьдаг. Хувийн хэвшил болон төрийн байгууллага сэжигтэй хэргийн талаар мэдээлж байх үүрэгтэй гэдэг нь арилжаа болон төрийн үйл ажиллагаатай холбоотойгоор байгууллага болон агентлагийн олж авсан хувийн мэдээллийг авлигатай холбоотой яллах үйл ажиллагаанд сонирхол илэрхийлэх эрх бүхий байгууллага олж авч болно. Энэ мэдээллийг албан ёсны мөрдөн шалгах үйл явцын үр дүнд олж авсан байж таарахгүй бөгөөд шүүх хуралд нотлох баримт болгон танилцуулах мэдээллийг цуглуулах болон ашиглахтай холбоотой үндсэн хуулийн буюу эрх зүйн хамгаалалд нийцэх байдлаар олж авсан байх албагүй. Ийм мэдээллийг шүүх хуралд нотолгоо болгох боломж тэр бүр байдаггүй. Ихэнх оронд төрийн болон хувийн хэвшлийн байгууллагаар дамжуулан олж аван СМН-д шилжүүлсэн мэдээллийг нотолгоо болгохоос илүүтэйгээр мэдээлэл болгож ашиглах замаар энэ асуудлыг шийддэг. Үүнийг зохих байдлаар нотлох баримт цуглуулах зорилго бүхий тэрхүү албан ёсны мөрдөн шалгах ажиллагааг эхлүүлэхэд л зөвхөн ашиглаж болно. Улс орнууд энэ тал дээр харилцан адилгүй үндсэн хуулийн болон эрх зүйн заалттай байдаг бөгөөд хэрэгт холбогдоод буй этгээдийн эрхийг хүндэтгэх байдлаар санхүүгийн мэдээллийг хамгаалж ашиглах орчинг бүрдүүлэх хэрэгтэй.

Одоогоор ихэнх орон төрийн болон хувийн хэвшлийн байгууллагад өгсөн хувийн мэдээллийн нууцлалыг хадгалах мэдээлэл хамгааллын орчинг бүрдүүлээд байна. Хууль тогтоох байгууллага эдгээр агентлагын зүгээс сэжигтэй хэргийн талаар мэдээлэх явдлыг хангахын тулд ийм заалтыг хэрэгсэхгүй болгох шаардлагатай. Гэвч, хүний үндсэн эрхийг орхигдуулахгүй байх хэрэгтэй. СМН болон түүний мэдээлэл түгээх байгууллага зэрэг мэдээлэл хүлээн авагчдаас мэдээлэл задруулахгүй байхыг шаардах замаар эдгээр эрхийг хүндэтгэж үзвэл зохино. Ийм орчныг бүрдүүлэх нь мэдээллийг хамгаалалтанд авах ач холбогдолтойгоос гадна тэдний мэдээллийн нууцлалыг хадгална гэдэгт итгэсэн тохиолдолд иргэд албан ёсоор мэдээлэл шаардахад илүү нээлттэй байдлаар хариу үзүүлдэг. Иргэний идэвхитэй оролцоо нь төрийн үйлчилгээг хүргэх, орлогын татварыг хураах зэрэг төрийн бодлогын зорилгоор хэрэглэгдэх мэдээллийн үнэн зөв байдлыг хадгалахад чухал.

Иргэн, төрийн байгууллагад өгсөн мэдээллийг тэдний ашиг сонирхолд хор хүргэх байдлаар бусад эрх бүхий байгууллага ашиглаж болзошгүй гэж бодсон тохиолдолд тэрхүү мэдээллийг өгөхдөө дурамжхан байх магадлалтай. Энэ тохиолдолд тэрхүү мэдээллийн үнэн зөв байх магадлал буурч, төрийн бодлого алдагдах явдал гарч болно. Нөгөөтэйгүүр авлигад оролцсон этгээд ямар ч тохиолдолд тэрхүү авлигын хэргийн талаар сайн дураар мэдээлэл бараг өгөхгүй гэдэг дээр санал зөрүүтэй байхыг үгүйсгэхгүй.

Оролцогч улс мэдээллийн нууцлалыг хадгалах зорилгоор төрийн агентлагуудын хооронд үүсгэсэн хаалтыг арилгаж, мэдээллийг хамгийн дээд түвшинд ашиглахын ач холбогдол болон иргэн өөрийн өгсөн мэдээллийн нууцлалыг хадгална гэдэгт эргэлзэж байгаа тохиолдолд тэрхүү мэдээллийн үнэн зөв байх магадлал буурахын сул талын 2ын хоорондын тэнцвэрт байдлыг хадгалахыг хичээвэл зохино.

Оролцогч улс үйл ажиллагааны аль чиглэлийг сонгохоос үл хамааран хувийн мэдээллийг хүлээж авсан этгээд мэдээллийн нууцлалыг хадгалж, хүний үндсэн эрхийг хамгаалах учиртай.

Санхүүгийн мэдээлэл солилцох тогтолцоог нэвтрүүлэх тал дээр дотоодын хэмжээнд авч үзвэл зохих асуудлын сүүлчийнх нь тогтолцоонд бий болох мэдээллийн хэмжээ болон энэ мэдээлэлд дүн шинжилгээ хийх, ангилан эмхлэх болон хадгалах үйл явцад зориулах боловсон хүчин болон техникийн нөөцтэй холбоотой. Технологи ашиглах нь дүн шинжилгээ хийх хүчин чадлыг нэмэгдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг ч хэт их хэмжээний мэдээлэл овоорох нь мөнгө угаахтай тэмцэх тогтолцооны үр ашигт байдалд хийгээд хариуцлага хүлээх чадварт муугаар нөлөөлнө. Олон орон эдгээр асуудлын заримыг мөнгө угаахаас урьдчилан сэргийлэх тогтолцоогоор дамжуулан цуглуулсан санхүүгийн мэдээллийг төвлөрүүлж, дүн шинжилгээ хийж, түгээх үүрэг бүхий төв байгууллага бий болгох замаар шийдэхийг чармайж байна. Ийм ч учраас 1(b) хэсэгт дээр дурдсан чиг үүргийг төвлөрүүлэх зорилгоор СМН-ийг үндэсний хэмжээнд байгуулахыг мөн конвенцийн 58 дугаар зүйлд тусгайлан авч үзсэн бусад улстай мэдээлэл солилцох чадварыг бодолцож үзэхийг оролцогч улсад санал болгосон байгаа.

Олон улсын хэмжээнд санхүүгийн мэдээлэл солилцох гол байгууллага нь 58 дугаар зүйлд дурдсан СМН юм. СМН-үүд өөр хоорондоо харилцан тохиролцсны үндсэн дээр мэдээлэл солилцох бөгөөд энэ нь сайн дурын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд хувь нэмэр болдог.

Авлигын хэргээр буруутгагдсан этгээдийн эрхийг хамгаалах болон мэдээллийн нууц байдлыг хадгалахтай холбоотойгоор дээр дурдсан асуудлын хүрээнд улс орнуудын эрхийг хамгаалах байдал нь өөр өөр байдгаас үүдэн олон улсын хэмжээнд мэдээлэл солилцох явдалд тодорхой хэмжээний хүндрэл үүсдэг. Хамгаалалтын дэглэмийн агуулга нь төстэй хэдий ч мэдээллийг хамгаалах байдал нь харилцан адилгүй байгаа тохиолдолд энэ нь мэдээлэл солилцох явцад саад үүсгэхгүй байх учиртай. Мэдээлэл солилцох журам нь харилцан эрх зүйн тусламж үзүүлэх журмаас хавьгүй энгийн хэлбэртэй байдаг. Эрх зүйн тусламж нь сэжигтний эрхийг хамгаалахад чиглэсэн байдаг бол СМН-үүдийн хооронд байгуулсан мэдээлэл солилцох хэлэлцээрт энэ тухай тусгадаггүй. Үнэндээ СМН-үүдийн өөр хоорондоо солилцож буй мэдээлэл нь нотлох баримт болохоос илүүтэйгээр мэдээллийн шинжтэй байдаг бөгөөд энэ хэлбэрээрээ шүүх хуралд хэрэглэгдэх нь ховор. Гэхдээ энэ нь мөрдөн байцаах үйл ажиллагаа эхлүүлэх үндэслэл болж болно. (энэ нь харилцан эрх зүйн тусламж үзүүлэх арга хэрэгслээр дамжуулан нотлох баримт болгох олон улсын хүсэлтийг өөртөө багтааж болно.) СМН-үүдийн хооронд байгуулсан хэлэлцээрт дараах зарчмуудыг ихэнхдээ мөрддөг:

- Нэг СМН-ээс нөгөө СМН-д хүсэлт гаргахдаа уг мэдээллийг хэрэглэх зорилго болон хүсэлт гаргаж буй шалтгаанаа тодорхой мэдээлж, хүсэлт нь дотоодын хууль

тогтоомжид нийцэж байгаа эсэхийг хүлээн авч буй СМН-ийн зүгээс тогтооход хангалттай мэдээлэл өгнө.

- СМН-үүдийн хооронд байгуулсан хоёр талын хэлэлцээр болон харилцан ойлголцлын санамж бичигт хүсэлт гаргасан мэдээллийн хэрэглээг тухайн мэдээллийн талаар хүсэлт гаргаж хүлээлгэн өгсөн тэрхүү зорилгоор хязгаарладаг.
- Хүсэлт гаргасан СМН өөр нэг СМН-ээс авсан мэдээллийг гуравдагч этгээдэд дамжуулж үл болохоос гадна мэдээллийг дамжуулсан СМН-ээс урьдаар зөвшөөрөөгүй тохиолдолд захиргааны, мөрдөн шалгах, яллах болон шүүхийн зорилгоор ашиглаж болохгүй. Мэдээллийг өгч буй СМН хүндэтгэх шалтгаангүйгээр энэхүү зөвшөөрлийг олгохоос татгалзаж үл болно.
- СМН-үүдийн өөр хоорондоо солилцсон мэдээлэл бүрт энэхүү мэдээллийг зөвхөн зөвшөөрөгдсөн байдлаар, хүний эрх, мэдээлэл хамгааллын тухай үндэсний хууль тогтоомжийн хүрээнд ашиглах явдлыг хангах зорилгоор хатуу хяналт тавьж хамгаална. Солилцсон мэдээллийг, хамгийн багадаа, хүлээн авч буй СМН-ийн дотоодын эх сурвалжаас олж авсантай төстэй мэдээлэлд үйлчилж буй хууль тогтоомжийн хүрээнд хамгаалвал зохино.

СМН-үүдийн Эгмонтын бүлгээс олон улсын хэмжээнд санхүүгийн мэдээлэл солилцох талаар эрх зүйн, бодит зөвлөмж бүхий “Санхүүгийн мэдээллийн нэгжүүд хооронд мэдээлэл солилцох зөв үйл ажиллагаа” нэртэй бичиг баримтыг 2004 онд хэвлүүлсэн. Энэхүү бичиг баримтад хүсэлт гаргах явц, хүсэлт гаргах мэдээллийн төрөл, хүсэлтийг хүлээн авах, хариу өгөх болон мэдээллийн нууц хадгалах журмын талаар зөвлөгөө өгсөн юм.

II.6. Бэлэн мөнгө ба санхүүгийн хөрвөх чадвартай хэрэгслийн хил дамнасан хөдөлгөөн

14 дүгээр зүйлийн хоёрдугаар хэсэгт оролцогч улсаас хилийг нь дамжих бэлэн мөнгө ба хөрвөх чадвартай санхүүгийн хэрэгслийн хөдөлгөөнийг илрүүлж, хянах талаар арга хэмжээ авахыг санал болгосон. Валют, хөрвөх чадвартай санхүүгийн хэрэгсэл ба банкны баталгаа, үнэт чулуу зэрэг хялбархан хэлбэр өөрчилж болох үнэт зүйлсийн тээвэрлэлт нь мөнгө угаахаас урьдчилан сэргийлэх тогтолцооны гол санаа зовоосон асуудлын нэг юм. Шалтгаан нь нилээд энгийн: хил дамнасны дараа буруу аргаар олсон орлогын эх сурвалжийг өөрчлөх нь хялбар болдог. Учир нь үүний эх сурвалжийг олж тогтоохын тулд олон улсын хамтын ажиллагаа шаардлагатай болдог бөгөөд энэ нь нэг улсын дотор явуулах мөрдлөгөөс хавьгүй удаан үргэлжилж сунжирдаг.

Энэхүү конвенц нь оролцогч улсад хилээр биет байдлаар бэлэн мөнгө ба хөрвөх чадвартай санхүүгийн хэрэгслийг тээвэрлэж буй этгээд бүрээс зохих эрх бүхий байгууллагад үнэн зөв мэдэгдэл хийхийг шаардах нөхцөлтэйгээр мэдэгдлийн тогтолцоог нэвтрүүлэхийг санал болгосон. Иймд тогтолцоог нэвтрүүлэхэд дараах асуудлыг анхаарч үзэх хэрэгтэй:

- Оролцогч улс тодорхой үнийн дүнгээс дээш гарсан тохиолдолд мэдэгдэл бөглөхийг шаардах тийм босго тогтоож болно. Ийнхүү босго тогтооход “хөрөнгийн чөлөөт хөдөлгөөн”-ий шалгуурыг тооцож үзэх хэрэгтэй. Бодит шалтгааны улмаас улс

орнуудад бусад оронд тогтоосон босгыг хуулбарлан авах хандлага ажиглагддаг. Ер нь 10.000 ам.доллар болон түүнтэй тэнцэх тухайн орны валютын босго өргөн тархсан.

- Оролцогч улс хөрвөх чадвартай санхүүгийн хэрэгслээс мэдэгдэл бөглөсөн байхыг шаардах асуудлыг шийдвэл зохино. Ер нь ийм тогтолцоонд чек, аяны чек, өр төлөх баталгаа, солигдох шилжүүлэг зэрэг хүлээн авагчийн нэр дээр бичигдсэн буюу хүлээлгэн өгөх үед тухайн эрхийг олгох хэлбэрийн (хязгаарлалт хийгээгүй, хуурамч хүлээн авагчийн нэр бүхий, бүрэн бус баримт бичиг) хөрвөх чадвартай санхүүгийн хэрэгсэлд багтдаг. Улс орнууд санхүүгийн баримт бичгээс гадна алт, үнэт метал, үнэт чулуу, буюу бусад өндөр үнэ бүхий хөдлөх хөрөнгө зэрэг хялбархан хэлбэр өөрчлөх боломжтой үнэт зүйлсийг мөн хамааруулах нь бий.
- Оролцогч улс тээвэрлэлтийн аль хэлбэрийг мэдэгдэл шаардах тогтолцоонд хамааруулахаа шийдэх хэрэгтэй. Ер нь улсууд дараах бэлэн мөнгө ба хөрвөх чадвартай санхүүгийн хэрэгслийн тээвэрлэлтэнд мэдэгдэл хийх тогтолцоог нэвтрүүлдэг: (1) валют ба хөрвөх чадвартай санхүүгийн хэрэгслийг биет байдлаар, тухайн хувь хүний ачаа бараа буюу тээврийн хэрэгсэл дотор тээвэрлэх; (2) каргогоор валют ба хөрвөх чадвартай санхүүгийн хэрэгсэл тээвэрлэх; (3) хувь хүн, хуулийн этгээдийн зүгээс валют ба хөрвөх чадвартай санхүүгийн хэрэгслийг шуудангаар явуулах. Орж ирж буй болон гарч буй тээвэрлэлтийн аль алинд мэдэгдэл шаардана.
- Үнийн дүнгийн доод босгоос дээш гарсан валют ба хөрвөх чадвартай санхүүгийн хэрэгслийг мэдэгдэхтэй холбоотой зөрчлийг илрүүлсэн тохиолдолд, тухайн хөрөнгийн эх сурвалж болон ашиглах зорилгын талаар тээвэрлэгчтэй холбоо барих эрхийг холбогдох эрх бүхий байгууллагад хуулиар олгосон байвал зохино. Оролцогч улс ийм мэдээллийг СМН-тэй хуваалцах явдлыг хангах хэрэгтэй. СМН мэдээллийн давтамж болон төрлийн талаар зохих эрх бүхий байгууллагад тусгай зөвлөмж өгч байна. Энэ талаар дүрэм, журам боловсруулахдаа мэдээллийг зохих байдлаар хэрэглэх шалгуурыг харгалзан үзэх нь зүйтэй.

Хилээр валют, эргэлтийн баримт бичиг тээвэрлэж буй этгээд бүрээс холбогдох эрх бүхий байгууллагын зүгээс үнэн зөв мэдэгдэл хийж байхыг шаардах нөхцөлтэйгээр, мэдэгдэл хийх жишиг тогтолцоог илрүүлэх тогтолцоотой хослуулах замаар ийм төрлийн зөрчлийг илрүүлэх үйл ажиллагааг хөнгөвчилнө. Энэ лавлагааг зорилгод үндэслэн, мэдээллийн эх сурвалжид болон тодорхой сэжиглэлд түшиглэн эсвэл гэнэтийн байдлаар явуулдаг.

Оролцогч улс валют болон эргэлтийн баримт бичгийг ташаа мэдэгдсэн, нуун дарагдуулсан эсвэл энэ нь ямар нэг гэмт хэрэгт холбоотой байж магадгүй тохиолдолд, хил дамжсан хөдөлгөөнийг илрүүлэх зорилгоор зорчигч, тээврийн хэрэгсэл болон каргонд шалгалт явуулах журмыг тогтоох хэрэгтэй.

Сэжигтэй валют ба хөрвөх чадвартай санхүүгийн хэрэгсэл илэрсэн үед нотлох баримтад халдахгүйн тулд валютыг ачаа бараа/каргоноос салгахгүй байвал сайн. Ташаа мэдэгдэл хийсэн, нуун дарагдуулсан эсвэл мөнгө угаахтай холбоотой байж болзошгүй валютын талаар мөрдлөг хийхэд хуурамч валют хэрэглэх явдалд зохих анхаарлыг хандуулах нь зүйтэй. Зарим улс орон хуурамч валютыг илрүүлэх механизмыг нэвтрүүлсэн байна. Жишээ нь, сэжигтэй еврогийн

асуудлаар эрх мэдэл бүхий байгууллагын зүгээс Европын төв банкны веб хуудаст (www.eur.ecb.int/en/section/recog.html) хандан тухайн мөнгөн дэвсгэртийг шалгаж болно. Ам. долларын талаар АНУ-ын Нууцын албаны хуурамч валют илрүүлэх веб хуудаст хандан тухайн долларыг шалгаж болох юм.

Валют болон эргэлтийн баримт бичгийн талаар ташаа мэдэгдэл хийсэн эсвэл нуун дарагдуулсан хэрэг гарсан, валют болон эргэлтийн баримт бичиг нь террорист үйл ажиллагааг санхүүжүүлэх буюу мөнгө угаахтай холбоотой байж магадгүй нь тогтоогдсон тохиолдолд тухайн хэрэгт оролцсон хувь этгээдийг баривчлах, яллах, валют, эргэлтийн баримт бичгийг хориглох, зогсоох талаар чиглэл боловсруулахад гаалийн эрх бүхий байгууллага ба бусад хууль сахиулах байгууллагын зүгээс прокурорын болон шүүхийн байгууллагатай хамтарч ажиллавал зохино. Оролцогч улс ташаа мэдэгдэл хийсэн болон мэдэгдэл хийхтэй холбоотой зөрчил гаргасан хэргийг хэрхэн шүүх талаар тодорхой дүрэм боловсруулж болно. Ер нь мөнгө угаах болон бусад гэмт хэрэгтэй холбоотой нотлох баримт байгаа эсэхийг тогтоох зорилгоор валютбахөрвөхчадвартайсанхүүгийнхэрэгслийг хориглохыг эрх мэдэл бүхий байгууллагад зөвшөөрөх түр зуурын арга хэмжээг авах юм.

Оролцогч улс мэдэгдэл хийхтэй холбоотой зөрчилд иргэний, захиргааны эсвэл эрүүгийн хуулийн хүрээнд хариуцлага тооцохоо шийдвэл зохино. Ер нь захиргааны эсвэл эрүүгийн хуулийн дагуу ногдуулснаас үл хамааран торгууль тавих нь энэ тогтолцоог мөрдүүлэхэд тухайн үйлдэлд тохирох, тухайн үйлдлийг дахин хийлгэхгүй байх арга хэмжээнд тооцогддог. Энэ нь хайхрамжгүй байдлаас үүдэлтэй хэрэгт бага торгууль ногдуулж, санаатайгаар хэрэг зөрчил өдүүлсэн тохиолдолд өндөр торгууль ногдуулах байдлаар хэлбэлзэж болно.

Бэлэн мөнгөний талаар мэдэгдэл хийх явдлыг мөрдүүлэх нь чухал. Оролцогч улс өдөр тутмын валютын мэдэгдлээс олж авсан мэдэгдлийг хэрхэн ашиглахаа тодорхойлвол зохино. Мэдэгдэл хийхтэй холбоотой зөрчил гаргасан этгээдийг баривчлах тал дээр зөвхөн төвлөрвөл авилгаас олсон орлогыг угаах явдлыг илрүүлэхэд бодит мэдээллийг ашиглах боломжийг сулруулна. Оролцогч улс бэлэн мөнгөний мэдэгдлийг хэрхэн хэрэглэхээ шийдэж чадахгүй бол эсвэл энэхүү мэдээлэлд дүн шинжилгээ хийхэд хүчин чадал нь хүрэлцэхгүй бол мэдээлэл цуглуулах нь төдий л ач холбогдолгүй. Авилгаас олсон орлогыг тээвэрлэх магадлалтай этгээдийн ерөнхий дүр зургийг гаргаж, мөрдөн шалгах явцад гол анхаарлыг энэхүү дүр зурагт тохирч буй этгээдээс авсан бэлэн мөнгөний мэдэгдэлд төвлөрүүлнэ. Энэхүү ерөнхий дүр зургийг улс орны болон олон улсын туршлагад нийцүүлэн шинэчилж байвал зохино. Оролцогч улс сэжиг төрүүлж цаашид мөрдөн шалгах үйл ажиллагааг эхлүүлж болох хүчин зүйлсэд анхаарал хандуулж, мэдэгдэл хүлээн авах боловсон хүчинг зохих байдлаар сургах нь чухал. Тээвэрлэж буй бэлэн мөнгөний нийт хэмжээ нь мөнгө угаагчдын хэрэглэдэг аргыг зохих байдлаар харуулж байж болох юм. Сэжиг төрүүлэх гол мэдээллийг авч байх явдлыг хангах зорилгоор бэлэн мөнгөний мэдэгдлийн маягтыг өөрчлөхөд эрсдлийн үнэлгээ, ерөнхий дүр зураг болон хандлагын талаарх мэдээллийг ашиглаж болно.

II.7. Мөнгөн шилжүүлэг

Хоёрдугаар хэсэгт дурдсантай адил асуудлаар, 14 дүгээр зүйлийн гуравдугаар хэсэгт оролцогч улсууд санхүүгийн байгууллага, үүний дотор мөнгө гуйвуулдаг байгууллагад дараахь шаардлагыг тавих талаар хэрэгжих боломжтой бөгөөд зохих арга хэмжээг хэрэгжүүлэх асуудлыг авч үзэхийг санал болгосон: (а) мөнгөний цахим шилжүүлгийн маягт болон холбогдох мэдээнд шилжүүлэгчийн талаар үнэн зөв бөгөөд зорилгод нийцсэн мэдээллийг тусгах; (b) ийм мэдээлийг төлбөрийн гүйцэтгэлийн шатанд хадгалах; (c) шилжүүлэгчийн талаар бүрэн мэдээлэл байхгүй мөнгөн шилжүүлгийн талаар нарийн шалтгалт явуулах.

Цахим шилжүүлгийн тогтолцоонд ч мөн бусад санхүүгийн үйл ажиллагааны нэгэн адил нарийн хяналт тавьж байвал зохино. Ерөнхий эрдслийн үнэлгээний хүрээнд мөнгө гуйвуулагч байгууллагатай холбоотой эрсдлийг тодорхойлох нь маш чухал байдаг. Оролцогч улсад, мөнгө, шилжүүлэгтэй холбоотойгоор “харилцагчаа мэдэж байх” дүрмийг мөрдүүлж байхыг мөн шилжүүлэгчийн талаархи мэдээлэл дутуу үед (шилжүүлгийг хүлээн авч буй талаас) төлбөрийн бүх шатанд мэдээлэл цуглуулж, хяналтыг сайжруулах замаар шилжүүлгийн ул мөрийг тогтоох боломжийг бий болгож байхыг чухалчлан зөвлөж байна.

Санхүүгийн зуучлагчдад цахим шилжүүлэг хийх зөвшөөрлийг олгохыг дотоодын хууль тогтоомжоор зохицуулдаг учраас энэ нь оролцогч улсуудад харилцан адилгүй байдаг. Гэхдээ, оролцогч улс, үндэсний болон олон улсын хэмжээнд мөнгөний бүх бизнес үйлчилгээг багтаах байдлаар цахим хэлбэрээр мөнгө илгээж, хүлээн авахыг харилцагчид зөвшөөрөхийг хүсч байж болох юм. Энэ гүйлгээний хүрээнд харилцагч үйлчилгээ үзүүлэх цэг дээр очиж, мөнгө шилжүүлэх маягыг бөглөн, гүйлгээний төлбөрийг төлснөөр мөнгө илгээх боломжтой болно. Шилжүүлгийг хүлээн авч буй талд ямар нэг төлбөр төлөхийг ихэнхдээ шаарддаггүй.

Цахим шилжүүлэгтэй холбоотой урьдчилан сэргийлэх арга хэмжээг нэвтрүүлэхэд оролцогч улс хэд хэдэн асуудлыг тооцож үзвэл зохино. Юун түрүүнд оролцогч улс мэдээллийн үйл ажиллагаа явуулах доод босгыг тогтоох боломжийг бодолцож үзэх хэрэгтэй. Улс бүр мэдээлэх үйл ажиллагааг эхлүүлэх босгыг харилцан адилгүй байдлаар тогтоосон байдаг. Зарим нь сар тутмын мэдээлэх байдалд босго тавьсан байдаг бол зарим нь “сэжигтэй” хэргийг мэдээлэх тал дээр босго тавихыг илүүд үздэг. “Төлөвлөсөн” гүйлгээг –босгоос мултрах зорилгоор тодорхой байдлаар хэсэгчилж хуваасан гүйлгээ- мөн анхаарч үзвэл зохино.

Түүнчлэн оролцогч улс мөнгө гуйвуулагч байгууллага харилцагчаасаа ямар мэдээлэл авч байвал зохихыг шийдэх хэрэгтэй. Оролцогч улсын шаардлагатай гэж үзэж болох мэдээллийн товч жагсаалтад эдгээр орно. Үүнд гуйвуулагчийн нэр, хаяг болон батлах үйл ажиллагаанд шаардагдах байдлаар биеийн байцаалтын хуулбар (ихэнхдээ гэрэл зураг бүхий 2 өөр биеийн байцаалт шаарддаг); гуйвуулах мөнгөн дүн; гуйвуулах захиалгын эцсийн хугацаа; мөнгө гуйвуулагч байгууллагын оногдуулсан төлбөр; хүлээн авагчийн санхүүгийн байгууллагын тодорхойлолт; гуйвуулгыг хийж буй хүний зүгээс бөглөж, гарын үсэг зурсан гүйлгээнд холбогдох ямар нэг маягт, гуйвуулгын захиалгад шаардснаар хүлээн авагчийн нэр, хаяг, дансны дугаар багтаж болно.

Эцэст нь оролцогч улс мөнгө гуйвуулагч байгууллага эдгээр мэдээллийн аль хэсгийг нь холбогдох эрх бүхий байгууллагад дамжуулж, аль хэсгийг нь өөртөө -ямар хугацаагаар- хадгалахыг шийдэх хэрэгтэй.

Зарим улс мөнгө гуйвуулагч байгууллагад үйлчилгээгээ тасалдсан байдлаар гүйцэтгэхийг зөвшөөрдөггүй бөгөөд харин ямар нэг үйлчилгээнд хамрагдахаас нь өмнө хувийн нилээд мэдээллийг харилцагчаас нэг дор авч байхыг шаарддаг. Ийм мэдээлэлд ажил алба, орлогын бусад эх үүсвэр, мөнгөн гуйвуулгын ерөнхий дүр зураг, хувь хүртэгчид багтах ба ингэснээр бодит мөнгөн гуйвуулгыг (болж өгвөл цахим байдлаар) гуйвуулгын ерөнхий дүр зурагтай харьцуулах боломжтой болох юм. Оролцогч улс энэ хандлагыг зохих байдлаар тооцож үзэх хэрэгтэй.

II.8. Хэрэгжүүлэлт

Оролцогч улс бүс нутгийн, бүс нутаг хоорондын болон олон талт байгууллагаас гаргасан мөнгө угаахын эсрэг холбогдох санаачилгыг удирдлага болгохыг хүсч байна.

Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн үйл ажиллагааны бүлэг (FATF) нь FATF-ын загвар бүхий бүс нутгийн байгууллагыг бий болгох ажлыг дэмжсээр ирсэн бөгөөд эдгээрийн зарим нь FATF-ын гишүүн юм. FATF-ын бүс нутгийн бүлгүүдэд дараах бүлэг орно:

Карибын тэнгисийн орнуудын FATF бүлэг, 1993 онд байгуулагдсан. (www.cfatf.org);

Ази, Номхон далайн орнуудын мөнгө угаахтай тэмцэх бүлэг, 1997 онд байгуулагдсан. (<http://www.apgml.org>);

Мөнгө угаахтай тэмцэх үйл ажиллагааг үнэлэх Мэргэжлийн комисс (MONEYVAL), 1997 онд байгуулагдсан. (www.coe.int/moneyval);

Евроазийн бүлэг, 2004 онд байгуулагдсан. (<http://www.eurasiangroup.org/index-1.htm>);

Зүүн болон Өмнөд Африкийн Мөнгө угаахтай тэмцэх бүлэг, 1999 онд байгуулагдсан. (<http://www.esaamlg.org/index.php>);

GAFISUD, 2000 онд байгуулагдсан,

Дундад, Зүүн болон Хойд Африкийн FATF бүлэг, 2004 онд байгуулагдсан. (<http://www.menafatf.org/Home.asp>).

СМН-үүдийн хүрээнд, бүлэг СМН олон улсын хамтын ажиллагааг эхлүүлэх зорилгоор 1995 онд албан бус бүлэг байгуулсан нь одоогийн Эгмонтын бүлэг юм. (<http://www.egmontgroup.org/index2.html>). 2006 оны байдлаар 101 идэвхитэй гишүүнийг эгнээндээ нэгтгэсэн Эгмонтын бүлэг нь ялангуяа мэдээлэл солилцох, сургалт явуулах болон туршлага

солилцох тал дээр хамтран ажиллах арга замыг олж тогтоох зорилгоор тогтмол чуулга уулзалт зохион явуулдаг.

Үүнээс гадна мөнгө угаахтай тэмцэхийн тулд шүүх, хууль сахиулах болон санхүүгийн зохицуулалтын эрх бүхий байгууллага хоорондын хамтын ажиллагааг дэлхийн, бүс нутгийн, дэд бүсийн болон хоёр талын хэмжээнд хөгжүүлж, дэмжихажиллагааг оролцогч улсуудад санал болгосон байгаа. Эна талаар дараагийн хэд хэдэн бүлэгт авч үзнэ.

Гэмт хэрэгт тооцох, хууль сахиулах

(Ш бүлэг, 15-42 дугаар зүйлүүд)

Конвенцийн 15-29 дүгээр зүйлүүдийн агуулга, бүтэц болон хэрэгжүүлэх шаардлагын талаар илүү мэдээлэл, дүн шинжилгээ олж авахыг хүсвэл Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний байгууллагын Конвенцийг хэрэгжүүлэх Эрх зүйн удирдамжийн холбогдох хэсгийг харна уу.

30 дугаар зүйл: Яллах, шүүхийн шийдвэр гаргах, шийтгэл ноогдуулах

1. Оролцогч улс бүр энэхүү конвенцийн дагуу тогтоосон гэмт үйлдэлд тухайн гэмт үйлдлийн ноцтой байдлыг харгалзан шийтгэл ноогдуулна.

2. Оролцогч улс бүр өөрийн төрийн албан хаагчийн албан үүрэгтэй нь холбогдуулан олгосон аливаа ялаас чөлөөлөх, шүүхийн харьяаллын давуу эрх болон шаардлагатай тохиолдолд, конвенциор тодорхойлсон гэмт үйлдлийг үр дүнтэйгээр мөрдөн шалгах, яллах, шүүхээр шийдвэрлүүлэх боломжийн зохих тэнцвэрийг эрхзүйн тогтолцоо болон үндсэн хуулийн зарчимдаа нийцүүлэн тогтоох буюу хадгалахад шаардлагатай хууль тогтоох болон бусад арга хэмжээг авна.

3. Оролцогч улс бүр энэхүү конвенциор тодорхойлсон гэмт үйлдлийн улмаас аливаа этгээдийг яллах талаар дотоодын хууль тогтоомжид заасны дагуу бие даан хуульзүйн эрх мэдлийг тэдгээр гэмт үйлдлийн хувьд хууль сахиулах арга хэмжээний үр ашигтай байдлыг аль болох дээшлүүлэхүйцээр бөгөөд ийм гэмт үйлдлийг гаргахгүй байх хэрэгцээг зохих ёсоор харгалзан хэрэгжүүлэх талаар хүчин чармайлт гаргана.

4. Энэхүү конвенциор тодорхойлсон гэмт үйлдлийн хувьд оролцогч улс бүр анхан буюу давж заалдах шатны шүүх ажиллагааны өмнөх батлан даалттай холбоотой нөхцлийг тогтоохдоо байцаан шийтгэх ажиллагаанд хариуцагчийг байлгах явдлыг хангах хэрэгцээг харгалзан үзэх зохих арга хэмжээг өөрийн дотоодын хууль тогтоомждоо нийцүүлэн, өөрийгөө хамгаалах эрхийг зохих ёсоор харгалзан авна.

5. Оролцогч улс бүр гэмт үйлдэлд шийтгэгдсэн этгээдийг хугацаанаас нь өмнө суллах буюу тэнсэн суллах боломжийг авч үзэхдээ тухайн гэмт үйлдлийн ноцтой байдлыг харгалзан үзнэ.

6. Оролцогч улс бүр энэхүү конвенциор тодорхойлсон гэмт үйлдэлд буруутгагдаж буй төрийн албан хаагчийн гэмбуруугэрхбүхийбайгууллаганотлоогүйболгэмбуруугүйдооцохзарчмыг хүндлэн үзэж, шаардлагатай гэж үзвэл албан тушаалаас чөлөөлөх, түдгэлзүүлэх буюу өөр албан тушаалд томилох журмыг бий болгох асуудлыг эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцэхүйц байдлаар а вчүзнэ.

7. Гэмт үйлдлийн ноцтой байдлаас гэм буруу нь нотлогдож байгаа тохиолдолд оролцогч улс бүр энэхүү конвенциор тодорхойлсон гэмт үйлдэлд буруутгагдаж буй этгээдийн дараахь үйл ажиллагаа явуулах эрхийг шүүхийн шийдвэр буюу зохих аливаа бусад хэрэгслээр дотоодын хуулиараа тогтоосон хугацаанд нь хасах журмыг тогтоох асуудлыг эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн авч үзнэ:

(a) Төрийн алба хаших;

(b) Төрийн өмчит буюу төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжид алба хаших.

8. Энэ зүйлийн 1 дэх хэсэг эрх бүхий байгууллага төрийн албан хаагчид сахилгын шийтгэл оногдуулах эрх мэдлээ хэрэгжүүлэхийг хөндөхгүй.

9. Энэхүү конвенцийн аль ч заалт конвенциор тодорхойлсон гэмт үйлдэл, эрх зүйн холбогдох хамгаалалт буюу тухайн үйлдлийн хууль ёсны байдлыг тодорхойлдог эрх зүйн бусад зарчмуудын талаарх тодорхойлолтыг зөвхөн оролцогч улсын дотоодын хууль тогтоомжид заах, түүнчлэн ийм гэмт үйлдлийг тэрхүү хуулийн дагуу яллаж, шийтгэх зарчмыг хөндөхгүй.

10. Оролцогч улс бүр энэхүү конвенциор тодорхойлсон гэмт үйлдэлд яллагдаж буй этгээдийгн ийгэмшүүлэх явдлыг дэмжих талаар хүчин чармайлт гаргана.

I. Ерөнхий тойм

Гуч дугаар зүйлийн заалтууд хууль сахиулах талаарх гол асуудлуудыг хөндсөн байна. Энд мөрдөн шалгах болон яллахтай холбоотой асуудлаас гадна дархан эрхтэй холбоотой чухал бөгөөд нарийн асуудал багтаж байгаа юм. Энэ зүйлд ял шийтгэл (эрүүгийн *strictu sensu* болон “нэмэлт” шийтгэл), сахилгын арга хэмжээ болон эрхийг нь хасах зэрэг тухайн гэмт хэргийн мөн чанар хийгээд ноцтой байдалд тохирсон шийтгэлд анхаарал хандуулсан байна. Төгсгөлд нь энэ зүйлд гэмт хэрэгтийг нийгэмшүүлэх асуудлыг авч үзсэн байна.

Энэ зүйлээр:

- Оролцогч улс бүр гэмт хэргийн ноцтой байдлыг харгалзан шийтгэл ногдуулахыг (1 дүгээр хэсэг);

- Оролцогч улс бүр өөрийн төрийн албан тушаалтанд чиг үүргээ гүйцэтгэхэд нь олгосон аливаа дархан эрх буюу шүүхийн харъяаллын давуу эрх болон шаардлагатай тохиолдолд конвенциор тогтоосон гэмт хэргийг үр дүнтэйгээр мөрдөн шалгах, яллах, ийм хэрэгт шүүхийн шийдвэр гаргах боломжийн хооронд зохих тэнцвэрийг эрх зүйн тогтолцоо болон үндсэн хуулийн зарчимдаа нийцүүлэн тогтоох буюу хадгалахад шаардлагатай хууль тогтоох болон бусад арга хэмжээг авахыг (2 дугаар хэсэг);
- Анхан буюу давж заалдах шатны шүүх ажиллагааны өмнө түр суллах буюу тэнсэн суллах тухай шийдвэр гаргахдаа дараагийн эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд хариуцагчийг байлгах явдлыг хангахыг (4 дүгээр хэсэг);
- Оролцогч улс гэмт хэрэгт шийтгэгдсэн этгээдийг хугацаанаас нь өмнө суллах буюу тэнсэн суллах боломжийг авч үзэхдээ тухайн гэмт хэргийн ноцтой байдлыг харгалзан үзэхийг (5 дугаар хэсэг) шаардсан байна.

Эдгээр заавал гүйцэтгэх заалтаас гадна энэ зүйлд заавал гүйцэтгэх албагүй дараах заалтууд ч багтаж байгаа болно:

- Оролцогч улс бүр энэхүү конвенцийн дагуу тогтоосон гэмт хэргийг үйлдсэн гэж яллагдаж буй төрийн албан тушаалтныг эрх бүхий байгууллага зохих тохиолдолд албан тушаалаас чөлөөлөх, түдгэлзүүлэх буюу өөр албан тушаалд томилж болох журмыг тогтоох асуудлыг авч үзнэ (6 дугаар хэсэг);
- Оролцогч улс бүр энэхүү конвенцийн дагуу тогтоосон гэмт хэрэгт яллагдаж буй этгээдийг дотоодын хуулиараа тогтоосон хугацаанд дараахь үйл ажиллагаа явуулах эрхийг нь хасах журмыг тогтоох асуудлыг авч үзнэ: (a) төрийн алба хаших; (b) төрийн өмчит буюу төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжид алба хаших (7 дугаар хэсэг);
- Оролцогч улс бүр энэхүү конвенцийн дагуу тогтоосон гэмт хэрэгт яллагдаж буй этгээдийг нийгэмд дахин нэгдэн орохыг дэмжихийг чармайна (10 дугаар хэсэг).

Гуч дугаар зүйлийн заалтуудыг хэрэгжүүлснээр хуульд захирагдах ёс зохих байдлаар хэрэгжих, уг явдлыг бэхжүүлэх зорилгоор ямар арга хэмжээ авбал зохихыг тодорхойлох маш чухал “бэлэн байдлын шалгалт”-ыг эрүүгийн шүүхийн тогтолцоонд явуулах юм. Эдгээр заалт нь шүүх үйл ажиллагааны бодлого саадгүй хэрэгжих явдлыг хангах ухаалаг арга зам болно.

II. Бэрхшээл ба шийдэл

II.1. Гэмт хэргийн ноцтой байдлыг харгалзан шийтгэл ногдуулах

“Шийтгэл” гэдэгт эрүүгийн болон эрүүгийн бус захиргааны буюу иргэний шийтгэл орно. Гэхдээ энэхүү конвенцын дагуу “эрүүгийн гэмт хэрэг” гэж тогтоосон үйлдэлд эрүүгийн шийтгэлийн хамтаар эрүүгийн бус шийтгэлийг оногдуулж болох бөгөөд харин эрүүгийн бус шийтгэлээр эрүүгийн шийтгэлийг орлуулахгүй.

Энэхүү конвенцоор гэмт хэрэгт тухайн гэмт хэргийн ноцтой байдлыг харгалзан шийтгэл ногдуулахыг оролцогч улсаас хүссэн байгаа. Шийтгэлийн хэлбэр нь ямар байхыг тохиролцоогүй ч тухайн гэмт хэргийн ноцтой байдалд тохирсон торгох, шоронд хорих зэрэг ял шийтгэлийг ногдуулж байхыг конвенцид онцолж үзсэн байна. Гэмт хэргийн ноцтой байдлыг үнийн дүн, зохисгүй давуу байдлаас гадна тухайн хэрэгт холбогдсон этгээдийн зэрэг дэв, хэрэг гарсан орчин нөхцөл, тухайн хэрэгт холбогдогч албан тушаалтанд хүлээлгэх итгэлцлийн түвшин зэргийг харгалзан үзэж тогтоож болно.

Конвенцид шийтгэлийн хүнд, хөнгөн байдал буюу ялын хэмжээг ямар нэг байдлаар тогтоогоогүй. Ял шийтгэл нь улс бүрийн харилцан адилгүй уламжлал, бодлогыг тусгаж байдаг тул адил төрлийн гэмт хэрэгт ногдуулах шийтгэл нь орон бүрд өөр өөр байж болохыг конвенцид дурдсан байна. Үнэндээ авлигын гэмт хэргийн шийтгэл нь үндэсний эрх зүйн хүрээнд нийцэхээс гадна оролцогч улсын эрүүгийн хуулиар заасан ял шийтгэлийн ерөнхий орчинд тохирч байх учиртай юм. Ер нь тухайн гэмт хэргийн ноцтой байдлыг харгалзан шийтгэл оногдуулахад конвенцийн дагуу тогтоосон авлигын гэмт хэрэгт ногдуулах эрүүгийн ял шийтгэл нь энэ хэрэгтэй дүйцэхүйц эдийн засгийн гэмт хэрэгт ногдуулах ял шийтгэлээс хөнгөн биш байна. Хил дамнасан авлигын хэргийн хувьд хоёр талын эрх зүйн харилцан туслалцаа болон гэмт хэрэгтэнг гадаад улсад шилжүүлэх асуудал чухал үүрэг гүйцэтгэдэг, ба ял шийтгэл нь хоёр талын эрх зүйн асуудлаар үр нөлөөтэй байдлаар харилцан туслалцах болон гэмт хэрэгтэнг гадаад улсад шилжүүлэх явдалд боломж олгож байхаар хангалттай өргөн хүрээг хамарсан байх хэрэгтэйг оролцогч улс анхаарч үзвэл зохино. Зарим улсын хувьд гэмт хэрэгт шийтгэл ногдуулах тал дээр шоронд хорих ял шийтгэлд тодорхой хугацаа заахдаа хоёр улсын хүлээн зөвшөөрсөн шаардлагад нийцүүлэх хэрэгтэй болдог

Ял шийтгэлийг хэрэглэх байдал нь тухайн оролцогч улсын эрх зүйн тогтолцооноос хамаарч харилцан адилгүй байж болно. Шүүхээс өргөн хүрээний боломжит ял шийтгэлийг тодорхой хэмжээгээр өөрийн үзэмжээр ял шийтгэл оногдуулдаг оролцогч улсуудад, гэм буруутай байдал болон хохирлыг үнэлэн, хүндрүүлэх болон хөнгөрүүлэх хүчин зүйл (авлигын гэмт хэргийн тухайд итгэл эвдсэн байдал гол хүндрүүлэгч хүчин зүйл болж болох юм), хувийн хүндэтгэх шалтгаан болон гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн мэдэгдэл байгаа эсэхийг харгалзан тухайн гэмт хэргийн ноцтой байдлын тухайд шийдвэр гаргах байдлаар шүүх ажиллагаа ихэнхдээ эхэлдэг. Ингэснээр шүүхэд эрх чөлөг хязгаарлах шийтгэлийг оногдуулах босгоос илүү гарсан эсэхийг тогтоох боломж олдоно. Түүнчлэн гэм буруутай нь тогтоогдож, шүүгдэгч авлигын хэргээс санхүүгийн ашиг олоогүй гэдэгт итгэлтэй болохын тулд хөрөнгийг тодорхой байдлаар үнэлж, хураасны дараагаар хохирлыг барагдуулах талаар шүүхийн шийдвэр гаргах хэрэгтэй болно.

Оролцогч улс (хувь этгээдтэй холбоотойгоор) үр нөлөөтэй, тухайн үйлдэлд таарсан, тухайн үйлдлийг дахин үйлдүүлэхгүй байх тийм шийтгэл ногдуулахыг заасан 26 (4) зүйлийн ял шийтгэл оноох удирдамжийг анхаарч үзэх хэрэгтэй.

Ял оноох удирдамжийн заалтууд энэ тал дээр тус болж болох юм. Олон оролцогч улс шүүгчийн албан заавар биш харин чиглүүлэг болгон ашиглах боломжтой тийм ял шийтгэл оноох удирдамжийг бий болгосон байна.

Их Британид, жишээлбэл, шүүгчдэд буюу ял ногдуулагчдад зориулсан ял шийтгэл ногдуулах удирдамжийг⁶ Ял ногдуулах асуудлаар зөвлөх комисс ба Ял оноох удирдамжийн зөвлөл гэсэн өөр хоорондоо ойр холбоотой бие даасан хоёр байгууллага хариуцдаг. Эдгээр нь Англи болон Уэйлсийг хамарсан шүүхүүдэд ял ногдуулахад тууштай байдлыг хангаж, шийтгэл ногдуулагчийг шийдвэр гаргах тал дээр дэмжих зорилгоор ял ногдуулах тухай удирдамжийг боловсруулахад хамтран ажилладаг юм.

Ял ногдуулах асуудлаар зөвлөх комисс нь тодорхой гэмт хэрэг болон гэмт хэргийн бүлгийн хүрээнд ял ногдуулах удирдамжийн талаар мөн бусад ял ногдуулах тухай асуудлаар зөвлөгөө өгдөг. Өргөн хүрээнд зөвлөлдөж, судалгаа хийсний дараагаар шаардлагатай гэж үзвэл энэхүү комиссоос зөвлөмж боловсруулж, Ял оноох удирдамжийн зөвлөлд хэлэлцүүлэхээр өргөн барина. Ял оноох удирдамжийн зөвлөл тодорхой сэдвийн хүрээнд Ял ногдуулах асуудлаар зөвлөх комиссоос зөвлөмж авч, үүнийг тухайн сэдвээр ял ногдуулах удирдамж боловсруулахад ашигладаг. Эдгээр “удирдамжийн төсөл”-ийг хэвлээд, энэ талаар зөвлөлдөөд эцэст нь хянана.

Үүний дараа ял ногдуулагч хэрэглэхэд бэлэн болсон эцсийн байдлаар ял ногдуулах удирдамжийг хэлэлцэнэ.

Мэдээж хэрэг бусад олон улс оронд ийм “албан бус” удирдамж байхгүй бөгөөд ял оноох хэмжүүрийг UNCAC конвенцийн дагуу тогтоосон гэмт хэргийг шийдэх эрүүгийн хууль тогтоомжийн хүрээнд тодорхойлж өгсөн байдаг.

Зарим оролцогч улс шийтгэл нь үр нөлөөтэй, тухайн үйлдэлд таарсан, тухайн үйлдлийг дахин үйлдүүлэхгүй байх шалгуурыг хангахуйц сайтар баримтжуулсан өөр дэглэмтэй байж болох юм. Жишээлбэл, Герман улсын Эрүүгийн хууль нь тохиролцох (*Absprachen*) болон шүүх хурлаар шийдүүлэх тогтолцоонд тохирох байдлаар өргөн хүрээний ял шийтгэлийг зөвшөөрсөн байдаг. Хувь этгээдийн ял ногдуулах тухайд Герман улс Захиргааны гэмт хэргийн тухай хуулийн хүрээнд (торгууль ногдуулах болон “санхүүгийн ашиг”-ийг хураахаас бүрдсэн) захиргааны торгуулийн тогтолцоотой.

II.2. Дархан эрх буюу шүүхийн харъяаллын давуу эрх

Дархан эрхийг зарчмын хувьд хоёр бүлэгт авч үзнэ: хариуцлага үл хүлээх ба халдашгүй байх. Эхний төрлийн дархан эрх нь (парламентын гишүүн зэрэг) хууль тогтоох байгууллагын гишүүний чиг үүргээ биелүүлэхтэй холбоотой санал илэрхийлэх, санал хураалтанд оролцоход хамаарах байдлаар хэрэгжинэ. Үүний зорилго нь хараат бус байдал болон үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг шүүхийн бүх байцаалтаас ангид байлгаж, хамгаалах явдал юм. Гэхдээ энэ нь эрүүгийн хариуцлага хүлээх байдалд тодорхой хязгаарлалт тавьж болно. Дараагийн төрлийн дархан эрх нь төрийн албан тушаалтны тодорхой бүлгүүдийг үүргээ гүйцэтгэж байх хугацаанд нь баривчлах, саатуулах, яллах зэрэг хуулийн үйл ажиллагаанаас хамгаалах асуудалтай холбоотой бөгөөд зарим оронд эдгээрээс гадна цагдаагийн мөрдөн байцаах ажиллагаа болон тусгай мөрдөн шалгах арга хэрэгслийг хэрэглэх явдлаас ч ангид байлгадаг.

Оролцогч улсуудын ихэнх нь дархан эрх болон шүүхийн харъяаллын давуу эрхийг төрийн байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг хамгаалахад шаардлагатай хэрэгсэл болгож хууль тогтоох байгууллагын гишүүд зэрэг төрийн албан тушаалтанд хамааруулж үздэг ч дархан эрх нь төрийн тэдгээр албан тушаалтныг хуулиас дээгүүр буюу ангид байдалтай болгож байгаа мэт сэтгэгдэл төрүүлдэг учраас тодорхой бэрхшээлийг дагуулдаг. Яллахаас дархлагдсан байх нь авлигын хэрэг ихсэх гол шалтгаан мэтээр ойлгох явдал түгээмэл ажиллагддаг. Учир нь улс төрийн дархан эрх өндөр түвшний авлигын хэрэгт мөрдөн байцаах ажиллагаа явуулахад томоохон саадыг үүсгэж байж болно. Энэ үр дагаврыг харгалзан дэлхийн цөөнгүй улс орон дархан эрхийн тухай дүрмээ өөрчилсөн буюу өөрчлөхөөр завдаж байна.

Гуч дугаар зүйлд дархан эрх буюу шүүхийн харъяаллын давуу эрх болон үр нөлөөтэй байдлаар хууль сахиулах боломжийн хооронд зохих тэнцвэрийг тогтоох арга замыг тооцож үзэхийг санал болгосон. Бүх хэлбэрийн дархан эрх буюу шүүхийн харъяаллын давуу эрх нь тодорхой этгээд буюу тодорхой этгээдийн бүлэгт эрүүгийн хуулийн заалтууд буюу эрүүгийн хуулийн үйл хэрэг үйлчлэхгүй байх гэсэн нэг ижил санаан дээр үндэслэдэг. Оролцогч улс эдгээр хуулийг хуулийн өмнө бүгд эрх тэгш байх зарчмаас хазайсан явдал гэж үзэх бөгөөд энэ дархан эрх нь ноцтой үндэслэлтэй байвал зохино.

Энэхүү зүйлд дархан эрх буюу шүүхийн харъяаллын давуу эрхийн “чиг үүргийн” ойлголтыг баримталж байгааг оролцогч улс анхаарч үзэх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл дархан эрх буюу шүүхийн харъяаллын давуу эрх нь тодорхой албан тушаалтанд биш харин тодорхой албан тушаалд хамаарна. Иймээс оролцогч улс тэнцвэртэй бөгөөд хууль ёсны дархан эрх болон бусад давуу эрхийг зөвхөн төрийн үйл ажиллагааг хэвийн явуулах байдлыг хамгаалахад зайлшгүй шаардлагатай хэрэгсэл болгож ашиглах нь зүйтэй. Оролцогч улс бүр дархан эрх буюу шүүхийн харъяаллын давуу эрх болон үр ашигтайгаар мөрдөн байцаах, яллах боломжийн хооронд зохих тэнцвэрийг тогтоохын тулд дараах шаардлагыг харгалзан үзвэл зохино:

- Оролцогч улс дархан эрх буюу шүүхийн харъяаллын давуу эрх эдэлж буй этгээдүүдийн жагсаалтанд анхаарал хандуулж, давуу эрх олгосон төрийн албан тушаал болон төрийн чиг үүргийн жагсаалтанд тодорхой хязгаарлалт тавих шаардлагатай эсэхийг шийднэ. Ер нь дархан эрх буюу шүүхийн харъяаллын давуу эрх нь албан тушаалтанд тухайн үйлдлийн хууль ёсны үр дагавраас нь айлгүйгээр тодорхой үйлдлийг хийх боломж олгох зорилго агуулдаг гэдгийг тооцож үзэх хэрэгтэй юм. Энэ тохиолдолд оролцогч улс хувийн буюу албан тушаалын эрх мэдлийн хүрээнд үйлдсэн авлига болон бусад гэмт хэргийн үйлдэлд үл хамаарах хязгаарлагдмал дархан эрх олгодог тэдгээр улсын туршлагыг нэвтрүүлэх асуудлыг бодолцож үзэхийг хүсч байж болно. Ийнхүү оролцогч улс дархан эрх буюу шүүхийн харъяаллын давуу эрх олгох тухай дүрэм нэвтрүүлэхдээ дархан эрх буюу шүүхийн харъяаллын давуу эрх олгох нь төрийн тухайн албан тушаал, чиг үүргийг гүйцэтгэхэд зайлшгүй чухал эсэхийг тооцож үзэх хэрэгтэй юм.
- Дархан эрх буюу давуу эрхийн чиг үүргийн ойлголтын дагуу, оролцогч улс зөвхөн албан тушаалтны чиг үүргээ гүйцэтгэхэд гаргасан үйлдлийг харгалзан мөн зөвхөн тухайн албан тушаалтан хуулийн дагуу тухайн албан тушаалаар олгогдсон үүрэг

хариуцлагаа биелүүлж байх нөхцөлд дархан эрх буюу шүүхийн харъяаллын давуу эрхийг хэрэглэх явдлыг анхаарч үзвэл зохино. Үүнээс гадна дархан эрх буюу шүүхийн харъяаллын давуу эрх зөвхөн албан тушаалтны үүргээ гүйцэтгэж байх хугацаанд үйлчилж байх учиртай. Иймээс дархан эрх буюу шүүхийн харъяаллын давуу эрх нь тухайн албан тушаалтны албан тушаалаа орхисон буюу төрийн алба хашихаа больсны дараах үйлдэхүй буюу эс үйлдэхүйд үйлчлэхгүй. Төрийн албан тушаал хашиж байсан этгээд төрийн алба хашихаа больсны дараа бий болсон тэрхүү шүүх ажиллагаан дахь давуу эрхээ эдэлж байгаа үед дархан эрх буюу шүүхийн харъяаллын давуу эрх нь хууль сахиулах шаардлагатай зохих тэнцвэрийг хадгалахгүй. Төрийн алба хашиж байх хугацаандаа үйлдсэн үйлдэлтэй холбоотой шүүх ажиллагаанд ч тухайн этгээд бусад иргэнтэй адил тэнцүү эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

- Оролцогч улс дархан эрхийг хэзээ, хэрхэн халах тухай журам болон болзол нөхцлийг тогтоосон хууль тогтоомж буюу хууль ёсны удирдамж боловсруулах асуудлыг харгалзан үзвэл зохино. Ийм хууль тогтоомж буюу удирдамжтай холбоотойгоор оролцогч улс дараах төлөв байдал болон загваруудыг анхаарч үзэх хэрэгтэй:
 - Хууль тогтоомж болон удирдамж нь дархан эрхийг түдгэлзүүлэх үндэслэлийг тодорхой заах бөгөөд улс төрийн сэдэл үзэмжээр шийдэх явдал боломжгүй юм. Энэ хуульд авлигын хэрэг хариуцсан хороо нь дархан эрх буюу давуу эрхийг халах хууль ёсны шалтгааныг тогтоох байдлаар тусгаж өгөхийг оролцогч улс хүсч болно.
 - Дархан эрхийг халах эсэхийг тогтоох журам нь сэжигтний зүгээс мөрдөн байцаах ажиллагаанаас мултрах буюу саад хийхээс сэргийлж шуурхай шийдвэр гаргахад боломж олгосон байх хэрэгтэйг оролцогч улс анхаарч үзнэ.
 - Оролцогч улс дархан эрхийг халах шийдвэрийг гаргах явцад сонирхлын зөрчил үүсэх явдлаас зайлсхийнэ.
 - Дархан эрх буюу шүүхийн харъяаллын давуу эрхийг халах боломжгүй нөхцөл байдал үүсвэл оролцогч улс тухайн улсад үйлдэгдсэн тодорхой гэмт хэрэгтэй холбоотойгоор хувь этгээдэд тодорхой түвшний эрүүгийн буюу иргэний арга хэмжээ авч чадах гадаад улсын шүүхийн байгууллагатай холбоо барих асуудлыг⁷ бодолцож үзэж болох юм.
- Оролцогч улс албан тушаал хаших хугацаа төгсгөл болсны дараагаар яллах, шүүхийн шийдвэр гаргах боломж олгох талаар зохих дүрмийг авч үзэх хэрэгтэй. Албан тушаал хаших үеийн хууль ёсны хязгаарлалт тогтоосон хугацааг түдгэлзүүлэх асуудлыг мөн тооцох хэрэгтэй. Албан тушаал хаших хугацаанд дархан эрхийг халах тухай заалтгүй оролцогч улс 30 дугаар зүйлийн дагуу шаардсан тэнцвэрийг тогтоох зохих арга замыг авч үзвэл зохино.

- Эцэст нь оролцогч улс тодорхой этгээдэд олгосон дархан эрх буюу шүүхийн харъяаллын давуу эрх нь бусад этгээдийн оролцсон хэргийг яллах болон тухайн хэрэгт шүүхийн шийдвэр гаргах ажиллагаанд үйлчлэхгүй байх асуудлыг анхаарч үзэх хэрэгтэй.

II.3. Үзэмжээрээ шийдвэрлэх хууль зүйн эрх мэдэл

Гуч дугаар зүйлд оролцогч улс үзэмжээрээ шийдвэрлэх эрх мэдлийг хэрэгжүүлж байгаа тохиолдол болгонд авлигын хэрэг үйлдэх явдлыг таслан зогсоох хэрэгцээг харгалзан хууль сахиулах арга хэмжээний үр ашгийг аль болох дээшлүүлэх явдлыг анхаарч үзнэ. Иймээс удирдамж болгох тэрхүү зарчим нь бодлого боловсруулах болон хууль тогтоомжийн төсөл санаачлахад оролцогч этгээд төрийн бодит шаардлагыг аль болох харгалзах байдлаар үр ашигтай, үр нөлөөтэй бөгөөд ил тод механизмыг нэвтрүүлэхийг чармайх явдлыг тусгасан байвал зохино. Оролцогч улс хууль сахиулах эрх бүхий байгууллагадаа авилгын хэргийг мөрдөн шалгах болон яллах нь хэвийн үзэгдэл харин шүүх тухайн хэргийг хэрэгсэхгүй болгох нь онцгой явдал бөгөөд энэ нь тодорхой үндэслэлтэй байвал зохихыг зөвлөснөөр гэмт хэргийг таслан зогсоох явдлын үр нөлөөг нэмэгдүүлж болох юм. Гэхдээ оролцогч улс хууль тогтоох байгууллагын нөөцийг тооцож үзэх хэрэгтэй. Нөөцийн хувьд хязгаарлагдмал хөгжиж буй улс орнууд томоохон хэргүүд дээр тухайлбал төрийн өндөр албан тушаалтны оролцсон тийм хэргүүд дээр төвлөрсөн.

Зарим улсад хууль тогтоомж буюу удирдамж нь прокурорын өөрийн үзэмжээрээ шийдэх эрх мэдлээ хэрэгжүүлэх байдлыг тодорхой заасан байдаг. Ийм шийдвэр гаргах талаар мэдээлэл өгч буй хууль тогтоомж буюу удирдамж нь олон нийтэд хүртээмжтэй байвал зохино. Эдгээр хууль тогтоомж буюу удирдамжийн зарим нь тухайн яллах ажиллагаа нь “нийгмийн ашиг сонирхол”-д нийцэхгүй байна гэж үзвэл яллахаас татгалзах боломжийг прокурорт олгох тухай заалтыг багтаасан байдаг. Ийм тохиолдолд оролцогч улс ерөнхий болзол нөхцөл тулгахаас зайлсхийж болно. Эсвэл иймэрхүү өргөн хүрээний үзэмжээрээ шийдэх явдлыг багтааж өгөхийг хүсвэл ийм шийдвэрт хүрэхэд ямар хүчин зүйлсийг харгалзан үзсэнийг тодорхой байлгах зорилгоор олон нийтэд нээлттэй байдлаар тогтоосон шалгуурын дагуу энэхүү эрх мэдлийг олгож байвал зохино. Тэгэхээр оролцогч улс дотоод болон гадаад хяналтыг тавих боломж олгох байдлаар хэргийг хэрэгсэхгүйболгох тухай шийдвэрээ прокурор өөрөө бүртгэж болно. Цаашлаад оролцогч улс гэмт хэргийн талаар гомдол мэдүүлж, хэргийг шалгах явдлыг эхлүүлсэн этгээдэд мөрдөн шалгах ажиллагааны үр дүн болон яллах ажиллагааг явуулах эсэх талаар шийдвэрийг прокурорын зүгээс мэдээлж байхыг шаардах замаар ил тод байдал, хяналт болон тэнцвэрийг баталгаажуулах сайн арга гэж үзэж болно. Оролцогч улс ийм шийдвэрийг хамгаалах хэд хэдэн загварт анхаарал хандуулах хэрэгтэй.

- Оролцогч улс ялангуяа улс төрийн сэдэлтэй хэрэгтэй холбоотойгоор Ерөнхий прокурор, Хууль зүйн яамын сайд зэрэг өндөр албан тушаалтан нь зохисгүй нөлөөлөлд автах явдал гарсан улсуудын туршлагыг харгалзан үзэхийг хүсч байж болно. Үүнээс гадна оролцогч улс мөрдөн шалгах болон яллах ажиллагаа эхлэхээс өмнө эрх бүхий дээд байгууллагад мэдээлэх шаардлагыг тавихгүй байх нь прокурорын шийдвэрт зохисгүй байдлаар нөлөөлөх явдлыг бий болгодог гэдгийг анхаарч үзэх хэрэгтэй. Ийнхүү оролцогч улс мөрдөн шалгах болон шүүхийн шийдвэр гаргахад ийм

шаардлага, болзол нөхцөл тавих хэрэгцээ байгаа эсэхийг үнэлж үзэх эсвэл ийм эрх бүхий байгууллагыг хуулиар тогтоогоогүй тохиолдолд эдгээр бүх шаардлага, болзлыг хүчингүй болгох асуудлыг анхаарч үзэх нь чухал.

- Ямар нэг шалтгаанаар тодорхой хэргийн талаар дээд байгууллагаас заавар ирүүлсэн байхыг шаарддаг улс орон ил тод байх, тал татахгүй байх явдлыг зайлшгүй нөхцөл болгож болох юм. Ил тод, тал татахгүй байдлыг хангахын тулд оролцогч улс тухайн хэргийн талаар заавар нь хяналт тавьж болохуйцаар, бичгээр үйлдэгдсэн байхыг шаардаж болно. Түүнчлэн оролцогч улс ийм шийдвэрт гадаад хяналт тавих боломж олгох асуудлыг харгалзан үзэх нь чухал. Эдгээрийг харгалзан оролцогч улс олон нийтэд ийм мэдээллийг олж авах боломжийг бий болгож, хохирогч этгээдийн эсвэл тухайн гэмт хэргийг мэдээлсэн байгууллага, хувь этгээдийн гомдолд шүүхийн хяналт тавихыг зөвшөөрөх хэрэгтэй.

II.4. Шүүх хуралдаан буюу давж заалдахаас өмнө түр суллах тухай шийдвэр

Энэ зүйлд шүүгдэгчийн шүүх хуралдаан буюу давж заалдахаас өмнө эрх чөлөөтэй байх тухай зохих нөхцлийг заасан байхыг оролцогч улсаас хүссэн. Оролцогч улс хуулийн хүрээнд батлан даалтаар суллах тухай заалтыг шүүгдэгчийг дараагийн шүүх хуралдаанд байлгах явдлыг хангах хэрэгсэл гэж үзвэл зохино. Гэхдээ оролцогч улс ялангуяа хууль сахиулах байгууллагын зүгээс гэмт хэргээс олсон орлого болон гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэсэн хэрэгслийг битүүмжлэх, хураах боломжгүй тохиолдолд, авлигын хэрэгт холбогдсон этгээдэд тухайн улсаас оргон зайлах боломж олгох санхүүгийн ихээхэн нөөц байж болохыг харгалзан үзэх хэрэгтэй. Түүнчлэн мөрдөн шалгах ажиллагааны үеэр буюу шүүх хуралдаан эхлэхээс өмнө түр суллагдсан үедээ шүүгдэгчийн зүгээс гэрчийг сүрдүүлэх болон нотлон баримт цуглуулах явцад хөндлөнгөөс саад үүсгэх болон шүүх хурал явуулахад саад болох магадлалыг тооцож үзвэл зохино. Шүүх хурлаас хувь этгээдийн эрх чөлөө болон нүүн шилжих эрхийг хязгаарлах зохих нөхцлийг тавьж болох юм. Батлан даалтаар суллагдах болзол нөхцөлд хууль сахиулах байгууллагад тогтмол мэдээлж байх, паспорт зэрэг зорчиход шаардлагатай холбогдох баримт бичгээ хураалгах (гэхдээ зарим хүн нэгээс олон паспорт эзэмшиж байж болохыг харгалзан бүх паспорт болон аялахад шаардлагатай бүх бичиг баримтыг хурааж авах нь ухаалаг арга зам байж болно) болон нэр заасан гэрчтэй холбоо тогтоохгүй байх. Ноцтой хэрэг мөрдөж буй тохиолдолд төстэй бусад хэргийн нэгэн адилаар шүүгдэгчийг шүүх хуралдаан хүртэл хорих эрхээ оролцогч улс өөртөө хадгалах хэрэгтэй.

II.5. Хугацаанаас нь өмнө суллах буюу тэнсэн суллах

Конвенцийн 30 дугаар зүйлийн 5 дугаар заалтад оролцогч улс бүр гэмт хэрэгт шийтгэгдсэн этгээдийг хугацаанаас нь өмнө суллах буюу тэнсэн суллах боломжийг авч үзэхдээ тухайн гэмт хэргийн ноцтой байдлыг харгалзан үзнэ гэж заасан байдаг.

Хугацаанаас нь өмнө суллах буюу тэнсэн суллахдаа ял шийтгэлийн нийгмийн нөлөө болон хувь этгээдтэй зөрчил үүсгэхээс зайлсхийх зорилгоор тухайн гэмт хэргийн ноцтой байдлыг харгалзан үзэх шаардлагатай юм.

Оролцогч олон улс орон гэмт хэрэгт шийтгэгдсэн этгээдийг хугацаанаас нь өмнө суллах буюу тэнсэн суллах боломжоор хангасан байхад зарим нь тэнсэн суллах тогтолцооноос татгалзаж, “ял оноох” буюу урьдаас нарийн тогтоосон ял ногдуулах тогтолцоог илүүд үздэг. Ялангуяа иргэд зөөлрүүлж болох шийтгэлийн уг үйлдлийг дахин хийлгэхгүй байдал болон үр нөлөөтэй байдалд эргэлзэж буй тохиолдолд “ялоноох” нь хууль болон хууль сахиулах явдалд итгэх иргэдийн итгэлийг олж авах нэг сонголт болж болох юм. Гэхдээ энэ сонголтыг хийсэн тохиолдолд хүний эрхийг хүндэтгэх хэрэгцээ болон гэмт хэрэгт шийтгэгдсэн этгээдийг тэнсэн суллах сонголтгүй тогтолцооны байж болох сөрөг үр дагаврыг тооцож үзвэл зохино.

II.6. Албан тушаалаас чөлөөлөх, түдгэлзүүлэх буюу өөр албан тушаалд томилох

Оролцогч улс энэ заалтыг аюултай (тодорхой албан тушаалын төлөө өрсөлдөхөд нь саад хийх зорилгоор авлигын хэрэгт ташаа байдлаар буруутгагдсан улс төрийн өрсөлдөгч г.м.) эсвэл “хэт үнэнч” гэж тооцсон хүнийхээ хөдөлгөөнийг хориглох үр нөлөө бүхий хэрэгсэл болгон ашиглахаас зайлсхийвэл зохино. Ийм явдал харамсалтай нь элбэг тохиолддог бөгөөд бодлого боловсруулагчид энэ тухай мэдлэгтэй байж, анхаарч үзэх шаардлагатай.

Албан тушаалаас шууд түдгэлзүүлэх тухай заалтыг хөдөлмөрийн гэрээнд оруулахыг санал болгосон тохиолдолд ч энэ заалтыг таамгаар шийтгэл ногдуулах хэрэгсэл болгон ашиглахаас зайлсхийж тухайн сэжиг хангалттай нотлогдсон байхыг шаардах зэргээр тодорхой баталгаа олгосон бол энэ нь эргээд гай болох аюултай гэдгийг анхаарвал зохино.

Оролцогч улс авлигын гэмт хэргийг үйлдсэн гэж яллагдаж буй төрийн албан тушаалтныг албан тушаалаас чөлөөлөх, түдгэлзүүлэх буюу өөр албан тушаалд томилох журмыг тогтоох асуудлыг анхаарч үзнэ. Ийм арга хэмжээ нь мөрдөн байцаалт эхлүүлэхэд нөлөөлөхөөс гадна мөрдөн байцаах хугацааны туршид хүчин төгөлдөр байх учиртай. Түүнчлэн энэ арга хэмжээ нь сэжигтний зүгээс гэрчид нөлөөлөх буюу түүнийг сүрдүүлэх мөн нотлох баримтыг өөрчлөх, засварлах замаар мөрдөн байцаах ажиллагаанд саад болохоос сэргийлэхэд үйлчилж байвал зохино. Үүнээс гадна энэ нь мөрдөн байцаах ажиллагаанд саад болох байдлаар “esprit de corps” гэсэн ойлголтыг ташаа ойлгох явдлаас зохих байдлаар сэргийлсэн байх учиртай. Энэ зүйлд санал болгосон арга хэмжээг улс төрийн сэдлээр хэрэглэхгүй байхаас гадна төрийн тухайн албан тушаалтанд нотлогдоогүй бол гэм буруугүйд тооцох зарчмыг хүндэтгэн үзвэл зохино.

II.7. Эрх хасах

Конвенцийн 30 дугаар зүйлийн 7 дугаар хэсэгт төрийн байгууллага болон төрийн өмчит буюу төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжид алба хаших эрхийг хасах журмыг тогтоохыг оролцогч улс бүрт үүрэг болгосон байна. Оролцогч улс төрийн албанд итгэл болон шударга байдал зайлшгүй шаардлагатай бөгөөд энэ арга хэмжээ нь зохих нэмэлт шийтгэл гэж үзэх хэрэгтэй. Оролцогч улс энэхүү арга хэмжээ нь төрийн бусад албан тушаалтан болон олон нийтэд авлигатай тэмцэх тал дээр эрс шийдэмгий байгаагаар харуулан цаашид гарч болзошгүй авлигач үйлдлийг таслан зогсоож, авлигаас сэргийлэх үр нөлөөтэй хэрэгсэл болохыг санаж байвал зохино. Нөгөөтэйгүүр ийм арга хэмжээг авч буй улс орон эрх хасах арга хэмжээ нь түр эсвэл

тогтмол байдлаар хэрэгжих эсэх талаар нухацтай бодож үзвэл зохино. Энэ шийдвэрийг гаргахдаа хувь этгээдийн холбогдсон гэмт хэргийн ноцтой байдлыг харгалзан үзэх хэрэгтэй.

Оролцогч улс аль байгууллагыг “төрийн” гэж тодорхойлохыг заасан үндэсний хууль дүрмийнхээ дагуу “төрийн өмчит буюу төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж” гэсэн томъёог хэрэглэх асуудлыг тооцож үзвэл зохино.

II.8. Нийгэмшүүлэх

Дээр дурдсанчлан конвенцийн 30 дугаар зүйлийн 10 дугаар хэсэгт тухайн үйлдэлд тохирсон эрүүгийн болон нэмэлт шийтгэлийг ногдуулах хэрэгтэй гэж заасан байгаа. Гэмт хэрэгт яллагдаж буй этгээдийг нийгэмд дахин нэгдэн орохыг дэмжих хэрэгцээ нь тухайн үйлдэлд тохирсон байдлаар ял шийтгэл оноох зарчмаас урган гарч байгаа юм.

Оролцогч улс энэхүү заалтыг ял шийтгэл болон нийгэмд дахин нэгдэн орох боломжийн хоорондох тэнцвэрийг хангах тухай энэ зүйлийн гол санааг тусгасан гэдгийг анхаарч үзвэл зохино. Үүнээс гадна нийгэмд дахин нэгдэн орох тухай заалт нь төрийн албан тушаалтны чадварыг нийтийн ашиг тусын тулд ашиглах зорилгоор тодорхой байдлаар урьдаас зөвшөөрсөн олон нийтийн буюу сайн дурын ажил зэрэг нийгэмд нэгдэн орох нөхцөл бүхий ял шийтгэлийг тодорхой хяналтын дор суллах тухай заалт дээрээ нэмэх байдлаар нэвтрүүлж болох тухай ял шийтгэлийн өөр нэг загварыг тооцож үзэхэд оролцогч улсыг чиглүүлж байгааг харгалзан үзэх хэрэгтэй.

31 дүгээр зүйл: Битүүмжлэх, түр хураах, хураах

1. Оролцогч улс бүр дотоодын эрх зүйн тогтолцооныхоо хүрээнд дараахь зүйлийг хураан авах боломжийг аль болох өргөн хэмжээнд бий болоход шаардлагатай арга хэмжээг авна:

(a) энэхүү конвенциор тодорхойлсон гэмт үйлдлээс олсон орлого буюу тийм орлогын үнийн дүнтэй тохирох эд хөрөнгө;

(b) энэхүү конвенциор тодорхойлсон гэмт үйлдэлд ашигласан эсхүл ашиглах зорилготой эд хөрөнгө, тоног төхөөрөмж буюу бусад хэрэгсэл.

2. Оролцогч улс бүр энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан аливаа зүйлийг хураан авах зорилгоор таньж олох, мөрдөх, битүүмжлэх буюу түр хураах боломжтой болоход шаардлагатай арга хэмжээг авна.

3. Энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт дурдсан битүүмжилсэн, түр хураасан, хураан авсан эд хөрөнгийг эрх бүхий байгууллагаас захиран зарцуулахад шаардлагатай хууль тогтоох болон бусад арга хэмжээг оролцогч улс бүр дотоодын хууль тогтоомждоон ийцүүлэн авна.

4. Гэмт үйлдлээс олсон ийм орлогыг бүхэлд нь буюу хэсэгчлэн өөр эд хөрөнгөд шилжүүлсэн буюу өөрчлөн хувиргасан бол тэрхүү эд хөрөнгөд энэ зүйлд дурдсан адил арга хэмжээг авна.

5. Гэмт үйлдлээс олсон ийм орлогыг хууль ёсны эх үүсвэрээс олж авсан эд хөрөнгөтэй хольж нийлүүлсэн бол өмч хөрөнгийг битүүмжлэх, түр хураахтай холбоотой аливаа эрхийг үл хөндөн орлогын ийнхүү холилдсон хэсгийн үнийн дүнгийн хэмжээгээр хурааж авна.

6. Гэмт үйлдлээс олсон ийм орлогын шилжүүлж буюу өөрчлөн хувиргаж бий болгосон эд хөрөнгө эсхүл гэмт үйлдлээс олсон орлогын холилдсон эд хөрөнгөнөөс олсон орлогын ашиг орлого буюу бусад ашиг хонжоонд мөн энэ зүйлд заасан арга хэмжээг гэмт үйлдлээс олсон орлоготой адил хэлбэрээр болон адил хэмжээгээр авна.

7. Энэхүү конвенцийн энэ зүйл болон 55 дугаар зүйлийн зорилгоор оролцогч улс бүр банк, санхүү буюу худалдааны тэмдэглэлийг гаргаж өгөх буюу түр хураах шийдвэр гаргах эрхийг өөрийн шүүх буюу эрх бүхий бусад байгууллагад олгоно. Оролцогч улс банкны нууц гэсэн үндэслэлээр энэ заалтыг хэрэгжүүлэхээс зайлсхийх ёсгүй.

8. Оролцогч улсууд гэмт үйлдлээс олсон гэх хураан авахуйц орлого буюу бусад эд хөрөнгө хууль ёсны гарал үүсэлтэйг нотлохыг сэжигтэн этгээдээс шаардах боломжийг судлах бөгөөд ийм шаардлага нь тухайн орны дотоодын хуулийн тулгуур зарчмууд болон шүүхийн ба бусад ажиллагааны мөн чанартай нийцсэн байна.

9. Энэ зүйлд заасныг шударга гуравдагч талын эрхийг хөндөхөөр тайлбарлаж болохгүй.

10. Энэ зүйлийн аль ч заалт энэ зүйлд дурдсан арга хэмжээг оролцогч улсын дотоодын хуулийн заалтын дагуу, түүнд нийцүүлэн тодорхойлж, хэрэгжүүлэх зарчимд сөргөөр нөлөөлөх ёсгүй.

I. Ерөнхий тойм

Энэхүү конвенцийн 31 дүгээр зүйл нь 23 дугаар зүйлээ гүйцэлдүүлж өгч байгаа юм. 23 дугаар зүйлд хөрөнгө битүүмжлэх, түр хураах, хураах асуудлыг “хэн” хариуцахыг өгүүлсэн бол 31 дүгээр зүйлд “юуг”, “хэрхэн” битүүмжлэх, түр хураах, хураахыг авч үзнэ. Хураах –буюу конвенцийн 2 (g) хэсэгт тодорхойлсноор шүүх буюу эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийн дагуу эд хөрөнгийг бүрмөсөн авах - нь зөрчил гаргасан этгээдээс буруу аргаар олсон орлогыг салган авах хууль ёсны чухал арга хэрэгсэл юм. Энэхүү конвенцийн хөхиүлэн дэмжиж буй тэрхүү дэглэм нь конвенцийн 2 (e)-д “гэмт хэрэг үйлдэх замаар шууд буюу шууд бусаар олсон, эсхүл авсан аливаа эд хөрөнгө” гэж тодорхойлсон “гэмт хэргээс олсон орлого”-ыг хураах ойлголтын хүрээнд хэрэгжинэ.

Гэмт хэргээс олсон орлогыг хураах нь ихэнх хуулийн тогтолцоонд хэдийнэ тодорхойлж заасан байдаг бусад төрлийн хураах ажиллагаа буюу гэмт хэргийн хэрэгслийг хураах болон гэмт хэргийг объектийг хураахаас ялгаатай байх учиртай. Хэдий эдгээр гурван төрлийн хураах ажиллагааны аль альнийг нэвтрүүлэхийг 31 (1) хэсэгт шаардсан ч гэмт хэргээс олсон орлогыг

хураах нь энэ шинэ дэглэмийн гол цөм нь юм. 31 дүгээр зүйлийн 4, 5 ба 6 дугаар хэсэгт гэмт хэргээс олсон орлогыг хураах ажиллагааны хамрах хамгийн бага хүрээг тогтоож өгсөн байна. Эдгээрт нэмэлт арга хэмжээ болгож, 8 дугаар зүйлд гэмт хэргээс олсон орлогын эх үүсвэрийг тогтоох явдлыг хөнгөвчлөх зорилгоор нотлох шаардлагыг хүчингүй болгох асуудлыг авч үзэхийг оролцогч улсаас хүсчээ. Ер нь хэд хэдэн орон нотлох шаардлагыг хэрэгсэхгүй болгох арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа. Гэхдээ энэ ойлголтыг нотлогдоогүй бол буруугүйд тооцох зарчимд шууд хамаарах тэрхүү гэмт хэргийн бүрдүүлэгч элементтэй холбоотой нотлох шаардлагаас ялгаж салгах нь чухал.

Эдгээр хамгийн доод түвшний шаардлагаас үл хамааран дараах асуудлаар энэхүү тогтолцоог нэвтрүүлэх тал дээр оролцогч улсад бодлогын олон сонголт бий:

- “Үнийн дүнд тулгуурласан тогтолцоо”-ны эсрэг “объектод тулгуурласан тогтолцоо”-нд давамгайллыг олгох эсэх;
- Эрүүгийн шийтгэлд тулгуурласан хураах тогтолцоонд нэмэлт болгох байдлаар иргэний шийтгэлд тулгуурласан хураах тогтолцоонд давамгайллыг олгох эсэх;
- “Авлигаас олсон орлогыг хураах”-ыг нөхөн төлүүлэх буюу буцаан өгөх арга хэмжээний оронд эрүүгийн арга хэмжээнд тооцох эсэх, тооцох бол энэ нь ямар нөхцөлтэй байх;
- Хувь этгээдэд хариуцлага тооцох журмын оронд эд хөрөнгөнд тооцох арга хэмжээг нэвтрүүлэх буюу онцлох эсэх;

Авлигын хэрэгт холбогдогч этгээдээс хууль бус үйл ажиллагаанаас олсон орлогыг нь хураах авах бодлогын туслах хүчин зүйлсээс хамгийн чухал нь дараа нь хураан авах зорилгоор эд хөрөнгийг түр хураах, битүүмжлэх буюу бусад байдлаар тухайн эд хөрөнгийн хөдөлгөөнийг хориглох урьдчилсан арга хэмжээг авах тэр тогтолцоо юм. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт ийм арга хэмжээ авахыг оролцогч улсаас хүссэн бол 3 дахь хэсэгт шүүх буюу бусад эрх бүхий байгууллагаас цаашид хэрхэхийг шийдэх хүртэл ийм эд хөрөнгийг захирч байх тогтолцоог нэвтрүүлэхийг шаардаж байна.

31 дүгээр зүйлд мөн эд хөрөнгө хураах дэглэмийн хоёр гол бүрэлдэхүүн хэсэг болох олон улсын хамтын ажиллагаа (7 дугаар хэсэг) болон гуравдагч этгээдийн эрх (9 дүгээр хэсэг)-ийн талаар арга хэмжээ авахыг санал болгосон.

II. Хураах хэлбэрүүд

Конвенцийн 31 дүгээр зүйлийн 1 дүгээр хэсэгт дараах 2 төрлийн хураах ажиллагааг явуулахад шаардлагатай арга хэмжээг авахыг хүссэн байна:

- (1) (a) – гэмт хэргээс олсон орлогыг хураах;
- (1) (b) – гэмт хэргийн хэрэгслийг хураах.

(1) (b) нь энэхүү конвенцийн дагуу тогтоосон гэмт хэргийг үйлдэхэд ашигласан, эсхүл ашиглах зорилготой эд хөрөнгө, тоног төхөөрөмж буюу бусад хэрэгсэлд хамаарна.

Гэмт хэргийн хэрэгслийг хураахын цаад зарчим нь эдгээр объектыг нийгэмд хор хөнөөлтэй байдлаар буруугаар ашиглаж ирсэн явдалтай холбоотой. Тиймээс ч оролцогч улс энэ явдал дахин гарахаас сэргийлэх учиртай юм. Гэмт хэрэг үйлдэхэд ашигласан объект нь тухайн гэмт хэргийн өдөөсөн хор хөнөөлтэй үр дагаварт биет байдлаар хамаардаг. Тиймээс гэмт хэрэг үйлдэхэд ашигласан хэрэгслийг хураах нь мөн чанартаа залхаан цээрлүүлэх арга хэмжээнд тооцогдох бөгөөд тухайн гэмт этгээдээс “урвуулан ашигласан” эд хөрөнгийг хураах байдлаар нэмэлт шийтгэл болгож шүүгдэгчид хувь этгээдийнх нь хувиар ногдуулж буй ял шийтгэлд хамаарууна.

Энэ ойлголтод гэмт хэрэг үйлдэхэд –баримт бичиг, үлгэр загвар, програм хангамж зэрэг шууд байдлаар эсвэл хуурамч паспорт зэрэг үйлдлийг хөнгөвчлөх зорилгоор шууд бус байдлаар шаардагдах объект хамаарна. Ийм хэрэглэгдэхүүнийг ихэнхдээ устгадаг. Ийм хэрэглэгдэхүүнийг хураахын цаад зарчим нь урьдчилан сэргийлэх мөн чанартайг харуулж байгаа юм. Эдгээр хэрэглэгдэхүүнийг урвуулан ашиглах магадлал өндөр байдаг учир ийнхүү устгах нь тодорхой ач холбогдолтой. Цаашлаад ийм төрлийн хураах ажиллагаа нь залхаан цээрлүүлэх биш харин тодорхой зүйлийг хамгаалах байдлаар ашиг тусаа өгч болох юм. Тиймээс ч мансууруулагч бодисыг хэрэгтнийг шийтгэх гэж биш харин нийгмийг хамгаалах зорилгоор хураан авдаг.

Гэмт хэргийн хэрэгслийг хураах талаар өгүүлсэн бол харин 1 (a)-д гэмт хэргээс олсон орлогыг хураах арга хэмжээг нэврүүлэхийг оролцогч улсаас хүссэн байна.

Конвенцийн 2 (e) ба (g)-д “гэмт хэргээс олсон орлогыг хураах” гэж “гэмт хэрэг үйлдэх замаар шууд буюу шууд бусаар олсон, эсхүл авсан аливаа эд хөрөнгийг шүүх буюу эрх бүхий бусад байгууллагаас гаргасан шийдвэрийн дагуу бүрмөсөн авах”-ыг хэлнэ гэж заасан байна.

III. Хураах загварууд

Энэ зүйлийн 1 (a) хэсэгт өгүүлсэн эхний сонголт нь хураах ажиллагаа дараах хоёр загварт хамаарна. Үүнд “энэхүү конвенцийн дагуу тогтоосон гэмт хэргээс олсон орлого”-той холбоотой объект хураах ба “тийм орлогын үнийн дүнтэй тохирох эд хөрөнгө”-тэй холбоотой үнийн дүнг хураах орно. Эдгээр нь эд хөрөнгө эзэмших эрхэд хамаарч байгаагаараа ялгагдах юм. Объект хураах гэдэгт эд хөрөнгийг төрд шилжүүлэх асуудал орох бол үнийн дүнг хураах гэдэгт өгсөн эсвэл авсан хэлбэрээс үл хамааран ихэнхдээ гэмт хэргийн үйлдлээс олж авсан зохисгүй давуу байдал буюу ашиг хонжоотой дүйцэх хэмжээний мөнгөн төлбөр ногдуулахыг ойлгоно.

Объект хураах нь гэмт хэрэг болон эд хөрөнгийн хоорондын харилцаанд үндэслэсэн байна. Яг ийм загвар нь гэмт хэргийн хэрэгслийг хураахад хүчин төгөлдөр хэрэгждэг. Үүнтэй холбоотойгоор дараах асуудлуудыг анхаарч үзвэл зохино:

- Объект хураах тогтолцоо нь тухайн эд хөрөнгийн жинхэнэ эзэмшигч нь хэн байхаас үл хамааран хэрэгжих бөгөөд үүнд шударга гуравдагч этгээдийн эрхийг хамгаалах асуудалд анхаарал хандуулах шаардлага гардаг. Энэ тухайд энэ зүйлийн 9 дэх хэсэгт өгүүлсэн.
- Цэвэр объект хураах тогтолцоо нь хураах тухай шийдвэр гартал тухайн хөрөнгийг хэрэглэж эсвэл зарцуулж байсан болон нэгэнт олдохоосоо өнгөрсөн эд хөрөнгийг хураах боломжгүй байх гэсэн сөрөг үр дагаварт хүргэж болох юм.
- Энэ тогтолцоо нь эд хөрөнгөд чиглэсэн мөн чанартай учраас объект хураах ажиллагааг эрүүгийн болон иргэний шийтгэлийн журмын аль алинд нийцүүлж болох талтайгаас гадна зарим улс аливаа гэмт хэргээс олсон орлогыг хураах ажиллагааг залхаан цээрлүүлэх шийтгэлд тооцож байхад зарим нь иргэний шийтгэлийн журамд суурилж, объект хураах загварын хүрээнд хэрэгждэг тул гэмт хэргээс олсон орлогыг хураахыг буцаан олгох шинжтэй шийтгэлд тооцох хэрэгтэй гэж үзэж байна.

Эцэст нь объект хураах тогтолцоог нэвтрүүлэхэд гэмт хэрэгтэн олсон орлогоо компани буюу хууль ёсны байгууллага дотор нуун дарагдуулсан тухай хэргийг хэрхэн шийдвэрлэхийг авч үзэх хэрэгтэй. Тэрхүү орлого тухайн гэмт хэрэгтний эзэмшилд байхаа нэгэнт больсон болохоор энэ хэргийг эрүүгийн хуулийн журмаар шийдэх эсвэл иргэний хуулийн журмаар шийдэх эсэх нь компанийн эрүүгийн хариуцлага маш бага эсвэл огтоос байхгүй тэр хуулийн тогтолцоонд маш чухал асуудал болж хувирдаг.

Энэ бэрхшээлийг үнийн дүнг хураах тогтолцоог нэвтрүүлэх замаар шийдэж болох юм. Эд хөрөнгө болон гэмт хэргийн харилцаанд үндэслэсэн объект хураах тогтолцооноос ялгаатайгаар гэмт хэргээс олсон орлогын үнийг дүнг хураах тогтолцоо нь “гэмт хэргээс ашиг олох ёсгүй” гэсэн санаанд тулгуурладаг билээ. Тиймээс эд хөрөнгө шилжүүлэх тухай энд яригдахгүй, харин энэ тогтолцоонд тухайн гэмт хэргээс олсон орлогын үнийн дүнтэй тэнцэх мөнгөн торгуулийг ногдуулах шийдвэр гаргадаг.

Юун түрүүнд үнийн дүнг хураах тогтолцоо нь гэмт хэргийн үйлдэлд шууд холбоотой мөнгө буюу хөрөнгөөс илүүтэйгээр гэмт хэргээс олж авсан мөнгө буюу хөрөнгөнд үйлчилнэ. Тиймээс гэмт хэргээс олсон хөрөнгийг яг олж тогтоох шаардлага үүсэхгүй харин гэмт хэргээс олж авсан орлогын үнийн дүнг тогтоож, гэмт этгээдийн эзэмшдэг эсвэл түүний мэдэлд харьяалагддаг аливаа боломжит хөрөнгөөс энэ үнийн дүнг хурааж авах хэрэгтэй болдог.

Энэ тогтолцооны объект хураах тогтолцооноос ялгарах өөр нэг чухал ялгаа нь үнийн дүнг хураахдаа тогтолцоонд шууд буюу шууд бус орлого эсвэл хууль ёсны буюу хууль ёсны бус эд хөрөнгөтэй холилдсон орлогод санаа зовох шаардлага гардаггүй. Хурааж авах үнийн дүнг тогтоосны дараагаар тухайн эд хөрөнгийн эх үүсвэрийн асуудал чухал байхаа болино.

Үүнээс гадна үнийн дүнг хураах тогтолцоо –*in personam* хувь этгээдэд үйлчлэх байдлаар- тухайн гэмт хэрэгтний эзэмшдэг эд хөрөнгөд л үйлчилнэ, гэмт хэргийн дараагаар тухайн эд хөрөнгийг эзэмших болсон шударга гуравдагч этгээдийн эрхийг огт хөндөхгүй. Мэдээж хэрэг энэ тогтолцооны илэрхий сөрөг тал гэвэл гэмт хэрэгтэн бүх хөрөнгөө өөр хувь этгээд буюу

хуулийн этгээдэд шилжүүлэн өөрийн нэр дээр огт хөрөнгөгүй болсон байх тохиолдлыг дурдаж болно. Гэхдээ ийм хөрөнгийг олж авсан этгээд мөнгө угаах гэмт хэрэг үйлдсэн байж таарна, иймээс энэ орлогыг 23 дугаар зүйлд дурдсны дагуу хураавал зохино гэсэн байр суурь дээр санал зөрөөтэй байж болох юм. Хэрэв ингэж үзвэл үнийн дүнд суурилсан тогтолцоонд энэ эд хөрөнгийг ч мөн хурааж болно.

Зарим улс үнийн дүнг хураах тогтолцоонд давамгайллыг олгосон бол иргэний хууль бүхий эрх зүйн тогтолцоотой зарим улс үнийн дүнг хураах тогтолцоог объект хураах тогтолцоонд хавсарга болгон, туслах чанартай хэрэглэж байна. Оролцогч улс энэ хоёр тогтолцооны аль алиныг хэлэлцэн үзэж, тухайн нөхцөлд илүү тохиромжтой байдлаар сонголт хийхээр аль алиныг нь хэрэглэж болох юм.

IV. Юуг гэмт үйлдлээс олсон орлогод тооцож хураах тухай

31 дүгээр зүйлийн 4, 5 ба 6 дугаар хэсэгт энэ зүйлд заасныг хэрэгжүүлэх арга хэмжээний хамгийн бага хамрах хүрээг заасан байгаа.

4 дүгээр хэсэг

Энэ нь гэмт хэргийн орлогыг өөр эд хөрөнгөд шилжүүлсэн буюу өөрчлөн хувиргасантай холбоотой. Энэ тохиолдолд шууд орлогын оронд шилжүүлсэн буюу өөрчлөн хувиргасан эд хөрөнгийг хурааж авахыг оролцогч улсаас хүссэн байна.

Гэмт хэрэгтэн ийм эд хөрөнгөтэй холбоотой мөрдөн шалгах ажиллагаанд саад учруулах зорилгоор гэмт хэргээс олсон анхдагч орлогоосоо аль болох түргэн салж авахыг чармайх болно гэдгийг бодолцож үзвэл, байж болох *bona fide-шударга* гуравдагч этгээдтэй зөрчил үүсэхээс зайлсхийх мөн мөрдөн шалгах болон яллах ажиллагааг хөнгөвчлөх зорилгоор объектод тулгуурласан хураах загварыг хэрэглэх байгааг нь маш чухал. Энэ заалт үнийн дүнд тулгуурласан хураах загвартай адил гэмт хэрэгтэнд хууль бус аргаар олсон хөрөнгөөр хөрөнгөжих боломж олгохгүй байх гэсэн зарчимтай.

Энэ заалт нь “Бохирдсон хөрөнгө” гэж нэрлэгддэг зарчмыг дагадаг. Энэ зарчмаар бохирдсон хөрөнгийг “цэвэр хөрөнгө”-өөр сольсон ч нэгэнт л бохирдсон хөрөнгөөр сольсон тул тэр “цэвэр” хөрөнгө нь ч бохирдсонд тооцогддог. Үүнтэй холбоотойгоор эд хөрөнгийг шударгаар хүлээн авах тухай асуудал үүсдэг бөгөөд улс орнууд шилжүүлэх, хүлээн авах болон өөрчилснөөс үл хамааран “бохир” хөрөнгийн байдалд хууль тогтоомжийн гол анхаарлыг хандуулах шаардлага бий болоод байна.

5 дугаар хэсэг

Энэ нь гэмт хэргээс олсон орлогыг хууль ёсны эх үүсвэрээс олж авсан эд хөрөнгөтэй хольсон асуудалтай холбоотой. Энд уг орлогын ийнхүү холилдсон хэсгийн үнийн дүнгийн хэмжээгээр хураахыг оролцогч улсаас хүссэн байна.

Дээр дурдсанчлан хоёр тохиолдлын аль алинд нь объект хураах тогтолцооны хүрээнд ажиллагаа явуулахад бэрхшээлтэй нүүр тулж байгаа бөгөөд гол нь гэмт хэргээс олсон хөрөнгийг тогтоох шаардлага үүсч байгаа юм. Харин үнийн дүнг хураах тогтолцоон дээр ямар нэг асуудал үүсэхгүй.

6 дугаар хэсэг

Энд оролцогч улс гэмт хэргээс олсон зөвхөн анхдагч орлого бус хоёрдагч орлогыг хураахад анхаарал хандуулахыг хүссэн байна. Анхдагч орлого гэж 100,000 долларын хахууль зэрэг гэмт хэрэг үйлдэх байдлаар шууд олж байгаа олз ашгийг хэлнэ. Харин хоёрдагч орлого гэж гэмт хэргээс олсон орлогын банкны хүү, эсвэл энэ орлогыг хөрөнгө оруулалт болгон ашигласнаас олсон ашиг зэрэг анхдагч орлогоос бий болсон олз ашгийг хэлдэг. Үүнтэй холбоотойгоор анхдагч болон хоёрдагч орлогод албан ёсны хураах ажиллагааг явуулж байхыг оролцогч улсаас хүссэн.

Хэдийгээр 2 (g) зүйлд заасан гэмт хэргээс олсон орлогын тодорхойлолтод “гэмт хэрэг үйлдэх замаар шууд болон шууд бусаар олсон” эд хөрөнгө гэж заасан байгаа ч энэ заалтанд гэмт хэргээс олсон орлогоос үүдэлтэй “ашиг орлого буюу ашиг хонжоо” гэж тодоор томъёолсон байгаа бөгөөд энэ нь 4 ба 5 дугаар хэсэгт заасан нөхцөлөөс бий болсон ашиг хонжоонд -өөр хөрөнгөд шилжүүлсэн, өөрчлөн хувиргасан буюу өөр хөрөнгөтэй хольсон хөрөнгөнд - мөн хэрэгжиж байгаа юм. Өөрөөр хэлбэл гэмт хэргээс олсон орлогын ямар нэг байдлаар нэмэгдсэн дүнг нь өөр ямар нэг гэмт хэргэгт хамаарахгүй байсан ч хураах ёстой.

V. Дараа нь хураах зорилго бүхий урьдчилсан арга хэмжээ

Гэмт хэрэгтнээс хууль бус үйлдлээс олсон олз ашгийг амжилттай хураан авахын тулд 31 дүгээр зүйлийн 2 дугаар хэсэгт дараа нь хураах шийдвэрийн объект болж болох хөрөнгийг таньж тогтоох, мөрдөх, хөдөлгөөнийг нь хязгаарлах, түр хураах, битүүмжлэх зэрэг шаардлагатай арга хэмжээг авч байхыг оролцогч улсаас хүссэн байна.

Хөрөнгийг таньж тогтоох болон мөрдөх тал дээр оролцогч улс хураах ажиллагааг явуулах хангалттай сэжиг бүхий хөрөнгө болон эзэмших эрхийг хянах эрх мэдлийг хууль сахиулах байгууллагад болон захиргааны, шүүхийн эрх бүхий байгууллагад олгож байвал зохино. Үндэсний хэмжээнд эд хөрөнгийг таньж тогтоох арга хэмжээг нэвтрүүлэхдээ эрх бүхий байгууллагыг шаардлагатай мөрдөн байцаах эрх, бичиг баримт олж авах боломжоос гадна банк, үл хөдлөх хөрөнгө, тээврийн хэрэгсэл, хуулийн этгээд зэргийн талаархи өгөгдлийн санд нэвтрэх боломжоор ч мөн хангасан байх хэрэгтэй. Хэрэв ийм өгөгдлийн сан байхгүй бол оролцогч улс цаг тухайд нь нотлох баримт цуглуулах ажлыг хөнгөвчлөх зорилгоор өгөгдлийн сан бий болгохыг онцгойлон авч үзвэл зохино. Хураах шийтгэлд хамаарах хөрөнгийг таньж тогтоох болон мөрдөх эрх мэдлийг хууль сахиулах бүх байгууллагын мөрдөн байцаах ажиллагааны гол хэрэгсэлд тооцох нь зүйтэй. Мэдээлэх үүргийг мөрдүүлж, зохицуулах агентлаг нь хурааж болзошгүй эд хөрөнгийг таньж тогтоох, илрүүлэх болон энэ талаарх мэдээллийг хууль сахиулах байгууллагад хүргэх боломжоор хангагдсан байна.

Үүнээс гадна ойр холбоотон, гэр бүлийн гишүүд, хуурмаг компани эсвэл хувь этгээдэд нуун дарагдуулсан эзэмшлийн талаар нотолгоо цуглуулах арга замыг хууль сахиулах албан тушаалтны зүгээс эрэлхийлэх явдлыг зөвлөж байна. Ял шийтгэлийг хөнгөрүүлэх тал дээр хамтын ажиллагааны олон төрөл байдаг бөгөөд эдгээрийг ашиглан хуурмаг хувь этгээдийг гэмт хэргээс олсон орлогыг нуун дарагдуулсан эсвэл мөнгө угаасан хэрэгт буруутгах боломж үүсдэг тул энэ нь “орлон тоглогч”-той холбоотой асуудлыг шийдэх үр ашигтай арга хэрэгсэл болох нь батлагдсан юм.

Хөрөнгийг хязгаарлах, битүүмжлэх, түр хураах тал дээр оролцогч улс дараах нөхцөл байдлыг анхаарч үзэх хэрэгтэй:

- Эрх бүхий байгууллагад мөрдөн байцаах ажиллагааны бүр эхэнд түр арга хэмжээ авах эрхийг олгосон байна. Хөрөнгийг хязгаарлах, битүүмжлэх, түр хураах арга хэмжээг үр нөлөөтэй байлгахын тулд энэ арга хэмжээг *ex parte* (нэг цэгээс), урьдаас мэдэгдэлгүй авах хэрэгтэй.
- –Хүний үндсэн эрхэнд халдах байдлаар арга хэмжээ авах тохиолдолд Шүүхийн байгууллагын зөвшөөрөл шаардлагатай болох ба зөвшөөрөл олгох асуудлыг саатуулахгүй, үйл явцыг тасалдуулахгүй байхаар журмыг тогтооно. Өөр улсын шүүхийн тогтолцоотой уялдах шаардлага гарсан үед ийм арга хэмжээг цаг тухайд нь авч байхад онцгой анхаарал хандуулвал зохино.
- Оролцогч улс мөнгө угаахтай тэмцэх дүрэм журмыг мөрдөхдөө байдлаар сэжиг бүхий шилжүүлгийн мэдэгдэлд өгүүлсэн эд хөрөнгийг битүүмжлэх тал дээр өөр тогтолцоог бий болгохын ач холбогдлыг хэлэлцэж үзвэл зохино. Шүүхийн уламжлалт зөвшөөрлөөс гадна захиргааны болон автомат битүүмжлэлийн тогтолцоо гэсэн хоёр сонголт байгааг харгалзан үзэх хэрэгтэй. Захиргааны журмаар битүүмжлэлийн тогтолцоонд СМН зэрэг сэжиг бүхий мэдээллийг авч буй байгууллагад түр битүүмжлэх эсэх талаар шийдвэр гаргах эрх мэдлийг олгосон байх бөгөөд энэ шийдвэрийг шүүхийн зүгээс богино хугацааны дотор батлах шаардлагатай. Автомат битүүмжлэлийн тогтолцоонд “хаалгач” мэдэгдэл ирүүлэх хугацаанд шилжүүлэгт дурдсан эд хөрөнгийг харилцагчид мэдэгдэлгүйгээр битүүмжлэх үүрэгтэй бөгөөд холбогдох эрх бүхий байгууллагын зүгээс битүүмжилсэн эд хөрөнгийг хадгалах эсэх талаар богино хугацааны дотор шийдвэр гаргана. Аль ч тохиолдолд энэ ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэх зорилгоор шийдвэр гаргах ба энэ шийдвэр нь хүний үндсэн эрхийг үл хөндөн цаг тухайд нь битүүмжлэх ажиллагааг явуулах боломжийг олгосон байх учиртай. Энэ хоёрын завсарын сонголт ч байж болох юм. Үүнд сэжигтэй шилжүүлгийн талаар мэдээлсний дараа СМН жирийн дансны үйл ажиллагаанд зөвшөөрөл олгох боловч (мөрдөн шалгах тухай урьдаас сэрэмжлүүлсэн байх зэрэг) бусад нөхцөл байдлаас үүдэн хөрөнгийн хөдөлгөөнийг хязгаарлах болон битүүмжлэх ажиллагаа тасалдаж магадгүй тул шилжүүлгийн ажиллагааг тогтмол мэдээлж байхыг мэдээлэгч байгууллагаас хүснэ.
- Объект болон үнийн дүнг хураах тогтолцоог хоёуланг нь нэвтрүүлсэн оролцогч улс тухайн гэмт хэрэгт “ашигласан”, “мөрдөх боломжтой” буюу “хамаарах” эд хөрөнгөөс

гадна мөнгөн дүнгийн талаар шийдвэр гаргах явдлыг хамгаалах зорилгоор ашигласан бусад хөрөнгийг ч бас битүүмжлэх ажиллагаанд хамруулна. Үүнтэй нэгэн адил шалтгаанаар гэмт хэрэгт “хамаарах” хөрөнгө гадаад улсад байгаа тохиолдолд хэрэгтэнд харъяалагдах гэмт хэрэгт “үл хамаарах” хөрөнгийг битүүмжлэх боломжийг оролцогч улс авч үзэх хэрэгтэй.

31 дүгээр зүйлийн 7 дугаар хэсэгт гадаадын эрх бүхий байгууллагаас түр хураах, битүүмжлэх буюу хураах зорилгоор хүсэлт гаргахад тэрхүү хүсэлт гаргасан банкны, санхүүгийн буюу арилжааны тэмдэглэлийг бэлэн байлгах эрх мэдлийг шүүхэд олгохыг оролцогч улсаас хүссэн байна.

31 дүгээр зүйлийн 3 дугаар хэсэгт битүүмжлэгдсэн, түр хураагдсан буюу хураагдсан хөрөнгийг захирах явдлыг зохицуулах тал дээр шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг оролцогч улсад үүрэг болгожээ. Ялангуяа эрүүгийн хэргийг шүүх явц удаашрах магадлалтай улс орнуудад энэ тухайд анхаарч үзвэл зохих хэд хэдэн асуудал бий:

- Юун түрүүнд битүүмжилж болох хөрөнгийн төрөл харилцан адилгүй байж болох учраас удирдлага болон захиргааны ажил хэргийн зорилгоор эд хөрөнгийн төрлийн дагуу мэргэшсэн боловсон хүчнийг томилох хэрэгтэй юм. Арилжааны бүх үйл ажиллагаанд хязгаарлалт хийх арга хэмжээ авах зэрэг шийдэхэд нарийн төвөгтэй асуудал тулгарахад энэ нь ялангуяа шаардлагатай болно. Мөнгөний асуудлын тухайд үүнийг эрх бүхий байгууллагын дансанд шилжүүлэхэд л хангалттай. Үл хөдлөх хөрөнгийн хувьд оролцогч улсын зүгээс ашиглах болон хадгалах эрхийг эзэнд үлдээн ямар нэг байдлаар шилжүүлэх явдлыг хориглож байх нь хангалттай болно.
- Хоёрдугаарт энэ тогтолцоонд битүүмжлэгдсэн хөрөнгийг хууль бусаар ашиглах явдлаас зохих шалгалт, хяналт тавих мөн хариу арга хэмжээ авах замаар сэргийлж болно. Түүнээс гадна улсад ихээхэн хэмжээний хохирол учруулахаас сэргийлж тухайн үйлдэлд таарсан, тухайн үйлдлийг дахин хийлгэхгүй байх шийтгэлийг ногдуулж болох юм. Битүүмжлэгдсэн, түр хураагдсан буюу хураагдсан хөрөнгийг захирах нь өөрөө нилээд өртөг өндөртэй байж болох ба энэ тал дээр улсад дааж давашгүй хохирол учруулахгүй тийм удирдлагын хэлбэрийг нэвтрүүлж өгвөл зохистой.
- Эцэст нь тухайн хөрөнгийг ерөөс хураахаа больж битүүмжилсэн буюу түр хураасан хөрөнгийн эзэнд нөхөн олговор олгох буюу хохирол барагдуулах болбол энэ нь ямар байдалтай байхыг оролцогч улс тооцож үзвэл зохино.

VI. Нотолгоо шаардахыг хүчингүй болгох/шилжүүлэх

8 дугаар зүйлд гэмт хэргээс олсон гэх орлогын эх үүсвэртэй холбоотойгоор нотолгоо шаардахыг хүчингүй болгох боломжийн талаар бодож үзэхийг зөвлөсөн байгаа.

Энэ зөвлөмж нь гэмт хэргийн бүрдүүлэгч элементтэй холбоотойгоор нотолгоо шаардахыг хүчингүй болгохоос ялгаатай байх учиртай. Дээрх тусгай арга замыг амжилттайгаар нэвтрүүлсэн

улсууд ихэнхдээ үүнийг яллах ажиллагааны дараахь хураах асуудлыг зохицуулсан тусгай журамд шигтгэж өгсөн байдаг.

Энэ зөвлөмжийг хэлэлцэх үедээ оролцогч улс дараахь зүйлсийг анхаарч үзвэл зохино:

Зарим улс мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэг, зохион байгуулалттай гэмт хэрэг мөн мөнгө угаах гэмт хэргээс олсон орлоготой холбоотойгоор нотолгоо шаардахыг хүчингүй болгох тухай энэ төрлийн хууль тогтоомжийг гаргасан байдаг. Үүнд эдгээр гэмт хэргийн аль нэгээр буруутгагдсан этгээд эд хөрөнгийнхөө эх үүсвэрийг тайлбарлаж чадахгүй бол мөн энэ эд хөрөнгө тухайн этгээдийн орлого буюу эдийн засгийн үйл ажиллагаатай дүйцэхгүй бол тухайн этгээдийн харъяалалд байх хөрөнгийг хураана гэж заасан байна. Энэ тохиолдолд тухайн эд хөрөнгө шууд буюу шууд бусаар гэмт хэргээс үүдэлтэй гэдгийг батлах шаардлагагүй; ийм хууль бус орлогоос шууд бус байдлаар үүсэл гаралтай эд хөрөнгө буюу (гуравдагч этгээдэд харъяалагдахаас бусад тохиолдолд) бусад төрлийн эд хөрөнгийг буруутгагдсан этгээд үүсэл гарлыг нь баталж чадахгүй тохиолдолд хурааж болно.

Бусад улс автомат хураах тогтолцоог сонгосон байна. Энэ нь ямар нэг этгээд мансууруулах бодис, мөнгө угаах, террорист ажиллагаа, хүний наймаа, залилан гэсэн гэмт хэргээр яллагдаж байгаа тохиолдолд хэрэгжинэ. Холбогдох заалт нь “хөдөлгөөнийг нь хязгаарлах шийдвэр гарсан ямар нэг хөрөнгө нь хэрэгтний эзэмшдэг буюу эрх мэдэлд харъяалагддаг аливаа хөрөнгө, гэмт хэргээс олсон орлого мөн” гэсэн няцааж болох үндэслэл бий болгодог. Ялласны дараагаар хураах ажиллагаанд ийм хөрөнгийг хамруулахгүй байхын тулд шүүгдэгчийн зүгээс тухайн хөрөнгө нь хууль ёсны эх үүсвэртэй гэдгийг батлах шаардлагатай. Хэрэв тухайн хөрөнгө гэмт хэрэг үйлдэхэд ашиглагдаагүй буюу гэмт хэрэгт ямар нэг холбоогүй гэдгийг батлах нотолгоог гаргаж чадахгүй бол шүүхийн зүгээс тэрхүү хөрөнгийг гэмт хэрэг үйлдэхэд ашигласан буюу гэмт хэрэгт ямар нэг холбоотой гэж үзэн хураах учиртай.

Энэ хандлагын өөр нэг хувилбарыг зарим оронд хэрэглэдэг. Хэдийгээр тэд нотолгоо шаардахыг хүчингүй болгодоггүй ч яллах ажиллагаагаар хэрэгтний гэм буруутайг ямар ч эргэлзээгүйгээр тогтоомогц нотлох баримтын жишгийн давуу байдлын дагуу хураах ажиллагааны хамрах хүрээг тогтоож болно. Загвар хуулинд “цэвэр ашиг”-ийн нотолгоо нь орлогын эх үүсвэрийг батлах шууд бус арга зам гэж тодорхойлсон тохиолдол ажиглагддаг. Үнэндээ “цэвэр ашиг”-ийн аргын гол санаа нь шүүгдэгчийн хууль ёсны орлого болон өв, бэлэг зэрэг итгэхүйц үндэслэл бүхий тайлбарыг үл оролцуулан эзэмшиж буй хөрөнгийн үнийн дүн хоорондын ялгааг тогтоох явдал юм.

Зарим улсын эрүүгийн хууль зохион байгуулалттай гэм хэрэгт буруутгагдсан этгээдэд хамаарах бүх эд хөрөнгө тухайн гэмт хэргийн бүлэглэлийн эрх мэдэлд харъяалагдана гэсэн санааг гаргаж ирдэг. Тэгэхээр яллах ажиллагаанд эд хөрөнгийн үүсэл гарлыг нотлох шаардлага гарахгүй гэсэн үг. Тухайн эд хөрөнгө гэмт хэргийн бүлэглэлийн хяналтанд байна гэж тооцох нь хэдий хууль ёсоор олж авсан байлаа ч энэ хөрөнгийг бохирдсон гэж үзэх хангалттай үндэслэл болж өгнө. Эзэмшигчийн зүгээс энэ таамаглалыг няцааж болох ч тэрээр үүнийг нотлох шаардлагатай нүүр тулна.

Мөнгө угаахтай холбоотой бүх гэмт хэргийг багтаасан үндсэн гэмт хэргийн тогтолцоо энэ зүйлийн зөвлөмжийг хэрэгжүүлэх явдлыг хөнгөвчилж болох юм.

Эцэст нь, ял ногдуулсны дараахь нотлох баримтын эрүүгийн бус жишгийг хүлээн зөвшөөрдөг *sui generis* (төрөлдөө цор ганц) журамд нэмэлт болгож, тодорхой тооны улс хураах асуудлыг шийдэх тухай эд хөрөнгөд үйлчилж, нотлох баримтын давуу байдлын жишгээр зохицуулагддаг иргэний журмыг нэвтрүүлсэн байна.

VII. *Bona fide*-шударга буюу гуравдагч талыг хамгаалах тухай

9 дүгээр зүйлд энэ зүйлийн аль ч заалтыг *bona fide*-шударга гуравдагч талын эрхийг хөндөхөөр тайлбарлахгүй байхыг оролцогч улсаас хүссэн байна. Гэхдээ энэхүү конвенцид гуравдагч этгээдийн эрхээ хадгалж авч үлдэхийн тулд хууль ёсны үр нөлөөтэй хэрэгслээр хангагдаж байх цар хүрээг тогтоогоогүй. Иймээс энэ заалтыг хэрэгжүүлэхдээ зарим улс түр хураасан хөрөнгөнд гуравдагч этгээдийн зүгээс эзэмших эрх нэхэмжлэх асуудлыг зохицуулах тусгай журам нэвтрүүлснийг оролцогч улс харгалзан үзвэл зохино. Ийм журмын дагуу яллах ажиллагаанд нэхэмжлэгчтэй холбоотой дараахь зүйлийг тооцож үздэг:

- Нэхэмжлэгч үндсэн гэмт хэргийг нуун дарагдуулах зорилготой үйлдэл гаргасан эсэх, мөн ямар нэг нэмэлт гэмт хэрэгт холбогдсон эсэх;
- Нэхэмжлэгч тухайн эд хөрөнгөд хууль ёсны сонирхол илэрхийлж байгаа эсэх;
- Нэхэмжлэгч хууль болон арилжааны үйл ажиллагааны хүрээнд зохих ёсоор үйлдэл гаргасан эсэх;
- Тухайн хөрөнгө шилжүүлэг буюу ямар нэг захиргааны үйл ажиллагаатай холбоотойгоор төрийн бүртгэлд хамрагдсан байх шаардлагатай бол ийм мэдээлэл байгаа эсэх (жишээ нь., үл хөдлөх хөрөнгө, тээврийн хэрэгсэл);
- Хэрэв тухайн шилжүүлэг дарамт учруулахуйц бол энэ нь бодит зах зээлийн үнээр тогтоогдсон эсэх.

32 дугаар зүйл: Гэрч, шинжээч, хохирогчийг хамгаалах

1. *Оролцогч улс бүр энэхүү конвенцийн дагуу тогтоосон гэмт үйлдлийн талаар мэдүүлэг өгч буй гэрч, шинжээч, шаардлагатай гэж үзвэл тэдний хамаатан садан болон бусад ойрын хүнийг өс хонзон буюу айлган сүрдүүлгээс үр дүнтэйгээр хамгаалах талаар зохих арга хэмжээг өөрийн дотоодын эрх зүйн тогтолцоонд нийцүүлэн, өөрийн боломжийн хэмжээнд авна.*

2. *Энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан арга хэмжээнд хариуцагчийн эрх, түүний дотор хэргээ зохих ёсоор шийдвэрлүүлэх эрхийг үл хөндөн бусад болон ялангуяа дараахь арга хэмжээ авч болно:*

(a) бололцоо, шаардлагынхаа хэрээр дурдсан этгээдийг шилжүүлэн суурьшуулж, зохих тохиолдолд тэдний хэн болох хийгээд байгаа газрын талаархи мэдээллийг задруулахгүй байх буюу задруулахад хязгаарлалт тавих зэргээр тэдний биеийг хамгаалах журам тогтоох;

(b) мэдүүлгийг видео буюу бусад тохиромжтой хэрэгсэл гэх мэт холбоо харилцааны технологи ашиглан өгөхийг зөвшөөрөх зэргээр гэрч, шинжээчийн аюулгүй байдлыг хангах хэлбэрээр мэдүүлэг өгөх боломжийг бүрдүүлсэн журам бий болгох.

3. Оролцогч улсууд энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан этгээдийг шилжүүлэн суурьшуулах талаар бусад улстай гэрээ байгуулах буюу тохиролцоо хийх асуудлыг авч үзнэ.

4. Энэ зүйлийн заалтыг хохирогч гэрчээр оролцож байгаа тохиолдолд тэдэнд мөн хэрэглэнэ.

5. Хохирогч эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны зохих үе шатанд сэжигтэн этгээдийн эсрэг үзэл бодол, сэтгэл зовоосон асуудлаа өөрийгөө хамгаалах рхийг үл хөндөх байдлаар танилцуулж, хэлэлцүүлэх бололцоог оролцогч улс бүр өөрийн дотоодын хуулийн дагуу олгоно.

I. Ерөнхий тойм

Гэрч, шинжээч, хохирогчийг хамгаалах асуудлыг конвенцид шүүн шийтгэх ажиллагааг саатуулахтай холбоотой гэмт хэрэг зэргийг зохицуулдаг эрүүгийн хуулийн заалтанд чухал нэмэлт болгож авч үзэж байна.

32 дугаар зүйлд заавал биелүүлэх заалтууд болон заавал биелүүлэх албагүй заалтууд орсон байна. Заавал биелүүлэх заалтын нэг болох 32 (1) заалтад оролцогч улс бүр энэхүү конвенцийн дагуу тогтоосон гэмт хэргийн талаар мэдүүлэг өгч буй гэрч ба шинжээч, мөнтэдний хамаатан садан болон бусад ойр дотны хүний буюу гэр бүлийн хүнийг өс хонзон буюу айлган сүрдүүлгээс үр дүнтэйгээр хамгаалахаар заах талаар зохих арга хэмжээг өөрийн дотоодын эрх зүйн тогтолцоонд нийцүүлэн, өөрийн боломжийн хэмжээнд авна гэж заажээ. Харин 1 дүгээр хэсэгт шаардсны дагуу гэрч ба шинжээчийг хамгаалах явдлыг хангах зорилгоор авч болох арга хэмжээг 2 дугаар хэсэгт заасан байна. 2 (a) хэсэгт өс хонзон буюу айлган сүрдүүлгийн эсрэг бие хамгаалалтад авах журмын талаар заалт багтсан бол 2 (b) хэсэгт гэрч ба шинжээчид тэдний аюулгүй байдлыг хангах хэлбэрээр мэдүүлэг өгөхийг зөвшөөрөх нотолгооны дүрэм дээр төвлөрсөн юм.

Хамгааллын арга хэмжээг 2 бүлэгт ангилж авч үзэж болно: Нэгдүгээрт, эдгээр этгээдийг бие хамгаалалтад авах журам болон мэдүүлгийг видео буюу бусад тохиромжтой хэрэгсэл зэрэг холбоо харилцааны технологи ашиглах замаар өгөхийг зөвшөөрөх зэргээр гэрч ба шинжээчийн аюулгүй байдлыг хангах хэлбэрээр мэдүүлэг өгөхийг тэдэнд зөвшөөрөх нотолгооны дүрэм; Хоёрдугаарт, шаардлага болон бололцооны хэрээр оролцогч улсын зүгээс эдгээр этгээдийг шүүх хурал болтол болон шүүх хурлын турш удаан хугацаагаар хамгаалалтад авахыг санал болгож, шүүх хурлын дараагаар магадгүй гэрчийг шилжүүлэн суурьшуулж, эдгээр этгээдийн хэн болох

мөн байгаа газрын талаархи мэдээллийг задруулахгүй байх буюу задруулах талаар хязгаарлалт тогтоохыг зөвшөөрөх асуудалтай холбоотой.

3 дугаар хэсэгт заавал биелүүлэх албагүй заалт орсон бөгөөд аюулд өртөх магадлалтай этгээдийг өөр улсад шилжүүлэн суурьшуулах замаар гэрчийг хил дамнуулан хамгаалах боломжийг авч үзэхийг оролцогч улсаас хүссэн байна.

4 дүгээр хэсэг 32 дугаар зүйлийн заалтыг хохирогч гэрчээр оролцож байгаа тохиолдолд тэдэнд мөн хэрэглэхийг хүсчээ.

5 дугаар зүйлд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны зохих үе шатанд гэмт хэрэгтний эсрэг үзэл бодол, сэтгэл зовоосон асуудлаа танилцуулж, хэлэлцүүлэх бололцоог хохирогчид олгохыг оролцогч улсаас хүссэн байна. Энэ заалт нь хохирогч гэрчээр оролцохгүй байгаа тохиолдолд хамаарна.

II. Бодит бэрхшээл ба шийд

Оролцогч улс дараах нэр томъёонд онцгой анхаарал хандуулвал зохино:

- Гэрч, шинжээч мөн тэдний хамаатан садан болон бусад ойрын хүн;
- Болзошгүй өс хонзон буюу айлган сүрдүүлгээс үр дүнтэйгээр хамгаалах;
- Шаардлага болон бололцооны хэрээр эдгээр этгээдийг шилжүүлэн суурьшуулж, хэн болох ба байгаа газрын талаархи мэдээллийг задруулахгүй байх буюу задруулах талаар хязгаарлалт тогтоох зэргээр эдгээр этгээдийг бие хамгаалалтад авах;
- Мэдүүлгийг видео буюу бусад тохиромжтой хэрэгсэл зэрэг холбоо харилцааны технологи ашиглах замаар өгөхийг зөвшөөрөх зэргээр гэрч ба шинжээчийн аюулгүй байдлыг хангах хэлбэрээр мэдүүлэг өгөхийг тэдэнд зөвшөөрөх нотолгооны дүрэм;
- Гэрчийг шилжүүлэн суурьшуулах талаар бусад улстай гэрээ байгуулах буюу тохиролцоо хийх.

II.1. Гэрч, шинжээч мөн тэдний хамаатан садан болон бусад ойрын хүн

Конвенцид “гэрч” гэсэн нэр томъёог тодорхойлоогүй байгааг оролцогч улс анхаарч үзэх хэрэгтэй. Иймээс хэнийг гэрч гэж үзэхийг оролцогч улсын эрүүгийн хуулиар тогтоосон байх учиртай. Гэхдээ 32 дугаар зүйлд энэ конвенцийн дагуу тогтоосон гэмт хэргийн талаар мэдээлэл өгч буй гэрч этгээдийг гэж томъёолох байдлаар энэ нэр томъёоны хэрэглэгдэх хүрээнд тодорхой хязгаарлалт тавьсан байна. Энэ зүйлд энэ заалтын хамрах хүрээг эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны тодорхой үе шатыг заах байдлаар хязгаарлаагүй.

Дээр дурдсныг харгалзан оролцогч улс энэ зүйлийн заалтыг хэрэгжүүлэх дараахь гурван загварыг анхаарч үзвэл зохино:

- Юун түрүүнд оролцогч улс үнэхээр гэрчийн мэдүүлэг өгч байгаа этгээдийг л зөвхөн хамгаалах байдлаар энэ хэсгийн заалтыг хэрэгжүүлж болох юм. Энэ тохиолдолд тэдний хамгааллын арга хэмжээ нь зөвхөн мөрдөн байцаах ажиллагааны нэг хэсэг болсон шүүх хуралдаанд гэрчийн мэдүүлэг өгч буй этгээдийг л зөвхөн хамарна гэсэн үг. Гэхдээ тухайн этгээдийн статус мөрдөн байцаах ажиллагааны явцад өөрчлөгдөж болох бол харин түүнд учирч болох аюул занал үргэлжилсэн хэвээр байж болно гэдгийг оролцогч улс анхаарч үзэх шаардлагатай. Иймээс мөрдөн байцаах ажиллагааны аль ч шатанд мөн тухайн этгээдийн үнэхээр мэдүүлэг өгөх (шаардлагатай) эсэх нь одоо хэр тодорхойгүй байсан ч гэсэн гэрчийг хамгаалалтанд авч байвал зохино.
- Хоёрдугаарт, оролцогч улс хамтран ажиллахыг хүссэн гэсэн шалтгаанаар айлган сүрдүүлэх буюу өс санах аюул заналд өртсөн этгээдийг хамгаалах тухай энэ зүйлийн үндэслэлийг тооцон үзэж заалтыг илүү өргөн хүрээнд хэрэгжүүлэхийг хүсч байж болох юм. Энэ тохиолдолд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны хожуу шатанд гэрчийн мэдүүлэг өгөх хүсэлтэй этгээдийг ч энэ хамгаалалтанд хамруулж болно. Оролцогч улс энэхүү этгээдийг үгүйдээ шүүхэд гэрчийн мэдүүлэг өгөх шаардлагагүй нь тодорхой болох хүртэл хамгаалах боломжийг бодож үзэх хэрэгтэй.
- Эцэст нь оролцогч улс шүүхэд гэрчийн мэдүүлэг өгөхгүй ч гэмт хэрэгт буруутгах бичиг баримт зэрэг чухал нотолгоог өгөх буюу тодорхойлох этгээдийг хамрах байдлаар бүр өргөн хүрээнд энэ заалтыг хэрэгжүүлэхийг хүсч байж болно.

Оролцогч улс “шинжээч” гэсэн нэр томъёог өргөн хүрээнд тайлбарлах асуудлыг анхаарна. Ийм тайлбарын дагуу мөрдөн байцаах ажиллагааны туршид буюу шүүхэд гэрч болох байдлаар хууль сахиулах байгууллага болон шүүхийн тусын тулд мэргэжлийн ур чадвараа ашиглаж буй аливаа этгээдийг энэ нэр томъёонд хамруулах боломжийг оролцогч улсын зүгээс тооцож үзэх нь чухал. Түүнчлэн тэднийг гэрчид үзүүлсэнтэй адил хүрээний хамгаалалтын арга хэмжээнд хамруулах хэрэгтэй. Эцэст нь хамаатан садан буюу ойр дотны хүмүүс гэдэг тодорхойлолтыг гэр бүлийн гишүүд гэсэн утгаар хэрэглэх ч энэ заалтыг өргөн хүрээнд хэрэгжүүлж байгаа тохиолдолд гэрч буюу шинжээчийн ойр дотны этгээдүүдийг өргөн хүрээнд оролцуулан ойлгох нь илүү зохимжтой юм. Гэрчийн зүгээс хамтран ажиллах болон сүрдүүлгээс шалтгаалан үүнээс татгалзах хоёрын хооронд сонголт хийхэд ойр дотныхон болон анд нөхдийн харьцаа чухал хүчин зүйл болдог гэдгийг оролцогч улс анхаарч үзвэл зохино.

II.2. Үр дүнтэй хамгаалалтад авах

Оролцогч улс гэрчийг хамгаалалтад авах цогц хөтөлбөр хэрэгжүүлэх явдлыг гэрч болон шинжээчийн аюулгүй байдлыг хангах хамгийн үр дүнтэй арга зам гэж үзэж болно. Үүнтэй холбоотойгоор (нэр өөрчлөх зэрэг) зарим хамгаалалтын арга хэмжээг авахад албан болон албан бус орчин бүрдсэн байх хэрэгтэй байдгийг оролцогч улс анхаарч үзэх хэрэгтэй. Ийм хөтөлбөрийг

хэрэгжүүлж байгаа тохиолдолд яллах ажиллагааг амжилттай явуулахын тулд гэрчийн тодорхой шаардлагад нийцүүлэн хөтөлбөрийг зохих байдлаар өөрчилж болдог байх явдлыг оролцогч улс тооцож үзнэ.

Оролцогч улс сүрдүүлэг болон өс хонзон олон арга хэлбэртэй байж болохыг анхаарч үзвэл зохино. Гэрчийг хамгаалалтад авах хөтөлбөрт ямар нэг этгээдийг хамруулах талаар шийдвэр гаргахдаа зөвхөн биет заналхийлэлд төвлөрвөл өрөөсгөл болно. Харин хөтөлбөрийг илүү өргөн хүрээг хамарсан байдлаар хэрэгжүүлэх хэрэгтэй. Хууль сахиулах байгууллагын зүгээс тухайн этгээдийг хамгаалалтад авах эсэх талаар шийдвэр гаргахдаа тодорхой тооны нэмэлт хүчин зүйлийг анхаарч болно. Ийм хүчин зүйлд хариуцагч буюу түүний холбоотны заналхийлэх магадлал ба мөрдөн байцаах ажиллагаа болон шүүх хурал дууссны дараа тэрхүү заналхийлэл үргэлжилсээр байх эсэх мөн үүний хугацаа *inter alia* багтаж болох юм. Үүнээс гадна оролцогч улс тухайн гэмт хэрэгт зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэглэл оролцсон эсэхийг мөн анхаарч үзвэл зохино. Ийм тохиолдолд ийм бүлэглэлийн гишүүний эсрэг гэрчийн мэдүүлэг өгөх нь ноцтой бөгөөд удаан хугацаагаар өс хонзон санах явдалд хөтөлж болзошгүй юм.

Гэрчийг хамгаалалтад авах нь өртөг өндөртэй, хүн хүч их шаардсан ажил тул оролцогч улс хамгаалалтад авах арга хэмжээний хамрах хүрээг харилцан адилгүй байдлаар тогтоох боломжийг харгалзан үзэх хэрэгтэй. Иймээс гэрчийг хамгаалалтад авах бүрэн хэмжээний хөтөлбөрийг зөвхөн тодорхой тооны гэрчид хэрэгжүүлэх бөгөөд тэдгээр гэрч нь яллах ажиллагааг амжилттай явуулахад мөрдөн байцаах буюу ажиглалт хийх өөр арга болон нотлох баримтаар орлуулах аргагүй байдлаар гол хүчин зүйл болж байх шаардлагыг тавьж болно. Оролцогч улс гэрчийг хамгаалалтад авах иж бүрэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээг хязгаарлах нь бусад гэрчийг ямар нэг хамгаалалтгүйгээр орхино гэсэн үг биш гэдгийг анхаарч үзэх хэрэгтэй. Үнэндээ гэрчийг хамгаалахад богино хугацаанд бие хамгаалахаас авахуулаад урт хугацаанд гэрч болон тэднийг гэр бүлийн хамт шилжүүлэн суурьшуулах хүртэл боломжит олон арга зам байдаг. Эрсдлийн үнэлгээ хийх нь тухайн хэрэгт хангалттай хамгаалалтын арга хэмжээ авах орчинг бий болгоно. Гэрчийг хамгаалалтад авах цогц арга хэмжээ нь өс хонзон санах явдлын эсрэг урт хугацааны хамгаалал бий болгоход голлон чиглэсэн байдаг бол бусад авлигын хэрэгтэй холбоотойгоор гэрчийг хамгаалалтад авах арга хэмжээ нь шүүх хурлаас өмнөх сүрдүүлэгт төвлөрдөг бөгөөд иймээс ч гэрчийг хамгаалалтад авах цогц арга хэмжээнээс илүүтэйгээр гэрчийг бие хамгаалах бусад арга хэмжээг авах замаар асуудлыг зохих байдлаар шийдвэрлэж болох юм.

Онцгой хэрэгт гэрчийг хамгаалалтад авах хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор зарим улс тухайн нөхцөлд авах хамгаалалтын арга хэмжээг зохицуулах харилцан ойлголцлын санамж бичиг буюу протоколыг төр болон гэрчийн хооронд байгуулах боломжийг зааж өгсөн байдгийг оролцогч улс анхаарч үзэх хүсэлтэй байж болно. Ийм харилцан ойлголцлын санамж бичиг буюу протокол нь хамгааллын үр нөлөөг нэмэгдүүлж, хамтран ажиллах хөшүүрэг болж болох юм. Ямар ч тохиолдолд ийм харилцан ойлголцлын санамж бичиг буюу протокол хамгааллын хамрах хүрээг тодорхой болгож, болзошгүй санал зөрөлдөх явдлаас зайлсхийхэд ашиг тусаа өгнө. UNODC гэрчийг хамгаалалтад авах талаар баримт бичгийн багцыг боловсруулсан бөгөөд үүнд “Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй холбоотой эрүүгийн байцаан

шийтгэх ажиллагаанд гэрчийг хамгаалалтанд авах зөв үйл ажиллагаа” нэртэй гарын авлага орсон. Энэ гарын авлагыг UNODC-ын веб хуудаснаас¹ авч болно.

III. Бусад улстай гэрээ байгуулах буюу тохиролцоо хийх

Гэрчийг хамгаалах тал дээр оролцогч улс өөрийн туршлагыг харгалзан үзэн бусад улстай гэрчийг шилжүүлэн суурьшуулах асуудлыг зохицуулах гэрээг байгуулах буюу тохиролцоо хийх хэрэгтэй гэсэн дүгнэлтэд хүрч болно. Гэхдээ байцаан шийтгэх үйл ажиллагааны үеэр энэхүү тохиолцоо нь гар дор бэлэн байхгүй бол шинээр гэрээ байгуулах буюу тохиролцоо хийх нь нилээдгүй цаг хугацаа шаардана гэдгийг оролцогч улс бодолцож үзэх хэрэгтэй. Дээрхи асуудлыг шийдэх өөр нэг аргад зөвхөн нэг хэрэгт үйлчилдэггүй харин дахин гарч болох олон хэргийг шийдэх орчин нөхцөл үүсгэх байдлаар хэрэглэж болох улс хоорондын гэрээ байгуулах буюу тохиролцоо хийх арга орж болно.

Гэрчийг хамгаалалтанд авах хил дамнасан хөтөлбөрийг хэрэгжүүлэх хамгийн сайн арга нь “улс орнуудын гэр бүл”-д үндэслэсэн хамтын ажиллагааны гэрээ буюу тохиролцоог бий болгох боломжийг оролцогч улс тооцож үзвэл зохино. Ийм гэр бүлийн гишүүн орныг аюулгүй хоргодох газар болгон ашиглах боломж оролцогч улсад үүсэх юм. Ийм “гэр бүлийн” гишүүн орнууд газар зүйн байршилын хувьд хил залгаа байж болохоос гадна хэл, эдийн засаг, соёлын хувьд хоорондоо ижил төстэй байж болно.

IV. Хохирогч

Олон хэрэгт бүх хохирогчоос нотлох баримт өгөхийг шаарддаггүйгээс гадна зарим тохиолдолд хохирогч болох магадлалтай этгээдийн хамрах хүрээ нь шууд хохирол амссан буюу хохирсон хүмүүсээс ч давж гарах үе байдаг. Тухайн хэргийн ноцтой байдалд дүгнэлт өгөх тал дээр хохирогчдод эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны үе шатанд мөн ялангуяа шүүхээс буруутай гэж тогтоосон шийдвэр гарсны дараа, ял ногдуулахаас өмнө үзэл бодол, сэтгэл зовоосон асуудлаа танилцуулж, хэлэлцүүлэх бололцоог олгох замаар нийт хохирлын хэмжээг тогтоох боломжтой. Энэ заалт нь хохирогч гэрч болохгүй буюу болж чадахгүй, иймээс ч төрөөс хариуцагчийн эсрэг эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг явуулж байгаа тул санал бодол, сэтгэл зовоосон асуудлаа илэрхийлэх боломжгүй тохиолдол хамаарна.

33 дугаар зүйл: Мэдээлэгч этгээдийг хамгаалах

Оролцогч улс бүр энэхүү конвенциор тодорхойлсон гэмт үйлдлийн талаархи баримт нотолгоог шударга ёсны үүднээс, үндэслэлтэйгээр эрх бүхий байгууллагад мэдээлж буй этгээдийг аливаа шударга бус хандлагаас хамгаалах талаарх зохих арга хэмжээг өөрийн дотоодын эрх зүйн тогтолцоонд нэвтрүүлэх асуудлыг авч үзнэ.

I. Ерөнхий тойм

¹ <http://www.unodc.org/documents/organized-crime/Witness-protection-manual-Feb08.pdf>

33 дугаар зүйл нь заавал биелүүлэх албагүй заалт юм. Оролцогч улсууд энэ заалт нь гэрч болон шинжээчийг хамгаалах асуудлыг тусгасан зүйлийг гүйцэлдүүлж байгаа гэдгийг анхаарч үзэх хэрэгтэй. 33 дугаар зүйл хууль зүйн үүднээс нотлох баримт бүрдүүлэхэд хангалттай нарийвчилсан байдалтай биш мэдээлийг эзэмшиж буй хувь этгээдийг хамрахыг зорьсон болно. Ийм мэдээлэл нь хэрэгт анхан шатанд олдох магадлалтай бөгөөд зөрчил гарч байгааг илтгэгч зүйл болж болох юм. Авлигын хэргийн тухайд энэ хэрэг нь нилээд ярвигтай байдаг тул ийм илтгэгч зүйл нь эрх бүхий байгууллагыг сэрэмжлүүлэх, тэдэнд мөрдөн байцаах ажиллагааг эхлүүлэх эсэх талаар чухал шийдвэр гаргах зөвшөөрөл олгоход хэрэгтэй болдог.

Энэхүү конвенцид “мэдээлэгч этгээд” гэсэн нэр томъёог хэрэглэсэн. Энэ нэр томъёогоор нэрлэх этгээд болон гэрчийн хоорондын ялгааг тодорхой болгосон гэж үзэн энэ нэр томъёо нь илэрхийлэхийг зорьсон гол санааг хангалттай байдлаар тусгаж байгаа гэж ойлгож болно. “Шүгэл үлээгч” гэсэн нэр томъёоноос энэ нэр томъёог илүүд үзэж байгаа бөгөөд “шүгэл үлээгч” гэдэг нь олон хэлэнд яг оноон орчуулах боломжгүй хар ярианы хэллэг юм.

II. Бодит бэрхшээл ба шийд

II.1. Бодлогын орчин

Ерөнхийдөө дараах асуудлыг шийдэх бодлогын орчинг бий болгох шаардлагатай:

- Хэн болон аль талбар, үйл ажиллагаа, салбар, байгууллага хамрагдах;
- Хэн мэдээлж болох;
- Мэдэгдэл хэнд хаяглагдсан байх;
- Шударга бус хандлагад юу багтах;
- Мэдээллийн эх сурвалжид ямар төрлийн хамгаалалт санал болгох;
- Далд санаатай буюу заргын мэдэгдлийг шийдэхэд ямар баталгааг анхаарч үзвэл зохих.

33 дугаар зүйлийг хэрэгжүүлэхтэй холбоотой анхаарч үзэх гол зүйл нь мэдээлэл буюу мэдэгдлийн бай болсон этгээдийн эрх болон мэдээлэгч этгээдийг хамгаалах шаардлага хоёрын хооронд зохих тэнцвэрийг тогтоох юм. Энэ тэнцвэрийг дотоодын хууль тогтоомжийн хүрээнд мөн нийгмийн орчин бүрт тогтоосон байх учиртай. Иймээс энэ зүйлд эдгээр арга хэмжээг өөрийн дотоодын эрх зүйн тогтолцоонд нэвтрүүлэн оруулах боломжийг оролцогч улсад олгох байдлаар өргөн хүрээний үзэмжээрээ шийдэх эрхийг олгосон байгаа.

II.2. Төрийн албан тушаалтныг татан оролцуулах

Төрийн албан тушаалтныг оролцуулах тухай асуудалд дараах багтана:

- Зүй зохистой үйлдлийн талаарх ойлголтыг хэвшүүлэх –ямар түвшинд, хэнийг оролцуулан юу зөв, юу буруу болох;
- Зүй зохисгүй явдлаас зайлсхийх шаардлагыг онцолж үзэх; ялангуяа аль үйл буруу болохыг тогтоох чадвартай байх;
- Санал бодлоо илэрхийлэхийн ач холбогдлыг ойлгох; ялангуяа буруу үйлийг мэдээлэх үүрэг хариуцлага хүн бүрт ногдоно гэдгийг онцгойлох;
- Дараах зүйлд сайтар итгэлтэй болж авах:
 - Мэдээллийг эерэг байдлаар хүлээж авах;
 - Үр дүнтэй бөгөөд тохирсон арга хэмжээг авах;
 - Мэдээлэх явдлаас олох олз ашиг нь үүнд зарцуулах зардлаас илүү байх;
 - Мэдээлэгч этгээдийг хамгаалалтанд авах боломжоор хангах.

II.3. Олон нийтийг татан оролцуулах

Оролцогч улс олон нийтэд авлигын талаар мэдээлэх хүсэл төрүүлэхийн ач холбогдлыг анхаарч үзнэ. Тиймээс статусыг нь үл харгалзан төрийн албан хаагч, хуулийн этгээдийн ажилтнаас гадна авлига гарсан байж болзошгүй сэжиг бүхий явдлыг мэдээлсэн хүн бүрийг хамгаалах боломжийг оролцогч улс авч үзэхийг хүсч байж болно. Түүнчлэн энэ зүйлд дурдсан шалгуурын дагуу түүх, болсон явдлыг хэвлэн нийтэлдэг учир сэтгүүлчдийг ч мөн энэ хамгаалалтад хамруулах нь чухал ач холбогдолтой гэдгийг анхаарч үзвэл зохилтой.

Авлигын талаар ямар байгууллагад мэдээлэх, хэрхэн мэдээлэх талаар олон нийтэд зөвлөмж өгсөн “мэдээлэх тухай” удирдамжийг гаргахыг оролцогч улс хүсч байж болох юм. Гэхдээ олон нийтийн дунд хангалттай итгэл үнэмшил бий болтол тогтоосон журмаас гадуур мэдээлэх явдал байж болохыг оролцогч улс анхаарч үзэх шаардлагатай.

II.4. Хэнд мэдээлэх тухай

Оролцогч улс мэдэгдэл хүлээн авах мөн хангалттай хамгаалалтаар хангах хүчин чадалтай байх тэрхүү байгууллага буюу байгууллагуудыг тодорхой зааж өгөхийг хүсч байж болно. Гэхдээ багахан хэмжээний мэдэгдэл нь авлигын талаар нилээд нарийн лавлах ажиллагааг эхлүүлэх анхны алхам болж болох ба иймээс мэдээлэх явдлын хамгаалалтын талаар төрийн бодлого болон журмыг мөрдөж байх шаардлагатай тул хэд хэдэн байгууллагад үүрэг болгож болохыг оролцогч улс тооцож үзнэ.

Ер нь мэдээлэгч этгээд санал бодлоо хамгийн багадаа хоёр түвшинд илэрхийлэх боломжтой байх тийм тогтолцоог нэвтрүүлэх нь ашигтайд тооцогддог. Үүний доод түвшинд

тухайн этгээдийн ажилладаг байгууллага доторхи сул удирдлагын асуудлыг шийдвэрлэх зорилгоор бий болсон удирдлага, байгууллагын дарга буюу дотоод гадаад хяналтын байгууллага зэрэг тухайн этгээдийг удирдан чиглүүлэх байгууллага, этгээд багтана.

Мэдээллэгч этгээд доод түвшинд мэдээлсэн ч энэ нь зохих үр дүнгээ өгөөгүй болон ялангуяа мэдэгдэл хийсэн байгууллага буюу этгээд дараахь үйлдлийг гаргасан тохиолдолд мэдээллэгч өөр байгууллагад хандах боломжоор хангагдсан байвал зохино. Эдгээр үйлдэлд:

- Мөрдөн шалгах ажиллагаа явуулахгүй байх шийдвэр гаргасан;
- Тодорхой хугацааны дотор мөрдөн шалгах ажиллагааг дуусгаж чадаагүй;
- Мөрдөн шалгах ажиллагааны эерэг үр дүнг үл харгалзан арга хэмжээ аваагүй
- Тодорхой хугацааны дотор мэдээллэгч этгээдэд буцааж мэдэгдэл хийгээгүй явдал орно.

Мэдээллэгч этгээд дараах тохиолдолд дээд түвшний байгууллагад хандах сонголтыг хийж болно:

- Асуудлыг байгууллага дотроо буюу дээр дурдсан доод түвшний гадаад хяналтын байгууллагад тавьбал өөрсдөө хохирч болзошгүй гэдэгт итгэх хангалттай шалтгаантай бол; эсвэл
- Нуун дарагдуулахаас айх шалтгаантай бол.

Дээд түвшний байгууллага гэдэг нь обдусман, авлигатай тэмцэх байгууллага болон ерөнхий прокурор байж болно.

II.5. Мэдээлэх шалгуур

Энэ зүйлд сайн санааны үүднээс, үндэслэлтэйгээр мэдээлсэн байх явдлыг хамгаалалтанд авах нөхцөл болгон заасан байгаа.

Энэ шалгуурыг хэрэгжүүлэхэд хэд хэдэн асуудлыг анхаарч үзэх шаардлагатай. Үүнд: мэдээлэлд бодитой байдлаар хандаж, энэ нь үнэн зөв биш болох нь тогтоогдсон тохиолдолд ч тухайн мэдээллэгч сайн санааны үүднээс энэ үйлдлийг хийсэн л бол хамгаалалтанд авч улмаар хууль үйлчилж байх учиртай. Түүнчлэн тухайн мэдээлэл нууцад хамаарч байх болон мэдээллэгч этгээд нууцлалын хууль зөрчсөн ч энэ хууль үйлчилнэ.

Шударга ёсны үүднээс мэдээлсэн байх нь тухайн этгээдийг хамгаалалтад авах эсэхийг шийдэхэд нөлөөлөх эерэг хүчин зүйл гэж үзнэ. Гэхдээ мэдээлэл худал бөгөөд шударга ёсны үүднээс мэдээлээгүй гэдэг нь тогтоогдвол холбогдох арга хэмжээг мөн авч байвал зохино.

Шүгэл үлээх нь хоёр иртэй хутга шиг хаашаа ч эргэж болох зүйл тул хуурмаг, заргын шинжтэй болон хорон санаа агуулсан байдлаар мэдэгдэл хийсэн хүний эрх чөлөө, нэр төрийг хамгаалах шаардлагатай. Ялангуяа нэр хүндийг нь гутаасан тохиолдолд тэрхүү нэр төрийг сэргээх талаар зохих арга хэмжээг авч байх заалтыг хуульд тусгасан байна. Санаатайгаар ташаа мэдээлэл хийсэн этгээдийг шийтгэх заалтыг эрүүгийн хуульд оруулсан байдаг. Шударга ёсны үүднээс мэдээлээгүй тохиолдолд тэдэнд авч болох арга хэмжээг мэдээлэгч этгээд мэдэж байх явдлыг хангавал зохино. Мэдээлэгч этгээдэд шударга ёсны үүднээс мэдээлж байгаагаа батлах шаардлага тавихгүй.

Тодорхой үндэслэлтэй байх шалгуурын үүднээс оролцогч улс зөвхөн мэдэгдэл нь худал болох нь батлагдсан гэсэн шалтгаанаар тусгай хамгаалалтад авахгүй байх шийдвэр гаргахгүй байх талаар анхаарч үзвэл зохино. Харин тухайн үйл явдал болохоос өмнө тодорхой таамаглал дэвшүүлэх хэрэгтэй. Энд, оролцогч улс тухайн мэдэгдлийг дэмжсэн мэдээлэл байгаа гэж итгэх хангалттай шалтгаан мэдээлэгчид байгаа эсэхийг тогтоож болох юм. Оролцогч улс тухайн мэдэгдэл тодорхой үндэслэлтэй эсэхийг тогтоохын тулд мэдээлэх асуудлыг зохицуулсан илүү ерөнхий хэрэглээ бүхий хүчин төгөлдөр өөр дүрэм журам буюу удирдамжид хандаж болно.

II.6. Мэдээлэгч этгээдийг хамгаалах

Ер нь оролцогч улс мэдээлэгч этгээдийн хэн болохыг тогтоох, түүнд ямар аюул занал учирч болох, түүнээс илүү мэдээлэл авч болох эсэх, тухайн этгээд гэрчлэх мэдээлэлтэй эсэх, санхүүгийн болон ажил мэргэжлийн хувьд мэдээлэгч ямар аюулд өртөж болох түүнчлэн ямар нөхөн олговор буюу нөхөн төлбөр олгож болохыг харгалзан хамгаалалтын хэлбэрийг тогтоох асуудлыг анхаарна.

Мэдээлэгч олон төрлийн шударга бус хандлагатай нүүр тулж болно гэж сэтгэл зовниж болох юм. Иймээс ч эдгээр хандлагыг үгүй хийх олон төрлийн арга хэрэгсэл байдаг. Ер нь хамгааллын арга хэмжээ нь учирч болох аюул заналтай хэмжээний хувьд таарсан байх учиртайгаас гадна мэдээлэгч тухайн мэдэгдлийн ноцтой байдлын талаар мэдээлээгүй, буюу мэдэгдлийг шалгах явцад дараа дараагийн лавлагаа нь анхны мэдэгдэлтэй дүйцэхээргүй байдлаар ноцтой болж ирэх магадлалыг тооцохгүй байгаа тохиолдолд мөн хамгааллын арга хэмжээг авна.

Оролцогч улс мэдээлэгчийн хэн болохыг нууцлах боломжийг тооцож үзэж болох юм.² Нэрээ нууцлах боломжийг олгох боломжгүй тохиолдолд, оролцогч улс заналхийлэл, сүрдүүлэг буюу өс хонзонг гэмт хэрэгт тооцох нь мэдээлэгч этгээдийг хамгаалах үр дүнтэй арга байж болох эсэхийг анхаарч үзнэ.

² Энэ нь Европын Хиний эрхийн шийхийн хууль зийтэй хамааралтай. Энэ хууль зийд зааснаар бол гэрчийн хэн болохыг нууцлах нь Конвенцийн шийх хурал шударга байх тухай 6 дугаар заалттай зерчилдэхгүй. Тэнд “емгеегчид ийсэх хиндрэлийг шийхийн байгууллагын мердех журмаар тэнцвэржилнэ” гэсэн байгаа. (Жишээ нь, нэрээ нууцалсан гэрчийг гэрчийн хэн болохыг мэдэх мерден байцаах шийгчийг байлцуулан байцааж болох бегеед емгеегч гэрчийн хэн болохыг мэдэхгүй байж болно.) (Дорсон, Голланд улсын эсрэг, 1996 оны 3 сарын 26-ны шийх хурал, Appl. No.20524/92, Мэдэгдлээд 1996-II, 72-73 хэсгийг харна уу).

Албан үүргээ үргэлжлүүлэн гүйцэтгэж байх явдлыг зохих шүүхийн шийдвэрийг гаргах замаар хангах зэргээр мэдээлэгч этгээдийг албан ажлаа алдахаас хууль ёсоор хамгаалах буюу иргэний журмаар хохирлыг барагдуулах арга хэмжээ авахыг санал болгох заалт болон журмыг хэрэгжүүлэх явдлыг оролцогч улс бодолцож үзэж болох юм. Үүнээс гадна мэдээлэгч мэргэжлийн хувьд ялгаварлалд өртөх эрсдэлтэй нүүр тулж болно гэдгийг оролцогч улс анхаарна. Иймээс ийм хэлбэрийн шийтгэл ногдуулахтай тэмцэх байдлаар хуулийн арга хэмжээ авах явдлыг тооцож үзвэл зохино. Мэдээлэгчийг шударга бус байдлаар ажлаас халахаас нь хамгаалах арга хэмжээ нь тухайн улсын хөдөлмөрийн хуулинд нийцсэн байх учиртай. Ажил олгогчийн зүгээс ажилтнаа тодорхой шалтгаангүйгээр ажлаас халах боломжтой тохиолдолд хууль тогтоомжинд заавал нийцүүлэх албагүйгээр мэдээлэгчийг хамгаалах шаардлага гарч болох юм.

Эцэст нь оролцогч улс гүтгэлгийн талаарх хуулиндаа шинэтгэл хийх нь авлигатай тэмцэхэд чухал нөлөөтэй гэдгийг анхаарч үзэж болно. Энэ нь ялангуяа мөрдөн байцаах ажиллагаа болон сэтгүүлчдийн мэдэгдэлтэй хамааралтай байж болох юм.

34 дүгээр зүйл: Авлигадахүйлдлийн үр дагавар

Оролцогч улс бүр авлигын үр дагаврыг шийдвэрлэх арга хэмжээг гуравдагч талын шударгаар олж авсан эрхийг зохих ёсоор харгалзан дотоодын хууль тогтоомжийнхоо тулгуур зарчимд нийцүүлэн авна. Энэ утгаар оролцогч улсууд гэрээг цуцлах буюу хүчингүй болгох, концесс буюу бусад адилтгах баримт бичгээс татгалзах эсхүл эрх зүйн хамгаалалтын аливаа бусад арга хэмжээ авах зэрэг хууль зүйн ажиллагаанд авилгыг холбогдох хүчин зүйлд тооцно.

I. Ерөнхий тойм

Авлигын үйлдлийг ихэнхдээ эдийн засгийн орлого бий болгох эсвэл орлогоо нэмэгдүүлэх гэж үйлддэг. Түүнчлэн бизнесийн боломжийг бий болгох, гэрээнд таатай нөхцлөөр тохиролцох, концессын буюу бараа, ажил, үйлчилгээ худалдан авах шийдвэр зэрэг захиргааны таатай орчинд гэрээг байгуулах, тендерт амжилт гаргах, зөрчил гаргагчид бизнес эхлүүлэх боломж олгох зорилгоор авлига гаргана. Конвенцид тусгасан зарчмуудын нэг бөгөөд хөрөнгө буцаан олгох тухай 5 дугаар зүйлд тодорхой өгүүлсэн зарчмаар бол авлигаас ашиг олох ёсгүй тул зөрчил гаргагч ч мөн авлигач үйлдлээс ашиг хонжоо хүртэх учиргүй юм. Гэхдээ үүнд дан ганц эрүүгийн шийтгэл хангалттай биш байж болно. Хууль зүйн тогтолцоонд тууштай байдлыг хангахын тулд авлигач үйлдлийг жигших үзлийг хуулийн холбогдох зохицуулалт бүрт хэвшүүлж өгөх хэрэгтэй юм. Ийм хуулиудад хувь этгээд ба эзэмшлийн тухай хууль, татварын хууль, өрсөлдөөний хууль, захиргааны хууль, гэрээний хууль, иргэний шүүхийн хууль, маргаан таслах тухай хууль орох бөгөөд эдгээр нь авлигач үйлдлийн эсрэг тогтмол хариу үйлдэл үзүүлж байхад хувь нэмрээ оруулна. Авлигын эдийн засгийн үр дагаврыг иргэдийн эзэмшлийн тухай хууль болон захиргааны хуулиар зохицуулдаг.

34 дүгээр зүйлийн эхний хэсэгт заавал биелүүлэх заалт байгаа. Гэхдээ энэ зүйлээр иргэний болон захиргааны хууль дахь тусгай үр дагаврыг оролцогч улс үзэмжээрээ шийдэж болохоор тогтоосон. Конвенц ийнхүү 34 дүгээр зүйлийн дагуу шийдвэрлэх арга хэмжээг

гуравдагч талын сайн санааны үүднээс олж авсан эрхийг зохих ёсоор харгалзан дотоодын хууль тогтоомжийнхоо тулгуур зарчимд нийцүүлэн авахыг оролцогч улсаас хүссэн байна.

II. Бодит бэрхшээл ба шийдэл

Мэргэжилтнүүд янз бүрийн чиг үүргээр үйл ажиллагаа явуулах явцдаа авлигын төрөл бүрийн үр дагавартай нүүр тулж болох юм. Тухайлбал, концесс, бараа, ажил, үйлчилгээ худалдан авах зэрэг захиргааны гэрээ бичигтэй ажиллаж буй мэргэжилтэн өмнөх шийдвэрт авлига нөлөөлсөн гэдэг нь илрэн ийм гэрээ бичгийг хууль болон захиргааны талаас хянан шалгах явцад авлигын үр дагавартай нүүр тулж болно. Иргэдийн эзэмшлийн тухай хуулийн хүрээнд авлигын үр дагавартай холбоотой байцаан шийтгэх ажиллагаанд оролцогч авлигатай холбоотой байдлаар олж авсан гэрээний хүчинтэй/хүчингүй байдал, хэрэгжих боломжтой/боломжгүй байдал буюу гэрээний засварын тухай асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй болно. Үүнээс гадна удирдлага болон шүүгчдэд зориулан авлигатай тэмцэх стратеги боловсруулж буй засгийн газрын албан тушаалтан авлигын үр дагавар нь хамааралтай болж ирэх байцаан шийтгэх ажиллагаанд холбогдох байгууллагыг бэлэн байлгахын тулд энэ асуудлыг харгалзан үзэх хэрэг гарна. Татварын байгууллагын албан тушаалтны зарлага нь үнэндээ дүр хувиргасан хахууль байсныг тогтоосон тохиолдолд татвараас чөлөөлсөн тухай асуудлыг шийдвэрлэх шаардлагатай нүүр тулж болох юм.

II.1. Арга хэмжээний төрлүүд

Конвенц энэ асуудлаар ямар төрлийн арга хэмжээ авахыг үзэмжээрээ шийдэх боломжийг оролцогч улсад олгосон.

Мэргэжилтэн 34 дүгээр зүйлд авч үзсэн тэр арга хэмжээ нь эрүүгийн эрхзүйн хэм хэмжээ биш байх учиртайг тооцож үзнэ. Тиймээс энэ асуудлыг шийдвэрлэх явцад өөр журмаар зохицуулагдах эрхийн асуудлыг хөндөх хэрэгтэй болох юм. Жишээ нь, *in dubio pro reo* эсвэл *ne bis in idem* зарчим иргэний болон захиргааны байцаан шийтгэх ажиллагаанд үйлчлэхгүй. Нөгөөтэйгүүр эд хөрөнгө эзэмших эрх, мэргэжил эзэмших эрх, арилжааны эрх чөлөө зэрэг хүний бусад үндсэн эрхийг анхаарч үзэх шаардлага бий болно.

Ихэнх улс оронд иргэний буюу захиргааны хэрэгт шаардах нотолгооны жишиг нь эрүүгийн хэрэгт шаардах нотолгооны жишгээс доогуур байдаг. Авлигын үр дагаврын талаар байцаан шийтгэх ажиллагаанд оролцож буй этгээд үүнийг өөрийн хэргийн стратегид ашиглаж болох юм. Эрүүгийн хариуцлага хүлээхэд хангалттай нотлох баримт бүрдээгүйн улмаас буюу *ne bis in idem* зарчим үйлчилж байгаа гэсэн шалтгаанаар эрүүгийн шийтгэл ногдуулах боломжгүй байгаа тохиолдолд иргэний байцаан шийтгэх ажиллагаа боломжит сонголт хэвээр үлдэнэ. Авлигын үр дагаврын асуудлыг шийдвэрлэж буй этгээд тусгай хэргийг зохицуулах дүрмийг мэддэг байх шаардлагатай.

II.2. Урьдчилан сэргийлэхэд төвлөрөх

Конвенцоор заасан арга хэмжээг хэрэгжүүлэх хамгийн оновчтой арга замыг тогтооход анхаарах учиртай нэг гол асуудал бол гэрээ байгуулах болон концесс, тусгай зөвшөөрөл буюу

бусад адилтгах гэрээ бичиг олгох захиргааны үйл явцыг цогц байдлаар баримтжуулах явдал юм. Ийм гэрээ бичиг үйлдснээр аливаа журмын хүрээнд гарсан авлигын үр дагаврын тухай энэхүү удирдамжид тухайн гэрээ бичиг нь зохих арга хэмжээг авах үндэс суурь болж байгааг илтгэсэн мэдэгдлийг баримтжуулж багтаахаас гадна, дээрхи гэрээг нотлох баримт болгох хууль ёсны байцаан шийтгэх ажиллагаа болон үйл явцыг товч мэдэгдэнэ. Оролцогч улс тендерт холбоотой бичиг баримтад дээрхи үр дагаврыг харгалзан тендерийн материалаа ирүүлж буй этгээдүүд болон гэрээ, концессийн эрх авахын тулд үнэ хаялцагчдаас ямар нэг авлигын хэрэгт оролцохгүй талаар мэдүүлэгт гарын үсгээ зурсан байх тухай мэдэгдлийг багтаасан байх явдлыг хангаж болно. Дээр дурдсан бичиг баримтад ийм арга хэмжээг гэрээ буюу концесс хэрэгжих явцад хэдийд ч авч болохыг түүнчлэн –тухайн хууль тогтоомжийн ерөнхий хандлагаас шалтгаалан-гэрээг хүчингүй болгох, тусгай зөвшөөрөл болон концессийг цуцлах зэрэг янз бүрийн үр дүнг дагуулж болохыг заана.

Хууль сахиулах байгууллага болон тусгай зөвшөөрөл, концесс олгох, гэрээ байгуулах эрх мэдэл бүхий байгууллагын хооронд мэдээлэл солилцож байх нь маш чухал гэдгийг оролцогч улс анхаарч үзэх хэрэгтэй. Улс оронд шүүх байгууллагуудын хооронд мэдээлэл солилцох явдал байхгүйгээс болж, нэг бус удаа авлигын гэмт хэрэгт шийтгэгдсэн байгууллага, этгээдэд концесс, тусгай зөвшөөрөл олгох, гэрээ байгуулах асуудалтай нүүр тулсан юм.

II.3. Дотоодын хууль тогтоомжид нийцүүлэн арга хэмжээ авах

Оролцогч улс арга хэмжээ бүрийг дотоодын хууль тогтоомжийнхоо тулгуур зарчимд нийцүүлэн авна.

Конвенцийн санал болгосон арга хэмжээнээс гадна, оролцогч улс тодорхой заасан хугацаагаар татаас олгохыг болиулах, санхүүгийн дэмжлэгийг зогсоох, тендерт оролцохыг хориглох зэрэг нэмэлт арга хэмжээг авах асуудлыг бодолцож үзэж болох юм. Цаашлаад оролцогч улс дотоодын хууль тогтоомжийнхоо зарчимд нийцүүлэн татварын хууль болон өрсөлдөөний хуулийн хүрээнд арга хэмжээ авах боломжийг анхаарч үзэх хэрэгтэй.

Конвенцийн 35 дугаар зүйлийн агуулга, бүтэц болон хэрэгжүүлэх шаардлагын талаар илүү мэдээлэл, дүн шинжилгээ олж авахыг хүсвэл Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний байгууллагын Конвенцийг хэрэгжүүлэх Эрх зүйн удирдамжийн холбогдох хэсгийг харна уу.

36 дугаар зүйл: Эрх бүхий тусгай байгууллага

Оролцогч улс бүр хууль сахиулах замаар авилгатай тэмцэх эрх бүхий тусгай байгууллага, байгууллагууд буюу этгээд ажиллуулах явдлыг эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн байлгах явдлыг хангана. Эдгээр байгууллага, байгууллагууд буюу этгээдийг чиг үүргээ үр дүнтэйгээр, аливаа зүй бус нөлөөллөөс ангид биелүүлэхэд шаардлагатай хараат бус байдлаар оролцогч улс эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн хангана. Эдгээр байгууллага буюу байгууллагуудын ажилтнуудыг үүргээ биелүүлэхэд нь шаардлагатай зохих сургалтад хамруулж, зохих эх үүсвэрээр хангана.

I. Ерөнхий тойм

Цөөнгүй улс энэхүү конвенцийн 6 дугаар зүйлд заасан шаардлагын дагуу авлигатай тэмцэх нэгж (АТН) байгуулж, боловсрол олгох, мэдлэг дээшлүүлэх, уялдаа холбоо тогтоох зэрэг урьдчилан сэргийлэх арга хэмжээнээс авахуулаад мөрдөн байцаах, яллах ажиллагааг хамарсан өргөн хүрээний бүрэн эрхийг тэдэнд олгосон. Бусад оролцогч улсад ийм чиг үүргийг тодорхой тооны агентлаг хооронд хуваарилж, мөрдөн байцаах, яллах ажиллагааг хууль сахиулах байгууллагуудад хариуцуулсан байна.

Энэ зүйлд мөрдөн байцаах болон магадгүй прокурорын чиг үүрэг зэрэг хууль сахиулах асуудалд голлон төвлөрөх байгууллага буюу этгээд байх зайлшгүй шаардлагатай гэж заасан байгаа. Гэхдээ хэдийгээр тодорхой шаардлагаас нь хамааран байгууллагын хамгийн зөв тогтолцоог нэвтрүүлэх тал дээр оролцогч улсыг чиглүүлэхтэй холбоотойгоор журмын болон нөөцийн тухай асуудал үүсч болох ч энэхүү зүйлээр байгууллагын тодорхой хэлбэрийг зааж өгөөгүй.

36 дугаар зүйл нь заавал биелүүлэх зүйл юм. Гэхдээ конвенцоор зөвхөн хамгийн доод түвшний жишгийг л тогтоож байгаа гэдгийг мөн энэхүү зүйлийн шаардсныг дотоодын онцгой нөхцөл байдалдаа тааруулан өөрчлөх боломжийг олгох байдлаар үзэмжээрээ шийдэх эрхийг ч бас оролцогч улсад олгож байгаа гэдгийг анхаарч үзвэл зохино.

II. Бэрхшээл ба шийдэл

Дараах асуудлыг шийдвэрлэх шаардлагатай:

- Тусгай байгууллагын төрөл ямар байх;
- Нэмэлт ашиг ба үүрэг;
- Хараат бус байдал ба нөөц.

III.1. Тусгай байгууллагын төрлүүд

Хууль сахиулах асуудал дээр онцгой анхаарал хандуулна гэж тооцон, оролцогч улс дан ганц авлигын асуудлыг хариуцах тусгай байгууллага бий болгох болон цагдаа, прокурорын байгууллага буюу шүүхийн угаас байгаа бүтцийн хүрээнд тусгай мэргэжлийн үйл ажиллагаа явуулах гэсэн хоёр хувилбараас сонголтоо хийж болно.

Ийм үзэмжээрээ шийдэх эрх мэдэл өгөгдсөн оролцогч улс байгууллагын загварыг шууд хуулбарлах буюу импортлох амаргүй гэдгийг бодолцон дотоодын нөхцөл байдалдаа нарийн үнэлэлт өгөх шаардлагатай. Гэхдээ энэ нь тухайн улсын бүтцийн асуудалд зөрчил үүсгэхгүй байвал зохино. Иймээс юун түрүүнд дотоодын нөхцөл байдлаа цогц байдлаар үнэлэх хэрэгтэй болж байгаа юм. Энэ нь нэг талаас гарч буй авлигын хэргийн цар хүрээ, нөгөө талаас тухайн улсын зүгээс тэр байгууллагыг хангаж чадах нөөцийн хэмжээтэй холбоотой болно. Конвенцийн 6 дугаар зүйлтэй холбоотойгоор энэхүү удирдамжид дурдсанчлан шинэ байгууллага байгуулах болон тодорхой агентлагийн хүрээнд авлигатай тэмцэх үйл ажиллагаа явуулахад давуу тал

болоод сул талууд бий. Оролцогч улс энэ зүйлд дурдсан тусгай байгууллага буюу байгууллагуудын давуу тал нь авлигатай тэмцэх ажилд хөдөлгөгч хүч бий болох мөн энэ ажлыг хариуцсан байгууллагатай болох явдлаас гадна ийнхүү энэ ажилд чиглэсэн байгууллага байснаар илүү үр дүнтэй байдлаар авлигатай тэмцэх боломж юм. Нөгөөтэйгүүр өртөг, институцийн саад бэрхшээл, уялдаа холбоо тогтоох, тусгаар байдлаас шалтгаалан хязгаарлагдмал хариу үйлдэл хүлээж авах, авлигатай тэмцэх ажилд урьд нь оролцсоор ирсэн байгууллагын хүчийг сулруулж байгаа сэтгэгдэл төрүүлэх зэрэг сул тал үүсч болно.

Нэг эсвэл нэгээс илүү тооны байгууллагатай байх талаар шийдвэр гаргахад хууль тогтоомжийн хамрах хүрээ, мэдээлэх орчин, эрх бүхий байгууллага хоорондын харилцаа, төсвийн нөхцөл, прокурор болон шүүхийн хүчин чадал, улс төрийн хам хүрээ зэрэг асуудлыг шийдвэрлэх авлигатай тэмцэх үндэсний цогц стратегийг боловсруулсан байдлыг харгалзан үзнэ.

Конвенцийн 5 дугаар зүйлийг хэрэгжүүлэх талаар энэхүү удирдамжийн харгалзах бүлэгт дэлгэрэнгүй байдлаар өгүүлсэн тийм стратегийг боловсруулснаар аль хэлбэрийн авлигыг илүү чухалчилж үзэх талаархи үнэлгээнд үндэслэсэн шийдвэр гаргахад бодлого боловруулагчид хялбар болж өгөх юм. Бодлого болосруулагчид хууль сахиулахад зориулах нөөцийг “эзлэх хувь өндөртэй” авлигатай (замын цагдаа, тусгай зөвшөөрөл бүхий албан хаагч гэх мэт) эсвэл “үнийн дүн өндөртэй” авлигатай (бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээ гэх мэт) тэмцэхэд эсвэл энэ хоёрыг хослуулсан байдлаар авлигатай тэмцэхэд зарцуулах эсэх талаар шийдвэр гаргана. Цаашлаад оролцогч улс шаардсан үүргийг биелүүлэх тухайд одоогийн хууль сахиулах байгууллагын давуу тал хийгээд сул талыг тооцож үзэхийг хүсч болно.

Оролцогч улс 36 дугаар зүйл хууль сахиулах тал дээр мэргэшсэн байх явдлыг онцгойлон авч үзэж байгааг анхаарч үзэж болно.

Олон улсын туршлагаас харвал тусгай АТН байгуулахын цаад хөдөлгөгч хүч нь одоо байгаа хууль сахиулах байгууллагын хараат бус байдлын асуудал болон тэдний ажлын талаархи олон нийтийн санааг зовоосон асуудал юм гэдгийг оролцогч улс бодолцож үзвэл зохино. Цаашлаад шинэ, тусдаа АТН байгуулснаар энэ нь авлигатай тэмцэх тал дээр “цоо шинэ эхлэл”-ийн дохиог өгч, хууль сахиулах урьдын байгууллагад итгэх олон нийтийн итгэл бий болох хүртэл цаг хугацааны хувьд холбогч гүүр болж чадна. Эцэст нь шинэ, тусдаа АТН байгуулснаар үйл явц, амжилт болон доголдлыг үнэлэх тал дээр нарийн тодорхой байдлыг баталгаажуулж болох юм.

Гэхдээ АТН байгуулах нь мөн сөрөг үр дагавар дагуулна. Ийм байгууллагыг байгуулахад нилээдгүй хөрөнгө шаарддаг. Түүнчлэн энэ шинэ байгууллага нь өргөн хүрээний чиг үүрэг гүйцэтгэж чадах эсэх талаарч асуудал үүснэ. Үүнээс гадна ялангуяа жижиг бөгөөд хөгжиж буй орнууд “оюуны дайжил”-ын асуудалд зохих байдлаар анхаарал хандуулах шаардлага гарч болох юм. Шинээр тусдаа байгууллага бий болгоход хууль сахиулах байгууллагын туршлага бүхий мэргэжилтнүүдээс удирдлагаа бүрдүүлэх шаардлага үүсэх тул дээрхи хүмүүсийг ажилд авах буюу өөр ажилд томилох нь бусад хууль сахиулах байгууллагын чадамжид нөлөөлж болно. Илүү чухал нь ийм хүмүүс, тэдний ур чадвар, эрх мэдлийг нэг дор төвлөрүүлснээр агентлаг хооронд өрсөлдөөн бий болж гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлж болохыг оролцогч улс анхаарч үзвэл зохино.

Тусдаа АТН байгуулснаар мэргэжсэн бөгөөд мэргэшсэн байдал, шаардлагатай эрх мэдэл зэрэг давуу талыг бий болгох өөр нэг арга нь өөрийн хүчин чадлыг сайжруулахад шаардлагатай нөөц бүхий тусгай нэгжийг одоогийн хууль сахиулах байгууллага дотор бий болгох юм.

II.2. Тусгай байгууллагын ач холбогдол ба үүрэг роль

Тусдаа бие даасан байгууллага эсвэл хууль сахиулах байгууллагын хүрээн дэх тусгай нэгжийн нэмэлт ашиг болон үүргийг оролцогч улс нарийн үнэлж үзэх хэрэгтэй. Авлига болон санхүүгийн ноцтой бөгөөд нарийн төвөгтэй гэмт хэргийг нэгэн дор үр дүнтэйгээр шалгахын тулд тусгай байгууллагад эд материалын болон үйл ажиллагааны зохих орчинг бүрдүүлсэн байх шаардлага бий болно. Ийм орчны хүрээнд тусгай байгууллагад бичиг баримт болон бусад холбогдох мэдээлэл, нотлох баримтыг гаргаж ирэх; санхүүгийн тайланг олж авах; хөрөнгийн хөдөлгөөнийг хязгаарлах, хураах тусгай эрх мэдэл олгоно. Тусгай байгууллага нь үүргээ биелүүлэхийн тулд мөн санхүүгийн болон гэмт хэргийн мэдээлэл олж авах, эрүүгийн байцаан шалгах, яллах ажиллагаа явуулах, иргэний хөрөнгө буцааж олгох эрх мэдлийг шаарддаг.

Авлигатай болон магадгүй бусад санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх тусгай байгууллага байгуулах болон түүнд эрх мэдэл олгохтой холбоотой хууль зүйн хүрээний шинэтгэлийг эрүүгийн шүүхийн цогц шинэтгэлийн ажлын хүрээнд хэрэгжихүйц байдлаар төлөвлөх учиртай. Авлига, мөнгө угаах зэрэг тусгай хэргийг тусад нь уялдаа холбоогүй байдлаар шийдэх шаардлагатай байдаг тул зөвхөн нэг төрлийн гэмт хэрэгт чиглэсэн уялдаа холбоогүй шинэтгэл нь угаас бага нөөцийг улам бүр үрэгдүүлнэ. Энэ бүлэгт өгүүлсэн шинэтгэл нь хэрэв тэдгээр нөөцийн болон үйл ажиллагааны талаархи эрүүгийн хуулийн хэсгийг хянах, шинэчлэх, гэмт хэргийг мөрдөн шалгах, яллах, үүнд шүүхийн шийдвэр гаргахад үүрэг бүхий байгууллагын удаан хугацааны хөтөлбөрийн нэг хэсэг болвол илүү үр нөлөөтэй хэрэгжих болно. Энэхүү конвенц болон бусад гэрээнд заасан олон улсын үүрэг нэмэгдэж байгаатай холбоотойгоор улс орон бүрт ийм хөтөлбөрийн хэрэгцээ одоо улам бүр өсч, зайлшгүй шаардлагатай болоод байгаа юм.

II.3. Хараат бус байдал ба материаллаг нөөц боломж

Тусгай байгууллагыг байгууллагын хэлбэрээс үл хамааран үр нөлөөтэй байлгахын тулд оролцогч улс хараат бус байдал, мэдээлэх орчин, нөөцөөр хангах хуулийн болон үйл ажиллагааны хам хүрээ зэргийг харгалзан үзэхийг хүсчболно.

Тусгай байгууллагын хараат бус байдлыг хууль тогтоомжоор зохицуулах бөгөөд дээд удирдлагатай холбоотой ажилд авах, томилох, сахилгын арга хэмжээ авах, ажлаас халах шалгуурыг тодорхой зааж өгнө. (Боломжит нэг загвар нь шүүхийн байгууллагыг зохицуулж буй болзол нөхцлийг дагахболно). Оролцогч улс ажилд томилох асуудал дээр гүйцэтгэгчээс хараат байдал үүсэхээс зайлсхийхийн тулд урьдаас тогтоосон нөхцлөөр ажилд томилох боломжийг авч үзэхийг хүсч болно. Боловсон хүчнийг ажилд авах талаар болон байгууллагын чиг үүргийн гүйцэтгэлийн тал дээр тусгай байгууллагын тэргүүний үүрэг хариуцлагыг хууль тогтоомжоор шийдсэн байх хэрэгтэй.

Зүй бус нөлөөллөөс зайлсхийхийн тулд итгэж болохуйц дотоод буюу гадаад хяналтын тогтолцоог нэвтрүүлэх байдлаар илүү баталгаажсан байдал бий болгож болох юм. Энэ тал дээр оролцогч улс хууль тогтоох байгууллага дотроо ийм хяналтыг хариуцах мэргэжлийн хороо байгуулсан зарим улсын туршлагаас санаа авч болно. Бусад улс гадаад хяналт буюу мөрдөн шалгах хороог байгуулсан байдаг.

Эрүүгийн мөрдөн шалгах болон байцаан шийтгэх ажиллагааны явцад зүй бус нөлөөллөөс хамгаалах нь чухал ач холбогдолтой. Зарим улсад тусгай байгууллага нь тодорхой хэргийг мөрдөн байцаах ажиллагааг эхлүүлэхдээ Ерөнхий прокурор, Хууль зүйн яам зэрэг дээд байгууллагад мэдээлж байх үүрэг хүлээдэггүй. Нөгөөтэйгүүр олон оронд тодорхой хэрэгтэй холбоотой шүүх ажиллагааг эхлүүлэхийн тулд зөвшөөрөл шаардлагатай болдог бөгөөд энэ тохиолдолд ийм эрх мэдэл нь тусгай хяналтын дор байх хэрэгтэй эсэхийг тооцож үзэх шаардлагатай юм. Зарим улс оронд мөрдөн байцаах ажиллагааг явуулж буй албан тушаалтан, прокурор, мөрдөн байцаагч-шүүгчид хэргийг хэрэгсэхгүй болгох заавар өгөхийг хориглодог.

Тусгай байгууллагад жил бүр тухайн үед шүүгдэж буй баривчилгаа явагдсан хэргүүдийн хураангуйг багтаасан тайлангаа хэвлэн нийтэлж байхыг хуулиар үүрэг болгосон байх бөгөөд байгууллага энэ тайлангаа хууль тогтоох байгууллагад өргөн барина. Хууль тогтоох байгууллага, тусгай байгууллагын ажил, гүйцэтгэлд үнэлэлт өгөхөөр хяналтын байгууллагын удирдлагыг дуудах албан эрх мэдэлтэй байна.

Тусгай байгууллагын тэргүүнийг томилох асуудлаас гадна оролцогч улс боловсон хүчний хөдөлмөр эрхлэлтийн зохих журмыг тогтоох асуудлыг анхаарч үзвэл зохино. Үүнээс гадна оролцогч улс сүрдүүлгээс сэргийлэхийн тулд иргэний нэхэмжлэлтэй холбоотойгоор чиг үүргийн зохих дархан эрхийг олгон мэргэжлийн хараат бус байдлыг бэхжүүлэх боломжийг анхаарч үзэж болох юм.

Түүнчлэн боломжит хамгийн сайн мэргэжилтнийг ажилд авах мөн тогтвортой ажиллуулах явдлыг хангах зорилгоор тусгай байгууллагад зохих цалин хөлсний тогтолцоог нэвтрүүлэхэд оролцогч улс анхаарал хандуулахыг хүсч байж болно. Зохих байдлаар сургалтад хамруулах тухайд, авлигатай тэмцэх талаар мэргэших гэж буй мөрдөн байцаагч, прокурор, шүүгч нь авлигын хэргийг мөрдөн байцаахад мэргэшихээсээ өмнө ерөнхий мөрдөн байцаах ур чадварын хувьд сайтар бэлтгэгдсэн байвал зохино. Конвенцид тодорхой арга хэмжээг заагаагүй ч оролцогч улс зарим улс орны хэрэгжүүлж ирсэн тодорхой загваруудыг анхаарч үзэж болох юм:

- Шууд гүйцэтгэх арга хэмжээнд оролцож буй туршлагатай, итгэл хүлээсэн мөрдөн байцаагчдын зүгээс сургалтыг явуулах. Эрх бүхий байгууллагын ажилд оролцох магадлалтай хүн бүрийг үүн дотор шүүгчдийг сургалтад хамруулах боломжтой байх.
- Сургалтын хөтөлбөрт аудитор, татварын хуулийн мэргэжилтэн, удирдлагын мэргэжилтнийг оролцуулах. Үүнээс гадна мэргэжлийн ёс зүйн лекцийг сургалтын хөтөлбөрт багтаах асуудлыг оролцогч улс тооцож үзнэ.
- Дотооддоо болон улс хооронд томилолтоор явуулах, боловсон хүчин солилцох.

Сургалтаар хангаж чадах мэргэжилтнийг авч ажиллуулахыг юун түрүүнд зорих хэрэгтэй. Сургалт шаардлагатай хэт олон мэргэжлийн талбарт мэргэших нь ховор мөн өндөр өртөгтэй байж болохыг анхаарч үзвэл зохино. Хөгжиж буй орнуудын хувьд UNODC болон бусад ханган нийлүүлэгч байгууллагын шугамаар техникийн туслалцаа авч болох юм.

Оролцогч улсын хэрэгжүүлж буй стратеги болон хяналт нь тусгай байгууллагад шаардлагатай төсвийг тодорхойлно. Оролцогч улс гэхдээ тогтоосон төсвөөс хэтэрсэн тусгай хэрэг болон нарийн төвөгтэй лавлагаанд нөөц хуваарилах боломжийг тооцож үзэх хэрэгтэй. Ер нь оролцогч улсын төсөв нь зөвхөн хэмжээний тухай асуудал биш мөн төлөвлөх тухайд ч анхаарах хэрэгтэйг бодолцож үзнэ.

37 дугаар зүйл: Хууль сахиулах байгууллагатай хамтран ажиллах

1. Оролцогч улс бүр энэхүү конвенцийн дагуу тогтоосон гэмт үйлдэлд оролцож байгаа буюу оролцсон этгээдүүдийг мөрдөн шалгах, баримт нотолгоо цуглуулах зорилгоор эрх бүхий байгууллагад мэдээлэл өгөх, гэмт хэрэг үйлдэн уг гэмт үйлдлээс орлого олохыг нь таслан зогсоох, тийм орлогыг нөхөн төлөхөд бодит, тодорхой тусламжийг эрх бүхий байгууллагад үзүүлэхийг хөхүүлэн дэмжих зохих арга хэмжээг авна.

2. Оролцогч улс бүр энэхүү конвенциор тодорхойлсон гэмт үйлдлийг мөрдөн шалгах буюу яллахад идэвхтэй хамтран ажиллаж буй яллагдагч шаардлагатай тохиолдолд ялаа хөнгөрүүлэх боломжтой байх асуудлыг авч үзнэ.

3. Оролцогч улс бүр энэ конвенциор тодорхойлсон гэмт үйлдлийг мөрдөн шалгах буюу яллахад идэвхтэй хамтран ажиллаж буй этгээдийг шаардлагатай тохиолдолд ялаас чөлөөлөх давуу боломж олгох асуудлыг авч үзнэ.

4. Эдгээр этгээдийн хамгаалалтыг харилцан адилгүй нөхцөл байдлыг харгалзан (mutatis mutandis) энэхүү конвенцийн 32 дугаар зүйлд заасны дагуу зохицуулна.

5. Нэг оролцогч улсад оршиж буй энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан этгээд нөгөө улсын эрх бүхий байгууллагатай идэвхтэй хамтран ажиллах боломжтой тохиолдолд нөгөө улсаас энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт дурдсан хөнгөлөлтийг олгох талаар холбогдох улсууд дотоодын хуулийнхаа дагуу хэлэлцээр байгуулах буюу тохиролцоо хийх асуудлыг авч үзнэ.

I. Ерөнхий тойм

Авлигын хэргийг илрүүлэх, мөрдөн байцаах, шүүх явдлыг дэмжихэд чиглэсэн хэд хэдэн заалт энэхүү конвенцид орсон байгаа. Авлига нь өөрөө нууц байдлаар үйлдэгддэг далд хэлбэрийн гэмт хэрэгт тооцогддог тул үүнийг илрүүлэх хамгийн шилдэг арга зам нь тухайн авлигын гэмт хэрэгт оролцсон буюу гэрч болох этгээдээс мэдээлэл авах байдаг. Тиймээс хууль сахиулах байгууллагад бусад тохиолдолд нууц байдалтай үлдэх тэрхүү мэдээллийг илчлэх, дамжуулах тал дээр гэмт хэрэгт оролцогчийг дэмжиж өгөх арга замыг олж тогтоох шаардлага үүснэ. Конвенцид ийнхүү хамтран ажиллах нь ял хөнгөрүүлэх, яллахаас чөлөөлөгдөх дархан эрх

олгох зэрэг тодорхой зардал шаарддаг гэдгийг дурдсан. Конвенцийн хөрөнгө нөхөн олголт болон олон улсын хамтын ажиллагаанд төвлөрсөн байдлыг харгалзан үзээд 37 дугаар зүйлд гэмт хэрэгтний гэмт хэргээс орлого олохыг таслан зогсоож, тийм орлогыг нөхөн төлүүлэхэд гэмт хэрэгт оролцогчдын зүгээс тусламж үзүүлэхийг хөхиүлэн дэмжих талаар авах арга хэмжээг багтаасан байгаа (1 дүгээр хэсэг). Энд мөн мөрдөн байцаах буюу шүүх ажиллагаа явагдаж буй улсаас өөр улстай хамтран ажиллаж буй тохиолдолд хамаарах тийм урамшууллыг багтаасан байдлаар оролцогч улсууд хооронд гэрээ байгуулах, тохиролцох боломжоор хангах олон улсын дэмжлэгийн талаар заалт багтсан байна (5 дугаар хэсэг).

II. Бодит бэрхшээл ба шийдэл

37 дугаар зүйл заавал биелүүлэх шаардлагатай болон заавал биелүүлэх албагүй заалтуудыг багтаасан байна.

Заавал биелүүлэх шаардлагатай заалтын хувьд 37 дугаар зүйлд оролцогч улс бүр энэхүү конвенцийн дагуу тогтоосон гэмт хэргийг үйлдэхэд оролцсон хүмүүсийг мөрдөн байцаах ба баримт нотолгоо цуглуулах зорилгоор эрх бүхий байгууллагад мэдээлэл өгөх болон гэмт хэрэгтнийг гэмт хэргээс орлого олохоос таслан зогсоож, тийм орлогыг нөхөн төлөхөд хувь нэмэр болох бодит, тодорхой тусламжийг эрх бүхий байгууллагад үзүүлэхийг хөхиүлэн дэмжих талаар зохих арга хэмжээг авна гэж заасан байна.

Түүнчлэн 37 дугаар зүйл эдгээр этгээдийн хамгаалалтыг *mutatis mutandis* энэхүү конвенцийн 32 (4) зүйлд заасны дагуу зохицуулахыг оролцогч улсад үүрэг болгосон байгаа.

Энэ санаа нь зохион байгуулалттай гэмт хэргийг шийдэж ирсэн хууль сахиулах байгууллагуудын туршлагаас урган гарч ирсэн юм. Гэрчтэй хамтран ажиллах болон ийм хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжих нь хууль сахиулах байгууллагад зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэглэлийн ихэнхдээ олон давхраатай буюу олон салаалсан бүтцэд нэвтрэх, түүнийг ойлгох, шийдэх тал дээр үр ашгаа өгдөг нь батлагдсан билээ. Ихэнхи тохиолдолд ийм туршлагыг авлигын хэргийг шийдэхэд үр дүнтэйгээр хэрэглэж болох юм.

II.1. Холбогдох мэдээлэл

Эдгээр этгээдийн өгсөн мэдээлэл нь хэргийг мөрдөн байцаах, яллах, хэрэгт шүүхийн шийдвэр гаргахад мөн авлигаас олсон орлогыг зохих байдлаар нөхөн төлүүлэхэд хэрэгтэй бөгөөд үүнтэй холбоотой байвал зохино.

Оролцогч улс гэмт хэрэгтнийг гэмт үйлдлээс орлого олохыг нь таслан зогсоож, тийм орлогыг нөхөн төлөхөд хувь нэмэр болох бодит, тодорхой тусламжийг үзүүлэхийг хөхиүлэн дэмжих талаар зохих арга хэмжээг авна. “Бодит, тодорхой тусламж” гэдэгт бодит тусламж болон мэдээллийн аль алийг хамруулж ойлгох учиртай.

Эдгээр арга хэмжээний талаар мэдээллийг олон нийтэд нээлттэй байлгаж, олон нийтийн дэмжлэгийг олж авах зорилгоор соён гэгээрүүлэх хөтөлбөрт багтаасан байх явдлыг оролцогч улс тооцож үзвэл зүйтэй.

II.2. Ялыг хөнгөрүүлэх

Илүү хөнгөн ял ногдуулах, буюу ялыг илүү зөөлөн байдлаар хэрэгжүүлэх боломжоор хангах замаар оролцогч улс “ял хөнгөрүүлэх” заалтыг хэрэгжүүлж болох юм. Үүний дагуу оролцогч улс ял хөнгөрүүлэхэд дараах 2 загварыг бодолцож үзэж болно:

- Юун түрүүнд шүүх хурал буюу шүүгчдийн зүгээс ер нь тухайн тохиолдолд ногдуулдаг ялаас хөнгөрүүлсэн байдалтай ял ногдуулж болно. Жишээ нь шүүх хурал буюу шүүгчдийн зүгээс шоронд хорих ялыг мөнгөн шийтгэлээр солих боломжийг авч үзэж болох юм.
- Хоёрдугаарт шүүхийн шийдвэрийн дараа, ял эдэлж байх хугацаанд ялыг бодит байдлаар хөнгөрүүлж болно. Энэ загварт хугацаанаас нь өмнө суллах, тэнсэн суллах зэрэг урамшуулал багтаж болно.

Үйл ажиллагаандаа тохирох байдлаар оролцогч улс дараах хэд хэдэн сонголтоос шийдвэр гаргаж болно:

- Шударга байх зарчмыг харгалзан ялыг хөнгөрүүлэх саналыг шүүх буюу прокурорын байгууллагын зүгээс урьдаас хүлээн зөвшөөрсөн байх тийм байцаан шийтгэх ажиллагааг явуулах асуудлыг оролцогч улс тооцож үзнэ. Үүнд оролцогч улс ялыг хөнгөрүүлэх саналыг шүүхэд албан байдлаар тавихыг эрүүгийн хуулиндаа заалт болгон оруулсан болно.
- Гэхдээ оролцогч улс “ялыг хөнгөрүүлэх” гэдэг нь зөвхөн урьдаас тодорхойлсон ял хөнгөрүүлэх заалтыг биш мөн ялыг тухайн хэрэг бүр дээр *de facto* (бодитоор) хөнгөрүүлэх явдлыг ч багтаадаг гэдгийг санаж байвал зохино. Иймээс үүнийг зөвшөөрдөг эрх зүйн тогтолцоо бүхий оролцогч улс ялыг хөнгөрүүлэх тухай заасан тусгай дүрэм нэвтрүүлэхгүй байж болох ч урьдаас тогтоосон хүрээнд ял тохиролцож байхыг хууль сахиулах байгууллагадаа зөвлөх хэрэгтэй. Үүнээс гадна оролцогч улс хөнгөрүүлсэн ял ногдуулж болох гэмт хэргийг тодорхой тогтоож хязгаарлалт тавих байдлаар ялыг өөрчлөх прокурорын газар байгуулж болох юм. Гэхдээ шүүхийн хараат бус байдлыг харгалзан үзэж оролцогч улс шүүхийн шийдвэр гарахаас өмнө хэргээ хүлээн зөвшөөрөх хэлэлцээр байгуулахад шүүхийг оролцуулсан байх явдлыг анхаарч үзэх хэрэгтэй болно. Ийм байцаан шийтгэх ажиллагаатай холбоотойгоор ялыг хөнгөрүүлэх нөхцөл болзлыг заасан бөгөөд бүх талаас гарын үсэг зурсан бичмэл гэрээг шаардах асуудлыг оролцогч улс бодолцоно.
- Оролцогч улс ялангуяа олон нийтийн тусгаж авч буй тэр байдлыг харгалзан шүүхийн эрх тэгш байдал болон гэмт хэрэгтний ял шийтгэлд хөнгөлөлт эдлэх тухайд

тэнцвэрийг тогтоох шаардлагыг анхаарч үзвэл зохилтой. Тиймээс ял хөнгөрүүлэхэд идэвхтэй хамтран ажиллахтай холбож үзэх хэрэгтэй. Гэхдээ идэвхтэй хамтран ажиллах гэдэг нь тэр мэдээдэл байхгүй бол мөрдөн байцаах, шүүхийн шийдвэр гаргах ажиллагаа явуулах боломжгүй байх тийм мэдээллийг шаардах гэсэн утгатай биш гэдгийг оролцогч улс бодолцож үзвэл зохино. Нөгөөтэйгүүр авлигын хэрэгтэй холбоотой гол мэдээлэл нь ялыг хөнгөрүүлэх шалтгаан болох тийм өргөн хүрээний хэрэгжилтийг оролцогч улс сонгож болох юм. Энэ тохиолдолд оролцогч улс ялын хөнгөлөлтийн хэмжээг хамтын ажиллагааны цар хүрээ болон чанарт хамааруулж болно.

- Оролцогч улс ял хөнгөрүүлэх болзлыг зөвхөн хамтын ажиллагаанд биш, мөн гэмт хэргийн ноцтой байдал, яллагдагч этгээдийн гэм буруутай байдалд хамааруулж болно. Тиймээс ялын хөнгөлөлт нь авлигын томоохон хэрэг болон хамтран ажиллаж буй этгээдийн ноцтой буруутай үйлдэл зэрэг тохиолдолд үйлчлэхгүй байж болох юм.

II.3. Ялаасчөлөөлөх

Энэхүү зүйлд идэвхтэй хамтран ажиллаж буй яллагдагч этгээдэд яллагдахаас чөлөөлөгдөх дархан эрх олгох боломжийг зохих тохиолдолд олгох асуудлыг авч үзэхийг оролцогч улсад санал болгосон байна. Оролцогч улс үүнийг хэрэгжүүлэх тал дээр дараах хоёр загварыг бодолцож үзэж болох юм:

- Юун түрүүнд оролцогч улс дархан эрх олгох боломжийг заасан шинэ хууль тогтоомж баталж болно. Энэ нь эрх зүйн тогтолцоонд албан яллах ажиллагаанд үйлчлэх байдлаар тусч болно.
- Хоёрдугаарт, прокурор нь хэргийг яллахгүй байх талаар үзэмжээрээ шийдвэр гаргах эрхтэй байдаг улс орон идэвхтэй хамтын ажиллагаа нь прокурорын үзэмжээрээ шийдэх эрх мэдлийн хүрээнд дархан эрх олгох явдлыг зөвшөөрөх шалтгаан болох талаар хууль сахиулах байгууллагадаа зөвлөж болно.

Хэргийг гол гэрчийн тусламжгүйгээр шүүхэд шилжүүлэх боломжгүй тохиолдолд дархан эрх нь гол гэрчийг хамтын ажиллагаанд татан оруулах хүчтэй түлхэц болж болох юм. Нөгөөтэйгүүр ял шийтгэлээс бүрэн чөлөөлөх арга замыг хэт их хэрэглэж байгаа бол эсвэл олон нийт тухайн дархан эрх нь улс төр болон санхүүгийн нөлөө бүхий этгээдэд олгогдож байна гэж үзвэл авлигатай тэмцэх үйл ажиллагааны үнмшилтэй байдлыг сааруулдаг. Тиймээс оролцогч улс тодорхой хэргийг шийдэхэд дархан эрх олгохын ач холбогдол болоод шүүхийн шийдвэрийн эрх тэгш байдалд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх хэрэгцээ хоёрын хооронд тэнцвэр тогтоох шаардлагыг хэлэлцэж үзнэ.

Ялаас чөлөөлөх эрх олгох эсэх нь дан ганц хамтын ажиллагааны цар хүрээ болон чанараас хамаарахгүй байж болно. Үүнээс илүүтэйгээр хууль сахиулах байгууллага тухайн этгээдийн хувийн шинж чанар болон тэрхүү гэмт хэрэгт оролцсон байдлыг харгалзан үзэх шаардлагатай болно. Жишээ нь оролцогч улс авлигын гэмт хэргийн сүлжээний гол толгойлогчид дархан эрх

олгохоос татгалзаж болно. Түүнчлэн улс төрч гэх мэт өндөр эрх ямба бүхий яллагдагч этгээдэд дархан эрх олгох нь хууль сахиулах байгууллагад итгэх олон нийтийн итгэлд сөрөг нөлөө үзүүлдэг болохыг анхаарах хэрэгтэй.

Цаашлаад тэр мэдээлэлгүйгээр мөрдөн байцаах, шүүхийн шийдвэр гаргах ажиллагааг явуулах боломжгүй тийм мэдээллийг яллагдагч этгээд өгсөн байх онцгой тохиолдолд л дархан эрхийг олгох сонголтыг оролцогч улс хийж болно.

Байцаан шийтгэх ажиллагаатай холбоотойгоор оролцогч улс чухал ач холбогдол бүхий дараах зүйлийг анхаарч үзэх хэрэгтэй байж болно:

- Ялаасчөлөөлөх эрх олгох тухай шинэ хууль тогтоомж гаргаж буй оролцогч улс хуулийн хүрээнд яв цав бөгөөд маргашгүй нөхцөл болзлыг зааж болно.
- Оролцогч улс мөн адил хууль тогтоомждоо нэг талаас дархан эрхийн хариуцлага болон урьдчилсан нөхцөл, нөгөө талаас үүний эрх болон ашиг тустай холбоотой аливаа маргаанаас зайлсхийхийн тулд дархан эрх олгох нөхцөл болзлыг тусгасан, бүх талаас гарын үсэг зурж баталгаажуулсан бичмэл гэрээг шаардах асуудлыг авч үзнэ.
- Ялаасчөлөөлөх эрх олгох нь хүчтэй арга хэрэгсэлд тооцогддог тул үүнийг буруугаар ашиглах магадлалыг оролцогч улс анхаарч үзвэл зохино. Тиймээс хууль сахиулах байгууллага дархан эрх олгохоосоо өмнө тэдэнд өгч буй мэдээллийг баталгаажуулахыг хичээх хэрэгтэй. Үүнд тухайн этгээдийн өгсөн мэдээллийг нэмэлт мэдээллээр бататгахад хууль сахиулах байгууллагын зүгээс зохих чармайлтыг үзүүлэх шаардлагатай болно. Үүнээс гадна тухай этгээд хууль сахиулах байгууллагыг буруу тийш чиглүүлэхийг чармайж байгаа тохиолдолд дархан эрхийг цуцлах боломжоор хангавал зохино. Энэ асуудалтай холбоотойгоор тухайн мэдээлэл худал буюу далд санаатай болох нь тогтоогдвол гэрээг хүчингүй болгох тухай зохих заалтыг оролцогч улс дархан эрх олгох тухай гэрээнд оруулж өгсөн байхыг хүсч байж болно.
- Оролцогч улс мөрдөн байцаах ажиллагааны аль шатанд, ямар нөхцлөөр хэний зүгээс тохиролцоо хийхийг санал болгож болох талаар тодорхой удирдамжтай байх асуудлыг бодолцож үзэж болно.
- Оролцогч улс нэг хэрэгт хамаарах дархан эрх нь өөр холбогдох хэрэг буюу ирээдүйд гарч ирэх хэрэгт хамаарахгүй байх тухай зохих заалтыг дархан эрх олгох гэрээнд тусгахыг хүсч болох юм.

II.4. Оролцогч улсууд хооронд гэрээ байгуулах, тохиролцоо хийх

Нэг оролцогч улс дахь яллагдагч нөгөө оролцогч улсад мөрдөн байцаах ажиллагаа явуулж буй хэрэгт холбогдох буюу үүнд хэрэгтэй мэдээлэл буюу нотлох баримтаар хангах боломжтой байж болохыг оролцогч улс тооцож үзнэ. Ялангуяа улс хоорондын авлигын хэрэгт оршин сууж

буй улсдаа одоогоор яллагдаагүй авлигын гэмт хэргийн талаар мэдээлэн илчлэх тал дээр тэдгээр этгээдийг дэмжихэд анхаарч үзэх болно.

Иймээс оролцогч улс өөр оролцогч улсад үйлдэгдсэн авлигын хэрэгтэй холбоотойгоор идэвхтэй хамтын ажиллагааны хариуд хөнгөрүүлсэн ял бүр цаашлаад дархан эрх санал болгохыг оролцогч улсын хууль сахиулах байгууллагад зөвшөөрөх замаар оролцогч хоёр улсын аль алины ашиг сонирхлыг тусгасан шийд олох зорилгоор гэрээ байгуулах буюу тохиролцоо хийх асуудлыг анхаарч үзнэ. Энэ нь дархан эрх олгох тухай одоогийн хүчин төгөлдөр дүрмийг засварлах буюу шинээр дүрэм мөрдүүлэх шаардлагыг бий болгож болох юм.

Тусгай гэрээ байгуулах буюу тохиролцоо хийх нь тухайн үед үргэлжилж буй эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд хохирол учруулах байдлаар цаг хугацаа шаардаж болохыг оролцогч улс харгалзан үзэхийг хүсч байж болно. Иймээс шаардлагатай үед хувь этгээдийн хэрэгт үйлчилж болох байдлаар хамрах хүрээг тогтоох асуудлыг оролцогч улс анхаарч үзэж болох юм.

38 дугаар зүйл: Үндэсний эрх бүхий байгууллага хоорондын хамтын ажиллагаа

Оролцогч улс бүр нэг талаас өөрийн улсын төрийн эрх бүхий байгууллага ба төрийн албан тушаалтан, нөгөө талаас өөрийн улсын эрүүгийн гэмт үйлдлийг мөрдөн шалгах, яллах эрх бүхий байгууллага хоорондын хамтын ажиллагааг дотоодын хуулийнхаа дагуу хөхүүлэн дэмжихэд шаардлагатай байж болох арга хэмжээг авна. Ийм хамтын ажиллагаанд дараахь зүйл багтаж болно:

(а) Энэхүү конвенцийн 15, 21, 23 дугаар зүйлийн дагуу тогтоосон аливаа гэмт үйлдлийг үйлдсэн гэж үзэх үндэслэл байгаа нөхцөлд эрүүгийн гэмт үйлдлийг мөрдөн шалгах, яллах эрх бүхий байгууллагад энэ талаар өөрийн санаачлагаар мэдээлэх; эсхүл

(б) Эрүүгийн гэмт үйлдлийг мөрдөн шалгах, яллах эрх бүхий байгууллагад хүсэлтийнх нь дагуу шаардлагатай бүх мэдээллийг өгөх.

I. Ерөнхий тойм

Энэхүү конвенцийн 15, 21, 23 дугаар зүйл үндэсний төрийн албан тушаалтныг хахуульдах, хувийн хэвшил дэх авлига болон гэмт хэргээс олсон орлогыг угаах талаар тус тус өгүүлсэн байна. Аливаа гэмт хэрэг гарч болзошгүй тохиолдлыг ийм гэмт хэргийг мөрдөн байцаах, яллах эрх мэдэл, мэргэжлийн ур чадвар бүхий байгууллагад эртхэн мэдэгдэх нь гэмт хэрэгтэн тухайн улсаас зугтахгүй байх явдлыг хангах болон нотлох баримтыг засварлах, хөрөнгийг шилжүүлэх явдлаас урьдчилсан сэргийлэх буюу хяналтад авахад чухал ач холбогдолтой юм. Авлигын хэрэг ихэнхдээ нарийн төвөгтэй, далд хэлбэртэй байдаг. Иймээс ч төрийн холбогдох байгууллагад эрт мэдэгдэх болон мөрдөн байцаах байгууллагын хүсэлтийн дагуу хамтран ажиллах нь үйл ажиллагааны нэг сайн хэлбэрт тооцогдоно.

II. Бодит бэрхшээл ба шийдэл

Төрийн байгууллагын дээд удирдлага, төрийн албан тушаалтны зүгээс энэхүү зүйлийн зорилгыг мөн энэ зүйлийг хэрэгжүүлэхэд өөрсдийн хүлээх үүргийг ойлгож байх тал дээр тодорхой шаардлага тавих талаар зохих арга замыг оролцогч улс тооцож үзэхийг хүсч болно. Ийнхүү ойлгож байх явдлыг сургалтын хөтөлбөрөөр мөн төрийн байгууллагын дээд удирдлага, төрийн албан тушаалтан болон мөрдөн байцаах, яллах байгууллага хоорондын тогтмол, зохион байгуулалттай хамтын ажиллагаагаар дэмжиж өгч болох юм. Түүнчлэн холбогдох агентлагт мэдээлж байгаа буюу мэдээлэл хүссэний дагуу хамтран ажиллаж буй дээд байгууллага нь бодитой шалтгаанаар шударгаар ажиллаж байгаа үед өгсөн мэдээлэл нь цаашдын ажиллагааг эхлүүлээгүй тохиолдолд ямар нэг сөрөг үр дагавар гарахгүй гэдэгт итгэлтэй байх боломжоор хангагдана.

Энэхүү зүйлийн дагуу үйлчилж буй аливаа тохиролцоо, хууль тогтоомж буюу дүрэм журамд тухайн гэмт хэргийн үйлдэгдсэн “бодитой шалтгаан”-ыг тодорхой заасан байна.

39 дүгээр зүйл: Үндэсний эрх бүхий байгууллага, хувийн хэвшил хоорондын хамтын ажиллагаа

1. Оролцогч улс бүр үндэсний мөрдөн шалгах, яллах эрх бүхий байгууллага болон хувийн хэвшлийн байгууллага, ялангуяа санхүүгийн байгууллага хоорондын энэхүү конвенцийн дагуу тогтоосон гэмт үйлдлүүдтэй холбоотой асуудлаархи хамтын ажиллагааг дотоодын хуулийнхаа дагуу хөхүүлэн дэмжихэд шаардлагатай байж болох арга хэмжээг авна.

2. Оролцогч улс бүр өөрийн харьяат болон нутаг дэвсгэрт нь байнга оршин суугч бусад этгээд энэхүү конвенцийн дагуу тогтоосон гэмт үйлдлийг үйлдсэн талаар үндэсний мөрдөн шалгах ба яллах эрх бүхий байгууллагад мэдээлж байхыг хөхүүлэн дэмжих асуудлыг авч үзнэ.

I. Ерөнхий тойм

39 дүгээр зүйл хувийн хэвшил ба хувь этгээд төрийн албан тушаалтантай нэг ижил үүрэг хүлээх тал дээр 38 дугаар зүйлийг тусгасан байна. Авлигын хэрэг ихэнхдээ нарийн төвөгтэй, далд хэлбэртэй байдаг. Иймээс ч холбогдох эрх бүхий байгууллагын анхаарлыг татахгүй буюу хувийн хэвшлийн байгууллага үүнд ялангуяа санхүүгийн байгууллага болон хувь иргэний хамтын ажиллагаагүйгээр мөрдөн байцаах ажиллагаа бүрэн гүйцэд явагдахгүй байж болох юм. Тухайлбал хувийн хэвшлийн холбогдох байгууллагаас эрт мэдэгдэх эсвэл мөрдөн байцаах байгууллагатай эртнээс хамтран ажиллах нь нотлох баримтыг таньж тогтоох, хамгаалах болон лавлагааг эхлүүлэхэд чухал. Үүнээс гадна санхүүгийн байгууллагын үүрэг -өндөр үнийн дүн бүхий үйл ажиллагаанд оролцож буй тэдгээр байгууллагын үүрэг- энэхүү конвенцийн дагуу тогтоосон гэмт хэргээс үр дүнтэйгээр урьдчилан сэргийлэх, ийм гэмт хэргийг мөрдөн байцаах, яллахад гол хүчин зүйл болдог. Санхүүгийн байгууллага сэжигтэй үйл ажиллагаа буюу шилжүүлгийг мэдээлж байх үүрэг хүлээх ч энэ нь ямар нэг байгууллагын зүгээс бусад үйл ажиллагаанд жишээлбэл данс нээх тал дээр сэжигтэй хандаж байгаа үед хамтын ажиллагааг хязгаарлана гэж ойлгох учиргүй.

II. Бодит бэрхшээл ба шийдэл

Энэхүү конвенцийг хөхүүлэн дэмжихэд тэдний үүрэг болон энэ зүйлийн зорилгыг хувийн хэвшлийн зүгээс ойлгосон байх явдлыг оролцогч улс хангана. Холбогдох хууль сахиулах агентлагт мэдээлэл өгч хүссэний дагуу хамтран ажиллаж буй хувь этгээд, дээд удирдага болон боловсон хүчин нь бодитой шалтгаанаар мөн шударгаар үйл ажиллагаа явуулж байгаа үед нууцыг хадгалах тал дээр итгэлтэй байж, тэрхүү мэдээлэл нь мөрдөн байцаах ажиллагааг эхлүүлээгүй тохиолдолд мэдэгдэл хийсэн этгээдийн зүгээс иргэний нэхэмжлэл гаргах, мөн хохирол нөхөн төлүүлэхийг шаардах явдлаас цаашид хамгаалагдсан байна.

Аль агентлаг, (туслах чанарын мэдээлэл, баримт бичгийг оролцуулан) мэдээллийг ямар хэлбэртэйгээр хүлээн авах тухай оролцогч улс тодорхой заасан байх шаардлагатай. Өгч буй мэдээллийн ач холбогдлын тухайд мөрдөн байцаах, яллах эрх бүхий байгууллага болон хувийн хэвшлийн байгууллага, ялангуяа санхүүгийн байгууллагын хоорондын харилцааг нэмэгдүүлэх арга замыг оролцогч улс эрэлхийлвэл зохино. Өгч буй мэдээллийн хэлбэр, агуулгын жишиг бий болгох асуудалд хувийн хэвшлийн байгууллага, үүнд ялангуяа санхүүгийн байгууллагыг оролцуулах нь ашигтай байж болох юм. (Энэ тухайд 14 дүгээр зүйлд илүү дэлгэрэнгүй байдлаар авч үзсэн).

40 дүгээр зүйл: Банкны нууцлал

Оролцогч улс бүр энэхүү конвенциор тодорхойлсон гэмт үйлдлийг дотооддоо эрүүгийн журмаар мөрдөн шалгах тохиолдолд дотоодын эрх зүйн тогтолцоонд нь банкны нууцын талаарх хуулийг хэрэглэхтэй холбоотой гарч болох бэрхшээлийг даван туулах шаардлагатай механизм бүрдүүлэх явдлыг хангасан байна.

I. Ерөнхий тойм

Банкны мэдээллийг хамгаалах нь банкны тогтолцоонд эртнээс тогтсон уламжлалын нэг юм. Хувь этгээдийн түвшинд банкны зүгээс зохих байдлаар нууц хадгалах нь хувийн нууцлалын эрхийн, түүнчлэн саяхнаас хувийн мэдээллийн эрхийн нэг хэсэгт тооцогдох болсон билээ. Зарим улсад банкны нууцлал нь сүрдүүлэг буюу хүн хулгайлахаас сэргийлэх тал дээр хүний аюулгүй байдлыг хамгаалах нэг зүйл гэж тооцогддог. Компанийн түвшинд энэ нь шударга бус өрсөлдөөний буюу үл итгэх явдлын тухай хуулийг зөрчихөөс сэргийлж өгнө. Банкны нууцлалыг төрийн бодлогын түвшинд нэвтрүүлснээр итгэл дээр үндэслэсэн банкны тогтолцоо бий болох бөгөөд харилцаанд нууцлалыг эрхэмлэх нь итгэлийг олоход чухал хүчин зүйл болж байна.

Оролцогч улс бүр хууль тогтоомжийнхоо дагуу их бага хэмжээгээр гуравдагч хувь этгээдэд харилцагчийн мэдээллийг задруулахаас татгалзах болон төрийн байгууллагад тодорхой мэдээлэл олж авахыг зөвшөөрөх эрх мэдэл болон үүргийг банканд олгож байна. Оролцогч олон улс оронд мөнгө угаах хэргийг мэдээлэх тухайд нууцлалын шаардлага нь өөрчлөгдсөн бөгөөд 40 дүгээр зүйл эрүүгийн мөрдөн байцаах ажиллагааны тухай асуудлыг өргөн хүрээнд шийдэж байгаа юм.

Оролцогч улсууд банкны нууцлалын хуулийн дагуу тогтоосон хамгаалалтын хувьд өөр хоорондоо харилцан адилгүй. Оролцогч ихэнх улсад банкны нууцлал нь банк болон харилцагч хоорондын гэрээний харилцааны гол хүчин зүйл бөгөөд тиймээс ч үүнийг хувь этгээд болон эзэмшлийн тухай хуулиар зохицуулах асуудал гэж үзэн гэрээг зөрчсөн тохиолдолд иргэний хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авна. Оролцогч бусад улсад банкны мэдээллийг хамгаалах асуудал нь ердөө гэрээний харилцааны зүйл байхаа больж, үүнийг олон нийтийн эрх ашгийн асуудлын хэмжээнд авч үзэх болжээ. Иймээс ч эдгээр улс оронд банкны нууцлалыг зөрчих нь эрүүгийн гэмт хэрэгт тооцогдох болсон байна.

40 дүгээр зүйлд энэхүү конвенцийн дагуу тогтоосон гэмт хэрэгт мөрдөн байцаах ажиллагаа явуулах хамгаалалтын хууль тогтоомж, дүрэм журмаас үүдэн гарч болох аливаа саадыг зайлуулахыг оролцогч улсаас хүссэн байна. Энэ хүсэлтийг конвенцийн сэжиг бүхий шилжүүлгийг мэдээлэх болон оролцогч улс бүр СМН байгуулах талаар тухайн хэсэгт тус тус дурдсан байгаа. Түүнчлэн олон улсын банкны тогтолцооны технологийн хүчин чадлын ачаар улс хоорондын санхүүгийн хөдөлгөөнийг оролцогч улсын ийм хөдөлгөөнийг хянах буюу мөрдөн байцаах байгууллагаас илүүтэйгээр олон улсын банкны тогтолцоогоор зохицуулах боломжтой юм. Энэ зүйлд авлигын хэрэгтэй үр нөлөөтэйгээр тэмцэх зорилгоор дотоодын хууль сахиулах өөр байгууллагад мэдээлэл өгөх мөн мөрдөн байцаах ажиллагааг түргэн шуурхай явуулах ажлыг хангахын тулд банкны нууцлалын нөхцлийг өөрчлөх замаар тэнцвэрийг тогтоох арга замыг эрэлхийлсэн байна.

II. Бэрхшээл ба шийдэл

40 дүгээр зүйлийг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд олон асуудлыг анхаарч үзэх шаардлагатай.

II.1. Хэн , ямар орчин нөхцөлд, ямар зорилгоор банкны нууцлалд нэвтрэх эрх эдлэх тухай

Аль байгууллагад банкны мэдээллийг олж авах эрх мэдэл олгох шийдвэр нь хэд хэдэн хүчин зүйлээс шалтгаална. Иймээс энэ тухайд улс орнуудын хууль тогтоомж нь харилцан адилгүй байдаг.

Улс орон бүрт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон хяналтын бодлогын төлөвлөгдсөн байдал мөн тухайн орны соёл, эдийн засагт банкны нууцлалын гүйцэтгэх үүрэгтэй харьцуулбал энэхүү асуудлыг чухалчилж байгаа байдал нь банкны нууцлалын нэг гол хүчин зүйл юм. Хамгийн багадаа шууд байдлаар буюу шүүхийн зөвшөөрлийн дагуу ажиллагаа явуулж буй прокурор болон бусад шүүхийн байгууллага банкны мэдээллийг олж авах эрхтэй байх ёстой. Бусад тохиолдолд 40 дүгээр зүйлийг мөрдөх боломжгүй.

Гэхдээ банкны мэдээлэл нь авлига болон түүнээс олсон орлогыг угаах хэрэгт нотлох баримтын үүрэг гүйцэтгэж байгаа тохиолдолд оролцогч улс банкны мэдээллийг хууль сахиулах бусад байгууллага олж авах тогтолцоог бий болгох боломжийг тооцож үзнэ. Ийм хандлагыг 14 ба 58 дугаар зүйлд зөвшөөрсөн байгаа. Ийм тогтолцоог бий болгохдоо дараах хүчин зүйлсийг

анхаарч үзнэ: тухайн улсын байгууллагын ерөнхий тогтолцоо ба хууль зүйн уламжлал, энэхүү асуудлыг хариуцсан агентлагын эрх мэдэл ба хараат бус байдлын хэмжээ, албан тушаалтын ур чадвар, (урьдчилан сэргийлэх хяналт шалгалт, нууцлалыг зөрчсөн тохиолдолд авах арга хэмжээ зэрэг) мэдээллийг хариуцлагатайгаар хэрэглэхтэй холбоотой хангалттай хамгаалалт байгаа эсэх.

Шууд буюу шүүхийн байгууллагын зөвшөөрлөөр банкны мэдээллийг олж авах эрх мэдлийг олгож болох хууль сахиулах байгууллагуудын жагсаалтыг дор харууллаа. Тохиолдол болгонд зарим улсын тогтмол үйл ажиллагаатай холбоотойгоор мэдээллийн хэрэглээнд хязгаарлалт тавих байдлыг дурдсан:

- Конвенцийн 36 дугаар зүйлд дурдсан шиг авлигаас урьдчилан сэргийлэх байгууллага, урьдчилсан мөрдөн байцаах ажиллагаа явуулах эрх мэдэлтэй бол, эсвэл эрүүгийн гэмт хэргийн мэдэгдэл гаргах эрх мэдэлтэй бол, эсвэл шүүхэд буруутгагч тал болж байгаа бол банкны мэдээлэл олж авах эрхтэй. Зарим улс эдгээр байгууллагад олгосон банкны мэдээлэл олж авах эрх мэдлийг эрүүгийн хэрэгт нотлох баримт болгон ашиглах явдлаар хязгаарладаг;
- Мөнгө угаах гэмт хэргийг мөрдөн байцаах эрх бүхий СМН-үүд. Олон улс оронд СМН-д олгосон банкны мэдээлэл олж авах эрхийг энэ мэдээллийг мөнгө угаах хэрэгт нотлох баримт болгон ашиглах талаар буюу мөнгө угаахтай тэмцэх тухай хуулиар зохицуулах захиргааны үйл ажиллагаанд хөрөнгө хураах тухай тушаалыг дэмжих баримт болгохоор хязгаарладаг;
- Татвараас зайлсхийх буюу гаалийн дүрэм журмыг зөрчих нь дотоодын хууль тогтоомжийн дагуу эрүүгийн гэмт хэрэгт тооцогддог болон энэхүү олж авсан мэдээллийг бусад байгууллагад дамжуулахгүй тохиолдолд татварын болон гаалийн эрх бүхий байгууллага;
- Цагдаагийн газар;
- Аудитын байгууллага;
- Шүүхийн шийдвэрээр эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд тал болж оролцогчид болон шүүхийн тогтоол гүйцэтгэгчид;
- Урьдчилсан мөрдөн байцаах ажиллагаа явуулах эрх мэдэлтэй бол, эсвэл эрүүгийн хэргийн шийдвэр гаргах эрх мэдэлтэй бол, эсвэл шүүхэд буруутгагч тал болж байгаа бол төв банк.

Олж авсан мэдээллийн хэрэглэх хүрээг тухайн байгууллагын тодорхой чиг үүргээр хязгаарладаг –мөн бусад байгууллагад дамжуулахыг хориглодог- тогтолцоонд нэг ижил мэдээллийг өөр өөр байгууллагад дахин давтан олгох ачаалал болон зардлаас үүдэн ихэнхдээ санхүүгийн байгууллагуудад нилээдгүй дарамт үүсдэг нь ажиглагдсан байна.

II.2. Банкны нууцлалыг цуцлахад ямар журам шаардлагатай вэ?

Дотоодын мөрдөн байцаах ажиллагаанд учруулах саад нь банкны нууцлалын журмын асуудалтай холбоотой байж болно. Олон оронд банкны нууцлалд нэвтрэх боломж ерөнхийдөө байгаа мэт харагддаг ч үнэндээ журмын шаардлага нь энэ боломжийг бараг байхгүй болгох хэмжээний нүсэр, төвөгтэй байж болно.

Мэдээллийг олж авах байгууллага болон энэ мэдээллийг хэрхэн хэрэглэхийг зөвшөөрсөн байдлаас хамаарч оролцогч улсууд банкны мэдээллийг олж авахад журмын дагуу ямар шаардлага тавих тал дээр харилцан адилгүй байна. Зарим улсад хууль сахиулах байгууллагын тушаал хангалттай. Бусад оронд зохицуулагч буюу хяналтын байгууллагын зөвшөөрлийг шаарддаг. Илүү хатуу журам бүхий орнуудад банкны нууцлалыг цуцлахыг зөвхөн шүүхийн шийдвэрийн дагуу зөвшөөрдөг. Мэдээжийм зөвшөөрлийг олж авах жишиг нь тухайн эрх бүхий байгууллагаас хамаарч өөр өөр байна.

II.3. Мэдээллийг шууд эсвэл хүсэлтийн дагуу задлах

Оролцогч улс банк болон бусад санхүүгийн байгууллага нь тодорхой мэдээллийг мэдээллийн санг удирдаж буй тодорхой эрх бүхий байгууллагад шууд байдлаар задруулж байх уу, эсвэл мэдээллийн нууцлалыг зөвхөн захиргааны буюу шүүхийн хүсэлтийн дагуу задруулж байх уу гэдгийг шийднэ. Холимог тогтолцоо ч байж болох бөгөөд үүнд тодорхой босгоос илүү гарсан үнийн дүн бүхий шилжүүлгийг эсвэл сэжиг төрүүлсэн шилжүүлгийг тогтмол байдлаар задруулж болох юм.

Банкны нууцлалыг захиргааны буюу шүүхийн хүсэлтийн дагуу задруулсан байх тохиолдолд оролцогч улс зөвшөөрөл бүхий хууль сахиулах байгууллагад мэдээлэлд нэвтрэх боломжийг төвлөрсөн мэдээллийн сангаар буюу төв байгууллагаар дамжуулж, эсхүл шууд бус байдлаар, шүүхийн тушаалаар олгож байх талаар шийдвэр гаргах шаардлагатай болох юм. Жишээ нь оролцогч улс мөнгө угаах хэргийг хянах чиг үүргийнхээ хүрээнд санхүүгийн мэдээллийн нэгжийн хүлээн авсан сэжиг бүхий шилжүүлгийн талаар мэдэгдлийг шууд олж авах эрх мэдлийг мөрдөн байцаах эрх бүхий байгууллагад олгох эсэх асуудлыг анхаарч үзэж болно.

Энэ шийдвэрийг гаргахад оролцогч улс эрүүгийн мөрдөн байцаах ажиллагаанд цаг хэмнэхийн ач холбогдол болон хүсэлт гаргасан мэдээлэл нь тухайн хэрэгт холбоотой эсэх мөн тухайн мэдээллийн ач холбогдол нь банкны мэдээллийн нууцлалыг цуцлахуйц хэмжээнд эсэхийг тогтоох шүүхийн байгууллага зэрэг хараат бус байгууллагад тодорхой хяналтын эрхийг олгох асуудлын хооронд тэнцвэрийг тогтоож болох юм.

Журам нь дарамт учруулахуйц биш бөгөөд банкны мэдээлэл олж авах байдалд саад учруулан цаг хугацаа үрэгдүүлэхгүй гэдэгт итгэлтэй болж авахын тулд мэдээллийн тогтолцооны хүчин чадал хийгээд удирдлагын боломжийг нягтлан хянаж байх хэрэгтэй.

Нилээд бодитой бөгөөд дотоодын мөрдөн байцаах ажиллагаанд ихээхэн тохиолддог нэг бэрхшээл бол мэдээлэл хүсэхэд банкны байгууллагын зүгээс цаг тухайд нь хариу өгөхгүй байх

явдал юм. Эрх бүхий байгууллагаас хүсэлт гаргахад, олон тохиолдолд хүсэлт гаргасан байгууллага өөрийн тушаалыг мөрдүүлэхийн тулд шүүхийн байцаан шийтгэх ажиллагаанд хандах шаардлагатай болдог. Зарим оронд энэ нь мөрдөн байцаах ажиллагаанд шаардлагагүй саатал бий болгож болно.

Эрх бүхий байгууллагаас тушаалыг үл мөрдсөн явдалд шийтгэлийн арга хэмжээ авч болдог тогтолцоо нь илүү үр нөлөөтэй тогтолцоонд тооцогдоно. Ийм шийтгэлийн арга хэмжээнд торгууль ногдуулах, үйл хэрэгт хөндлөнгөөс оролцох, нэгжлэг явуулах, бичиг баримтыг хураах зэрэг орж болох юм.

II.4. Мэдээллийн төвлөрсөн санг ашиглах

Дээр дурдсан бэрхшээлээс зайлсхийх мөн дотоодын мөрдөн байцаах ажиллагааг сайжруулах нэг арга бол байгууллага болон тэдэнд зөвшөөрсөн хэрэглээний цар хүрээнээс хамаарч тодорхой түвшинд мэдээллийн төвлөрсөн санг ашиглах явдал юм.

Мэдээллийн төвлөрсөн санг төв банк, татварын алба буюу СМН-ийн аль нэг нь удирдаж байж болох бөгөөд энэ нь мэдээллийг цуглуулахад цаг хэмнэх ач холбогдолтой юм. Мэдээллийн төвлөрсөн сангүй байх нь ялангуяа мөрдөн байцаах ажиллагааны эрт шатанд мэдээлэл хэрэгтэй болсон үед үйл ажиллагааг “гар аргаар” явуулах болдогтой холбоотойгоор өөр өөр эх сурвалжаас бүх мэдээллийг цуглуулах нь олон сараар ч үргэлжилж болох учир цаг хугацааг ихээр үрэгдүүлэхтэй.

Үүнтэй төстэй өөр нэг аргад мэдээллийг хангалттай хамгаалагдсан байдлаар илгээх этерийн тогтолцоо нэвтрүүлэх нь чухалбайна. Энэ тохиолдолд энэхүү хандлагыг нэвтрүүлэх боломжийг тооцож үзэхийн тулд хувийн мэдээллийг хамгаалах тухай хуулийг нягтлан хянах хэрэгтэй. Зарим оронд банкны тэмдэглэлийг тухайн мэдээллийг эзэмшигчийн шууд зөвшөөрөлгүйгээр мэдээллийн тогтолцоонд нэвтрүүлэхийг хориглодог.

II.5. Хүсэлтийн агуулга

Мэдээллийн агуулга ба хэлбэрт тавих шаардлага нь мэдээллийн сан болон мэдээлэл шууд задруулах тогтолцоо байгаа эсэхээс ихэнхдээ хамаардаг. Мэдээлэл шууд задруулах тогтолцоо хэрэгжиж байгаа тохиолдолд оролцогч улс мэдээллийн хүсэлт гаргах болон зөвхөн тодорхой сэжиг байгаа тохиолдолд хүсэлт тавих шаардлагыг тогтоох эрх бүхий байгууллагын тоог хязгаарлах хандлагатай байдаг. Хууль ёсны эрх мэдэл байгаа тохиолдолд эсвэл мөрдөн байцаах ажиллагаагаар хүсэлтийг хангалттай үндэслэлээр дэмжиж байгаа бол хүсэлтэд дотно хамаатан эсвэл данс эзэмшигчийн зүгээс тодорхой шилжүүлэг хийсэн тэр этгээд хамрагдаж болох юм.

Мэдээллийн сан болон мэдээллийг шууд задруулах тогтолцоо байхгүй тохиолдолд оролцогч улс тухайн хувь этгээд буюу хуулийн этгээдийн аливаа банкны данс, хөрөнгө оруулалтын талаар өргөн хүрээний нээлттэй хүсэлт тавихыг зөвшөөрч болно. Банкны зүгээс

банкны данс эзэмшигч буюу үүний жинхэнэ эзнийг таньж тогтоохын тулд хүсэлтийн дэлгэрэнгүй байдалтай холбоотой зарим нэг хязгаарлалт тавьж болох юм.

Хүсэлт гаргаж буй байгууллагад ийм мэдээлэл байхгүй тохиолдолд банк өөрийн салбар болон орон нутгийн нэгжүүдээсээ мэдээлэл цуглуулах үүрэг хүлээж болно. Үүнээс гадна банк “данс эзэмшигч”-ээс ялгаж тогтоох байдлаар жинхэнэ эзнийг тодорхойлохын тулд –зөвхөн дансууд ч биш- мөн тухайн хувь буюу хуулийн этгээдийн ашигласан бүх хөрөнгө оруулалтыг таньж тогтоох үүрэг хүлээж болно. Ийнхүү жинхэнэ эзнийг тогтоох нь компанийн хэрэгслийг буруугаар ашиглахаас үүдэн гарах үр дагаварыг бууруулж өгөх юм. Хувь этгээдийн нэр, биеийн байцаалт болон хуулийн этгээдийн бүртгэлийн нэр нь үндэсний хэмжээнд мөрдөн байцаах ажиллагаа явуулах түвшинд тухайн улсын нутаг дэвсгэр дэх банкны гүйлгээгээр хөрөнгийн хөдөлгөөнийг таньж тогтооход зарчмын хувьд хангалттай байж болно.

II.6. “Харилцагчаа тань, жинхэнэ эзнийг тань” гэсэн урьдчилан сэргийлэх зарчмыг мөрдүүлэхтүхай

Дээр дурдсан асуудал нөгөө талаас 14 ба 52 дугаар зүйлийн заавал биелүүлэх заалтыг, үүнд ялангуяа “харилцагчаа мөн жинхэнэ эзнийг тань” (ХЖЭТ) гэсэн зарчмыг буруу хэрэгжүүлснээс үүдэлтэй байдаг.

ХЖЭТ зарчмыг үр дүнтэйгээр хэрэгжүүлснээр офшор компанийн механизмыг ашиглахаас буюу харилцагчийн бүрэн бус мэдээллээс үүдэн гарах бэрхшээлийг тодорхой хэмжээгээр багасгаж болно. Тиймээс оролцогч улс тэдгээр хуулийн этгээдэд зөвшөөрсөн хэрэглээ болон санхүүгийн байгууллагын өөрийн харилцагчаа таньж байх шаардлагын хооронд тэнцвэр тогтоох хэрэгтэй юм. Гадаадын компанийн механизмыг ашиглахыг зөвшөөрч байгаа тохиолдолд байгууллагын үйл ажиллагаа болон хэрэглээг ойлгох мөн гүйлгээ хийх болон данснаас мөнгө авах эрх бүхий этгээд, жинхэнэ эзнийг таньж тогтоох талаар үр дүнтэй бодлогыг авч хэрэгжүүлж байвал зохино.

Тодорхой тохиолдолд эрх бүхий байгууллагын зүгээс банкнаас авч болох мэдээлэлд данс эзэмшигчийн талаар мэдээлэл (нэр, овог, ургийн нэр, нийгмийн даатгалын дугаар, татвар төлөгчийн бүртгэлийн дугаар, төрсөн огноо, одоогийн болон өмнөх хаяг, одоогийн ажлын газар), гарын үсэг бүхий карт (жишээ нь хуулийн этгээдийг батлах, ямар нэг байдлаар холбоогүй мэт харагдах татвар төлөгчийг тухайн этгээдтэй холбоотой болохыг баталгаажуулах зорилгоор), мөн санхүүгийн мэдээлэл орно. Санхүүгийн мэдээлэлд хууль ёсоор олсон ч мэдэгдээгүй буюу хууль бусаар олсон орлого байгаа эсэхийг баталгаажуулах; татвар төлөгч ташаа суутгал шаардсан эсэхийг тогтоох; цуваа буюу хуурамч шилжүүлэг байгаа эсэхийг тогтоох; хөрөнгийн эх үүсвэрийн талаар асуултад хариулт олж авах; гадаадын төрийн албан тушаалтныг хахуульдсан болон сэжигтэй төлбөр хийсэн эсэхийг тогтоох зорилгоор орлогын эх үүсвэр, дансны тэнцэл, дансны дугаар, мөнгөн шилжүүлэг, хадгаламж, данснаас татаж авсан мөнгөний талаар мэдээлэл орно.

II.7. Банкны нууцлал ба мэргэжилтэн

Энэхүү заалтыг хэрэгжүүлэхдээ оролцогч улс банкны нууцлал нь зөвхөн мөрдөн байцаагдаж буй харилцагчид хамаардаггүй, түүнээс гадна мөрдөн байцаагдаж буй үйлчлүүлэгчид нь харьяалагдаж болох үйл ажиллагаатай холбоотой банкны нууцлалын давуу байдлыг шаардах мэргэжлийн зөвлөгчийн үйлдэлд ч мөн хамаардаг гэдгийг харгалзан үзнэ. Мэргэжлийн нууцлал нь ялангуяа ийм нууцлал чиг үүрэгтэй холбоотой байж таарахгүй тохиолдолд асуудал үүсгэх магадлал өндөр байдаг. Жишээ нь оролцогч зарим улсад үйлчлүүлэгч өмгөөлөгч хоорондын харилцааны давуу байдал нь үйлчлүүлэгчийн хууль ёсны эрх ашгийн тодорхой хам хүрээнд солилцсон тийм мэдээлэлд л хэрэгждэг. Өөрөөр хэлбэл өмгөөлөгч санхүүгийн зуучлагчийн үүрэг гүйцэтгэж байгаа тохиолдолд мэргэжлийн нууцлал үйлчилдэггүй. Үйлчлүүлэгчийнхээ нэр дээр данс эзэмших давуу эрхийг мэргэжлийн этгээдэд олгосон оролцогч улс энэхүү заалт нь эрх бүхий байгууллагын зүгээс банкны мэдээлэл олж авахад саад болохгүй байх явдлыг хангавал зохино.

41 дүгээр зүйл: Гэмт хэрэгтний талаарх бүртгэл

Оролцогч улс бүр энэхүү конвенциор тодорхойлсон гэмт үйлдлийн мөрдөн байцаалт, шүүх ажиллагаанд ашиглах зорилгоор сэжигтэн этгээдийн өмнө нь өөр улсад яллагдаж байсан талаархи мэдээллийг өөрийн зохистой гэж үзсэн нөхцөл, зорилгоор авч үзэхэд шаардлагатай хууль тогтоох буюу бусад арга хэмжээг авч болно.

I. Ерөнхий тойм

Авлигын гэмт хэргийг давтан үйлдэх тохиолдол их ажиглагддаг. Үүнээс гадна олон улсын бизнес нэмэгдэж байгаа энэ үед авлигын үйлдэл болон авлигын үйлдлийг гаргагч этгээд үе үе хил даван өөр улсууд руу нэвтрэх тохиолдол гардаг бөгөөд заримдаа эдгээр нь өөр компанийн нэрийн дор үйл ажиллагаа явуулдаг билээ. Конвенц хоёр асуудлын үр дагаврыг нэг заалтад нэгтгэсэн байна. 41 дүгээр зүйлд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд ашиглах зорилгоор сэжигтэн этгээдийн өөр улсад өмнө нь яллагдаж байсан талаархи мэдээллийг харгалзан үзэхийг оролцогч улсад зөвлөжээ.

II. Бодит бэрхшээл ба шийдэл

Өөр улсад өмнө яллагдаж байсан асуудлыг зохих байдлаар харгалзан үзэхийг оролцогч улсад зөвлөсөн 41 дүгээр зүйл нь заавал биелүүлэх албагүй заалт юм. Энэхүү заалтыг хэрэгжүүлэх талаар шийдвэр гаргахдаа оролцогч ихэнх улс хангалттай бөгөөд шаардлагатай урьдчилан сэргийлэх үр нөлөөг үзүүлж байх хууль ёсны арга хэмжээг авах болон шийтгэл ногдуулахын тулд урьд нь яллагдаж байсан байдлыг харгалзан үзэх боломжийг эрх бүхий байгууллагад олгох эрүүгийн гэмт хэргийн бүртгэл хөтөлж байхыг заасан байдгийг оролцогч улс анхаарч үзэх хэрэгтэй. Олон оронд ийнхүү бүртгэл хөтлөхийг хуулийн дагуу ял шийтгэлийн хязгаар болон тухайн этгээдийн зохих харьцааг харгалзан үзэж үйлдсэн гэмт хэргийн ноцтой байдал болон үүнд холбогдох орчин нөхцлийг тусгах байдлаар хангалттай ял ногдуулах явдлыг баталгаажуулахад шаардлагатай гэж үздэг. Эрүүгийн гэмт хэргийн бүртгэл нь хууль бус үйлдэл гаргах болон гэмт хэргийг давтан үйлдэх хандлагыг харуулдаг. Энэ нь тодорхой ял ногдуулах байдалд нөлөөлж болно. Үүнээс гадна эрүүгийн гэмт хэргийн бүртгэлд анхаарал хандуулах нь

урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй. Оролцогч улс гэмт хэрэг давтан үйлдэх нь нуугдмал аюул юм гэж үзэж болох тул ийм гэмт хэрэгтнийг нийгэмд буцаан оруулахад чиглэсэн тодорхой ял ногдуулах буюу цаашид авлигын гэмт хэрэг үйлдэх боломжийг олгох тийм чиг үүрэг бүхий албан тушаалд тэдгээр этгээдийг томилохгүй байх замаар энэхүү аюулаас урьдчилан сэргийлж болох юм. (Конвенцийн 30 дугаар зүйл, 7 дугаар хэсгийг харна уу). Эцэст нь, өөр улсад яллагдсан байдлыг харгалзан үзэх нь гэмт хэрэгтний шилжилт хөдөлгөөнд зохих хариу болох юм гэдгийг оролцогч улс анхаарч үзвэл зохино.

41 дүгээр зүйлд “өмнө нь яллагдаж байсан аливаа тохиолдол” гэж зааснаар гадаад улсад яллагдах тухайд нилээд өргөн хүрээний тодорхойлолт хийсэн гэж ойлгож болно. Иймээс гадаад улсад яллагдсан аливаа тохиолдлыг үүнд ялангуяа ноцтой гэмт хэргээр яллагдсан тохиолдлыг харгалзан үзэхийг оролцогч улс хүсч байж болох юм. Гэмт этгээдийн ёс зүй болон хууль мөрдөх байдалд дүгнэлт хийж болох тул өргөн цар хүрээг хамарч байх нь үнэхээр ч ач холбогдолтой байж болно. Гэхдээ оролцогч улс тодорхой төрлийн гэмт хэрэгт өмнө нь яллагдсан байдлын жин нөлөө, учруулсан хохирлын хэмжээ болон өмнө яллагдснаас хойш өнгөрсөн хугацаа зэргийг мөн харгалзан үзэх шаардлагатай.

“Яллагдсан байдал” гэсэн нэр томъёо нь одоо давж заалдах боломжгүй болсон гадаад улсад яллагдсан байдлыг илэрхийлж байгаа гэдгийг оролцогч улс анхаарч үзнэ. (41 дүгээр зүйлд хавсаргах тайлбараас харна уу, А/58/422/Нэмэлт.1, 40 дүгээр хэсэг).

Оролцогч улс эрүүгийн гэмт хэргийн бүртгэлд нь хууль зүйн болон техникийн талаас нэвтрэх боломжийг бусад улсад олгохыг хүсч болно. Хууль зүйн талаас нэвтрэх боломжийн хувьд оролцогч улс эрүүгийн гэмт хэргийн бүртгэл зэрэг мэдээллийг олон улсад шилжүүлэхийг дотоодын хуулиар зөвшөөрч байгаа эсэхийг харж үзэх мөн зохих байдлаар хянан засварлах шаардлагатай болж болно. Техникийн талаас нэвтрэх боломжийн хувьд оролцогч улс олон улсын хэмжээнд мэдээлэл солилцох асуудал хариуцсан байгууллага бий болгохыг хүсч болно. Хууль зүйн харилцан туслалцаа зэрэг эрүүгийн гэмт хэргийн асуудлаар олон улсын хамтын ажиллагааг хариуцдаг байгууллагад энэ үүргийг даалгах нь тохиромтой болно.

42 дугаар зүйл: Шүүхийн харъяалал

1. Энэхүү конвенциор тодорхойлсон гэмт үйлдэл доорх нөхцөлд үйлдэгдсэн бол оролцогч улс бүр харъяалан шийдвэрлэх шаардлагатай арга хэмжээг авна:

(a) Тухайн оролцогч улсын нутаг дэвсгэрт үйлдсэн; эсхүл

(b) Гэмт үйлдлийг үйлдэх үед тухайн улсын далбаа бүхий хөлөг онгоцны тавцан дээр буюу тухайн улсын хуулийн дагуу бүртгэгдсэн агаарын хөлөгт үйлдсэн.

2. Энэхүү конвенцийн 4 дүгээр зүйлийн дагуу, аливаа ийм гэмт үйлдлийг дор дурдсан байдлаар үйлдсэн бол оролцогч улс харъяалан шийдээж болно:

(a) Тухайн улсын харьяат иргэний эсрэг үйлдсэн;

(b) Тус улсын харьяат иргэн буюу тус улсын нутаг дэвсгэрт байнга оршин суудаг харьяалалгүй этгээд үйлдсэн;

(c) Энэхүү конвенцийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн (a)(i) буюу (ii), эсхүл (b)(i) дэд хэсэгт тодорхойлсон гэмт үйлдлийг оролцогч улсын нутаг дэвсгэрт үйлдэх зорилгоор конвенцийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн (b)(ii) дэд хэсэгт тодорхойлсон гэмт үйлдлийн аль нэгийг тухайн улсын нутаг дэвсгэрийн гадна үйлдсэн; эсхүл

(d) Тухайн оролцогч улсын эсрэг үйлдсэн.

3. Энэхүү конвенцийн 44 дүгээр зүйлийн зорилгод, сэжигтэн этгээд нутаг дэвсгэрт нь байгаа бөгөөд тухайн улс өөрийн харьяат гэсэн ганц үндэслэлээр уг этгээдийг шилжүүлэн өгөхгүй байгаа тохиолдолд оролцогч улс бүрэн энэхүү конвенциор тодорхойлсон гэмт үйлдлийг харьяалан шийдвэрлэх шаардлагатай арга хэмжээг авна.

4. Сэжигтэн этгээд нутаг дэвсгэрт нь байгаа бөгөөд тухайн улс уг этгээдийг шилжүүлэн өгөхгүй байгаа тохиолдолд оролцогч улс бүр энэ конвенциор тодорхойлсон гэмт үйлдлийг харьяалан шийдвэрлэх шаардлагатай арга хэмжээг авна.

5. Хэрэв ижил хэргийн талаар аливаа өөр оролцогч улс мөрдөн шалгах, яллах, шүүн таслах ажиллагаа явуулж буй тухай мэдээллийг энэ зүйлийн 1, 2 дахь хэсгийн дагуу уг хэргийг харьяалан шийдвэрлэж байгаа оролцогч улс авсан эсхүл аливаа өөр байдлаар мэдсэн бол шаардлагатай гэж үзвэл, тэдгээр улсын эрх бүхий байгууллагууд үйл ажиллагаагаа зохицуулах үүднээс харилцан зөвшилцөнө.

6. Энэхүү конвенц нь олон улсын нийтлэг эрх зүйн хэм хэмжээг үл хөндөх бөгөөд, аливаа оролцогч улс дотоодын хууль тогтоомжийнхоо дагуу тогтоосон эрүүгийн хэргийн харьяаллаа хэрэгжүүлэхийг үгүйсгэхгүй.

I. Ерөнхий тойм

Энэхүү конвенцийн нэг гол зорилго нь авлигатай тэмцэхэд олон улсын хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжих юм (Конвенцийн 1 (b) зүйлийг харна уу). Иймээс энэхүү конвенцид гадаадын төрийн албан тушаалтныг хахуулдах заалтаас гадна шилжүүлэн өгөх, эрх зүйн харилцан туслалцаа, хамтарсан мөрдөн байцаах ажиллагаа түүнчлэн авлигатай тэмцэх тал дээр томоохон ололт болох хил дамнасан хөрөнгийг буцаан олгох арга хэмжээ зэрэг эрүүгийн гэмт хэрэгтэй холбоотой асуудлаар олон улсын хамтын ажиллагааны өөр өөр хэв шинжийн талаарх тусгай зүйлүүд багтсан. Нөгөөтэйгүүр 4 (1) зүйлд оролцогч улсын бүрэн эрхт тэгш байдал болон нутаг дэвсгэрийн халдашгүй дархан байдал, өөр улсын дотоод хэрэгт үл оролцох зарчмын дагуу энэхүү конвенцоор хүлээсэн үүргээ биелүүлэхийг онцгойлон авч үзсэн байна. Цаашлаад 4 (2) зүйлд энэхүү конвенцийн аль ч заалт өөр улсын нутаг дэвсгэрт гагцхүү тухайн улсын дотоодын хууль тогтоомжийнх нь дагуу тус улсын эрх бүхий байгууллагын эрх мэдэлд хамаарах шүүхийн харьяаллыг хэрэгжүүлэх болон чиг үүргийг гүйцэтгэх эрхийг оролцогч аль ч улсад олгохгүй гэж

заасан байгаа. Шилжүүлэн өгөх, эрх зүйн хувьд харилцан туслалцах болон хөрөнгө буцаан олгох нь оролцогч улсуудын мөрдөн байцаах ажиллагаа, дотоодын яллах болон бусад шүүн таслах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх тал дээр харилцан туслалцах нь олон улсын хамтын ажиллагааны хэлбэр юм. Гэхдээ үүнд оролцогч улсууд урьдчилсан нөхцөл болгож дотоодын хууль тогтоомжоор шүүхийн харьяаллын асуудлыг, чиг үүргийн дагуу зохих байдлаар зохицуулахыг анхаарах.

II. Бодит бэрхшээл ба шийдэл

42 дугаар зүйлийн 1 дэх хэсэг нь заавал биелүүлэх заалт бөгөөд энд оролцогч улс шүүхийн харьяаллыг “нутаг дэвсгэрийн зарчим”-ын дагуу буюу өөрөөр хэлбэл гэмт үйлдлийг оролцогч улсын нутаг дэвсгэрт үйлдсэн эсхүл тус улсын далбаа бүхий хөлөг онгоцны тавцан дээр буюу тухайн улсын хуулийн дагуу бүртгэгдсэн агаарын хөлөгт үйлдсэн бол тухайн улс шүүхийн харьяалалд хамаарна гэж заасан байна.

Түүнчлэн 42 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт сэжигтэн этгээд нутаг дэвсгэрт нь байгаа бөгөөд тухайн улс өөрийн харьяат гэсэн зөвхөн нэг үндэслэлээр уг этгээдийг шилжүүлэн өгдөггүй тохиолдолд оролцогч улс бүр энэхүү конвенцийн дагуу тодорхойлогдсон гэмт үйлдэлд шүүхийн харьяаллаа тогтоохыг үүрэг болгосон. Энэ заавал биелүүлэх шаардлага нь конвенцийн гэмт этгээдийг өөрийн харьяат гэсэн ганц үндэслэлээр шилжүүлэн өгдөггүй бол шилжүүлэн өгөх хүсэлт тавихын оронд дотооддоо энэ хэргийг яллах ажиллагааг эхлүүлэхийг заасан 44 дүгээр зүйлийн 11 дэх хэсэгт тавьсан тэрхүү шаардлагатай холбогдож байгаа юм.

42 дугаар зүйлийн 2 дахь хэсэг заавал биелүүлэх албагүй заалтыг багтааж байгаа бөгөөд энд оролцогч улс шүүхийн харьяаллаа “идэвхтэй буюу идэвхгүй хувийн этгээдийн зарчим”-ын дагуу буюу өөрөөр хэлбэл тухайн улсын харьяат үйлдсэн буюу тухайн улсын харьяатын эсрэг тус тус үйлдсэн гэмт хэрэгт шүүхийн харьяаллаа тогтоож болно гэж заасан байгаа юм. Үүнээс гадна гэмт хэргийн гол үйлдлийг оролцогч улсын нутаг дэвсгэрийн дотор үйлдэх үүднээс дараах оролцоо бүхий үйлдлийг тус улсын нутаг дэвсгэрийн гадна үйлдсэн бол мөнгө угаах аливаа гэмт хэргийг үйлдэхэд оролцсон, хамтарсан эсхүл хуйвалдсан, ийм гэмт хэргийг үйлдэхээр завдсан, тусалсан, дэмжсэн, ийм гэмт хэрэг үйлдэхийг хөнгөвчилсөн, зөвлөсөн тохиолдолд шүүхийн харьяаллаа тогтоох боломжийг тооцож үзэхийг оролцогч улсад зөвлөж байна. Эцэст нь энэ хэсэгт заавал биелүүлэх албагүй нэг заалт багтсан бөгөөд энд оролцогч улсад “хамгаалалтын зарчим”-ын дагуу шүүхийн харьяаллаа тогтоохыг, өөрөөр хэлбэл тухайн улсын эсрэг үйлдсэн гэмт хэрэгт шүүхийн харьяаллаа тогтоохыг хүссэн байгаа юм.

Цаашлаад 42 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заавал биелүүлэх албагүй заалт багтсан бөгөөд энд оролцогч улсаас сэжигтэн этгээд нутаг дэвсгэрт нь байгаа бөгөөд тухайн улс уг этгээдийг шилжүүлэн өгөхгүй тохиолдолд энэхүү конвенцийн дагуу тогтоосон гэмт хэрэгт шүүхийн харьяаллаа тогтооход шаардлагатай байж болох арга хэмжээг авахыг хүссэн байна.

Эцэст нь 42 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт олон улсын нийтлэг эрх зүйн хэм хэмжээг үл хөндөн, аливаа оролцогч улс дотоодын хуулийнхаа дагуу тогтоосон эрүүгийн хэргийн харьяаллыг хэрэгжүүлж болохыг хүлээн зөвшөөрсөн.

Энэхүү зүйлийн 5 дахь хэсэгт, нэгэн адил үйлдлийн талаар аливаа өөр оролцогч улс мөрдөн байцаах, яллах, шүүх ажиллагаа явуулж буй тухай мэдээллийг оролцогч улс авсан, эсхүл аливаа өөр байдлаар мэдсэн бол тэдгээр улсын эрх бүхий байгууллагууд үйл ажиллагаагаа зохицуулах үүднээс бие биетэйгээ зөвшилцөхийг хүссэн байна.

Оролцогч улсууд дараах асуудлуудад анхаарал хандуулахыг хүсч байна:

- Гэмт хэргийг тухайн оролцогч улсын нутаг дэвсгэрт үйлдсэн;
- Гэмт хэргийг тухайн улсын харъяатын эсрэг үйлдсэн;
- Гэмт хэргийг тус улсын харъяат буюу тус улсын нутаг дэвсгэрт байнга оршин суудаг харъяалалгүй этгээд үйлдсэн;
- Тухайн гэмт хэрэг нь энэхүү конвенцийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн (b)(ii) дэд хэсгийн дагуу тогтоосон гэмт хэргийн аль нэг нь бөгөөд түүнийг энэхүү конвенцийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн (a)(i) буюу (ii), эсхүл (b)(i) дэд хэсгийн дагуу тогтоосон гэмт хэргийг тус улсын нутаг дэвсгэр дотор үйлдэх үүднээс тус улсын нутаг дэвсгэрийн гадна үйлдсэн;
- Гэмт хэргийг тухайн улсын эсрэг үйлдсэн;
- Сэжигтэн этгээд нутаг дэвсгэрт нь байгаа бөгөөд тухайн улс өөрийн харъяат гэсэн ганц үндэслэлээр уг этгээдийг шилжүүлэн өгдөггүй тохиолдолд энэхүү конвенцийн дагуу тогтоосон гэмт хэрэгт шүүхийн харъяаллаа тогтоох;
- Сэжигтэн этгээд нутаг дэвсгэрт нь байгаа бөгөөд өөр үндэслэлээр уг этгээдийг шилжүүлэн өгдөггүй тохиолдолд энэхүү конвенцийн дагуу тогтоосон гэмт хэрэгт шүүхийн харъяаллаа тогтоох.

III.1. Гэмт хэргийг тухайн оролцогч улсын нутаг дэвсгэрт үйлдсэн байх

Конвенцийн 42 (1)(a)-д энэхүү конвенцийн дагуу тогтоосон гэмт хэргийг нутаг дэвсгэрт нь үйлдсэн бол тухайн оролцогч улс сэжигтэн этгээдийн иргэний харъяаллаас үл хамааран шүүхийн харъяаллаа тогтооно гэж заасан байна. Ихэнх улс нутаг дэвсгэрийн шүүхийн харъяаллын зарчмыг хүлээн зөвшөөрдөг ч хэрэгжүүлэх байдал нь нилээд ялгаатай байдаг.

Оролцогч улсууд энэхүү заалтыг хэрэгжүүлэх олон загвар байдгийг анхаарч үзэж болох юм. Зарим улс гэмт этгээд тухайн нутаг дэвсгэрт үйлдэл гаргасан бол нутаг дэвсгэрт нь гэмт хэрэг үйлдсэн гэж тооцдог. Бусад улс нутаг дэвсгэрийн зарчмыг илүү өргөн хүрээний загварын дагуу хэрэгжүүлж болох юм: гэмт хэргийн ядаж аль нэг хэсэг нь тухайн улсын нутаг дэвсгэр дотор үйлдэгдсэн бол нутаг дэвсгэрийн зарчим үйлчилж болно. Тиймээс авлигын хэргийн гол үйлдэл гадаад улсад гарсан ч дотоодын оролцоо байхад л энэ зарчим үйлчлэхэд хангалттай гэж

үзнэ. Үүнээс гадна илүү өргөн дэлгэр байдлаар хүлээн зөвшөөрдөг “газар сайгүй байх зарчим” буюу “объектив зарчим”-ын дагуу тухайн гэмт хэрэг нутаг дэвсгэрт нь үр нөлөө үзүүлэх тэрхүү улс шүүхийн харьяаллаа тогтоож болно гэж үздэг. Иймээс гадаад улсад үйлдсэн авлигын хэрэг дотоодын зах зээл буюу дотоодын ямар нэг сонгон шалгаруулалтад сөргөөр нөлөөлсөн тохиолдолд тухайн улс шүүхийн харьяаллаа тогтоох эрхтэй.

II.2. Гэмт хэргийг тухайн улсын харьяатын эсрэг үйлдсэнбайхтохиолдол

Оролцогч улсууд гэмт хэрэг хаана үйлдэгдсэнээс үл хамааран тухайн улсын харьяатын эсрэг үйлдэгдсэн л бол тухайн гэмт хэрэгт шүүхийн харьяаллаа тогтоох боломжийг авч үздэг. Харьяатын зарчмын энэ идэвхгүй хувилбар нь хамгааллын зарчимтай холбоотой. Хамгааллын зарчим нь тухайн улсыг хамгаалахад чиглэсэн байдаг бол харьяатын зарчмын идэвхгүй хувилбар нь тухайн улсын иргэнийг хамгаалахыг илүүд үздэг.

Зарим улс тухайн улсын нутаг дэвсгэр болон иргэдэд үр нөлөөлөл үзүүлсэн авлигын бүх хэргийг хамрах байдлаар хэрэгжүүлэх өргөн хүрээний загварыг дагадаг байж болох юм. Харин бусад нь энэ загварыг гадаад улсад харьяат нь хохирсон тохиолдлуудыг хамрах байдлаар илүү өргөжүүлсэн байна. Нутаг дэвсгэрийн зарчмыг илүү нарийн хүрээнд хэрэгжүүлэхийг сонгосон улс орон гадаад улсын авлигын хэргээс болж тухайн улсын харьяат болон үндэсний компани хохирсон тохиолдолд тухайн хэрэгт шүүхийн харьяалал тогтоохын тулд харьяатын идэвхгүй зарчмыг хэрэгжүүлж байх шаардлагатай байдгийг анхаарч үзвэл зохино.

Оролцогч улс цогц хамгаалалтыг бий болгохын тулд “харьяат” гэсэн нэр томъёог илүү өргөн хүрээг хамрах байдлаар буюу тухайн улсын иргэн, тухайн улсын нутаг дэвсгэр дотор байх хуулийн этгээдийг багтаах байдлаар хэрэглэх асуудлыг бодолцож үзэж болох юм.

II.3. Гэмт хэргийг тус улсын харьяат буюу тус улсын нутаг дэвсгэрт байнга оршин суудаг харьяалалгүй этгээд үйлдсэн байх тохиолдол

Ингэхийг хэдийгээр шаардаагүй ч оролцогч улс идэвхтэй хувь этгээдийн зарчмаар шүүхийн харьяалал тогтоохыг хүсч байж болох юм. Энэ заалтыг хэрэгжүүлэх талаар шийдвэр гаргахдаа оролцогч улс авлигын гэмт хэргийг шийдвэрлэх тал дээр нэвтрүүлсэн байх шаардлагатай хандлагыг бодолцож үзэх хэрэгтэй. Тиймээс иргэддээ хууль мөрдөх хандлага төлөвшүүлэх, ийм хандлагыг хамгаалах, түүнчлэн дотооддоо болон гадаадад зан үйлийн дүйцэхүйц жишгийг хөхиүлэн дэмжихийн тулд оролцогч улс энэ зарчмын дагуу шүүхийн харьяалал тогтоох явдлыг нэвтрүүлэхийг хүсч болно. Энэ зарчмын дагуу оролцогч улс авлигын хэргийг хаана үйлдсэнээс нь үл хамааран өөрийн иргэддээ шүүхийн харьяаллыг тогтоож болно. Энэ нь тус улсын нутаг дэвсгэрт байнга оршин суудаг харьяалалгүй этгээдэд хамаарах тул энэ тохиолдолд шилжүүлж өгөх нөхцөл бүрдэхгүй.

Энэхүү конвенцийн дагуу тогтоосон гэмт хэрэгт шүүхийн харьяалал тогтоох талаар шийдвэр гаргахдаа оролцогч улс 16 дугаар зүйлд заасан гадаадын төрийн албан тушаалтныг хахуульдах гэмт хэргийг ер нь гадаад улсад үйлддэг гэдгийг, иймээс энэ хэрэгт харьяатын

зарчим үйлчилж байгаа тохиолдолд л үүнийг үр дүнтэйгээр яллах боломж бий болно гэдгийг санаж байх хэрэгтэй.

Хуулийн этгээдийн тухайд нилээд олон асуудлыг тооцож үзэх хэрэгтэй болно. Юун түүрүүнд “харьяат” гэсэн нэр томъёог иргэний харьяалал бүхий хуулийн этгээдийг хамрах байдлаар хэрэглэх асуудлыг оролцогч улс тооцож үзвэл зохилтой. Хоёрдугаарт, оролцогч улс харьяатын зарчимтай холбоотойгоор хэрэгжүүлж болох хоёр загварыг анхаарч үзнэ. Оролцогч ихэнх улс тухайн улсын харьяат хуулийн этгээд авлигын гэмт хэрэгт хариуцлага хүлээж байгаа тохиолдолд харьяатын зарчмын дагуу шүүхийн харьяалал тогтоодог. Хэрэв ямар нэг компани тухайн улсын хуулийн дагуу байгуулагдсан бол эсхүл тухайн улсын нутаг дэвсгэрт байрлаж байгаа бол тус компанийг харьяат гэж үзэж болно. Оролцогч бусад улс шүүхийн харьяаллын асуудлыг тухайн хуулийн этгээдийн иргэний харьяалалд бус харин үйлдэл гаргаж буй хувь этгээдийн иргэний харьяалалд хамааруулж авч үздэг. Тиймээс эдгээр улсууд тухайн хуулийн этгээдийн байгууламж дотор буюу тухайн хуулийн этгээдийн тусын тулд авлигын үйлдэл гаргасан этгээдийг тухайн улсын иргэн гэж үзэхийг шаардаж болно. Гэхдээ компанийн хариуцлагатай холбоотой чухал хэрэг дээр мөрдөн байцаах байгууллагын зүгээс тухайн гэмт хэргийг өдөөн хатгагч хувь этгээд буюу гэмт хэрэгтнийг таньж тогтоох боломжгүй байж болох тул энэ нь хуулийн ноцтой цоорхой үүсэхэд нөлөөлж болзошгүй. Түүнчлэн компанийг хувийн этгээд болон тэдний харьяаллаас салган авч үзснээр хувь этгээдийн хариуцлагын зарчим нь хууль ёсны үр дагаврыг тухайн байгууллагад өөрт нь ногдуулна гэдгийг оролцогч улс анхаарч үзэж болох юм.

II.4. Мөнгө угаахаар завдсан гэмт үйлдэлд шүүхийн харьяалал тогтоох

Конвенцийн 23 дугаар зүйлийн 1 (a)(i), (ii) буюу (b)(i) хэсэгт заасан мөнгө угаах аливаа гэмт хэргийг үйлдэхэд оролцсон, хамтарсан эсхүл хуйвалдсан, ийм гэмт хэргийг үйлдэхээр завдсан, тусалсан, дэмжсэн, ийм гэмт хэрэг үйлдэхийг хөнгөвчилсөн, зөвлөсөн тохиолдолд эсхүл гэмт хэргийн гол үйлдлийг оролцогч улсын нутаг дэвсгэрийн дотор үйлдсэн буюу үйлдэхийг завдсан ч оролцоо бүхий үйлдлийг тус улсын нутаг дэвсгэрийн гадна үйлдсэн бол шүүхийн харьяаллаа тогтоох боломжийг оролцогч улс тооцон үзэж болно. Ийнхүү энэ зүйл ямар нэг хуулийн цоорхой гаргалгүйгээр шүүхийн харьяаллаа тогтоох замаар мөнгө угаахтай тэмцэхэд олон улсын хамтын ажиллагааг дэмжихийг уриалсан конвенцийн зүйлийг хэрэгжүүлж байгаа юм.

Оролцогч улс энэ зарчмыг өргөн хүрээнд хэрэгжүүлснээр нутаг дэвсгэрийн зарчмын үндсэн дээр тэдгээр хэрэгт шүүхийн харьяаллаа тогтоох боломжтой болно гэдгийг харгалзан үзвэл зохино.

II.5. Гэмт хэргийг оролцогч улсын эсрэг үйлдсэн тохиолдол

Эрүүгийн хэрэгт шүүхийн харьяаллаа тогтоох байдлаар өөрсдийгөө болон байгууллагуудаа хамгаалах боломжийг 42 (2) хэсэгт оролцогч улсад олгосон байна. Гэхдээ энэ заалт нь оролцогч улс аль загварын дагуу нутаг дэвсгэрийн зарчмыг хэрэгжүүлж байгаагаас хамаарна. Тиймээс нутаг дэвсгэрт нөлөөлсөн аливаа хэргийг хамрах байдлаар өргөн хүрээнд

нутаг дэвсгэрийн зарчмыг хэрэгжүүлж байгаа бол хамгааллын зарчмыг хэрэгжүүлэх тухайн улсын хуулийн заалт нь нилээд нарийн хүрээнд хэрэгжих болно гэсэн үг.

Нутаг дэвсгэрийн зарчмыг нарийн хүрээнд хэрэгжүүлэхээр заасан оролцогч улс орон шүүхийн харъяалал тогтоох асуудлаар аливаа хуулийн цоорхой үүсэхээс зайлсхийж, мөн иргэдийнх нь сайн сайханд чухал шүүхийн байцаан шийтгэх ажиллагаа болон байгууллагуудаа хамгаалах зорилгоор хамгааллын зарчмын тухай заалтыг хэрэгжүүлэх боломжийг тооцож үзнэ.

Үүнээс гадна оролцогч улс энэ зарчмын идэвхгүй хувь хүний зарчимтай үүсэх харилцааг ч анхаарч үзэх шаардлагатай. Тухайн улсын эсрэг үйлдсэн гэмт хэргийг хамрах идэвхгүй хамгааллын загварыг оролцогч улс анхаарч үзэж болох юм. Энэ тохиолдолд хамгааллын зарчмыг нарийн хүрээнд хэрэгжүүлнэ гэсэн үг.

Харъяатын зарчим нь дээр дурдсан хэрэгт хамаардаггүй оролцогч улсууд хамгааллын зарчмыг хэрэгжүүлэх замаар хуулийн цоорхойг бөглөж болно. Үүнд хэрэгжүүлэх дараах хоёр арга замыг анхаарч үзэж болох юм:

- Тухайн улсад өөрөөр хэлбэл түүний байгууллага, төрийн байгууллага, төрийн корпорацид нөлөөлсөн бол гэмт хэргийг тухайн улсын эсрэг үйлдсэн гэж оролцогч улс үзэж болно. Тиймээс оролцогч улс иргэдэд нь нөлөөлсөн гэмт хэрэг энэ заалтад биш харин 42 (2)(а) заалтанд хамаарахыг харгалзан үзвэл зохино.
- Нөгөөтэйгүүр тухайн улсын төрийн албан тушаалтанд нөлөөлсөн бол гэмт хэргийг тухайн улсын эсрэг үйлдсэн гэж оролцогч улс үзэж болно. Гэхдээ энэ нь төрийг төлөөлсөн албан тушаалтны тодорхой үүрэг буюу чиг үүргийн хүрээнд тухайн албан тушаалтанд нөлөөлсөн байх шаардлагатай.

II.6. Эрүүгийн шүүхийн харъяаллыг “aut dedere aut judicare” (нэг бол шилжүүлэн өг нэг бол шүүн тасал) зарчмын үндсэн дээр тогтоох

Au dedere aut judicare зарчмын дагуу оролцогч улс сэжигтэн этгээдийг шилжүүлэн өгч болохгүй байх тохиолдолд дотооддоо яллах ажиллагааг явуулах учиртай. Шилжүүлэн өгөхийн оронд дотооддоо эрүүгийн хэргийг байцаан шийтгэх ажиллагааг эхлүүлэх нь зохих шүүхийн харъяаллын үндэслэл дээр суурилсан байх хэрэгтэй бөгөөд иргэний харъяаллын шалтгаанаар шилжүүлэн өгөхгүй байгаа бол Конвенцид үүнийг заавал биелүүлэх шаардлага болгож (42 дугаар зүйл, 3 дахь хэсэг), буюу сонголт болгож (42 дугаар зүйл, 4 дэх хэсэг) заасан байна. Эдгээр заалтыг дотоодын түвшинд үр дүнтэйгээр хэрэгжүүлснээр сэжигтэн этгээдийг яллахгүй мөн шилжүүлэн өгөхгүй байх явдлаас зайлсхийхэд шаардлагатай эрх зүйн орчноор оролцогч улсын шүүх болон хууль сахиулах байгууллагыг хангаж өгч байгаа юм. Оролцогч улс ялангуяа харъяатыг үл шилжүүлэх явдлыг харгалзан үзэж тухайн улсын харъяатын гадаад улсад үйлдсэн гэмт хэргийг идэвхтэй харъяатын зарчимд хамруулж болохыг, тиймээс хууль сахиулах байгууллага нь энэ зүйлийн дагуу энэ хэрэгт шүүхийн харъяаллаа тогтоож болохыг тооцож үзэж болно. Гэхдээ харъяатын зарчим нь гэмт этгээд гадаад улсад гэмт хэрэг үйлдснийхээ дараагаар иргэний харъяалал авсан тохиолдлыг хамардаггүй гэдгийг оролцогч улс санаж байх хэрэгтэй.

Энэ тохиолдлыг хамрахын тулд оролцогч улс 42 (3) заалтыг хэрэгжүүлэх боломжийг тооцож үзэж болох юм.

Олон улсын хамтын ажиллагаа
(IV бүлэг, 43-50 зүйлүүд)

43 дугаар зүйл: Олон улсын хамтын ажиллагаа

1. Оролцогч улсууд эрүүгийн хэргийн хувьд энэхүү конвенцийн 44-өөс 50 дугаар зүйлийн дагуу хамтран ажиллана. Дотоодын эрх зүйн тогтолцоотой нь нийцэх шаардлагатай тохиолдолд оролцогч улсууд авлигатай холбоотой мөрдөн байцаалт, иргэний ба захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд харилцан туслалцаа үзүүлэх асуудлыг авч үзнэ.

2. Улс хоорондын хамтын ажиллагааны явцад аливаа нэг үйлдлийг харилцагч хоёр талын аль аль нь гэмт үйлдэлд тооцсон байх зарчмыг шаардаж буй тохиолдолд хүсэлт хүлээн авагч тал оролцогч улсын хуулиар уг гэмт үйлдлийг хүсэлт гаргагч оролцогч улсын хуульд заасан гэмт үйлдлийн адил ангилалд багтаадаг буюу адил нэр томъёогоор нэрлэдэг эсэхээс үл хамааран, гэмт үйлдлийн бүрэлдэхүүн нь аль аль оролцогч улсын хуулийн дагуу эрүүгийн гэмт үйлдэлд тооцогддог бол энэ арчмыг хангаж байна гэж үзнэ.

I. Ерөнхий тойм

Авлигатай тэмцэхэд олон улсын үр дүнтэй, хариуцлагатай, шуурхай хамтын ажиллагааг дэмжихийн тулд оролцогч улсууд хоорондын өндөр түвшний ажлын түншлэл бий болсон байх шаардлагатай. Ийм хамтын ажиллагааг гүнзгийрүүлж, өргөжүүлэхийн тулд гадаад улсын эрх зүйн тогтолцоонд итгэж, үнэмших явдлыг дэмжих хэрэгтэйг бодит туршлага харуулж байна.

43 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт энэхүү конвенцийн 44-өөс 50 дугаар зүйлийн дагуу авлигатай тэмцэх олон улсын үр дүнтэй хамтын ажиллагааг дэмжих үр нөлөө бүхий тогтолцоо болон механизмыг нэвтрүүлэхийг оролцогч улсаас хүссэн байгаа юм. Энэ нь юун түрүүнд “авлигаас урьдчилан сэргийлж, тэмцэх ... талаар олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх, хөнгөвчлөх, дэмжих” конвенцийн тулгуур зорилгод нийцэж байгаа болно (Конвенцийн 1(b) зүйл). Конвенцийн IV бүлэгт зааснаар эрүүгийн асуудлаар олон улсын хамтын ажиллагааны хамрах хүрээ нь хууль сахиулах тал дээр хамтран ажиллах, шилжүүлэн өгөх, эрх зүйн харилцан туслалцаа зэрэг хамтын ажиллагааны “уламжлалт” хэлбэрийг хамраад зогсохгүй эрүүгийн асуудлаар байцаан шийтгэх ажиллагааг шилжүүлэх, хамтарсан мөрдөн байцаах байгууллага байгуулах, мөрдөн байцаах тусгай арга хэрэгслийг ашиглахад хамтран ажиллах зэрэг олон улсын эрүүгийн шүүхэд гарсан харьцангуй шинэ сонголтуудыг багтааж байгаа юм.

43 дугаар зүйлийн 1 дэх хэсэг хамтын ажиллагаагаа зөвхөн эрүүгийн асуудлыг хамраад зогсохгүй авлигатай холбоотой иргэний ба захиргааны шинжтэй асуудлыг ч багтаах байдлаар өргөжүүлэх боломжийг оролцогч улсад олгож байна. Иргэний ба захиргааны асуудлаар мөрдөн байцаах болон байцаан шийтгэх ажиллагатай холбоотой олон улсын хамтын ажиллагааны

механизмыг боломжит байдлаар ашиглахыг ийнхүү тод томруун заасан нь маш чухал ололт гэж ойлгож болно. Нөгөөтэйгүүр иргэний журмаар хэрэг шийдэх үйл явц нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны гүйцэлдүүлэгч, нэмэлт зүйл мэтээр ойлгосоор ирсэн. Иргэний зарга нь ихэнхдээ эд хөрөнгөтэй буюу иргэний эрхийн зөрчилтэй холбоотой хуулинд үндэслэсэн байдаг бөгөөд эрүүгийн гэмт үйлдлийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудалд голлон төвлөрдөг. Үүнээс гадна эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны мөн чанар болон үүний шаардлагаас үүдэн бий болох бэрхшээлийн улмаас олон хуульчид тодорхой тохиолдолд авлигын хэргийг шийдэхдээ иргэний журмаар шийдвэрлэхийг ялангуяа эрүүгийн яллах ажиллагааг явуулах боломжгүй (жишээ нь, хариуцагч нас барах, байхгүй байх, дархан эрхтэй байх буюу хариуцагчийг эрүүгийн шүүх хуралд ирүүлэн авчрах ерөнхийдөө боломжгүй байх) тохиолдолд сонгож болох боломжит хувилбар гэж үзэж байна. Цаашлаад 43 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг авлигатай холбоотой гэмт хэргээс олж авсан эд хөрөнгийг өмчлөх эрх буюу өмчлөлийг тогтоох зорилгоор өөрийн шүүхэд иргэний хэрэг үүсгэхийг оролцогч өөр улсад зөвшөөрөхийг оролцогч улсаас хүсэх, ийм байдлаар олж авсан эд хөрөнгийг шууд буцаан олгоход шаардлагатай арга хэмжээг авах боломжийг тусгасан конвенцийн 53 дугаар зүйлтэй холбож авч үзнэ.

Нөгөөтэйгүүр энэхүү конвенциор олон улсын хамтын ажилгааны тухай өөрийн хуулийн заалтын хүрээнд авлигатай холбоотой захиргааны байцаан шийтгэх ажиллагаа явуулах боломжтой болж байгаа юм. Ингэснээр харилцан туслалцах механизм нь эрүүгийн асуудал болон байцаан шийтгэх ажиллагаа төдийгүй мөн авлигатай холбоотой захиргааны шинжтэй байцаан шийтгэх ажиллагаанд ч хамаарч хэрэгжиж болохоор байна. Байцаан шийтгэх ажиллагаанд, жишээ нь, хүсэлт гаргагч болон хүсэлтийг хүлээн авагч аль аль оролцогч улсын дотоодын эрх зүйн хүрээнд шийтгэж болох үйлдэлтэй холбоотой захиргааны эрх бүхий байгууллагын зүгээс мэдүүлсэн хэргийг хамааруулж болно. Энд гарах шийдвэр нь авлигын хэрэгт шүүхийн харьяаллаа тогтоосон эрүүгийн шүүх хурлын өмнө байцаан шийтгэх ажиллагааг эхлүүлж болох юм. Энэ нь эрүүгийн гэмт хэргийн үйлдэл болон журмын зөрчил холилдсон буюу захиргааны шийтгэл хүлээх тэрхүү хуулийн этгээд энэхүү конвенцоор тогтоосон гэмт хэрэгт оролцсон тохиолдолд хамаарна (Конвенцийн 26 дугаар зүйлийг харна уу). Харьцуулах зорилгоор, Эрүүгийн асуудлаар харилцан туслалцах тухай Европын конвенцын хоёр дахь нэмэлт протоколд (2001) ялангуяа эрүүгийн хэргийн асуудлаар шүүхийн харьяаллаа тогтоосон шүүх хурлын өмнө байцаан шийтгэх ажиллагааг эхлүүлж болох захиргааны байцаан шийтгэх ажиллагааг хамрах байдлаар цар хүрээг нь өргөтгөсөн байгааг (Конвенцийн 1 дүгээр зүйл, 3 дахь хэсэг) анхаарч үзэж болох юм. Үүнтэй төстэй заалт Эрүүгийн асуудлаар харилцан туслалцах тухай Европын холбооны 2000 оны конвенцид (3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг) орсон.

II. Бодит бэрхшээл ба шийдэл

Олон улсын хамтын ажиллагааг уламжлал ёсоор хоёр талын, бүс нутгийн, олон улсын түвшний гэрээ буюу хэлэлцээрээр зохицуулдаг. Зарим тохиолдолд хамтын ажиллагаа нь ийм ямар нэгэн гэрээнд суурилсан суурь хүрээгүйгээр тухайн улсын хууль, харилцан солилцоо болон улс хоорондын эелдэг харилцаанд тулгуурласан байж болно. Хамтын ажиллагааны эрх зүйн үндэстэй холбоотой асуудал нь тухайн улсын шүүхийн харьяаллын үйл ажиллагаа болон зарим тохиолдолд тухайн асуудлаас хамаарч үнэндээ өөр өөр байдаг.

Авлигатай тэмцэх тал дээр олон улсын утга учир бүхий хамтын ажиллагаанд оролцох хүсэл эрмэлзэл байгаа ч ийм үр дүнтэй бөгөөд үр ашигтай хамтын ажиллагааг бий болгохын тулд шийдэх шаардлагатай бодит бэрхшээл, саад олон байна. Бэрхшээлд оролцогч улсад гэрээний дагуу өөрийн үүрэг хариуцлагаа биелүүлэхэд нь туслах хангалттай бөгөөд зохистой эрх зүйн орчин байхгүй байх явдал, шуурхай байдлаар тусламжаар хангахад саад болох хэт нарийн төвөгтэй, дарамттай мөн хэт албархаг журам, түүнчлэн нөөц буюу туршлагатай боловсон хүчний дутагдалтай байдал, байгууллагын хүчин чадлын хамтын ажиллагааг дэмжихэд хангалтгүй байдал орно.

43 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг хэрэгжүүлэхэд үүсч болзошгүй эрх зүйн, журмын болон үйл ажиллагааны холбогдох бүх асуудлыг тооцож үзэхийг оролцогч улсуудаас хүсч байна. Энэ заалтыг өргөн хүрээнд хэрэгжүүлэх явдлыг эрхэмлэвэл зохихыг оролцогч улс тооцож үзнэ. Оролцогч улсын холбогдох асуудалд гар бие оролцсон хуулийн мэргэжилтэн, эрх бүхий байгууллага 43 дугаар зүйлийн 1 дэх хэсэг болон конвенцийн 1(b) зүйлийн санаа, чиглүүлэгч зарчим нь олон улсын хамтын ажиллагааны тухай IV бүлгийн заалтуудад үйлчилж, өргөн хүрээнд уян хатан байдлаар ойлгон үр нөлөөтэй байдлаар хэрэгжүүлэх боломжийг олгож байгааг анхаарч үзэх хэрэгтэй.

II.1 Хоёр талаас гэмт хэрэгт тооцохтой холбоотой асуудал

43 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт хоёр талаас гэмт хэрэг гэж тооцсон байх тухай асуудлыг хөндсөн бөгөөд энэ нь ялангуяа шилжүүлэн өгөх тал дээр олон улсын хамтын ажиллагааны үндсэн зарчимд тооцогдсоор ирсэн юм. Энэ зарчмын дагуу өөрийн хууль тогтоомжийн дагуу тэдгээр үйлдлийг гэмт хэрэг гэж тооцсон тохиолдолд өөрийн шүүхийн харъяаллын гадна үйлдэгдсэн гэмт хэрэгтэй холбоотойгоор оргодлыг шилжүүлэн өгөх буюу туслалцаа үзүүлэхийг оролцогч улсаас шаардана. Хоёр талын гэрээ байгуулах тал дээр гарч буй сүүлийн үеийн хөгжил дэвшил нь ялангуяа шилжүүлэн өгөх тухай хууль болон үйл ажиллагаанд төвлөрч ирсэн бөгөөд хоёр талаас гэмт хэрэг гэж тооцох шаардлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой үүсэх бэрхшээлийг багасгах тал дээр тодорхой чармайлт үзүүлсэн юм. Ийнхүү хоёр улсын аль алины хуулиар гэмт хэрэг гэж үзэх үйлдлийг жагсааж, шийтгэл ногдуулахыг шаардахын оронд аль нэг улсад гэмт хэрэг гэж үзэн тодорхой шийтгэл ногдуулах гэмт хэргийг шилжүүлэн өгөхийг зөвшөөрдөг “гэмт хэргийн жагсаалт”-ын аргыг нэвтрүүлсэн гэрээ болон конвенцид энэ талаар ерөнхий заалтуудыг оруулж өгсөн болно. Энэ байдлаар хоёр улсад гэмт хэрэг гэж тооцох зарчмыг тогтоосноор хоёр улсын аль аль нь шинэ төрлийн гэмт хэргийг шийдвэрлэх хууль гаргах тохиолдолд эсхүл шилжүүлэн өгөх гэрээний гэмт хэргийн жагсаалт нь хоёр улсын аль алинд шийтгэж болох эрүүгийн гол гэмт хэргийн төрлийг санаандгүй байдлаар орхигдуулсан бол гэрээ болон хавсаргалтыг шинэчлэх шаардлага үүсэхээ болих юм.

43 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт үүнийг цааш нь үргэлжлүүлэн тухайн гэмт хэргийг тодорхойлоход хэрэглэж байгаа хуулийн нэр томъёо болон ийм гэмт хэргийг багтаах гэмт хэргийн ангилалаас үл хамааран хэрэв тухайн гэмт хэргийг бүрдүүлж буй үйлдэл нь туслалцаа үзүүлэхийг хүссэн аль аль оролцогч улсын хуулийн дагуу эрүүгийн гэмт хэрэгт тооцогддог бол олон улсын хамтын ажиллагаа явуулахад хоёр улсаас гэмт хэрэг гэж тооцсон байх шаардлага тавьж буй тохиолдол болгонд оролцогч улс энэ шаардлагыг биелүүлж байна гэж үзэхийг хүссэн

байна. Эрүүгийн гэмт хэргийн бүрдүүлж буй үйлдлийг оролцогч улсуудын аль алинд гэмт хэргийн нэг адил ангилалд багтаадаг буюу адил нэр томъёогоор нэрлэдэг байх шаардлагагүй бөгөөд хоёр улсаас гэмт хэрэг гэж тооцож байх ерөнхий жишгийг мөрдүүлэх тайлбар заалт конвенцид орсон болно. Ингэснээр энэ нь гэмт хэргийн үйлдлийг шийтгэхэд хэрэглэгдэж буй тодорхой хууль зүйн үг хэллэгийн ач холбогдлыг багасгаж, гэмт хэргийг бүрдүүлэгч бодит үйлдэл нь өөр өөр нэртэй хууль ёсны ангилалд багтаж байхаас ч үл хамааран гэрээг байгуулсан хоёр улсын хувьд шийтгэж болох эсэх дээр бодит байдлаар төвлөрч байх явдлыг дэмжиж байгаа юм. Үүнд тухайлбал хүсэлт өргөн барьсан гэмт хэргийг хүсэлт хүлээн авагч оролцогч улс бүрэн хүлээн зөвшөөрөхгүй байгаа тохиолдолд олон улсын хамтын ажиллагаанд үүсэх зарим нэг бэрхшээлийг арилгахыг чармайсан болно. Олон улсын хамтын ажиллагаа явуулах буюу туслалцаа үзүүлэхийг хүссэн (тодорхой босгоос дээш гарсан тохиолдолд шийтгэж болох) гэмт хэрэгт дотоодын хууль тогтоомжид нь дүйцэх гэмт хэрэг байгаа эсэхийг тогтоохыг хүсэлт хүлээн авагч зарим оролцогч улс хүсч болох ч конвенцид хүсэлтийг хүлээн авсан улсаас энэ асуудлыг өргөн хүрээний арга замаар шийдэхийг шаардсан байна. Ерөнхий Ассемблейн 45/116 тоот тогтоолоор баталсан, дараа нь мөн Ерөнхий Ассемблейн 52/88 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан Шилжүүлэн өгөх тухай гэрээний загвар нь хоёр улсаас гэмт хэрэг гэж тооцох шалгуурыг тогтоохдоо гэмт хэргийг бүрдүүлэгч үйлдлийг хүсэлт хүлээн авагч болон хүсэлт гаргагч оролцогч улсын хуулиар гэмт хэргийн адил ангилалд багтаадаг буюу адил нэр томъёогоор нэрлэдэг эсэхээс үл хамааран тухайн гэмт хэргийг бүрдүүлж буй үйлдлийг анхаарч үзнэ гэж чиглэл өгсөн төстэй заалтыг (2 дугаар зүйлийн 2 дэх хэсэг) багтаасан байгаа.

II.2. Төвийн буюу бусад эрх бүхий байгууллагын оролцоо

Төвлөрсөн журам бүхий чиг үүргийн дотоодын хуулийн болон институцийн орчинг бий болгох нь тулгараад буй бэрхшээлүүдийг даван туулах сайн арга замд тооцогдох бөгөөд төв (эрх зүйн тал дээр харилцан туслалцах тохиолдолд, конвенцийн 46 дугаар зүйл 13 дахь хэсгийг харна уу) –буюу бусад эрх бүхий (шилжүүлэн өгөх зэрэг олон улсын хамтын ажиллагааны бусад хэлбэр)- байгууллага ба энэ байгууллагын дотоодын болон оролцогч бусад улсын эрх бүхий байгууллагатай тодорхой байдлаар харилцаа тогтоосон байх шаардлагатай. Жишээ нь ийм төв/эрх бүхий байгууллага олон улсын хамтын ажиллагааны бүх шатанд оролцох эсэх мөн эдгээр нь хүсэлт хүлээн авч, хэрэгжүүлэх эсхүл гүйцэтгэх асуудлыг хариуцсан байгуулагад хүсэлтийг дамжуулах эсэхийг тодорхой заах нь зүйтэй. Ер нь олон улсын хамтын ажиллагаанд тууштай байдлыг нэвтрүүлэх, мөн ямар нэг нэмэлт үр ашиггүйгээр захиргааны түвшний хүнд суртлыг бий болгохоос боломжийн хэрээр зайлсхийхийн тулд эдгээр байгууллагын ажил үүргийг тодорхойлох шаардлага үүснэ. 43 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн хүрээнд үр дүнтэй хамтын ажиллагааг хөнгөвчлөх зохимжтой бодлого болоод журмыг тогтоохдоо оролцогч улс тэдний төв байгууллагын нөөц болон боловсон хүчин нь конвенцийн хүрээнд олон улсын хамтын ажиллагааны механизмыг бэхжүүлэхэд шаардлагатай баталгаа ба хамгаалалтыг бий болгох эсэхэд үнэлэлт өгөх хэрэгтэй.

Тухайлбал гадаад улсаас туслалцах шаардлагатай тийм авлигын хэргийг мөрдөн байцаах ажиллагааны хувьд ялангуяа өөр байцаан шийтгэх ажиллагаа буюу мөнгө угаах хэрэгт зэрэгцэн мөрдөн шалгах ажиллагаа явагдаж байгаа тохиолдолд мөрдөн байцаах ажиллагаа буюу хэргийг хариуцан ажиллаж буй тэдгээр байгууллага хоорондын үйл ажиллагааны холбоо болон хамтын

ажиллагааг хөнгөвчлөхийг төв байгууллагад үүрэг болгохыг зөвлөж болно. Ялангуяа мөрдөн байцаах ажиллагааны анхан шатанд өөр оролцогч улсуудын шүүхийн / мөрдөн байцаах байгууллагуудын хооронд шууд харилцаа холбоо тогтоох явдлыг дэмжих нь чухал. Үүний нэгэн адилаар олон улсын хамтын ажиллагааны асуудалд оролцсон төв/эрх бүхий байгууллага эрх мэдлийнхээ хүрээний асуудлаар хамтран ажиллаж буй оролцогч улсуудын авлигатай тэмцэх газар болон хууль сахиулах байгууллагын хооронд уялдаа, холбоог хөнгөвчлөх үйл ажиллагааны орчин, арга замыг бий болгож болно.

II.3. Хамтын ажиллагааны хүрээ

Дээр дурдсанчлан 43 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт олон улсын хамтын ажиллагааг дэмжих дотоодын хуулийн болон институцийн хамрах хүрээг хамгийн өргөн хүрээг хамарсан байдлаар мөн сайтар тооцоолон тогтоохыг хүссэн. Оролцогч улсууд авлигатай холбоотой мөрдөн байцаах, лавлах, яллах болон шүүнтаслах ажиллагаанд туслалцаа үзүүлэх хамгийн өргөн хүрээний арга хэмжээг авах үүднээс энэ асуудлыг зохицуулах шинэ хууль тогтоомж батлах буюу илүү оновчтой журам бий болгох түүнчлэн ямар ч тохиолдолд өөр хоорондын харилцааны сувгийг улам бэхжүүлэх боломжийг анхаарч үзнэ. Олон улсын зөв хамтын ажиллагааны жишээ олон байдаг бөгөөд энд 1998 онд Машатуд эхэлсэн дугуй ширээний цуврал хэлэлцүүлгийн оргил болсон Авлигын эсрэг Өмнөд Африкийн форумыг (SAFAC) дурдаж болох юм. Одоогоор Ангол, Ботсван, Лесото, Бүгд найрамдах Ардчилсан Конго улс, Малави, Маурити, Намиб, Мозамбик, Свазиланд, Танзани, Замби, Зимбаби дахь авлигатай тэмцэх газрууд SAFAC-ын гишүүн болоод байгаа юм. SAFAC оролцогч улсууддаа бүс нутгийн болон олон улсын хэмжээний авлигатай тэмцэхэд тулгарч буй бэхшээлийг даван туулах тал дээр (бүс нутгийн хэмжээний авлигатай тэмцэх SADAC-ын хөтөлбөр зэрэг) томоохон дэмжлэг үзүүлэх байдлаар харилцаа тогтоох боломжийг олгодог байна. Энэ талаар 46, 59 дүгээр зүйлд дэлгэрэнгүй авч үзнэ. Өөр нэг жишээ нь бүс нутгийн 28 орныг эгнээндээ нэгтгэсэн Азийн хөгжлийн банк – OECD Авлигатай тэмцэх Ази, Номхон далайн орнуудын санаачлага юм. 2005 оноос одоог хүртэл энэ санаачлагын нэг гол зорилго нь олон улсын үр дүнтэй хамтын ажиллагаанд үүсч буй саад бэрхшээлийг даван туулах байсаар ирсэн. Энэ зорилгодоо хүрэхийн тулд энэхүү санаачлагад хамрагддаг Ази, Номхон далайн (тэр үеийн тоогоор) 27 орон шүүхийн харъяалалд эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх, шилжүүлэн өгөх болон хөрөнгө буцаан олгох асуудлын хамрах хүрээ болон үйл ажиллагааны тухай нарийн, сэдэвчилсэн шүүмжийг явуулсан юм. Үүнээс гадна энэ санаачлагын зүгээс 2007 оны 9 сард хамтын ажиллагааг бэхжүүлэх талаар олон улсын семинар зохион байгуулсан билээ.

II.4. Эрүүгийн гэмт хэргийн асуудлаар олон улс хамтран ажиллах явцад үүсэх бодит бэрхшээлийг шийдэх материаллаг нөөцөөр хангах арга зам ба хэрэгсэл

Түншлэлийн төлөвлөгөө болон олон улсын хамтын ажиллагааны механизмнь бүрдсэн байлаа ч ихэнхдээ улс хоорондын элементийг багтаасан авлига зэрэг нарийн төвөгтэй гэмт хэргийг мөрдөн байцаах аливаа ажиллагаанд тухайн улсын эрүүгийн хэргийн шүүх болон хууль сахиулах байгууллагуудын хооронд ойр бөгөөд байнгын хамтын ажиллагаа шаардлагатай болдог. Шаардлагатай хүн хүч болон санхүүгийн нөөцөөс гадна тоног төхөөрөмж, хэрэгсэл, дэд бүтэц бэлэн байх нь оролцогч олон улсын гол санаа зовоосон асуудал болох төлөвтэй байна. Шаардлагатай боловсон хүчинд нарийн төвөгтэй бөгөөд эрчимтэй лавлагаа, банкны болон

аудитын арга хэрэгсэл, мэдээллийн эх сурвалж, эрсдэл бүхий гэрч зэрэг оролцсон хэргийг шийдэх үүрэг авсан хуулийн мэргэжилтэн, өмгөөлөгч, мөрдөн байцаагч болон санхүүгийн шинжээч орж болох юм. Зохих боловсон хүчин хангалтгүй байх нь конвенцийн IV бүлгийн шаардлагыг хэрэгжүүлэх боломж олгоход буюу үр дүнтэй хууль тогтоомжийн төслийг санаачлах оролцогч улсын чадамжид сөргөөр нөлөөлж болно.

Оролцогч зарим улс тэдэнд хэт их хэмжээний албан болон албан бус хүсэлт тавьж байгаагаас үүдсэн асуудалтай тулгарч болох юм. Хүсэлтийн хэт бөөгнөрөл болон үүний олон улсын хамтын ажиллагаанд учруулах дарамтаас зайлсхийхийн тулд оролцогч улс хүндрэлийг багасгах буюу бүрэн шийдэх зохих арга хэмжээг урьдаас тогтоох шаардлагатай. Ийм арга хэмжээний нэг нь “хүсэлт хүлээн авах” тодорхой шалгуур болон босго тогтоох замаар хэт их хүсэлт бөөгнөрөхөөс сэргийлж энэ асуудлыг хаязгаарлах юм. Ийм шалгуур нь, тухайлбал уг гэмт хэргийн ноцтой байдал эсвэл гэмт хэргээс олсон орлогын үнийн дүнтэй холбоотой байж болно. Энэ асуудалтай холбоотой үүсэх бусад бэрхшээл нь шилжүүлэн өгөх буюу эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэхэд үүсэх зардал түүнчлэн ийм хүсэлтийг хэрэгжүүлэхэд үүсэх саатал юм. Зарим тохиолдолд энэ нь туслалцаа үзүүлэхээс татгалзах байдалд ч хүргэж болдог. Үүнийг шийдвэрлэх боломжит нэг арга зам нь зардлыг хуваалцах тохиролцоог хийх байж болох юм. Энэ тохиолцоогоор хүсэлт гаргагч улс бичиг баримт орчуулах, боловсон хүчин буюу тоног төхөөрөмжөөр хангах, хувийн өмгөөлөгч хөлслөх зардлаас гадна видеоконферанс явуулах зэрэгт шаардагдах эд материалын болон онцгой зардлыг хариуцаж болно.

Илүү систематик байдлаар ийм томилгоог зөвтгөхүйц хэмжээний хамтын ажиллагааны ач холбогдол, шаардлага бүхий нэгэн бүс нутгийн улс орнууд буюу бүс нутаг эсхүл тивийн гол улсуудын төв байгууллагад эдгээр улсууд хоорондын уялдаа холбоог хариуцах хамтран ажиллагчийг томилох хоёр талын гэрээ, тохиролцоог хийхийг оролцогч улсад зөвлөж байна (конвенцийн 48 дугаар зүйл 1(e) хэсгийг харна уу). Олон улсын хамтын ажиллагаанд хамтран ажиллагчийн үүрэг нь оролцогч зочин улсын эрх бүхий байгууллагуудтай шууд холбоо тогтоох, мэргэжлийн харилцааг хөгжүүлэх, оролцогч хоёр улсын байгууллагууд хоорондын харилцан итгэлцлийг хөхиүлэн дэмжих юм. Хамтран ажиллагч зочин улсад ямар нэг эрх мэдэл эдлэхгүй ч авлигатай холбоотой хэргээс урьдчилан сэргийлж, үүнийг илрүүлэхэд мөн хариуцагчийг танин тогтоож, шүүхэд хүлээлгэн өгөхөд ашиглаж болох мэдээллийг цуглуулахад харилцаа холбоогоо ашиглаж болно. Түүнчлэн энэхүү харилцаа холбоогоо хамтран ажиллагч туслалцаа авахаар албан хүсэлт боловсруулах тал дээр зочин улсын хууль сахиулах, прокурын байгууллагад болон өөрийн орны холбогдох байгууллагад зөвлөгөө өгөхөд ашиглаж болох юм. Ийм хүсэлтийг өргөн барьсны дараа хамтран ажиллагч хүсэлтийг цагаа олсон байдлаар, амжилттайгаар боловсруулсанд итгэлтэй болохын тулд энэ хүсэлтийг мөрдөж, явц буюу аливаа саатлын шалтгааныг мэдээлж байна. Оролцогч хоёр улсын эрх зүйн тогтолцоо харьцангуй ялгаатай байгаа тохиолдолд энэ арга нь нилээд өгөөжтэй юм.

II.5. Чадамжийг бэхжүүлэх

Конвенцийн 60 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт шилжүүлэн өгөх болон эрх зүйн харилцан туслалцааны талаар оролцогч улсууд хооронд олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх явдлыг хөнгөвчлөх сургалт, туслалцаа болон холбогдох туршлага, мэргэжлийн мэдлэгийг харилцан

солилцох асуудлыг багтаасан авлигатай тэмцэх төлөвлөгөө, хөтөлбөрийн хүрээнд ялангуяа хөгжиж буй орны тусын тулд техникийн өргөн хүрээний тусламжийг харилцан үзүүлэх талаар бодолцож үзэхийг оролцогч улсад уриалсан байна.

Энэ тал дээр гол бүрдүүлэгч зүйл болох сургалтын хөтөлбөр нь авлигатай холбоотой хэргүүдийг мөрдөн байцаах, яллах ажиллагаа үүнд дотор санхүүгийн мөрдөн байцаах ажиллагаатай холбоотой хэрэгжиж болохуйц хууль, дүрэм журам болон туршлага дээр төвлөрсөн байхаас гадна дараах өргөн хүрээний үйл ажиллагааг хамарч болно:

- Хууль сахиулагч, прокурор, шүүгч буюу шүүхийн бусад ажилтанд тогтмол курс буюу уулзалтзөвөөгөөний нэг хэсэг болгож авлигатай тэмцэх ажилд оролцогчдын зүгээс лекц, илтгэл тавих;
- Холбогдох асуудлыг шийдэх институцийн, эрх зүйн орчин болон ярвигтай хэрэгт төвлөрдөг шүүгч, прокурор, хууль сахиулагч ба бусад холбогдох боловсон хүчинд зориулж олон улсын хамтын ажиллагааны талаар үндэсний, бүс нутгийн, бүс нутаг хоорондын воркшоп зохион явуулах;
- Нотлох баримтыг олж авах, нотлох баримтаар хангах, шилжүүлэн өгөх, авлигаас олсон орлогыг хязгаарлах, хураахтай холбоотой хүсэлтийг үр нөлөөтэй байдлаар боловсруулах, гүйцэтгэх явдлыг хэвшүүлэхэд чиглэсэн шүүгч, прокурорын сургалт явуулах;
- Ийм мэргэжилтнүүдэд зориулж холбогдох сургалтын аян зохион явуулах;
- Эрх зүйн болон хууль сахиулах талаар үндсэн сургалтын хөтөлбөрийн нэг хэсэг болгож олон улсын хамтын ажиллагааны талаар хөтөлбөр нэвтрүүлэх;
- Конвенцийн гэмт хэрэгт тооцох болон олон улсын хамтын ажиллагааны тухай заалтуудын талаар мэдлэг дээшлүүлэх, сургалт явуулах;

Ийм сургалтыг явуулахын зэрэгцээ олон улсын хамтын ажиллагааны эрх зүйн, институцийн болон үйл ажиллагааны орчны талаар чиглүүлэг өгөх сургалтын материал, хэрэгслийг тараах, түгээх хэрэгтэй. Ийм сургалтын материалд дараах материалууд орно:

- Шилжүүлэн өгөх тухай гэрээний загвар;
- Эрүүгийн асуудлаар харилцан туслалцах тухай гэрээний загвар;
- Шилжүүлэн өгөх тухай хуулийн загвар (2004);
- Эрүүгийн асуудлаар харилцан туслалцах тухай хуулийн загвар (2007);
- Үр нөлөөтэй байдлаар шилжүүлэн өгөх ажлын тухай илтгэл;
- Эрх зүйн харилцан туслалцааны ажлын зөв дадлын тухай илтгэл.

III. Шалгах асуултууд

- Олон улсын хамтын ажиллагааны асуудлыг шийдэхэд оролцогч улсын эрх бүхий байгууллага аль эрх зүйн үндсийг ашигладаг вэ?
- Гэрээнд суурилсан хамтын ажиллагааны үед олон улсын хамтын ажиллагааны тухай хүсэлтийг өргөн барих / гүйцэтгэхэд оролцогч улс энэхүү конвенцийг эрх зүйн үндэс болгож ашигладаг уу? Конвенцийн олон улсын хамтын ажиллагааны тухай заалтуудыг

сайжруулах буюу үүнд бодит байдлаар нөлөөлөх хоёр талт эсхүл олон талт гэрээг / тохиролцоог оролцогч улс байгуулсан уу?

- Оролцогч улсад олон улсын хамтын ажиллагааны хүсэлтийг шийдэх төв / бусад эрх бүхий байгууллага байгаа юу?
- Энэхүү байгууллага нь олон улсын хамтын ажиллагааны хүсэлтийг шийдэхэд мэргэжилтэн, санхүүгийн нөөц болон технологийн арга хэсэгслийн хувьд бэлэн үү?
- Олон улсын хамтын ажиллагааны тал дээр үүсэх үйл ажиллагааны болон бодит бэрхшээлийг шийдэх, уялдуулах тал дээр энэ байгууллага болон өөр улс дахь үүнтэй ижил үүрэг бүхий байгууллага хооронд харилцааны суваг бий болсон уу?

44 дүгээр зүйл: Шүлжүүлэн өгөх

1. Шилжүүлэн өгөх этгээд нь хүсэлт хүлээн авагч оролцогч улсын нутаг дэвсгэрт байгаа тохиолдолд энэ конвенциор тодорхойлсон гэмт үйлдлийн хувьд энэ зүйлийг хэрэглэх бөгөөд ингэхдээ шилжүүлэн өгөх хүсэлт тавих болсон үйлдэл нь хүсэлт гаргагч, хүлээн авагч оролцогч улсын аль алиных нь дотоодын хуулиар ял шийтгэл оногдуулахаар заасан байвал зохино.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг үл харгалзан, энэ Конвенцид заасан гэмт үйлдэлд холбогдсон этгээдийг шилжүүлэх өгөхийг дотоодын хууль тогтоомж нь зөвшөөрч байгаа тохиолдолд уг гэмт үйлдийг дотоодын хууль тогтоомжоор нь ял шийтгэл оногдуулахаар заасан эсэхээс үл хамаарч шилжүүлэн өгч болно.

3. Хэрэв шилжүүлэн өгөх тухай хүсэлт нь хэд хэдэн тусдаа гэмт үйлдэлд холбогдож байгаа бөгөөд тэдгээрийн аль нэг нь энэ зүйлийн дагуу шилжүүлэн өгөх хэрэг, бусад нь хорих хугацаанаасаа хамааран шилжүүлэн өгөх хэрэг биш байсан нь энэ конвенциор тодорхойлсон гэмт үйлдэлд бол хүсэлт хүлээн авагч оролцогч улс энэ зүйлийг тэдгээр гэмт үйлдлийн хувьд хэрэглэж болно.

4. Энэ зүйлийг хэрэглэх гэмт хэрэг бүрийг оролцогч улсуудын хооронд байгуулсан гэмт хэрэгтэн шилжүүлэн өгөх тухай аливаа гэрээнд оруулсанд тооцно. Эдгээр гэмт үйлдлийг оролцогч улсуудын харилцан байгуулах гэмт хэрэгтэн шилжүүлэн өгөх тухай гэрээнд хамаарах гэмт үйлдэлд тооцох үүрэг хүлээнэ. Дотоодын хуулиа нь тийнхүү зөвшөөрсөн оролцогч улс энэхүү конвенцийг гэмт хэрэгтэн шилжүүлэн өгөх үндэслэл болгон ашиглаж байгаа тохиолдолд энэ конвенциор тодорхойлсон аливаа гэмт үйлдлийг улс төрийн гэмт хэрэг гэж үзэхгүй.

5. Хэрэв Гэмт хэрэгтийг гагцхүү гэрээний үндсэн дээр шилжүүлэн өгөх нөхцөл тавьдаг оролцогч улс хоёр талын гэрээ байгуулаагүй нөгөө оролцогч улсаас гэмт хэрэгтэн шилжүүлэн өгөх тухай хүсэлт хүлээн авбал энэ зүйлд хамаарах аливаа гэмт үйлдлийн хувьд энэ конвенцийн заалтыг гэмт хэрэгтэн шилжүүлэн өгөх эрхзүйн үндэслэл гэж үзэж болно.

6. Гэмт хэрэгтийг гэрээний үндсэн дээр шилжүүлэн өгөх нөхцөл тавьдаггүй оролцогч улс:

(а) Энэхүү конвенцийг гэмт хэрэгтэн шилжүүлэн өгөх асуудлаар энэхүү конвенцид оролцогч бусад улстай хамтран ажиллах эрх зүйн үндэс болгон хэрэглэх эсэхээ энэхүү

конвенцийн батламж жуух бичиг, түүнийг хүлээн зөвшөөрсөн, баталсан буюу нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулахдаа Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэнэ;

(b) Хэрэв энэхүү конвенцийг гэмт хэрэгтэн шилжүүлэн өгөх асуудлаар хамтран ажиллах эрхзүйн үндэслэлд тооцохооргүй тохиолдолд энэ зүйлийг хэрэгжүүлэх үүднээс конвенцид оролцогч бусад улстай зохих тохиолдолд гэмт хэрэгтэн шилжүүлэн өгөх тухай гэрээг байгуулахыг эрмэлзэнэ.

7. Гэмт хэрэгтийг гэрээний үндсэн дээр шилжүүлэн өгөх нөхцөл тавьдаггүй оролцогч улсууд энэ зүйлд хамаарах гэмт үйлдлийг гэмт хэрэгтэн шилжүүлэх гэмт хэрэг гэж хүлээн зөвшөөрнө.

8. Гэмт хэрэгтэн шилжүүлэх ажиллагаа нь хүсэлт хүлээн авагч оролцогч улсын дотоодын хууль болон гэмт хэрэгтэн шилжүүлэн өгөх тухай холбогдох гэрээнд заасан нөхцлүүд, түүний дотор ялангуяа, гэмт хэрэгтэнд хамгийн хөнгөн ял ногдуулах шаардлага, болон хүсэлт хүлээн авагч оролцогч улс тухайн этгээдийг шилжүүлэн өгөхөөс татгалзах үндэслэлд тус тус нийцэн гүйцэтгэгдэнэ.

9. Оролцогч улсууд дотоодын хууль тогтоомжоо мөрдөхийн сацуу энэ зүйлд хамаарах аливаа гэмт үйлдлийн хувьд шилжүүлэн өгөх ажиллагааг түргэтгэх, холбогдох нотлох баримтын шаардлагыг хялбарчлахыг чармайна.

10. Хүсэлт хүлээн авагч оролцогч улс дотоодын хууль болон гэмт хэрэгтэн шилжүүлэн өгөх гэрээнийхээ заалтыг мөрдөхийн сацуу нөхцөл байдал шаардлагатай хийгээд хойшлуулашгүй гэж үзсэн бөгөөд хүсэлт гаргагч оролцогч улс нутаг дэвсгэрт нь байгаа шилжүүлж авах этгээдийг цагдан хорих тухай хүсэлт гаргасан тохиолдолд тухайн этгээдийг шилжүүлэх ажиллагаанд байлгах нөхцлийг хангах үүднээс шаардлагатай арга хэмжээг авч болно.

11. Сэжигтэн этгээд нутаг дэвсгэрээс нь олдсон оролцогч улс тухайн этгээдийг энэ зүйлд хамаарах гэмт үйлдлийн хувьд өөрийн харьяат гэсэн ганц үндэслэлээр шилжүүлэн өгөхгүй тохиолдолд хүсэлт тавьж буй оролцогч улсын хүсэлтээр хэргийг өөрийн эрх бүхий байгууллагаар шалгаж, шийдвэрлүүлэхээр, цаг алдалгүй шилжүүлэх үүрэг хүлээнэ. Эрх бүхий байгууллага нь тухайн оролцогч улсын дотоодын хууль тогтоомжийн дагуу аливаа бусад ноцтой гэмт үйлдлийн адил шийдвэр гаргаж, байцаан шийтгэх ажиллагаа явуулна. Холбогдох оролцогч улсууд тэрхүү ялах ажиллагааны үр ашигтай байдлыг хангах үүднээс нэн ялангуяа процессийн болон нотолгооны асуудлаар хамтран ажиллана.

12. Оролцогч улс өөрийн харьяат иргэнийг гагцхүү тухайн шилжүүлэн өгөх буюу бусад байдлаар хүлээлгэн өгөх шаардлагатай болсон гэмт үйлдлийг хуулийн дагуу шийдвэрлэсний эцэст оноосон ялыг өөрийн улсад эдлүүлэ хнөхцөлтэйгөөр шилжүүлэн өгөх буюу бусад байдлаар хүлээлгэн өгөхийг дотоодын хууль тогтоомж нь зөвшөөрсөн бөгөөд тухайн оролцогч улс шилжүүлэн авах хүсэлт гаргаж буй оролцогч улс ийм нөхцлийг харилцан тохиролцсон эсхүл

зохистой гэж үзсэн бусад болох бусад нөхцлийг зөвшөөрсөн тохиолдолд шилжүүлэн өгөх буюу өгөх нь энэ зүйлийн 11 дэх хэсэгт заасан үүргээс чөлөөлөгдөх хангалттай үндэслэл болно.

13. Оногдсон ялыг эдлүүлэх зорилгоор гэмт хэрэгтэнг шилжүүлэн авах оролцогч улсын хүсэлтээс нөгөө оролцогч улс тухайн этгээд тус улсын иргэн гэсэн үндэслэлээр татгалзах тохиолдолд хүсэлт хүлээн авагч улс дотоодын хууль тогтоомжоор нь зөвшөөрсөн буюу хуульд нийцэх эсэхийг нь харгалзан хүсэлт гаргагч улсын дотоодын хуулийн дагуу ногдуулсан ял буюу үлдсэн ялыг эдлүүлэх асуудлыг авч үзнэ.

14. Энэ зүйл хэрэглэгдэх аливаа гэмт үйлдэлтэй холбогдуулан шалгаж буй аливаа этгээдтэй байцаан шийтгэх ажиллагааны бүх шатанд шударгаар харьцах, түүний дотор тухайн этгээд нутаг дэвсгэрт нь байгаа оролцогч улсын дотоод хуулиар олгосон бүхийл эрх, баталгааг эдлэх баталгаагаар хангана,

15. Хэрэгтэн шилжүүлэн өгөх хүсэлтийг авсан оролцогч улс тэрхүү хүсэлтийг тухайн этгээдийг хүйс, арьс үндэс, шашин шүтлэг, иргэний харьяалал, арьс үндэс буюу улс төрийн итгэл үнэмшлийнх нь улмаас яллах буюу шийтгэх зорилгоор гаргасан эсхүл тухайн хүсэлтийг биелүүлбэл тухайн этгээдийн байдалд эдгээр шалтгааны аль нэгийг улмаас хохирол учирна гэж үзэх баттай үндэслэл байгаа бо энэхүү конвенцийн аль ч заалтыг заавал шилжүүлэн өгөх үүрэг хүлээлгэж байгаагаар тайлбарлаж үл болно.

16. Оролцогч улсууд гэмт үйлдлийг санхүүгийн асуудалтай холбоотой гэсэн ганц үндэслэлээр шилжүүлэн өгөх хүсэлтийг биелүүлэхээс татгалзаж үл болно.

17. Хүсэлт хүлээн авагч оролцогч улс гэмт этгээдийг шилжүүлэн өгөхөөс татгалзахынхаа өмнө хүсэлт гаргагч оролцогч улсад үзэл бодлоо илэрхийлэх, хүсэлтэд заасан асуудлаар мэдээлэл өгөх хангалттай боломж олгохын тулд шаардлагатай гэж үзвэл тухайн улстай зөвлөлдөнө.

18. Оролцогч улсууд шилжүүлэн өгөх ажиллагааг гүйцэтгэх буюу үр нөлөөг дээшлүүлэх үүднээс хоёр болон олон талт хэлэлцээр, тохиролцоо байгуулахыг эрмэлзэнэ.

I. Ерөнхий тойм

Шилжүүлэн өгөх нь олон улсын хамтын ажиллагааны уламжлалт нэг хэлбэр бөгөөд хүсэлт гаргагч улс яллах буюу ял ногдуулах зорилгоор оргодол этгээдийг шилжүүлэн өгөхийг хүсэлт хүлээн авагч улсаас хүссэнээр явагдах ажиллагаа гэж тодорхойлно.

Шилжүүлэн өгөх үйл явц нь техникийн талаас нилээд ярвигтайгаас гадна шүүхийн болон захиргааны шинжтэй олон үе шатыг дамжих шаардлагатай. Хүсэлт гаргагч улс гэмт этгээдийг танин тогтоогоод түүнийг шилжүүлэн өгөхийг хүсч хүсэлт хүлээн авагч улстай холбоо барина. Ингэхдээ тухайн этгээд шилжүүлэн өгөх зайлшгүй шаардлагатай тийм гэмт хэрэг үйлдсэн, нотолхуйц үр нөлөөтэй нотолгоо гаргаж ирэхийг шаарддаг. Энэхүү нотолгооны стандарт нь нийгмийн эдийн засаг, эх газрын эдийн засгийн тогтолцооны өөрөөр дадал хандлагаас хамаарч

харилцан адилгүй байдаг бөгөөд “гэм буруутайг тогтоох анхан шатны нотолгоо гаргах” илүү хөнгөрүүлсэн шаардлага тавих, шилжүүлэн өгөх баримт бичиг дэх мэдээлэл нь хүсэлтийг зөвтгөхөд хангалттай байх зэргээр өргөн хүрээнд хэлбэлзэж байна.

II. Бэрхшээл ба шийдэл

II.1. Өнөөгийн санаа зовоосон асуудлыг шийдвэрлэх тухай

Зарчмын хувьд хүсэлт хүлээн авагч улс шилжүүлэн өгөх хүсэлтийг нааштайгаар хүлээн авбал гэмт этгээдийг баривчлан сануулж, үүнд уг шилжүүлэн өгөх хүсэлтэд эсэргүүцэх эрх олгож эрүүгийн буюу эсвэл захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулсны үндсэн дээр тухайн этгээдийг шилжүүлэн өгөх нь зүйтэй гэж үзвэл үүнийг хүсэлт гаргагч улс руу шилжүүлж өгнө.

Хоёр талын аль аль нь шилжүүлэн өгөх тухай үндэсний / олон улсын хууль, үйл ажиллагааг эсхүл шилжүүлэн өгөх хүсэлтэд татгалзсан хариу өгөх үндэслэл, шилжүүлэн өгөх үйл явцыг түргэсгэх, сайжруулах арга зам, хэрэгслийг мөн ял шийтгэлээс чөлөөлөгдөх явдлаас зайлсхийхийн тулд шилжүүлэн өгөхийн оронд авч болох хууль ёсны өөр арга хэмжээг мэдэхгүй байх явдал өргөн ажиглагддаг.

Үүнээс гадна дээр дурдсан хүсэлт хүлээн авагч улсын баримталдаг нотолгооны шаардлагын ялгаатай байдлыг хүсэлт гаргагч улс хангалттай ойлгоогүй байж болох бөгөөд үүнээс үүдэн шилжүүлэн өгөх явцад саад болон удаашрал гарсан байж болно.

Энэ тохиолдолд тус үйл ажиллагаанд олон төрлийн асуудал тулгарч болох төдийгүй үүнээс үүдэн бодит бэрхшээлүүд гарч болно:

- Хэлтэй холбоотой асуудал –шилжүүлэн өгөх тухай хүсэлт болон хавсралт материалыг орчуулах нь өндөр зардалтай;
- Хэт давчуу хугацаа -энэ нь ихэнхдээ тайлбарын ноцтой алдаа гарахад хүргэдэг;
- Холбоо тогтоосон улсуудын эрх бүхий байгууллага хоорондын төдийгүй цаашлаад дотооддоо харилцаа, уялдаа холбооны асуудал үүсгэдэг.
- Хүсэлт гаргагч болон хүсэлт хүлээн авагч улсуудад их хэмжээний зардал үүсэх ба энэ нь шилжүүлэн өгөх үйл явцын үр нөлөө хийгээд үр ашигт сөргөөр нөлөөлнө.

II.2. Орчин, хам нөхцлийг өөрчлөх

Шилжүүлэн өгөх тухай хуулийн сүүлийн үеийн чиг хандлага, хөгжил нь шилжүүлэн өгөхөөс татгалзахад тодорхой үндэслэлийн чанд хэрэгжих байдалд зөөлрөх аяс гарч байгаа дээр төвлөрч байгаа юм. Жишээ нь, оролцогч олон улсад өөрийн харьяатыг шилжүүлэх тал дээр дурамжхан байх явдал нилээд өөрчлөгдөх шинжтэй байна. UNCAC-д энэ хандлагыг тусгасан нэг заалт багтсан: 44 (12) заалт оргодлыг ногдуулсан ялыг нь эдлүүлэхээр түүний тухайн хүсэлтийг гаргагч оролцогч улсад нь буцаан өгөх нөхцөлтэйгээр түр шилжүүлэн өгөх боломжийг тусгасан. Хүсэлт хүлээн авагч оролцогч улс оргодлыг өөрийнх нь харьяат гэсэн цорын ганц үндэслэлээр

шилжүүлэн өгөхгүй тохиолдолд тухайн оролцогчулс тэрхүү этгээдийн хэргийг шүүн таслах үүрэг хүлээнэ. (UNCAC, 44 дүгээр зүйл 11 дэх хэсэг). Энэ нь *aut dedere aut judicare* (нэг бол шилжүүлэн өг нэг бол шүүн тасал) зарчимд нийцэж байгаа бөгөөд цаашлаад зохих шүүхийн харъяаллын үндэслэлийг шаардаж байна (42 дугаар зүйл 3 дахь хэсгийг харна уу). Ял эдлүүлэх зорилгоор шилжүүлэн өгөхийг хүсч байгаа тохиолдолд хүсэлтийг хүлээн авагч оролцогч улс өөрийн дотоодын хуулийн шаардлагын дагуу ногдуулсан ялыг эдлүүлж болох юм (UNCAC, 44 дүгээр зүйл 13 дахь хэсэг).

Сүүлийн үеийн хөгжил дэвшлээс харвал улс төрийн хэргийг үл хамааруулах байдлын цар хүрээг хязгаарлах буюу үүнийг бүрмөсөн цуцлах оролдлогууд хийгдэх болсон байна. Шилжүүлэн өгөх тухай загвар гэрээний 1990 онд батлагдсан анхны бичмэлд үл хамааруулах байдлыг, шилжүүлэн өгөхөөс татгалзах зайлшгүй үндэслэл болгон багтаасан байсан юм (3(a) заалт). Энэ загвар гэрээний дахин хянасан хувилбарт шилжүүлэн өгөхгүй тохиолдолд яллах ажиллагааг явуулахыг ямар нэг олон талт конвенцоор оролцогч улсад үүрэг болгосон ноцтой гэмт хэрэгт улс төрийн хэргийг үл хамааруулах зарчим үйлчлэхгүй байхаар энэ заалтыг улам хязгаарлаж өгсөн байна. Цаашлаад олон улсад террор ажиллагаа ихэссэнтэй холбоотойгоор оролцогч улсууд улс төрийн хэргийг үл хамаарах зарчмын хэрэгжих цар хүрээг улам хязгаарлахыг хүсэх болсон юм. Энэ нь олон улсын хуулийн эсрэг гэмт хэрэгт хэрэгждэггүй билээ. Цөөнгүй оролцогч улс тухайн гэмт хэрэг улс төрийн сэдэлтэй байж болох тохиолдолд шилжүүлэн өгөхөөс татгалзаж болох ч (жишээ нь гадаад амьдарч буй улс төрийн хуучин тэргүүний эсрэг) олон улсад террор ажиллагаа ихэссэнтэй холбоотойгоор оролцогч улсууд улс төрийн хэргийг үл хамаарах зарчмын хэрэгжих цар хүрээг улам хязгаарлахыг хүсэх болсон. Тэгээд ч шилжүүлэн өгөхөөс татгалзсан тохиолдолд прокурорын яллах ажиллагааг явуулахыг ямар нэг олон талт конвенцоор оролцогч улсад үүрэг болгосон жигшүүрт гэмт хэрэгт улс төрийн хэргийг үл хамааруулах зарчим үйлчлэхээ ер нь больсон байна. Түүнчлэн хүчирхийллийн гэмт хэрэгт улс төрийн хэргийг үл хамааруулах зарчим хэрэгжихгүй болох хандлага ажиглагдаж байгаа юм.

Энэхүү конвенцийг гэмт хэрэг үйлдэн шилжүүлэн өгөх үндэс болгон ашиглаж байгаа тохиолдолд тухайн хэрэгт улстөрийн гэмт үйлдлийг үл хамаарах зарчим үйлчлэхгүй (44 (4) зүйл).

II.3. Шилжүүлэн өгөх эрх зүйн хүрээг тогтоох

Улсууд шилжүүлэн өгөх явдлыг хялбаршуулах зохих эрх зүйн хүрээг бүрдүүлэн шилжүүлэн өгөх гэрээнийхээ хамрах хүрээг өргөсгөх буюу холбогдох хууль тогтоомжиндоо өөрчлөлт оруулахыг эрмэлзэнэ. Конвенц шилжүүлэн өгөх хамгийн доод үндсэн жишгийг тогтоож байгаа бөгөөд гэмт хэрэгтнийг гэрээний үндсэн дээр шилжүүлэн өгөх нөхцөл тавьдаг оролцогч улсаас энэхүү конвенцийг гэмт хэрэгтэн шилжүүлэн өгөх үндэс болгон ашиглах эсэхээ мэдэгдэхийг, хэрэв ийм нөхцөл тавьдаггүй бол 44 дүгээр зүйлийг хэрэгжүүлэхийн тулд гэрээ байгуулахыг (44 дүгээр зүйл, 6(b) хэсэг), түүнчлэн шилжүүлэн өгөлтийн үр нөлөөг дээшлүүлэх үүднээс хоёр талт болон олон талт хэлэлцээр, тохиролцоо байгуулахыг (44 дүгээр зүйл, 18 дахь хэсэг) хүссэн. Гэмт хэрэгтнийг гэрээний үндсэн дээр шилжүүлэн өгөх нөхцөл тавьдаггүй оролцогч улсуудаас шилжүүлэн өгөх тухай хууль тогтоомжоо оргодлыг шилжүүлэн өгөх эрх

зүйн үндэс болгон ашиглаж, энэ зүйлд хэрэглэгдэх гэмт үйлдлийг өөр хоорондоо шилжүүлэн өгөх гэмт хэрэг хэмээн хүлээн зөвшөөрөхийг (44 дүгээр зүйл, 7 дахь хэсэг) хүссэн байна.

Энэ конвенцид заасан гэмт үйлдэлд холбогдсон этгээдийг шилжүүлэн өгөхийг дотоодын хууль тогтоомж нь зөвшөөрч буй тохиолдолд уг гэмт үйлдлийг дотоодын хууль тогтоомжоор нь ял шийтгэл ноогдуулахаар заасан эсэхээс үл хамааран шилжүүлж өгч байна. (44 (2) гэж зааснаар хоёр талаас гэмт хэрэг гэж тооцсон байх шаардлагыг цуцлахыг зөвшөөрсөн байна.

Энэхүү конвенцийн бусад тодорхой тооны зүйлд оролцогч улс хууль тогтоомжоо өөрчлөх шаардлага гарч болзошгүй гэж таамагласан байгаа. Дотоодын хууль тогтоомж болон хүчин төгөлдөр гэрээнд шилжүүлэн өгөх асуудлыг ямар хэмжээнд шийдсэн байгаагаас хамааран өөрчлөх шаардлага нь конвенцийг мөрдүүлэх явдлыг хангахын тулд нэн чухал ба журмын өөрчлөлт хийх болон шинэ гэмт хэргийг багтаахаар шинээр шилжүүлэн өгөх орчинг бий болгох зэргээр арай бага хэмжээний өргөжүүлэлт буюу өөрчлөлт хийх хүртэл хэлбэлзэж болох юм. Ер нь шилжүүлэн өгөх тухай заалтуудыг конвенцийг зүгээс урьдаас тогтсон шилжүүлэн өгөх орчинг дэмжих, гүйцэлдүүлэх мөн тэдгээрийг доош нь татахгүй байх явдлыг хангах байдлаар заахыг хичээсэн болно.

Гэхдээ улсууд шинэ гэрээнд гарын үсэг зурахаас гадна ялангуяа гэмт хэргийн тухай зарим нэг конвенц шилжүүлэн өгөх талаар заалтуудыг багтаасан гэдгийг анхаарч үзвэл зохино. (Жишээ болгон, Олон улсын худалдааны хэлэлцээрт гадаадын төрийн албан тушаалтныг хахуульдахтай тэмцэх OECD-ын 1997 оны конвенцийг (10 дугаар зүйл), болон Улс хоорондын зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх НҮБ-ын конвенцийг (16 дугаар зүйл) харна уу). Үүнээс гадна оролцогч улсууд хоорондын хамтын ажиллагааг дэмжих шилжүүлэн өгөх асуудлыг тухайлан авч хэлэлцсэн бүс нутгийн шинжтэй олон тооны баримт бичиг байдаг бөгөөд үүнд Шилжүүлэн өгөх тухай Америкийн улсуудын конвенц, Шилжүүлэн өгөх тухай Европын конвенц ба үүний нэмэлт хоёр протокол, Шилжүүлэн өгөх тухай Баруун Африкийн улсуудын эдийн засгийн нийгэмлэгийн конвенц, Оргодол гэмт этгээдийг шилжүүлэн өгөх тухай Хамтын нөхөрлөлийн орнуудын төлөвлөгөө (1966 онд баталсан, 1990 онд өөрчлөлт оруулсан), Шилжүүлэн өгөх тухай Арабын улсуудын холбооны хэлэлцээр (1952) орно.

II.4. Журмыг сайжруулах

Гадаадын улсын баривчлах зөвшөөрлийг дэмжих, хүлээн зөвшөөрөх тогтолцоог багтаан шилжүүлэн өгөх үйл явцыг хялбарчлах, сайжруулах боломжийг олгох арга хэмжээг нэвтрүүлэх асуудлыг оролцогч улс тооцож үзэж болох юм. Баривчлах зөвшөөрлийг дэмжих нь шилжүүлэн өгөх ажиллагаанд харьцангуй анхан үе шатанд байгаа улс орнууд хоорондын шилжүүлэн өгөхийн хялбаршуулсан хэлбэр бөгөөд үүнд баривчлах зөвшөөрлийг хоёр талаас хүлээн зөвшөөрнө хэмээн тохиролцож ингэснээр нэг улсын эрх бүхий байгууллагын гаргасан баривчлах тушаал нөгөө улсад хүчин төгөлдөр гэж тооцогдож, хэрэгжих юм. Ийм төлөвлөгөөний хамгийн сайн жишээ нь нийтлэг хуулийн уламжлал бүхий улсуудад голлон хэрэгждэг Хамтын нөхөрлөлийн орнуудын төлөвлөгөө юм. Энэхүү төлөвлөгөөний хувилбарууд Сингапур, Малайз ба Бруней хооронд; Австрали ба Шинэ Зиланд хооронд; Их Британи ба Чанал сувгийн тодорхой арлууд хооронд амжилттайгаар хэрэгжиж байна. 2004 оны эхэнд Европын холбооны хүрээнд нэг

шинэ журам хэрэгжиж эхэлсэн бөгөөд, гишүүн орнууд хооронд шилжүүлэн өгөх уламжлалт ажиллагааны оронд Европын баривчлах зөвшөөрөл (ЕБЗ)-ийг танилцуулж нэвтрүүлсэн юм.

ЕБЗ-ийн бүтцийн шийдвэр ба Европын холбооны гишүүн улсуудын хооронд шилжүүлэн өгөх журам (ЕБЗ-ийг 2002 оны 6 сарын 13-нд Европын холбооны зөвлөлөөр танилцуулсан) нь Европын холбооны хүрээнд эрүүгийн асуудлаар хамтын ажиллагааны тулгын чулуунд тооцогдох шүүхийн шийдвэрийг харилцан хүлээн зөвшөөрөх зарчим дээр тулгуурладаг. Энэ нь шүүхийн шийдвэр болон шүүхийн эрх бүхий байгууллагын бусад шийдвэрт хамаардаг юм. Бүтцийн шийдвэрт “Европын баривчлах зөвшөөрөл”-ийг эрүүгийн прокурорын яллах ажиллагааг явуулах буюу цагдан хорих болон түр саатуулах шийдвэрийг гүйцэтгэх зорилгоор гишүүн улсын зүгээс тухайн хүсэлт хамаарах этгээдийг баривчлах буюу шилжүүлэн өгөх үүднээс гишүүн улсын гаргасан аливаа шүүхийн шийдвэр гэж тодорхойлсон байна (1(1) зүйл). Баривчлах зөвшөөрлийг гаргаж буй улсын хуулиар хорих ял эсхүл 12 сараас багагүй хугацаар саатуулах тушаал гарган шийтгэж болох буюу аливаа ял ногдуулсан эсхүл 4 сараас багагүй хугацаагаар саатуулах тушаал гарсан тийм үйлдэлд ЕБЗ-ийг гаргаж болно (2 дугаар зүйл 1 дэх хэсэг).

ЕБЗ нь үүний нэгдэн орсон гишүүн улсуудад шилжүүлэн өгөх тухай уламжлалт журмыг орлох бөгөөд тэдгээр нь нэг улс мэтээр өөр хоорондоо шилжүүлэн өгөх ажиллагааг хялбарчилж, түргэсгэх хялбар бөгөөд шуурхай баривчлах зөвшөөрлийн нийтлэг тогтолцоог бий болгож байна. Энэ нь дараах шинэлэг журмуудыг нэвтрүүлж байгаа юм:

- *Шуурхай ажиллагаа*: ЕБЗ-ийг гүйцэтгэх эцсийн шийдвэрийг тухайн гаргасан хүсэлтэд хамаарах этгээдийг баривчилснаас хойш 90 хоногоос ихгүй хугацаанд гаргах ёстой. Хэрэв тухайн этгээд шилжүүлэн өгөхийг зөвшөөрвөл зөвшөөрлийг өгснөөс хойш 10 хоногийн дотор шийдвэр гарах ёстой.
- *Урьдаас тогтоосон хэрэгт хоёр талаас гэмт хэрэг гэж тооцсон байх шаардлагыг цуцлах*: Шилжүүлэн өгөх тухай уламжлалт хуульд ул суурьтайгаар хэвшсэн хоёр талаас гэмт хэрэг гэж тооцсон байх зарчмыг зөвшөөрөл гаргагч гишүүн улсын хуулиар тодорхойлсон, 3 жилээс багагүй хугацаагаар хорих ял ногдуулж болох мөн ЕБЗ-ийн бүтцийн шийдвэрийн 2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт жагсаасан 32 гэмт хэрэгт хэрэгжүүлэхээ больсон болно. Эдгээр хэрэгт *inter alia* авлига болон гэмт хэргээс олсон орлогыг угаах багтаж байгаа юм. Энэ жагсаалтад багтаагүй буюу 3 жилийн хорих ял ногдуулах босгод хүрээгүй гэмт хэрэгт хоёр талаас гэмт хэрэг гэж тооцсон байх зарчим үйлчилсэн хэвээр байна (2 дугаар зүйлийн 4 дэх хэсэг).
- *Шилжүүлэн өгөх явдлыг “Хууль ёсны болгох”*: ЕБЗ-д тулгуурласан шилжүүлэн өгөх талаар шинэ журам нь гүйцэтгэх засаглалын үйл ажиллагааны хүрээнээс гарч шүүхийн эрх мэдэлд шилжсэн. Шилжүүлэн өгөх тухай тушаал гаргах болон энэ тушаалыг гүйцэтгэх эрх мэдэл нь шүүхийн эрх мэдэлд тооцогдох болсон ба энэ нь шилжүүлэн өгөх асуудлаар тушаал гаргаж буй гишүүн улсуудын хуулиар зөвшөөрсний дагуу шилжүүлэн өгөх асуудлаар тушаал гаргах, тушаалыг гүйцэтгэх нь эрх бүхий шүүхийн байгууллагад харьяалагдах болсон юм. Иймээс ЕБЗ-ийг гүйцэтгэх журам нь юун түрүүнд шүүхийн ажиллагаанд хамаарах болсон тул шилжүүлэн өгөх асуудлын зайлшгүй нэг хэсэг болсон захиргааны үе шат буюу өөрөөр хэлбэл хүсэлт гаргагч оролцогч улсад эрэн

- сурвалжлагдаж буй этгээдийг шилжүүлэн өгөх талаар эцсийн шийдвэр гаргах тухай гүйцэтгэх эрх мэдэл бүхий байгууллагын бүрэн эрхийг цуцалж байгаа болно.
- *Гишүүн улсын харъяатыг шилжүүлэн өгөх:* Европын холбооны гишүүн орнууд өөрийн харъяатыг шилжүүлэн өгөхөөс татгалзах эрхгүй болсон. Бүтцийн шийдвэр нь иргэний харъяаллыг шилжүүлэн өгөх хүсэлтийн үл гүйцэтгэх зайлшгүй эсхүл сонгож болох үндэслэл болгож тооцохгүй байгаа. Цаашлаад 5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт гэм бүруутай нь тогтоогдсны дараа хувь этгээдийн ялыг нь тэнд эдлүүлэхээр харъяалагдах улсад нь буцаан өгөх баталгааг нөхцөл болгон хүсэлтийг гүйцэтгэх сонголт хийж болохыг заасан байна.
 - *Улс төрийн гэмт хэргийг үл хамааруулах зарчмыг цуцлах:* Улс төрийн хэргийг үл хамааруулах нь ЕБЗ-ийг үл гүйцэтгэх зайлшгүй эсхүл сонгож болох үндэслэлд тооцогдохгүй. Энэ үл хамааруулах байдлын ганц элемент нь Бүтцийн шийдвэрийн өмнөх хэсэгт л нэг тохиолдол (12 дахь хэсэг) болж үлдсэн бөгөөд энэ нь үл ялгаварлах заалтын сүүлийн үеийн хувилбар хэлбэртэй байна.
 - *Мэргэжлийн байдлын дүрмээс нэмэлт хазайлт:* Бүтцийн шийдвэрийн 27 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, мөн адил мэдэгдэл өгсөн бусад гишүүн улстай харилцаатай нь холбогдуулан шилжүүлэн өгөхөөс өмнө тухайн этгээдийн шилжүүлэн өгөх шалтгаан болсон тэрхүү гэмт хэргээс өөр гэмт хэрэгт холбоотойгоор хорих ял буюу саатуулах тушаалыг хэрэгжүүлэх үүднээс зөвшөөрлийг яллах, ял эдлүүлэх буюу саатуулах ажиллагаанд зориулан олгосон гэж үзэхийг Зөвлөлийн ерөнхий нарийн бичгийн газарт мэдэгдэх боломжийг гишүүн улсад олгосон.

2004 оны 1 сараас эхлэн ЕБЗ нь Европын холбооны гишүүн орнууд хоорондын шилжүүлэн өгөх тухай гэрээ, хэлэлцээрүүдийг орлох болсон (Үүнд: одоог хүртэл шилжүүлэн өгөхтэй холбоотойгоор дараах гэрээ хэлэлцээр хамаарч байна: Шилжүүлэн өгөх тухай Европын 1957 оны конвенц ба үүний хоёр протокол, Терроризмыг зогсоох тухай Европын 1978 оны конвенц, шилжүүлэн өгөх хүсэлтийг дамжуулах явдлыг хялбаршуулах тухай Европын холбооны тухайн үеийн гишүүн 12 орон хоорондын 1989 оны хэлэлцээр, Шенгений 1990 оны хэлэлцээрийн холбогдох заалтууд, Шилжүүлэн өгөх явдлыг хялбаршуулах тухай 1995 оны конвенц, Шилжүүлэн өгөх тухай 1996 оны конвенц). Гэхдээ тэдгээр улс шилжүүлэн өгөх ажиллагааг цаашид хялбаршуулах буюу хөнгөвчлөх хоёр талт болон олон талт хэлэлцээрийг байгуулж болох нь хэвээр байна.

Эхэн үедээ саатал үүсч байсан ч Европын баривчлах зөвшөөрөл нь одоо заасан хэргүүдийн ихэнхэд хүчин төгөлдөр хэрэгжиж байна. Хүний тулгуур эрхийг үл зөрчихөөс гадна шүүхийн хяналт, үр нөлөө, хурдны тухайд сайн үзүүлэлттэй байгаа тул ЕБЗ-ийн үр нөлөө нь ч эерэг байгаа юм. Шилжүүлэн өгөх ажиллагаа шуурхай байдлаар хэрэгжих тухайд урьдчилсан байдлаар Бүтцийн шийдвэр хүчин төгөлдөр болж хэрэгжиж эхэлснээс хойш зөвшөөрлийн гүйцэтгэх дундаж хугацаа нь есөн сараас 43 хоног болтлоо буурсан харагдаж байна. Үүнд тухайн этгээд өөрийг нь шилжүүлэн өгөхийг зөвшөөрсөн тохиолдол багтахгүй байгаа юм. Энэ тохиолдол нь дундажаар 13 хоног үргэлжилдэг. Энэ бүх амжилт нь Европын холбооны гишүүн тодорхой орнуудаас Бүтцийн шийдвэрийг бүрэн мөрдөхийг мөн Европын холбооноос тогтолцоон дахь тодорхой доголдлыг арилгахыг шаардаж буй тэрхүү хүчин чармайлтаа алдагдуулах учиргүй юм (Бүтцийн шийдвэрийн 34 дүгээр зүйлд тулгуурласан Европын

нийгэмлэгүүдийн комиссын 2006 оны 1 сарын 26-нд Брюсселд гаргасан хамгийн сүүлийн мэдэгдлийг харна уу).

III. Шалгах асуултууд

- Шилжүүлэн өгөх асуудлаар оролцогч улс эрх зүйн үндэс болгож юуг ашигладаг вэ?
- Энэхүү конвенцийг шилжүүлэн өгөх асуудлаар эрх зүйн үндэс болгон ашигладаг уу? Үгүй бол, эсхүл конвенцид нэмэлт болгож оролцогч улс шилжүүлэн өгөх явдлыг хөнгөвчлөх хоёр талт буюу олон талт хэлэлцээр, тохиролцоог байгуулсан уу?
- Конвенцид хамаарах хэргээр өөрийн улсын харъяатыг оролцогч өөр улсад шилжүүлэн өгөх журмыг оролцогч улс тогтоосон уу?
- Өөрийн харьяат гэсэн үндэслэлээр эсхүл өөр бусад үндэслэлээр шилжүүлэн өгөхөөс татгалзсан тохиолдолд тухайн эрэн сурвалжлагдаж буй этгээд эрүүгийн хариуцлагаас мултрахгүй байх явдлыг оролцогч улс хэрхэн хангах вэ?
- Шилжүүлэн өгөх хэргийг шударгаар шүүх явдлыг хангах шүүхийн буюу захиргааны ажиллагааг оролцогч улс явуулдаг уу?
- Шилжүүлэн өгөх хүсэлтийг шийдвэрлэх үүрэг хүлээсэн төв буюу эрх бүхий бусад байгууллага оролцогч улсад бий юу?

45 дугаар зүйл. Шийтгэгдсэн этгээдийг шилжүүлэх

Энэ конвенциор тодорхойлсон гэмт үйлдлийн улмаас хорих буюу эрх чөлөөгөө бусад хэлбэрээр хасуулах ял шийтгүүлсэн этгээдийн ялыг нөгөө оролцогч улсын нутаг дэвсгэрт эдлүүлж дуусгахаар шилжүүлэх тухай хоёр болон олон талт хэлэлцээр буюу тохиролцоо байгуулах асуудлыг авч үзэж болно.

I. Ерөнхий тойм

Конвенцийн гол зорилгуудын нэг нь авлигатай тэмцэхэд олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх, хөнгөвчлөх, дэмжих бөгөөд хамтын ажиллагааны олон хэлбэрийг үр нөлөөтэйгээр ашиглаж болохын нэг нь шийтгэгдсэн этгээдийг шилжүүлэх юм. 45 дугаар зүйлд энэхүү конвенцийн дагуу тогтоосон гэмт хэрэгт буруутай нь тогтоогдсон болон шийтгүүлсэн этгээдийг оролцогч улсууд ялыг нь нутаг дэвсгэртээ эдлүүлж дуусгахын тулд шилжүүлэх талаар хоёр талт буюу олон талт хэлэлцээр, харилцсан зөвшилцсөнөөр ийм этгээдийн нийгэмд буцан нэгдэх боломжийг нэмэгдүүлэх асуудлыг авч үзэхийг хүссэн байна.

Энэ хэлбэрийн хамтын ажиллагаа нь оргодлыг шилжүүлэн өгөхөөс иргэний харьяаллын шалтгаанаар татгалзсан тохиолдолд шилжүүлэн өгөх ажиллагаанд мөн хэрэглэж болох гадаад улсын тогтоосон ял шийтгэлийг эдлүүлэх санаан дээр үндэслэдэг. Ийм тохиолдолд хүсэлт хүлээн авагч оролцогч улс дотоодын хуулиар н тийхүү зөвшөөрсөн бол тийм хуулийн шаардлагад нийцүүлэн хүсэлт гаргагч оролцогч улсын дотоодын хуулийн дагуу ногдуулсан ялыг эдлүүлж болно (44(13) зүйл).

II. Бэрхшээл ба шийдэл

Оролцогч улсад уг төлөвлөгөөнд нэгдэн орох саналыг холбогдох хууль эдийн засгийн хүрээний дагуу буюу хүчин төгөлдөр болсон гэрээ хэлэлцэх зөвшилцлийн үндсэн дээр тавина. Тиймээс энэ талаар хамтын ажиллагааг оролцогч улсуудын оролцогч тал болсон хоёр талт гэрээ буюу олон талт баримтыг батлах замаар дэмжиж болно. Зарим тохиолдолд оролцогч улсуудын хооронд тухайн шийтгэгдсэн этгээдийг буцаан өгөх талаар тодорхой дурдсан тийм тусгай тохиролцоо хийх нь ашигтай байж болох юм. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ба гэмт хэрэгтний харьцааны талаар НҮБ-ын 1985 оны долдугаар Конгрессоор батлагдсан Гадаад хоригдлыг шилжүүлэх тухай гэрээний загвар нь ийм гэрээ, хэлэлцээр буюу тохиролцооны агуулгын тал дээр чиглүүлэг болж болох юм.

II.1. Эрх зүйн хүрээ

Ялоноосон этгээдийг шилжүүлэх үүргийг заахаар хууль тогтоомж боловсруулахдаа оролцогч улсууд энэ боломжийг шийтгэгдсэн этгээдийн биш харин зөвхөн оролцогч улсын эрх байхаар тогтооход анхаарах хэрэгтэй. Цаашлаад үндэсний хууль тогтоомж нь хүсэлт гаргагч болон хүсэлт хүлээн авагч оролцогч улсын хувьд шилжүүлэх хүсэлт гаргах нь гэм буруутайг нь тогтоосон этгээдийн хамтран ажиллах сонирхлоос хамаарч байхаар уян хатан байх боломж олговол зохино. Гэхдээ шийтгэгдэгч этгээдийг өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр иргэний харъяалалтай оролцогч улсруу нь шилжүүлэх боломжтой байх нөхцөл боломжийг мөн зааж өгч болох юм. Хэрэв шийтгэгдэгч этгээдийг ял шийтгэлээ эдлэснийх нь дараа ял эдэлсэн тухайн оролцогч улсаас албадан гаргах тушаал гарсан бол шилжүүлгийг зөвшөөрөл үл харгалзан гүйцэтгэж болно.

Олон улсын хамтын ажиллагааны энэ асуудлыг хөнгөвчлөх олон тооны олон улсын конвенц одоогоор байна. Яллагдагч этгээдийг шилжүүлэх талаар Хамтын нөхөрлөлийн орнуудын төлөвлөгөө үүний нэг жишээ юм. Их Британид Хоригдлуудыг эх оронд нь буцаан өгөх тухай 1984 оны хуулиар ялагдсан хоригдлуудыг буцааж эсвэл шилжүүлэн өгөхийг зөвшөөрдөг. Европын холбоо (ЕХ) одоогоор цаашид ЕХ-ны гишүүн орнуудын хооронд нэгэн хөтөлбөр болох шинэ Бүтцийн шийдвэрийг тохиролцоо шатандаа явж байна. (Гэмт хэргийн асуудал хариуцсан Европын зөвлөлийн эрх мэдлийн хүрээнд, засгийн газрын мэргэжилтнүүдийн комиссийн боловсруулсан) 1985 онд батлагдсан, үүнд Европын зөвлөлийн гишүүн биш орнуудыг ч мөн багтаах байдлаар 62 орны нэгдэн орсон Шийтгэгдсэн этгээдийг шилжүүлэх тухай Европын зөвлөлийн конвенц нь эрх зүйн тодорхой орчинг бий болгосон юм.

Европын зөвлөлийн конвенц нь ял шийтгэгдсэн этгээд нь өөрийн дассан орчинд ял эдэлснээр түүнийг шийтгэхэд дөхөм болох эрх зүйн таатай орчинг бүрдүүлэхийг зорьсон. Энэхүү баримт бичигт хэрэг тус бүрийн тодорхой хэрэгцээ шаардлагуудыг шийдвэрлэх талын заалт багтсан бөгөөд хүсэлт бүрийг өөрийн баримтуудад тулгуурлан авч үзнэ. Гэхдээ бүх нөхцөл шаардлагууд нь хангагдсан тохиолдолд хүсэлт хүлээн авагч улс тэрхүү шилжүүлэх хүсэлтийг биелүүлнэ. Конвенцийг 1997 онд гарын үсэг зурахаар нээлттэй болсон, мөн үүнийг 2000 онд хүчин төгөлдөр болсон нэг нэмэлт протокол дагалдаж байгаа болно.

II.2. Гэмт этгээдийг шилжүүлэх нөхцлүүд

Ялоноогдсон этгээдийг шилжүүлэх тухай Европын зөвлөлийн конвенц нь шийтгэгдсэн этгээдийг шилжүүлэх тухай хүсэлтийг шийдэхэд анхаарвал зохих хүчин зүйлсэд холбоотой зарим нэг хэрэгтэй үзүүлэлтийг зааж өгсөн байна. Ерөнхий зарчим болон шилжүүлэлтийн шаардлагын тухайд энэ конвенц ялын тогтоол гаргагч оролцогч улс буюу ялын тогтоолыг гүйцэтгэгч оролцогч улсын аль нь ч шилжүүлэх хүсэлт гаргаж болохыг конвенцийн дагуу эдгээр улсын аль хүссэндээ шилжих хүсэлтээ илэрхийлж болохыг заасан байна. Шилжүүлэхтэй холбоотой дараах нөхцлүүд байна:

- Шийтгэгдэгч этгээд ялын тогтоолыг гүйцэтгэж буй оролцогч улсын харъяат байх;
- Шүүхийн эцсийн шийдвэр гарсан байх;
- Тухайн ялыг ногдуулсан үйлдэл ялын тогтоолыг гүйцэтгэж буй оролцогч улсын хуулийн дагуу эрүүгийн гэмт хэрэг бүрдүүлж байх;
- Шилжүүлэх тухай хүсэлтийг хүлээн авах мөчид, ялоноогдсон этгээдийн ял эдлэх хугацаань зургаан сараас доошгүй хугацаагаар хорих ял, эрх чөлөөг хасах өөр шийтгэл эдлэхээр болсон байх эсхүл шийтгэл нь эдгээрийн завсрынх байх; гэхдээ онцгой тохиолдолд оролцогч улсууд ял оноогдсон этгээдийн эдлэх ялын хугацаа нь дээрх босгоос доогуур байгаа тохиолдолд харилцан тохиролцон шилжүүлж болно.
- Ялын тогтоол гаргагч улс ялын тогтоолыг шилжүүлэхээр тохиролцсон байх;
- Ял оноогдсон этгээдийг шилжүүлэхийг уг этгээд нас, биеийн болон сэтгэцийн байдлыг харгалзан хоёр улс шаардлагатай гэж үзсэн эсхүл түүнийг шилжүүлэхийг хууль ёсны төлөөлөгч зөвшөөрсөн байх.

II.3. Шилжүүлэхүйл явц ба шийтгэл

Европын зөвлөлийн конвенц нь (СоЕС, 10 дугаар зүйл) уг ялын тогтоол гаргагч оролцогч улсын тогтоосон хугацаа болон ял шийтгэлийн хэлбэрийн дагуу ялын тогтоолыг хүлээн авч буй оролцогч улс заавал биелүүлэх шаардлагатай. Гэхдээ хэрэв энэ шийтгэл нь хэлбэр болон хугацааны хувьд ялын тогтоол гүйцэтгэгч оролцогч улсын хуулинд нийцэхгүй бол, тэрхүү улс өөрийн шүүхийн болон захиргааны шийдвэрээр хуулинд тухайн гэмт хэрэгтэй төстэй гэмт хэрэгт ногдуулахаар урьдаас заасан шийтгэл буюу арга хэмжээг авч болно. Хэлбэрийн хувьд уг ял шийтгэл болон арга хэмжээ нь эдлүүлэхээр ногдуулсан ял шийтгэлтэй аль болох дүйцэхүйц хэмжээнд байна. Энэ нь хэлбэр болон хугацааны хувьд ялын тогтоолыг гаргагч оролцогч улсын ногдуулсан ял шийтгэлийг дордуулахгүй мөн ялын тушаалыг гүйцэтгэгч оролцогч улсын хуулинд тухайн гэмт хэрэгт ногдуулахаар заасан хамгийн чанга ялаас мөн хэтрэхгүй байна. Ял шийтгэлийг хувиргах болсон тохиолдолд ялын тогтоолыг хүлээн авсан оролцогч улсын заасан дүрэм журам хэрэгжих учиртай. Эрх бүхий байгууллага шийтгэлийг хувиргахдаа ялын тогтоолыг гаргагч оролцогч улсын ногдуулсан шүүхийн шийдвэрт ил болон далд байдлаар илэрхийлэгдсэн баримтын дүгнэлтээр хязгаарлагдана. Ялын тогтоолыг хүлээн авагч оролцогч улс эрх чөлөөг хасах хэлбэр оролцсон шийтгэлийг мөнгөн шийтгэл болгож хувиргахгүй, тэр мөчийг хүртэл ялыг эдэлсэн нийт хугацааг шийтгэгдсэн этгээдийн хорих ялаас суутгана, шийтгэгдсэн этгээдийн хорих дэглэмийг бууруулахгүй, мөн ялын тогтоолыг хүлээн авагч

оролцогч улс ялын тогтоолыг гүйцэтгэгч оролцогч улсын хуулинд төстэй гэмт хэрэгт буюу гэмт хэрэг үйлдсэнд ногдуулахаар заасан хамгийн хөнгөн ялаар хязгаарлагдахгүй.

II.4. Мэдээлэл

Хамтран ажиллаж буй оролцогч улсуудын эрх бүхий байгууллагууд хооронд харилцааны албан суваг тогтоох нь ухаалаг алхам болно. Энэ нь ялын тогтоолыг гүйцэтгэгч оролцогч улсад шийтгэлийг эдлүүлэх буюу үүний дуусах цаг хугацааны талаар цаашдын нөхцөл байдал, түүнчлэн ногдуулаад буй ялын тогтоолын талаар болон бусад холбогдох мэдээллээр ялын тогтоолыг гаргагч оролцогч улсыг хангах боломж олгоно. Холбогдох мэдээлэлд шийтгэгдсэн этгээд шийтгэлийг эдлүүлэхээс өмнө цагдан хорихоос зугтсан эсэх ч багтаж болох юм.

Оролцогч улсууд холбогдох зардал болон шийтгэгдсэн этгээдийн тээвэрлэлтийн асуудлыг шийтгэлийг эдлүүлэхтэй хамаатай ямар нэг тохиролцооны заалтад тусгаж өгөхийг хүсч болно.

III. Шалгах асуултууд

- Оролцогч улс шийтгэгдсэн этгээдийн шилжүүлэлтийн талаар аливаа хоёр талт хэлэлцээр байгуулсан буюу олон талт хэлэлцээрт нэгдэн орсон уу?
- Ийм үйл явцад оролцсон этгээдийн эрхийг хамгаалах зохих журам бий юу?
- Шийтгэлийн талаар мэдээллийг улсуудын эрх бүхий байгууллагууд хооронд солилцох тухай хэлэлцээр буюу тохиролцоог оролцогч улс бусад оролцогч улстай байгуулсан уу?

46 дугаар зүйл. Эрх зүйн харилцан туслалцаа

1. Оролцогч улсууд энэхүү конвенцоор хамарсан гэмт үйлдлийг мөрдөн шалгах, яллах, шүүх шийдвэрлэхэд эрх зүйн хамгийн өргөн хүрээний туслалцааг харилцан үзүүлнэ.

2. Энэ конвенцийн 26 дугаар зүйлд заасан хуулийн этгээдэд хариуцлага хүлээж болох гэмт үйлдэлтэй нь холбогдуулан хүсэлт гаргагч оролцогч улсаас мөрдөн шалгах, яллах, шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахад хүсэлт хүлээн авагч оролцогч улс холбогдох хууль, гэрээ, хэлэлцээр, тохиролцооны дагуу бололцоотой бүхий л хэмжээнд эрх зүйн туслалцааг харилцан үзүүлнэ.

3. Энэ зүйлийн дагуу харилцан үзүүлэхэр эрх зүйн туслалцааг дор дурдсан аль нэг зорилгоор хүсч болно:

- (a) Тодорхой этгээдүүдээс нотолгоо, мэдэгдэл авах;*
- (b) Шүүхийн баримт бичгийг хэрэгжүүлэх;*
- (c) Нэгжлэг хийх, эд хөрөнгө түр хураах, битүүмжлэх;*
- (d) объект, газарт үзлэг хийх;*

- (e) мэдээлэл, эд мөрийн баримт, шинжээчдийн үнэлэлт дүгнэлт гаргаж өгөх;
- (f) холбогдох баримт бичиг, тэмдэглэл, түүний дотор засгийн газар, банк, санхүү, байгууллага, бизнесийн тэмдэглэлийн эх хувь буюу баталгаат хуулбар гаргаж өгөх;
- (g) нотлох баримт бүрдүүлэх зорилгоор гэмт үйлдлээс олсон орлого, гэмт хэрэг үйлдэхэд ашигласан эд хөрөнгө, хэрэгсэл, бусад зүйлийг таньж тогтоох буюу мөрдөх;
- (h) холбогдох этгээдийг хүсэлт гаргагч оролцогч улсын байгууллагад сайн дураараа биечлэн очихыг дэмжих;
- (i) хүсэлт хүлээн авагч оролцогч улсын дотоодын хуульд үл харилгах аливаа бусад туслалцаа үзүүлэх;
- (j) энэхүү конвенцийн V бүлэгт заасны дагуу гэмт үйлдлээс олсон орлогыг таньж тогтоох, битүүмжлэх, мөрдөх;
- (k) энэхүү конвенцийн V бүлэгт заасны дагуу хөрөнгө буцаан олгох.

4. Шалгалт, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах буюу амжилттай явуулж дуусгахад тухайн эрх бүхий байгууллагад тус болно эсхүл нөгөө оролцогч улс энэхүү конвенцийн дагуу хүсэлт гаргахад хүргэнэ гэж үзвэл оролцогч улсын эрх бүхий байгууллагууд дотоодын хуулиа үл хөндөн, урьдчилсан хүсэлтгүйгээр нөгөө оролцогч улсын эрх бүхий байгууллагад гэмт үйлдлийн талаарх мэдээллийг дамнуулж болно.

5. Энэ зүйлийн 4 дэх хэсгийн дагуу мэдээллийг дамнуулах нь мэдээлэл өгч буй эрх бүхий байгууллагын өөрийн улсдаа явуулах шалгалт, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг хөндөхгүй. Мэдээллийг хүлээн авагч эрх бүхий байгууллага уг мэдээллийн нууцыг богино хугацаанд ч хадгалах нөгөө талын хүсэлтийг биелүүлж, түүнийг ашиглах талаар тавьсан хязгаарлалтыг мөрдөнө. Гэхдээ энэ нь мэдээллийг хүлээн авагч оролцогч улс байцаан шийтгэх ажиллагааны явцад шүүгдэгчийг гэм буруугүйг нотлох мэдээллийг задруулахад саад болохгүй. Ийм тохиолдолд мэдээлэл хүлээн авагч оролцогч улс мэдээллийг задруулахаас өмнө мэдээлэл дамнуулагч оролцогч улсад мэдэгдэж, хэрэв хүсэлт хүлээн авсан бо лмэдээлэл лдамнуулагч оролцогч улстай зөвшилцөнө. Хэрэв онцгой тохиолдолд урьдчилан мэдэгдэх боломжгүй бол мэдээлэл хүлээн авагч оролцогч улс мэдээлэл дамнуулагч оролцогч улсад мэдээллийг тийнхүү задруулсан талаараа шуурхай мэдээнэ.

6. Энэ зүйлийн заалт нь эрх зүйн харилцан туслалцааны асуудлыг бүхэлд нь буюу хэсэгчилэн зохицуулдаг эсхүл цаашид зохицуулах хоёр буюу олон талт аливаа бусад гэрээгээр хүлээх үүрэгт харилгахгүй.

7. Тухайн оролцогч улсууд хоорондоо эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээ байгуулаагүй тохиолдолд эрх зүйн туслалцаа үзүүлэх хүсэлтийн хувьд энэ зүйлийн 9-өөс 29 дэх

хэсгийг хэрэглэнэ. Хэрэв эдгээр оролцогч улс хоорондоо эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээ байгуулсан бөгөөд тухайн гэрээний оронд энэ зүйлийн 9-өөс 29 дэх хэсгийг хэрэглэхээр тохиролцоогүй бол тухайн гэрээний холбогдох заалтыг хэрэглэнэ. Хамтын ажиллагаанд нь тус дөхөм болох бол энэ зүйлийн эдгээр заалтыг хэрэглэхийг оролцогч улсуудад тууштай санал болгож байна.

8. Оролцогч улсууд банкны нууцлал гэсэн үндэслэлээр энэ зүйлийн дагуу эрхзүйн харилцан туслалцаа үзүүлэхээс зайлсхийж үлболно.

9. (a) Хоёр улс тухайн үйлдлийг гэмт хэрэг гэж хоёулаа тогтоосон байх зарчим үйлчлэхгүй тохиолдолд хүсэлт авагч оролцогч улс энэ зүйлийн дагуу туслалцаа үзүүлэх хүсэлтэд хариу өгөхдөө энэхүү конвенцийн I дүгээр зүйлд заасан конвенцийн зорилгыг харгалзан үзнэ.

(b) Оролцогч улсууд хоёр улсын аль аль нь тухайн үйлдлийг гэмт үйлдэлд тооцсон зарчим байхгүй гэсэн үндэслэлээр энэ зүйлийн дагуу туслалцаа үзүүлэхээс татгалзаж болно. Гэвч хүсэлт хүлээн авагч оролцогч улс албадагын бус шинжтэй эрх зүйн туслалцааг эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн үзүүлнэ. Туслалцаа үзүүлэх хүсэлт нь төдийлөн ач холбогдолгүй (*de minimis*) асуудлыг тусгасан, эсхүл энэхүү конвенцийн өөр заалтын дагуу хамтран ажиллаж буюу хүссэн туслалцааг үзүүлж болох асуудалтай холбоотой тохиолдолд эрх зүйн туслалцаа зүүлэхээс татгалзаж болно.

(c) Хоёр улсын аль алинд тухайн үйлдлийг гэмт үйлдэлд тооцсон зарчим байхгүй тохиолдолдоо оролцогч улс бүр энэ зүйлийн дагуу эрх зүйн туслалцааг аль болох их хэмжээнд үзүүлэх боломжтой байхад шаардлагатай арга хэмжээ авах талаар судлана.

10. Оролцогч нэг улсын нутаг дэвсгэрт цагдан хоригдож буюу ял эдэлж байгаа этгээдийг энэ конвенциор тодорхойлсон гэмт үйлдэлд нь холбогдуулан мөрдөн шалгах, ялах буюу шүүх ажиллагаанд нотлох баримт бүрдүүлэхэд хэн болохыг нь тогтоох, мэдүүлэг авах эсхүл өөрөөр туслах зорилгоор оролцогч нөгөө улсад байлгахыг хүссэн тохиолдолд дараах нөхцлийг хангасан бол шилжүүлж болно:

(a) тухайн хүн зөвшөөрлөө мэдээлэлд үндэслэн, чөлөөтэй өгсөн;

(b) оролцогч хоёр улсын эрх бүхий байгууллагууд зохистой гэж үзсэн тийм нөхцлүүдийн дагуу зөвшөөрсөн.

11. Энэ зүйлийн 10 дахь хэсгийн зорилгод:

(a) аливаа этгээдийг шилжүүлж өгсөн оролцогч улс хүсэлтээ өөрөөр гаргаагүй буюу эрх олгоогүй бол түүнийг шилжүүлэн авсан оролцогч улс тухайн этгээдийг хамгаалалтанд байлгах эрх, үүрэгтэй;

(b) оролцогч хоёр улсын эрх бүхий байгууллагууд урьдчилан буюу өөрөөр тохиролцож, аливаа этгээдийг шилжүүлэн авсан оролцогч улс түүнийг шилжүүлж өгсөн оролцогч улсын хамгаалалтанд буцаан өгөх үүргээ сааталгүйгээр хэрэгжүүлнэ;

(c) аливаа этгээдийг шилжүүлж авсан оролцогч улс түүнийг буцаах үүднээс шилжүүлэх ажиллагаа эхлүүлэхийг шилжүүлж өгсөн оролцогч улсаас шаардаж болохгүй;

(d) аливаа этгээдийн түүнийг шилжүүлж авсан оролцогч улсад хамгаалалтанд байсан хугацааг түүнийг шилжүүлж өгсөн оролцогч улсад эдлэсэн ялын хугацаанд оруулж тооцно.

12. Энэ зүйлийн 10, 11 дэх хэсгийн дагуу аливаа этгээдийг шилжүүлж өгсөн оролцогч улс зөвшөөрөөгүй бол тухайн этгээдийг аль улсын харьяат гэдгээс үл хамааран, шилжүүлж өгсөн оролцогч улсын нутаг дэвсгэрээс гарахаас өмнө үйлдсэн аливаа үйлдэл, эс үйлдэл, эсхүл ял шийтгүүлсэнтэй нь холбогдуулан яллах, цагдан хорих, шийтгэх буюу аливаа бусад хэлбэрээр эрх чөлөөг нь хязгаарлах арга хэмжээг шилжүүлж авсан оролцогч улсын нутаг дэвсгэрт авч болохгүй.

13. Оролцогч улс бүр эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай хүсэлтийг хүлээн авах, гүйцэтгэх, эсхүл гүйцэтгүүлэхээр эрх бүхий байгууллагуудад дамнуулах асуудлыг хариуцсан, эрх бүхий төв байгууллагыг томилно. Хэрэ аливаа оролцогч улсад эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх өөр тогтолцоотой тусгай бүс буюу нутаг дэвсгэр байдаг бол тухайн улс нь тухайн бүс буюу нутаг дэвсгэрийн хувьд мөн адил чиг үүргийг гүйцэтгэх эрх бүхий төв байгууллагыг тусад нь томилж болно. Эрх бүхий төв байгууллага нь туслалцаа үзүүлэх хүсэлтийг шуурхай бөгөөд зохистой гүйцэтгэх буюу дамнуулах явдлыг хангана. Эрх бүхий төв байгууллага эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлэхээр хүсэлт тавихдаа хүсэлтийг шуурхай бөгөөд зохистой гүйцэтгэх явдлыг дэмжинэ. Энэхүү конвенцийг соёрхон баталсан тухай батламж жуух бичиг, хүлээн зөвшөөрсөн, батласан буюу нэгдэн орсон тухай баримт бичгийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулахдаа оролцогч улс бүр энэхүү зорилгоор томилсон эрх бүхий төв байгууллагынхаа тухай мэдэгдэнэ. Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай хүсэлт болон үүнтэй холбогдсон аливаа мэдээ, мэдээллийг оролцогч улсуудын томилсон эрх бүхий төв байгууллагуудад дамнуулж байна. Энэхүү шаардлага нь ийм хүсэлт, мэдээ, мэдээллийг дипломат шугамаар, түүнчлэн яаралтай бөгөөд оролцогч улсууд харилцан тохиролцсон нөхцөлд, боломжтой бол Олон улсын эрүүгийн цагдаагийн байгууллагаар дамнуулан авч байхыг шаардах оролцогч улсын эрхийг хөндөхгүй.

14. Хүсэлтийг бичгээр эсхүл бичгийн хэлбэрт оруулах чадвартай аливаа хэрэгслээр, хүсэлт хүлээн авагч оролцогч улсад хэрэглэгддэг хэлээр, тухайн хүсэлтийн жинхэнэ агуулгыг тогтоох боломжийг хүсэлт хүлээн авагч оролцогч улсад олгох нөхцлийн дагуу гаргана. Энэхүү конвенцийг соёрхон баталсан тухай батламж жуух бичиг, хүлээн зөвшөөрсөн, батласан буюу нэгдэн орсон тухай баримт бичгийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулахдаа оролцогч улс бүр өөрийн улсад хэрэглэгддэг хэл буюу хэлнүүдийн тухай мэдэгдэнэ. Яаралтай нөхцөл байдалд, оролцогч улсууд харилцан тохиролцсон нөхцөлд хүсэлтийг амаар гаргаж болох боловч үүнийгээ бичгээр даруй нотлоно.

15. Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай хүсэлтэд дараахь зүйлийг тусгана:

- (a) хүсэлт гаргаж байгаа эрх бүхий байгууллагын нэр;
- (b) хүсэлттэй холбоотой асуудал, мөрдөн шалгах, яллах, шүүх ажиллагааны гол асуудал, түүнчлэн мөрдөн шалгах, яллах, шүүх ажиллагаа явуулж буй эрх бүхий байгууллагын нэр, чиг үүрэг;
- (c) шүүхийн баримт бичгүүдийг биелүүлэх зорилготой хүсэлтээс бусад тохиолдолд холбогдох үйл баримтын товч танилцуулга;
- (d) хүссэн туслалцааны дэлгэрэнгүй тайлбар болон мөрдөгдөх шаардлагатай гэж хүсэлт гаргагч оролцогч улсын үзэж буй аливаа тодорхой журмын талаархи дэлгэрэнгүй мэдээлэл;
- (e) боломжтой тохиолдолд холбогдох аливаа этгээдийн овог нэр, байгаа газар болон иргэний харьяалал;
- (f) нотлох баримт, мэдээлэл буюу арга хэмжээг хүссэн зорилго.

16. Хүсэлт хүлээн авагч оролцогч улс нь тухайн хүсэлтийг гүйцэтгэхэд дотоодын хуулийнх нь дагуу шаардлагатай гэж үзсэн эсхүл хүсэлтийг гүйцэтгэх ажиллагааг хөнгөвчилөхүйц нэмэлт мэдээлэл хүсч болно.

17. Хүсэлтийг хүсэлт хүлээн авагч оролцогч улсын дотоодын хуулийн дагуу буюу дотоодын хуульд харшлаагүй тохиолдолд, боломжтой гэж үзвэл тухайн хүсэлтэд заасан журмын дагуу гүйцэтгэнэ.

18. Аливаа хувь хүн аль нэг оролцогч улсын нутаг дэвсгэрт байгаа бөгөөд гэрч эсхүл шинжээчийн хувьд оролцогч нөгөө улсын шүүхийн эрх бүхий байгууллагуудад мэдүүлэг өгөх ёстой боловч хүсэлт гаргагч оролцогч улсын нутаг дэвсгэрт биечлэн очих бололцоогүй эсхүл зохимжгүй байвал нутаг дэвсгэрт нь байгаа оролцогч улс нь нөгөө талын хүсэлтийн дагуу боломжтой нөхцөлд дотоодын хууль тогтоомжийнх нь тулгуур зарчимтай нийцэж байвал видео уулзалтын хэлбэрээр мэдүүлэг авахыг зөвшөөрч болно. Оролцогч улс байцаалтыг хүсэлт гаргагч оролцогч улсын шүүхийн эрх бүхий байгууллага явуулж, хүсэлт хүлээн авагч оролцогч улсын шүүхийн эрх бүхий байгууллагыг байлцуулах талаар тохиролцож болно.

19. Хүсэлт гаргагч оролцогч улс хүсэлт хүлээн авагч оролцогч улсын урьдчилсан зөвшөөрөлгүйгээр түүний өгсөн мэдээлэл эсхүл нотлох баримтыг хүсэлтэд зааснаас өөр мөрдөн шалгах, яллах буюу шүүх ажиллагааны зорилгоор дамнуулж буюу ашиглаж үл болно. Хүсэлт гаргагч оролцогч улс байцаан шийтгэх ажиллагааны явцад яллагдагчийн гэм буруугүйг нотлох мэдээлэл буюу нотлох баримт задруулахад энэ зүйлийн аль ч заалт саад болохгүй. Ийм тохиолдол хүсэлт гаргагч оролцогч улс нь тийнхүү задруулахаас өмнө хүсэлт хүлээн авагч оролцогч улсад мэдэгдэх бөгөөд нөгөө улс хүсэлт гаргасан тохиолдолд хүлээн авагч оролцогч улстай зөвшилцөнө. Онцго тохиолдолд урьдчилан мэдэгдэх боломжгүй бол хүсэлт гаргагч

оролцогч улс хүсэлт хүлээн авагч оролцогч улсад мэдээллийг тийнхүү задруулса н талаар шуурхай мэдээлнэ.

20. Хүсэлт гаргагч оролцогч улс хүсэлтийг гүйцэтгэхэд шаардлагатайгаас бусад тохиолдолд хүсэлт тавьсныг болон хүсэлтийн агуулгыг нууцлахыг хүсэлт хүлээн авагч оролцогч улсаас шаардаж болно. Хүсэлт хүлээн авагч оролцогч улс нууцлах шаардлагыг биелүүлэх боломжгүй бол энэ тухайгаа хүсэлт гаргагч оролцогч улсад даруй мэдээлнэ.

21. Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэхээс дараахь тохиолдолд татгалзаж болно:

(a) хүсэлтийг энэ зүйлийн заалтуудтай нийцүүлж гаргаагүй;

(b) хүсэлт хүлээн авагч оролцогч улс хүсэлтийг гүйцэтгэснээр түүний бүрэн эрхт байдал, аюулгүй байдал, нийтийн дэг журам (*ordre public*), бусад чухал ашиг сонирхлыг хөндөх магадлалтай гэж үзэж байгаа;

(c) хэрэв хүссэн арга хэмжээг авахыг хүсэлт хүлээн авагч оролцогч улсын дотоодын хуулиар аливааад илтгэх гэмт үйлдэлтэй холбогдуулан түүний эрх бүхий байгууллагуудад хориглосон бөгөөд уг гэмт үйлдлийг өөрөө харьяалан мөрдөн шалгах, яллах, шүүх шийдвэрлэх;

(d) хүсэлтийг биелүүлэх нь түүнийг хүлээн авагч оролцогч улсын эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэхтэй холбогдсон эрх зүйн тогтолцоотой нь зөрчилдөх.

22. Оролцогч улсууд аливаа гэмт үйлдлийг санхүүгийн асуудалтай холбоотой гэж үздэг гэсэн ганц үндэслэлээр эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх хүсэлтээс татгалзаж үл болно.

23. Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэхээс татгалзсан аливаа тохиолдолд шалтгаан, үндэслэлийг заана.

24. Хүсэлт хүлээн авагч оролцогч улс нь эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай хүсэлтийг аль болох түргэн гүйцэтгэж, хүсэлт гаргагч оролцогч улсаас тавьсан аливаа эцсийн хугацааг аль болох баримтлах бөгөөд ингэхдээ эцсийн хугацаа тогтоосон шалтгаанаа хүсэлтдээ заасан байвал зохино. Хүсэлт гаргагч оролцогч улс нь хүсэлт хүлээн авагч оролцогч улсаас хүсэлтийг нь биелүүлэхээр авч буй арга хэмжээний явц, байдлын талаар мэдээлэл өгөхийг хүсч үндэслэл бүхий хүсэлт гаргаж болно. Хүсэлт хүлээн авагч оролцогч улс уг хүсэлтийг биелүүлэхийн тулд авч буй арга хэмжээний явц, байдлын талаар хүсэлт гаргагч оролцогч улсаас гаргасан үндэслэл бүхий хүсэлтэд хариу өгнө. Туслалцаа цаашид хэрэггүй болсон үед хүсэлт гаргагч оролцогч улс нь хүсэлт хүлээн авагч оролцогч улсад нэн даруй мэдээлнэ.

25. Ажиллагаанд байгаа мөрдөн байцаалт, яллах, шүүх таслах ажиллагаанд саад учруулна гэсэн үндэслэлээр хүсэлт хүлээн авагч оролцогч улс эрхзүйн харилцан туслалцаа үзүүлэхийг хойшлуулж болно.

26. Энэ зүйлийн 21 дэх хэсгийн дагуу хүсэлтийг биелүүлэхээс татгалзах эсхүл энэ зүйлийн 25 дахь хэсгийн дагуу хүсэлтийг гүйцэтгэхийг хойшлуулахаасаа өмнө хүсэлт хүлээн авагч оролцогч улс туслалцааг шаардлагатай гэж үзсэн болзол, нөхцлөөр үзүүлж болох эсэх асуудлыг авч үзэхээр хүсэлт гаргагч оролцогч улстайз өвшилцөнө. Хэрэв хүсэлт гаргагч оролцогч улс тийм нөхцлөөр туслалцаа авахыг зөвшөөрвөл түүнийг дагаж мөрдөнө.

27. Энэ зүйлийн 12 дахь хэсэгт заасныг үл хөндөн хүсэлт гаргагч оролцогч улсын нутаг дэвсгэрт явагдаж буй мөрдөн шалгах ажиллагаанд мэдүүлэг өгөхийг болон мөрдөн шалгах, яллах, шүүх ажиллагаанд туслалцаа үзүүлэхийг хүсэлт гаргагч оролцогч улсын хүсэлтээр зөвшөөрсөн гэрч, шинжээч эсхүл өөр этгээдийг хүсэлт хүлээн авагч оролцогч улсын нутаг дэвсгэрээс гарахаас өмнө хийсэн үйлдэл, эс үйлдэл, эсхүл ял шийтгүүлсэнтэй нь холбогдуулан тухайн нутаг дэвсгэрт яллах, цагдан хорих, шийтгэх буюу бусад аливаа бусад хэлбэрээр эрх чөлөөг нь хязгаарлах арга хэмжээг авч болохгүй. Гэрч, шинжээч эсхүл өөр этгээдийг хүсэлт гаргагч оролцогч улсын нутаг дэвсгэрт цаашид байх шаардлагагүй болсон тухай шүүхийн эрх бүхий байгууллагаас албан ёсоор мэдээлсэн өдрөөс хойш арван таван өдрийн хугацаанд эсхүл оролцогч улсуудын тохиролцсон хугацаанд тухайн оролцогч улсын нутаг дэвсгэрээс гарах боломжтой байсан ч сайн дураараа үлдсэн эсхүл гарсныхаа дараа өөрийн хүслээр эргэж ирсэн тохиолдолд хувийн аюулгүй байдлын дээрхи баталгаа үйлчлэхгүй.

28. Холбогдох оролцогч улсууд өөрөөр тохиролцоогүй бол хүсэлт гүйцэтгэхтэй холбогдсон ердийн зардлыг хүсэлт хүлээн авагч оролцогч улс хариуцна. Хэрэв хүсэлтийг биелүүлэхэд ихээхэн эсхүл онцгой зардал шаардлагатай буюу шаардагдахаар байвал оролцогч улсууд хүсэлтийг гүйцэтгэх болзол, нөхцөл, түүнчлэн зардлыг хэрхэн хариуцахыг тодорхойлохоор зөвшилцөнө.

29. Хүсэлтхүлээнанавагчоролцогчулснь:

(a) дотоодын хууль тогтоомжийнх нь дагуу олон нийтэд гаргаж өгч болох өөрт нь байгаа засгийн газрын тэмдэглэл, баримт бичиг буюу мэдээллийн хуулбарыг хүсэлт гаргагч оролцогч улсад өгнө;

(b) дотоодын хууль тогтоомжийнх нь дагуу олон нийтэд гаргаж өгч болохгүй өөрт нь байгаа засгийн газрын аливаа тэмдэглэл, баримт бичиг буюу мэдээллийн хуулбарыг бүрэн, хэсэгчлэн, эсхүл өөрийн зохистой гэж үзсэн нөхцлийн дагуу өөрийн үзэмжээр хүсэлт гаргагч оролцогч улсад өгч болно.

30. Оролцогч улсууд энэ зүйлийн зорилго, бодит хэрэгжилтийг хангах, заалтуудыг нь бэхжүүлэх хоёр буюу олон талт хэлэлцээр буюу тохиролцоо байгуулах боломжийг шаардлагатай болавчүзнэ.

I. Ерөнхий тойм

Гэмт хэрэгтнүүд олон улсад улам их зорчих болж, гэмт хэрэг үйлдэхэд сүүлийн үеийн технологи, олон улсын банкны тогтолцоог ашиглах болсоноор хууль сахиулах болон шүүхийн

эрх бүхий байгууллагуудын ийм гэмт хэрэгтэй холбоотой мөрдөн байцаах, яллах, шүүн таслах үйл ажиллагааг үр дүнд хүргэхийн тулд хамтран ажиллах, харилцан туслалцах явдал юу юунаас ч илүү чухал болж ирж байгаа юм.

Дээрхи зорилгод хүрэхийн тулд оролцогч улс гадаад улсын шүүхийн тогтолцоонд тусламж үзүүлэх боломж олгох, ингэснээр хууль тогтоомж нь боловсронгуй болох хэрэгжүүлэх олон улсын эрүүгийн эрх зүйн асуудлаар харилцан туслалцаа үзүүлэх гэрээ, хэлэлцээрийг байгуулах явдал улам ихэсч байна. Ийм гэрээ, хэлэлцээрт ямар төрлийн тусламж үзүүлэх, тусламж үзүүлэхэд ямар шаардлага хангасан байх, хамтран ажиллагч улс ямар үүрэг гүйцэтгэх, гэмт хэргийн сэжигтэн ямар эрх эдлэхийг ихэнхдээ заасан байхаас гадна холбогдох хүсэлтийг өргөн барих болон гүйцэтгэхэд дагаж мөрдөх журмыг ч багтаасан байна.

Энэхүү конвенц нь эрх зүйн харилцан туслалцааны үр ашигтай байдлыг нэмэгдүүлэхийн тулд цаашид хэлэлцээр, тохиролцоо байгуулахад оролцогч улсуудыг дэмжин, эрх зүйн харилцан туслалцааг хөнгөвчлөх, сайжруулах арга замыг эрэлхийлж байгаа болно. Ямартаа ч конвенцийн 46 дугаар зүйлийн 1 дэх хэсэг энэхүү конвенцид хамаарах гэмт хэрэгт мөрдөн байцаах, яллах, шүүн таслах ажиллагаа³ явуулахад 46(3) заалтад жагсаасан эрх зүйн харилцан туслалцааны хамгийн өргөн хүрээний арга хэмжээг авахыг оролцогч улсаас хүссэн юм. Хэрэв эрх зүйн харилцан туслалцааны тухай оролцогч улсын одоогийн эрх зүйн хүрээ нь энэхүү конвенцид хамаарах гэмт хэргийг багтаахаар өргөн биш бол хууль тогтоомжид өөрчлөлт оруулах шаардлага үүсч болно.

46 (2) Хуулийн этгээдэд холбогдуулан мөрдөн шалгах, яллах, шүүх ажиллагаа явуулахтай холбоотойгоор эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх оролцогч улсад эрхөлгөсөн байна (конвенцийн 26 дугаар зүйлийг мөн харна уу).

46 (3) заалтад конвенцийн дагуу үзүүлэх туслалцааны төрлийг жагсаасан байна. Энэ заалтыг мөрдөхийн тулд оролцогч улсууд харилцан туслалцах эрх зүйн хүрээгээ нарийн шалгаж үзэн, эрх зүйн хүрээ нь 3 дахь хэсэгт жагсаасан хамтын ажиллагааны төрөл бүрийг хамрахаар хангалттай өргөн байгаа эсэхийг үнэлж үзэх шаардлагатай. Улс хоорондын зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцид нэгдэн орсон оролцогч улс ер нь энэ заалтыг биелүүлж байх учиртай бөгөөд үүнээс гадна гэмт хэргээс олсон орлогыг таньж тогтоох, битүүмжлэх, мөрдөх болон хөрөнгө буцаан олгох тохиолдолд туслалцаа үзүүлэх зохих механизмыг бүрдүүлэх хэрэгтэй болно (46 дугаар зүйлийн 3(j) ба (k) хэсгийг харна уу).

Эрх зүйн харилцан туслалцааны гэрээ байхгүй тохиолдолд дээр дурдсан туслалцааны төрлүүдтэй холбоотойгоор хүсэлт дамжуулах, гүйцэтгэхэд энэхүү конвенц 46 дугаар зүйлийн 7 ба 9-өөс 29 дэх хэсэгтээ боломжит механизмыг зааж өгсөн байна. Тухайн оролцогч улсуудын хооронд гэрээ хэрэгжиж байгаа мөн оролцогч улсууд 9-өөс 29 дэх хэсгийг хэрэглэхээр тохиролцоогүй бол үүний оронд тухайн гэрээний дүрэм хэрэгжиж болно. Эдгээр хэсэг нь оролцогч улсуудын хамтын ажиллагааг хөнгөвчлөх бол ямар ч тохиолдолд эдгээр хэсгийг

³Оролцогч улс эдгээр ажиллагаанд туслалцаа үзүүлэх цар хирээг еерийн үзэмжээр тогтоож болох ч игйдээ энэхүү туслалцаа нь зарим оронд жинхэнэ шийх хурлын нэг хэсэгт үл тооцогдох шийх хурлаас емнех ажиллагаа, яллах ажиллагаа болон дав заалдах ажиллагаа зэрэг эрийгийн үйл явцын хэсгийг харгалзсан байвал зохино.

ашиглахыг оролцогч улсуудаас хүснэ. Зарим улсад эдгээр заалтыг бүрэн хэрэгжүүлэхийн тулд шинээр хууль тогтоомж шаардлагатай болж болох юм.

46 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт оролцогч улсууд банкны нууцлал гэсэн үндэслэлээр эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэхээс зайлсхийж үл болно гэж заасан байгаа. Эрх зүйн харилцан туслалцааны гэрээ байгуулаагүй тохиолдолд зөвхөн хэрэглэх хэсгүүд дунд энэ хэсгийг оруулаагүй байгаа нь маш чухал юм. Харин энд оролцогч улсаас татгалзах ийм үндэслэл нь тэдний Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Эрүүгийн хууль, банкны хууль тогтоомж, дүрэм журам зэрэг дотоодын эрх зүйн тогтолцоонд шалтаг болохоор тусгагдсан байх явдлыг үл харгалзан шаардах явдал юм. (31(7), 55, 57 дугаар зүйлийг мөн харна уу). Иймээс оролцогч улсын хууль тогтоомж ийм үндэслэлийг шалтаг болгохыг зөвшөөрсөн бол тэдгээр хууль тогтоомжид өөрчлөлт оруулах шаардлага гарна.

9 дүгээр зүйлд хоёр улс тухайн үйлдлийг хоёулаа гэмт хэрэг гэж тогтоосон байх зарчим үйлчлэхгүй тохиолдолд туслалцаа үзүүлэх хүсэлтэд хариу өгөхдөө энэ конвенцийн зорилго болон санааг харгалзан үзэхийг оролцогч улсаас хүссэн байна (1 дэх хэсэг). Хэдийгээр хоёр улс тухайн үйлдлийг хоёулаа гэмт хэрэг гэж тогтоосон байх зарчим үйлчлэхгүй тохиолдолд оролцогч улс туслалцаа үзүүлэхээс татгалзаж болох ч (9(b) хэсэг), энэ шаардлага үйлчлэхгүй байгаа тохиолдолд ч гэсэн өөрийн үзэмжээр шийдэх эрх мэдлээ хэрэгжүүлэхийг мөн туслалцааны цар хүрээг өргөсгөх арга хэмжээг авахыг оролцогч улсад уриалсан байна (9(c) хэсэг).

Гэвч туслалцаа үзүүлэх хүсэлт нь *de minimis* шинжтэй асуудалтай хамаарахгүй, эсхүл энэхүү конвенцийн өөр заалтын дагуу хамтран ажиллаж болохооргүй гэдгийг ойлгосон тохиолдолд оролцогч улсаас эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн албадлагын бус арга хэмжээ агуулсан туслалцаа үзүүлэхийг хүссэн байна (9(b) хэсэг).

Түүнчлэн конвенц нь оролцогч улс бүр харилцан эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай хүсэлтийг хүлээн авах, гүйцэтгэх, эсхүл гүйцэтгүүлэхээр эрх бүхий байгууллагуудад дамжуулах асуудлыг хариуцах зохих бүрэн эрхтэй төв байгууллагыгтомилон (13 ба 14 дүгээр хэсэг) ингэснээр дипломат сувгаас өөр дахин нэг сувгийг бий болгоно гэж заасан байна. Хүсэлт гаргагч улсын шүүхийн эрх бүхий байгууллага энэхүү төв байгууллагатай харилцаж болно. Өнөө үед илүү шууд сувгийг ашиглах явдал улам газар авч байгаа бөгөөд энэхүү сувгаар хүсэлт гаргагч улсын албан тушаалтан өөр бусад улсын зохих албан тушаалтанд хүсэлтээ шууд илгээх боломжтой юм.

Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх өөр тогтолцоотой тусгай бүс буюу нутаг дэвсгэр бүхий оролцогч улсад тухайн бүс буюу нутаг дэвсгэрийн эрх бүхий төв байгууллага мөн адил чиг үүргийг гүйцэтгэж болно. Олон улс орон өөр бусад конвенцийн төстэй заалтын дагуу эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх эрх бүхий төв байгууллагыг аль хэдийн байгуулсан мөн Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэж болох юм. Ийм олон улсын бичиг баримтын өргөн дэлгэр тархаж байгааг тэмдэглэн өөр өөр төрлийн гэмт хэргийн тухайд эрх зүйн харилцан туслалцааны тууштай байдлыг бэхжүүлэх мөн энэ талаар ажил үүргийн давхцал, уялдаа холбоогүй байдлыг үгүй хийхийн тулд оролцогч улсын зүгээс

эдгээр бичиг баримтын дагуу байгуулагдсан эрх бүхий төв байгууллага нь цор ганц байх явдлыг хангах нь маш чухал.

46 дугаар зүйлийн 4 ба 5 дахь хэсэгт өөр оролцогч улс туслалцаа үзүүлэх хүсэлт тавиагүй эсхүл ийм мэдээлэл буюу нотолгоо байдгийг огт мэдэхгүй байгаа байцаах, яллах буюу шүүх ажиллагааны анхан шатанд конвенцид хамарсан гэмт хэрэгтэй тэмцэхэд шаардлагатай гэж үзсэн мэдээлэл буюу нотлохбаримтыг оролцогч улсаас нөгөө оролцогч улсад сайн дураар дамжуулах эрх зүйн үндсийг зааж өгсөн байна. Эдгээр заалтын зорилго нь оролцогч улсуудыг эрүүгийн асуудлаар мэдээллээ сайн дураар болон урьдчилан солилцоход хөхиүлэн дэмжих зорилготой юм. Хүлээн авагч оролцогч улс хүлээн авсан мэдээллийг туслалцаа хүсэх албан ёсны хүсэлтээ өргөн барихдаа ашиглаж болно. Хүлээн авагч оролцогч улсад хүлээлгэх цор ганц үүрэг нь туслалцаа хүсэх тухай хүсэлтийг хэрэгжих хязгаарлалттай төстэй байдлаар шилжүүлсэн тохиолдолд мэдээллийн нууцлалыг хадгалах, хүлээн авсан мэдээлэл тухайн буруутгагдсан этгээдийн гэм буруугүйг нотолсон биш бол үүнийг хэрэглэхэд тавих хязгаарлалтыг мөрдөх юм. Харин тухайн этгээдийн гэм буруугүйг нотлох мэдээллийг хүлээн авагч оролцогч улс өөрийн дотоодын ажиллагаандаа чөлөөтэй ашиглаж болно.

Хамтын ажиллагааг сайжруулах шаардлагатай өөр нэг талбар нь сүрдүүлэг, заналхийлэлд өртөх магадлалтай гэрчийг хамгаалахтай холбоотой болно. Конвенцийн 32 дугаар зүйл энэ асуудалтай холбоотой тодорхой арга хэмжээг заасан байгаа бөгөөд үүнд гэрчийг мөн зохих байдлаар түүний хамаатан болон ойр дотныхныг нүүлгэн суурьшуулах орж байгаа юм. 46 (18) хэсэгт гэрч мэдүүлэг өгөхөөр хүсэлт гаргагч оролцогч улсын нутаг дэвсгэрт биечлэн очих бололцоогүй эсхүл зохимжгүй байвал нотлох баримтаар хангах хэрэгсэл болгож видео уулзалтын хэлбэрийг ашиглаж болно гэж заасан байна.

46 дугаар зүйлийн үндсэн заалтуудын товчхон дүгнэлт нь үүний эрх зүйн харилцан туслалцааны талаар хамтын ажиллагааг дэмжих боломж хийгээд шинэлэг шинжийг харуулсан байна. Гэхдээ ялангуяа эрх зүйн тогтолцоо болон уламжлалын хувьд харилцан адилгүй оролцогч улсуудын хамтын ажиллагаанд саад учруулж болох бодит бэрхшээл, хүндрэлийг оролцогч улсууд нухацтайгаар тооцож үзэж болох юм.

II. Бэрхшээл ба шийдэл

II.1. Тулгараад буй асуудлыг шийдэх

Оролцогч улс эрх зүйн харилцан туслалцааны албан суваг байнга шаардлагатай биш байж болох тал дээр анхаарал хандуулах хэрэгтэй. Үүний оронд албан арга хэмжээ шаардлагагүй үед хууль сахиулах байгууллагууд хооронд албан бус, илүү түргэн, уян хатан сувгийг ашиглаж болох юм (сайн дураар гэрчийн мэдүүлэг авах, бичиг баримт хайх, хураах, боловсруулах үүнд орж болно). Ийм харилцаа холбоог Интерпол, Европол болон бүс нутгийн хэмжээний бусад хууль сахиулах байгууллага буюу тохиролцоо дэмжиж өгч болно.

Гэхдээ албан бус сувгаар нотлох баримт олж авахад нотлох баримт болж чадах эсэх талаар асуудал үүсэх магадлал илүү өндөр байдгийг оролцогч улс анхаарч үзнэ. Тиймээс хууль

сахиулах байгууллага нотлох баримт олж авахаар хичээхдээ урьдаас тогтсон эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх сувгийг ашиглаж байвал зохистой. Албан арга хэрэгслийг ашиглах нь мөн эрсдэл өндөртэй мэдээллийг хамгаалах илүү өндөр түвшний арга хэмжээг хангаж өгнө.

Цаашлаад авлигын гэмт хэргийн асуудлаар эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх орчинд анхаарвал зохих хэд хэдэн хүчин зүйл бий.

Оролцогч зарим улсад, хэрэв мөрдөн байцаах ажиллагаанд хүсэлт хүлээн авагч оролцогч улсын нөлөө бүхий улс төрч эсхүл томоохон бизнес эрхлэгч хамрагдах болбол “үндэсний ашиг сонирхол” эсхүл тодорхой төрийн албан тушаалтанд олгосон дархан эрх (буюу улс төрийн асуудалтай холбоотойгоор тухайн этгээдэд олгосон “хамгаалалт”)-ийг үндэслэл болгон хүсэлт тавьсан туслалцааг үзүүлэхгүй байж болно. Оролцогч бусад улсын хувьд тухайнэрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хүсэлт тавьсан этгээд буюу байгууллагад хүсэлт гаргагч оролцогч улстай нотлох баримтыг хуваалцахгүй байх талаар дав заалдах эрх олгосон байдаг. Задруулахгүй байх талаар дав заалдах эрх олгосон тохиолдолд энэ нь урт хугацааны саатал үүсгэж болохоос гадна сэжигтэн этгээдэд болзошгүй аюулын талаар “сануулга” өгсөн хэрэг болж болох юм.

Үүнээс гадна баримт бичиг хайх буюу хураах хүсэлт гаргах нь хүсэлт гаргасан улсад одоогоор үргэлжилж буй мөрдөн байцаалт буюу шүүхн таслахажиллагаанд нотлох баримт гаргаж ирж болох шалтгааныг тайлбарлах хангалттай мэдээлэл өгөөгүй тохиолдолд ийнхүү баримт бичигтэй холбоотой хүсэлт гаргах нь асуудал үүсгэж болно.

Хүсэлт нь ялангуяа авлигын хэргийг мөрдөн байцаах ажиллагаа нь зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэглэлийн ажиллагаатай холбоотой эсхүл улс төрч болон бусад чухал этгээд үүнд оролцсон тохиолдолд тухайн мөрдөн байцаах ажиллагаатай холбоотой маш эмзэг асуудлыг задруулах эрсдлийг дагуулж байдаг. Тиймээс ийм эмзэг мэдээллийг туслалцаа хүсэх албан хүсэлтэнд багтаах шаардлагатай тохиолдол гарч болох юм. Түүнчлэн тухайд нь мөрдөн байцаах ажиллагаа явуулж буй этгээдийн зүгээс гэрчийг сүрдүүлэх, бусад мэдээллийг ашиглаж гэрч болон мэдээллийг задруулах магадлалыг нухацтайгаар үнэлж дүгнэн, мөрдөн байцаах ажиллагаа явуулахад гэрчид тулгарч болох эрсдлийг аль болох багасгаж, мэдээллийг хамгаалах шаардлагатай эсэхийг анхаарч үзнэ. Тиймээс туслалцаа үзүүлэх хүсэлт боловсруулахдаа эрх бүхий байгууллагаас нууцлалын асуудалд зохих анхаарал хандуулах шаардлага гарч болох юм. Хамгийн эрсдэлтэй, эмзэг мэдээллийг орхин хүсэлтийг гүйцэтгэхийг зөвшөөрөхөд хангалттай мэдээлэл оруулан, хүсэлт гаргах замаар хүндрэл үүсэхээс зарим тохиолдолд зайлсхийж болно.

Хүсэлт хүлээн авагч улсад туслалцаа үзүүлэхэд хангалттай нөөц байхгүй буюу нөөцийн хязгаарлагдмал байдлаас үүдэн хүсэлтийг заримдаа саатуулах буюу тэр бүү хэл эс ойшоох явдал гарч болох юм. Ийм нөхцөлд хүсэлт гаргагч улс хамтран ажиллагчийг хүсэлт хүлээн авагч улсруу томилох, мэргэжилтнээр хангах, цаашлаад тодорхой түвшний санхүүгийн дэмжлэг үзүүлэх зэргээр туслалцаа үзүүлж болно.

Бодит өнцгөөс харвал, туслалцаа хүсч буй оролцогч улс энэ асуудлыг хөөцөлдөх нь хүсэлтийг хүлээн авч буй оролцогч улсаас илүү өөрт нь чухал юм гэдгийг харгалзан үзэх хэрэгтэй. Хүсэлт хүлээн авагч оролцогч улсаас энэхүү хүсэлтэнд нь эерэг хариу өгөх явдлыг аль

болох боломжтой байлгахын тулд хүсэлт гаргагч оролцогч улс шаргуу чармайлт үзүүлэх нь чухал. Энэ нь дараах үе шатуудтай:

- Туслалцаа үзүүлэх тал дээр хүсэлт хүлээн авагч улсын материаллаг хийгээд журмын шаардлагыг таньж тогтоох (энэ нь нилээдгүй нөөц шаарддаг тул гол чухал хэргүүдийг сонгож, хайлтын ажиллагаа нягт нямбай бөгөөд тодорхой байх явдлыг хангах гадаад эрх зүйн туслалцаа үзүүлэх);
- Хүсэлтийг зохих эрх бүхий байгууллагад илгээх эсэхэд итгэлтэй болж авахын тулд хүсэлт хүлээн авагч оролцогч улстай шууд холбогдох;
- Оролцогч улстай хүсэлтийн талаар албан бус байдлаар, урьдаар ярилцах (хүсэлт гаргагч оролцогч улсаас хүсэлтийн урьдчилсан төслийг өргөн барихыг хүсэлт хүлээн авагч оролцогч улс хүсч байж болно, ингэснээр хүсэлт хүлээн авагч оролцогч улс хүсэлт дэх алдаануудад анхаарал хандуулах буюу хүсэлт боловсруулах шилдэг арга замын талаар зөвөлгөө өгч болно);
- Хүсэлт нь илгээсэн газартаа эрсдэлгүй хүрч, ямар нэг алдаагүй байж, зохих байдлаар шийдэгдэх явдлыг хангахын тулд хүсэлтийг мөрдөх.

Оролцогч улсуудын журмын тухай нилээд ялгаатай байж болох тул хүсэлт гаргагч оролцогч улс (нотариатаар батлуулсан гэрчийн мэдүүлэг зэрэг) хүсэлт хүлээн авагч оролцогч улсын хуулиар хүлээн зөвшөөрөөгүй тусгай журамтай байж болох юм. Ер нь хүсэлт хүлээн авагч оролцогч улс өөрийн хуулийг юун түрүүнд дагах нь хамгийн өөрчлөгдөшгүй зарчим байсаар ирсэн. Гэхдээ энэ зарчим нь зарим бэрхшээлийг үүсгэдэг. Ялангуяа хүсэлт гаргагч болон хүсэлт хүлээн авагч улсууд харилцан адилгүй эрх зүйн уламжлалтай тохиолдолд энэ зарчим ихээхэн хүндрэл дагуулдаг. Жишээ нь, хүсэлт хүлээн авагч оролцогч улсын шилжүүлсэн нотлох баримт нь энэ улсын хуульд заасан хэлбэртэй байсан ч, ийм нотлох баримт нь хүсэлт гаргагч оролцогч улсын хуулиар хүлээн зөвшөөрөгдөөгүй байж болно. Сүүлийн үед журамтай холбоотойгоор илүү уян хатан байдлыг зөвшөөрөх хандлага ажиглагдаж байна. Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус худалдаатай тэмцэх 1988 оны конвенцийн 7(12) зүйлийн дагуу хүсэлтийг хүсэлт хүлээн авагч оролцогч улсын дотоодын хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэдэг. Гэхдээ энэхүү зүйл хүсэлт хүлээн авагч оролцогч улсын дотоодын хууль тогтоомжид нийцэх цар хүрээнд мөн боломжтой тохиолдолд хүсэлтийг хүсэлтэд заасан журмын дагуу гүйцэтгэнэ гэж заасан байна. Ийнхүү 1998 оны конвенц хүсэлт хүлээн авагч оролцогч улсаас хүсэлт гаргагч оролцогч улсын хүссэн үйл ажиллагааны хэлбэрийг дагахыг шаардаагүй ч хүсэлт хүлээн авагч оролцогч улсыг энэ байдлаар гүйцэтгэх тал дээр дэмжиж өгсөн байна. Үүнтэй ижил заалт Улс хоорондын зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх конвенцийн 18 (17) зүйл болон Авлигатай тэмцэх конвенцийн 47 (17) зүйлд үг бүрчлэн орсон байгаа. Мөн ижил хамрах хүрээнд, Эрүүгийн асуудлаар харилцан туслалцааны тухай гэрээний загварт хүсэлт хүлээн авагч оролцогч улсын хууль тогтоомж болон үйл ажиллагаанд нийцэх цар хүрээнд, хүсэлт гаргагч оролцогч улсын заасан байдлаар хүсэлтийг гүйцэтгэнэ гэж заасан байна (6 дугаар зүйл).

II.2. Бэрхшээлийг шийдэх: 46 дугаар зүйлд тусгасан эрх зүйн өргөн цар хүрээ

Улс хоорондын зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцид эрх зүйн харилцан туслалцааны талаар төстэй заалт (18 дугаар заалт) орсон бөгөөд тэр Конвенцид нэгдэн орсон улсууд Авлигатай тэмцэх конвенцийн 46 дугаар зүйлээс урган гарч буй холбогдох шаардлагыг хангаж байгаа. Гэхдээ энэ хоёр конвенцийн хооронд зарим нэг томоохон ялгаа бий.

Юун түрүүнд Авлигатай тэмцэх конвенцид эрх зүйн харилцан туслалцаа нь цаашлаад энэхүү конвенцийн тулгуур зарчмын нэг болох хөрөнгө буцаан олгох асуудалтай холбогдож байгаа (Конвенцийн 1 дүгээр зүйл, 46 дугаар зүйлийн 3(j)(k) хэсэг мөн V бүлгийг харна уу).

Хоёрдугаарт хоёр улс тухайн үйлдлийг хоёулаа гэмт хэрэг гэж тогтоосон байх зарчим үйлчлэхгүй тохиолдолд, энэ нь тэдний дотоодын хууль тогтоомжид нийцэж байгаа бол мөн тухайн хэрэг нь хөнгөн хэрэгт тооцогдохгүй бол оролцогч улсуудаас албадлагын арга хэмжээ оролцоогүй тийм туслалцаа үзүүлэхийг хүссэн. Ийм заалт Палермогийн Конвенцид ороогүй байсан юм.

Үүнээс гадна 43 дугаар зүйлд дурдсанчлан эрүүгийн асуудлаар олон улсын хамтын ажиллагаа явуулах зорилгоор тухайн үйлдлийг гэмт хэрэг гэж хоёр тал тогтоосон байх зарчмыг шаардаж байгаа тохиолдолд, UNTOC-д багтдаггүй энэхүү дүрмийг хэрэглэхийн тулд нэмэлт тайлбарын дүрмийг UNCAC-д заасан байгаа. Энэ нь хэрэв туслалцаа үзүүлэхийг хүссэн тухайн гэмт хэргийг бүрдүүлж буй үйлдэл нь аль аль оролцогч улсын хуулийн дагуу эрүүгийн гэмт хэрэгт тооцогддог бол хүсэлт хүлээн авагч оролцогч улсын хуулиар уг гэмт хэргийг хүсэлт гаргагч оролцогч улсын хуульд заасан гэмт хэргийн адил ангилалд багтаадаг буюу адил нэр томъёогоор нэрлэдэг эсэхээс үл хамааран ийм зарчмыг хангаж байна гэж үзэхэд чиглэсэн юм (43 дугаар зүйл 2 дахь хэсэг). Цаашлаад энэхүү конвенц нь оролцогч улсууд эрүүгийн асуудлаар хамтран ажиллахаар өөрсдийгөө хязгаарлалгүй зохих тохиолдолд, дотоодын эрх зүйн тогтолцоотой нь нийцсэн бол авлигатай холбогдсон мөрдөн байцаалт, иргэний ба захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд бие биедээ туслалцаа үзүүлэхийг зөвшөөрсөн (43 дугаар зүйл 1 дэх хэсэг).

II.3. Холбогдох бусад конвенцтой уялдах

Оролцогч улс хамтын ажиллагааны энэ хэлбэрийн талаар өргөн хүрээний заалт бүхий эсхүл холбогдох асуудлыг тухайлан авч үзсэн олон талт бусад гэрээг харгалзан үзэх замаар эрх зүйн харилцан туслалцааны тал дээр чиглүүлэн эрэлхийлэхболно.

Хамтын ажиллагааны энэ хэлбэрийн талаар өргөн хүрээний заалт бүхий гэрээнд дараах орно: Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус худалдаатай тэмцэх Нэгдсэн Үндэстний Байгууллагын 1988 оны конвенц (7 дугаар зүйлийг харна уу), Улс хоорондын зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх конвенц (18 дугаар зүйлийг харна уу), Гэмт хэргээс олсон орлогыг угаах, хайх, хураах, битүүмжлэх асуудлаар Европын Зөвлөлийн конвенц (8-аас 10 дугаар зүйлийг харна уу), Кибер гэмт хэргийн асуудлаар Европын Зөвлөлийн конвенц, Авлигад эрүүгийн хариуцлага тооцох талаар Европын Зөвлөлийн конвенц (26 дугаар зүйлийг харна уу),

Авлигатай тэмцэх Америкийн улсууд хоорондын конвенц (XIV зүйлийг харна уу), Олон улсын худалдааны хэлэлцээрт гадаадын төрийн албан тушаалтныг хахуульдахтай тэмцэх OECD-ын 1997 оны конвенц (9 дүгээр зүйлийг харна уу).

Үүнээс гадна Европын Зөвлөл (Эрүүгийн асуудлаар харилцан туслалцах тухай Европын конвенц болон үүний 1998 ба 2001 оны нэмэлт хоёр протокол), Хамтын нөхөрлөл (Эрүүгийн асуудлаар харилцан туслалцах тухай Хамтын нөхөрлөлийн орнуудын 1986 оны төлөвлөгөө, 1990 ба 1999 онд өөрчлөлт оруулсан байдлаар), Америкийн улсуудын байгууллага (Нотлох баримтыг гадаад улсруу гаргах тухай Америкийн улсуудын 1975 оны конвенц ба үүний 1984 оны нэмэлт протокол мөн Эрүүгийн асуудлаар харилцан туслалцах тухай Америкийн улсуудын 1992 оны конвенц ба үүний 1993 оны нэмэлт протокол), Баруун Африкийн улсуудын эдийн засгийн нийгэмлэг (Эрүүгийн асуудлаар харилцан туслалцах тухай ECOWAS-ын 1992 оны конвенц), Өмнөд Африкийн оролцогч улсууд болон Европын Холбоо (Европын Холбооны оролцогч улсуудын хооронд Эрүүгийн асуудлаар харилцан туслалцах тухай 2000 оны конвенц ба үүний 2001 оны нэмэлт протокол), мөн Эрүүгийн асуудлаар харилцан туслалцах тухай Арабын улсуудын холбооны 1983 оны конвенцийн хүрээнд эрх зүй харилцан туслалцаа үзүүлэх тухай тусгай бичиг баримт боловсруулагдсан.

Энэ тал дээр, Нэгдсэн Үндэстний Байгууллага Эрүүгийн асуудлаар харилцан туслалцах тухай гэрээний загвар бэлтгэсэн (Ерөнхий Ассемблейн 45/117 тоот тогтоол, хавсралт болон 53/112 тоот тогтоол, хавсралт I). Үүнд ийм эрх зүйн харилцан туслалцааны гэрээг ялангуяа эрх зүйн тогтолцооны хувьд харилцан адилгүй оролцогч улсууд хооронд хэрэгжүүлснээр олж авсан олон улсын туршлагаас сорчилж авсан түүврийг харуулсан байгаа.

II.4. Шинэ дэвшил

Сүүлийн жилүүдэд эрх зүйн харилцан туслалцаанд нилээдгүй ахиц дэвшил гарч байна. Ялангуяа 2001 оны 9 сарын 11-ний өдөр Америкийн Нэгдсэн улсад болсон үйл явдлаас хойш олон улсын эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хүчин чадлаа оролцогч улсууд нилээд өргөжүүлснийг баталж болохоор байгаа юм. Жишээ нь: өөрчлөлт нилээд эрчимтэй явагдаж буй Европын Холбооны улсуудад эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх талаар, , маш их дэвшил гарч байгаа нь ажиглагдаж байна. Үүнд дээр дурдсан Эрх зүйн талаар харилцан туслалцах тухай 2000 оны конвенц ба үүний 2001 оны нэмэлт протокол, Хамтарсан мөрдөн байцаах ажиллагааны баг ашиглах талаар (2002), Эд хөрөнгө буюу нотолгоо битүүмжлэх тушаалыг харилцан хүлээн зөвшөөрөх талаар (2003), Гэмт хэрэгт холбогдох орлого, баримт бичиг, эд хөрөнгө хураах талаар (2005), Хураах харилцан хүлээн зөвшөөрөх зарчмын хэрэглээний талаар (2006) Бүтцийн шийдвэр мөн ноцтой гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг бэхжүүлэх үүднээс Еврожастыг байгуулах 2002 оны шийдвэр зэрэг Европын Зөвлөлийн шийдвэрүүд орно.

2006 оны 6 сард Европын Холбооны Зөвлөлөөс Нотлох баримтын Европын зөвшөөрлийн асуудлаар Бүтцийн шийдвэрийн тухайд ерөнхий хандлагыг тохиролцсон (EEW – бичмэлийг http://register.consilium.europa.eu/pdf/en/07/st09913_en07 хаягаас авч болно). Энэ шинэ төлөвлөгөөг эцсийн хэлбэрт оруулан, батласны дараа гишүүн улсууд хэрэгжүүлэх хэрэгтэй байгаа юм. EEW-ийн Бүтцийн шийдвэрт Европын баривчлах зөвшөөрлийн Бүтцийн

шийдвэрийнхтэй адил байдлаар харилцан хүлээн зөвшөөрөх хандлагыг нэвтрүүлж байгаа болно (EAW – 44 дүгээр зүйл харна уу). Ийнхүү EEW нь шийдвэр гаргах шүүхийн байгууллагаас шийдвэрийг гүйцэтгэх байгууллагад шууд шилжих шүүхийн шийдвэр болж байгаа бөгөөд цаашдын албан харилцаа нь энэ хоёр эрх бүхий байгууллага хооронд шууд явагдана. Үүнийг тодорхой ангилалд багтах объект, бичиг баримт эсхүл мэдээлэл, хөндлөнгөөс чагнасан харилцааны тэмдэглэл, тагнуулын мэдээлэл, сэжигтэнтэй хийсэн ярилцлага, гэрчийн мэдүүлэг болон ДНХ-ийн шинжилгээний хариу олж авах зорилгоор ашиглаж болно.

II.5. Зохицууландэмжих шинэ механизм

Европын Холбоонд сүүлийн жилүүдэд гарсан хөгжил дэвшлийг улс хоорондын зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх тал дээр олон улсын хамтын ажиллагаа болон уялдаа холбоог дэмжихэд бүс нутгийн хэмжээнд улам ихээр авч явуулсан үр нөлөө бүхий хамтын арга хэмжээ гэж тооцох учиртай. Энэ тал дээр, 1996 оны 4 сарын 22-ны Хамтарсан арга хэмжээний төлөвлөгөө нь (96/277/ЖНА) Европын Холбооны гишүүн улсууд хооронд шүүхийн хамтын ажиллагааг сайжруулах зорилготой хамтран ажиллагч шүүгч солилцох орчинг бүрдүүлж өгсөн юм. Энэхүү хамтарсан арга хэмжээний төлөвлөгөө нь гишүүн улсууд хооронд, хоёр талт буюу олон талт тохиролцооны үндсэн дээр “хамтран ажиллагч шүүгч” ч гэж нэрлэдэг тийм шүүхийн хамтын ажиллагаанд тусгай мэргэшил бүхий шүүгч буюу албан тушаалтныг томилох буюу солилцох орчинг бий болгосон билээ (1 дүгээр зүйл). Хамтран ажиллагч шүүгч нь ялангуяа зочин улсын холбогдох алба болон шүүхийн эрх бүхий байгууллагатай шууд холбоо тогтоох замаар эрүүгийн асуудлаар шүүхийн хамтын ажиллагааны бүх хэлбэрийг дэмжих, хөнгөвчлөх зорилго бүхий аливаа үйл ажиллагаанд үүрэг хүлээж оролцоно. Хамтран ажиллагч шүүгчийн улс болон зочин улсын хооронд хийсэн тохиролцооны дагуу, хамтран ажиллагч шүүгчийн үүрэгт тухайн улсуудын эрх зүйн тогтолцоо болон эрх зүйн мэдээллийн санг харилцан ойлголцох явдлыг мөн эдгээр улсуудын эрх зүйн мэргэжилтнүүдийн хоорондын цаашдын харилцааг хөхиүлэн дэмжих зорилгоор мэдээлэл, статистик баримт солилцох асуудалтай холбоотой аливаа үйл ажиллагаанд оролцох багтаж болох юм (2 дугаар зүйл).

Түүнчлэн Европын шүүхийн сүлжээ 1998 оны 6 сарын 29-ний Хамтарсан арга хэмжээний төлөвлөгөөний дагуу байгуулагдсан бөгөөд Европын Холбооны гэрээний (98/428/ЖНА) К.3 зүйлд нийцүүлэн Европын Холбооны Зөвлөлөөр батлагдсан болно. Энэ нь ялангуяа улс хоорондын зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэхэд анхаарал хандуулан эрүүгийн асуудлаар хамтын ажиллагааг дэмжих, хөнгөвчлөх зорилгоор бий болсон гишүүн улсууд хоорондын шүүхийн харилцаа холбооны нэгжүүдийн сүлжээ юм. Энэхүү Хамтарсан арга хэмжээний төлөвлөгөөний 4 дүгээр зүйлийн дагуу энэхүү холбооны нэгж нь ялангуяа онц ноцтой гэмт хэрэгтэй (зохион байгуулалттай гэмт хэрэг, авлига, мансууруулах бодис худалдаалах, терроризм) тэмцэхэд гишүүн улсууд хооронд шүүхийн хамтын ажиллагааг хөнгөвчлөхөд зуучлагчийн үүрэг гүйцэтгэнэ. Түүнчлэн эдгээр нь шүүхийн хамтын ажиллагааны үр дүнтэй хүсэлт боловсруулахад туслах, шүүхийн хамтын ажиллагааг ерөнхийд нь сайжруулах зорилгоор өөрийн улсын орон нутгийн шүүхийн эрх бүхий байгууллага болон өөр бусад улсын холбооны нэгж болон орон нутгийн шүүхийн эрх бүхий байгууллагыг хууль ёсны бөгөөд хэрэгцээтэй мэдээллээр хангана. Цаашлаад нэг гишүүн улсын шүүхийн эрх бүхий байгууллагуудын нэг бүлэг хүсэлттэй холбоотойгоор өөр гишүүн улс дахь уялдаа бүхий ажиллагаа шаардлагатай болж байгаа

тохиолдолд эдгээр нь шүүхийн хамтын ажиллагааны уялдаа холбоог сайжруулах үүргийг мөн хүлээх юм.

Эцэст нь хэлэхэд, Еврожаст 2002 оны 2 сарын 28-нд Европын Холбооны Зөвлөлийн шийдвэрийн (2002/187/ЖНА) дагуу байгуулагдсан бөгөөд гишүүн улсуудын мөрдөн байцаах, яллах ажиллагааг үр дүнтэй болгох зорилгоор тэдгээрийн мөрдөн байцаах, яллах ажиллагааны уялдаа холбоог сайжруулах, дэмжих, эрх бүхий байгууллагууд хооронд хамтын ажиллагааг бэхжүүлэх, ялангуяа олон улсын эрх зүйн харилцан туслалцаа болон шилжүүлэн өгөх хүсэлтийн хэрэгжилтийг хөнгөвчлөх, эрх бүхий байгууллагуудад бусад байдлаар дэмжлэг үзүүлэх зорилготой юм (3 дугаар зүйл). Энэ нь прокурор, шүүгч буюу дүйцэх эрх мэдэл бүхий цагдаагийн ажилтны хувиар гишүүн улс бүрээс сонгогдсон үндэсний гишүүдээс бүрддэг (2 дугаар зүйл).

Гэхдээ эдгээр жишээ нь оролцогч улсууд хооронд мэдээлэл солилцох урсгалыг сайжруулахад зардал өндөртэй сонголтууд байх магадлалтай. Олон орон одоогийн хамтын ажиллагааны тохиролцооны хүрээнд эрх зүйн туслалцаа үзүүлэх, хүлээж авах, үүнийг үр дүнтэйгээр ашиглах боломжоо нэмэгдүүлэх хууль тогтоох, шүүх буюу гүйцэтгэх байгууллагын санаачлагыг сонгосон байдаг. Үүнд жишээ болгон SAARC, Бүс нутгийн хамтын ажиллагааны Өмнөд Азийн нийгэмлэг, SARPCCO, Өмнөд Африкийн бүс нутгийн Цагдаагийн удирдлагын зөвлөлийн байгууллага болон (186 гишүүн оролцогч улс бүхий) Интерполыг дурдаж болох юм. Энэ хандлагыг 48 дугаар зүйлд илүү дэлгэрэнгүй байдлаар авч үзнэ.

III. Шалгах асуултууд

- Эрх зүйн харилцан туслалцаанд оролцогч улс юуг эрх зүйн үндэс болгон ашигладаг вэ?
- Оролцогч улс энэхүү конвенцийг эрх зүйн харилцан туслалцаанд эрх зүйн үндэс болгон ашигладаг уу? Үгүй бол, эсхүл конвенцид нэмэлт болгож оролцогч улс шилжүүлэн өгөх явдлыг хөнгөвчлөх хоёр талт буюу олон талт хэлэлцээр, тохиролцоог байгуулсан уу?
- Оролцогч улс ямар нэг хуулийн мэргэжилтний буюу шүүгчдийн сүлжээнд хамрагддаг уу?
- Эрх зүйн харилцан туслалцааны хүсэлтийг хүлээн авах, боловсруулах, гүйцэтгэх үүрэг хүлээсэн эрх бүхий тусгай төв байгууллага оролцогч улсад бий юү?
- Эрх зүйн харилцан туслалцаанд үүссэн бодит бэрхшээл болон асуудлын талаар тодорхой чиглүүлэг төв байгууллагад бий юү?
- Оролцогч улсад эрх зүйн харилцан туслалцааны хүсэлтийг шийдэх тогтсон журам бий юү?

47 дугаар зүйл: Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг шилжүүлэх

Энэхүү конвенцийн дагуу тогтоосон гэмт үйлдлийг яллах ажиллагааг бие биедээ шилжүүлэх нь ялангуяа хэд хэдэн харьяаллын асуудал үүссэн тохиолдолд яллах ажиллагааг нэгтгэх үүднээс хууль ёсыг зохистойгоор сахиулах ашиг сонирхолд нийцнэ гэж үзсэн тохиолдолд оролцогч улсууд тийнхүү шилжүүлэх боломжийг авч үзнэ.

I. Ерөнхий тойм

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг нэг улсаас нөгөө улсад шилжүүлэх сонголт нь олон улсын эрүүгийн шүүхийн тогтолцоонд харьцангуй шинэд тооцогдоно. Энэ нь байцаан шийтгэх ажиллагааг хүлээн авч буй улсад тухайн байцаан шийтгэх ажиллагааг явуулахад илүү зохимжтой буюу хариуцагч этгээд энэ улстай (жишээ нь хариуцагч энэ улсын иргэн эсхүл оршин суугч гэсэн шалтгаанаар) ойр холбоотой тохиолдолд зохих шийдэл болж болох юм. Түүнчлэн шилжүүлэхийн оронд эхлүүлсэн буюу явуулсан дотоодын байцаан шийтгэх ажиллагааны үр ашиг, үр дүнг нэмэгдүүлэх зохих хэрэгсэл болгон (ялангуяа эрэн сурвалжлагдаж буй этгээд хүсэлт хүлээн авагч улсын харъяат гэсэн шалтгаанаар шилжүүлэхээс татгалзсан тохиолдолд) үүнийг ашиглаж болно.

Хуулийн түвшинд, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг шилжүүлэх талаар тухайлан авч үзэж буй олон талт конвенц ердөө ганц байдаг нь Европын Зөвлөлийн хүрээнд батлагдсан Эрүүгийн асуудлаар байцаан шийтгэх ажиллагааг шилжүүлэх конвенц юм. Энэхүү конвенцийг 1972 онд гарын үсэг зурахаар нээж, 1978 онд хүчин төгөлдөр болгосон.

Европын Зөвлөлийн конвенц нь өөрөө нилээд ярвигтай ч цаад санаа нь энгийн: хэрэв нэг хүн нэг оролцогч улсын хуулиар гэмт хэрэг үйлдсэн гэж сэжиглэгдэж байгаа бол, тэрхүү улс энэхүү конвенцийн дагуу өөрийнх нь өмнөөс арга хэмжээ авахыг өөр улсаас хүсч болох бөгөөд хүсэлт хүлээн авагч оролцогч улс өөрийн хуулийн дагуу яллах ажиллагааг явуулж болно. Конвенц энэ зорилгоор хоёр улсын зүгээс тухайн үйлдлийг гэмт хэрэг гэж тооцсон байхыг шаардана.

Үүнээс гадна Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус худалдаатай тэмцэх 1988 оны конвенц болон Улс хоорондын зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенц нь хоёулаа, ялангуяа хэд хэдэн харьяаллын асуудал үүссэн тохиолдолд хууль ёсыг зохистойгоор сахиулах ашиг сонирхолд нийцнэ гэж үзвэл олон улсын энэ хэлбэрийн хамтын ажиллагаанд хандах боломжийг оролцогч улсад олгосон (харгалзан 8 ба 21 дүгээр зүйл) бөгөөд энэ дагуу яллах ажиллагааг явуулахад хамгийн зохимжтой газрыг тогтооно.

Энэ утгаараа дээр дурдсан конвенцид нэгдэн орсноор зохих хууль тогтоомж баталсан тэдгээр оролцогч улсууд Авлигын эсрэг Конвенцийн 47 дугаар зүйлийг мөрдөхийн тулд томоохон өөрчлөлт хийх шаардлагагүй болно гэсэн үг.

Нэгдсэн Үндэстний Байгууллага, Эрүүгийн асуудлаар байцаан шийтгэх ажиллагааг шилжүүлэх тухай гэрээний загварыг (Ерөнхий Ассемблейн 45/118 тоот тогтоолоор баталсан) бэлтгэн, хоёр талт болон олон талт гэрээ боловсруулах явдлыг дэмжих арга замыг эрэлхийлж ирсэн. Энэ нь ердөө ийм гэрээ байгуулах гэж буй хоёр болон түүнээс дээш тооны оролцогч улсын тодорхой шаардлагад нийцүүлэн өөрчилж болох загвар юм.

II. Бэрхшээл ба шийдэл

II.1. Шилжүүлэх шийдвэрийг гаргахад тавих бодлогын шалгуур

Асуудал олон улсын хэмжээнд эрүүгийн гэмт хэргийг яллах арга хэмжээ авахад хамгийн сайн бөгөөд үр дүнтэй шүүхийн харьяаллыг тогтооход чиглэх үед тодорхой шийдэлд хүрэхгүй байх явдал нилээд ажиглагддаг.

47 дугаар зүйл ялангуяа хэд хэдэн харьяаллын асуудал үүссэн үед хууль ёсыг зохистойгоор сахиулах ашиг сонирхолд нийцнэ гэж үзсэн тохиолдолд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг бие биендээ шилжүүлэх боломжийг авч үзэхийг оролцогч улсууд уриалж байгаа бөгөөд тухайн улсын шүүхийн харьяаллын яллах шаардлага болон яллах ажиллагаанд төвлөрөх хэрэгтэй. Жишээ нь: Конвенц авлигын хэрэг нэгээс олон улсад нөлөөлсөн болон оролцсон улсууд хаана мөрдөн байцаах ажиллагаа болон шүүх хурлыг явуулвал хамгаас зохистойг тогтоохыг хүсч байгаа тохиолдолд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг шилжүүлэхийг зөвшөөрөх, асуудлыг шийдэх тийм хэлэлцээр, тохиролцоонд нэгдэн орохыг оролцогч улсуудад уриалж байна.

Улс хоорондын гэмт хэрэг хэдий ихэсч байгаа ч яллах болон шүүх эрх бүхий байгууллагад туслах байцаан шийтгэх газрыг тогтоох олон улсын удирдамж бараг байхгүй байна. Улс хоорондын авлигын хэрэгт, ялангуяа, янз бүрээр өрнөж болох олон төрлийн аюул учирч болзошгүй байдал ажиглагдаж байгаа юм. Жишээ нь, өөр бусад улс эхлүүлнэ гэж буруу тооцоолон яллах ажиллагааг аль ч улсаас эхлүүлэхгүй байх; эсхүл яллах ажиллагааг “буруу” (тохиромжгүй) газар эхлүүлэх; эсхүл хоёр болон түүнээс дээш тооны улс шүүхийн харьяаллаа тогтоож энэ нь зөрчилдөөн үүсгэх асуудал гарч болно.

Иймээс эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг эхлүүлэх хамгийн зохимжтой шүүхийн харьяаллыг тогтоох нь чухал асуудал юм. Үүнтэй холбоотойгоор 47 дугаар зүйлийг шүүхийн харьяаллын тухай 42 дугаар зүйлтэй хамтад нь авч үзэж, эрүүгийн процессийг явуулах хамгийн тохиромжтой шүүхийн харьяаллыг тогтоох үүднээс шүүхийн харьяаллын талаар шийдвэр гаргах тэрхүү уламжлалт шалгуурыг анхаарч үзвэл зохино.

Ингэхдээ чухалчлах асуудлуудыг урьдаас жагсаах хэрэгтэй. Юун түрүүнд тухайн үйлдэл гарсан тэр улсад гэмт хэрэгтнийг яллах асуудлыг чухалчилж авч үзэх хэрэгтэй. Өөр бусад шалгуур нь ч энэ зарчимд захирагдаж байвал зохино. Ийм ч учраас гэмт хэрэгтнийг оршин суудаг улсад нь яллах эсэх нь гэмт хэрэг үйлдэгдсэн бөгөөд яллахаас татгалзсан улсаас хамаарна гэсэн үг.

Гэмт хэрэг үйлдэгдсэн газар яллах нь хамгийн зохистой гэсэн санааг гэхдээ байнга зөвтгөөд байх аргагүй. Өнөө үед гэмт хэрэгтнийг нийгэмд дахин оруулах асуудлыг эрүүгийн тогтолцоонд улам бүр анхаарч үзэх болж байгаа бөгөөд энэ шаардлагын дагуу засан хүмүүжүүлэх зорилгод хүрэх хамгийн боломжтой газар ял шийтгэлийг ногдуулж, эдлүүлэх ёстой болж байгаа юм. Энэ газар нь ерөнхийдөө гэмт хэрэгтний гэр бүлийн амьдардаг, нийгмийн хамаарал бүхий буюу шийтгэлээ эдэлж дууссны дараа суурьших тэр улс юм.

Нөгөөтэйгүүр нотлох баримтыг хамгаалахад гарах бэрхшээл нь гэмт хэрэг үйлдэгдсэн улсаас өөр улсууд байцаан шийтгэх ажиллагааг шилжүүлэхэд байнга саад дотгор учруулна. Тухайлсан тохиолдолд эдгээрээс алийг нь чухалчилж үзэхийг ямар нэг ерөнхий хуулиар шийдэх аргагүй байж болох юм. Энэ нь тухайн тохиолдол бүрт тэрхүү асуудлыг анхаарч үзэх байдлаар шийдвэр гаргах хэрэгтэй болно гэсэн үг. Тухайн улсууд хооронд ийм аргаар тохиролцоонд хүрэхийг хичээснээр эрх мэдлээ шийтгэл ногдуулахаар хязгаарласан тогтолцооны урьдаар хүлээн зөвшөөрсөн байдлаас үүдэх хүндрэлээс зайлсхийх боломжтой болно.

Оролцогч улсууд цаашид эрт шатанд шийдвэр гаргах шаардлагатай болж болох бөгөөд шүүхийн харьяаллын асуудлыг хэзээ, хэрхэн авч үзвэл зохих мөн зөвөлгөө, тохиролцооны асуудлыг аль эрх бүхий байгууллага хариуцах талаар хандан асууж болох юм. Шийдвэрийг байцаан шийтгэх ажиллагааны эхэнд эсхүл тухайн тохиолдлын шинж байдал хэлбэржиж, үүсч болох асуудлууд шийдэгдсний дараа гаргавал зохих асуудал үүсч болох тул цаг хугацааг товлох явдал үүнд чухал болж болно.

II.2. Шилжүүлэх шийдвэр гаргахад тавигдах бодит шалгуур

Шилжүүлэх талаар шийдвэр гаргах явдлыг хөнгөвчилөхийн тулд, оролцогч улсууд шүүхийн харьяаллын ийм нарийн төвөгтэй асуудлыг шийдвэрлэхэд туслаж болох бүлэг шалгуурыг тогтоох хэрэгтэй. Жишээ нь, оролцогч улсууд энэ шалгууртаа дараах асуултуудыг багтааж болох юм:

- Гэмт хэрэг хаана үйлдэгдсэн ба гэмт хэрэгтнийг хаана баривчилсан бэ?
- Ихэнх гэрч, хамгийн гол нотлох баримт буюу гэмт хэргийн хохирогч хаана байгаа вэ?
- Аль шүүхийн тогтолцоо хамгийн сайн / хамгийн үр нөлөөтэй хуультай вэ?
- Аль шүүхийн тогтолцоо хураан авах тухай хамгийн сайн хуультай вэ?
- Аль шүүхийн тогтолцоонд хамгийн бага саатал үүсэх вэ?
- Аль шүүхийн тогтолцоо хамгийн сайн хамгаалалт / хорин саатуулах баталгаагаар хангах вэ?
- Аль шүүхийн тогтолцоо эмзэг нууц мэдээллийг задруулах тухай асуудлыг хамгийн сайн шийдэж чадаж вэ?
- Аль тогтолцоо байцаан шийтгэх ажиллагааны зардлыг үүрч чадах вэ?
- Гэмт хэрэг аль шүүхийн тогтолцоонд хамгийн их нөлөө үзүүлсэн вэ?
- Буцаан олгож болох хөрөнгийн ихэнх хаана байна вэ?
- Аль оролцогч улсад хөрөнгө буцаан олгох хамгийн боловсронгуй механизм байна вэ?

III. Шалгах асуултууд

- Оролцогч улс эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг шилжүүлэх талаар хэлэлцээр буюу тохиролцоо байгуулсан уу?
- Оролцогч улс эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг шилжүүлэх буюу хүлээн зөвшөөрөх талаар шийдвэр гаргах бодлого болон бодит шалгуур боловсруулсан уу?

- Шүүхийн шийдвэр, үйл ажиллагааны асуудал болон ял ногдуулахтай холбоотойгоор эдгээр асуудлаар гаргасан шийдвэрийн үр дагаварын талаар бодлогын баримт бичигт дурдсан уу?
- Оролцогч улс холбогдох асуудлаар зөвлөх болон шийдвэр гаргахыг голлон хариуцсан байгууллагыг тогтоож, холбогдох эрх үүргийг олгосон уу?

48 дугаар зүйл: Хууль сахиулах талаар хамтран ажиллах

1. Оролцогч улсууд өөр өөрийн дотоодын эрх зүй ба захиргааны тогтолцоондоо нийцүүлэн энэхүү конвенциор тодорхойлсон гэмт үйлдлүүдтэй тэмцэхдээ хууль сахиулах арга хэмжээний үр нөлөөг нэмэгдүүлэх үүднээс харилцан нягт хамтран ажиллана. Тухайлбал, оролцогч улсууд дараахь чиглэлээр үр дүнтэй арга хэмжээ авна:

(a) Энэ конвенциор тодорхойлсон гэмт үйлдэлтэй холбогдсон бүх талын мэдээллийг найдвартай, хурдан солилцох явдлыг бий болгох үүднээс эрх бүхий байгууллага, агентлаг, албадын хоорондын харилцаа холбоог бэхжүүлэх болон шаардлагатай тохиолдолд харилцаа холбооны сувгийг бий болгох, түүний дотор хэрэв холбогдох оролцогч улсууд зохистой гэж үзсэн бол эрүүгийн бусад үйл ажиллагаатай холбоо тогтоох;

(b) Энэхүү конвенцоор хамарсан гэмт үйлдэлтэй холбогдуулан дараахь асуудлаар шалгалт явуулахад оролцогч бусад улстай хамтран ажиллах:

(i) Тухайн гэмт үйлдэлд холбогдсон хэмээн сэжиглэгдэж байгаа этгээдийн хэн болох, хаана байгаа, түүний үйл ажиллагаа эсхүл холбогдох бусад этгээдийн байгаа газар;

(ii) Гэмт үйлдлээс олсон орлого эсхүл тухайн гэмт үйлдлийг үйлдэх замаар олсон эд хөрөнгийн хөдөлгөөн;

(iii) Тухайн гэмт үйлдлийг үйлдэхэд ашигласан эсхүл ашиглах зорилготой эд хөрөнгө, тоног төхөөрөмж буюу бусад хэрэгслийн хөдөлгөөн;

(c) Шаардлагатай эд зүйл болон бодисыг шинжлүүлэх буюу мөрдөн байцаалтын зорилгоор зохих тохиолдолд өгөх;

(d) Энэ конвенциор тодорхойлсон гэмт үйлдэлд ашигладаг тодорхой арга, хэрэгслийн талаархи мэдээлэл, түүний дотор хуурамч биеийн байцаалт, дуурайлгасан, өөрчилсөн буюу хуурамч баримт бичиг, нуун дарагдуулах зорилготой бусад арга хэрэгслийн талаархи мэдээллийг бусад оролцогч улстай зохих тохиолдолд солилцох;

(e) Өөрийн эрх бүхий байгууллага, агентлаг, албадын хоорондын уялдаа холбоог үр дүнтэй байлгах явдлыг хялбарчлах болон боловсон хүчин ба бусад мэргэжилтэн солилцох явдлыг дэмжих, түүний дотор холбогдох оролцогч улсуудын хооронд байгуулсан хоёр талт хэлэлцээр буюу тохиролцооны дагуу харилцааны ажилтан томилох;

(f) Энэхүү конвенцоор хамарсан гэмт үйлдлүүдийг эрт таньж тогтоох зорилгоор зохих мэдээлэл солилцож, захиргааны болон бусад арга хэмжээг уялдуулан зохицуулах.

2. Энэхүү конвенцийг хэрэгжүүлэх үүднээс оролцогч улсууд хууль сахиулагч эрх бүхий байгууллагуудынхаа хооронд шууд хамтран ажиллах хоёр буюу олон талт хэлэлцээр буюу тохиролцоо байгуулах, түүнчлэн тийм хэлэлцээр буюу тохиролцоо байгаа бол нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг авч үзнэ. Холбогдох оролцогч улсуудын хооронд тийм хэлэлцээр буюу тохиролцоо байхгүй тохиолдолд оролцогч улсууд энэ конвенциор тодорхойлсон гэмт үйлдлүүдийн хувьд энэхүү конвенцийг хууль сахиулах харилцан хамтын ажиллагааны үндэс хэмээн үзэж болно. Аливаа зохих тохиолдолд оролцогч улсууд хууль сахиулагч эрх бүхий байгууллагуудынхаа хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилгоор хэлэлцээр буюу тохиролцоо байгуулах явдлыг, түүний дотор олон улсын буюу бүс нутгийн байгууллагуудыг бүрэн ашиглана.

3. Энэ конвенциор тодорхойлсон гэмт үйлдлийг орчин үеийн технологи ашиглаж үйлдсэн тохиолдолд оролцогч улсууд тэдгээр гэмт үйлдэлтэй тэмцэх талаар өөрийн бололцооны хэрээр хамтран ажиллахыг чармайна.

I. Ерөнхий тойм

Хууль сахиулах нь улс төрийн бүрэн эрхийг гүйцэтгэх нүдэнд хамгийн ил бөгөөд ярвигтай хэлбэр тул улсууд гадаадын хууль сахиулах агентлагтай хамтран ажиллахдаа ер нь дурамжхан байсаар ирсэн. Гэхдээ энэ хандлага онц ноцтой гэмт хэрэгтэй тэмцэхэд хамтын эрх ашиг болон улс хоорондын гэмт хэрэгт холбогдох арга хэмжээг авахад хамтын ажиллагааны ач холбогдлыг улам бүр ойлгох болсонтой холбоотойгоор аажмаар өөрчлөгдөж байна.

Конвенцийн 48-аас 50 дугаар зүйл нь, ялангуяа, улс хоорондын авлигын хэргийг амжилттай мөрдөн байцаахад чухал хэрэгсэл болохын хувьд оролцогч улсуудын хууль сахиулах байгууллагууд хоорондын илүү нягт хамтын ажиллагааг хөхилүүн дэмжихэд чиглэсэн юм. Тухайлбал 48 дугаар зүйл хууль сахиулах талаар хамтын ажиллагааны үр нөлөөг сайжруулах арга замыг эрэлхийлж, оролцогч улсуудаас энэхүү конвенцоор хамарсан гэмт үйлдэлтэй холбогдсон бүх талын мэдээллийг найдвартай, хурдан солилцох явдлыг хөнгөвчлөхийн тулд эрх бүхий байгууллага, агентлаг, албадын хоорондын харилцаа холбоог бэхжүүлэх болон шаардлагатай нөхцөлд харилцаа холбооны сувгийг бий болгох, түүний дотор шаардлагатай тохиолдолд эрүүгийнбусад үйл ажиллагаатай холбоо тогтоохыг хүссэн байна.

Энэ зүйлийн 1 дэх хэсэг хамтран ажиллах үүргийн цар хүрээг тогтоож, хамтын ажиллагааны үндсийг бүрдүүлэх тэдгээр арга хэмжээг тодорхойлсон байна.

Энэ зүйлийн 2 дахь хэсэг энэхүү конвенцийг хэрэгжүүлэх үүднээс оролцогч улсууд хууль сахиулагч эрх бүхий байгууллагуудынхаа хооронд шууд хамтран ажиллах хоёр буюу олон талт хэлэлцээр буюу тохиролцоо байгуулахыг уриалсан байгаа. Үүнд цаашлаад тийм хэлэлцээр буюу

тохиролцоо байхгүй тохиолдолд оролцогч улсууд энэхүү конвенцийг хууль сахиулах харилцан хамтын ажиллагааны үндэс болгон ашиглаж болно гэж заасан байна.

Энэ зүйлийн 3 дахь хэсэг энэхүү конвенцоорхамарсан олон гэмтүйдлийг үйлдэх зорилгоор орчин үеийн технологи ашиглах явдал ихэсч байгааг дурдан, оролцогчулсуудаас тэдгээрорчин үеийн технологи ашиглан үйлдсэн авлигатай холбоотой гэмт үйлдэлтэй тэмцэх талаар хамтран ажиллахыг чармайхыг хүссэн байна.

II. Бэрхшээл ба шийдэл

II.1. Шийдэх асуудлууд

Хууль сахиулах талаар албан ба албан бус хамтын ажиллагааны аль алинд олон тооны асуудал, хүндрэл үүсдэг. Жишээ нь, өөр өөр шүүхийн тогтолцооны чиг хандлагын харилцан адилгүй байдлаас үүдэн улсуудын хууль сахиулах байгууллага хил дамжсан тодорхой хэлбэрийн гэмт хэргийг хэрхэн шийдэх тал дээр зөвшилцөлд хүрч чадахгүй байж болно. Иймээс оролцогч зарим улс хууль сахиулах байгууллага эсхүл шүүхийн албан тушаалтан нь гэрчтэй өөрийн хэл дээр ярилцах буюу асуултуудыг тэдэнд урьдаас ирүүлэх шаардлага тавьж байж болох юм. Оролцогч бусад улс хүсэлт гаргагч оролцогч улсын албан тушаалтны явуулж буй бүх ярилцлагад өөрийнх нь албан тушаалтныг байлгахыг шаардаж байж болно. Түүнчлэн зарим оролцогч улс гадаад улсад гэрчлүүлэхээр өөрийн хууль сахиулах байгууллагын албан хаагчийг явуулахаас татгалзаж байж болох юм. Эцэст нь, цахим ажиглалт болон нууц ажиллагаанд үйл ажиллагааны нууцлалыг хангах шаардлага нь, ялангуяа итгэлцэл, үнэмшил бүрдээгүй тохиолдолд, дотооддоо болон гадаад улстай эрүүгийн мэдээлэл солилцоход сонирхолгүй байх явдалд хүргэж болно.

Оролцогч улсуудын хууль сахиулах тогтолцооны бүтцийн ялгаатай байдал нь гадаадын хууль сахиулах аль байгууллагатай холбоо барих тал дээр төөрөгдөл, холбоо барих байдалд давхцал, түүнчлэн зарим тохиолдолд агентлагууд хооронд өрсөлдөөн үүсгэж болох бөгөөд энэ нь хязгаарлагдмал нөөцийг ашиглах явдалд үргүйзардалгаргаж болох юм.

II.2. Хамтран ажиллах талбарууд

Дээр дурдсан хүндрэлүүдийг шийдэхийн тулд оролцогч улсууд дараах талбаруудад хамтын ажиллагаа явуулж, харилцан үр ашигтай байж болохыг тооцож үзвэл зохино:

- (a) *Стратегийн болон техникийн мэдээллийг солилцох.* Тухайн улсын холбогдох эрх мэдлийн дагуу мөн мэдээллийн нууцлал зэрэг холбогдох дүрэмд нийцүүлэн стратегийн болон техникийн мэдээллийг солилцож болох юм. Мэдээллийг сайн дураар эсхүл хүсэлтийн дагуу солилцож болно. Мэдээллийг дундын өгөгдлийн санд хадгалж, оролцоо бүхий олон янзын агентлагийн явуулах үйл ажиллагааны дүн шинжилгээг дэмжихэд ашиглаж болох юм. Стратегийн мэдээлэлд гэмт хэргийн хандлага, гэмт хэргийн бүлэглэлийн үйл ажиллагааны бүтэц болон сэжиг бүхий хувь этгээдийн талаархи мэдээлэл мөн гэмт хэрэг үйлдэхэд ашиглах стратеги, арга, техникийн мэдээлэл орж болно. Энэ нь цаашлаад авлигач үйлдлийн санхүүжилт болон гэмт хэргээс олсон орлогыг түгээх шилдэг арга

замын тухай мэдээллийг хамаарч болох юм. Түүнчлэн конвенцийн 50 дугаар зүйлд өгүүлсэн арга барил ба хандлага үүнд багтаж болно.

- (b) *Мэдээллийн салбарт хамтран ажиллах болон техникийн тусламж.* Ийм хамтын ажиллагаа нь ялангуяа аюул заналыг үнэлэх болон эрсдэлд дүн шинжилгээ хийх тал дээр тухайн улсын холбогдох үйл ажиллагаанд уялдаа холбоог үр нөлөөтэй байлгах үүднээс үндэсний эрх мэдлийн хүрээнд явагдах учиртай. Ийм хамтын ажиллагааг тодорхой техникийн арга хэрэгсэл түүнчлэн хуурамч бичиг баримт ашиглах, компани, хувь хүнийг далдлах зэрэг авлигатай холбоотой хандлага, арга замын талаар мэдээлэл солилцоход авч явуулж болох юм.
- (c) *Мэргэжилтэн бэлтгэх болон ажлын хэсэг гаргах чиглэлээр хамтран ажиллах.* Хамтарсан сургалт зохион байгуулах тал дээр хамтран ажиллах явдлыг цаашид хөгжүүлэхийг оролцогч улсууд хүсч болно. Үүнтэй холбоотойгоор ажиллах хэсэг, семинар, дадлагын хичээл зохион байгуулах нь зөв дадлыг илүү өргөн хүрээнд түгээх, шинэ хандлага, арга боловсруулах, болон авлигатай тэмцэх хууль сахиулах байгууллагуудын сүлжээг бий болгоход боломжоор хангах. Боловсон хүчнийг томилох болон солилцох байдлаар мэргэжлийн туршлага болон мэдээллийг солилцож болно. Оролцогч улсууд эдгээр хүчин чармайлт нь задарч тасрахгүй мөн нөөц үрэгдүүлэхгүй байх явдалд анхаарал хандуулах хэрэгтэй.
- (d) *Холбооны нэгж ба сүлжээг ашиглах.* Холбооны нэгжийн сүлжээ нь бүс нутгийн хэмжээнд оролцогч улсууд хооронд үр нөлөөтэй хамтран ажиллах тал дээр ашиг тустай хэрэгсэл болох нь батлагдсан юм. Төлөөлөгчид шаардлагатай үед харилцан итгэлцэл, үнэмшлийг дэмжих, дундын стратегийг болосвруулах, шинэ хандлагыг бий болгох, бодит амьдралд тулгараад буй асуудлыг шийдвэрлэхээр цугларч байх хэрэгтэй.
- (e) *Хамтарсан мөрдөн байцаах ажиллагааны багт оролцох.* Европол, Интерполын мэдээлэл солилцох үйл ажиллагаагаар мөн Луйвартай тэмцэх Европын товчоо (OLAF), Европол зэрэг хууль сахиулах болон гүйцэтгэх агентлагууд хооронд үр нөлөөтэй хамтын ажиллагааг дэмжих арга замыг эрэлхийлсэн бүс нутгийн олон тооны арга хэрэгслээр дамжуулан оролцогч улсууд дотооддоо болох өөр хоорондоо хууль сахиулах тал дээр үр дүнтэй байдлаар хамтран ажиллаж буй жишээ олон байна (49 дүгээр зүйлийг харна уу).

II. 3. Хамтран ажиллах арга зам

Гадаад улсад нотлох баримт болон мэдээлэл нь байгаа мөрдөн байцаах ажиллагааг явуулахад мэдээлэл эсхүл тагнуулын мэдээг эрх зүйн харилцан туслалцааны албан арга замаас илүүтэйгээр эхлээд үүнээс хурдан, хямд, уян хатан байж болох хууль сахиулах албан бус сувгаар олж авахыг хичээж болно. Гэхдээ ийм албан бус холбооны тухайд зохих протокол хөтөлж, баталгаажуулж байх шаардлагатай. Эдгээр нь харилцан ойлголцлын санамж бичиг буюу үүнтэй төстэй протокол байгуулсан тохиолдолд орон нутгийн гэмт хэрэг хариуцсан харилцааны ажилтныг ашиглахаас авахуулаад бүс нутгийн тохиролцоо байгуулах зэргээр янз бүр байж болно.

48 дугаар зүйлийн 1 (е) хэсэгт боловсон хүчнийг солилцох талаар дурдах байдлаар харилцааны ажилтныг илгээх асуудлыг иш татсан байгаа. Өөр улсруу харилцааны ажилтан илгээх нь нилээдгүй зардалтай тул харилцааны ажилтныг зөвхөн тухайн ажилтан илгээж буй улстай томоохон хэмжээний хамтын ажиллагаа хэдийн явуулсан тийм улсруу л илгээдэг. Зардлыг багасгахын тулд харилцааны ажилтанд зочин улстай төдийгүй мөн бүс нутгийн нэг болон түүнээс дээш улстай харилцах харилцаа холбоог даалгаж болно. Өөр нэг боломж нь хэд хэдэн улсыг төлөөлсөн харилцааны нэг ажилтныг байлгах явдал юм.

Олон улсын хэмжээний зохион байгуулалт, бүтцийн хүрээнд хамтран ажиллах явдлыг цаашид хэлэлцэж үзвэл зохино. Үүнд Интерпол, Европол, Шенгений улсуудын хэлэлцээр, Өмнөд Африкийн цагдаагийн удирдлагуудын хамтын ажиллагааны байгууллагын ажлууд орж болно. Ийм олон улсын хэмжээний зохион байгуулалт, бүтцийн хүрээнд хамтын ажиллагааг сайжруулахын тулд бүс нутаг болон олон улсын хэмжээнд мэдээлэл солилцох илүү үр нөлөөтэй тогтолцоог нэвтрүүлэх арга замыг эрэлхийлэх хэрэгтэй.

Интерполын мэдэгдлийн тогтолцоо, Шенгений мэдээллийн сан зэрэг мэдээллийн аливаа тогтолцооны үр нөлөө нь өгч буй мэдээллийн үнэн зөв байдал болон цагаа олсон байдлаас хамаардаг. Түүнчлэн үйл ажиллагааны мэдээллийг олж авах, ашиглах, олон улсын хэмжээнд шилжүүлэх нь хууль сахиулах ажиллагааны хууль ёсны байдал, ил тод байдал, хариуцлага хүлээх байдлын тухайд асуудал үүсэх шалтгаан болж болно. Хуулийн болон шүүхийн хяналтгүйгээр энэ нь мэдээллийг буруугаар ашиглах явдалд хүргэж болох юм. Үйл ажиллагааны мэдээллийг цуглуулах, ашиглах болон үүнд дүн шинжилгээ хийх механизм нь хүний тулгуур эрхийг бүрэн хүндэтгэж үзэх хэрэгтэйг анхаарч үзвэл зохино. Хууль сахиулах явдлыг дэмжих зорилгоор мэдээллийн сан бий болгож байгаа бол мэдээлэл хамгаалах талаар үндэсний хууль тогтоомж нь хангалттай байх мөн ийм мэдээллийн сан нь үндэсний төдийгүй олон улсын хэмжээний үйл ажиллагааг хамарч байх явдлыг хангах хэрэгтэй.

III. Шалгах асуултууд

- Хууль сахиулах байгууллагууд хооронд үр дүнтэй уялдаа холбоог дэмжих хоёр талт буюу олон талт хэлэлцээр буюу тохиролцоог оролцогч улс байгуулсан уу?
- Оролцогч улс хууль сахиулах талаар хамтын ажиллагаатай холбоотой хүсэлтийг шийдэх тусгай байгууллага буюу байгууллагуудыг байгуулсан уу?
- Энэ байгууллагад энэхүү конвенцид хамрах гэмт хэрэгтэй холбоотойгоор гадаадын оролцогч улсын өмнөөс мөрдөн байцаах ажиллагаа явуулах эрх мэдэл олгосон уу?
- Энэ байгууллагад гадаадын оролцогч улсын бусад байгууллагатай байгуулсан хамтын ажиллагааны тохиролцоо болон харилцаанд гол үүрэг хариуцлага хүлээх, мэдээлэл солилцох эрх мэдэл олгосон уу?

49 дүгээр зүйл: Хамтарсан мөрдөн шалгах ажиллагаа

Оролцогч улсууд нэг буюу хэд хэдэн улсад мөрдөн шалгах, ялах, шүүн шийдвэрлэх ажиллагаа явагдаж байгаа хэргийн талаар оролцогч улсуудын эрх бүхий холбогдох байгууллагууд хамтарсан мөрдөн шалгалт явуулах бүтцийг байгуулах болон хоёр буюу олон талт хэлэлцээр эсвэл тохиролцоо байгуулах асуудлыг авч үзнэ. Тийм хэлэлцээр буюу тохиролцоо байхгүй тохиолдолд хамтарсан мөрдөн байцаалтыг тухай бүр тохиролцож явуулж болно. Холбогдох оролцогч улсууд нутаг дэвсгэрт нь тийм мөрдөн шалгах ажиллагаа явагдах гэж буй оролцогч улсын бүрэн эрхт байдлыг бүрэн хүндэтгэнэ.

I. Ерөнхий тойм

Энэхүү заавал биелүүлэх албагүй заалт нь 48 дугаар зүйлд дурдсан шаардлага дээр үндэслэсэн бөгөөд оролцогч улсууд хооронд нягт үргэлжлэх харилцааг дэмжиж өгч байгаа юм. Энэхүү зүйл нь тухайн хэрэгт хэд хэдэн оролцогч улс шүүхийн харьяаллаа тогтоосон тохиолдолд хамтарсан мөрдөн байцаах байгууллагыг ашиглахыг зөвшөөрөх тохиролцоог байгуулах асуудлыг тооцож үзэхийг оролцогч улсаас хүсч байна. Цаашлаад 49 дүгээр зүйлд холбогдох хэлэлцээр, тохиролцоо байхгүй тохиолдолд тухай бүрт нь хамтарсан мөрдөн байцаах ажиллагаа явуулах боломжийг олгож байгаа болно.

II. Бэрхшээл ба шийдэл

II.1. Үйл ажиллагаатай холбоотой асуудлууд

Хамтарсан мөрдөн байцаах ажиллагаа нь хил дамнасан гэмт хэрэг, үүнд ялангуяа хил дамнасан зохион байгуулалттай гэм хэрэгт олон улсын хамтын ажиллагааны нэг хэлбэр болж олон жил хэрэглэгдсээр ирсэн. Гэхдээ энэ ажиллагаа нь бараг ихэнхдээ тусгайлсан хэлэлцээр дээр үндэслэн хөгжиж ирсэн харагдаж байна.

Бодит туршлагаас харахад ийм ажиллагаанаас үүдэн өөр улсад үйл ажиллагаа явуулж буй албан тушаалтны хууль ёсны байр суурь болон эрх мэдэл, тухайн улсад өөр улсын албан тушаалтны олж авсан мэдээлэл тухайн улсад нотолгоо болох боломж болон оролцогч улсууд хооронд мөрдөн байцаах ажиллагаанаас өмнө ба мөрдөн байцаах ажиллагааны үеэр мэдээлэл солилцохтой хамаатай асуудал үүсдэг юм.

Эдгээр бодит асуудлыг урьдаас хүлээн зөвшөөрч, асуудлыг мөрдөн байцаах төлөвлөлтийн арга замыг ашиглан шийдэж болохыг анхаарч үзэх хэрэгтэй. Гэхдээ улс хоорондын гэмт хэргүүд, үүнд ялангуяа улс хоорондын авлигын хэрэгт мөрдөн байцаах ажиллагаа явуулах, мэдээлэл солилцох тал дээр тодорхой бөгөөд тууштай байдал шаардлагатай. Энэ нь, тухайн нотолгоог шүүх хуралд хэрэглэж болохыг, багийн гадаад гишүүдийн эрх, үүргийг хамгаалахыг мөн 49 дүгээр зүйлд шаардсанчлан нутаг дэвсгэрт нь мөрдөн шалгах ажиллагаа явагдах гэж буй оролцогч улсын бүрэн эрхт байдлыг бүрэн хүндэтгэхийг баталгаажуулж өгөхөд гарцаагүй тус болно.

II.2. Мөрдөн шалгах ажиллагааны хүрээ, бүтэц

Саяхныг хүртэл хамтарсан мөрдөн байцаах ажиллагааг явуулах түүнчлэн ажиллагааг явуулах багийг бүрдүүлэхолон улсын хэмжээнд зөвшөөрсөн орчин нөхцөл бүрдээгүй байсан юм. Европын Холбооны гишүүн улсууд 2002 оны 7 сард Хамтарсан мөрдөн байцаах ажиллагаа явуулах багийн талаар Европын Зөвлөлийн Бүтцийн шийдвэрийг батлуулан ийм орчин нөхцлийг бий болгосон. Энэ шийдвэр нь Эрүүгийн асуудлаар харилцан туслалцах тухай Европын Холбооны 2000 оны конвенцийн 13, 15, 16 дугаар зүйлийн хэрэгжилтийг дэмжиж байгаа юм (13 дугаар зүйл хамтарсан мөрдөн байцаах баг байгуулах, хамтарсан мөрдөн байцаах ажиллагаа явуулах асуудлыг шийдэж байгаа бол 15, 16 дугаар зүйл оролцогсдын эрүүгийн болон иргэний үүрэг хариуцлагад хамаарна).

Эрүүгийн асуудлаар харилцан туслалцах тухай Европын Зөвлөлийн конвенцийн Хоёр дахь нэмэлт протоколын 20, 21, 22 дугаар зүйлд мөн Гишүүн орнуудын гаалийн удирдлагуудын хооронд харилцан туслалцах ба хамтын ажиллагааны тухай Наплесийн II конвенцийн 3, 19, 24 дүгээр зүйлд хамтарсан мөрдөн байцаах багийн талаар төстэй заалт орсон байгаа.

Хамтарсан мөрдөн байцаах ажиллагааны тал дээр Европын Холбооны хандлага нь улс хоорондын шинжтэй онц ноцтой гэмт хэргийг мөрдөн байцаах хамтарсан баг байгуулах асуудалд юун түрүүнд төвлөрдөг. Үүнд нөхцөл байдлын хувьд уялдаа холбоо бүхий хамтын ажиллагаа шаардах тийм гэмт хэргийг хэд хэдэн оролцогч улс мөрдөн байцааж байх шаардлага тавина.

Прокурор мөрдөн байцаах ажиллагааны бүр анхан шатанд цагдаатай хамтранажилдагүүнд шүүхийн харъяалал тогтоох, мэдээлэл задруулах болон Европын бусад мэргэжил нэгтнүүдтэйгээ уялдаа холбоотой байх зэрэг өргөн хүрээний асуудлаар зөвөлгөө өгөх хариуцлага хүлээхийг ЕХ-ны гишүүн улсуудад хэзээд сануулж байдаг. Үнэхээр ч оролцож буй улсын багийн ахлагч нь прокурор эсхүл шүүгч байх нь нилээд өндөр магадлалтай.

II.3. Хамтарсан ажиллагааг төлөвлөх

Хамтарсан мөрдөн байцаах ажиллагааг төлөвлөх болон ямар нэг ажиллагаа явуулахаас өмнө шийдвэл зохих асуудлыг тогтоохдоо дор дурдсан зүйлсийг анхаарч үзэх шаардлагатай:

- Хамтарсан мөрдөн байцаах ажиллагааны талаар шийдвэр гаргах шалгуур тавих; Үүнд улс хоорондын тодорхой тогтоосон ноцтой авлигын хэргийг юун түрүүнд чухалчилж үзнэ. Ийм мөрдөн байцаах ажиллагааг тухайн хэрэгт тохирсон байдлаар мөн сэжигтний хүний эрхийг зохих байдлаар хүндэтгэн явуулах асуудал чухал.
- Хамтарсан мөрдөн байцаах ажиллагаа явуулах газрыг сонгох шалгуур тавих (хилийн ойр, гол сэжигтэнд ойр г. м.);
- Олон тооны өөр өөр шүүхийн харъяаллын оролцоо байгаа тохиолдолд мөрдөн байцаах ажиллагааг түргэтгэх үүднээс уялдуулагч байгуулагыг ашиглах;

- Мөрдөн байцаах ажиллагааг удирдаж, хянах гол мөрдөн байцаагчийг томилох;
- Хамтын ажиллагааны хамтын зорилго болон үр дүнг тохиролцох, оролцогч байгууллага бүрийн оруулах хувь нэмэр мөн оролцогч байгууллага бүрийн өөрийн улсын бусад байгууллагатай харилцах харилцаа;
- Шүүхийн тогтолцоо хоорондын аливаа ялгаатай байдлыг шийдэх;
- Хүлээн авагч улс тухайн багийн дэд бүтцийн асуудлыг хариуцах учир мөрдөн байцаах ажиллагааны урьчилсан нөхцлийг шийдэх;
- Хамтарсан мөрдөн байцаах ажиллагааны ивээл дор ажиллах гадаадын байгууллагын ажилтны үүрэг хариуцлага;
- Шүүгч буюу мөрдөн байцаагчийн тавих хяналтын түвшин;
- Хамтарсан мөрдөн байцаах ажиллагааны санхүүжилт ба нөөц. Энэ тал дээр, хэлэлцээрт оролцож буй улсуудад шууд ногдуулах зардлыг заасан байх шаардлагатай. Оролцогч улс бүр зардлыг боловсон хүчнийг хуваарилж буй байгууллага шууд хариуцах эсхүл үндэсний буюу олон улсын өөр төрлийн санхүүжилт хариуцах эсэхийг тодорхой заана;
- Мэдээлэл нэгтгэх, хадгалах, хуваалцах, үйл ажиллагааны нууцлал, нотлох баримтын үнэн зөв байдал, нотолгоо болох боломж, мэдээлэл задруулахтай холбоотой асуудал (нийтлэг хуулийн шүүхийн харъяалал ялангуяа санаа зовоож болно), нууц ажиллагааг ашиглах асуудал, зохих зардал, хууль сахиулах зорилгоор мэдээллийн хөдөлгөөний саатал зэрэг үүсч болох хуулийн болон бодит асуудлыг тогтоох дүрэм, журам, зохицуулалтыг тодорхойлох;
- Хамтарсан мөрдөн байцаах ажиллагаанд оролцож буй хөгжиж буй улсын хүчин чадал, мэргэжлийн ур чадвар, туршлагыг дээшлүүлэх явдлыг хангах.

III. Шалгах асуултууд

- Оролцогч улсын эрх бүхий байгууллагууд шүүхийн олон харъяалал бүхий хэргийг шийдэх хамтарсан мөрдөн байцаах ажиллагаанд эсхүл хамтарсан мөрдөн байцаах ажлын хэсэгт оролцож байсан уу?
- Ийм оролцоо нь тусгай хэлэлцээрт үндэслэсэн байсан уу эсхүл ийм эрх мэдэл олгох урьдаас тогтоосон орчин байгаа юу?
- Хамтарсан мөрдөн байцаах ажиллагаа явуулахад хуулийн, үйл ажиллагааны болон нотолгооны ямар асуудал тулгарч байсан бэ?

50 дугаар зүйл. Мөрдөн шалгах тусгай арга хэрэгсэл

1. Авлигатай үр дүнтэй тэмцэх үүднээс оролцогч улс бүр эрх бүхий байгууллагууд хяналтанд ор хүргүүлэх, цахим болон бусад төрлийн хянах, тагнах төхөөрөмж зэрэг мөрдөн шалгах тусгай арга хэрэгслийг зохистой гэж үзсэн тохиолдолд нутаг дэвсгэртээ зохистойгоор ашиглахыг зөвшөөрөх, тийнхүү олж авсан баримтыг шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нотлох баримтаар тооцуулж, үнэлүүлэх талаар шаардлагатай арга хэмжээг бололцооныхоо хэрээр дотоодын эрх зүйн тогтолцооныхоо үндсэн зарчмаар зөвшөөрсөн хэмжээнд, дотоодын хууль тогтоомждоо заасан нөхцөлд нийцүүлэн авна.

2. Шаардлагатай тохиолдолд энэ конвенциор тодорхойлсон гэмт үйлдлийг мөрдөн шалгах зорилгоор мөрдөн шалгах тусгай хэрэгслийг олон улсын түвшний хамтын ажиллагаанд хэрэглэх тухай хоёр буюу олон талт зохих хэлэлцээр буюу тохиролцоог оролцогч улсууд байгуулахыг дэмжинэ. Тийм хэлэлцээр буюу тохиролцоог улсуудын бүрэн эрхт тэгш байдлын зарчимд бүрэн нийцүүлэн байгуулах буюу хэрэгжүүлэх бөгөөд тэдгээр хэлэлцээр, тохиролцооны нөхцлийг чанд сахина.

3. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт дурдсан хэлэлцээр буюу тохиролцоо байхгүй тохиолдолд мөрдөн шалгах тийм тусгай арга хэрэгслийг олон улсын түвшинд хэрэглэх тухай шийдвэрийг тухай бүр гаргах бөгөөд шаардлагатай тохиолдолд холбогдох оролцогч улсуудын хэргийн харьяаллаа хэрэгжүүлэх тухай ойлголт буюу санхүүгийн тохиролцоог харгалзан үзэж болно.

4. Хяналтанд ор хүргүүлэх аргыг олон улсын түвшинд хэрэглэх тухай шийдвэрт бараа буюу хөрөнгийг замд нь саатуулах буюу хэвээр нь цааш явуулах эсхүл бүхлээр нь буюу хэсэгчлэн хураах эсхүл солих зэрэг аргыг холбогдох оролцогч улсуудын зөвшөөрснөөр багтаана.

I. Ерөнхий тойм

50 дугаар зүйл авлигын хэргийг мөрдөн байцаахад мөрдөн шалгах тусгай арга хэрэгслийг зохих байдлаар ашиглах арга хэмжээг авахыг оролцогч улсуудад зөвшөөрсөн байна.

Энэхүү зүйлийн 1 дэх хэсэгт хяналтанд ор хүргүүлэх ба ажиглан судлах болон нууц ажиллагааны цахилгаан болон бусад хэлбэр зэрэг мөрдөн шалгах тусгай аргыг зохистой гэж үзсэн тохиолдолд мөн ийм арга хэрэгсэл нь авлигатай холбоотой эрүүгийн нарийн гэмт хэрэгтэй тэмцэхэд хууль сахиулах эрх бүхий байгууллагын хэрэглэж болох үр дүнтэй зэвсэг болж болохыг ойлгосны үндсэн дээр ашиглах явдлыг хамгаалж байгаа болно. Гэхдээ ийм арга хэрэгслийг дотоодын эрх зүйн тогтолцооныхоо үндсэн зарчмаар зөвшөөрсөн хэмжээнд, дотоодын хууль тогтоомждоо заасан нөхцөлд нийцүүлэн ашиглах хэрэгтэй. Нэг дэх хэсэгт мөн ийм арга хэрэгсэл ашиглан олж авсан нотлох баримтыг шүүхэд хүлээн зөвшөөрүүлэх талаар арга хэмжээ авахыг оролцогч улсад үүрэг болгосон байна.

Энэ зүйлийн 2 дахь хэсэгт мөрдөн шалгах тусгай арга хэрэгслийг ашиглахыг зөвшөөрсөн эрх зүйн зохих орчин бүрдүүлсэн байх явдлыг чухалчилж байгаа бөгөөд иймээс ч энэ тал дээр хамтын ажиллагааг дэмжих хоёр буюу олон талт хэлэлцээр буюу тохиролцоог үндэсний бүрэн эрхт байдлын асуудлыг харгалзан үзэж байгуулахыг хөхиүлэн дэмжиж байгаа юм.

3 дэхь хэсэгт холбогдох хэлэлцээр буюу тохиролцоо байхгүй тохиолдолд мөрдөн шалгах тийм тусгай арга хэрэгслийг тухай бүрт нь хэрэглэх тухай эрх зүйн үндсийг санал болгох прагматик арга барилыг зааж өгсөн байна.

4 дэх хэсэгт олон улсын түвшинд хэрэглэж болох мөн бараа буюу хөрөнгийг замд нь саатуулж, хэвээр нь цааш явуулах эсхүл бүхлээр нь буюу хэсэгчлэн хураах буюу солих зэрэг аргыг багтаасан хяналтанд ор хүргүүлэх аргыг тодорхойлсон байна. Аль аргыг хэрэглэх нь тухайн тодорхой хэргийн орчин нөхцлөөс хамаарч болох ба үүнд үндэсний хууль тогтоомж болон үүний нотлох баримт болж хүлээн зөвшөөрөгдөх байдал нөлөөлж болно.

II. Бэрхшээл ба шийдэл

Сүүлийн үед мэдээлэлд түшиглэсэн, урьдчилсан мөрдөн байцаах ажиллагааг илүү ихээр анхааран үзэх болж, гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах тусгай арга хэрэгслийн ашиглалт болон мөрдөн байцаах ажиллагааны шинж байдалд нилээд өөрчлөлт гараад байна. Үүнээс гадна мөрдөн байцаагчийн нууцаар мэдээлэл цуглуулахад ашиглаж болох технологийн арга хэрэгсэл ч нилээд хурдацтай хөгжиж байгаа юм. Гэхдээ байцаах тусгай арга хэрэгслийг илүү өргөн хүрээнд ашиглах тал дээр хүний эрхийг хамгаалах асуудал болон дараа дараагийн байцаан шийтгэх ажиллагааны нотолгооны шаардлагыг харгалзан үзэх шаардлагатай.

II.1. Хүний эрхийн хамгаалалт

Оролцогч улс мөрдөн шалгах тусгай арга хэрэгслийг ашиглахын хууль зүйн болон бодлогын үр дагаврыг чухалчлан тооцож үзэхийг хүсч байж болно. Үүнд хүний эрхийг хамгаалахын тулд зохимжтой бөгөөд тохирсон байдлаар шалгалт хийж, тэнцвэрийг хадгалах асуудлыг нухацтайгаар үнэлж үзэх шаардлагатай. Мөрдөн шалгах тусгай арга хэрэгслийн ашиглалтыг хянах үүргийг шүүхийн байгууллагад эсхүл гүйцэтгэх засаглалын байгууллагад ногдуулах асуудлыг анхаарч үзвэл зохино.

II.2. Материаллаг нөөц боломж / Технологийн чадавхи/

Мөрдөн шалгах тусгай арга хэрэгслийг ашиглах хууль сахиулах байгууллагын мэргэжлийн ур чадвар болон эрх мэдэл, тэдгээрийн сургалтын түвшин нь энэ асуудалд холбогдох чухал хүчин зүйлсийн нэг бөгөөд анхаарч үзвэл зохино. Үүнээс гадна энэ тал дээр олон улсын хамтын ажиллагааг сайжруулах хамгийн зөв аргыг эрэлхийлж байгаа үед чадамжийг нэмэгдүүлэх болон мөрдөн шалгах тусгай арга хэрэгслийг ашиглан олж авсан нотлох баримтын хүлээн зөвшөөрөгдөх байдлыг хангахын тулд гадаад улсын хууль сахиулах байгууллагын мэргэшсэн төлөөлөгчийг өөр бусад оролцогч улсад ажиллуулах нь зохистой байж болох юм.

II.3. Нотлох баримтын хүлээн зөвшөөрөгдөх байдал

Мөрдөн шалгах тусгай арга хэрэгслийн хамрах цар хүрээ, ашиглалтийн хууль ёсны байдал болон үүний үр дүнд олж авсан баримтын нотолгоо болж чадах эсэхтэй холбоотойгоор асуудал үүсч болно. Энэ нь ялангуяа хамтарсан ажиллагаа явуулах тохиолдолд асуудал үүсгэж болох бөгөөд тагнуулын мэдээ, мэдээлэл болон нөөцийг анхааралтайгаар зохицуулах шаардлагатай байдаг. Зарим улсад шүүгч тухайн үйл явц хийгээд технологийг бүрэн ойлгохгүй байхаас үүдэн мөрдөн шалгах тусгай арга хэрэгсэл ашиглах нь хүндрэл үүсгэж болох юм. Энэ асуудлыг зохих сургалт болон тухайн технологийг ойлгох мэргэжилтэн шүүгчийн тусламжтайгаар шийдэж болно.

II.4. Арга хэрэгслүүд

Оролцогч улсын анхаарч үзэхийг хүссэн олон төрлийн мөрдөн шалгах тусгай арга хэрэгсэл байж болох бөгөөд II.4.1- II.4.7-д өргөн дэлгэр хэрэглэгддэг арга хэрэгслүүдийг дурдсан байгаа. Оролцогч улс ийм мөрдөн шалгах тусгай арга хэрэгслээр олж авсан нотлох баримтыг шүүхийн өмнө өргөн барьж байгаа үед энэхүү нотлох баримтын үнэн зөв байх асуудал маш чухал.

II.4.1. Техникийн ажиглалт- судалгаа– харилцуур утас чагнах, чагнах төхөөрөмж суулгах

Хэзээнээс хэрэглэгдэж ирсэн ажиглалт хийх цахим хэрэгсэл болохын хувьд энэ нь мөрдөн байцаах эрх бүхий байгууллагын хэрэглэхэд бэлэн, аюултай арга хэрэгсэлд тооцогдоно. Гэхдээ эдгээр нь хувь хүмүүсийн -үүнд зарим тохиолдолд мөрдөн байцаах ажиллагаанд хамааралгүй хүмүүсийн- харилцан яриаг сонсох зорилготой байдгийг тооцон эдгээрийг ашиглах тал дээр нарийн тодорхой болзол тавьж, эрх олгох зохих хамгаалалтанд анхаарал хандуулах хэрэгтэй. Цахим ажиглалт хийх гэдэгт сонсох төхөөрөмж хэрэглэх, харилцуур утас болон э-шууданд замаас нь нэвтрэх, мөрдөгч багаж ашиглах орж болно.

II.4.2. Биет судалгаа ба газар дээрх ажиглалт

Энэ арга хэрэгсэл нь техникийн ажиглалтын арга хэрэгслийн харьцангуй бага танигдсан хэлбэр бөгөөд үүнд сэжигтэнд биет байдлаар ажиглалт хийх, мөрдөх, сэжигтний гэрэл зургийг авах орж болно. Гэхдээ банкны дансыг хянах буюу шилжүүлэг хянах илүү нарийн аргууд ч үүнд багтаж болох юм.

II.4.3. Нууц ажиллагаа, гүнд нь нэвтэрч судлах арга

Нууц ажиллагаанд “дотор нь нэвтэрч орох ажиллагаа” багтдаггүй бөгөөд нууц ажиллагаа нь авлигын хуйвалдааны мэдээллийг уламжлалт аргаар олж авах бараг боломжгүй тийм тохиолдолд маш чухал арга хэрэгсэл болдог. Ийм ажиллагааны зорилго нь авлигач талтай холбоо тогтоох, ингэснээр авлигач үйлдлийг илрүүлж гаргах, үүнд гэрч болох явдал юм. Цагдаагийн ажилтан эсхүл бүр хамтран хуйвалдагч байхаас үл хамааран “дотоод этгээд”-ийн нотлох баримт нь яллах ажиллагааг амжилттай явуулах гол хүчин зүйл болж өгдөг. Цаашлаад ийм нотлох

баримтын үнэмшилтэй байдал нь ихэнхдээ хамтран ажиллах санал гаргах, хариуцагч гэм буруугаа хүлээх шалтгаан болж ингэснээр урт хугацаа, зардал шаардсан шүүн таслах ажиллагаа шаардлагагүй болж болох юм (37 дугаар зүйлийг харна уу).

Нууц ажиллагаа нь нууц ажилтны зүгээс замын цагдаа эсхүл доод албан тушаалтанд хахууль санал болгох зэрэг өдөр тутмын ажиллагаанаас авахуулаад (түр экспорт/импорт “үүсгэх” зэрэг) мөрдөн байцаах тусгай арга хэрэгсэл болон мөрдөн байцаах ажиллагааны чадварын аль алины хувьд нарийн, илүү ярвигтай удаан хугацааны төлөвлөгөө хүртэл хоорондоо ялгаатай байдлаар хэлбэлзэж болно. Гэхдээ нууц ажиллагаа болон дотор нь нэвтэрч орох аргын хуулиар зөвшөөрсөн байдалтай холбоотой, ялангуяа эрүүгийн хэрэг өдөөсөн тухай эсхүл (хахууль санал болгох зэрэг) гэмт хэрэг үйлдсэн ажилтны асуудал, түүнчлэн ийм ажиллагааны нөөц, үргэлжлэх хугацаа, зардал зэрэг хүндрэл оролцогч зарим улсад үүсч болох юм.

II.4.4. Мэдээлэгч

Оролцогч олон улс мэдээллийн эх сурвалж болгож төрийн байгууллагууд доторх мэдээлэгчийг ашигладаг эсхүл ажилд авдаг. Эдгээр нь хууль сахиулах ажилтан биш харин төрийн албан хаагч юм. Албан тушаалын хүрээний мэдээлэл болон тагнуулын мэдээ нь нууц ажиллагаа эсхүл ажиглалтанд захирагдахгүй тул ийм мэдээлэгчтэй ажиллах нь үр дүнтэй байж болно. Нөгөөтэйгүүр тэдэнтэй ажилласнаар мэдээллийн түгээлт, төлбөр, аюулгүй байдал болон мэдээлэгч-хариуцагчийн харилцаатай холбоотой асуудал үүсч болно. Ийм мэдээлэл нь шүүхийн өмнө хэрэг эхлүүлэхэд хангалтгайд тооцогдсон тохиолдолд энэхүү мэдээлэгчийн гэрч болж болох эсэхтэй холбоотой асуудал мөн тулгарч болох юм.

II.4.5. Үнэнч байдлыг турших

Үнэнч байдлыг турших нь авлигаас урьдчилан сэргийлэх болох авлигын хэргийг яллах явдлыг сайжруулах арга зам бөгөөд авлигыг таслан зогсооход үр дүнтэй, үр ашигтай болох нь батлагдсан юм. Үнэнч байдлыг турших аргыг хувь этгээд буюу хувь этгээдүүд, ихэнхдээ төрийн албан тушаалтны авлигын хэрэгт холбоотой гэдгийг харуулах мэдээлэл байгаа тохиолдолд голдуу хэрэглэдэг.

Жишээ нь төрийн албан хаагчийн эрүүгийн буюу бусад зохисгүй үйлдэл гаргах тал дээр өөрийн хувийн үзэмжээрээ шийдэх эрх мэдлээ ашиглан шийдвэр гаргах боломжтой жирийн өдөр тутмын байдалд тодорхой зохиомжит байдал үүсгэж болно. Тухайн ажилтанд, нууц ажилтан хахууль авах боломжийг санал болгож болно, эсхүл жишээ нь, төрийн чиг үүргийг урвуулан ашиглах байдлаар авлига хүсэх боломжийг олгож болох юм (19 дүгээр зүйлийг харна уу). Гэхдээ энэ туршилтыг нэлэнхүйд нь тэгшитгэх байдлаар хэрэглэж болохгүй, харин тухайн албан хаагч авлигач байж болох талаар тодорхой түвшний мэдээлэл дээр үндэслэж туршилтыг явуулна. Үүнээс гадна сэжигтэнд гэмт хэрэг үйлдэх боломжийг бий болгохыг нууц тагнуулд зөвшөөрөх, харин ийм үйлдэл гаргах бодит дэмжлэг үзүүлэхийг үл зөвшөөрөх хязгаарлалт буюу “эрүүгийн хэрэг өдөөх”-өөс сэргийлэх зорилготой хязгаарлалтыг анхаарч үзвэл зохино.

II.4.6. Санхүүгийн гүйлгээнд хяналт тавих

Санхүүгийн байгууллагаар дамжих хууль бус хөрөнгийн хөдөлгөөн болон оролцогч улсын СМН-д мэдээлэх түвшин нь хөрөнгийн хөдөлгөөний тухай төдийгүй мөн тэдгээр оролцогчдын харилцааны талаар мэдээлэл олж авах боломжоор мөрдөн байцаагчийг хангаж байдаг. 50 дугаар зүйлийг мөрдүүлэх зорилгоор, санхүүгийн мэдээллийн зохих хяналт, удирдлага, зохицуулалт бүхий мэдээлэх тогтолцоо нь мөрдөн байцаагчдад дансыг хянах болгомж олгох байдлаар авлигаас олсон санхүүгийн ашгийн байршил, хөдөлгөөн болон чиглэл өөрчлөх явцыг мөрдөхийг зөвшөөрч байна.

II.5. Холбогдох конвенцууд

Оролцогч зарим улс, ялангуяа Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус худалдаатай тэмцэх Нэгдсэн Үндэстний Байгууллагын 1988 оны конвенц (хяналтын дор хүргүүлэх тухай 11 дүгээр зүйлийг харна уу) ба Улс хоорондын зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцид (20 дугаар зүйлийг харна уу) нэгдэн орсноор мансууруулах бодисын худалдаа, зохион байгуулалттай гэмт хэрэг зэрэг гэмт хэрэгтэй холбоотойгоор 50 дугаар зүйлд заасан механизмыг аль хэдийн нэвтрүүлсэн байж болох юм. Гэхдээ эдгээр арга хэрэгслийг хэрэглэх эсэх талаар шийдвэр нь тухайн улсын дотоодын хууль тогтоомжийн шаардлага, үзэмжээрээ шийдэх эрх мэдэл болон нөөцөөс хамаарна.

III. Шалгах асуултууд

- Тухайн улсын эрх бүхий байгууллагуудад ажиглансудлах арга хэрэгсэл болон мөрдөн шалгах бусад тусгай аргыг ашиглах эрх олгогдсон уу?
- Ийм арга хэрэгслийг ашиглах талаар тодорхой удирдамж байгаа юу?
- Мөрдөншалгахтусгайарга хэрэгслийг ашиглан олж авсан нотлох баримтыг үндэсний шүүх хуралд хүлээн зөвшөөрдөг үү?
- Оролцогч улс мөрдөншалгахтусгайарга хэрэгслийг ашиглахад олон улсын хамтын ажиллагааг дэмжих аливаа хоёр талт хэлэлцээр буюу тохиролцоог байгуулсан уу эсхүл ийм олон талт хэлэлцээр буюу тохиролцоонд нэгдэн орсон уу?

Хөрөнгө буцааж олгох арга хэмжээ

(V бүлэг, 51-ээс 59 дүгээр зүйл)

51 дүгээр зүйл: Ерөнхий тойм

Энэ бүлгийн дагуу хөрөнгө буцааж олгох нь энэхүү конвенцийн тулгуур зарчим мөн бөгөөд энэ талаар оролцогч улсууд аль болох өргөн хүрээнд хамтран ажиллаж, туслалцаа үзүүлнэ.

Тулгуур зарчмын нэг болохын хувьд хөрөнгө буцааж олгох арга хэмжээ

Авлигаас олсон орлогыг энэхүү орлогын эх сурвалж болсон улсад буцааж олгох нь энэхүү конвенцийн гол зорилгуудын нэг юм (1(b) зүйл). 51 дүгээр зүйл цаашлаад авлигаас олсон орлогыг буцааж олгохыг конвенцийн “тулгуур зарчим”-ын нэг гэж заасан байна.

Энэ бүлэгт хамтын ажиллагаа болон туслалцааг хэрхэн хангах, авлигаас олсон орлогыг хүсэлт гаргагч оролцогч улсад хэрхэн буцааж олгох мөн бусад хохирогч болон хууль ёсны эзэмшигчийн эрх ашгийг хэрхэн тооцож үзэх талаар өгүүлж байгаа юм. “Тулгуур зарчим” гэсэн нэр томъёо нь конвенцийн V бүлгийн бусад заалтад эрх зүйн ач холбогдолгүй байгааг тогтоосон конвенцийн тайлбар тэмдэглэлийг (A/58/422/Add.1, 48 дахь хэсэг) үл харгалзан 51 дүгээр зүйлд хөрөнгө буцааж олгохтой холбоотой заалтыг тайлбарлах тал дээр ямар нэг эргэлзээ гарсан тохиолдолд конвенцийн олон улсын хамтын ажиллагааны гол зорилгын хувиар хөрөнгө буцааж олгох талаас нь асуудлыг шийдэх учиртай гэсэн санааг илэрхийлж байгаа болно.

Хөрөнгө буцааж олгох тухай V бүлгийг конвенцийн II бүлгээс IV бүлгийн хэд хэдэн заалттай, үүнд ялангуяа мөнгө угаахаас урьдчилан сэргийлэх тухай 14 дүгээр зүйл, олон улсын хамтын ажиллагаа ба хөрөнгө буцааж олгох арга хэмжээний урьдчилсан нөхцөл болгож авлигаас олсон орлогыг дотоодын хэмжээнд битүүмжлэх, хураах дэглэмийг тогтоох тухай 31 дүгээр зүйл, үндэсний эрх бүхий байгууллага хувийн хэвшил хоорондын хамтын ажиллагааны тухай 39 дүгээр зүйл мөн олон улсын хамтын ажиллагаа болон эрх зүйн харилцан туслалцааны тухай 43 болон 46 дугаар зүйлтэй холбогдуулан ойлгох хэрэгтэй. Энэхүү конвенцийн 52 дугаар зүйл өндөрдүнтэйдансныг үйлгээний үр шим хүртэгч нь хэн болохыг тодорхойлох талаар боломжит арга хэмжээ авах, төрийн чухал чиг үүрэг гүйцэтгэж байгаа буюу байсан хувь хүн, тэдний гэр бүлийн гишүүд болон ойр холбоотой түншүүдийн нээх гэсэн буюу эзэмшиж буй данс, эсхүл нэрийн нь өмнөөс нээх гэсэн буюу эзэмшиж буй дансанд хатуу хяналт явуулахыг шаардахад шаардлагатай байж болох арга хэмжээг авахыг оролцогч улсаас хүссэн тул нилээд ач холбогдолтой зүйлд тооцогдоно.

52 дугаар зүйл: Гэмт хэргээс олсон орлогыг шилжүүлэхээс урьдчилан сэргийлэх, шилжүүлгийг илрүүлэх

1. Энэхүү конвенцийн 14 дүгээр зүйлийг үл хөндөн оролцогч улс бүр харьяалалд нь багтах санхүүгийн байгууллагуудаас харилцагчийнхаа биеийн байцаалтыг нягтлах, өндөр дүнтэй дансны гүйлгээний хүлээн авагч нь хэн болохыг тодорхойлох талаар боломжит арга хэмжээ авах, төрийн чухал чиг үүрэг гүйцэтгэж байгаа буюу байсан хувь хүн, тэдний гэр бүлийн гишүүд болон ойр холбоотой түншүүдийн нээхийг хүссэн буюу эзэмшиж буй данс, эсхүл тэдний нэрийн өмнөө нээхийг хүссэн буюу эзэмшиж буй дансанд хатуу хяналт явуулахыг шаардлагатай арга хэмжээг дотоодын хууль тогтоомждоо нийцүүлэн авна. Ийм хатуу хяналт эрх бүхий байгууллагад мэдээлэл хүргэх зорилгоор сэжиг бүхий гүйлгээг илрүүлэхэд үндэслэлтэй зориулагдсан байх бөгөөд ийм шалгалтыг санхүүгийн байгууллагыг хууль ёсны харилцагчтайгаа бизнесийн үйл ажиллагаа явуулахыг саатуулсан буюу хориглсон гэх утгаар тайлбарлаж болохгүй.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан арга хэмжээг хэрэгжүүлэх явдлыг хялбарчлах үүднээс оролцогч улс бүр дотоодын хууль тогтоомждоо нийцүүлэн, мөнгө угаахтай тэмцдэг бүс нутгийн, бүс хоорондын болон олон талт байгууллагуудын санаачлагыг удирдлага болгон:

(a) Харьяалалд нь багтах санхүүгийн байгууллагаас дансанд нь хатуу хяналт явуулах ёстой хувь хүн, хуулийн этгээдийн төрөл, онцгой анхаарал хандуулах данс ба гүйлгээний төрөл, түүнчлэн тэдгээр данстай холбогдуулан данс нээх, эзэмших, бүртгэл хөтлөх талаархи зохих арга хэмжээний талаар сэрэмжлүүлэг заавар гаргаж;

(b) Харьяалалд нь багтах санхүүгийн байгууллагын таньж тогтоосон хувь хүн, хуулийн этгээдээс гадна эдгээр байгууллагаас хатуу хяналт явуулах ёстой тодорхой хувь хүн, хуулийн этгээдийн талаар зохих тохиолдолд оролцогч өөр улсын хүсэлтээр буюу өөрийн санаачлагаар санхүүгийн байгууллагад мэдэгдэнэ.

3. Энэ зүйлийн 2 дахь хэсгийн (a) дэд хэсгийн хүрээнд, энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан хүмүүст хамаарах данс, гүйлгээний зохистой бүртгэлийг санхүүгийн байгууллагууд нь зохих хугацаанд хөтлөж байх явдлыг хангах арга хэмжээг оролцогч улс бүр авч хэрэгжүүлэх бөгөөд энэ бүртгэлд наад зах нь харилцагчийн, мөн боломжтой тохиолдолд дансны гүйлгээг хүлээн авагчийн талаарх мэдээллийг агуулбал зохино.

4. Энэ конвенциор тодорхойлсон гэмт үйлдлээс олсон орлогыг шилжүүлэхээс урьдчилан сэргийлэх, шилжүүлгийг илрүүлэх зорилгоор оролцогч улс бүр бодитоор оршдоггүй болон хуулиар зохицуулсан санхүүгийн байгууллагад үл харьяалагдах банк байгуулахаас зохицуулалт, хяналтын байгууллагуудынхаа тусламжтайгаар урьдчилан сэргийлэх талаар үр дүнтэй бөгөөд зохистой арга хэмжээ авна. Түүнчлэн, оролцогч улсууд санхүүгийн байгууллагуудаасаа ийм байгууллагуудтай банкны корреспондент харилцаа тогтоох буюу тийм харилцаагаа үргэлжлүүлэхээс татгалзах, түүнчлэн бодитоор оршдоггүй болон хуулиар зохицуулалт бүхий санхүүгийн байгууллагад үл харьяалагдах банк дансыг нь хэрэглэхийг зөвшөөрч буй гадаадын санхүүгийн байгууллагуудтай харилцаа тогтоохын эсрэг хамгаалалт бий болгохыг шаардах талаар авч үзнэ.

5. Оролцогч улс бүр дотоодын хууль тогтоомжийнхоо дагуу төрийн зохих албан тушаалтнуудын санхүүгийн байдалтай холбогдсон мэдээллийг нээлттэй болгох үр дүнтэй тогтолцоо бий болгох асуудлыг авч үзэх бөгөөд үл биелүүлэх тохиолдолд оногдуулах зохих хариуцлагыг тогтооно. Түүнчлэн энэ конвенциор тодорхойлсон гэмт үйлдлээс олсон орлогыг мөрдөн шалгах, шаардах, буцааж олгох шаардлагатай тохиолдолд дээрх мэдээллийг оролцогч бусад улсын эрх бүхий байгууллагуудтай хуваалцахыг зөвшөөрөх талаар шаардлагатай арга хэмжээг авахыг оролцогч улс бүр бодолцоно.

6. Гадаад улсад санхүүгийн данс эзэмшдэг, гарын үсэг зурах эрхтэй буюу өөр эрх эдэлдэг төрийн зохих албан тушаалтнаас энэ тухайгаа эрх бүхий зохих байгууллагад мэдээлэх ба уг данстай холбоотой зохих бүртгэл хөтлөж байхыг шаардахад чиглэгдсэн дотоодын хууль тогтоомжийнх нь дагуу шаардлагатай арга хэмжээг авахыг оролцогч улс бүр авч үзнэ. Үл биелүүлэх тохиолдолд оногдуулбал зохих хариуцлагыг эдгээр арга хэмжээнд мөн заана.

I. Ерөнхий тойм

14 дүгээр зүйлд мөнгө угаахаас урьдчилан сэргийлэх тогтолцооны үйл ажиллагааны үндсэн зарчмыг тогтоосон бол 52 дугаар зүйлд санхүүгийн байгууллагууд харилцагчийнхаа биеийн байцаалтыг нягталж байх, өндөр дүнтэй дансны гүйлгээний үр шим хүртэгч нь хэн болохыг тодорхойлох талаар боломжит арга хэмжээ авах, улс төрд танигдсан хүний (PEP буюу 1(b) дэд хэсэгт тодорхойлсноор төрийн чухал чиг үүрэг гүйцэтгэж байгаа буюу байсан хувь хүн, тэдний гэр бүлийн гишүүд болон ойр холбоотой түншүүд) нээх гэсэн буюу эзэмшиж буй данс, эсхүл нэрийн нь өмнөөс нээх гэсэн буюу эзэмшиж буй дансанд хатуу хяналттай шаардлага тавихыг оролцогч улсуудаас хүссэн байна. Энэ шаардлагыг хэрэгжүүлэх тал дээр оролцогч улсууд эдгээр үүргийг хэрхэн биелүүлэх тухай санхүүгийн байгууллагууддаа зориулсан заавар гаргах хэрэгтэй. Заавар нь албан байх бөгөөд чиглэл болохын хувьд заавал биелүүлэх шаардлага тавигдана. Хэдийгээр хэрхэн хэрэгжүүлэх талаар нарийн дэлгэрэнгүй зүйлийг зааврыг хүлээн авч буй байгууллагад даалгаж болох ч банкны буюу санхүүгийн үйлчилгээг зохицуулагч, сангийн яам, СМН эсхүл энэ асуудлыг хариуцсан бусад байгууллага зааврыг хариуцан гаргаж болно. Үүнээс гадна 52 дугаар зүйл хууль бус аргаар олсон хөрөнгийг шилжүүлэх, чиглэлийг нь өөрчлөх буюу хувиргах явдалд ашиглахыг үл дэмжин хуурамч банкттай корреспондент харилцаа тогтоохоос зайлсхийхийг зөвлөсөн байгаа.

Оролцогч улсууд ийм зааврыг гаргах асуудлыг аль эрх бүхий байгууллага хариуцахыг юун түрүүнд шийдэхийг хүсч байж болно. Мөнгө угаах арга байнга хөгжиж, өөрчлөгдөж байдгийг харгалзан үзэж, сэжигтэй гүйлгээний талаар мэдэгдэлд тулгуурлан тогтоосон мөнгө угаах арга зам болон “хаалгач”-ийн мэргэжлийн санал бодолд түшиглэн зааврыг гаргах хэрэгтэй. Эдгээрийг харгалзан мөн энэхүү конвенцийн зөвлөгөөг тусган, СМН буюу мөнгө угаахаас урьдчилан сэргийлэх асуудлыг хариуцсан байгууллагын зүгээс 1 дэх хэсгийн заавал биелүүлэх гурван шаардлага, 2(b) болон 3 дугаар хэсгийн шаардлагад холбоотой асуудлуудыг шийдэх зааврыг гаргаж болох юм. СМН-ийн бүтэц, үүргийг 58 дугаар зүйлд өгүүлсэн.

Энэхүү зүйлд өөрийн харилцагчийнхаа, үүнд ялангуяа төрийн чухал чиг үүрэг гүйцэтгэж буй хүмүүс болон тэдэнд хамаатай хүмүүсийн байдлыг харгалзан илүү өндөр түвшний хяналт тавихыг, мөн 8 дугаар зүйлийн шаардлагыг биелүүлэн гадаадын дансны эзэмшигчийг оролцуулан төрийн зохих албан тушаалтны санхүүгийн байдлын мэдээллийг нээх тогтолцоог бий болгохыг санхүүгийн байгууллагуудаас хүссэн байна. 52 дугаар зүйл авлигаас олсон орлогыг эх сурвалж болсон тухайн оролцогч улсаас гарахаас урьдчилан сэргийлэх бөгөөд үгүйдээ л холбогдох шилжүүлгийн тухайд эрх бүхий байгууллагад сэрэмжлүүлэг өгнө. Авлигаас олсон орлогын эх сурвалж болсон оролцогч улсын байгууллага орлогыг шилжүүлэх явдлаас урьдчилан сэргийлж чадаагүй тохиолдолд хүлээн авч буй оролцогч улс үүнээс татгалзах эсхүл энэ талаар мэдээлэх боломжтой болох юм.

II. Бодит бэрхшээл ба шийдэл

II.1. Харилцагчийн хэн болохыг нягтлан шалгах

Холбогдох байгууллагад тавих эхний шаардлага нь өөрийн харилцагчдын хэн болохыг нягталж байх явдал бөгөөд энэ нь ердийн нэг албан биеийн байцаалтын зарчмаас ч илүү чухлаар тавигдаж байгаа юм. “Харилцагчаа таньж байх” зарчим нилээд албан байдлаар хэрэгжиж буюу ойлгогдож, ингэснээр харилцагчийн биеийн байцаалтын хуулбар эсхүл хэн болохыг тодорхойлох өөр бусад бичиг баримтыг олж авахад хязгаарлагдмал байдал үүсэх нь бишгүй тохиолддог. Санхүүгийн байгууллага харилцагч хоорондын харилцааг тогтооход хуурамч бичиг баримт ашиглах явдлаас сэргийлэхийн тулд 1 дэх хэсэг санхүүгийн байгууллагаас өөрийн харилцагчийн хэн болохыг “тогтоох” төдийгүй хэн болохыг “нягтлан шалгаж байх”-ыг хүссэн байна. Өөр өөр харилцагчид зориулан хэн болохыг нь нягтлан шалгаж байх өөр өөр журам нэвтрүүлэх шаардлага үүснэ.

Хувь хүнтэй “нүүр тулсан” харилцаа үүсгэж байгаа үед, гэрэл зураг бүхий (паспорт, иргэний үнэмлэх, жолооны үнэмлэх буюу эдгээртэй төстэй бусад баримт бичиг зэрэг) албан ёсны нэг эсхүл хоёр биеийн байцаалтын хуулбарыг авч, шалгаж байх нь тухайн байгууллагын зүгээс баримт бичгийн үнэн зөвийг батлах боломжит арга хэмжээг авахад хангалттай байх болно. Хувь хүнтэй нүүр тулан харилцаагүй тохиолдолд (эчнээ харилцаагаар, захидлаар буюу интернетээр), санхүүгийн байгууллага албан ёсны биеийн байцаалтын нотариатаар баталгаажсан буюу өөр бусад санхүүгийн байгууллагын зүгээс баталгаажуулсан хуулбарыг олж авах мөн байгууллага, баталгаа гаргах компани доторх, гуравдагч этгээдийн эсхүл тусгай арга хэрэгсэл ашиглан ихэнхдээ шуудан солилцох замаар заасан хаягийг баталснаар боломжит данс эзэмшигчийн хэн болохыг тогтоож болох юм.

Дотоодын болон гадаадад төвтэй хууль ёсны байгууллагатай харилцаж байгаа тохиолдолд, санхүүгийн байгууллагын зүгээс аж ахуйн нэгж, байгууллагуудын бүртгэл дэх компани буюу байгууллагын бичиг баримтын хамгийн сүүлд шинэчилсэн хуулбарыг олж авах эсхүл хэрэв тэдгээр нь албан ёсны хэвлэл буюу веб хуудас дахь аливаа жагсаалтанд багтсан бол улсын бүртгэл, тогтмол албан хэвлэл, тогтмол хэвлэл эсхүл сонингоос компани буюу байгууллагын мэдээллийн хуулбарыг олж авах, шалгах замаар тэдгээрийн “хэн болох”-ыг батлах шаардлагатай.

Эдгээр ажиллагаа нь нилээд цаг хугацаа шаардаж болох тул бизнесийн харилцаагаа таслахгүй байх үүднээс оролцогч улс санхүүгийн байгууллагад тухайн ажиллагаа бүрэн дуусах хүртэл түр данс нээхийг зөвшөөрөх эсэхээ тооцож үзнэ. Гэхдээ шаардлагатай бүх бичиг баримт бүрдүүлэх, баталгаа гаргах явц дууссны дараа л тодорхой босгоос дээгүүр дүнтэй буюу томоохон хэмжээний гүйлгээ хийх, гадаад улсруу шилжүүлэг хийх, гадаад улсаас шилжүүлэг хүлээн авахыг зөвшөөрнө. Үүнээс гадна хэрэв бичиг баримт бүрдүүлэх ажиллагаа тохирсон эцсийн хугацаанаас өмнө дуусахгүй бол харилцааг дуусгавар болгохыг журамд зааж өгч болох юм.

II.2. Өндөр дүнтэй данс эзэмшигчдийн хэн болохыг тогтоох

Хоёр дахь шаардлага өндөр дүнтэй дансны гүйлгээний үр шим хүртэгч нь хэн болохыг тодорхойлох талаар боломжит арга хэмжээ авах нь авлигач хувь этгээдийн өмнөөс гэмт хэргээс олсон орлогыг эзэмшигч гуравдагч этгээдийг ашиглах явдалд саад хийхийг зорьж байгаа юм.

Үүнд дансийг эзэмшигч нь өөрөө жинхэнэ эзэн нь мөн эсэх тал дээр аливаа эргэлзээ байгаа тохиолдолд хэрэглэж болох тусгай журам тогтоох шаардлага үүсч байна. Ийм журам нь дөрвөн гол хэсгээс бүрдэнэ.

Юун түрүүнд, “жинхэнэ эзэн”-ийг тогтоохын тулд оролцогч улс жинхэнэ эзэн нь байж таарахгүй компанийн байгууламж эсхүл хууль ёсны байгууллагыг хүлээн зөвшөөрөхийг санхүүгийн байгууллагад хориглох асуудлыг бодолцож үзэх хэрэгтэй.

Хоёрдугаарт, санхүүгийн ямар төрлийн бүтээгдэхүүнийг “өндөр дүнтэй данс” гэж тооцохыг тодорхойлох шаардлагатай (2(a) хэсэг). Энд *de minimis* хэмжээний талаар өгүүлсэн хэдий ч энэ асуудлаар зохицуулалт хийж буй оролцогч улсууд эдгээр шаардлагыг банкны данс төдийгүй, жишээ нь, үнэт цаасны данс, гуравдагч этгээдийн байгуулсан хөрөнгийн талаар удирдлагын хэлэлцээр, валют буюу үнэт металын гүйлгээ ба эрсдэл бүхий бусад гүйлгээнд ч хэрэгжүүлэх боломжийг тооцож үзнэ. Үүнд санхүүгийн бүтээгдэхүүн, офшор байгууламж, үзэмжийн итгэмжлэлийн компани, мэргэжлийн этгээд гэсэн дөрвөн зүйлд тусгайлан анхаарал хандуулах хэрэгтэй.

Тэгэхлээр дундын данс, үнэт цаасны дундын данс, хөрөнгө оруулагч компанийн болон бусад хамтын хөрөнгө оруулалт зэрэг шинж байдлаас нь харахад тухайн харилцагч болон жинхэнэ эзэн нь нэг этгээд биш байх тэдгээр санхүүгийн бүтээгдэхүүнд анхаарал хандуулна гэсэн үг. Энэ тохиолдлуудад харилцагчаас шаардах бүх мэдээллийн хамтаар хувь хүртэгч жинхэнэ эздийн бүрэн жагсаалтыг тогтмол шинэчлэх байдлаар санхүүгийн байгууллагад өгч байхыг ийм бүтээгдэхүүний эзэмшигчээс шаардаж болно. Хөрөнгийн биржээр арилжаа явуулж буй компанийг хэд хэдэн оронд тусад нь авч үздэг.

Офшор компани гэж бүртгэл бүхий албан байр нь байрлах тэр оролцогч улсад ямар нэг арилжааны үйл ажиллагаа явуулдаггүй, эсхүл өөрийн байгууламж буюу боловсон хүчингүй, эсхүл өөрийн боловсон хүчинтэй ч тэдгээр нь зөвхөн захиргааны ажил хэрэг эрхэлдэг тэдгээр байгууллага, компани, сан, итгэмжлэлийн компани эсхүл бусад байгууламжийг хэлнэ. Эдгээр компанийн эзэмших эд хөрөнгийн хувьд, оролцогч улс тэдгээрийн хэн болохыг тодорхойлж баталсан компанийн бичиг баримтын баталгаажуулсан хуулбараас гадна тухайн эд хөрөнгийн жинхэнэ эзэн эсхүл эздийг тодорхойлсон мэдэгдлийг бичгэн хэлбэрээр шаардахыг санхүүгийн байгууллагадаа үүрэг болгох хэрэгтэй. Гэсэн ч оролцогч улс компанийг бусад компанийн эд хөрөнгө, байгууламжийн жинхэнэ эзнээр хүлээн зөвшөөрөхийг санхүүгийн байгууллагадаа хориглож болно.

Тодорхой жинхэнэ эзэнгүй (итгэмжлэлийн компани зэрэг) эд хөрөнгийг эзэмшиж буй харилцагчийн хувьд, санхүүгийн байгууллага нь тухайн эд хөрөнгийг хяналтандаа байлгаж буй этгээдийн талаар (жинхэнэ суурьшигч, данс эзэмшигчид заавар өгөх эрх бүхий бүх этгээд буюу ийм эрх бүхий бусад төлөөлөгч болон хувь хүртэгч, асран хамгаалагч, хамгаалагч болох магадлалтай этгээдүүд г. м.) мэдээлэл агуулсан мэдэгдэл бичиж өгөхийг харилцагчаасаа шаардаж болно.

Оролцогч улс холбогдох зааврыг гаргахдаа, итгэмжлэгдсэн этгээд эсхүл нотариат зэрэг мэргэжлийн нууцлалаар хязгаарлагдсан харилцагчаас эзэмшиж буй дансныхаа жинхэнэ эзнийг задруулахыг шаардах нөхцлийг тодорхой заах хэрэгтэй. Түгээмэл тохиолддог шийдэх шаардлагатай асуудлууд дараах болно: хууль ёсны зардлын тухайд урьчилгаа, маргалдагч талуудын төлөх эсхүл тэдэнд төлөх төлбөр, хараахан шийдэгдээгүй өв тараах асуудал, гэрээслэлийн гүйцэтгэл, гэрлэлт цуцлуулахтай холбоотой хараахан шийдэгдээгүй эд хөрөнгө хуваах асуудал.

Гуравдугаарт, санхүүгийн байгууллагууд жинхэнэ эзний асуудлаар тавих шаардлагыг хэрэгжүүлэхэд үзэмжээрээ шийдэх эрхээ ашиглах хамгийн боломжит байрлалд байж болох ч оролцогч улсууд журмыг хэрэгжүүлэхийг шаардах нөхцөл байдал, тохиолдол, жишээний жагсаалтыг санхүүгийн байгууллагадаа гаргаж өгч болох юм. Харилцагч болон жинхэнэ эзэн нэг хүн эсэх талаар шийдвэр гаргахад санхүүгийн байгууллага хамгийн тохиромжтой байрлалд байгаа ч суурь үзүүлэлт болгон хэрэглэж болохуйц тулгарах магадлалтай нөхцөл байдлын жагсаалт ч хэрэгтэй болж болно. Ийм нөхцөл байдлын жишээ болгож, гүйлгээнд оролцож буй эд хөрөнгө нь тухайн гүйлгээг хийхийг хүсч буй этгээдийн санхүүгийн байдалтай хэмжээний хувьд тохирохгүй байх эсхүл данс эзэмшигчтэй хангалттай ойр холбоогүй этгээдэд итгэмжлэлийн эрх мэдлийг олгох тохиолдол зэргийг дурдаж болох юм.

Дөрөвдүгээрт, баталгааны шалгуурыг хангахгүй тохиолдолд, эд хөрөнгийн жинхэнэ эзэнтэй холбоотой эргэлзээ, үнэмшилгүй байдалд үндэслэн арилжааны харилцааг дуусгавар болгох нөхцөл байдлын талаар оролцогч улсын зүгээс санхүүгийн байгууллагад зөвөлгөө өгч болно. Дараах тохиолдлуудад ийм үндэслэл байна гэж үзэж болох юм:

- Банкны зүгээс данс эзэмшигчийн хэн болохтой холбоотой мэдээллийн үнэн зөвд эргэлзэх шалтгаан байх;
- Жинхэнэ эзний тухай мэдэгдлийн үнэн зөв эсэх нь эргэлзээтэй байх;
- Урьдаар мэдээлээгүй чухал өөрчлөлтүүд илрэх;
- Данс эзэмшигчийн хэн болохыг батлах үед банкыг хууран мэхэлсэн гэж үзэх шалтгаан байх;
- Банканд жинхэнэ эзний талаар санаатайгаар хуурамч мэдээлэл өгсөн байх;
- Журмыг биелүүлэх явцад данс эзэмшигчийн мэдэгдэлтэй холбоотой эргэлзээ газар авсан байх.

II.3. Улс төрд оролцогч этгээдийн (PEP) эзэмших дансанд хатуу хяналт тавих

Дээрх II.1 ба II.2-д дурдсан арга хэмжээнээс гадна төрийн чухал чиг үүрэг гүйцэтгэж байгаа буюу байсан хувь хүн, тэдний гэр бүлийн гишүүд болон ойр холбоотой түншүүдийн (хамтад нь PEP гэж нэрлэдэг) нээх гэсэн буюу эзэмшиж буй данс, эсхүл нэрийн нь өмнөөс нээх

гэсэн буюу эзэмшиж буй данстай холбоотой сэжигтэй гүйлгээг илрүүлэх зорилгоор хатуу хяналт явуулахыг оролцогч улсуудаас хүссэн байгаа. РЕР-ийн тухайд энэ зүйлд заасны дагуу заавар гаргахдаа оролцогч улс хэд хэдэн асуудлыг анхаарч үзвэл зохино.

Юун түрүүнд, РЕР гэсэн нэр томъёог оролцогч улс нарийн тодорхойлох шаардлагатай. 5 ба 6 дугаар хэсгийн шаардлагыг мөн оролцогч улс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч бусад оролцогч улсад хамгийн өргөн хүрээнд дэмжлэг үзүүлнэ гэдгийг тооцон оролцогч улс үүнд дотоодын төдийгүй гадаадын улс төрийн зүтгэлтэн, гэр бүлийн гишүүд, ойр дотны түншийг хамруулж болох юм. Гэр бүлийн гишүүдийг оролцуулах нь ямар нэг асуудал үүсгэхгүй байж болох ч гэр бүл, ураг төрөл болон гэрлэлтийн харилцааг харгалзан шийдвэр гаргаж болно. “Ойр дотны түнш” гэдгийг хэрхэн тогтоохтой холбоотой бэрхшээл үүсч болно. Үүний хариулт нь тухайн улсын “хаалгач”-ийн олж авах боломжтой тэр мэдээллийн түвшнээс ихэнхдээ хамаардаг. Жишээ нь, зохицуулагч байгууллага үл хөдлөх хөрөнгө, байгууламж, компанийн бүртгэлд хялбар нэвтрэх боломжтой байгаа тохиолдолд бүртгэгдсэн эд хөрөнгийг дундаа эзэмшдэг эсхүл түншлэл буюу арилжааны өөр бусад хэлбэрийн холбоо бүхий тэдгээр этгээдийг санхүүгийн байгууллагын зүгээс ойр дотны түнш гэж үзэхийг заавар болгож болох юм. Зарим улсад заавар нь санхүүгийн байгууллагад боломжит “ойр дотно түнш”-ийн талаар мэдээлэл авахаар хэвлэл мэдээллийг байнга шалгаж үзэхийг үүрэг болгох байдлаар “төрийн мэдээлэл”-д хандаж болно.

Хоёрдугаарт, оролцогч улс “хатуу хяналт” гэдэг ойлголтыг нэвтрүүлэх хэрэгтэй. Сүүлийн үед олон улс орон урьдаас тогтоосон ерөнхий шаблонд таарахгүй байгаа сэжигтэй шилжүүлгийг холбогдох эрх бүхий байгууллагад мэдээлж байх үүднээс “харилцагчийн ерөнхий шаблон” үүсгэхийг санхүүгийн байгууллагуудаас шаардах явдал түгээмэл болсон. Харилцагчийн шаблонуыг ийнхүү ашиглахын тулд тухайн санхүүгийн байгууллага нь эд баялгийн эх сурвалж, ашиглагдах магадлалтай санхүүгийн бүтээгдэхүүн, дансанд орох болон данснаас гарах хөрөнгийн хэлбэр ба хэмжээ, тухайн зах зээлийн орчин дахь бизнесийн гүйцэтгэл, үзүүлэлтийг ойлгож байх шаардлагатай. Зарим улс орон РЕР-тэй үүсгэх харилцаандаа дагаж мөрдөх боломжит дараах хамгийн доод шаардлагыг багтаасан арга хэмжээг тогтоохыг санхүүгийн байгууллагуудаасаа хүссэн байна:

- Бусад гадаад өргөдөл гаргагч дундаас РЕР-ийг таньж тогтоох өргөдөл гаргах жишиг үйл явц;
- Харилцагч эсхүл жинхэнэ эзэн РЕР тохиолдолд тухайн данс нээх үнэмшихүйц шалтгаан болон хяналт тавьж болохуйц орлогын эх үүсвэрийг шалгах. Жишээ нь өөр улсад байрлах арилжааны пүүсээс эсхүл төрийн байгууллагаас орж ирэх нийт мөнгөн дүнгийн баримтыг хянах замаар эд баялгийн эх үүсвэрийг тогтоох;
- Энэ шалгалтаар ямар нэг асуудал үүсэлгүй, харилцаа тогтоосон тохиолдолд банк аливаа тохиолдолд тэрхүү харилцагч болон тэдгээрийн гүйлгээнд зохих шаардлага тогтмол тавих журмыг бий болгох;
- Хяналтын явцад ямар нэг асуудал гарсан тохиолдолд эрх бүхий байгууллагад даруй мэдэгдэх;

- РЕР-тэй үүсгэх харилцагчийн бүх харьцааг санхүүгийн байгууллагын дээд удирдлагаас тогтмол нягтлан шалгах;
- Одоогийн байгаа данс болон банктай харилцаа тогтоосны дараа хуучин харилцагчийн РЕР болох магадлалыг тогтмол нягтлан шалгах.

II.4. Дотоодын санхүүгийн байгууллагад хатуу хяналт тавих

РЕР-ийг таньж тогтооход гарах бэрхшээлийг харгалзан, ялангуяа энэ ойлголт нь тэдний гэр бүл болон ойр дотны түншийг хамардаг учир 52 дугаар зүйл тодорхой харилцагчид илүү хатуу хяналт тавих шаардлагыг санхүүгийн байгууллагад нь тавиулахаар оролцогч улсын зүгээс РЕР-ийн хэн болохыг өөр бусад оролцогч улсад мэдээлэх тухай шинэлэг заалтыг багтаасан болно. Энэ заалтыг хэрэгжүүлэхэд оролцогч улсууд ийм хамтын ажиллагаа, туслалцаа нь мэдээллийн үнэн зөв байдал, нууцлал, ашиглах боломж зэрэг (дараагийн II.8 зүйлийг харна уу) зохих хамгаалалтыг хариуцах гадаадын эрх бүхий хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагад дамжуулахаар холбогдох мэдээллийг цуглуулах зорилгоор тогтмол журам хэрэг болох эсэхийг олж мэдэж болох юм. Авлигаас олсон орлогыг өөр тийш нь чиглүүлэх ажиллагаа тогтмол явагддаг байж болох тэдгээр улсуудын хувьд энэ нь чухал арга хэрэгсэл болох учиртай. 56 дугаар зүйл оролцогч улсуудын асуудал үүсч болзошгүй үед РЕР-ийн тухайд өөр бусад оролцогч улсад сэрэмжлүүлэг өгөхөд бэлэн байх явдлыг дэмжиж өгсөн байна.

II.5. Бүртгэл хөтлөх

52 (3) хэсэгт өндөр эрсдэл бүхий харилцагчид болон РЕР-ийн тухайд тусгай бүртгэл хөтөлж байх үүргийг заах зааврыг 2(а) дэд хэсгийн хүрээнд бий болгохыг хүссэн байна. 14 (1) заалт нь оролцогч улсаас ерөнхий бүртгэл хөтлөх явдлыг санхүүгийн байгууллагууддаа үүрэг болгохыг шаардаж байгаа бол 52 (3) РЕР-үүдийн хувьд нэмэлт буюу илүү хатуу бодлого баримтлахыг хүссэн байна.

Энэ заалтыг хэрэгжүүлэхэд оролцогч улс тодорхой тооны шалтгаанаар бүртгэлийг хадгалах бодит цаг хугацааны хязгаарыг тогтоохын тулд хувьсагч өөр бусад хүчин зүйлийг анхаарч үзэх шаардлагатай. Үүнд: гэмт хэрэг болон аливаа мөрдөн байцаах ажиллагаа эхлүүлэхийн хоорондын саатал, (үүнтэй холбоотойгоор дархан эрх эдэлж байх эсхүл мөрдөн байцаах ажиллагаанд нөлөө үзүүлж чадах) эрх мэдэл хэрэгжүүлж байсан эсхүл албан тушаалаа хашсаар байгаа албан тушаалтны орлогыг мөрдөн шалгахад гарах хүндрэл, олон улсын хэмжээнд эд хөрөнгөтэй холбоотой хэргийг мөрдөх журмын нарийн төвөгтэй байдал болон энэхүү конвенцийн дагуу тогтоосон гэмт хэрэгт хязгаарлалт тавих тухай 29 дүгээр зүйлийг хэрэгжүүлэхэд хүчин төгөлдөр болсон бодлогын шийдвэр орж болно. Олон улс орон гүйлгээ эхэлснээс хойш таван жил гэх мэт бүртгэл хадгалах тодорхой цаг хугацааны хязгаарыг тогтоохыг зохицуулагч байгууллагаасаа хүсдэг. Олон тохиолдолд бүх баримт бичгийн эх хувийг хадгалж байж болно. Оролцогч улсууд РЕР-д хатуу хяналт тавих асуудлын хүрээнд тухайн РЕР албан тушаалаас халагдах үед л хөрөнгө буцаан олгох арга хэмжээ эхэлж болох тохиолдлууд байж

болохыг харгалзан бүртгэлийг илүү удаан хугацаагаар хадгалах асуудлыг тооцож үзэж болох юм.

II.6. Санхүүгийн байгууллагад үл харьяалагдах банк байгуулах корреспондент харилцаа тогтоох явдлаас урьдчилан сэргийлэх

Олон улсын санхүүгийн тогтолцоонд эд хөрөнгө нуухад хамгийн ихээр хэрэглэгддэг санхүүгийн байгууллага бол “Санхүүгийн байгууллагад үл харьяалагдах банк” гэж нэрлэгддэг зүйл юм. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн тодорхойлолтоор бол дээрх банк нь “*бүртгэгдсэн болон зөвшөөрөл авсан тухайн улсдаа бодитоор оршдоггүй (өөрөөр хэлбэл оюуны хөрөнгө ба удирдлагын хувьд) мөн үр дүнтэй нэгдмэл хяналттай санхүүгийн үйлчилгээний бүлэгт харьяалагддаггүй банк*” юм (Бээлийн Комисс 2003; мөн Корреспондент банкны тухай Wolfsberg AML зарчмыг харна уу).

Санхүүгийн байгууллагад үл харьяалагдах банк гэмт үйлдлээс олсон орлогыг тухайн улсаас гадагш гаргахад, үүнд ялангуяа авлигын томоохон төлөвлөгөөнд хэрэглэсээр ирсэн. Иймээс 4 дэх хэсэгт оролцогч улсаас өөрийн тогтолцоондоо санхүүгийн байгууллагад үл харьяалагдах банк байгуулах явдлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авахыг хүссэн юм.

Санхүүгийн байгууллагын хувьд бодитоор оршихгүй байх гэдэг нь ердөө албан байргүй байна гэсэн үг биш. Санхүүгийн байгууллагад үл харьяалагдах банк нь ихэнхдээ бүртгэл бүхий улсдаа хуулиар шаардсны дагуу тодорхой хаягтай байх үүднээс орон нутгийн төлөөлөгч эсхүл маш доод түвшний боловсон хүчний хариуцах албан байр байлгадаг. Санхүүгийн байгууллагын хувьд бодитоор орших гэж зохицуулагч байгууллагын хяналтаа тавьж болох “оюуны хөрөнгө болон удирдлага” бүхий газрыг ихэнхдээ ойлгоно. Санхүүгийн байгууллагад үл харьяалагдах банкны тухайд оюуны хөрөнгө болон удирдлага нь өөр улсад холбоо бүхий байгууллагын албан байранд эсхүл бүр хувийн орон байранд ч байрлаж болдог. Удирдлага нь ийнхүү өөр улсад байх нь тухайн бүртгэл бүхий улсын зохицуулагч байгууллагын зүгээс зохих хяналтыг тавих боломж олгохгүй гэсэн үг.

Санхүүгийн байгууллагад үл харьяалагдах банкны тодорхойлолтонд байх өөр нэг зүйл нь хяналт бүхий санхүүгийн үйлчилгээний бүлэгт харьяалагдахгүй юм.

Харилцагчид санхүүгийн байгууллагад үл харьяалагдах банкыг юун түрүүнд нэр нууцлах байдал, хөрөнгийн эх үүсвэрийг зүс хувиргах болон эдгээрийг бусад санхүүгийн байгууллага руу илгээх зорилгоор ашигладаг. Өөрөөр хэлбэл, санхүүгийн байгууллагад үл харьяалагдах банкинд мөнгө барагтай л бол хадгалагдаж үлддэггүй. Иймээс оролцогч улс цаашлаад санхүүгийн байгууллагад үл харьяалагдах банктай корреспондент банкны харилцаа тогтоохыг өөрийн санхүүгийн байгууллагууддаа хориглох арга хэмжээг авах хэрэгтэй.

Корреспондент банкны харилцаа гэдэг нь нэг банкнаас нөгөөд үзүүлэх үйлчилгээг хэлнэ. Энэ нь банкны салбарт чухалд тооцогддог бөгөөд нэг улсад орших банкинд банк бодитоор оршдоггүй өөр улсад үйл ажиллагаа явуулах мөн энэ улс дахь харилцагчиддаа үйлчилгээ үзүүлэх боломж олгодог юм. Корреспондент данс нээснээр гадаад банк буюу респондент нь

корреспондент улсад зөвшөөрөл авах буюу бодитоор оршихтой холбоотой зардал гаргалгүйгээр корреспондент банкны санал болгох үйлчилгээний ихэнхийг эсхүл бүгдийг авч болно. Өнөөдөр дэлхийн санхүүгийн гол төвд байрлах олон улсын томоохон банк бусад мянга мянган банканд корреспондент болж үйлчилгээ үзүүлж байна.

Корреспондент банк гадаад банкын харилцагч нь бусад гадаадын банкинд тэдний дансыг ашиглахыг хэр хэмжээгээр зөвшөөрөхийг тогтмол асуух эсхүл корреспондент дансаар урсах эд хөрөнгийн эзний хэн болохыг (дээр II.1. ба II.2-ийг харна уу) асуух эрх мэдэлгүй байдаг тул гарцаагүй эрсдэл дагуулдаг. Тэдний харилцагч нь мөн банк байж болох учир мөнгө угаахтай тэмцэх журмыг гадаад харилцагчаар мөрдүүлэх нь зардал өндөртэй мөн ихэнхдээ боломжгүй байдаг гэсэн цаад шалтгаанаар корреспондент банк энэхүү журмыг өөрийн мөрдөж буй байдал дээрээ түшиглэхээс өөр аргагүй болдог. Үүнээс гадна корреспондент дансыг эзэмшигч нь гадаад банк учир энэ дансаар урсаж буй хөрөнгө гадаад банкны олон тооны харилцагчид харъяалагдаж болох юм.

Оролцогч улсууд авч хэрэгжүүлэхийг зөвлөж буй арга хэмжээнүүдийн тухайд дараах зүйлийг анхаарч үзнэ:

- Респондент банкны удирдлага, санхүү, бизнесийн ажиллагаа, нэр хүнд, зохицуулалтын орчин, үйл ажиллагааны журамд эрсдлийн үнэлгээ явуулах буюу зохих хяналт тавихыг санхүүгийн байгууллагуудаасаа хүсэх;
- Зохих хяналтын үр дүнд санхүүгийн байгууллагад үл харъяалагдах банк нь тэдэнд нэвтрэх тал дээр эргэлзээ үүссэн тохиолдолд гадаад банктэй корреспондент харилцаа тогтоохыг санхүүгийн байгууллагууддаа хориглох;
- Респондент банкны мөнгө угаахтай тэмцэх дүрэм журам, бодлогын хуулбарыг олж авч, хадгалж байхыг санхүүгийн байгууллагуудаасаа хүсэх;
- Зөвшөөрөл олгогч эрх бүхий байгууллагад бүх корреспондент харилцаагаа мэдээлж байхыг санхүүгийн байгууллагуудаасаа хүсэх;
- Тодорхой байгууллага буюу тохиолдлыг шалгах тал дээр санхүүгийн байгууллагууддаа тусламж үзүүлэх зорилгоор гадаадын хянагч байгууллага болон СМН-тэй мэдээлэл солилцох суваг нээх.

II.7. Төрийн зохих албан тушаалтны санхүүгийн мэдээллийг нээлттэй болгох тогтолцоо

5 ба 6 дахь хэсэгт гадаад данс эзэмшигчийг оролцуулан төрийн зохих албан тушаалтны санхүүгийн мэдээллийг нээлттэй болгох тогтолцоог бий болгохыг оролцогч улсаас хүссэн байна. Энэ тухай 8 дугаар зүйлд мөн авч хэлэлцэнэ.

Энэхүү зөвлөгөөг хэрэгжүүлэхийг хүсч буй оролцогч улсууд 8 дугаар зүйлд тулгарсан асуудлуудыг санаж байх хэрэгтэй. Үүнд, юун түрүүнд мэдээлэл задруулах болон батлах (мөн

зөрчлийг мөрдөн байцааж, хариуцлага ногдуулах) тогтолцоог эрх бүхий аль байгууллага хариуцаж удирдахыг тогтоох шаардлага үүснэ. Оролцогч зарим улс энэхүү конвенцийн 6 ба 36 дугаар зүйлд дурдсан байгууллагуудад хандаж байхад, заримынх нь хувьд тэрхүү тогтолцоог татварын байгууллага эсхүл (хууль тогтоох байгууллага дахь нэг хороо зэрэг) тусгай байгууллага хариуцан удирдаж байна. Эдгээрийн зарим нь хууль ёсны эрх мэдэлтэй бол зарим нь зөвөлгөө өгөх түвшний үйл ажиллагаа явуулдаг. Эдгээр арга барил, төрийн албан тушаалтны оролцоо, задруулах мэдээлэл, батлах болон бусад журам, ногдуулах шийтгэл нь их өргөн хүрээнд хэлбэлзэж байгааг анхаарч үзэн оролцогч улс холбогдох мэдээлэлд үр дүнтэй нэвтрэх институцийн ерөнхий арга барил, батлах тууштай зарчим болон журмыг үр дүнтэйгээр мөрдүүлэх арга замыг тооцож үзэх шаардлагатай байна.

Хоёрдугаарт, “төрийн зохих албан тушаалтан” гэх ойлголтонд хэнийг хамруулах талаар бодож үзэхдээ оролцогч улс “зэрэг дэвээр” нь төдийгүй “эмзэг талбар” эсхүл “эрсдэл бүхий байдал”-ын дагуу сонголт хийж болно (7 дугаар зүйлийг харна уу). Ийнхүү оролцогч ихэнх улс үүнд сонгогдсон албан тушаалтан, (сайд, төрийн нарийн бичгийн дарга, төрийн хоёрдугаар нарийн бичгийн дарга зэрэг) улс төрийн томилгоо бүхий албан тушаалтан, төрийн дээд албан тушаалтан, шүүхийн шүүгчид, мөн заримдаа цэргийн дээд зэрэг цолтныг хамруулдаг. Оролцогч улс төрийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдаж авах газрын тэргүүн, төрийн өмчийн аж ахуйн нэгж түүнчлэн зэвсгийн үйлдвэрлэл, санхүүгийн үйлчилгээ зэрэг эмзэг салбарын удирдлага гэх мэт төрийн нэр дээр худалдан авч, зарцуулах эрх бүхий аливаа албан тушаалтныг хамруулах боломжийг авч үзэж болох юм. Үүнээс гадна оролцогч олон улс гэр бүлийн гишүүдээ авлигаас олсон орлогын эзэмшигч эсхүл “нуун дарагдуулагч” болгон ашиглахаас сэргийлэх зорилгоор төрийн албан тушаалтнаас гэр бүлийнхээ хөрөнгө, орлогыг мэдүүлэхийг шаардаж байж болно.

Гуравдугаарт, оролцогч улсууд хөрөнгө, орлогын мэдүүлэгт ямар мэдээллийг (мөн хэр дэлгэрэнгүй байдлаар) шаардах, ийм мэдээллийг ямар хугацаагаар өргөн барьж байх асуудлыг анхаарч үзэж болно. Энэхүү мэдээлэл задруулах тогтолцоо нь аль болох өргөн хүрээний мэдээллийг нээлттэй байлгахад гадна хүсэлт гаргаагүй тохиолдолд ч мэдээллийг задруулахыг зөвшөөрч байх учиртай (ашиг сонирхлын илэрхий зөрчил үүссэн мөн мэдээллийг нээлттэй байлгах шаардлага амжилтгүй болсноор үүнийг таньж тогтоох хэрэгцээ үгүй болсон гэж шаардаж байгаа тохиолдолд төрийн албан тушаалтанд ашиг сонирхол илэрхийлэх боломж олгохгүй).

Дөрөвдүгээрт, энэхүү конвенцийн дагуу тогтоосон гэмт хэргээс олсон орлогыг таньж тогтоох, мөрдөн байцаах, хязгаарлах, шаардах, буцаан олгох явдлыг хөнгөвчлөх зорилгоор мэдээлэл задруулах тогтолцоогоор дамжуулан олж авсан мэдээллийг оролцогч бусад улсын эрх бүхий байгууллагатай хуваалцахыг өөрийн эрх бүхий байгууллагадаа зөвшөөрөхөд шаардлагатай байж болох арга хэмжээг авахыг оролцогч улсаас хүссэн байгаа.

Эмзэг мэдээллийг гадаадын эрх бүхий байгууллагатай хуваалцах нь олон улсын хууль, гадаад бодлого зэргийг ерөнхийд нь харгалзан үзэхээс хамаарч болох ч СМН-үүд хоорондын тогтолцоо зэрэг мэдээллийг дэлхийн хэмжээнд солилцох тогтолцоо нь шуурхай бөгөөд үр дүнтэй болох нь батлагдсан юм. Шаардлагатай үед мэдээллийн нууцлалыг хадгалах зөв дүрэм болон

зөрчил гаргасан үед хариуцлага тооцох асуудлын хооронд тэнцвэрийг хадгалах нь маш чухал. Авлигатай тэмцэх байгууллагууд (эсхүл СМН-үүд буюу 6 ба 36 дугаар зүйлийн дагуу байгуулагдсан байгууллагууд) хооронд мэдээлэл солилцох талаар хоёр талт гэрээ эсхүл харилцан ойлголцлын санамж бичиг нь хувийн нууцтай холбоотой хууль тогтоомж буюу хэрэв банк, татварын мэдээллийг мөн задруулах бол банкны нууцлал ба татварын нууцлалын тухай хууль тогтоомжид нийцэж байвал зохино. Ийм гэрээг боловсруулахдаа мэдээлэл солилцох явдлыг нилээд сайжруулах арга хэмжээ болох мэдээллийг хүсэлтийн дагуу төдийгүй сайн дураар шилжүүлэх (56 дугаар зүйлийг харна уу) албан сувгийг багтаахыг зөвлөж байна. Оролцогч улсууд дотоодын олон тооны байгууллага оролцсон тохиолдолд хэрхэн өөр хооронд нь уялдуулах асуудлыг анхаарч үзэх хэрэгтэй.

II.8. Төрийн албан тушаалтан ба гадаад улс дахь данс

Цаашид тодорхой заасан мэдээлэл задруулах санал нь юун түүрүүнд төрийн албан тушаалтан гадаадын дансанд хувийн эзэмшилтэй байх тохиолдлыг, хоёрдугаарт, төрийн албан тушаалтан өөр оролцогч улс дахь төрийн өмчийн аж ахуйн нэгжийн гадаад данс, арилжаа буюу арилжааны данс, элчин сайдын яамны, дипломат төлөөлөгчийн газрын данс зэрэг санхүүгийн сонирхолд итгэмжлэлийн, гарын үзэг зурах эсхүл төрийг төлөөлөх өөр бусад эрх мэдэл эдэлдэг байх тохиолдлыг хамарна.

Эхний тохиолдолд, 5 дугаар зүйлээр хэлэлцсэн тогтолцоог хэрэгжүүлэх үед нэвтрүүлсэнтэй ижил дүрэм үйлчилнэ. Гадаадын эрх бүхий байгууллагатай холбоотой санхүүгийн мэдээлэл солилцох тал дээр зохих анхаарлыг хандуулах нь зүйтэй. Хоёр дахь тохиолдолд, 6 дахь хэсэгт төрийн сан хөрөнгийг хуурч мэхлэх замаар өмчлөх эрх авах болох залилах, түүнчлэн итгэл, үзэмжээрээ шийдэх эрх мэдлийг урвуулан ашиглахаас сэргийлэх хүчтэй арга хэрэгслийг зааж өгсөн байна. Энэ заалтыг биелүүлэхдээ оролцогч улсууд ийм дансыг мөн 5 дахь хэсэгт заасан мэдээлэл нээлттэй байлгах тогтолцоог удирдах байгууллага нь мэдээлэл задруулах асуудлыг хянах зохих эрх бүхий байгууллага байх эсэхийг түүнчлэн тэрхүү мэдээллийн тодорхой зорилго болон хэрэглээг хянахад улсын аудитын үүргээ анхаарч үзвэл зохино.

Мэдээлэл задруулахтай холбоотой зөрчил гаргасан тохиолдолд ногдуулах арга хэмжээний тухайд, оролцогч улс 6 дахь хэсгийн шаардлагатай холбогдох зөрчил гаргасан тохиолдолд ногдуулах шийтгэлийг анхаарч үзэх хэрэгтэй. Шийтгэл нь зөрчлийн хэмжээтэйгээ дүйцэхүйц байна. Тэгэхлээр торгууль ногдуулах зэрэг өргөн хүрээний шийтгэл нь зарим албан тушаалтан болон зарим тохиолдлын хувьд уг үйлдлийг дахин гаргуулахгүй болгодог.

Энэхүү тогтолцоо нь сонирхлын зөрчил эсхүл мэдээлэл задруулахтай холбоотой гэмт хэргийг өөртөө багтааж байдаг. Оролцогч улсуудын зарим “төрийн албан тушаалтан”-г баривчлах дархан эрхтэйг анхаарах шаардлагатай. Энэ тохиолдолд төрийн албан тушаалтан санаатайгаар худал хэлсэн, мэдээллийг нээлттэй болгох маягтад худал мэдүүлэг өгсөн, эсхүл дараа нь өгсөн эд хөрөнгөнд тайлбар хийхээс зайлсхийх зорилгоор хөрөнгө, орлогыг санаатайгаар хэтрүүлэн мэдүүлсэн нь илэрсэн бол эрүүгийн гэмт хэргийг хадгалж үлдээж болно (дархан эрхийн тухай 15 ба 30 дугаар зүйлийг харна уу).

53 дугаар зүйл: Эд хөрөнгийг шууд буцаан олгох арга хэмжээ

Оролцогч улс бүр дотоодын хууль тогтоомждоо нийцүүлэн:

(a) Энэ конвенциор тодорхойлсон гэмт үйлдлээс олж авсан эд хөрөнгийг өмчлөх эрх буюу өмчлөлийг тогтоох зорилгоор шүүхдээ иргэний хэрэг үүсгэхийг оролцогч өөр улсад зөвшөөрөхөд шаардлагатай арга хэмжээг авч;

(b) Энэ конвенциор тодорхойлсон гэмт үйлдлийн улмаас хохирсон оролцогч өөр улсын хохирлыг гэмт хэрэг үйлдсэн этгээдээр нөхөн төлүүлэх буюу арилгуулах шийдвэр гаргахыг өөрийн улсын шүүхэд зөвшөөрөхөд шаардлагатай арга хэмжээг авч;

Энэхүү конвенцийн дагуу тогтоосон гэмт үйлдлийг үйлдэх замаар олж авсан эд хөрөнгийн хууль ёсны өмчлөгч гэдгээ тогтоолгох тухай оролцогч өөр улсын шаардлагыг эд хөрөнгийг хураан авах шийдвэр гаргах үедээ хүлээн авахыг өөрийн шүүх буюу эрх бүхий байгууллагад зөвшөөрөх шаардлагатай арга хэмжээг тус тус авна.

I. Ерөнхий тойм

53 дугаар зүйлд хууль бусаар эзэмшиж буй хөрөнгөнд нэхэмжлэл гаргах тухайд хууль бусаар олсон болон өөр тийш нь шилжүүлсэн хөрөнгийг буцааж болох иргэний арга хэмжээ болон бусад шууд арга хэмжээг тухайн улсад эхлүүлэхийг бусад улсад зөвшөөрөхийг оролцогч улсуудаас хүссэн байгаа. Өмчлөх давуу эрх, хохирлыг барагдуулах болон нөхөн төлөх нь тус тус хохирогч оролцогч улсын хувьд тухайн эд хөрөнгийг өөр тийш нь шилжүүлсэн оролцогч улсын шүүхэд нэхэмжлэл гаргах хууль ёсны зохих үндэслэл болох ба хохирогч оролцогч улсад хөрөнгийн талаар иргэний маргаанд зарга мэдүүлэгч болох, гэмт хэргээс үүдэн гарсан хохирлыг нөхөн төлүүлэгч тал болох, эсхүл аливаа иргэний буюу эрүүгийн эд хөрөнгө хураах ажиллагаанд өмчлөх эрх шаардагч гуравдагч тал болох зохих хууль ёсны эрхийг олгоно.

II. Бодит бэрхшээл ба шийдэл

II.1. Байр суурийг баталгаажуулах

Оролцогч улсуудаас энэхүү конвенцид заасны дагуу гэмт үйлдлийг үйлдэх замаар шууд буюу шууд бус байдлаар олж авсан эд хөрөнгийг өмчлөх эрх буюу өмчлөлийг тогтоох зорилгоор өөрийн шүүхэд иргэний хэрэг үүсгэхийг оролцогч өөр улсад зөвшөөрөхийг хүссэн. Энэ заалтыг хэрэгжүүлэхэд оролцогч улс хоёр арга хэмжээг тооцож үзэх болно.

Юун түрүүнд, оролцогч улс ямар нэг хяналт, нягтлан шалгалт хэрэгтэй эсэхийг дүгнэж үзэхийн тулд иргэний болон эрүүгийн тогтолцоон дахь хууль ёсны байр суурийг бүрдүүлэгч элементийн талаар одоогийн заалтуудаа 53 (a) заалтын зорилготой нийцүүлэхийг хүснэ. Зарим шүүхийн тогтолцоонд оролцогч улс болон тэдгээрийн хуулийн төлөөлөгчийг гадаадын бусад

хуулийн этгээдтэй ижил түвшинд хүлээн зөвшөөрөх шаардлага үүснэ. Хууль ёсны байр суурь болон шүүхэд нэвтрэх боломж нь хохирол буюу алдагдлыг нотлох баримт, тухайн гомдол мэдүүлж буй гэмт хэрэгтэй учир шалтгааны холбоотой эсэхийг шаардах зэрэг хязгаарлах шаардлагад тулгуурладаг шүүхийн тогтолцоонд үүнийг хэрэгжүүлэх зорилгоор дээрх хязгаарлалтын үр дагаврыг үнэлж үзэхийг зөвлөж байна. Оролцогч улс шууд болон шууд бус учир шалтгаантай алдагдал эсхүл хохиролыг хууль ёсны байр суурь илэрхийлэх үндэслэл гэж хүлээн зөвшөөрсөн тохиолдолд шууд харилцаа тогтоох байдлаар хууль бусаар хууран мэхэлж өмчлөх эрх олж авах замаар түүнчлэн (хохирогч оролцогч улсын харьцангуй бага шууд харилцаатай байдлаар) хахуульдаж эсхүл конвенцид дурдсан бусад гэмт хэргийг үйлдэх замаар олж авсан эд хөрөнгийг өмчлөх эрх буюу өмчлөлийг тогтоох зорилгоор тухайн улсын шүүхэд нэвтрэхийг өөр улсад зөвшөөрч болно.

Хоёрдугаарт, зарга мэдүүлэгч нь оролцогч өөр улс шүүхэд нэвтрэх шалгуурыг нягталж үзэх шаардлагатай. Иргэний хэрэгт зарга мэдүүлэгч нь оролцогч улс болж буй олон улс орны хувьд шүүхийн харъяаллын болон журмын асуудлууд үүсч болно. Шүүхийн харъяаллын асуудлын хувьд, зарим улс гадаадын оролцогч улсыг зарга мэдүүлэгчийн тусгай бүлэг гэж үзэн тэдэнд анхан шатны шүүхээс дээгүүр шүүхэд шүүхийн үндсэн харьяалал олгодог. Эдгээр болзол нөхцөл нь давж заалдах эрхийг хязгаарлаж байгаа эсэхийг оролцогч улс анхаарч үзнэ. Байр сууриа илэрхийлэх эрх болон шүүхэд нэвтрэхтэй холбоотой журмын асуудлын хувьд, эдгээр эрх зүйн нарийн мэргэжлийн үйлчилгээ нь их үнэтэй бөгөөд сунжрах хандлагатай байдаг тул ялангуяа буурай хөгжилтэй болон хөгжиж буй олон орны хувьд дотоодын хуулийн зөвлөх байлгах хэрэгцээ нь асуудал үүсгэж болох юм.

II.2. Авлигын гэмт хэргийн хохирлыг нөхөн төлүүлэх ба арилгуулах

Оролцогч улсуудаас, энэхүү конвенцийн дагуу тогтоосон гэмт үйлдлийн улмаас хохирсон оролцогч өөр улсад ийм гэмт үйлдлийг үйлдсэн этгээдээр хохирлыг нөхөн төлүүлэх буюу арилгуулах шийдвэр гаргуулахаар өөрийн шүүхэд зөвшөөрөхөд шаардлагатай арга хэмжээг авахуулахыг хүссэн байна (34, 35 дугаар зүйлийг мөн харна уу). Энэ шинэлэг заалт нь зөвхөн хураан авсны үндсэн дээр авлигаас олсон орлогыг буцаан олгох тухай тэрхүү ойлголтоос хазайж, хохирлыг нөхөн төлүүлэх, арилгуулах арга замыг эрэлхийлэгч хохирогч, оролцогч улсын эрхийг хүлээн зөвшөөрөх боломжийг өөрийн шүүхдээ олгохыг оролцогч улсад үүрэг болгож байгаа юм.

Энэхүү заалтыг хэрэгжүүлж буй оролцогч улсууд хэд хэдэн асуудлыг анхаарах хэрэгтэй. Юун түрүүнд хэрэгжихүйц журмын талаар шийдвэр гаргах нь чухал. Үүнд өргөн хүрээний хоёр сонголт бий:

- (a) Оролцогч улсууд иргэний эрхийн зөрчлийн тухай хууль болон иргэний бусад үзэл баримтлалын дагуу хохирол нөхөн төлүүлэх буюу арилгуулах нэхэмжлэл гаргахыг хохирогч оролцогч улсаас хүсч болно.
- (b) Оролцогч улс хохирлыг нөхөн төлүүлэхийг гол шийтгэлд хавсаргах нэмэлт шийтгэл болгож тогтоохыг гэмт этгээдэд ял ногдуулж буй эрүүгийн шүүхэд зөвшөөрч

болно.”Үнийн дүнд түшиглэсэн” хөрөнгө хураах тогтолцоог нэвтрүүлсэн оролцогч улсын хувьд энэ сонголт нь илүү зөв байх магадлалтай.

Тодорхой тооны оролцогч улс авлигын үйлдлийн улмаас үүссэн хохирлоо нөхөн төлүүлэх хувь хүн болон хуулийн этгээдийн эрхийг хэдийн тогтоосон. Жишээ нь, Авлигын асуудлаар Иргэний эрхийн тухай Европын конвенцид нэгдэн орсон улсууд.

Үүнд өөр оролцогч улсын ийм ажиллагаан дахь байр суурийг мөн нэмэх шаардлагатай. Авлигын үйлдлээс үүдэлтэй хохирлыг нэхэмжлэх тухай тогтсон журам байхгүй тийм оролцогч улсуудад хохирогч оролцогч улсын эрх, нотлох баримтын хэрэгжихүйц жишиг болон өмгөөлөгчийн эрхийг тооцож үзэх тодорхой журам тогтоох шаардлага үүсч болно.

Журмын талаас нь авч үзвэл, иргэний нэхэмжлэл нь нэхэмжилж буй эд хөрөнгийн эх сурвалжаас хамааран эд хөрөнгөд суурилсан эсхүл иргэний эрхийн зөрчилд суурилсан байж болох юм. Төрийн сан хөрөнгийг залилсан, шамшигдуулсан тохиолдолд, зарга мэдүүлэгч оролцогч улс өөрийн иргэдийн эсхүл сангийн яамны нэрийн өмнөөс эд хөрөнгийн хууль ёсны эзэмших эрхийг шаардаж болно. Нэхэмжилж буй эд хөрөнгө нь хувийн эх сурвалжтай бөгөөд ямар нэг нөлөөлөл болон өөр бусад гэмт хэргийн хариуд үйлдсэн хахуулийн хэрэгт, хариуцагчийн учруулсан хохирол эсхүл төрийн албан тушаал, аливаа эрх мэдлийг урвуулан ашиглах замаар хууль бусаар олж авсан давуу байдлыг буцааж олгох арга замыг эрэлхийлэх оролцогч улсын эрхэд үндэслэн нэхэмжлэл гаргаж болох юм.

Оролцогч улс зөвхөн эд материалын хохирлыг эсхүл үүнээс гадна мөн ашгийн алдагдал болон мөнгөн бус алдагдлыг нэхэмжилж байж болохыг харгалзан шийдвэр гаргана. Тухайн авлигын хэргийн улмаас тэрхүү улсын орлого буюу ашиг багассан гэдгийг илтгэн харуулж байгаа тохиолдолд ашгийн алдагдлыг зөвшөөрч болох юм. Эд материалын бус хохирол буюу мөнгөн бус алдагдлыг авлигаас бий болсон институцийн хохиролтой холбож ойлгоно. Хэдий эдгээр хохирлыг тооцоолоход бэрхшээлтэй ч нөхөн төлбөрт институцийн хөтөлбөрт хувь нэмэр оруулах, авлигатай тэмцэх чадамжийг дээшлүүлэх зэрэг багтана. Үүнээс гадна авлигын үр дагаварт, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн зохих ёсоор судлахгүйгээр дэд бүтцийн ажил явуулахыг зөвшөөрснөөс үүдэлтэй байгаль орчны хохирол, хорт хаягдлыг хаяхыг зөвшөөрснөөс үүсэх байгаль орчны бохирдол, ард иргэдийн эрүүл мэндэд хор хохирол учруулах болон байгаль орчны хохирол зэрэг авлигын хэргээс шалтгаалсан шууд бус хохирол багтана.

III. Гадаадын эд хөрөнгө хураах ажиллагаанд эд хөрөнгө өмчлөх эрх тогтоох

Энэ зүйлд оролцогч улсаас энэхүү конвенцийн дагуу тогтоосон гэмт үйлдлийг үйлдэх замаар олж авсан эд хөрөнгөд эзэмших эрх шаардахыг, хөрөнгө хураах ажиллагаанд гуравдагч тал болох оролцогч өөр улсад зөвшөөрөхийг хүссэн. Өмнөх шүүхийн харъяалалд гадаадын төрийн албан тушаалтныг хахуульдсан хэрэгт ямар нэг компанид ял тулгаж байх зэрэг тохиолдолд тухайн оролцогч улс байцаан шийтгэх ажиллагаа явагдаж байгаа талаар мэдээлэлгүй байж болно. Аливаа бусад хохирогчийн нэгэн адил байцаан шийтгэх ажиллагааны анхан шатанд оролцогч өөр улсад мэдэгдсэн гэдэгт оролцогч улс хэзээ ямагт итгэлтэй болж авах хэрэгтэй.

Цаашлаад оролцогч улсын зүгээс мөн 56 дугаар зүйлд заасны дагуу нэхэмжлэл гаргах болон үүнийгээ батлах эрхтэйг нь тухайн оролцогч улсад мэдэгдэх асуудлыг тооцож үзвэл зохино.

54 дүгээр зүйл: Эд хөрөнгийг хураах асуудлаар олон улсын хэмжээнд хамтран ажиллах замаар эд хөрөнгийг буцаан олгох механизм

1. Энэ конвенциор тодорхойлсон гэмт үйлдлийн үр дүнд олж авсан буюу тийм гэмт үйлдэлтэй холбоотой эд хөрөнгийн хувьд оролцогч улс тус бүр энэхүү конвенцийн 55 дугаар зүйлийн дагуу эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэхийн тулд дотоодын хууль тогтоомждоо нийцүүлэн:

(a) Оролцогч өөр улсын шүүхээс эд хөрөнгийг хураах талаар гаргасан шийдвэрийг биелүүлэхийг өөрийн эрх бүхий байгууллагад зөвшөөрөхөд шаардлагатай арга хэмжээг;

(b) Холбогдох хэргийг харъяалан шийдвэрлэх эрх бүхий өөрийн байгууллагадаа мөнгө угаах гэмт хэрэг буюу тухайн байгууллагын харъяалалд багтах бусад гэмт үйлдлийн талаар шүүхийн шийдвэр гаргуулах эсхүл өөр бусад арга замаар гадаад улсаас гаралтай эд хөрөнгийг хураан авахыг зөвшөөрөхөд шаардлагатай арга хэмжээг;

(c) Гэмт хэрэгтэн насбарсан, оргон зайлсан буюу алга болсон гэх шалтгаанаар яллаж болохгүй тохиолдолд болон бусад зохих тохиолдолд тухайн эд хөрөнгийг ял шийтгэлгүйгээр хураан авахыг зөвшөөрөхөд шаардлагатай арга хэмжээг авахасуудлыг тус тус авч үзнэ.

2. Энэхүү конвенцийн 55 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн дагуу гаргасан хүсэлтийн дагуу эрх зүйн туслалцаа үзүүлэхийн тулд оролцогч улс бүр дотоодын хууль тогтоомждоо нийцүүлэн:

(a) Хүсэлт гаргагч оролцогч улсын шүүх буюу эрх бүхий байгууллагаас гаргасан эд хөрөнгийг битүүмжлэх буюу түр хураах шийдвэрийн дагуу өөрийн эрх бүхий байгууллагад эд хөрөнгийг битүүмжлэх буюу түр хураахыг зөвшөөрөхөд шаардлагатай арга хэмжээг авах бөгөөд уг шийдвэр тийм арга хэмжээ авах хангалттай үндэслэл байгаа эсэх, түүнчлэн энэ зүйлийн 1 дэх хэсгийн (a) дэд хэсгийн зорилгоор тухайн эд хөрөнгийг хураах шийдвэрийг гаргах нь зайлшгүй болоход хүсэлт хүлээн авагч оролцогч улс итгэх боломжит үндэслэлийг заана;

(b) Эд хөрөнгийг битүүмжлэх буюу түр хураах хүсэлтийн дагуу эд хөрөнгийг битүүмжлэх буюу түр хураахыг эрх бүхий байгууллагадаа зөвшөөрөхөд шаардлагатай арга хэмжээг авах бөгөөд уг хүсэлтэд ийм арга хэмжээ авах хангалттай үндэслэл байгаа, түүнчлэн энэ зүйлийн 1 дэх хэсгийн (a) дэд хэсгийн зорилгоор уг эд хөрөнгийг хураан авах нь зайлшгүй болоход хүсэлт хүлээн авагч оролцогч улс итгэх боломжит үндэслэлийг заана;

Тухайн эд хөрөнгийн өмчлөлтэй холбоотой гадаад улсын хэрэгжүүлж буй битүүмжлэл буюу эрүүгийн ялтай холбогдуулан эд хөрөнгийг хамгаалалтад авах зөвшөөрлийг өөрийн эрх бүхий байгууллагад олгох нэмэлт арга хэмжээ тогтоох асуудлыг авч үзнэ.

I. Ерөнхий тойм

54 дүгээр зүйл хөрөнгө буцаан олгох тууштай тогтолцоог нэвтрүүлэхэд оролцогч улсуудад туслах гэсэн энэхүү конвенцийн ерөнхий зорилгын хүрээнд нэгэн чухал арга замын тухай өгүүлж байна. Авлигаас олсон орлогыг буцааж олгоход тулгарах бэрхшээлийг даван туулахад чиглэсэн энэхүү зүйл нь өөр оролцогч улсаас үүсэлтэй авлигын орлогыг хураах явдлыг баталгаажуулах журам тогтоохыг хураах ажиллагааг хөнгөвчлөх үүднээс урьдчилсан арга хэмжээ авах буюу ийм хүсэлт гаргахаас урьтаж тодорхой арга хэмжээ авахыг оролцогч улсуудаас хүссэн байна. Хүсэлт гаргагч оролцогч улс буюу улсуудын эрх зүйн тогтолцоо нь харилцан адилгүй байж болохыг харгалзан үзэж 54 дүгээр зүйлд оролцогч улсуудаас өөр өөр эрх зүйн тогтолцооны хүрээнд хамтран ажиллах боломжтой байхыг хүссэн байгаа юм.

II. Бодит бэрхшээл ба шийдэл

II.1. Эд хөрөнгийг хураах гадаад улсын шүүхийн шийдвэрийг биелүүлэх боломж

54 (1) хэсгийн хүрээнд гадаад улсын шүүхээс эд хөрөнгийг хураах талаар гаргасан шийдвэрийг биелүүлэхийг өөрийн эрх бүхий байгууллагад зөвшөөрөх арга хэмжээг авахыг оролцогч улсуудаас хүссэн байна. Энэ арга хэмжээ нь уламжлалт хоёр хэлбэртэй. Хүсэлт хүлээн авагч оролцогч улсын эрх бүхий байгууллага хөрөнгө хураах тухай гадаад улсын шийдвэрийг зөвшөөрч хэрэгжүүлж болно эсхүл дотоодын хууль тогтоомжийн хүрээнд шинээр шүүн таслах ажиллагаа эхлүүлж тэрхүү хууль тогтоомжийн хүрээнд гадаадын оролцогч улсын нэрийн өмнөөс битүүмжлэх буюу хураах шийдвэрийг гаргаж болно.

Оролцогч улсууд 54 (1) хэсгийг хэрэгжүүлэхдээ энэ заалтанд тус конвенцийн дагуу тогтоосон гэмт хэрэг үйлдэх замаар олсон эд хөрөнгөөс гадна ийм гэмт хэргийг үйлдэхэд ашигласан, оролцуулсан эд хөрөнгийг хураах явдлыг багтаах байдлаар хамтын ажиллагааны хамрах хүрээг өргөжүүлнэ. Цаашлаад, ихэнх оролцогч улсын хувьд хөрөнгө хураах тухай гадаад улсын шийдвэрийг биелүүлэхийн тулд шүүхийн шийдвэр шаардлагатай болохыг хүлээн зөвшөөрсөн 54 (1) хэсэгт “эрх бүхий байгууллага” гэж заасан байгаа бөгөөд ингэснээр гадаад улсын шүүхийн шийдвэрийг биелүүлэхэд захиргааны журмыг тогтоох асуудлыг шийдэх эрхийг оролцогч улсуудад үлдээсэн байна.

Дээр дурдсан асуудалтай холбоотойгоор хүсэлт хүлээн авагч оролцогч улсын зүгээс хүсэлт гаргагч оролцогч улсад гаргасан тэрхүү шийдвэр нь тодорхой бөгөөд эцсийн шийдвэр байхыг шаардах магадлал өндөр байгааг анхаарч үзэх хэрэгтэй. Энэхүү шийдвэр нь давж заалдах эрхгүй, *res judicata* (хууль ёсоор хүчин төгөлдөр) байдалтай эцсийн шийдвэр байх явдлыг эрх зүйн хамгаалалт болон өмгөөллийн эрхийн дагуу шаардана.

Хөрөнгө хураах тухай байцаан шийтгэх ажиллагааг шинээр эхлүүлэхтэй харьцуулахад гадаад улсын шүүхийн шийдвэрийг биелүүлэх нь: –эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг шилжүүлэх нэг хэлбэр, - илүүд тооцогддог ч хүсэлт хүлээн авагч оролцогч хүсэлтийг улсын дотоодын хууль тогтоомжид нийцүүлэхийн тулд байцаан шийтгэх ажиллагааг шинээр эхлүүлэх

шаардлага үүсэх хэд хэдэн нөхцөл байдал бүрдэж байна. Түгээмэл тохиолддог нэг ийм нөхцөл байдал үүсдэг. Жишээ нь: хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхийг зөвшөөрдөггүй оролцогч улсад хуулийн этгээдийн эсрэг хөрөнгө хураах шийдвэрийг хэрэгжүүлэхийг хүсч байгаа үед. Энэ тохиолдолд ямар хувь этгээдийн эсрэг шүүхийн шийдвэр хэрэгжүүлэхийг тогтоох байцаан шийтгэх ажиллагааг шинээр явуулах шаардлагатай болно.

Үндсэн гэмт хэрэгт буруутай байдлыг үнэлэх зорилгоор тогтоосон журмаас үл хамааран хэрэгжих хөрөнгө хураах тухай журмыг хэд хэдэн оролцогч улс бий болгосон байна. Хөрөнгө хураах тухай тусгай журам нь яллах эрх бүхий байгууллагад гэмт хэргээс олсон орлогын үүсэл гарлыг мөрдөн байцаахад илүү цаг хугацааг олгохоос авахуулаад хураах ажиллагаанд хамруулах эд хөрөнгийн үүсэл гаралтай холбоотой нотолгооны доогуур жишгийг зөвшөөрөх хүртэл өөр хоорондоо нилээд ялгаатай байж болдог.

II.2. Мөнгө угаах буюу холбогдох өөр бусад гэмт хэрэгт тулгуурлан гадаадын авлигын гэмт хэргээс олсон орлогыг хураах

Сүүлийн арван жилд мөнгө угаах гэмт хэргийг хууль бус орлогын чиглэлийг нь өөрчилсөн тэрхүү шүүхийн харьяалалд нь шүүн таслах байдлаар авлигын нилээдгүй гэмт хэрэгт холбоотой байдлаар олсон орлогыг буцаан олгосон юм.

Энэхүү конвенцид авлигын гэмт хэргээс орлого олохоос сэргийлэх, ийм орлогыг мөрдөх, хязгаарлах, түр хураах болон хураах мөнгө угаахтай тэмцэх механизмыг нэвтрүүлэх асуудлыг онцгойлон авч үзсэн байна (14, 23 ба 52 дугаар зүйлийг тус тус харна уу). 14 ба 52 дугаар зүйлд гэмт хэргээс олсон орлоготой хамааралтай байж магадгүй сэжигтэй гүйлгээг мэдээлэхийг санхүүгийн байгууллагуудаас хүссэн байгаа. Үүнээс гадна 23 (2) (с) хэсэгт үндсэн гэмт хэргийг хаана үйлдсэнээс үл хамааран мөнгө угаах гэмт хэрэгтэй холбоотой байцаан шийтгэх ажиллагааг дотооддоо явуулахыг зөвшөөрөхийг оролцогч улсуудаас хүссэн. Үүнд 54 (1) (b) хэсэгт мөнгө угаах гэмт хэрэгт хамаарах байцаан шийтгэх ажиллагаа явуулан гадаад улсын үндсэн гэмт хэргийн орлогыг хураах боломжоор хангах явдлыг оролцогч улсуудаас хүсэн энэхүү нэг тойргийг гүйцээж өгсөн байна.

II.3. Эрүүгийн хэрэгт буруутгалгүйгээр эд хөрөнгө хураах

54 (1) (с) хэсэгт гэмт хэрэг үйлдэгдсэн гэж сэжиглэж буй эсвэл үнэхээр үйлдэгдсэн оролцогч улс эсхүл тухайн эд хөрөнгө оршин буй оролцогч улс гэмт хэрэг үйлдэгчийг эрүүгийн гэмт хэрэгт буруутгахгүй байгаа тохиолдолд ч гадаад улсад үйлдэж өөрийнх нь шүүхийн харьяалал уруу чиглүүлсэн авлигын гэмт хэргийн орлогыг хураахыг зөвшөөрөх арга хэмжээг авахыг тухайн оролцогч улсад зөвлөсөн байгаа.

Энэхүү зөвлөмжийн хэрэгжилт нь хөрөнгө хураах арга хэмжээг тухайн оролцогч улс залхаан цээрлүүлэх эсхүл буцаан сэргээх арга хэмжээ гэсэн утгын алинаар авч үзэхээс хамаарна. Хэд хэдэн улс гэмт хэргээс олсон орлогыг хураах нь гагцхүү залхаан цээрлүүлэх арга хэмжээ гэж үзэж байгаа бол мөн олон тооны улс эд хөрөнгө хураах нь засах, буцаан сэргээх арга хэмжээ юм

гэж тооцдог бөгөөд зарим тохиолдолд үүнийг эрүүгийн бус арга хэмжээ болгон авч хэрэгжүүлдэг ажээ.

Энэхүү конвенцоор гэмт хэрэгтэн нас барсан, оргон зайлсан буюу байхгүй байгаа шалтгаанаар яллаж болохгүй тохиолдолд дахин сэргээх арга хэмжээг авах *de minimis* босгыг санал болгож байгаа. Гэмт хэрэгтэн нас барсан тохиолдолд, эрүүгийн шийтгэлийг өв залгамжлагчид шилжүүлэхийг хориглох зарчмыг анхаарч үзэн, шилжүүлэх болон хувиргах нь тухайн эд хөрөнгийн хууль бус байдлыг эсхүл эдгээрийг нэхэмжлэх хохирогч оролцогч улсын эрхийг үл өөрчилнө гэсэн таамаглал дээр үндэслэн хөрөнгө хураахыг буцаан сэргээх буюу засах арга хэмжээ гэж тооцож болох юм.

Европын Хүний эрхийн шүүх, жишээ нь, хөрөнгө хураахыг ял шийтгэл эсхүл иргэний арга хэмжээ гэж үзэх шалгуурыг тодорхой тогтоож өгсөн байгаа (Европын Хүний эрхийн комисс, No. 12386/1986 ба Европын Хүний эрхийн шүүх, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын эсрэг Филипсийн хэрэг, No. 41087/1998). Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаагаар хөрөнгө хураахаас ялгаатайгаар, иргэний эрх зүйн хүрээнд хөрөнгө хурааж авах тухай хуулиар хууль бус гэдэг нь “эргэлзээгүй” үүсэл гарлыг батлахыг шаарддаггүй. Үүний оронд таамаглалуудыг тэнцвэржүүлэн батлах асуудлыг бодолцож үзэх буюу хууль бус үндэслэлтэй байх магадлал өндөр бөгөөд хөрөнгийн эзэн үүнийг эсрэгээр нь баталж чадахгүй байх шаардлага тавьдаг.

II.4. Хөрөнгийг дараа хураах зорилготой түр арга хэмжээ

54 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт хөрөнгө битүүмжлэх буюу хураах шийдвэрийг хэрэгжүүлэх үүднээс оролцогч өөр улсын хүсэлтээр түр (буюу богино хугацааны) арга хэмжээг авахыг өөрсдийн эрх бүхий байгууллагадаа зөвшөөрөхийг оролцогч улсуудаас хүссэн байна. Гадаад улсын битүүмжлэх буюу түр хураах шийдвэрийг шүүхээс байгууллагаас өөр эрх бүхий байгууллага гаргаж болохыг 54 (2) (а) хэсэгт хүлээн зөвшөөрсөн юм. Гэхдээ эрүүгийн шүүхийн харьяалалгүй эрх бүхий байгууллагын гаргасан битүүмжлэх буюу түр хураах тухай шийдвэрийг биелүүлэх эсхүл хүлээн зөвшөөрөхийг оролцогч улсуудаас шаардаагүй (харьцуулах зорилгоор, 54.2 (а) хэсгийн тухай тайлбар тэмдэглэл, А/58/422/Нэмэлт 1, 61 дэх хэсгийг харна уу).

54 дугаар зүйлийн (2) (а) ба (b) хэсэг шаардлагатай түр арга хэмжээ болгож битүүмжлэх болон түр хураах асуудал дээр төвлөрсөн бол 54 (2) (с) хэсэгт гэмт хэргээс олсон эд хөрөнгийг эзэмшихтэй холбоотой дараа нь хөрөнгө хураах ажиллагаанд хүргэж болох гадаад улсын баривчлах буюу эрүүгийн хэрэгт ял тулгах асуудалд үндэслэх зэрэг байдлаар эд хөрөнгийг хураах зорилгоор хадгалахыг өөрийн эрх бүхий байгууллагадаа зөвшөөрөх бусад арга хэмжээг авахыг оролцогч улсуудад чухалчлан зөвлөж байна. Эрүүгийн журам бүрт битүүмжлэх, түр хураахаас гадна өр төлөгдөх хүртэл хөрөнгийг хяналтад авах, шүүхийн шийдвэрээр хязгаарлалт тавих, хөрөнгийн хөдөлгөөнийг хязгаарлах, аж ахуйн нэгж буюу дансыг хянах зэрэг хөрөнгийн байршил, ашиглалт болон эдэлгээг түр хязгаарлах арга хэмжээг заасан байдаг. Энэ зөвлөмжийг хэрэгжүүлэхийг хүсч буй оролцогч улс эдгээр арга хэмжээг оролцогч улсуудын ийм эд хөрөнгийг эзэмшихтэй холбоотой гадаад улсын баривчлах буюу эрүүгийн гэмт хэрэгт буруутгах

асуудлаар мэдээлэл хүлээж авах эрт үе шатыг хамрах байдлаар хэрэглэх болно. (56 дугаар зүйлийг харна уу).

Конвенцийн 55 дугаар зүйлийн агуулга, бүтэц болон хэрэгжүүлэх шаардлагын талаар илүү мэдээлэл, дүн шинжилгээ олж авахыг хүсвэл Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний байгууллагын Конвенцийг хэрэгжүүлэх Эрх зүйн удирдамжийн холбогдох хэсгийг харна уу.

56 дугаар зүйл: Тусгай хамтын ажиллагаа

Оролцогч улс бүр дотоодын хууль тогтоомжоо үл зөрчсөн байдлаар энэ конвенциор тодорхойлсон гэмт үйлдлээс олсон орлогын талаарх мэдээллийг өөр оролцогч улсад өгөх нь мэдээллийг хүлээн авагч оролцогч улсад хэргийг мөрдөн шалгах, яллах буюу шүүх ажиллагааг эхлүүлэх, явуулахад нь тус дөхөм болно буюу Конвенцийн энэ бүлгийн дагуу хүсэлт гаргах хүргэж болно гэж үзсэн тохиолдолд ийм мэдээллийг өөрийн мөрдөн шалгах, яллах буюу шүүх ажиллагаанд хохирол учруулахгүйгээр өөр оролцогч улсад хүсэлтийг нь урьдчилан авахгүйгээр өгөхийг зөвшөөрөх арга хэмжээ авахыг эрмэлзэнэ.

I. Ерөнхий тойм

Гагцхүү оролцогч улсын хүсэлтийн дагуу мэдээлэл өгөх буюу тусламж үзүүлэх зарчимд тулгуурласан байдалтай байдаг байсан олон улсын хамтын ажиллагааг 56 дугаар зүйлд цааш нь үүнээс нэг алхам ургашлуулж өгсөн байна. Энэхүү конвенцид заавал хүсэлт гаргахыг хүлээлгүйгээр, сайн дураар хамтран ажиллах гэсэн ойлголтыг оруулж өгсөн байгаа бөгөөд ингэснээр нилээд өндөр хурдтай санхүүгийн гүйлгээний орчинд ялангуяа маш чухалд тооцогдож болох урьдчилан ажиллагаа явуулах арга замыг дэмжиж өгч байгаа юм. Конвенцийн 56 дугаар зүйлд ийм мэдээлэл нь мөрдөн шалгах, яллах буюу шүүх ажиллагааг эхлүүлэх буюу явуулахад нь тус дөхөм болж болно гэж үзсэн тохиолдолд тухайн оролцогч улсаас хүсэлт хүлээлгүйгээр сайн дураар мэдээлэх тал дээр оролцогч улсуудыг дэмжсэн байна.

II. Бодит бэрхшээл ба шийдэл

Конвенцийн 56 дугаар зүйлийг хэрэгжүүлэхийн тулд оролцогч улсууд өөр бусад оролцогч улсын эрх бүхий байгууллагын сонирхол илэрхийлж болно гэж үзсэн мэдээллийг тэдэнд дамжуулахыг өөрийн эрх бүхий байгууллагууддаа зөвшөөрсөн урьдчилсан хамтын ажиллагааны тухай заалтыг дотоодын хууль тогтоомждоо оруулах боломжийг анхаарч үзэж болох юм. Гэхдээ ийм мэдээллийг хэрхэн солилцож болохыг оролцогч улсууд өөрсдөө тогтоох хэрэгтэй. Ийм заалтын хэрэгжиж болохуйц байдлыг тооцож үзвэл нөгөө улс дахь тэдэнтэй ижил төрлийн ажил эрхэлдэг мэргэжил нэгт эрх бүхий байгууллагад ийм мэдээллийг шууд дамжуулах боломжтой шууд харилцах сувгийг сонгох нь зүйтэй байж болно. Энэ төрлийн мэдээлэлд ялангуяа РЕР-ийн

сэжиг бүхий гүйлгээ, үйл ажиллагаа эсхүл төрийн аливаа албан тушаалтан итгэмжлэлийн эрх мэдэл, гарын үсэг зурах эрх мэдэлтэй байх тохиолдолд хамаарах сэжиг бүхий гүйлгээ, үйл ажиллагаа эсхүл аливаа бусад эрх бүхий байгууллага өөр оролцогч улс дахь санхүүгийн сонирхолд төрийг төлөөлж байх тохиолдлын сэжиг бүхий гүйлгээ, үйл ажиллагаа болон хуулийн этгээдүүдийн ер бусын төлбөрийн талаар мэдээлэл орж болох юм.

Оролцогч улсууд мэдээлэл солилцох ажиллагаанд аль хэдий нь тогтсон тэрхүү мэдээлэл солилцох орчинг ашиглахыг хүсч байж болно. Ийм харилцааны орчны нэг жишээ нь Эгмонтын бүлэг юм. Эгмонтын бүлэг нь санхүүгийн мэдээллийн нэгжүүд (СМН-үүд) болон мэдээлэл солилцоог дэмжиж ажилладаг. СМН нь харилцан солилцоо эсхүл хоёрт талт хэлэлцээр дээр үндэслэн мөн тогтоосон журмын дагуу өөр бусад СМН-тэй мэдээлэл солилцдог. Хүсэлтийн дагуу эсхүл сайн дураар ийнхүү мэдээлэл солилцох нь дүн шинжилгээ эсхүл санхүүгийн гүйлгээний талаар мөрдөн байцаах ажиллагаа, өөр бусад оролцогч хувь хүн буюу компани болон холбогдох бусад мэдээлэлд хамаатай мэдээллийг бий болгодог юм. СМН-үүд солилцох дундын мэдээллийн нууцлалыг болон хувь хүний нууцыг хамгаалахын сацуу өөр хоорондоо албан бус байдлаар, аль болох түргэн түүнчлэн хэт их албан шаардлага тавилгүйгээр мэдээлэл солилцож болно. Эгмонтын СМН-үүд өөр хоорондоо мэдээллийг найдвартай байдлаар солилцож байх учиртай юм. Иймээс ч Эгмонтын СМН-үүд зохих тохиолдолд Эгмонтын хамгаалалтын сүлжээг (ESW) ашигладаг болно.

Конвенцийн 57 дугаар зүйлийн агуулга, бүтэц болон хэрэгжүүлэх шаардлагын талаар илүү мэдээлэл, дүн шинжилгээ олж авахыг хүсвэл Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний байгууллагын Конвенцийг хэрэгжүүлэх Эрх зүйн удирдамжийн холбогдох хэсгийг харна уу.

58 дугаар зүйл: Санхүүгийн мэдээллийн нэгж (СМН)

Оролцогч улсууд энэ конвенциор тодорхойлсон гэмт үйлдлээс олсон орлогыг шилжүүлэхээс урьдчилан сэргийлэх, тийнхүү шилжүүлэхтэй тэмцэх, түүнчлэн тэдгээр орлогыг буцааж олгох арга зам, хэрэгслийг дэмжих зорилгоор харилцан хамтран ажиллах бөгөөд үүний тулд сэжиг бүхий санхүүгийн гүйлгээний талаархи мэдээллийг хүлээн авах, дүн шинжилгээ хийх, эрх бүхий байгууллагуудад тараах асуудал эрхэлсэн санхүүгийн мэдээллийн нэгж байгуулах асуудлыг авч үзнэ.

I. Ерөнхий тойм

Конвенцийн 58 дугаар зүйлд хөрөнгө буцаан олгох тал дээр хамтын ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэхийн тулд санхүүгийн мэдээллийн нэгж (СМН) байгуулах асуудлыг авч үзэхийг оролцогч улсуудаас хүссэн байна.

Мөнгө угаах болон террорист ажиллагааг санхүүжүүлэхтэй тэмцэх зорилгоор үндэсний хууль тогтоомж буюу дүрэм журмаар шаардсанаар гэмт хэргээс орлого олж терроризмыг санхүүжүүлсэн тухай санхүүгийн мэдээллийг задруулан хүлээн авах (мөн зөвшөөрөгдсөн байдлаар, хүсэлт гаргах) хуваалцах, дүн шинжилгээ хийх болон холбогдох эрх бүхий байгууллагад хүргэх асуудлыг хариуцах, мөнгө угаахаас урьдчилан сэргийлж, үүнтэй тэмцэхийн тулд 1990 оноос хойш 110 гаруй улсад үндэсний төв байгууллага буюу СМН байгуулагдаад байна. Эгмонтын бүлэг нь СМН-үүдийн ажлыг хөнгөвчлөх албан бус байгууллага юм. Эгмонтын бүлэг мэдээлэл солилцохыг хөхиүлэн дэмжих түүнчлэн улсууд хооронд мэдээлэл солилцоход саад болж буй бэрхшээлийг даван туулах асуудлыг юун түрүүнд чухалчилж авч үздэг.

II. Бодит бэрхшээл ба шийдэл

II.1. СМН-ийн үүргүүд

СМН нь ерөнхийдөө гурван гол үүргийг гүйцэтгэнэ. Юун түрүүнд энэ нь санхүүгийн байгууллагууд болон зуучлагчдаас ирж буй мөнгө угаах хэргийн талаархи мэдээллийг төвлөрүүлэх төв байгууллагын үүргийг гүйцэтгэж, эдгээр мэдээллийн ашиглалт болон түгээлтэнд үйл ажиллагааны чухал хяналтыг тавьдаг. Хоёрдугаарт, СМН “дүн шинжилгээ хийх үүрэг” гүйцэтгэх бөгөөд үүнд хүлээн авсан мэдээллээ боловсруулах, мэдээлсэн гүйлгээний тухай холбогдох чухал өгөгдлийг үүнд дээр нэмэх явдал орно. Ийм мэдээлэл нь ихэнхдээ СМН-ийн өөрийн өгөгдөл, СМН-ийн нэвтэрч болох Засгийн газрын бусад өгөгдлийн сан, олон нийтэд нээлттэй мэдээллийн эх сурвалж, мэдээлэгч байгууллагаас гаргасан нэмэлт мэдээлэл болон бусад СМН-ээс ирдэг. Дүн шинжилгээ хийх үүргийн нэгэнд хууль сахиулах бусад байгууллагатай хуваалцах стратегийн буюу статистикийн дүн шинжилгээ бүхий судалгааны ажлын гүйцэтгэл ордог. Эдгээр хууль сахиулах бусад байгууллага нь, жишээ нь, мөнгө угаах гэмт хэргийн шинэ хандлага эсхүл ангилалыг тогтоох, томоохон хэмжээний газар нутгийг хамарсан санхүүгийн гэмт хэргийн газрын зураг зохиох болон анхан шатны мөрдөн байцаах ажиллагаанд тодорч илрээгүй олон улсын холбоог тодорхойлох зэрэг асуудлыг хариуцаж байж болно. Эцэст нь, СМН нь гадаадын СМН-үүд буюу дотоодын хууль сахиулах, зохицуулах эсхүл шүүхийн байгууллагын хооронд ер бусын буюу сэжигтэй санхүүгийн гүйлгээний тухай –урьдчилан болон дараагаар нь- мэдээлэл солилцох явдлыг хөнгөвчлөх дамжуулагчийн үүрэг гүйцэтгэдэг.

Тодорхой тохиолдолд, санхүүгийн байгууллага эсхүл санхүүгийн бус ажил хэрэг эрхлэгч, мэргэжилтнийг эсхүл аль алиныг нь хянах нэмэлт үүргийг СМН-д ногдуулсан байдаг. Ийм тохиолдолд аж ахуйн нэгж, байгууллага буюу хувь хүний мэдээлэх буюу бүртгэл хөтлөх үүргийг мөрдүүлэх зорилгоор энэхүү үүргээ биелүүлэх тухайд зөрчил гаргасан этгээдэд шийтгэл ногдуулах (жишээ нь, торгууль тавих, тусгай зөвшөөрөлийг түр түтгэлзүүлэх эсхүл хүчингүй болох) эрх мэдлийг эдгээр нэгжид мөн олгосон байдаг. Зарим СМН-д мөнгө угаах болон террорист ажиллагааг санхүүжүүлэхтэй тэмцэх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зорилгоор дүрэм журам батлах эрх мэдэл олгосон байж болно.

Оролцогч улсын сонгосон СМН-ийн загвараас (дор харна уу) хамааран СМН нь битүүжлэх, түр хураах буюу хураах боломжит эд хөрөнгийг таньж тогтооход шүүхийн байгууллагатай хамтран ажиллаж эсхүл сэжигтэн этгээдийн буюу түүний хамсаатны санхүүгийн үйл ажиллагааг харгалзан мөнгө угаах хэрэгт зарим нэг урьдчилсан мөрдөн байцаах ажиллагаа явуулах хариуцлага хүлээдэг. Зарим тохиолдолд мөрдөн байцаах ажиллагаа явагдаж байх зуур СМН эд хөрөнгийн хөдөлгөөнийг хязгаарлах түр арга хэмжээ авч болдог.

Түүнчлэн СМН нь дотоодын, бус нутгийн болон олон улсын хэмжээнд мөнгө угаахтай тэмцэх дүрэм, журам болон террорист ажиллагааг санхүүжүүлэх асуудлын тухай санхүүгийн байгууллагын боловсон хүчин болон санхүүгийн бус ажил хэрэг эрхлэгч бусад мэргэжилтэнд зөвөлгөө өгч, сургалт зохион явуулна.

СМН байгуулахдаа оролцогч улсууд өөрсдийн эрх зүйн орчин, эдийн засгийн хэв шинжийг харгалзан үзэж дараах загваруудад анхаарал хандуулна:

- Төв банк эсхүл Сангийн яам эсхүл захиргааны бие даасан байгууллага зэрэг зохицуулагч/хянагч эрх бүхий байгууллагад хавсаргах захиргааны байгууллагын загвар;
- Хууль сахиулах байгууллагын загвар;
- СМН нь шүүхийн эрх бүхий байгууллага эсхүл прокурорын эрх бүхий байгууллагад харъяалагдаж байх шүүхийн эсхүл прокурорын байгууллагын загвар;
- Дээрх загваруудыг ямар нэг байдлаар хослуулсан эрлийз загвар.

Гэхдээ аль ч тохиолдолд хамгийн гол зүйл бол байгууллагын хараат бус байдал бөгөөд үүнийг хэд хэдэн аргаар баталгаажуулж болно. Тодорхой тохиолдолд СМН-ийг баталгаажсан төсөв болон ур чадвартай, хангалттай боловсон хүчин бүхий тусдаа байгууллага хэлбэрээр байгуулах замаар эсхүл СМН-ийн үр нөлөөт байдалд нөлөөлж болох эсхүл чиг үүрэг болон мэдээллийг нь урвуулан ажиглаж болох өөр байгууллагаар СМН-ийн нөөц болон үйл ажиллагааг захируулахгүй байх замаар хараат бус байдлыг бий болгож болно. Гэхдээ энэ хараат бус байдлын зэрэгцээ эрх мэдэл буюу мэдээлэл ашиглалтыг хянах, хууль тогтоох байгууллагад тайлагнуулж байх, аудит буюу шүүхийн хяналт тавих зэрэг зохих хяналтын болон хариуцлага тооцох механизмыг авч хэрэгжүүлэх хэрэгтэй.

II.2. СМН-ийн загварууд: захиргааны байгууллага

Захиргааны байгууллагын загварын СМН нь (хуулийн дагуу тогтоосон чиг үүрэг бүхий) тусдаа байгууллага болж үйл ажиллагаа явуулдаг, ямар нэг яамны эсхүл захиргааны байгууллагын хяналтанд харъяалагдах эсхүл ийм хяналтанд үл харъяалагдах (хараат бус) төрийн байгууллага эсхүл хувийн байгууллага болно. СМН-ийг санхүүгийн байгууллага, бусад мэдээлэгч салбар болон хууль сахиулах салбар хооронд “жийргэвч”-ийн үүрэг гүйцэтгэх захиргааны байгууллага болгосноор, хууль сахиулах байгууллагатай институцийн түвшинд шууд холбоотой байх нь харилцагчтай харилцаанд сөргөөр нөлөөлдгийг мэдэх мэдээлэгч

байгууллагатай төвөггүй байдлаар хамтран ажиллах боломжийг эрх бүхий байгууллагад олгоно. Захиргааны байгууллагын загварын СМН нэг талаас мэдээлэх үүрэг бүхий санхүүгийн болон бусад салбар, нөгөө талаас хууль сахиулах байгууллагуудын хооронд холбогч болж ихэнхдээ ажилладаг ба энэ нь ийм загварын СМН-ийн нэг давуу тал юм. Ингэснээр мэдээлэгч тал болон хууль сахиулах байгууллага хооронд институцийн шууд холбоо үүсгэхээс зайлхийхээс гадна хууль сахиулах байгууллагын анхаарлыг мэдээллийг задруулах асуудалд хандуулж байгаа болно. Ийнхүү мэдээлэл түгээх асуудал нь мөнгө угаах болон террорист ажиллагааг санхүүжүүлэх хэргээр хязгаарлагдаж, мэдээлэгч байгууллагын хязгаарлагдмал мэдээллээс илүүтэйгээр СМН-ийн өөрсдийн дүн шинжилгээн дээр үндэслэнэ гэдгийг санхүүгийн болон бусад байгууллага мэдэж аван, мэдээлэл задруулах тал дээр илүү итгэлтэй болох юм. Захиргааны байгууллагын загварын СМН нь “төвийг сахьсан”, техникийн гэж тооцогддог бөгөөд мэдээлэгч талын өмнөөс мэргэжлийн хэлэлцэгчийн үүрэг гүйцэтгэж болдог. Хэрэв зохицуулагч агентлаг дотор байгуулах юм бол энэ нь санхүүгийн байгууллагатай жам ёсны хэлэлцэгчийн үүрэг хүлээх болно. Ийм загварын СМН бусад бүх загварын СМН-тэй мэдээлэл хялбархан солилцож чаддаг.

Нөгөөтэйгүүр ийм СМН нь хууль сахиулах байгууллагын хэсэг биш тул санхүүгийн мэдээлэл дээр үндэслэн сэжигтэй гүйлгээг битүүмжлэх эсхүл сэжигтнийг баривчлах зэрэг хууль сахиулах арга хэмжээг хэрэгжүүлэх тал дээр саатал үүсч болно. Захиргааны байгууллагын загварын СМН-д эрэн сурвалжлах зөвшөөрөл гаргах, харилцаанд дундаас нь нэвтрэх, гэрчийг шүүхэд дуудах зэрэг хууль сахиулах байгууллага болон шүүхийн эрх бүхий байгууллагын нотолгоо олж авахад хэрэглэдэг хууль ёсны эрх мэдэл олгодоггүй. Гэхдээ захиргааны байгууллагын загварын зарим СМН зохицуулах болон бусад шийтгэлийг ногдуулах эрхтэй байхаас гадна зарим нь бичиг баримтын хэлбэртэй нотлох баримтыг өргөн барихыг төрийн буюу хувийн байгууллагаас хүсэх эрхтэй байдаг. Захиргааны байгууллагын загварын СМН-үүд хяналтын хувьд илүүтэйгээр улс төрийн эрх бүхий байгууллагын шууд хяналтанд байж болно.

II.3. СМН-ийн загварууд: хууль сахиулах байгууллага

Оролцогч зарим улсад СМН-ийн хууль сахиулах талыг онцгойлон авч үзэн СМН-ийг төрийн бие даасан агентлаг болгож эсхүл хууль сахиулах байгууллагын нэг хэсэг болгож байгуулсан байна. Энэ нь эрх зүйн болон захиргааны шинэ хүрээнд шинэ байгууллагын загвар гаргалгүйгээр хууль сахиулах зохих эрх мэдэл бүхий байгууллагыг бий болгох хамгийн хялбар арга зам юм. Үйл ажиллагааны хувьд энэ орчинд СМН нь бусад байгууллага дахь санхүүгийн гэмт хэрэг хариуцсан тасаг зэрэг хууль сахиулах бусад нэгжтэй ойр байж, тэдгээрийн мэргэжлийн ур чадвар болон мэдээллийн эх үүсвэрээс ашиг тус хүртэж болно. Үүний хариуд СМН-ийн хүлээн авсан мэдээлэлд хууль сахиулах байгууллагууд хялбархан нэвтэрч, аливаа мөрдөн байцаах ажиллагаанд ашиглаж ингэснээр үүний ашигт байдал нэмэгдэх учиртай. Эрүүгийн мэдээлэл солилцох үндэсний болон олон улсын сүлжээг ашиглан мэдээллийн солилцоог улам түргэсгэж болох юм.

Хууль сахиулах байгууллагын загварын СМН-ийн давуу талууд:

- Угаас байгаа дэд бүтцэд тулгуурлан бий болох тул шинэ агентлаг байгуулах шаардлагагүй.

- Санхүүгийн нээлттэй мэдээллийн тухайд хууль сахиулах арга хэрэгслийг дээд зэргээр ашиглах боломжтой.
- Мөнгө угаах болон бусад гэмт хэргийг илтгэн харуулж байгаа тохиолдолд даруй хууль сахиулах хариу үйлдлийг авна.
- Эрүүгийн мэдээлэл солилцох дотоодын, бүс нутгийн болон олон улсын сүлжээг ашиглан мэдээлэл солилцож болно.
- Хууль сахиулах орчин нөхцөл болон мэргэжлийн ур чадварыг хуваалцах боломж байгаа тул боловсон хүчнийг томилж, солилцож эсхүл баг болон ажлын хэсэгт оролцуулж болно.
- Тагнуулын мэдээ болон тагнуулын нийгэмлэгт ерөнхийдөө харьцангуй хялбар нэвтрэх боломж үүснэ.

Хууль сахиулах байгууллагын загварын СМН-д хууль сахиулах байгууллагын бүх эрх мэдэл олгогдсон байх учир хуулиар тусдаа, тодорхой эрх мэдэл зааж өгөх шаардлагагүй. Эдгээр эрх мэдэлд (оролцогч улсын хууль сахиулах бусад байгууллагад хэрэгждэгтэй адил түвшний шүүхийн хяналтын хамтаар) дансанд нэвтрэх, гүйлгээг хянах, эд хөрөнгө түр хураах эрх мэдэл орно.

Сул талууд нь:

- Энэ төрлийн СМН нь дүн шинжилгээ хийх буюу урьдчилан сэргийлэх арга хэмжээнээс илүүтэйгээр мөрдөн байцаах ажиллагаанд төвлөрөх хандлагатай байдаг.
- Хууль сахиулах байгууллага нь санхүүгийн байгууллагын жам ёсны хэлэлцэгч биш тул энэ тал дээр харилцан итгэлцлийг бий болгох хэрэг гарч, энэ нь цаг хугацаа шаардахаас гадна хууль сахиулах байгууллага ийм харилцааг үүсгэж явуулах санхүүгийн мэргэжилтэнгүй, санхүүгийн байгууллагад холбогдох, тогтмол хариуг өгч байхын ач холбогдлыг үнэлэх асуудал дээр доголдол үүсч болно.
- Санхүүгийн байгууллагын мэдээлэл (мэдээлсэн гүйлгээнээс гадна) олж авахад албан ёсны мөрдөн байцаах ажиллагаа эхлүүлэх эсхүл шүүхийн шийдвэр гаргуулах шаардлага ихэнхдээ үүсдэг.
- Мэдээлэгч байгууллага өгсөн мэдээллийг нь (зөвхөн мөнгө угаах ба авлигын гэмт хэрэг биш) ямар нэг гэмт хэрэг мөрдөн байцаахад ашиглаж болно гэдгийг мэдвэл хууль сахиулах байгууллагад мэдээлэл өгөх тал дээр дурамжхан байж болно.
- Мэдээлэгч байгууллага “сэжигтэй” төдий гүйлгээний талаар хууль сахиулах байгууллагад мэдээлэл задруулахаастатгалзах.

II.4. СМН-ийн загварууд: шүүхийн буюу прокурорын байгууллага

Энэ төрлийн СМН нь шүүхийн салбарын хүрээнд, ихэнхдээ прокурорын байгууллагын харъяалалд байгуулагддаг. Энэ нь улсын прокурор, шүүхийн байгууллагатай хамтран ажилладаг бөгөөд мөрдөн байцаах байгууллагад эрх мэдэлтэй байх Европын хуулийн уламжлалтай оролцогч улсад голлон тохиолдоно.

Шүүхийн болон прокурорын байгууллагын загварын СМН нь санхүүгийн байгууллагатай хамтран ажиллах явдлыг хангахад шүүх, прокурорын эрх бүхий байгууллагатай шууд холбоо шаардахаар банкны нууцлалын тухай хууль тогтоомж нь нилээд чанга оролцогч улсуудад сайтар тохирдог.

Шүүхийн эсхүл прокурорын байгууллагын загварын СМН-ийн давуу талууд:

- Эдгээр нь ихэнхдээ өндөр түвшний хараат бус байдалтай байдаг.
- Гэмт хэргийг мөрдөн байцаах буюу яллах эрх бүхий байгууллагад мэдээллийг шууд задруулах боломжтой байна.
- Шүүхийн эсхүл прокурорын байгууллагын (жишээ нь, хөрөнгө түр хураах, данс битүүмжлэх, байцаалт явуулах, хүмүүсийг саатуулах, эрэн сурвалжлах) эрх мэдэл, ур чадварыг даруй хэрэглэж болохоор байна.

Ийм загварын СМН-н сул талыг ашиглан дээр дурдсан хууль сахиулах байгууллагын загварын СМН-ийнхтэй адил бөгөөд “сэжиг”-т үндэслэн мэдээлэл задруулах тал дээр дурамжхан байхаас бусад тохиолдолд шүүхийн эсхүл прокурорын байгууллагын загварын СМН-д адил хэрэгжинэ.

II.5. СМН-ийн загварууд: Эрлийз загвар

СМН-д хамаарах энэхүү хамгийн сүүлийн загвар нь дээр дурдсан гурван загварыг өөр өөр байдлаар нийлүүлснээр үүснэ. Өөр өөр загварын СМН-ийн давуу талуудыг нэг байгууллагад хослуулах зорилгоор энэ төрлийг бий болгодог. Зарим СМН нь захиргааны байгууллагын загварын болон хууль сахиулах байгууллагын загварын СМН-ийн онцлогийг хослуулдаг бол зарим нь гаалийн байгууллагын эрх мэдлийг цагдаагийн байгууллагын эрх мэдэлтэй хослуулдаг. Зарим СМН-д өөрийн агентлагийн эрх мэдлийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ мэдээлэл хуваалцах болон хамтын хүчин зүтгэлийг дэмжих зорилгоор зохицуулагч болон хууль сахиулах олон төрлийн агентлагаас боловсон хүчнийг авч ажиллуулдгийг тэмдэглэх нь зүйтэй юм.

59 дүгээр зүйл: Хоёр ба олон талт хэлэлцээр ба тохиролцоо

Оролцогч улсууд Конвенцийн энэ бүлгийн дагуу хэрэгжүүлсэн олон улсын хамтын ажиллагааны үр дүнг дээшлүүлэхээр хоёр буюу олон талт хэлэлцээр буюу тохиролцоо байгуулах асуудлыг авч үзнэ.

I. Ерөнхий тойм

Энэ зүйлд энэхүү конвенцийн дагуу тогтоосон гэмт хэргээс үүсэлтэй хөрөнгийг буцаан олгох ажлыг бэхжүүлэх зорилгоор 51 дүгээр зүйлд заасан ерөнхий зарчмыг санан хоёр буюу олон талт хэлэлцээр байгуулахыг оролцогч улсад чухалчлан санал болгосон байна.

II. Бодит бэрхшээл ба шийдэл

Хөрөнгө буцаан олгох тухай заалт агуулсан хоёр талт буюу бүс нутгийн хэмжээний хэлэлцээрийг хэрэгжүүлэхээр дотоодын хууль тогтоомж хэдий нь гаргасан оролцогч улсууд энэхүү конвенцийн V бүлгийн дагуу өөрчлөлт хийх зорилгоор тэдгээр заалтыг дахин нэг харж үзэх хэрэгтэй. Түүнчлэн хоёр талт хэлэлцээрийг энэ зорилгоор дахин харж үзэн хэлэлцээрт гарын үсэг зурсан оролцогч улс нэмэлт протокол гаргах асуудлыг анхаарч үзнэ. Ингэхдээ хөрөнгө буцаан олгох хүрээнд эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх магадлалтай оролцогч улсууд болон эрх зүйн ялгаатай тогтолцооноос үүдэн хамтын ажиллагаанд техникийн бэрхшээл гарч болох бөгөөд үүнийг нь хоёр талт гэрээгээр шийдэж болох тэдгээр улсуудыг юун түүрүүнд хамрахаар нягтлан үзвэл зохино.

Хэлэлцээрт V бүлгийн заалтыг хэрхэн хэрэгжүүлэх тал дээр эсхүл V бүлгийн үүргийг биелүүлэх төдийгүй харилцан солилцооны нөхцлөөр зөвлөмжийг хэрэгжүүлэх тал дээр оролцогч улсуудын үүргийг заадаг. Түүнчлэн тэдгээр хэлэлцээрт тусгай хамтын ажиллагааны тухай 56 дугаар зүйл эсхүл СМН-үүд хоорондын хамтын ажиллагааны тухай 58 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд нууцлалын болон тусгай байдлын зарчим зэргийн дагуу мэдээлэл ашиглалтанд тодорхой хязгаарлалт тогтоож байж болох юм. Мэдээлэл ашиглалтанд тусгай байдлын зарчмын дагуу хязгаарлалт тавьсан тохиолдолд мэдээлэл өгч буй оролцогч улсын зүгээс мэдээлэл хүлээн авч буй оролцогч улсын хүсэлтийн дагуу тухайн мэдээллийг зааснаас бусад зорилгоор ашиглах эрх олгох боломжийг тооцож үзнэ.

Дотоодын эрх зүйн зарчмынхаа дагуу хоёр талт буюу олон талт хэлэлцээр байгуулахад оролцогч улсын анхаарч үзэх хэрэгтэй өөр заалтууд нь: мэдээлэл солилцох буюу эрх зүйн харилцан туслалцааг (ЭХТ) зохицуулах албан болон албан бус журмыг тогтоох, дипломат сувгаар явагдах эрх бүхий төв байгууллагатай албан харилцааг үл харгалзан ЭХТ-ны хүсэлтийн тухайд шүүхийн буюу тодорхой үүрэг хариуцлагатай эрх бүхий бусад байгууллагуудад урьдаас зэрэг мэдээлсэн байх явдлыг таньж тогтоох болон мэдээллийн эх сурвалж, агуулгатай холбоотой хамгаалалт өндөр харилцааны орчин үеийн арга хэрэгслийг нэвтрүүлж хэрэглэх зэрэг асуудалтай холбоотой заалтууд юм.

Хоёр талт буюу олон талт тодорхой хэлэлцээр болон дотоодын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх тал дээр бүс нутгийн буюу олон улсын байгууллага болон оролцогч улсууд ерөнхийдөө хэрэглэгчдэд зориулсан хэрэглэгчид ээлтэй веб хуудсанд эдгээр хуулийн заалтыг

нийтлэх, байрлуулах асуудлыг тооцож үзэж болно. Аль ч тохиолдолд, 55 дугаар зүйлд заасны дагуу оролцогч улс холбогдох хэлэлцээр болон тохиролцоо бүрийн нэг хуулбарыг Нэгдсэн Үндэстний Байгууллагад ирүүлнэ.

UNODC

Нэгдсэн Үндэстний Байгууллагын
Мансууруулах бодис болон гэмт хэргийн асуудал хариуцсан газар

Vienna Internatioanal Centre, PO Box 500, 1400 Vienna, Austria

Tel.: (+43-1) 26060-5866, www.unodc.org